

Мормоны Ном

Сайн Мэдээний Номлолын Багшийн Гарын Авлага



Мормоны Ном

Сайн Мэдээний Номлолын Багшийн Гарын Авлага

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс
хэвлэн гаргав.

Солт Лэйк Сити, Юта

Санал Зөвлөгөө

Энэ гарын авлагын талаар ирүүлэх таны санал зөвлөгөөнд бид талархах болно.

Та санал зөвлөгөөгөө дараах хаягаар ирүүлнэ үү:

Curriculum Planning

50 East North Temple Street, Floor 24

Salt Lake City, UT 84150-3200

USA

E-mail: cur-development@ldschurch.org

Та нэр, хаяг, хэсэг болон гадсаа бичнэ үү.

Та гарын авлагын нэрийг бичихээ мартуузай.

Дараа нь гарын авлагын давуу тал, хүч нөлөөний тухай санал зөвлөгөөгөө бичнэ үү.

© 1999 by Intellectual Reserve, Inc.

Бүх эрхийг эдэлнэ.

Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Англи эхийн зөвшөөрөл: 8/96

Орчуулгын зөвшөөрөл: 8/96

Book of Mormon: Gospel Doctrine Teacher's Manual-ийн орчуулга
Mongolian

Агуулга

Хичээлийн Дугаар ба Гарчиг	Хуудас
Багшид Зориулсан Тусламж	v
1 “Шашны Маань Тулгуур Чулуу”	1
2 “Бүгдийг Түүний Ёсоор” (1 Нифай 1–7)	6
3 “Амьдралын Модны Тухай Үзэгдэл” (1 Нифай 8–11; 12:16–18; 15)	12
4 “Би Сүнсэнд Автагдсан Байх Үедээ Харсан Тэдгээр Зүйлүүд” (1 Нифай 12–14)	17
5 “Үнэнийг Сонсож, Үүнд Анхаарлаа Хандуулах нь” (1 Нифай 16–22)	21
6 “Эрх Чөлөө Болон Мөнхийн Амьдралыг Сонгох Эрхтэй” (2 Нифай 1–2)	27
7 “Хэнд Итгэснээ Би Мэдэж Байна” (2 Нифай 3–5)	32
8 “Бурханы Маань Сайн Сайхан Ямар Агуу Их Билээ” (2 Нифай 6–10)	37
9 “Миний Бодгаль Исаегийн Үгэнд Баясдаг” (2 Нифай 11–25)	42
10 “Тэр Тэднийг Бүгд Өөрт нь Ирэхийг Урьдаг” (2 Нифай 26–30)	48
11 “Христэд Тууштайгаар Итгэн Урагшаа Тэмүүл” (2 Нифай 31–33)	54
12 “Та нар Бурханы Хаант Улсыг эрэлхийлэгтүн” (Иаков 1–4)	58
13 “Чидуны Модны Ёгтлол” (Иаков 5–7)	64
14 “Мэргэн Зорилгын Учир” (Инос, Жэром, Омнай, Мормоны Үгс)	69
15 “Тэнгэрлэг Эцэгтээ Өгөх Мөнхийн Өрөнд Орсон” (Мозая 1–3)	75
16 “Та Нар Христийн Хүүхдүүд Гэж Нэрлэгдсэн Байх Болно” (Мозая 4–6)	81
17 “Үзмэрч . . . Бусаддаа Агуу Их Ашиг Тус Болох Белгөө” (Мозая 7–11)	86
18 “Бурхан Өөрөө . . . Өөрийн Хүмүүсийг Гэтэлгэх Болно” (Мозая 12–17)	91
19 “Их Эзэнээс өөр хэн ч тэднийг чөлөөлж чадахгүй” (Мозая 18–24)	97
20 “Миний Бодгаль Цаашид Дахин Өвдөх нь Үгүй” (Мозая 25–28; Алма 36)	103
21 “Алма . . . Зөв Шударга Шүүлтүүдээр Шүүсэн Болой” (Мозая 29; Алма 1–4)	109
22 “Та Нар Түүний Дүрслэлийг Өөрсдийн Царай Төрхөндөө Хүлээж Авсан уу?” (Алма 5– 7)	113
23 “Нэгэн Гэрчээс Илүү” (Алма 8–12)	118

24	“Христэд Итгэх . . . Бидний Итгэлийн Дагуу Бидэнд Хүчийг Өгөөч” (Алма 13–16)	123
25	“Бурханаас Хүлээн Авсан Хүч мөн Эрх Мэдэлтэйгээр Тэд Зааж Байв” (Алма 17–22)	129
26	“Их Эзэнд Хөрвүүлэгдсэн” (Алма 23–29)	134
27	“Бүх Зүйл Бурхан Байдгийг Үзүүлдэг” (Алма 30–31)	138
28	“Авралд Хүргэдэг Үг нь Христэд Буй” (Алма 32–35)	143
29	“Үгсэд Минь Чих Тавин Сонс” (Алма 36–39)	147
30	“Аз Жаргалын Агуу Их Төлөвлөгөө” (Алма 40–42)	153
31	“Христийн Итгэлд Гуйвшгүй” (Алма 43–52)	158
32	“Тэд Зарлигийн Үг Бүрийг Яг Таг Гүйцэтгэхдээ Дуулгавартай Байсан” (Алма 53–63)	162
33	“Бат Бэх Суурь” (Хиламан 1–5)	167
34	“Та Нар Бурханаа Хэрхэн Мартаж Чадсан бэ?” (Хиламан 6–12)	171
35	“Наманчилж Их Эзэнд Ханд” (Хиламан 13–16)	177
36	“Маргааш Би Дэлхийд Ирэх Бөлгөө” (3 Нифай 1–7)	183
37	“Ирэх Хэнийг Боловч, Түүнийг Би Хүлээн Авах Болно” (3 Нифай 8–11)	188
38	“Хуучин Зүйлүүд Төгсөж Бүх Зүйл Шинэ Боллоо” (3 Нифай 12–15)	193
39	“Болгоогтун, Миний Баясал Дүүрэн Байна” (3 Нифай 17–19)	199
40	“Тэгээд Би Тэднийг. . . Цуглуулах Болно” (3 Нифай 16; 20–21)	204
41	“Тэр Тэдэнд Бүх Зүйлсийг Тайлбарласан” (3 Нифай 22–26)	209
42	“Энэ Бол Миний Сайн Мэдээ” (3 Нифай 27–30; 4 Нифай)	214
43	“Та Нар Их Эзэний Замаас Яахин Салж Чаднав?” (Мормон 1–6; Морунай 9)	219
44	“Та Нар Өмнө Минь Буй Мэтээр Би Та Нартай Ярьж Байна” (Мормон 7–9)	224
45	“Таны Нэгэн Адилаар Надад Хүмүүн Итгэж Байсангүй” (Ифэр 1–6)	229
46	“Итгэлээр Бүх л Зүйлс Гүйцэлддэг” (Ифэр 7–15)	233
47	“Тэднийг Зөв Замд Байлгахын Тулд” (Морунай 1–6)	238
48	“Христэд Ирэгтүн” (Морунай 7–8; 10)	242

Багшид Зориулсан Тусламж

Арван Хоёр Төлөөлөгчтэй уулзахдаа Бошиглогч Иосеф Смит “ах нарт хэлсэнчлэн Мормоны Ном бол энэ дэлхий дээрх бусад бүх номноос хамгийн зөв нь, мөн шашны маань тулгуур чулуу, мөн бусад ямар ч номноос илүүгээр, үүний зааврыг мөрдсөнөөр хүмүүн Бурханд илүү ойртох болой” хэмээжээ. (*History of the Church*, 4:461; мөн Мормоны Номын удиртгалыг үз).

Та Сайн Мэдээний Номлолын багшийн хувьд энэ жил “дэлхий дээрх бусад бүх номноос хамгийн зөв” номноос заах боломжтой юм. Та Сүнсээр удирдуулан ангийнхаа гишүүдийг мөнхийн заавруудыг ойлгож, Есүс Христ болон Түүний сайн мэдээ, Бошиглогч Иосеф Смитийн үүргийг ойлгоход туслах боломжтой болно. Мөн та Мормоны Номыг хичээнгүйлэн судалснаас ирдэг бусад адислалуудыг хүлээн авахад тэдэнд туслах боломжтой болно. Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон эдгээрийн заримын тухай ийнхүү дүрсэлжээ:

“Мормоны Ном Христийн дайснуудыг харуулдаг. Энэ нь буруу сургаалыг бүрмөсөн үгүйсгэж, маргаан тэмцлийг намжаадаг. (2 Ниф. 3:12.) Энэ нь Христийн даруу дагалдагчдыг хилэнцэт төлөвлөгөө, тулалдааны бодлого болон өнөө үеийн чөтгөрийн сургаалын эсрэг зоригжуулдаг. Мормоны Номонд гардаг урвагчдын хэлбэр нь бидний өнөө үед байгаатай төстэй байдаг. Бурхан өөрийн хэмжээлшгүй зөгнөх мэдлэгээрээ биднийг өөрсдийн цаг үедээ байгаа бурууг харж, хуурамч боловсрол, улс төр, шашны болон гүн ухааны зааврыг ялан дийлэг гэж Мормоны Номыг тийнхүү бий болгосон юм” (in Conference Report, Apr. 1975, 94–95; or *Ensign*, May 1975, 64).

“Энэ номыг нухацтайгаар судалж эхлэх тэр үеэс чинь эхлээд үүнд байдаг хүч та нарын амьдралд орж ирж эхэлнэ. Та нар уруу таталтыг эсэргүүцэх илүү агуу хүчийг олно. Мөн мэхлэх явдлаас зайлсхийх хүчийг олно. Та нар давчуу бөгөөд нарийн зам дээр үлдэх хүчийг олно. . . . Та нар эдгээр үгсийн төлөө өлсөж, цангаж эхлэхдээ амьдрал чинь илүү их элбэг дэлбэгээр бялхах болно” (in Conference Report, Oct. 1986, 6; or *Ensign*, Nov. 1986, 7).

Таныг зааж байхад хүмүүст Есүс Христийн болон Түүний сургаалын тухай тууштай бас гуйвшгүй мэдлэгийг авчрах Мормоны Номын хүч чадлыг Их Эзэний Сүнс танд гэрчилнэ.

Сүнсээр Заах

Та Сайн Мэдээний Номлолын хичээлийг бэлтгэхдээ Ариун Сүнснээс илэрхийлэлт болон удирдамжийг эрэлхийлэх нь чухал. Их Эзэн, итгэлтэйгээр залбирснаар Сүнс танд өгөгдөх бөгөөд хэрэв та Сүнсийг хүлээн аваагүй бол зааж эс чадна гэж хэлсэн байдаг. (С ба Г 42: 14-ийг үз.) Ариун Сүнс нь танай ангийн багш гэдгийг санаарай.

Та залбирч, мацаг барьж, судраас өдөр болгон суралцаж, зарлигуудыг дуулгавартай дагаснаар Сүнсийг эрэлхийлж чадна. Хичээлдээ бэлтгэж байхдаа судрууд болон ангийн гишүүдийн хэрэгцээг ойлгохын тулд Сүнснээс тусламж авахаар залбираарай. Мөн Сүнс танд судруудын талаар ярилцаж, тэдгээрийг амьдралд хэрэгжүүлэх чухал ач холбогдолтой арга замуудыг төлөвлөхөд тусалж чадна (1 Нифай 19:23-ыг үз). Сүнсний

удирдамжаар та түүний үгийг хүүхдүүдэд нь заах Их Эзэний мутар дахь үр ашигтай зэмсэг болно.

Сүнсийг ангидаа хэрхэн урих зарим зөвлөгөөг дор өгөв:

1. Хичээлийн эхэнд болон төгсгөлд залбируулахаар ангийн гишүүдийг урь. Хичээлийн туршид Сүнс таныг удирдаж, ангийн гишүүдийн зүрх сэтгэлийг нээж, гэрчилж, онгод оруулахын төлөө зүрх сэтгэлдээ залбир.
2. Судруудыг ашигла. (дор байгаа “Судрууд дээр Төвлөрөх нь”-ийг үз)
3. Зөвхөн хичээлийн төгсгөлд биш, Сүнс танд урам өгөх бүрт гэрчлэлээ хуваалц. Есүс Христийг гэрчил. Ангийн гишүүдийг гэрчлэлээ хуваалцахыг байнга урь.
4. Ангийн гишүүдийн зүрх сэтгэлийг Сүнсийг мэдрэхэд бэлтгэхийн тулд дуулал, Хүүхдийн Хэсгийн дуу болон бусад нандин дуу хөгжмийг хэрэглэ.
5. Ангийн гишүүд болон бусдад, мөн Тэнгэрлэг Эцэг, Есүс Христэд хайртайгаа илэрхийл.
6. Зохимжтой бол хичээлтэй холбоотой бодол, сэтгэгдэл болон туршлагаасаа хуваалц. Ангийн гишүүдийг мөн адил хийхийг урь. Ангийн гишүүд өнгөрсөн хичээл дээр ярилцсан зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлснээ ярьж болно.

Судрууд дээр Төвлөрөх нь

Ахлагч Бойд К.Пакер заахдаа, “Үнэн номлолыг ойлгосноор аливаад хандах хандлага, зан чанар өөрчлөгддөг” гэсэн (in Conference Report, Oct. 1986, 20; or *Ensign*, Nov. 1986, 17). Та бэлтгэж байхдаа мөн хичээлийн явцад сударт болон хожмын үеийн бошиглогчдын номлолд заасны дагуу сайн мэдээний авралын номлолд анхаарлаа голлон хандуул. Энэ нь таныг судруудаас хичээнгүйлэн мөн залбирч суралцахыг шаарддаг. Их Эзэн бидэнд түүний үгийг тунхаглахыг эрэлхийлэх бус, эхлээд түүний үгийг өөртөө олж авахаар эрэлхийл гэж тушаасан. Судраас суралцан түүний үгийг олж авах үед таны хэл суллагдана; тэгээд, хэрэв та хүсвэл түүний Сүнс, түүний үг, хүн төрөлхтнийг ятган үнэмшүүлэх Бурханы хүч чадлыг авах болно гэж Их Эзэн амласан. (С ба Г 11:21-ийг үз.)

Ангийн гишүүдийг долоо хоног бүр судраа авчрахыг урамшуул. Сонгосон судрын хэсгүүдээс ярилцахдаа хамтарч унш.

Ангийн гишүүн бүрт *Мормоны Ном Ангийн Гишүүний Суралцах Удирдамж* (35684)-ийг өгсөн байх ёстой. Энэ гарын авлага нь ангийн гишүүдэд суралцах ур чадвараа дээшлүүлэхэд нь тусална. Мөн энэ нь судрыг ойлгож, тэдгээрийг хэрэгжүүлж, ангидаа ярилцахаар бэлтгэн мөн тэдгээрийг гэр бүлийнхээ ярилцлаганд хэрэглэхэд тэдэнд тусална. Зохих судар болон суралцах удирдамжийн хэсгийг долоо хоног бүр хичээлдээ ирэхээсээ өмнө уншсан байхыг ангийн гишүүдэд уриал.

Мормоны Номыг Хуваалцах нь

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон Сүмийн гишүүдэд Мормоны Номноос хуваалцахыг уриалсан. Тэрээр хэлэхдээ:

“Ертөнцийг Мормоны Номоор хүчтэй үерлүүлэх цаг хэтрээд удаж байна. . . . Хэрэв бид одоо Мормоны Номыг гайхамшигтай арга замаар хөдөлгөхгүй бол Бурхан биднийг хариуцлагад татах болно.

“Бидэнд Мормоны Ном, гишүүд, номлогч нар, эх сурвалжууд байгаа бөгөөд дэлхийд хэрэгцээ шаардлага нь байгаа билээ.

“Одоо цаг нь ирлээ!” (in Conference Report, Oct. 1988, 4; or *Ensign*, Nov. 1988, 4–5).

Та энэ жил Ням Гарагийн Сургууль дээр Мормоны Номыг заахдаа ангийн гишүүдэд Мормоны Номыг гишүүн бус найзууд болон танилуудтайгаа хуваалцахыг уриалаарай (хичээл 1-ийн заах нэмэлт санаануудын хоёрдугаарыг үз). Жилийн эхэнд та бишопын зөвлөл эсвэл хэсгийн номлолын удирдагчтай ангийн гишүүд бусадтай хуваалцах Мормоны Номын хувийг хэрхэн олж авах тухай зөвлөлдөж болно.

Уг Гарын Авлагыг Ашиглах нь

Энэ гарын авлага нь танд судраас сайн мэдээний номлолыг заахад туслах хэрэгсэл юм. Энэ нь өсвөр насныхан болон насанд хүрэгсдийн Сайн Мэдээний Номлолын хичээлд зориулан бичигдсэн бөгөөд үүнийг дөрвөн жил тутамд хэрэглэнэ. Ахлагч М.Рассел Баллард хэлэхдээ: “Нэмэлт материалуудыг хэрэглэхээс нь өмнө судар болон гарын авлагаасаа хичээнгүйлэн суралцах талаар багш нарт сайн зөвлөсөн байх хэрэгтэй. Дэндүү олон багш нар бүрэн танилцаж уншиж үзэлгүйгээр баталсан хуваарь дахь материалуудыг хэрэглэхгүй байгаа юм шиг санагддаг. Хэрэв багш нар хичээлийг заахдаа судар болон гарын авлагаас өөр зарим нэг сайн нэмэлт эх сурвалжуудыг ашиглах хэрэгтэй бол юуны түрүүнд Сүмийн сэтгүүлүүдийг хэрэглэх нь зүйтэй” (in Conference Report, Apr. 1983, 93; or *Ensign*, May 1983, 68).

Хичээл тус бүрийг дор хаяж долоо хоногийн өмнөөс тоймлон үз. Та унших даалгавар болон хичээлийн материалыг урьдчилж судалбал уг хичээлийг заахад туслах санаа, бодлуудыг долоо хоногийн туршид хүлээн авах болно. Та долоо хоногийн туршид хичээлийг эргэцүүлэн бодохдоо Сүнсний удирдамжийг хайж залбир. Их Эзэн таныг адислана гэсэн итгэлтэй бай.

Энэ гарын авлагын хичээлүүдэд бараг нэг хичээлийн цагт заахаас илүү мэдээлэл агуулагдсан байгаа. Ангийн гишүүдийн хэрэгцээг сайн хангах судрын товч утга, асуулт болон хичээлийн бусад материалуудыг сонгохдоо Их Эзэний Сүнсийг эрэлхийл.

Хичээл бүр дараах хэсгүүдээс бүрдсэн:

1. *Гарчиг*. Гарчиг нь хоёр хэсгээс: тайлбар бүхий товч хэллэг буюу ишлэл болон хичээлд бэлтгэхээс өмнө таны унших ёстой судраас бүрддэг.
2. *Зорилго*. Зорилго хэсэгт хичээлийг бэлтгэж, заахдаа таны голлон анхаарах гол санааг санал болгодог.
3. *Бэлтгэл*. Энэ хэсэг хичээлд гарах судрын товч утгыг дүгнэдэг. Үүнд мөн нэмж унших зүйл болон ангид авчирч болох материалууд зэрэг хичээлийн бэлтгэлд зориулсан зөвлөгөө багтдаг. Эдгээр материалуудын ихэнх нь цуглааны байрны номын санд бий. (Санал болгосон зургуудын нэрний ард байгаа 5 оронтой дугаар нь цуглааны байрны номын сангийн дугаар юм; хэрэв зургууд нь Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулгад [34730] орсон бол уг дугаар нь өгөгдсөн байгаа.)

4. *Анхаарал татах үйл ажиллагаа.* Энэ хэсэг нь энгийн үйл ажиллагаа, бодит хичээл, ишлэл эсвэл ангийн гишүүдийг сурч мэдэж, оролцож, мөн Сүнсний нөлөөг мэдрэх зэрэгт бэлтгэхэд туслах асуултуудаас бүрддэг. Та гарын авлагын анхаарал татах үйл ажиллагаанаас эсвэл өөрийнхөөсөө ашиглах нь хамаагүй, харин хичээлийн эхэнд ангийн гишүүдийн анхаарлыг татахад голлон анхаарах нь чухал. Үйл ажиллагаа нь товч байх хэрэгтэй.
5. *Судрын ярилцлага ба хэрэглээ.* Энэ бол хичээлийн гол хэсэг юм. Сударт өгүүлсэн зүйлийг залбирч судалснаар та тэдгээрийг үр дүнтэй зааж, ярилцаж чадна. “Ангид Ярилцлага Өрнүүлэх” (хуудас viii–ix) ба “Судруудыг Заахад Төрөл Бүрийн Зүйлийг Ашиглах нь” (хуудас ix–x)-д өгөгдсөн зөвлөгөөг та заах арга барилаа өөрчлөхөд болон ангийн гишүүдийн сонирхлыг татахдаа хэрэглэ. Ангийн гишүүдийн нас, туршлаганд зохицсон асуулт болон арга барилыг сонго.
6. *Дүгнэлт.* Энэ хэсэг хичээлийг дүгнэж, таны ярилцсан зарчмуудын дагуу амьдрахад ангийн гишүүдийг урамшуулахад танд тусалдаг. Бас гэрчлэлээ хуваалцахыг танд сануулдаг. Хичээл тус бүрийг дүгнэж ярилцахад хангалттай цаг үлдээж бай.
7. *Заах нэмэлт санаанууд.* Энэ хэсэг гарын авлагын ихэнх хичээлд бий. Энэ нь сударт өгүүлсэн зүйлийн үнэнүүд, янз бүрийн заах аргууд, үйл ажиллагаанууд эсвэл хичээлийн гол санаанд нэмэлт болох бусад зөвлөгөөг багтаана. Та эдгээр санаануудын заримыг хичээлийн хэсэг болгон ашиглаж болох юм.

Ангид Ярилцлага Өрнүүлэх

Ер нь, та зөвхөн лекц өгөх ёсгүй. Үүний оронд ангийн гишүүдийг судраас ярилцахад үнэн сэтгэлээсээ оролцоход нь тусал. Ангийн гишүүдийн оролцоо нь тэдэнд доорх байдлаар тусалдаг:

1. Судрын талаар илүү ихийг сурах.
2. Сайн мэдээний зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлэхийг сурах.
3. Сайн мэдээний дагуу амьдрах илүү их эрмэлзэлтэй болох.
4. Ангид Сүнсийг урих.
5. Нэг нэгэндээ зааж мөн гэгээрүүлж, ингэснээр тэд нэг нэгнийхээ авъяас билиг, мэдлэг, туршлага болон гэрчлэлээс ашиг тусыг олох.

Ярилцлага нь ангийн гишүүдийг Христэд ойртож, Түүний шавь нарын адилаар амьдрахад туслах ёстой. Ярилцлагын сэдвийг өөрчлөх нь эдгээр зорилгод хүргэдэггүй.

Сэтгэн бодох асуулт асуух нь багшлах хамгийн үр ашигтай аргуудын нэг юм. Аврагч зааж байхдаа хэрэглэж байсан арга бол энэ юм. Та энэ гарын авлага дахь асуултуудыг судалж, алийг нь асуухаа шийдэхдээ Сүнсний удирдамжийг эрэлхийл. Гарын авлага эдгээр асуултуудын ихэнхэд нь хариулахад танд болон ангийн гишүүдэд туслах судрын ишлэлээр хангадаг. Ангийн гишүүдийн хувийн туршлага бусад асуултын хариуг өгнө.

Ангийн гишүүдэд судрыг ойлгож хэрэглэхэд туслах нь бэлтгэсэн хичээлийнхээ бүх зүйлийг заахаас илүү чухал. Хэрэв гишүүд сайн ярилцсаны үр дүнд сурч байвал, хичээлийн бүх материалыг заахыг хичээхийн оронд үүнийгээ үргэлжлүүлэх нь тустай байдаг.

Ангид ярилцлага өрнүүлэхдээ дараах зааврыг хэрэглэ:

1. “Тийм” эсвэл “Үгүй” гэж хариулахаас илүү бодол санаагаа хуваалцаж, ярилцах шаардлагатай асуулт тавь. *Яагаад, хэрхэн, хэн, юу, хэзээ* болон *хаана* гэж эхэлсэн асуултууд ер нь ярилцлага өрнүүлэхэд илүү үр дүнтэй байдаг.
2. Ангийн гишүүдийг судрын зарчмууд болон номлолуудыг амьдралд хэрхэн хэрэгжүүлж болохыг харуулсан туршлагаасаа хуваалцахад урамшуул. Мөн тэд судраас юу сурсан тухай сэтгэгдлээ хуваалцахыг тэдэнд урамшуул. Тэдний хийсэн зүйлд талархлаа илэрхийл.
3. Ангийн гишүүн бүрийн хэрэгцээг ойлгож ханд. Хэдийгээр ангийн бүх гишүүдийг ярилцлаганд оролцохыг урих ёстой ч зарим нь хариулт өгөхөөс зайлсхийж магад. Та тэднээс хичээл дээр чанга унших эсвэл оролцох нь ямар санагддагийг олж мэдэхийн тулд тэдэнтэй аминчлан ярилцаж болох юм. Хэрэв тэднийг ичээж магад бол ангийн гишүүдийг дуудахгүй байхыг анхаар.
4. Зарим асуултын хариуг олоход туслах судрын ишлэлийг ангийн гишүүдэд өг.
5. Ангийн гишүүдийг долоо хоног бүрийнхээ унших даалгаврыг хийхдээ *Мормоны Ном Ангийн Гишүүний Суралцах Удирдамж* дээрх асуултуудыг эргэцүүлэн бодохыг уриал. Та хичээл бүрийг бэлтгэхдээ эдгээр асуултуудыг хичээл дээрээ хэрхэн заахаа бодож үз. Ангийн гишүүд унших даалгавраа хийсэн бол, мөн та тэдний хариулахаар бэлтгэсэн асуултуудыг асуух юм бол тэд ярилцлаганд илүү сайн оролцох боломжтой болно.

**Судруудыг
Заахад Төрөл
Бүрийн Зүйлийг
Ашиглах нь**

Сударт өгүүлсэн зүйлсийг илүү үр дүнтэй, олон замаар заахын тулд дараах зөвлөгөөг хэрэглэ:

1. Сударт Есүс Христийн талаар юу заадгийг ойлгоход ангийн гишүүдэд тусал. Аврагчид итгэх итгэлийг нь судрын тодорхой нэг хэсэг хэрхэн нэмэгдүүлж, Түүний хайрыг мэдрэхэд тэдэнд хэрхэн тусалдгийг бодож үзэхийг хүс.
2. Судрын хэсгээс амьдралдаа хэрэгжүүлж болох тусгай арга замын талаар бодож, түүнийгээ хуваалцахыг ангийн гишүүдээс хүс. Сонгосон судрын хэсэгт нь тэдний өөрсдийн нэрийг орлуулж бодуулан судруудыг өөрийн болгуул.
3. Сургаал номлолыг заахын зэрэгцээгээр Мормоны Номон дахь урам өгөх түүхийг онцлон тэмдэглэ. Ангийн гишүүд түүхүүдийг ойлгож байгааг бататган тэдгээрийг хэрэгжүүлэх арга замын талаар ярилц. “Энэ өгүүлсэн зүйлийг Мормоны Номонд яагаад оруулсан гэж та нар бодож байна вэ?” эсвэл “Энэ түүхээс бид Христийн илүү сайн дагагч байхад туслах юуг сурч болох вэ?” гэж асуу.
4. Судрын хэсэгт байн байн давтагдсан эсвэл онцгой утга учир бүхий үгс, өгүүлбэр, санаануудыг олохыг ангийн гишүүдээс хүс.
5. Сударт өгүүлсэнтэй холбоотой өгүүлбэр, түлхүүр үгс эсвэл асуултуудыг самбарт бич. Тэгээд сударт өгүүлсэн зүйлийг унш эсвэл дүгнэ. Ангийн гишүүд тухайн өгүүлбэр, түлхүүр үгс болон асуултын хариуг сонсох үед зогсож, тэдгээрийн талаар ярилц.

6. Мормоны Номд заасан зарчмуудыг дүгнэж танилцуулахдаа “иймээс бид харвал” гэсэн хэллэгийг үргэлж хэрэглэдэг. (жишээ нь Хиламан 3:28-ыг үз). Судрын хэсгийг уншсаны дараа “иймээс бид харвал” гэсэн хэллэгийг хэрэглэж хэсэг дэх зарчмыг тайлбарлахыг ангийн гишүүдээс хүс.
7. Мормоны Номонд хэрэглэдэг бэлэг тэмдгийг олж, ярилц. Жишээ нь, давчуу бөгөөд нарийн зам нь ихэвчлэн сайн мэдээг төлөөлөн хэрэглэгддэг (жишээ нь, 2 Нифай 31:17–20; 33:9; Иаков 6:11; 3 Нифай 14:13–14; 27:33).
8. Судар дахь хүмүүс болон үйл явдлуудыг өөр хооронд нь хэрхэн зүйрлүүлж буюу харьцуулж болохыг тэмдэглэ. Жишээлбэл, та Лэмэн, Лэмүэл хоёрыг Нифай, Сэм гэсэн хоёр дүүтэй нь эсвэл Шинэ Гэрээн дээр бичигдсэн Аврагчийн Уулан дээрх Номлолыг 3 Нифай 12–14-т өгүүлсэнтэй харьцуулж болно.
9. Ангийн гишүүдээр түүхэнд гарч буй янз бүрийн хүмүүсийн үгийг чангаар уншуулан судрын түүхийг жүжигчлэн тоглуул. Жүжигчилсэн тоглолт нь судруудыг хүндэтгэж буй эсэхийг бататгаж үз.
10. Ангийг хоёр буюу олон жижиг бүлэг болгон хуваа. Сударт өгүүлсэн зүйлийг тоймлон үзсэний дараа бүлэг тус бүрээр уг мэдээлэлд заасан номлол болон зарчмуудыг бичүүл. Дараа нь эдгээр сургаалуудыг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг бүлгүүдээр ээлжлэн яриул.
11. Эдгээрийг ярилцах үед чухал шүлгүүдийг тэмдэглэж авах харандаа авчрахыг ангийн гишүүдээс хүс.

**Шинэ Гишүүдэд
Туслах нь**

Та Сүмийн шинэхэн гишүүдэд заах боломжтой байж болно. Таны заасан зүйл шинэ гишүүдийг баг итгэлтэй болоход нь тусалж чадна.

Тэргүүн Зөвлөлөөс хэлэхдээ, “Сүмийн гишүүн бүр, ялангуяа усан баталгааны дараах хэдэн сард хайрлуулж, тэтгэгдэх хэрэгтэй байдаг. Шинэ гишүүд чин сэтгэлийн нөхөрлөлийг олж авч, үйлчлэх боломжтой байж, Бурханы үгнээс суралцсанаар олж авах сүнслэг тэжээлийг хүртэхдээ тэд удаан үргэлжлэх өөрчлөлтийг мэдэрч, ‘гэгээнтнүүдийн адил нутгийн иргэд бөгөөд Бурханы гэр бүлийнх’ (Ефес 2:19) болдог” гэсэн. (First Presidency letter, 15 May 1997).

**Өсвөр Насныханд
Сайн Мэдээг
Заах нь**

Хэрэв та өсвөр насныханд зааж байгаа бол тэднийг аль болох идэвхтэй оролцуулж, тэдэнд ярилцаж буй сургаал номлолын үзүүлэн таниулах зүйлийг хэрэглэж заах хэрэгтэй гэдгийг сана. Дүрс бичлэг, зураг болон гарын авлагад санал болгосон үйл ажиллагааг ашиглах нь өсвөр насныхныг хичээлдээ сонирхолтой байхад тусална. Өсвөр насныханд сайн мэдээг заахад туслах бусад санаануудыг *Заах Удирдамж* (34595)-аас авч болно.

“Шашны Маань Тулгуур Чулуу”

Хичээл
1

Зорилго Мормоны Ном шашны маань тулгуур чулуу хэрхэн болдог бөгөөд үүний зааврыг мөрдөх нь биднийг Бурханд ойртоход хэрхэн тусалдгийг ойлгоход ангийн гишүүдэд туслах болно.


- Бэлтгэл**
1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир: 1 Нифай 13:38–41; 19:23; 2 Нифай 25:21–22; 27:22; 29:6–9; Мормон 8:26–41; Ифэр 5:2–4; Моронай 1:4; 10:3–5; Сургаал ба Гэрээ 10:45–46; 20:8–12; 84:54–58. Мөн гол хуудас, удиртгал, Гурван Гэрчийн Гэрчлэл, Найман Гэрчийн Гэрчлэл, Бошиглогч Иосеф Смитийн Гэрчлэл зэргийг Мормоны Номын удиртгал хэсгийн материалаас суралц.
 2. Ангийн нэг гишүүнээс Бошиглогч Иосеф Смитийн Гэрчлэлийг, нөгөөгөөс нь Гурван Гэрчийн Гэрчлэлийг, гурав дахиас нь Найман Гэрчийн Гэрчлэлийг дүгнэж ярихаар бэлтгэж ирэхийг урьдчилан хүс.
 3. Ангийн гишүүн бүрт *Мормоны Ном Ангийн Гишүүний Суралцах Удирдамж* (35684)-ийг авчир. (Та үүнийг Ням Гарагийн Сургуулийн ерөнхийлөгчийн зөвлөлөөс авах ёстой.)
 4. Дараах материалууд байгаа бол тэдгээрийг хичээлд хэрэглэхээр бэлтгэ:
 - а. Моронай Иосеф Смитийн Өрөөнд Үзэгдсэн нь (62492; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 404) ба Иосеф Смит Алтан Ялтсуудыг Хүлээн Авсан нь (62012; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 406) зургууд.

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Самбар дээр чулуун арк (нуман хэлбэртэй орц, нүх) зур:



Үүнтэй адил аркийг зөв баривал, энэ нь чулуунуудын хооронд шавар байхгүй байсан ч гэсэн бөх бат байж чаддаг.

- Арк нь юуг нийлүүлж хамтад нь барьж байдаг вэ?

Аркны төв хэсгийн чулуун дээр *тулгуур чулуу* гэж бич. Аркны тулгуур чулуу нь бусад чулуунуудыг тогтоон барьж байдаг гэдгийг тайлбарла. Энэ хичээлд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн тулгуур чулууны тухай ярилцдаг.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Мормоны Ном бол манай шашны тулгуур чулуу юм

Ангийн гишүүдээр Мормоны Номын удиртгал хэсгийг нээлгүүлж, нэг гишүүнийг зургаадугаар хам сэдвийг уншихыг урь.

Хэрэв та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглэсэн бол самбар дээр *тулгуур чулуу* гэсэн үгийн доор *Мормоны Ном* гэж бич.

Хэрэв та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглээгүй бол самбар дээр *Мормоны Ном =тулгуур чулуу* гэж бичээд, аркны тулгуур чулуу нь бусад чулуунуудыг тогтоон барьж, аркийг унахаас сэргийлж байдаг гэдгийг тайлбарла.

- Иосеф Смит Мормоны Номыг яагаад манай шашны тулгуур чулуу гэж нэрлэсэн гэж та нар бодож байна вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон тайлбарлахдаа, “Хэрэв тулгуур чулууг нь хөдөлгөвөл арк нурж унадаг шиг Сүмийн бүх юм Мормоны Номын үнэн байдлаас шалтгаалан оршин тогтож эсвэл нурж унадаг” гэсэн (in Conference Report, Oct. 1986, 5; or *Ensign*, Nov. 1986, 6).

- Сүм яагаад “Мормоны Номын үнэн байдлаас шалтгаалан оршиж эсвэл нурж унадаг” вэ?

Энэ асуултыг ярилцсаны дараа ангийн нэг гишүүнээр Ерөнхийлөгч Бэнсоны дараах мэдэгдлийг уншуул: “Мормоны Ном манай шашны тулгуур чулуу болдог гурван арга бий. Энэ нь Христийг гэрчилдэг бидний гэрчийн тулгуур чулуу юм. Энэ нь бидний сургаал номлолын тулгуур чулуу юм. Энэ нь гэрчлэлийн тулгуур чулуу юм” (in Conference Report, Oct. 1986, 4; or *Ensign*, Nov. 1986, 5).

Самбар дээр *Христийн Гэрч* гэж бич.

- Ангийн гишүүдээр Мормоны Номын гол хуудсыг нээлгүүлж, энэ хуудсыг бошиглогч Моронай бичсэн гэдгийг тайлбарла. Хоёрдугаар хам сэдэвт гарсны дагуу Мормоны Номын гурван зорилго юу вэ? (Их Эзэн тэдний эцэг өвгөдөд ямар агуу зүйлсийг хийж өгснийг Израилын угсааны үлдэгдэлд үзүүлэх; Их Эзэний байгуулсан гэрээнүүдийг заах; болон Өөрийгөө бүх үндэстнүүдэд үзүүлэн, Есүс бол Христ гэдгийг бүх хүмүүст итгүүлэх.)
- 1982 онд Мормоны Номонд *Есүс Христийн Бас Нэгэн Гэрээ* гэсэн давхар гарчгийг нэмсэн. Ингэж Аврагчийн тухай нэмэлт гэрээг бичих нь яагаад чухал вэ? (1 Нифай 13:38–41; 2 Нифай 29:6–9-ийг үз.) Мормоны Ном нь Христийг гэрчилдэг гэдгийг дэлхий дахинд тунхаглах нь яагаад чухал вэ?
- Та нар Мормоны Номоос Есүс Христийн тухай юу сурч авсан бэ? Есүс Христийн тухай гэрчлэлийг чинь Мормоны Ном хэрхэн батжуулсан бэ?

Самбар дээр *Сургаал Номлол* гэж бич.

- Мормоны Ном ямар замаар “манай сургаал номлолын тулгуур чулуу” болдог вэ? (С ба Г 10:45–46; 20:8–12-ыг үз.)

Ерөнхийлөгч Бэнсон мэдэгдэхдээ: “‘Есүс Христийн сайн мэдээний бүрэн дүүрэн байдлыг’ (С ба Г 20:9) Мормоны Ном агуулдаг гэж Их Эзэн Өөрөө мэдэгдсэн. Энэ нь ер нь л илчлэгдсэн бүх сургаал, номлолыг агуулдаг гэсэн утгатай биш юм. Харин энэ нь бидний авралд шаардлагатай тэдгээр номлолуудын бүрэн дүүрэн байдлыг бид Мормоны Номноос олно гэсэн үг юм. Мөн эдгээрийг энгийнээр болон хялбараар заадаг бөгөөд хүүхдүүд ч гэсэн авралын болон өргөмжлөлийн арга замуудыг сурч болно” гэсэн (in Conference Report, Oct. 1986, 4; or *Ensign*, Nov. 1986, 6).

- Сайн мэдээний чухал номлолуудын тухай ойлголтыг чинь Мормоны Ном хэрхэн нэмэгдүүлсэн бэ?

Самбар дээр *Гэрчлэл* гэж бич.

- Дахин Сэргээгдсэн сайн мэдээний гэрчлэлд Мормоны Ном яагаад үндэс нь болдог вэ?
- Мормоны Номын гэрчлэлийг хүлээн авч, сургаалуудыг нь дагадаг хүмүүст ямар адислалууд ирдэг вэ? Бид Мормоны Номын үнэний тухай гэрчлэлийг олж авахын тулд юу хийх ёстой вэ? (Моронай 10:3–5-ыг үз.)

Мормоны Номыг үнэн гэдгийг хэрхэн мэдэж авснаа ярихыг ангийн гишүүдээс урь.

2. Олон гэрчүүд Мормоны Номыг гэрчилсэн.

Хэрэв та Моронай Иосеф Смит дээр ирж байгаа, Иосеф Смит алтан ялтсуудыг хүлээн авч байгаа зургуудыг хэрэглэж байгаа бол тэдгээрийг одоо үзүүл. Урьдчилан даалгасан ангийн гишүүнээр Бошиглогч Иосеф Смитийн Гэрчлэл дээр бичигдсэн үйл явдлыг дүгнэн яриул. Дараа нь Иосеф Смит Мормоны Номыг орчуулж дууссаны дараа өөр бусад хүмүүс ялтсуудыг харах боломжтой байсныг тайлбарла. Урьдчилан даалгасан ангийн гишүүдээр Гурван Гэрчийн Гэрчлэл, Найман Гэрчийн Гэрчлэлийг дүгнэн яриул.

- Алтан ялтсуудыг гэрчлэх гэрчтэй байх нь яагаад чухал байсан бэ? (Ифэр 5:2–4-ийг үз.) Нэмэлт гэрчүүдтэй байх нь Бошиглогч Иосеф Смитэд хэрхэн тусалсан гэж та нар бодож байна вэ?
- Мормоны Ном үнэн гэдгийг гэрчлэх өөр ямар гэрчүүд бидэнд бий вэ?

3. Мормоны Номыг бидний үед зориулан бичсэн.

Хэдийгээр Мормоны Ном нь эртний бичиг баримт ч гэсэн үүнийг бидний үед зориулан бичиж, хадгалсан гэдгийг цохон тэмдэглэ (2 Нифай 25:21–22; 27:22; Мормон 8:34–35; Моронай 1:4).

- Мормон 8:26–41-ийг ангийн гишүүдтэй хамт унш. Эдгээр шүлгүүд нь Мормоны Номыг гарч ирэх тухай бошиглолыг агуулдаг гэдгийг тайлбарла. Мормоны Номыг дахин гарч ирэхэд дэлхий ямар нөхцөл байдалтай байна гэж Моронай урьдчилан харсан бэ? (Ангийн гишүүдийн хариултыг самбарт бич. Хариултанд доорх жагсаалтанд байгаагаас орж болно.) Эдгээр нөхцөл байдлууд өнөөдөр дэлхий дээр хэрхэн батлагдаж байна вэ?
 - а. “Бурханы хүч үгүйсгэгдэнэ” (шүлэг 28)
 - б. “Дэлхийн гадаргуу дээр агуу бохирдол байна” (шүлэг 31).

- в. Хүмүүс “зүрх сэтгэлийнхээ бардамналд өөрсдийгөө өргөнө” (шүлэг 36).
- г. Хүмүүс “ядуу мөн гачигдалтайг . . . хайрладгаасаа илүүгээр мөнгөнд . . . дуртай байна” (шүлэг 37).
- д. Хүмүүс “Христийн нэрийг өөрсөд дээрээ авахаас ичнэ” (шүлэг 38).

- Эртний бошиглогчдын сургаалууд ямар замаар бидэнд туслах эх сурвалж болдог вэ? Мормоны Номыг бидний үед зориулан бичсэн гэдгийг мэдэх нь үүнийг судалдаг бидний арга замд хэрхэн нөлөөлж болох вэ? (1 Нифай 19:23-ыг үз.)

Ерөнхийлөгч Бэнсон заахдаа: “Мормоны Ном нь . . . бидний үед зориулан бичигдсэн. Нифайчууд хэзээ ч номгүй байсан; эрт үеийн Лэмэнчүүдэд ч гэсэн байгаагүй. Энэ нь бидний үед зориулагдсан. . . . Мормоны Номын гол бичигч бүр ирээдүйн үе удамд зориулж бичсэн гэдгээ гэрчилсэн. . . . Хэрэв тэд бидний үеийг харж, эдгээр нь бидэнд хамгийн агуу үнэтэй зүйл байна гэдгийг сонгосон бол бид Мормоны Номыг ингэж судлах ёсгүй гэж үү? Бид үргэлж өөрсдөөсөө ‘Их Эзэн Мормоныг (эсвэл Моронайг, эсвэл Алмаг) тэмдэглэлдээ үүнийг оруулахыг яагаад урамшуулсан бэ? Үүнээс би өнөөгийн цаг үед амьдрахад надад туслах ямар хичээлийг сурч болох вэ?’ хэмээн асуух ёстой” гэжээ. (in Conference Report, Oct. 1986, 5; or *Ensign*, Nov. 1986, 6).

4. Мормоны Ном биднийг Бурханд ойртуулж чадна.

Ангийн гишүүнээр Мормоны Номын удиртгалын зургаадугаар догол мөрнөөс дахин уншуул.

- Зааврууд гэж юу вэ? (Зарлигууд буюу зарчмууд.) Мормоны Номын зааврууд биднийг Бурханд ойр болоход хэрхэн тусалж чадах вэ?
- Хэрэв бид Мормоны Номоос суралцахгүй бол бид хувиараа болон сүмээрээ шийтгүүлнэ гэж Их Эзэн хэлсэн. (С ба Г 84:54–58-ыг үз.)
- Мормоны Номноос тогтмол суралцаж, эргэцүүлэн бодсоноор таны амьдралд ямар өөрчлөлт, адислалууд ирсэн бэ?

Дүгнэлт

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны хэлсэн дараах мэдэгдлийг унш эсвэл ангийн гишүүнээр уншуул:

“[Мормоны Номыг] нухацтайгаар судалж эхлэх тэр үеэс эхлээд та уруу таталтыг эсэргүүцэх хүчийг олно. Та нар мэхлэхээс зайлсхийх хүчийг олно. Та нар давчуу бөгөөд нарийн зам дээр үлдэх хүчийг олно. . . . Та нар эдгээр үгсийн төлөө өлсөж, цангаж эхлэхдээ амьдрал чинь илүү их элбэг дэлбэгээр бялхах болно” (in Conference Report, Oct. 1986, 6; or *Ensign*, Nov. 1986, 7).

Энэ жил Мормоны Номыг судалснаар эдгээр амлалтуудыг өөрсдөө мэдэж авахыг ангийн гишүүдэд уриал.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Ангийн гишүүн бүрт суралцах удирдамж өг. Ангийн гишүүдэд эдгээр суралцах удирдамжуудыг долоо хоног бүр хичээлдээ бэлтгэн судраас суралцахдаа хэрэглэхийг уриал.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. Сайн мэдээг Дахин Сэргээхэд Мормоны Ном чухал байх нь Дараах өгүүлбэрүүдийг дугааргүйгээр нь самбарт бич:

6. Нас барагсдад зориулсан ариун сүмийн ажилд эхэлдэг.
3. Мелкизэдэк Пристийн Зэрэг дахин сэргэдэг.
5. Төлөөлөгчид дуудагддаг.
1. Иосеф Смит анхны үзэгдлээ үзсэн.
4. Сүм зохион байгуулагдсан.
2. Мормоны Номыг орчуулсан.

Ангийн гишүүдээс эдгээр үйл явдлын болсон дарааллыг асуу (Үйл явдлуудын зүүн талд байгаа дугаарууд тэдгээрийн зөв дарааллыг заадаг; оюутнуудыг үйл явдлуудын зохих дарааллыг олоход эдгээр дугааруудыг самбарт нэмж бич). Дараа нь Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны дараах саналыг унш эсвэл ангийн гишүүнээр уншуул:

“... Мормоны Номын чухал ач холбогдлын тухай хүчирхэг гэрчлэл нь үүнийг Их Эзэн дэлгэгдэн нээгдэх Дахин Сэргээлтийн цагийн хуваарийн хаана нь байрлуулсныг тэмдэглэх гэсэн явдал юм. Үүний өмнө болсон ганц зүйл бол Анхны Үзэгдэл байсан юм. . . .

“Энэ нь ямар далд утгыг агуулж байгааг бод доо. Мормоны Ном гарч ирсэн явдал пристийн зэргийн дахин сэргээлтийн өмнө болсон. Үүнийг Сүм байгуулагдахаас хэдхэн өдрийн өмнө хэвлэсэн. Гэгээнтнүүдэд агуу номлолууд болох алдар хүндийн гурван зэрэг, сэлэсчел гэрлэлт, мөн нас барагсдын төлөө хийх ажил зэрэг илэрхийлэлтүүдийг өгөхөөс өмнө Мормоны Номыг уншуулахаар өгсөн. Энэ нь пристийн зэрэгтний чуулгууд болон Сүмийн байгууллагуудаас өмнө ирсэн. Энэ нь Их Эзэн энэ нандин бүтээлийг хэрхэн дүгнэдэг талаар ямар нэгэн юм хэлэхгүй байна гэж үү?” (in Conference Report, Oct. 1986, 3; or *Ensign*, Nov. 1986, 4).

2. Мормоны Номыг Хуваалцах нь

Гишүүд танилууд болон гишүүн бус найзууддаа өгөх Мормоны Номын хувийг хэрхэн олж авч болох тухай бишопын зөвлөл болон хэсгийн номлогчийн удирдагчтай зөвлөлд.

Энэ жилийн зорилго нь гишүүн бус найзууд болон танилууддаа Мормоны Номыг хуваалцах явдал байвал зохино гэдгийг ангийнханд санал болго. Мормоны Номын хувийг яаж олж авч болохыг ангийн гишүүдэд тайлбарлаж, ангийн гишүүн бүрийг жилийн турш дор хаяж нэг найз эсвэл танилдаа нэгийг өгөхийг уриал.

Жилийн турш хэд хэдэн удаа ангийн гишүүдээс Мормоны Номын нэг хувийг хуваалцсан эсэхийг Сүнсний удирдамжаар асуу. Үүнийг хийсэн ангийн гишүүдээс хэрхэн хийсэн тухай явдлаа товч тайлбарлан ярихыг урь. Мормоны Номыг бусадтай хуваалцахыг ангийн гишүүдэд уриалахаа үргэлжлүүл.

Зорилго

Ангийн гишүүдэд Лихай, Нифай нарын жишээгээр аюулгүй байдал, аврал нь Их Эзэнд дуулгавартай байснаас ирдэг гэдгийг харахад туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. 1 Нифай 1–2. Лихай үзэгдэл үзээд Ерусалим устгагдана гэдгийг мэдэж авдаг. Тэр хүмүүст нүглээ наманчлахыг анхааруулдаг боловч тэд түүнийг эсэргүүцэж, түүний амийг хөнөөхийг эрэлхийлдэг. Их Эзэн Лихайд гэр бүлээ аваад Ерусалимаас явахыг хэлдэг. Лихай болон түүний гэр бүл аглаг буйд тийш явдаг.
 - б. 1 Нифай 3–4. Нифай болон түүний ах нар Лэбэнээс гуулин ялтсуудыг авахаар Ерусалимд буцаж очдог.
 - в. 1 Нифай 5. Нифай болон түүний ах нар ялтсуудыг гэр бүлийнхэн дээрээ авчирдаг. Эдгээр ялтсууд Лихайн гэр бүлийнхэнд хэл, удмын бичиг, Бурханы сургаал, зарлигуудыг үр удамдаа хадгалж үлдээх боломжийг олгодог.
 - г. 1 Нифай 7. Нифай болон түүний ах нар Ишмэил болон түүний гэр бүлийг өөрсөдтэйгөө нэгдэн аглаг буйд руу явахыг ятгахаар Ерусалим руу буцдаг.
2. Нэмж унших зүйл: Мозая 1:3–7; Алма 3:11–12.
3. Ангийн гишүүнээс Лэбэнээс гуулин ялтсуудыг авахад Нифай болон түүний ах нарын гаргасан оролдлогуудыг дүгнэж үзэхэд бэлтгэхийг урьдчилан хүс (1 Нифай 3:9–4:38).
4. Дараах материалууд байгаа бол тэдгээрийг хичээлдээ хэрэглэхээр бэлтгэ:
 - а. Лихай Ерусалим Дахь Хүмүүсийн Тухай Зөгнөн Хэлсэн нь (62517; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 300) ба Лихайн Гэр Бүл Ерусалимыг Орхин Явсан нь (62238; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 301) зургууд.
 - б. Ангийн гишүүн бүрт бал эсвэл харандаа, цаас бэлтгэ.
5. Хичээл эхлэхийн өмнө 9-р хуудсан дахь бүдүүвчинд хэрэглэсэн дүгнэлт, судрын ишлэлүүдийг самбарт жагсааж бич.

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Ангийн гишүүдийг тэдний амьдардаг хот устгагдах гэж байгаа бөгөөд тэд яаралтай явах ёстой гэдгээ дөнгөж олж мэджээ гэж төсөөлөхийг хүс.

- Та нар энэ мэдээг сонсоод ямар сэтгэгдэлтэй байх вэ? Та нар юу хийх вэ?
- Хэрэв энэ мэдээллийг Бурханы бошиглогч хэлсэн бол та нарын ямар сэтгэгдэлтэй байх, юу хийхэд ялгаа гарах уу?

Энэ хичээл бол хот нь удахгүй устгагдах гэж байгаа болохоор Ерусалимд байгаа гэрээ орхисон Лихай болон түүний гэр бүлийн тухай юм гэдгийг тайлбарла. Ерусалимаас явсныхаа дараа тэд хаашаа явж, юу хийсэн тухай энэ хичээлд ярилцана.

Судрын Ярилцлага ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Лихай Ерусалимыг орхиж, гэр бүлээ аглаг буйд тийш авч явдаг.

1 Нифай 1–2-ыг ярилц. Сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг ангийн гишүүдээс урь.

- Мормоны Номонд дүрслэгддэг анхны үйл явдлуудын нэг нь Лихай болон түүний гэр бүл Ерусалимыг орхидог явдал юм. Ямар нөхцөл байдал ийнхүү орхиж явахад хүргэсэн бэ? (1 Нифай 1:4–15, 18–20; 2:1–3-ыг үз. Та Лихайн бошиглож байгаа зургийг хэрэглэж байгаа бол үүнийг одоо үзүүл.)
- Ерусалимын хүмүүс Лихайн болон бусад бошиглогчдын захиасыг яагаад эсэргүүцсэн бэ? (1 Нифай 1:19–20; 2:12–13; 16:1–2-ыг үз.) Өнөөдөр зарим хүмүүс яагаад Их Эзэний болон Түүний үйлчлэгчдийн эсрэг босдог вэ? Нифай эцгийнхээ захиасыг хэрхэн хүлээж авсан бэ? (1 Нифай 2:16, 19-ийг үз.) Бид бошиглогчдын сургаалуудад зүрх сэтгэлээ илүү хүлээцтэй байлгах тухай Нифайгаас юу сурч болох вэ?
- Их Эзэн Нифайд зарлигийг нь дуулгавартай дагавал юу амласан бэ? (1 Нифай 2:19–20, 22-ыг үз.) Бослого гаргавал Лэмэн, Лэмүэл хоёрт юу тохиолдоно гэж Их Эзэн амласан бэ? (1 Нифай 2:21, 23–24-ийг үз.) Эдгээр амлалт нэг бүр бидэнд хэрхэн хамаардаг вэ?
- Лихай Ерусалимаас яваад гэр бүлээ ямаршуухан газарт авчирсан бэ? (1 Нифай 2:2-ыг үз. Та Лихайн гэр бүл Ерусалимаас явж байгаа зургийг хэрэглэж байгаа бол үүнийг одоо үзүүл.) Тэд явахдаа юугаа орхисон бэ? (1 Нифай 2:4-ийг үз.) Орон гэр, эд хөрөнгө, найз нөхдөө орхих болсондоо Лихайн гэр бүлийнхэн ямар сэтгэгдэлтэй байсан гэж та нар бодож байна вэ? Их Эзэнд дуулгавартай байхын тулд та нар ямар золиослолыг хийж байсан бэ? Тийм золиослолыг хийснээрээ та нар хэрхэн адислагдсан бэ?
- Аглаг буйд гурван хоногийг өнгөрөөснийхөө дараа Лихай тахилын ширээ босгож, Их Эзэнд талархсан (1 Нифай 2:6–7; мөн 1 нифай 5:9; 7:22-ыг үз.) Хүнд хэцүү нөхцөлд ч гэсэн талархах сэтгэлээ бид хэрхэн хөгжүүлж чадах вэ?
- Лихай Их Эзэнийг дуулгавартай дагаж, Ерусалимаас явсан нь ямар чухал адислалыг авчирсан бэ? (Ангийн гишүүдийн хариултуудыг самбарт бич. Хариултанд Лихайн болон Ишмэилийн гэр бүлүүд сөнөхөөс аврагдсан; Израилын угсааныхан амлагдсан нутаг руу удирдуулсан; Мормоны Ном, Есүс Христийн бас нэгэн гэрч өгөгдсөн зэрэг нь орж болно.)

2. Нифай болон түүний ах нар гуулин ялтсуудыг авахаар Ерусалимд буцаж очдог.

1 Нифай 3–4-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Лихай хөвгүүдээ Ерусалим руу яагаад буцаасан бэ? (1 Нифай 3:1–4-ийг үз.) Лэмэн, Лэмүэл хоёр буцаж явах болсондоо хэрхэн хандсан бэ? (1 Нифай 3:5-ыг үз.) Нифай хэрхэн хандсан бэ? (1 Нифай 3:7-г үз.) Хэрэв та нараас ингэж явахыг хүссэн бол та нар хэрхэн хандах байсан гэж бодож байна вэ? Их Эзэн та нараас үүнийг хүссэн бол ямар ялгаатай байх вэ?
- Лихайн гэр бүл гуулин ялтсуудыг яагаад олж авах хэрэгтэй байсан бэ? (1 Нифай 3:3, 19–20; 4:15–16; мөн 1 Нифай 5:21–22; Мозая 1:3–7-г үз.)

Ялтсуудыг авахад Нифай болон түүний ах нарын гаргасан оролдлогуудыг урьдчилан даалгасан ангийн гишүүнээр дүгнэн яриул (1 Нифай 3:9–4:38).

- “[Бид] хийвэл зохих зүйлүүдийг урьдчилан мэдэхгүй учир Сүнсэнд хөтлөгдөх” хэрэгтэй болох ямар нөхцөлүүд байдаг вэ? (1 Нифай 4:6). “Гэсэн хэдий ч би урагшлан явсан” хэмээн Нифайн хэлсэн үгнээс бид юу сурч болох вэ? (1 Нифай 4:7).
- Нифай Лэбэнийг алахдаа яагаад дурамжхан байсан бэ? (1 Нифай 4:10-ыг үз.) Лэбэнийг алах ёстой гэдэгтээ Нифай хэрхэн итгэсэн бэ? (1 Нифай 4:11–18-ыг үз.)
- Ангийн гишүүнээр 1 Нифай 3:7-г чангаар уншуул. Хийхийг зарлиглуулсан зүйлээ хийхэд нь Их Эзэн Нифайн “замыг” хэрхэн “бэлтгэж” өгсөн бэ? Зарлигуудыг нь дагахад Их Эзэн та нарт замыг хэрхэн бэлтгэж өгдөг байсан бэ?
- Нифай болон түүний ах нар яагаад Зорамыг өөрсөдтэйгөө хамт аглаг буйд руу буцаж очихыг хүссэн бэ? (1 Нифай 4:35–36-г үз.) Зорамыг Нифай болон түүний ах нартай нэгдэхэд юу итгүүлсэн бэ? (1 Нифай 4:31–34-ийг үз. Лихайн цаг үеийн хүмүүсийн дунд тангараг нь нандин зүйл байсан гэдгийг тайлбарла. Нифайг тангарагаа хэзээ ч таслахгүй гэдгийг Зорам мэдэж байсан.) Хэлсэн үгэндээ хүрдэг хүмүүс гэдгээ мэдэгдэж байх нь бидэнд яагаад чухал вэ?

Лэмэн, Лэмүэл хоёр аглаг буйд руу явж, дараа нь Ерусалим руу гуулин ялтсуудыг авахаар буцахдаа эцгийгээ дуулгавартай дагасан ч гэсэн тэд гэр бүлээрээ аялж явахдаа ахин дахин эсэргүүцэн бувтнаж байсан гэдгийг цохон тэмдэглэ. Нөгөөтэйгүүр Нифай, Сэм хоёр тохиолдсон явдал бүртээ итгэлтэй, дуулгавартай байсан. Сэмийн тухай их дурьдаагүй байдаг ч гэсэн сударт түүнийг Нифайн адил итгэлтэй, дуулгавартай нэгэн байсан гэж өгүүлдгийг та тайлбарлаж болно (1 Нифай 2:17; 8:3).

Ангийн гишүүдийн тал хэсгийг нь самбар дээрх “Нифай” гэж бичсэний дор жагсаасан судрын хэсгүүдийг уншихыг урь. Тэд нараар Нифайн зан чанарыг тодорхойлсон үгс буюу өгүүлбэрийг хайлга. Ангийн бусад гишүүдээр судрын үлдсэн хэсгийг уншуулж, Лэмэн, Лэмүэл хоёрын зан чанарыг тодорхойлсон үг, өгүүлбэрүүдийг хайлга. Дараа нь юу олсныг нь ангийн гишүүдээр хэлүүл. Самбар дээр шүлэг тус бүрийн агуулгыг товчхон бич (жишээнүүдийг дор байгаа бүдүүвчинд өгөв; та өгөгдсөн үгсийг яг байгаагаар нь хэрэглэх хэрэггүй).

НИФАЙ	ЛЭМЭН БА ЛЭМҮЭЛ
1:1 Түүнд “сайн эцэг, эх” бий гэдгийг мэддэг байсан	2:11 Эцгийнхээ эсрэг бувтнасан
2:16 Эцгийнхээ хэлсэн үгэнд итгэсэн	2:13 Лихайн бүх үгэнд итгээгүй
2:16, 19 Ойлгохын тулд Их Эзэнд хандсан	2:12 “Бурханы . . . үйлсийг мэддэггүй байсан”
3:7 Их Эзэний тушаасныг явж, гүйцэтгэхийг хүсэж байсан.	3:5 Их Эзэн “хэцүү зүйлийг” хүслээ гэж гомдоллосон
3:15 Ялтсуудгүйгээр буцаж очихоос татгалзсан	3:14 Нэг оролдсоныхоо дараа бууж өгөхийг хүссэн
4:1, 3 Их Эзэнийг “Лэбэнээс илүү агуу” гэдгийг мэдэж байсан	3:31 Их Эзэн Лэбэнийг тэдэнд авчирч өгнө гэдэгт эргэлзсэн

Бүдүүвчийг гүйцэд бичсэний дараа асуултуудыг ярилц:

- Нифай хүчтэй бөгөөд тууштай итгэлээ хэрхэн харуулсан бэ? Бид түүний жишээг хэрхэн дагаж болох вэ?
- Лэмэн, Лэмүэл хоёр яагаад эсэргүүцэж бувтнадаг вэ? (1 Нифай 2:11–12-ыг үз.) Тэд Бурханы үйлийг яагаад мэдэх боломжгүй байсан бэ? (1 Нифай 2:18-ыг үз.)

3. Нифай болон түүний ах нар гуулин ялтсуудыг гэр бүлдээ авчирдаг.

1 Нифай 5-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Лихай, Сариа хоёр дөрвөн хүүгээ гуулин ялтсуудыг авчрахад яаж хандсан бэ? (1 Нифай 5:1–9-ийг үз.) Тэд нарын эргэж ирсэн явдал Сариагийн гэрчлэлийг хэрхэн батжуулдаг вэ? (1 Нифай 5:8-ыг үз.)
- Гуулин ялтсуудад юу агуулагдаж байсан бэ? (1 Нифай 5:10–16; 13:23-ыг үз. Үүнд Мосегийн 5 ном, хаан Зэдэкая хүртэлх [ойролцоогоор МЭӨ 600] Жүүдүүдийн тэмдэглэл, ариун бошиглогчдын бошиглолууд болон Лихайн гэр бүлийн удмын бичиг багтдаг.)
- Гуулин ялтсуудын тухай Лихай юу бошиглосон бэ? (1 Нифай 5:17–19-ийг үз.) Эдгээр бошиглолууд хэрхэн биелж байна вэ?

4. Ишмэил болон түүний гэр бүлийг авчрахаар Нифай ах нартайгаа Ерусалимд буцаж ирдэг.

1 Нифай 7-гоос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Гуулин ялтсуудыг авчрангуутаа Нифай болон түүний ах нар Ерусалим руу яагаад буцсан бэ? (1 Нифай 7:1–2-ыг үз.) Ишмэил болон түүний гэр бүлийг Лихайн гэр бүлтэй нэгдэхэд хэрхэн ятгасан бэ? (1 Нифай 7:4–5-ыг үз.)
- Лэмэн, Лэмүэл болон Ишмэилийн зарим хүүхдүүд аглаг буйд аялж байх үедээ яагаад эсэргүүцэн босч байсан бэ? (1 Нифай 7:6–7-г үз.) Тэд Ерусалимд буцаж очихыг яагаад хүссэн гэж та нар бодож байна вэ? Хэрэв тэд аглаг буйд аяллаа үргэлжлүүлж, Их Эзэнд итгэлтэй байвал юу тохиолдоно гэж Нифай

хэлсэн бэ? (1 Нифай 7:13-ыг үз.) Тэд Ерусалимд үлдэхээр буцаж очвол юу тохиолдоно гэж тэр хэлсэн бэ? (1 Нифай 7:13–15-ыг үз.)

- Нифай ах нартайгаа харьцахдаа ямар зан чанараа харуулсан бэ? (1 Нифай 2:17–18 ба зарим жишээг 7:21-ээс үз.) Эдгээр чанарыг бид гэр бүлийнхэн, бусадтай харьцахдаа хэрхэн харуулж болох вэ?

Дүгнэлт

Лихай болон Нифайн дуулгавартай байх хүслийн ачаар сая сая хүн адислагдсан. Ангийн гишүүдийг үргэлж “явж, Их Эзэний тушаасан зүйлсийг хийж” байхад уриал (1 Нифай 3:7).

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. “Буянт сайн эцэг, эхээс мэндэлсэн” (1 Нифай 1:1)

- “Буянт сайн эцэг, эхийн” хүүхдүүдийнхээ төлөө хүлээсэн ямар үүрэг хариуцлагууд байдаг вэ? (1 Нифай 1:1-ийг үз.) Эцэг эхчүүд Лихай, Сариа хоёроос эдгээр үүргүүдийг хэрхэн биелүүлэх тухай юу сурч авч болох вэ?

2. Хүн бүр зовлон бэрхшээлтэй тулгардаг

Дараах үгсийг самбарт бич: *сүнслэг, зоригтой, санаа зовсон, хүчтэй, баяр баясгалантай, итгэлтэй, гунигтай, итгэмтгий, зориггүй, хичээнгүй, тэвчээртэй, энэрэнгүй.*

Ангийн гишүүдээр эдгээр үгсийн аль нь Нифайг дүрсэлдгийг сонгуул. Тэдний сонгосон үгсийг дугуйлж, тэрхүү зан чанарыг харуулдаг Нифайн тухай үйл явдлыг товч яриул.

Дараа нь эдгээр үгс бүгд Нифайг амьдралынх нь янз бүрийн цаг үед тодорхойлдог гэдгийг тайлбарла. Нифай итгэлтэй хүн байсан бөгөөд зарлигуудыг дуулгавартай дагахад бүхнээ зориулсныхаа төлөө дурсагдаж байдгийг онцлон тэмдэглэ. Нифай ч гэсэн зарим тохиолдолд санаа зовж, зориггүй, гунигтай болдог байсан. Бид бошиглогчид болон Сүмийн бусад удирдагчдад зөвхөн эерэг явдлууд тохиолдож, хэзээ ч хүнд хэцүү үетэй таардаггүй гэж заримдаа боддог гэдгийг цохон тэмдэглэ. Гэвч тэд бидэнтэй адил зовлон бэрхшээл, зүдгүүрийг тууж байдаг.

- Бошиглогчид болон Сүмийн бусад удирдагчдад бас саад тотгор тулгардаг гэдгийг мэдэх нь бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- Хэдийгээр Нифай “[өөрийн] амьдралынхаа турш өчнөөн зүдгүүрийг туулсан” боловч тэрээр “Их Эзэний өндөр их ээл хишгийг хүртсэн” гэдгээ мэдэж байсан (1 Нифай 1:1). Өчнөөн их зүдгүүрийг туулавч Их Эзэний ээл хишгийг хүртэх нь яаж боломжтой болдог вэ? Зовлон зүдгүүр бидэнд адислалыг хүртэхэд хэрхэн тусалдаг вэ? (Ангийн гишүүд хариултаа ангийнхантайгаа хуваалцахыг хүсэхгүй байгаа бол энэ асуултыг дотроо тунгаан бодохыг урь.)

3. Нифайн тэмдэглэлийн агуулга

- 1 Нифай 6-д Нифай тэмдэглэлдээ юу бичсэнээ тайлбарласан байдаг. Тэмдэглэл хөглөх зорилго нь юу байсан гэж Нифай хэлсэн бэ? (1 Нифай 6:3–4-ийг үз. Абрахам, Исаак, Иаковын Бурхан бол Есүс Христ гэдгийг тайлбарла.) Нифайн бичсэн зүйлс та нарыг Христэд ирэхэд хэрхэн тусалсан бэ?

Гэрчлэлээ, түүнчлэн өөр бусад сүнслэг явдлууд, бодол санаа, сэтгэгдлээ өдрийн тэмдэглэл дээрээ бичихийг ангийн гишүүдэд уриал.

Зорилго Ангийн гишүүд амьдралын модны тухай үзэгдлийн бэлэгдлийг ойлгож, эдгээр бэлэгдлийг амьдралдаа хэрэглэхэд туслах болно.

Бэлтгэл Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир: 1 Нифай 8–11; 12:16–18; 15.

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Судрууд дээр бэлэгдлийн зүүд ба үзэгдлүүд олон бичигдсэн байдгийг тайлбарла. Дараа нь дараах жишээнүүдийг хуваалцаж, бэлэгдэл нэг бүрийн утгыг тайлбарлахыг ангийн гишүүдээс хүс:

- а. Хаан Небухаднезар хүний нэг том биет буюу хөшөөг зүүдэлсэн. Хүний биеийн хэсэг нэг бүр нь өөр өөр материалаар хийгдсэн байсан. Чулуу уг биетийг устгаж, дэлхийг дүүргэн уул болдог. (Даниел 2:31–45, мөн С ба Г 65:2-ыг үз. Биетийн янз бүрийн хэсгүүд нь дэлхий дээр ноёрхож байсан хаант улсуудыг төлөөлдөг. Чулуу нь хожмын өдрүүд дэх бусад бүх хаант улсуудыг орлох Бурханы хаант улсыг төлөөлдөг.)
- б. Фараон долоон туранхай, муухай үхэр, долоон тарган, сайхан үхрийг идэж байхыг, мөн долоон хорчийсон нарийхан түрүү, долоон өтгөн сайхан тариан түрүүг залгиж байгааг зүүдэлжээ. (Эхлэл 41:17–31-ийг үз. Долоон тарган, сайхан үхэр, долоон өтгөн, сайхан тариан түрүү нь Египетэд долоон жил сайхан цэцэглэж хөгжих амьдралыг төлөөлдөг. Долоон туранхай, муухай үхэр, долоон хорчийсон нарийхан түрүү нь элбэг дэлбэг жилүүдийн дараа нүүрлэх долоон жилийн ган ганчгийг бэлэгддэг.)
- в. Төлөөлөгч Паул үзэгдэлдээ тэнгэрээс нэгэн том бүтээлэг бууж иртэл, дээр нь цэвэр бус амьтад байсан бөгөөд түүнд үүнийг алж, идэхийг тушааж байхыг үзжээ (Үйлс 10:9–16, 28, 34–35-ыг үз. Цэвэр бус амьтад нь одоо сайн мэдээг заалгах гэж байгаа харийнхныг төлөөлдөг.)

Өнөөдрийн хичээл дээр Лихай, Нифай нарын үзсэн амьдралын модны тухай үзэгдлийг өгүүлдэг, сударт дүрсэлсэн өөр бэлэгдлийн зүүдний тухай ярилцана гэдгийг тайлбарла. Олон зүүд буюу үзэгдлүүд нь зөвхөн тодорхой нэг цаг үеийн тодорхой нэг хүмүүстэй холбоотой, үхэр, тариан түрүүний тухай Фараоны зүүд шиг байхад амьдралын модны тухай үзэгдэл нь Бурханы хүүхэд нэг бүрт хамаардгаараа өөр юм.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ


Та дараах судрын хэсгийг заахдаа эдгээрт агуулагддаг бэлэгдлүүд хэрхэн бидний амьдралд хэрэглэгддэгийг ярилц. Ангийн гишүүдийг эдгээр

бэлэгдлүүдийг харуулсан зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг уриал.

1. Амьдралын модны тухай үзэгдлийн бэлэгдлүүд

Лихай үзэгдэл үзээд, энэ тухайгаа гэр бүлийнхэндээ хэлдэг гэдгийг тайлбарла (1 Нифай 8:2). Үзэгдэлд үзсэн зүйлийнхээ тухай аавыгаа ярихыг Нифай сонсоод тэр бас “[тэдгээр] зүйлүүдийг харж, бас сонсож, мэдэхийг” хүсдэг (1 Нифай 10:17; мөн заах нэмэлт санааны нэгдүгээрийг үз). Нифай Есүс Христэд итгэсэн учраас хүсэл нь биелсэн (1 Нифай 11:6). Өөрт тохиолдсон явдлаа Нифай бичиж тэмдэглэснээс нь бид үзэгдлийн тайллыг мэдэж авдаг.

Амьдралын модны тухай үзэгдлийг ярилц. Та Лихай болон Нифайн харсан зүйлийн тухай ярилцахдаа самбар дээр үзэгдлийн гол хэсгийг зур (эсвэл ангийн нэг буюу түүнээс дээш гишүүдээр зуруул). Зурж дууссаны дараа энэ нь нэг иймэрхүү харагдах ёстой:



Амьдралын мод ба үүний үр жимс

Ангийн гишүүнээр 1 Нифай 8:2–10-ыг уншуул. Дараа нь самбарт мод болон үүний үр жимсийг зур (эсвэл ангийн гишүүнээр зуруул).

- Нифай амьдралын модыг үзсэнийхээ дараа үүний тайллыг мэдэхийг хүсдэг (1 Нифай 11:8–11). Мод юуг төлөөлдөг тухай тэр юу мэдэж авсан бэ? (1 Нифай 11:21–25-ыг үз.) Бурханы хайрыг илүү сайн ойлгоход түүнд тусалсан ямар зүйлийг Нифай харсан бэ? (1 Нифай 11:13–21, 24, 26–33-ыг үз. Тэр Есүс Христийн төрөлт, үйлчлэл, Цагаатгалыг харсан.)

Ангийн гишүүнээр Иохан 3:16-г чангаар уншуул. Тэнгэрлэг Эцэг “цорын ганц хайрт Хүүгээ өгөхдөө” бидний төлөө гэсэн Өөрийн хайрын гүн ихийг харуулсныг нь онцлон тэмдэглэ. Цагаатгал нь бидний төлөө гэсэн Есүс Христийн агуу хайрын нотолгоо юм.

Ахлагч Жэффри Р.Холланд амьдралын мод нь Есүс Христийг бэлэгддэг гэж заасан байдаг. Тэрээр: “Христийн дүр төрх, мод хоёр нь салшгүй холбоотой юм. . . . Мормоны Номын хамгийн тэргүүнд . . .

Христийг мөнхийн амьдрал ба баяр баясгалангийн эх сурвалж, тэнгэрлэг хайрын амьд нотолгоо, Бурхан Израилын угсаатай, үнэндээ хүмүүний бүхий л гэр бүлтэй хийсэн гэрээгээ биелүүлэхдээ тэд бүгдийг

мөнхийн амлалтад нь буцаан авчирснаар гүйцэлдүүлэх зам мөн хэмээн дүрсэлдэг” гэж хэлсэн (*Christ and the New Covenant* [1997], 160, 162).

- Бурханы хайр бидний амьдралд ямар нөлөө үзүүлдэг вэ? Бидэнд өгсөн Бурханы хайрыг бид хэрхэн илүү бүрэн дүүрэн таньж чадах вэ?
- Модны жимс юуг төлөөлдөг вэ? (1 Нифай 15:36; С ба Г 14:7-г үз.)
- Лихай, Нифай нар амьдралын мод болон үүний жимсийг хэрхэн дүрсэлсэн бэ? (Ангийн гишүүнээр дор жагсааж бичсэн хэсгүүдийг олуулахын тулд зохих шүлгүүдээс нь харуул. Ангийн гишүүд тэдгээрийг олсны дараа самбарт бич. Шаардлагатай бол өгүүлбэрүүдийг товчилж бич.)
 - а. “Урьд өмнө нь миний амсаж асан бүхнээс дээгүүр тэргүүн амттай” (1 Нифай 8:11)
 - б. “Цагаан, . . . бүхнээс үлэмж цагаан” (1 Нифай 8:11; мөн 1 Нифай 11:8-ыг үз)
 - в. “Бүхий л жимснээс дээгүүр дур булаам” (1 Нифай 8:12; мөн 15:36-г үз)
 - г. “Үзэсгэлэн нь . . . бүх үзэсгэлэнгээс үлэмж” байх (1 Нифай 11:8)
 - д. “Бүхнээс эрхэм дээд”; “хамгийн үнэт” (1 Нифай 11:9; 15:36)
 - е. “Бодгальд хамгийн их баясгалант” (1 Нифай 11:23; мөн 1 Нифай 8:10-ыг үз)
 - ё. “Бурханы бүх бэлгүүдээс хамгийн агуу” (1 Нифай 15:36)

Мөнхийн амьдрал нь бидний хүртэж болох “хамгийн сайхан,” “хамгийн үнэт” адислал юм гэдгийг онцлон тэмдэглэ. Биднийг гэсэн Бурханы хайраар энэ адислал Есүс Христийн Цагаатгалаар дамжин бидэнд ирдэг.

- Лихай үзэгдэлдээ модны жимснээс идсэнийхээ дараа юу хүссэн бэ? (1 Нифай 8:12-ыг үз.) Бид өөрсдийн хайрладаг хүмүүсээ Аврагчид улам ойртуулж, мөнхийн амьдралын амлалтыг хүртэхэд хэрхэн тусалж чадах вэ?

Төмөр бариул

Ангийн гишүүнээр 1 Нифай 8:19–20-ийг уншуул. Дараа нь төмөр бариул болон мод руу хөглөх замыг зур (эсвэл ангийн гишүүнээр зуруул).

- Төмөр бариул юуг төлөөлдөг вэ? (1 Нифай 11:25; 15:23–24-ийг үз.) Бид Бурханы үгийг хаанаас олж болох вэ? (Судраас, хожмын үеийн бошиглогчдын сургаалаас, Ариун Сүнсний өдөөлтөөс.) Христэд ирэхэд Бурханы үг бидэнд хэрхэн тусалдаг вэ? Энэ нь биднийг мөнхийн амьдралд хүрэх зам дээр хэрхэн үлдээж чаддаг вэ?

Буртаглагдсан уст гол, харанхуй манан ба агуу хийгээд нүсэр барилга

Ангийн гишүүнээр 1 Нифай 8:13, 23, 26–27-г уншуул. Дараа нь гол, харанхуй манан, агуу хийгээд нүсэр барилга зур (эсвэл ангийн гишүүнээр зуруул).

- Буртаглагдсан уст гол юуг төлөөлдөг вэ? (1 Нифай 12:16; 15:26–29-ийг үз.)
- Харанхуй манан юуг төлөөлдөг вэ? (1 Нифай 12:17-г үз.) Харанхуй манангийн нөлөө нь юу вэ? (1 Нифай 8:23; 12:7-г үз.) Сатан биднийг яагаад Бурханы хайранд, Есүс Христийн Цагаатгалд, Бурханы үгэнд сохор байхыг хүсдэг вэ? Сатан ямар замаар бидний нүдийг сохор болгохыг оролддог вэ?
- “Голын эргийн дагуу сунан үргэлжилсэн” төмөр бариул (1 Нифай 8:19) нь давчуу бөгөөд нарийн зам, буртаглагдсан ус хоёрын дунд хамгаалагч болж

байдаг. Энэ нь мөн үзэгдэлд гардаг хүмүүсийг харанхуй манан дунд байхад барьж байх ямар нэгэн ном болдог (1 Нифай 8:24, 30). Энэ нь Бурханы үг бидэнд хэрхэн тусалдаг тухайд юуг заадаг вэ?

- Агуу хийгээд нүсэр барилга юуг төлөөлдөг вэ? (1 Нифай 11:34–36; 12:18-ыг үз.) Барилга нь “агаарт тогтсон . . .” байсан нь яагаад чухал ач холбогдолтой вэ? (1 Нифай 8:26-г үз. Барилга нь бат бөх суурьгүй байсан гэдгийг тайлбарла.) Бардамнал нь хүний мөнхийн амьдралыг авахад хэрхэн саад болдог вэ?
- Үзэгдэлд зарим хүмүүс нь жимснээс амсдаг боловч агуу хийгээд нүсэр барилгад байсан хүмүүс тэднийг шоолсон тул ичдэг (1 Нифай 8:26–28). Мөрдлөг хавчлагын эсрэг зогсох хүчийг бид хэрхэн олж авдаг вэ?

2. Амьдралын модны тухай үзэгдэл дэх хүмүүс

Лихай үзэгдэлдээ “тоогүй олон хүмүүсийг” харсан гэдгийг тайлбарла (1 Нифай 8:21). Эдгээр хүмүүсийг мод болон жимсийг хайж байгаад нь үндэслэн дөрвөн төрөлд хувааж болно. Ангийн гишүүдийг дор үзүүлсэн хэсгийг хэрэглэн тэдгээр дөрвөн төрлийг тогтоож, тайлбарлахад тусал. (Та ангийн гишүүдийг дөрвөн хэсэгт хувааж, хэсэг тус бүрт нэг судрын хэсгийг уншуулахаар өгч, дараа нь хэсгүүдэд гарсан хүмүүсийн үйлдлийг тайлбарлуул.)

- 1 Нифай 8:21–23. (Замаар явж эхэлдэг боловч харанхуй манан дунд төөрч алга болсон хүмүүс.)
 - 1 Нифай 8:24–28. (Модонд хүрч, жимсэнд хүртлээ төмөр бариулаас барьж явдаг боловч ичиж, унадаг хүмүүс.)
 - 1 Нифай 8:30. (Модонд хүрч, жимсэнд хүртлээ төмөр бариулаас барьж итгэлтэй үлддэг хүмүүс.)
 - 1 Нифай 8:31–33. (Зам дээр огт гаралгүй шууд агуу хийгээд нүсэр барилга руу явдаг хүмүүс.)
- Эдгээр төрлүүд өнөөдөр дэлхий дээр хэрхэн тодорхой харагддаг вэ? (Жишээ нь, мөнхийн амьдралыг авахыг хүсэж байна гэдэг боловч материаллаг эд баялаг буюу ертөнцийн тааламж зэрэг бусад зүйлд анхаарлаа сарниулдаг хүмүүс нь замаар явж эхэлдэг боловч дараа нь алга болсон хүмүүстэй адил юм.)
 - Үзэгдэлд хүмүүс төмөр бариулаас барьж явахдаа эсвэл амьдралын модыг орхиж явахдаа ямар замаар явж байсан бэ? (1 Нифай 8:28, 32; 12:17-г үз.) Ийм замуудаар явсан хүмүүст юу тохиолддог вэ? Хэрэв бид “хориглогдсон”, “этгээд” эсвэл “өргөн” зам руу явж байвал хэрхэн давчуу бөгөөд нарийн зам дээр буцаж гарч чадах вэ?
 - Давчуу бөгөөд нарийн зам дээр зогсож үлдэхийн тулд бид ямар зүйлсийг хийх ёстой вэ? Бид бусдыг энэ зам дээр зогсож үлдэхэд нь хэрхэн тусалж чадах вэ?

Дүгнэлт

Судар дээрээ дараах үгсийг зурж тэмдэглэхийг ангийн гишүүдэд санал болго: *эхэлсэн* (1 Нифай 8:22), *барьж* (1 Нифай 8:24), *барьсаар* (1 Нифай 8:24), *тууштай* (1 Нифай 8:30). Эдгээр үгс нь амьдралын модонд хүрэхийн тулд бид юу хийх ёстойг ойлгоход бидэнд тусалдаг гэдгийг цохон тэмдэглэ:

бид давчуу бөгөөд нарийн замаар явж эхлэн, төмөр бариулаас барьж, мөн үүнээс барьсаар байж, мод руу тууштай урагшлах ёстой.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. “Хичээнгүй хайгч тэр олох болно” (1 Нифай 10:19)

- Нифай аавынхаа үзэгдлийн тухай сонссоны дараа юу хийхийг хүссэн бэ? (1 Нифай 10:17-г үз.) Тэрээр энэ хүслээ биелүүлэхийн тулд юу хийсэн бэ? (1 Нифай 10:17–19; 11:1–6-г үз.) Сайн мэдээний үнэнүүдийг ойлгохоор эрэлхийлэхэд бидэнд Нифайн жишээ хэрхэн тусалж чадах вэ? (Сайн мэдээний үнэнүүдийг ойлгоход Ариун Сүнс тэдэнд тусалсан тухай явдлаасаа хуваалцахыг ангийн гишүүдээс хүс.)
- Эцгийнхээ үзсэн үзэгдлийн тухай сонсоод Лэмэн, Лэмүэл хоёрын хүлээж авсан байдал нь Нифайнхаас юугаараа ялгаатай вэ? (1 Нифай 15:1–2-ыг үз.) Лихайн заасан үнэнүүдийг Лэмэн, Лэмүэл хоёр яагаад ойлгож чадахгүй байсан бэ? (1 Нифай 15:3, 8–1-ийг үз.)

2. “Бурханы хүлцлийг мэдэх үү та?” (1 Нифай 11:16)

Ангийн гишүүдэд “Бурханы хүлцэл” (1 Нифай 11:16, 26) гэдэг үгийг ойлгоход нь туслахын тулд энэ хэллэг дэх хүлцэл гэдэг үг нь сайн дураараа доогуур түвшинд болох гэсэн утгатай юм гэж тайлбарла. Дараа нь Ахлагч Брүс Р.МакКонкийн удаах мэдэгдлийг хуваалц.

“Бурханы (Эцэг гэсэн үг) хүлцэл нь . . . тэр мөнх бус эмэгтэйгээс төрсөн мөнх бус үр удмын, төрсөн бөгөөд жинхэнэ Эцэг нь болсон явдлаас бүрддэг. Бурханы (Хүү гэсэн үг) хүлцэл нь . . . тэрбээр (Есүс Христ) мөнх бус байдлын зовлон ‘уруу таталт, мөн биеийн өвчин, өлсгөлөн, цангаа, мөн зүдрэлийг энэ нь үхэлд хүргэхээс бусдаар бол, бүр хүмүүний тэвчиж чадахаас илүүг тэвчих’ (Мозая 3:5–8), мөнх бус байдлын саад тотгорыг туулсан явдлаас бүрддэг” (*Mormon Doctrine*, 2nd ed. [1966], 155).

3. “Тэд элэглэх байдалтай байх ажээ” (1 Нифай 8:27)

Ангийн гишүүдийг агуу хийгээд нүсэр барилгын тухай ярилцаж байхад барилга дотор байсан хүмүүс “элэглэх байдалтай” байсан гэдгийг цохон тэмдэглэ. Энэхүү элэглэх байдал нь зарим хүмүүсийг ичингүйрэхэд хүргэж, замаасаа алдуурч, төөрөлддөг (1 Нифай 8:27–28).

- Бидний бусдад хандах байдал тэднийг төөрөлдөх явдалд ямар байдлаар хүргэж болох вэ?

Хариуцлага бүхий хувь хүмүүс нь өөрсдийнхөө үйлдэлд хариуцлага хүлээдэг гэдгийг, мөн бусдад хандах бидний байдал тэднийг зөв шударга чармайлтад нь батжуулж эсвэл тэдний сэтгэлийг гонсойлгодог гэдгийг онцлон тэмдэглэ. Ангийн гишүүдийг нэг нэгнийгээ зоригжуулж, бусдыг хэзээ ч бүү шоглож эсвэл шүүмжилж бай гэж уриал.

“Би Сүнсэнд Автагдсан Байх Үедээ Харсан Тэдгээр Зүйлүүд”

Хичээл

4

1 Нифай 12–14

Зорилго

Ирээдүйн тухай Нифайн үзсэн үзэгдэл, мөн үүнд гардаг сэрэмжлүүлэг болон амлалтууд өнөө үед бидэнд хэрхэн хамаардгийг ойлгоход ангийн гишүүдэд туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - 1 Нифай 12. Нифай үзсэн үзэгдэлдээ өөрийн үе удам, ах нарынхаа үе удмыг хардаг. Тэр тэдний нэг нэгэнтэйгээ дайтахыг, мөн ёсон бусыг үйлдэгчид Аврагчийн айлчилж ирэхээс өмнө устгагдахыг хардаг. Тэд Аврагчийн айлчлалын дараа хэсэг хугацаанд зөв шударга амьдардаг боловч бусармаг байдалд унадгийг хардаг.
 - 1 Нифай 13. Нифай үзэгдэлдээ нэгэн агуу хийгээд жигшүүрт сүмийн үүсэл, Америкийн колоничлогдолт, Урвалт, хожмын өдрүүдэд сайн мэдээ дахин сэргэхийг хардаг.
 - 1 Нифай 14. Итгэлтэй үлдсэн Харийнханд амласан адислалууд, итгэлгүй үлдсэн Харийнханд ирэх хараал болон Бурханы Хургын Сүм агуу хийгээд жигшүүрт сүмийг эцэст нь ялахыг Нифай үзэгдлээр үздэг.
2. Хэрэв та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглэвэл том цаас юмуу ватум цаасан дээр эсвэл самбар дээр он тооллын шугам зурж бэлтгэ.

Хичээлийг


Баяжуулах

Зөвлөмж

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Дараах он тооллын шугамыг хэрэглэ:



Он тооллын шугаман дээр дараах үйл явдлуудыг байрлуулахад ангийн гишүүдэд тусал. Та ангийн гишүүдийн мэдлэгт тулгуурлан он тооллын шугаман дээр он сар өдрийг нь бичиж болно. Тэгээд оюутнуудаас тэдгээр он сар өдөр тус бүрт ямар үйл явдал болсныг тодорхойлохыг ангийн гишүүдээс асуу. Эсвэл та үйл явдлуудыг самбарт жагсааж бичээд үйл явдал тус бүр хэзээ болсныг ангийн гишүүдээр тогтоолгож болно.

- Есүс Христийн Цовдлол (МЭ 33)
- Агуу Урвалт (ойролцоогоор МЭ 100–МЭ 1800)
- Лэмэнчүүд болон Нифайчуудын сүүлчийн тулаан (ойролцоогоор МЭ 385)

- г. Кристофер Колумб Америкийг нээсэн нь (МЭ 1492)
- д. Есүс Христийн сайн мэдээний дахин сэргэлт (МЭ 1820–одоог хүртэл)

Ангийн гишүүдийг эдгээр үйл явдлуудыг он тооллын шугаман дээр байрлуулсны дараа Нифай эдгээр болон бусад үйл явдлуудыг ирээдүйн тухай үзэгдэлдээ үзсэн гэж тайлбарла.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Нифай өөрийн болон ах нарынхаа үе удмын ирээдүйг хардаг.

1 Нифай 12-ыг ярилц. Сонгосон шүлгийг чангаар уншихыг ангийн гишүүдээс урь. 1 Нифай 12 дээр Нифай өөрийн болон ах нарынхаа үе удмын ирээдүйн тухай үзэгдлээ дүрсэлсэн байдгийг тайлбарла. Та энэ бүлгийн тухай ярилцахдаа амьдралын модны тухай үзэгдэлд гардаг зарим бэлэгдлүүд (харанхуй манан, агуу хийгээд нүсэр барилга, буртаглагдсан уст гол) нь Нифайн үе удмын уналтын дохио хэрхэн болдгийг тайлбарла.

- Аврагчийг Америкт ирэхээс өмнө дэлхийн нөхцөл байдал ямар байхыг Нифай хэрхэн дүрсэлсэн бэ? (1 Нифай 12:1–6-г үз.) Энэ нь Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн өмнөх нөхцөл байдалтай хэрхэн адил байсан бэ? (Иосеф Смит—Матай 1:27–37-г үз.) Аврагчийн айлчлалын дараа ямар нөхцөл байдал бий болно гэж Нифай дүрсэлсэн бэ? (1 Нифай 12:11–12-ыг үз; мөн 1 Нифай 1:2–4-т бичигдсэн энэ бошиглалын биеллийн тухай үз.) Энэ зөв шударга байдал, амар амгаланг юу авчирсан бэ? (4 Нифай 1:15-ыг үз.)
- Бараг зөв шударга дөрвөн үеийн дараа түүний болон түүний ах нарын үе удам нэг нэгэнтэйгээ дахин байлдаж эхэлнэ гэдгийг Нифай харсан (1 Нифай 12:12–15). Нифай өөрийнх нь үе удамд энэ байлдааны үеэр чухам юу тохиолдож байгааг харсан бэ? (1 Нифай 12:19–20-ийг үз.) Нифайн үе удам яагаад дийлдэж, устгагдсан бэ? (1 Нифай 12:19-ийг үз.) Бардамнал, чөтгөрийн уруу таталт хэрхэн устгал руу хөтөлдөг вэ?

2. Нифай агуу хийгээд жигшүүрт сүмийн үүсэл, Америкийн колоничлогдолт, Урвалт, сайн мэдээний Дахин Сэргэлтийг хардаг.

1 Нифай 13 дээрээс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. 1 Нифай 13-т Нифайн үзсэн дараах үзэгдлийн тухай бичсэн гэдгийг тайлбарла:

- а. Агуу хийгээд жигшүүрт сүмийн үүсэл.
- б. Америкийг нээсэн нь мөн колоничлогдсон нь.
- в. Урвалт ба Библийн олон тодорхой болоод эрхэм үнэт хэсгүүд алдагдсан нь.
- г. Мормоны ном гарч ирсэн нь ба сайн мэдээний Дахин Сэргэлт.

Агуу хийгээд жигшүүрт сүмийн үүсэл

- Нифай “Харийн үндэстнүүдийн дунд” юу үүсч бий болохыг харсан бэ? (1 Нифай 13:4–5-ыг үз.) Агуу хийгээд жигшүүрт сүмийг үндэслэгч нь хэн бэ? (1 Нифай 13:6-г үз.)

Ахлагч Брүс Р.МакКонки хэлэхдээ: “*Чөтгөрийн сүм ба агуу хийгээд жигшүүрт сүм* гэсэн нэрнүүд нь бүх сүмүүд буюу улс төр, гүн ухаан, боловсрол, эдийн засаг, нийгэм, ах дүүсийн, иргэний, шашны аливаа нэр эсвэл мөн чанар бүхий хүнийг Бурханаас болон түүний хуулиас, улмаар Бурханы хаант улс дахь авралаас холдуулах замаар дагуулж явах зорилготой байгууллагуудыг тодорхойлоход хэрэглэгддэг” гэжээ (*Mormon Doctrine*, 2nd ed. [1966], 137–38).

Агуу хийгээд жигшүүрт сүм нь урвалт болон үүний олон янзын төрлүүдийн бэлэгдэл ном гэдгийг онцлон тэмдэглэ. Энэ нь бүхий л худал сургаал номлол, худал бишрэл, шашинлаг бус хандлагыг төлөөлдөг. Энэ нь өнөөдөр дэлхий дээр байгаа тодорхой нэгэн сүмийг төлөөлдөггүй.

- “Агуу хийгээд жигшүүрт сүмийн” ямар шинжүүд байдаг вэ? (1 Нифай 13:5–9-ийг үз. Хариултанд, энэ нь итгэлийг доройтуулдаг, дэлхийн баялаг, нүгэл үйлдэх хүслийг төрүүлдэг, дэлхий ертөнцийн магтаал, хүндлэлийг эрдэг зэрэг орж болно.) Амьдралын модны тухай үзэгдлээс ямар бэлэгдэл нь агуу хийгээд жигшүүрт сүмийг төлөөлдөг вэ? (1 Нифай 13:5–9-ийг 1 Нифай 11:35–36-тай харьцуул.)
- Агуу хийгээд жигшүүрт сүм өнөөдөр Гэгээнтнүүдийг устгахаар ажиллаж байгаа ямар жишээ нотолгоог та нар харж байна вэ? Бид хүмүүсийг Бурханаас болон Түүний хуулиудаас холдуулж байдаг хүмүүс буюу байгууллагуудад хууртагдахгүй байхаа хэрхэн анхаарч чадах вэ?

Америкийг нээсэн нь мөн колоничлогдсон нь

- “Их усаар . . . явах” харийнхан нь Кристофер Колумб болон эртний бусад шинжээчид, америк тив дэх оршин суугчид байсан гэж ойлгогддог (1 Нифай 13:12–13). Эдгээр шинжээчид, оршин суугчдын зүтгэл чармайлтыг амжилтанд хүрэхэд юу тусалсан бэ? (1 Нифай 13:14–19-ийг үз.)
- Эртний эдгээр шинжээчид болон оршин суугчид сайн мэдээний Дахин Сэргэлтэнд ямар үүрэг гүйцэтгэсэн бэ? (Тэд Америкийн Нэгдсэн Улсыг олох замыг бэлтгэсэн. Мормоны Номыг авчирч, сайн мэдээг дахин сэргээхэд шаардагдах, шашинг эс харгалзан эрх чөлөөтэй байх явдлыг Нэгдсэн Улсын Үндсэн Хуулинд тогтоосон. С ба Г 101:77–80-ыг үз.)

Урвалт ба Библийн олон тодорхой болоод эрхэм үнэт хэсгүүд алдагдсан нь

- Нифайн харсан Харийнхны авч явж байсан ном нь ямар ном байсан бэ? (1 Нифай 13:20–23-ыг үз. Библи.) Агуу хийгээд жигшүүрт сүм энэ номыг яасан бэ? (1 Нифай 13:24–26-г үз.) Яагаад ингэсэн бэ? (1 Нифай 13:27-г үз.)
- Библиэс “олон тодорхой болоод эрхэм үнэт зүйлс” алдагдсан нь ямар үр дагаврыг авчирсан бэ? (1 Нифай 13:29-ийг үз.)

Мормоны ном гарч ирсэн нь ба сайн мэдээний Дахин Сэргэлт

- Агуу хийгээд жигшүүрт сүм Библи дэх Бурханы үгийг устгахыг оролдоно гэдгийг Их Эзэн мэдэж байсан. Тэр өөрийн үгсээ хожмын өдөр гарч ирж мэдэгдэхээр хадгалахаа хэрхэн анхаарсан бэ? (1 Нифай 13:35–36-г үз.) Нифайн үр удмын хадгалсан тэр тэмдэглэл нь юу байсан бэ? (Мормоны Ном.)

- Мормоны Номын зорилго нь юу вэ? (1 Нифай 13:40–41; мөн Мормон 7:8–9; С ба Г 20:8–12-ыг үз. Та ангийн гишүүдийн хариултыг самбарт бичиж болно.) Та нар эдгээр зорилгуудыг биелэхийг хэрхэн харсан бэ?
- Мормоны Номонд тодорхой болоод эрхэм үнэн боловч Библи дээрээс ойлгоход хэцүү байдаг ямар номлолууд бий вэ? (Хариултанд, Цагаатгал, Дахин Амилалт, усан баталгаа орж болно. Та эдгээр номлолуудыг Мормоны Номонд хэрхэн тодорхой заасан тухай жишээг хуваалцаж болно. Жишээ нь, та ангийн гишүүдээр Цагаатгал, Дахин Сэргэлтийн тухай тодорхой болоод эрхэм үнэт үнэнүүдийг заадаг Алма 11:42–45-ыг эсвэл усан баталгааны тухай тодорхой болоод эрхэм үнэт үнэнүүдийг заадаг 3 Нифай 11:21–26 ба Моронай 8:11–12-ыг уншуулж болно. Мормоны Ном танд Библийг илүү ойлгомжтой болгож, мөн Библийн тухай гэрчлэлээ өсгөхөд хэрхэн тусалсан бэ?

3. Нифай итгэлтэйд амлагдсан адислалыг хардаг; тэр мөн агуу хийгээд жигшүүрт сүмийг устахыг хардаг.

1 Нифай 14-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

Ангийнхнаа хоёр хэсэгт хуваа. Нэг хэсгээр нь 1 Нифай 14:1–7-г олж, Харийнхан (Израил хүмүүс биш)-д Их Эзэнд итгэлтэй хэвээр үлдвэл тэдэнд өгөгдсөн амлагдсан адислалуудыг олуул. Нөгөө хэсгээр мөн адил шүлгээс хэрэв Харийнхан зүрх сэтгэлээ хатууруулж, Их Эзэнээс татгалзвал тэдэнд ирэх хараалыг олуул. Эдгээр зүйлсийг самбарт бич. Дараа нь дараахыг асуу:

- Бид эдгээр адислалуудыг хүртэхээр зүрх сэтгэлээ зөөлрүүлэхийн тулд юу хийх ёстой вэ?
- Дэлхий дээр өнөөдөр ямар утгаараа зөвхөн хоёр хүч байдаг вэ? (1 Нифай 14:10; 2 Нифай 10:16-г үз.)
- Агуу хийгээд жигшүүрт сүмд аажимдаа юу тохиолдох вэ? (1 Нифай 14:3–4, 15–17; 22:23-ыг үз.)
- Хожмын өдрүүдэд Их Эзэний Сүмийн гишүүд харьцангуй цөөн байх хэдий ч тэд агуу хийгээд жигшүүрт сүмийн хавчлагыг давж гарч чадна гэдгийг Нифай харсан. Бурханы Гэгээнтнүүд юугаар зэвсэглэсэн байхыг Нифай харсан бэ? (1 Нифай 14:14-ийг үз.) Бид хэрхэн “зөв шударга байдал болон Бурханы хүчээр” зэвсэглэсэн байж чадах вэ?

Дүгнэлт

Нифайн үзсэн үзэгдэл дэлхийн түүхэнд тохиолдсон болон хараахан тохиолдоогүй байгаа олон зүйлүүдийг дүгнэж үзэх боломжийг олгодог гэдгийг тайлбарла. Мөн энэ нь бид Есүс Христийг дагах эсвэл Түүний эсрэг ажиллаж, Сатаныг дагах гэсэн зөвхөн хоёр талын нэгийг сонгох ёстой гэдгийг харуулдаг. Хэрэв бид Есүс Христийг дагахаар сонговол 1 Нифай 14 дээр амлагдсан адислалуудыг бид бүгд хүртэх боломжтой болдог гэдгийг ангийн гишүүдэд сануул.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

“Үнэнийг Сонсож, Үүнд Анхаарлаа Хандуулах нь”

Хичээл
5

1 Нифай 16–22

Зорилго

Нифайн итгэл, дуулгавартай байх хүслийн жишээг дагахад ангийн гишүүдийг урамшуулах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. 1 Нифай 16; 17:1–3. Лихайн хөвгүүд, Зорам нар Ишмэилийн охидтой гэрлэдэг. Их Эзэн хүмүүст тэднийг аглаг буйд явахад тэдний итгэл, хичээнгүй байдлын дагуу удирдахаар Лиахонаг өгдөг. Нифайн нум хугарч, хоол хүнсэнд хэрэгтэй ан хийхэд хэцүү болдог. Шинэ нум хийж, хоол хүнс олохоор хаашаа явахаа Лихайгаас асууж, хүмүүстээ хоол хүнс авчирдаг Нифайгаас бусад нь цөм бувтнадаг.
 - б. 1 Нифай 17:4–55; 18:1–4. Нифай усан онгоц барь гэсэн Их Эзэний зарлигийг дуулгавартай дагаснаараа гуйвшгүй итгэлээ харуулдаг.
 - в. 1 Нифай 18:5–25. Лэмэн, Лэмүүл, Ишмэилийн хөвгүүд болон тэдний эхнэрүүд усан онгоцон дээр эсэргүүцэлдээ нэгддэг. Энэ саадыг үл харгалзан эр зориг, талархалтай байгаагаа харуулдаг Нифайг Лэмэн, Лэмүүл хоёр хүлдэг. Их Эзэн агуу шуургыг илгээдэг. Усан онгоцыг амлагдсан нутаг руу жолооддог Нифайн хүлээсийг Лэмэн, Лэмүүл хоёр тайлдаг.
2. Нэмж унших зүйл: Алма 37:38–46.
3. Ангийн гурван гишүүнтэй, хүн бүр дор бичсэн судрын хэсгүүдээс нэгийг нь дүгнэж бэлтгэн ирэхийг хүсэж урьдчилж ярь. Тэднийг мэдээлсний дараа хичээл дээр ярилцах гэж буй номлол буюу хувьдаа тохиолдсон явдлын оронд уг хэсэгт гарсан үйл явдлуудын тухай тайлагнахыг тэднээс хүс.
 - а. 1 Нифай 16:9–33
 - б. 1 Нифай 17:4–55; 18:1–4
 - в. 1 Нифай 18:5–22
4. Дараах материалууд байгаа бол тэдгээрийг хичээлдээ хэрэглэхээр бэлтгэ:
 - а. Лиахона (62041; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 302) ба Лихай болон Түүний Хүмүүс Амласан Газарт Ирсэн нь (62045; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 304) зургууд.

Хичээлийг Баяжуулах Зөвлөмж

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Дараах өгүүлбэрүүдийг самбарт бич:

Би хүсэхгүй байна.
Би энэ тухай бодож үзье.
Би оролдоод үзье.

Ангийн гишүүнээс 1 Нифай 3:4-ийг уншихыг хүс.

- Хэрэв Нифай Их Эзэний зарлигийн хариуд самбарт байгаа өгүүлбэрүүдийн аль нэгийг хэлсэн бол юу тохиолдож болох байсан бэ? Нифай юу гэж хариулсан бэ? (“Би хийнэ.” 1 Нифай 3:7-г үз.)

Самбарт байгаа өгүүлбэрүүдийг арчиж, *БИ ХИЙНЭ* гэсэн өгүүлбэрийг том үсгээр бич. Нифай “Би хийнэ” гэсэн тэр чигээрээ Их Эзэний зарлигуудыг дуулгавартай дагахаас зайлсхийгээгүй тул Нифай болон түүний гэр амлагдсан нутаг руу аялахдаа адислагдаж байсныг тайлбарла. Энэ хичээл Нифайн итгэл, дуулгавартай дагах хүслийн жишээг бид хэрхэн дагаж чадахыг харуулдаг.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Их Эзэн Лихай болон Ишмэилийн гэр бүлүүдийг итгэл, хичээнгүй байдлынх нь төлөө удирддаг.

Та Лихай Лиахонаг олж байгаа зургийг хэрэглэж байгаа бол үүнийг одоо үзүүл. Урьдчилан даалгасан ангийн гишүүнээс 1 Нифай 16:9–33 дээр гардаг үйл явдлыг дүгнэж ярихыг хүс. Дараа нь 1 Нифай 16; 17:1–3-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Их Эзэний Лихайд өгсөн “Бөмбөг буюу удирдагчийг” “Лиахона” (Алма 37:38) гэж нэрлэдэг байсан. Лиахонагийн зорилго нь юу байсан бэ? (1 Нифай 16:10, 29-ийг үз.) Лиахонаг ажиллуулахын тулд хүмүүс юу хийх хэрэгтэй байсан бэ? (1 Нифай 16:28–29; Алма 37:40-ийг үз.) Хүмүүс итгэлгүй мөн дуулгаваргүй байхад ямар үр дагаварт хүрч байсан бэ? (Алма 37:41–42-ыг үз.)
- Бидний итгэл, хичээнгүй байдлын дагуу ажилладаг Лиахона шиг амьдралд маань биднийг удирддаг ямар зүйлүүд байдаг вэ? (Хариултанд, (Алма 37:38–46-д тайлбарласан шиг) судрууд; Ариун Сүнс; патриархын адислал; амьд бошиглогчдын сургаалууд; дор байгаа ишлэлд гардаг шиг бидний ухамсар зэрэг орж болно.) Эдгээр нь та нарт хэрхэн тусалдаг вэ?

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл хэлэхдээ:

“Их Эзэн . . . хүн бүрт буруу замаар явж эхлэх бүрт нь хэлж өгдөг ухамсрыг өгсөн. Хэрэв хүн сонсож байгаа бол түүнд үргэлж хэлж өгч байдаг юм; харин хүмүүс мэдээж захиас сонссоор байгаад дасаж, эцэст нь үүнийг огт тоохоо больтлоо үл тоомсорлодог.

“Та нар өөртөө хувьдаа Лиахона шиг луужинтай гэдгээ ухаарч байх ёстой. Энэ нь хүүхэд бүрт өгөгддөг. . . . Тэр өөрт байгаа Лиахонагаа үл тоомсорловол тэрээр аажимдаа үүний шивнээг сонсохоо больж болох юм. . . . Бидний ухамсар хэмээн нэрлэдэг өөрсдийн Лиахонагийн

удирдамжийг сонсох юм бол . . . бидний усан онгоц буруу замаар явахгүй” гэжээ (in Conference Report, Oct. 1976, 117; or *Ensign*, Nov. 1976, 79).

- Нифайг нумаа хугалахад Лэмэн, Лэмүэл хоёр түүнд яаж хандсан бэ? (1 Нифай 16:18, 20-ийг үз.) Лихай яаж хандсан бэ? (1 Нифай 16:20-ийг үз.) Нифай яаж хандсан бэ? (1 Нифай 16:22–23-ыг үз.) Энэ сорилтын хариуд Нифайн хандсан байдлаас бидэнд сорилт тулгарах үед туслах юу сурч болох вэ? (Хариултанд, бид Их Эзэнд итгэх ёстой; сорилтыг давж гарахын тулд хичээнгүйлэн ажиллах, Их Эзэний болон Түүний үйлчлэгчдийн эсрэг гомдоллохоос зайлсхийх зэрэг нь орж болно.)
- Нифай шинэ нум хийснийхээ дараа Лихайгаас хаашаа явж хоол хүнс олж авах вэ гэж асуудаг (1 Нифай 16:23). Хүүгийнхээ хүсэлтэнд Лихай хэрхэн хандсан бэ? (1 Нифай 16:24–25-ыг үз.) Лихай өөрийгөө даруу болгож, Их Эзэнд хандсаны үр дүн нь юу байсан бэ? (1 Нифай 16:26–32-ыг үз.) Бид Их Эзэн Лихайтай хэрхэн харьцсан энэ жишээнээс юу сурч болох вэ? (Хариултанд, өөрсдийгөө даруу болгож, Түүнд хандахад Их Эзэн биднийг уучилж, адисладаг нь орж болно.)
- Лиахонагийн тухай ярихад, Нифай “өчүүхэн арга замаар Их Эзэн агуу их үйл хэргүүдийг тохиол болгож чаддаг” болохыг анзаарсан (1 Нифай 16:29; мөн Алма 37:6–7; С ба Г 64:33-ыг үз.) Та амьдралдаа үүнийг үнэн гэдгийг хэрхэн харсан бэ? Энэ зарчмын тухай мэдээ бидэнд хэрхэн тусалдаг вэ?

2. Нифай усан онгоц барь гэсэн Их Эзэний зарлигийг биелүүлснээрээ гуйвшгүй итгэлээ харуулдаг.

Урьдчилан даалгасан ангийн гишүүнээс 1 Нифай 17:4–55; 18:1–4 дээр гардаг үйл явдлыг дүгнэж ярихыг хүс. Дараа нь тэдгээр хэсгүүдээс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Усан онгоц барихыг тушаасан Их Эзэний зарлигийн хариуд Нифайн хийсэн үйлдлээс бид юу сурч болох вэ? (1 Нифай 17:8–11, 16–19, 50–51; 18:1–3; мөн Иакоов 2:17–18-ыг үз.)

Ахлагч Л.Том Пэрри хэлэхдээ: “Их Эзэн тусалдаг ч дараа нь хойшоо болж Өөрийн хөвгүүдийн нэгийг өөрийн санаачлагаа хэрэглэхийг зөвшөөрдөг нэгэн жишээг өгүүлдэг учраас энэ нь сударт байдаг нэн сонирхолтой түүхүүдийн нэг юм. Би заримдаа, хэрэв Нифай Их Эзэнээс багаж хийх хүдрийг олох газрын оронд багаж хэрэгсэл өгөөч гэж хүссэн бол юу болох байсан бол гэж боддог юм. Их Эзэнд Нифайн ийм хүсэлт таалагдана гэдэгт би эргэлзэж байна. Их Эзэн Нифайг багаж хийж чадна гэдгийг мэдэж байсан гэдгийг та нар бод доо. Их Эзэн бидний өөрсдөө хийчихэж чадах юмыг бидэнд хийж өгөх нь ховорхон байдаг” гэжээ (in Conference Report, Oct. 1991, 87–88; эсвэл *Ensign*, Nov. 1991, 64).

- Нифайг усан онгоц барихаар зэхэж байхад Лэмэн, Лэмүэл хоёр түүнд яаж хандаж байсан бэ? (1 Нифай 17:17–22-ыг үз.) Нифай тэдэнд Израилчуудыг Египетээс гарсныг сануулан зэмлэсэн. Лихай болон түүний гэр бүлийн дүрвэн гарсан явдал Мосе болон Израилчуудын дүрвэсэнтэй хэрхэн төстэй байдаг вэ? (1 Нифай 17:23–44-ийг үз.)
- Нифай Лэмэн, Лэмүэл хоёрт тэд “мэдрэхээс өнгөрсөн, иймээс [тэд] [Их Эзэний] үгсийг мэдэрч чадсангүй” гэж хэлсэн (1 Нифай 17:45). Их Эзэний

үгсийг мэдрэх гэдэг ямар утгатай вэ? (Дор байгаа ишлэлийг үз.)
Хүмүүсийг “мэдрэхээс өнгөрөхөд” юу нөлөөлдөг вэ? Их Эзэний үгсийг мэдрэхэд бид өөрсдийгөө хэрхэн бэлтгэж чадах вэ?

Ахлагч Боид К.Пакер заахдаа: “Ариун Сүнс нь сэтгэлтэй харьцахдаа бие махбодоос илүүтэй бодол санаагаар дамжин харьцдаг. Энэ удирдамж нь бодол, мэдрэмж мэтээр сэтгэгдэл, өдөөлтөөр дамжин ирдэг. Урмыг тайлбарлах нь үргэлж хялбар байдаггүй. Сударт бид сүнслэг харьцааны үгсийг сонсохоосоо илүү мэдэрч болдог бөгөөд сүнслэгээр харахаасаа илүү мөнх бус нүдээрээ хардаг гэж заадаг (1 Нифай 17:45)” гэжээ (in Conference Report, Oct. 1989, 16; or *Ensign*, Nov. 1989, 14).

- Хүмүүс Лэмэн, Лэмүүл хоёр шиг үнэний эсрэг зүрх сэтгэлээ хатуу болгох үед тэд ямар үр дагавартай учирдаг вэ? (1 Нифай 17:46–47-г үз.)
- Нифай ах нартаа аавынхаа эсрэг бувтнахгүй байхыг уриалдаг (1 Нифай 17:49). Бувтнах нь бидний гэр бүлд ямар нөлөө үзүүлдэг вэ? Хов жив ярьж, гэр бүлийнхнийхээ өөдөөс үг хэлэхээ бид хэрхэн зогсоож чадах вэ?
- Нифай усан онгоц барьж байхдаа залбирахаа үргэлжлүүлсээр байдаг (1 Нифай 18:1–3). Их Эзэн түүний залбиралд хэрхэн хариулсан бэ? (1 Нифай 18:1, 3–4-ийг үз.) Их Эзэнийг залбиралдаа байнга хайх нь бидэнд яагаад чухал вэ?

3. Энэ саадыг үл харгалзан эр зориг, талархалтай байгаагаа харуулдаг Нифайг Лэмэн, Лэмүүл хоёр хүлдэг. Түүнийг чөлөөлсний дараа Нифай усан онгоцыг амлагдсан нутаг руу жолооддог.

Урьдчилан даалгасан ангийн гишүүнээс 1 Нифай 18:5–22 дээр гарсан үйл явдлыг дүгнэж ярихыг хүс. Дараа нь 1 Нифай 18:5–25-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Амлагдсан нутаг тийш явж байхдаа Лэмэн, Лэмүүл, Ишмэилийн хөвгүүд болон тэдний эхнэрүүд “өөрсдийгөө зугаацуулж эхэлдэг” (1 Нифай 18:9). Нифай тэдэнд юу гэж хэлсэн бэ? (1 Нифай 18:10-ыг үз.) Ийн зугаацахын буруу нь юу байсан бэ? (1 Нифай 18:9-ийг үз. Тэд Их Эзэнийг мартаж, бүдүүлэг үйлдэл хийсэн. Та энэ шүлгийг С ба Г 136:28-тай харьцуулж болно.)
- Нифайг чөлөөлөхөд Лэмэн, Лэмүүл хоёрыг итгүүлж чадсан ганц зүйл нь юу байсан бэ? (1 Нифай 18:15–20-ийг үз.) Лэмэн, Лэмүүл хоёр Их Эзэнийг эсэргүүцэж, нүглээ наманчилж, дараа нь дахин эсэргүүцэхэд тэд улам л хатуу сэтгэлтэй болж байсан (1 Нифай 18:20-ийг 1 Нифай 2:14; 7:19–21; 16:39; 18:4-тэй харьцуул.) Нэг нүглээ дахин дахин хийх нь ямар аюултай вэ? (С ба Г 82:7-г үз.)
- Лэмэн, Лэмүүл хоёрыг наманчилж, Нифайн хүлээсийг тайлсны дараа Их Эзэн хүмүүсийг хэрхэн адисласан бэ? (1 Нифай 18:21–25-ыг үз. Хэрэв та хүмүүс амлагдсан газарт ирж байгаа зургийг хэрэглэж байгаа бол үүнийг одоо үзүүл.)
- Хүмүүс аглаг буйд аялж, далайг гаталж байхад ямар нөхцөл байдлаас болж тэдний олонх нь бувтнаж байсан бэ? (1 Нифай 16:18–20, 34–36; 17:21-ийг үз.) Энэ хүнд хэцүү цагт Нифай хэрхэн хандаж байсан бэ? (1 Нифай 18:16-г үз.) Нифайгийн эргэн тойронд байсан хүмүүс Бурханы

эсрэг гомдоллож байсан ч гэсэн тэр Их Эзэнд дуулгавартай байж, түүнийг хайрлахдаа хэзээ ч эргэлзэж гуйваагүй.)

Дүгнэлт

Мормоны Номонд Нифайн бичсэн сүүлчийн үгс нь түүний үнэн зан чанарын тодорхойлолттой нийцэж байна гэдгийг цохон тэмдэглэ: “Их Эзэн надад тийн зарлигласан мөн би дагах ёстой” (2 Нифай 33:15). Дараа нь Ахлагч Хибэр Ж.Грантын дараах мэдэгдлийг хуваалц:

“Бурханыг зарлиглаж мөн бид дуулгавартай дагахад ямар ч саад давшгүй гаталшгүй бус юм” (in Conference Report, Oct. 1899, 18).

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Судраас хайх нь

Ангийн гишүүдээр Нифайг дүрсэлсэн мөн Лэмэн, Лэмүүл нарыг дүрсэлсэн үгсийг хайлгахаар 1 Нифай 16–18-ыг гүйлгэн уншуул. Үгсийг самбарт бичээд, тэдгээрийг Нифай болон түүний эсэргүүцэгч ах нарыг хооронд нь харьцуулахад хэрэглэ.

2. 1 Нифай 19–22-ын тухай бодлууд

- Гэр бүлүүдийг амлагдсан нутагт ирсний дараа Их Эзэн Нифайд хийхийг зарлигдсан анхны зүйлүүдийн нэг нь хүмүүсийнхээ тэмдэглэлийг хөтлөх явдал байв (1 Нифай 19:1–4). Нифай, тэрээр хүмүүстээ “тэднийг Их Эзэн өөрсдийн Гэтэлгэгчийг санахад ятган итгүүлж болох магад хэмээн” “эрхэм нандин зүйлүүдийг” бичсэн гэж хэлжээ (1 Нифай 19:5, 18). Хэрэв бид амьдралынхаа эрхэм нандин үйл явдлыг бичиж тэмдэглэвэл бидний үр садад ямар адислал ирэх вэ?
- Нифайн хэлснээр Аврагчийг мөнх бус үйлчлэлийнх нь үед дэлхий хэрхэн хүлээн авах вэ? (1 Нифай 19:7–10-ыг үз.) Дэлхий Есүсийг яагаад “гологдсон зүйл” мэт эсэргүүцсэн бэ? (1 Нифай 19:9-ийг үз.) Есүс ийм хавчлагыг яагаад тэвчих хүсэлтэй байсан бэ? (1 Нифай 19:9-ийг үз.)
- Нифайнхаар бол Жүүдүүд яагаад “бүх хүмүүсээр цээрлүүлэгдэх” вэ? (1 Нифай 19:13–14-ийг үз.) Жүүдүүд “өөрсдийн зүрх сэтгэлийг Есүсийн эсрэг өөр зүг дахин хандуулахгүй бол тэдэнд юу тохиолдох вэ? (1 Нифай 19:15–16-г үз.)
- Нифай ах нартаа “хуучны бошиглогчдын” тухай болон “урьд цагийн хүмүүсийн дундах, өөр нутгууд дахь Их Эзэний үйлүүдийн” тухай заасан (1 Нифай 19:21–22). Та нар судраас судалж, хуучны бошиглогчдын тухай суралцсанаар хэрхэн адислагдаж байсан бэ?
- “Бүхий л судруудыг өөрсөдтэйгөө адилтгах” нь яагаад чухал вэ? (1 Нифай 19:23). Үүнийг хийх нь та нарт ямар ашиг тустай байсан бэ?

1 Нифай 21–22-г хожмын өдрүүдийн тухай чухал бошиглолууд агуулагддаг. Та дараах хэсгүүдийг хянаж үзэж болно.

- а. 1 Нифай 21:22–23; 22:6–28. Сайн мэдээний Дахин Сэргээлт нь тарж бутарсан Израилыг дахин нэгтгэнэ.
- б. 1 Нифай 21:26; 22:10–12. Их Эзэн Израилыг “битүүлэг байдлаас мөн харанхуйгаас гаргах болно; мөн тэд Их Эзэн бол тэдний Аврагч мөн тэдний Гэтэлгэгч гэдгийг мэднэ.” (Мормоны Ном “[Их Эзэн] гэрээнүүдийг, мөн түүний сайн мэдээг Израилын угсаанд авчрахад” гол түлхүүр нь болдог гэдгийг тайлбарла. 1 Нифай 22:11–12-ыг Мормоны Номын гарчиг хэсэгтэй харьцуул.)
- в. 1 Нифай 22:13–15. Бурханыг эсэргүүцдэг үндэстнүүд нэг нэгнийхээ эсрэг байлдаж, устгагдах болно.
- г. 1 Нифай 22:16–19. Их Эзэн зөв шударгыг нь хамгаална.
- д. 1 Нифай 22:26. Христийн мянган жил ноёлох үед Сатан хүлээстэй байх болно.

“Эрх Чөлөө Болон Мөнхийн Амьдралыг Сонгох Эрхтэй”

Хичээл
6

2 Нифай 1–2

Зорилго Ангийн гишүүдийг “бүх хүмүүний агуу их Зуучлагч” Есүс Христээр дамжуулан “эрх чөлөө болон мөнхийн амьдралыг сонгох” илүү их хүсэлтэй болоход туслах болно (2 Нифай 2:27).

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. 2 Нифай 1. Лихай хүмүүстээ “амлагдсан нутгийг” гэрээний дагуу олж авлаа гэж заадаг. Наманчилж, Их Эзэний зарлигийг дуулгавартай дагаж, зөв шударгын хуяг дуулгыг өмсөхийг тэрээр хөвгүүддээ уриалдаг.
 - б. 2 Нифай 2:1–10. Гэтэлгэл нь Есүс Христийн Цагаатгалаар дамжин ирдгийг Лихай заадаг.
 - в. 2 Нифай 2:11–30. Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд сөрөг тал байх ёстой, тэгснээр бид “эрх чөлөө болон мөнхийн амьдралыг . . . эсвэл боолчлол болон үхлийг сонгох эрхтэй” болдог гэж Лихай заадаг.
2. Хэрэв та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглэж байгаа бол ангидаа сэрүүлэгтэй цаг авчир.

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

**Анхаарал Татах
Үйл Ажиллагаа**

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Ангидаа сэрүүлэгтэй цаг авчирч, үүнийг хичээлийн эхэнд дуугарахаар тохируул. Үүнийг дуугарсны дараа биднийг сэрээхэд заримдаа сэрүүлэгтэй цагтай адил зүйл хэрэг болдог гэдгийг цохон тэмдэглэ. Энэ хичээлийн сэдэв нь Лихай хөвгүүдийнхээ заримыг сүнслэг байдалдаа сэрэхэд нь туслах зөвлөгөө өгснөөр эхэлнэ гэдгийг тайлбарла.

**Судрын Ярилцлага
ба Хэрэглээ**

Энэ хичээлд багтсан бүлгүүдэд Лихайн хөвгүүддээ хэлсэн сүүлийн үгс бий. Ангийн гишүүдэд Лихайн зөвлөгөөг амьдралдаа хэрэгжүүлэх арга замыг эрж хайхыг уриал. Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго.

1. Наманчилж, Их Эзэний зарлигуудыг дуулгавартай дагаж, зөв шударгын хуяг дуулгыг өмсөхийг Лихай хөвгүүддээ уриалдаг.

2 Нифай 1-ийг ярилц. Сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг ангийн гишүүдээс урь. Лихай нас барахаасаа өмнөхөн хөвгүүддээ өгсөн зөвлөгөө нь энэ бүлэгт агуулагддаг гэдгийг тайлбарла. Лихай хөвгүүддээ хийхийг зөвлөсөн тодорхой зүйлүүдийг мөн хэрэв тэд түүний зөвлөгөөг дагавал хүртэнэ гэж амласан адислалуудыг нь хайхыг ангийн гишүүдээс хүс.

- Зовж зүдрэхийн оронд түүний хүмүүст гэрээний дагуу “амлагдсан нутгийг хүртсэн” гэж Лихай хэлсэн (2 Нифай 1:5). Их Эзэн болон Лихайн хүмүүсийн хооронд хийсэн гэрээ нь юу байсан бэ? (2 Нифай 1:6–7, 9–10-ыг үз.) Хэрэв уг нутгийн хүмүүс Аврагчийг эсэргүүцвэл тэдэнд юу тохиолдоно гэж Лихай хэлсэн бэ? (2 Нифай 1:10–12-ыг үз.)
- Лихай хөвгүүддээ “сэрээсэй . . . тамын нойрноос сэрээсэй, тэгээд та нар хүлэгдсэн тэр аймшигт гинжээ сэгсрэн зайлуулаасай” хэмээн зарлиглан наманчлахыг уриалсан (2 Нифай 1:13; мөн шүлэг 14, 21 ба 23-ыг үз.) Нүгэлтэй байх нь гүн нойрсохтой хэрхэн адил вэ? Нүгэлтэй байх нь гинжээр хүлүүлсэнтэй хэрхэн адил вэ?
- Лихай хөвгүүддээ “газар шорооноос босч, . . . эр хүн шиг байхыг” зөвлөсөн (2 Нифай 1:21). Зөв шударга хүний шинж ямар байдаг вэ? (2 Нифай 1:21–27-г үз. Лихайн зөвлөсөн шинжүүдийг эдгээр шүлгүүдээс ангийн гишүүдээр хайлга. Та эдгээр болон бусад шинжүүдийг самбарт бичиж болно.) Эр хүн байх гэдгийг дэлхий ертөнцөд юу гэж тайлбарладаг вэ? Дэлхий ертөнцийн эр хүн гэсэн тодорхойлолтоос зөв шударгыг сонгоход залуу эрэгтэйчүүдэд бид хэрхэн тусалж чадах вэ?
- Итгэлтэй байснаар Лихай ямар адислалуудыг хүртсэн бэ? (Ангийн гишүүнээр 2 Нифай 1:15-ыг чангаар уншуул. Хөвгүүдийнх нь зарим нь нүглийн “аймшигт гинжээр” хүлүүлсэн байхад, Лихай “[Аврагчийн] хайрын мутраар мөнхөд хүрээлүүлсэн байсан” гэдгийг тайлбарла. Бид даруухнаар наманчилж, дуулгавартайгаар Христэд ирвэл аврагдах бөгөөд “түүний хайрын мутраар мөнхөд хүрээлүүлсэн” байх болно гэдгийг онцлон тэмдэглэ.)

2. Лихай Есүс Христийн Цагаатгалын тухай гэрчилдэг.

2 Нифай 2:1–10 -ыг уншаад ярилц.

- “Хуулийн дагуу зөвтгөгдөх махан бодь гэж үгүй; өөрөөр хэлбэл, хуулиар хүмүүн нь тусгаарлагдсан байна” гэж Лихай хэлсэн (2 Нифай 2:5). Зөвтгөгдөх гэдэг нь Бурхантай эвлэрч, нүглийн шийтгэлээс өршөөгдөж, зөв шударга, гэмгүй гэж тунхаглуулах явдал юм. Хууль нь биднийг хэрхэн тусгаарлаж, зөвтгөгдөхөөс холдуулдаг вэ? (Иаков 2:10; 1 Нифай 10:21-ийг үз. Зарлигуудыг дуулгавартай дагахгүй үед бид гэмтэй, цэвэр бус болдог бөгөөд цэвэр бус зүйл Бурхантай хамт оршдоггүй.)
- Бид нэгэнт хуулиар зөвтгөгдөж чадахгүй тул бид хэрхэн зөвтгөгдөж, Бурханы дэргэд очиход зохистой болж чадах вэ? (2 Нифай 2:6–8-ыг үз. Есүс Христийн Цагаатгалын ачаар бид нүглээ наманчилж, өршөөгдөж чаддаг гэдгийг онцлон тэмдэглэ.)
- Лихай хэлэхдээ, Аврагч “хуулийн бүхий л шаардлагуудыг хангана” гэж хэлсэн (2 Нифай 2:7). “Хуулийн бүхий л шаардлага” гэдэг нь Уналтын үр дагавар болон Бурханы зарлигуудад дуулгаваргүй байсан хүмүүст “тогтоосон шийтгэлийг” хэлж байгаа юм (2 Нифай 2:5, 10). Аврагч хуулийн бүхий л шаардлагуудыг хэрхэн хангасан бэ? (2 Нифай 2:7; Алма 34:13–16; С ба Г 19:16–19; 45:3–5-ыг үз; мөн дор байгаа ишлэлийг үз.)

Ерөнхийлөгч Иосеф Ф.Смит хэлэхдээ, “Есүс ирж, чухам нүгэлгүй тэр нүгэлтэйных нь ‘зөвхөн шударга бус хүмүүсийнх нь төлөө’ зовж,

нүгэлтнүүдийн гэмийн төлөө хуулийн шийтгэлийг хүлээсэн” гэсэн (*Gospel Doctrine*, 5-р хэвлэл. [1939], 204).

- Бидний нүглийн төлөө зовсон Христээр дамжуулан зөвтгөгдөхийн тулд бид яаж амьдрах ёстой вэ? (2 Нифай 2:7; мөн Ром 10:4; С ба Г 19:15–16; Итгэлийн Тунхаг 1:3-ыг үз.)
- Ангийн гишүүнээс 2 Нифай 2:8-ыг чангаар уншихыг хүс. Бидний мэдүүлэх ёстой “эдгээр зүйлүүд” гэдэг нь юу вэ? (2 нифай 2:6–8-ыг үз.) Бид хэрхэн “эдгээр зүйлүүдийг мэдүүлж” чадах вэ? Эдгээр зүйлүүдийг мэдүүлэх нь Аврагчид болон Түүний Цагаатгалд талархах бидний сэтгэлийг хэрхэн харуулдаг вэ?

3. Лихай сөрөг талын болон сайныг хилэнцээс ялгаж сонгох эрхийн чухлын тухай заадаг.

2 Нифай 2:11–30-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

Лихай хөвгүүддээ сөрөг тал нь хэрэгтэй байдаг тухай заахдаа Адам Ева хоёр хориглосон жимснээс хүртсэн тухай түүхийг дүгнэж үзсэн. 2 Нифай 2:15–25-аас ангийн гишүүдээр ээлжлүүлэн цөөн хэдэн шүлгээр нь уншуул. Тэд нараас (1) Адам, Ева хоёр хориглосон жимсийг хүртэхээс өмнөх нөхцөл байдал, (2) жимсийг хүртсэний дараа Адам, Ева хоёрын үзсэн сөрөг талыг эрж хайхыг хүс. Ангийн гишүүдийн хариултуудыг нэгтгэн дүгнэж, самбарт бүдүүвч зургаар үзүүл. Бүдүүвч зураг нь дор байгаатай төстэй байх учиртай.

2 Нифай 2 дээр Лихай Уналтаас болж үүссэн зарим нэг нөхцөл байдлын тухай дурьдсан гэдгийг тайлбарла. Хэдий тийм ч Уналтын тухай сургаал нь энэ бүлэгт гардгаас хавьгүй том цар хүрээтэй юм. Ангийн гишүүд Уналт нь бие махбодийн үхэл болон сүнслэг үхлийг дэлхийд авчирч, ингэснээр гэтэлгэлийн төлөвлөгөө хэрэгжиж эхэлсэн гэдгийг ойлгох ёстой.

ЖИМСИЙГ ХҮРТЭХЭЭС ӨМНӨХ БАЙДАЛ	ЖИМСИЙГ ХҮРТСЭНИЙ ДАРАА ҮЗСЭН СӨРӨГ ТАЛ
Тэд өөрсдөө үйлдэх боломжтой байсан (2 Нифай 2:15–16), боловч “тэд нүглийг мэддэггүй” байсан учраас сайн зүйлийг тэд хийгээгүй (2 Нифай 2:23).	Тэд сайныг үйлдэж, мөн нүгэл хийж чаддаг болсон (2 Нифай 2:23). Тэдэнд нүглээ наманчлахыг зарлигласан (2 Нифай 2:21).
Тэд хоол хүнсний зүйл тарихын тулд газрыг боловсруулах хэрэггүй байсан (2 Нифай 2:19; мөн Мосе 2:29-ийг үз).	Тэд хоолоо олохын төлөө хөдөлмөрлөх ёстой болсон (2 Нифай 2:19).
Тэд зовлон буюу баяр баясгаланг мэддэггүй байсан (2 Нифай 2:23).	Тэд зовлон буюу баяр баясгаланг мэдэрсэн (2 Нифай 2:23).
Тэд “тэр байдлаараа . . . үүрд мөн төгсгөлгүйгээр” үлдэх байсан (2 Нифай 2:22).	Тэд унаж, мөнх бус буюу бие махбодийн үхэлд захирагдах болсон (2 Нифай 2:22; мөн Мосе 6:48-ыг үз).

- Хэрэв Адам, Ева хоёр жимсийг хүртээгүй байсан бол энэ бүдүүвчинд дурдсан сөрөг талуудыг үзэхгүй байх байсан (2 Нифай 2:22–23). Адам, Ева

хоёрын Уналт дэлхийд сөрөг талыг авчирсан тул бид ямар адислалуудыг хүртэж болох вэ? (2 Нифай 2:23–27; Мосе 5:10–12-ыг үз.)

- Лихай хүүхдүүддээ “бүх зүйлд сөрөг тал байх нь зайлшгүй болой” гэж хэлсэн (2 Нифай 2:11; мөн шүлэг 15-ыг үз). Өдөр тутмынхаа амьдралд сөрөг талтай тулгарч байх нь чухал гэдгийг та нар хэрхэн харсан бэ? (Та энэ асуултын талаар ярилцахдаа ангийн гишүүдээр 2 Нифай 2:11–13-ыг уншуулж болно.) Сөрөг тал нь биднийг өсч хөгжихөд хэрхэн тусалдаг вэ?
- 2 Нифай 2:24–28-д гардгийн дагуу Тэнгэрлэг Эцэг маань бидний төлөө юуг хүсдэг вэ? (Баяр баясгалан, эрх чөлөө, мөнхийн амьдрал.) Эдгээр адислалуудыг хүлээн авах замыг Тэр бидэнд хэрхэн өгсөн бэ? (2 Нифай 2:26–27; мөн Иохан 14:6-г үз.) Сатан бидэнд юуг хүсдэг вэ? (2 Нифай 2:18, 27, 29-ийг үз. Зовлон, боолчлол, сүнслэг үхэл.) Бидний хүн нэг бүрийн үйлдэл биднийг баяр баясгалан, эрх чөлөө, мөнхийн амьдрал эсвэл зовлон, боолчлол, сүнслэг үхлийг хүлээн авч байгаа эсэхийг хэрхэн тодорхойлдог вэ?

Ахлагч Иосеф Б.Вортлин заахдаа, “Их Эзэн танд чөлөөтэй сонгох бэлгийг өгсөн (Мосе 7:32-ыг үз) бөгөөд сайныг муугаас ялгахыг хангалттай заасан (2 Нифай 2:5-ыг үз). Та нар сонгох эрхтэй (2 Нифай 2:27-г үз) бөгөөд та нарт үйлдэхийг зөвшөөрсөн (2 Нифай 10:23; Хиламан 14:30-ийг үз), гэхдээ та нар үр дагаврыг нь сонгох эрхгүй. Гарцаагүй тодорхой зүйл нь нүгэл болон хилэнцийг сонгох нь яваандаа аз жаргалгүй байдал, гуниг, зовлон руу хөтөлж байхад сайн бөгөөд зөв сонголт нь аз жаргал, амар амгалан руу хөтөлдөг” гэжээ (in Conference Report, Oct. 1989, 94; or *Ensign*, Nov. 1989, 75)

- 2 Нифай 2 нь Бүтээлтийн сургаал (2 Нифай 2:14–15), Уналт (2 Нифай 2:4–5, 8, 18–25), Цагаатгал (2 Нифай 2:3–4, 6–10, 26–27) зэргийг агуулдаг. Эдгээр гурван сургаал нь Тэнгэрлэг Эцэгийн гэтэлгэлийн төлөвлөгөөний гол хэсэг хэрхэн болдог вэ?

Дүгнэлт

Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан бид “[Аврагчийн] хайрын мутраар мөнхөд хүрээлүүлсэн” (2 Нифай 1:15) байж чадна гэдгийг онцлон тэмдэглэ. “Сонгох эрхтэй” байх нь агуу их адислал гэдгийг тайлбарлаж, ангийн гишүүдийг “бүх хүмүүний агуу их Зуучлагч” Есүс Христээр дамжуулан “эрх чөлөө болон мөнхийн амьдралыг сонгохыг” уриал (2 Нифай 2:27).

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэ санааг хичээлдээ хэрэглэж болно.

Дэлхийн сургаалуудын эсрэг Лихайн сургаалуудыг хэрэглэх нь

“Дэлхийн Худал Сургаалууд” гэсэн гарчиг дор жагсааж бичсэн дор байгаа мэдэгдлүүдийг самбарт бич. Ангийн гишүүдийг найзаасаа, хамт ажилладаг хүнээсээ эсвэл сургуулийн багшаасаа эдгээр худал мэдэгдлүүдэд итгэж маргаж байгааг нь сонсжээ гэж төсөөлөхийг хүс. Дараа нь биднийг дэлхийн худал сургаалуудтай тулгарсан үед бидэнд амар амгалан, баталгаа нотолгоог авчрах үнэнүүдийг Лихай хуваалцсан гэдгийг тайлбарла. “Лихайн

Сургаалууд” гэсэн гарчиг дор жагсааж бичсэн дор байгаа судрын заалтуудыг самбарт бич. Ангийн гишүүдээр судрын хэсэг бүрийг уншуулж, эдгээр нь тэднийг дэлхийн худал сургаалуудаас болж хүнд байдалд орсон үед амар амгаланг мэдрэхэд тэдэнд хэрхэн туслах тухай тодорхойлуул. Судрын заалтуудыг амьдралдаа хэрэгжүүлэх арга замуудын талаар ярилцахыг ангийн гишүүдэд уриал.

ДЭЛХИЙН ХУДАЛ СУРГААЛУУД	ЛИХАЙН СУРГААЛУУД
Сайн буюу муу гэж байдаггүй.	2 Нифай 2:5. (“Хүмүүн нь сайныг муугаас ялгаж мэдэхээр хангалттай зааварлагдсан.”)
Хууль гэж үгүй.	2 Нифай 2:5. (“Хууль нь хүмүүнд өгөгдсөн.”)
Христ байдаггүй.	2 Нифай 2:6. (“Ариун Месая түүнд мөн түүгээр гэтэлгэл ирдэг.”)
Энэ амьдралын дараа амьдрал үгүй.	2 Нифай 2:10. (“Бүх хүмүүн [Бурханы] дэргэд түүгээр шүүгдэх гэж зогсоно.”)
Бурхан байдаггүй.	2 Нифай 2:14. (“Бурхан буй.”)
Амьдралд зорилго гэж үгүй.	2 Нифай 2:25. (“Хүмүүн баясгалантай байж болохын тул хүмүүн байх бөлгөө.”)
Бидний үйлдлүүд генээс болон хүрээлэн байгаа орчноос шалтгаалдаг.	2 Нифай 2:26–27. (Бидний эрх бол “өөрсдийн тул үйлдэх бөгөөд бусдаар дээрээ үйлдүүлэх үгүй болой.” Бид “эрх чөлөө болон мөнхийн амьдралыг . . . эсвэл боолчлол болон үхлийг сонгох эрхтэй.”)

Зорилго Ангийн гишүүдийг Бошиглогч Иосеф Смитийн тухай гэрчлэлээ бэхжүүлж, Их Эзэнд итгэн, Түүний зарлигуудыг дагаснаар аз жаргалыг олоход уриалан дуудахад туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. 2 Нифай 3. Лихай хүү Иосефтоо Иосеф Смитийн тухай бошиглосон эртний бошиглогч Иосефийн тухай заадаг. Тэдний үр удам нь Бошиглогч Иосеф Смит болон Мормоны Номоор дамжуулан адислагдана гэж Лихай Иосефт заадаг.
 - б. 2 Нифай 4. Лихай хүүхдүүд болон ач нартаа сүүлчийн зөвлөгөөгөө өгөөд нас бардаг. Нифай өөрийн нүгэлдээ харуусдаг ч Бурханы сайн сайхныг алдаршуулдаг.
 - в. 2 Нифай 5. Нифайн эсрэг Лэмэн, Лэмүэл хоёр илүү их уурлах болдог. Нифайг дагагчид Их Эзэний зарлигийг дагахаар Лэмэний дагагчдаас салдаг. Нифайчууд “аз жаргалтай” амьдардаг ба Лэмэнчүүд ёсон бусыг хийснийхээ төлөө хараалгадаг.
2. Та ангийн нэг гишүүнээс 2 Нифай 4:15–35-ыг чангаар уншихыг хүсэж болно. Энэ хэсгийг заримдаа “Нифайн дуулал” гэж нэрлэдэг бөгөөд энд Нифайн сэтгэлийн гүний мэдрэмжийг илэрхийлдэг гэдгийг ангийн гишүүдэд мэдэгд.

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

2 Нифай 3 дээр адилхан нэртэй дөрвөн эрийн тухай дурддаг гэдгийг ангийн гишүүдэд хэл. Ангийн гишүүдийг эдгээр дөрвөн эрийг 2 Нифай 3:1–15-аас хайж олохыг урь. Ангийн гишүүдэд хайж олох цаг өгснийхөө дараа тэднээс хэнийг олсныг нь асуу. Зөв хариултуудыг дор бичив:

- а. Иосеф, Лихай, Сариа хоёрын отгон хүү (2 Нифай 3:1–3)
- б. Египетийн Иосеф (2 Нифай 3:4–5)
- в. Бага Иосеф Смит (2 Нифай 3:6–15)
- г. Том Иосеф Смит (2 Нифай 3:15)

Энэ товч үйл ажиллагааны дараа шууд 2 Нифай 3-ыг ярилц.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын

зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Лихай өөрийнх нь үр удам Бошиглогч Иосеф Смит болон Мормоны Номоор дамжуулан адислагдана гэдгийг заадаг.

2 Нифай 3-ыг ярилц. Сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг ангийн гишүүдээс хүс.

- Лихай өөрийн хүү Иосефтоо “Египетэд боолчлолд хүргэгдсэн” Иаков, Рахел хоёрын хүү Иосефын хэлсэн бошиглолын тухай заасан (2 Нифай 3:4; мөн Эхлэл 30:22–24; 37:1–3, 23– 28-ыг үз.) Египетийн Иосефын Их Эзэнтэй хийсэн гэрээнүүд яагаад Лихайн гэр бүлд чухал байсан бэ? (2 Нифай 3:4–5; Иаков 2:25; мөн Эхлэл 95:7-г үз.)
- Египетийн Иосефын үзэгдэлдээ үзсэн “сонгогдсон үзмэрч” нь хэн байсан бэ? (2 Нифай 3:6–15-ыг үз. Бошиглогч Иосеф Смит.) Иосеф Смит “[Их Эзэний] үгийг хэрхэн авчирсан” бэ? (2 Нифай 3:11 ба дор байгаа ишлэлийг үз.) Иосеф Смитийн авчирсан Бурханы үгийн ачаар та нар хэрхэн адислагдсан бэ?

Ахлагч Ли Гранд Ричардс хэлэхдээ: “Бошиглогч Иосеф Смит бидэнд Мормоны Ном, С ба Г, Агуу Үнэт Сувд болон бусад олон бичмэлүүдийг авчирсан. Бидэнд байгаа цэдгүүдэд гарснаар бол тэр бидэнд дэлхий дээр урьд өмнө нь амьдарч байсан бошиглогчдоос хамгийн олон үнэнийг илчилсэн” гэсэн (in Conference Report, Apr. 1981, 43; or *Ensign*, May 1981, 33).

- Их Эзэн Египетийн Иосефт Жүдагийн үр удмын бичсэн үгсийг агуулдаг Библийн болон Иосефийн үр удмын бичсэн үгсийг агуулдаг Мормоны Номын тухай хэлсэн (2 Нифай 3:12). Библи болон Мормоны Ном хэрхэн “хамтдаа хөгжсөн” бэ? Библи, Мормоны Ном хоёр “хамтдаа хөгжсөөр” ямар адислалууд ирнэ гэж Их Эзэн хэлсэн бэ? (2 Нифай 3:12-ыг үз.)
- Египетийн Иосефын үр удмын “зөв шударга мөчир” “хугарсан” байх боловч “Их Эзэний гэрээнүүдэд санагдсан” байна гэж Их Эзэн амласан (2 Нифай 3:5). Эдгээр гэрээнүүдийг биелэхэд Иосеф Смит, Мормоны Ном ямар үүрэгтэй вэ? (2 Нифай 3:12–13, 18–21; 30:3–6-г үз.) Энэ амлалт өнөөдөр хэрхэн биелж байна вэ? Их Эзэнтэй хийсэн гэрээнүүдээ санаж, мөрдөж байхад Мормоны Ном та нарт хэрхэн тусалдаг вэ?
- Египетийн Иосеф, Лихайн хүү Иосеф, Иосеф Смит нарыг нэрнээс нь гадна юу холбож байдаг вэ? (2 Нифай 3:4–7, 11–12, 18–21-ыг үз. Хариултанд удам угсаа, гэрээнүүд, Мормоны Ном орж болно.)

2. Нифай нүгэлт байдалдаа харуусдаг ч Бурханы сайн сайхныг алдаршуулдаг.

2 Нифай 4-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Лихай нас барахынхаа өмнөхөн хүүхдүүд болон ач нартаа зөвлөгөө өгч, тэднийг адисласан гэдгийг тайлбарла (2 Нифай 4:3–12).

Лихайг нас бараад удаагүй байтал Лэмэн, Лэмүүл, мөн Ишмэилийн хөвгүүд Их Эзэний зэмлэлээс болж [Нифайд] уурласан (2 Нифай 4:13). Эдгээр хүнд хэцүү байдал үргэлжилж байгааг Нифай бичихдээ өөрийн сэтгэгдлээ нэг хэсэг дээр бичсэн бөгөөд үүнийг нь заримдаа “Нифайн дуулал” гэж нэрлэдэг. Нифайн дууллын тухай ярилцлагынхаа оршил болгож дуулал

гэдэг нь шүлэг буюу дуулал, бидний өнөөдрийн сүмийн дуулалтай илүү адил ном гэдгийг тайлбарла. Та ангийн гишүүдээр тэдний хамгийн дуртай цөөн хэдэн дууллыг нь нэрлүүлж, эдгээр дууллауд нь тэдэнд яагаад чухал утгатай болохыг нь товчхон яриулж болно.

Хэрэв та ангийн гишүүнээс Нифайн Дууллыг уншиж бэлтгэхийг хүссэн байсан бол түүнийг одоо уншихыг урь. Ангийн бусад гишүүдийг түүний даган чимээгүй уншихыг урь.

- Нифай хэлэхдээ, “сэтгэл минь Их Эзэний зүйлүүдэд баясч; мөн зүрх минь [тэднийг] үргэлж тунгаадаг” гэжээ (2 Нифай 4:16). Нифай чухам ямар тодорхой зүйлүүдэд баяссан бэ? (2 Нифай 4:15–16-г үз.) Тунгаах гэдэг нь ямар утгатай вэ? Их Эзэний зүйлүүдийг тунгаах цаг гаргахын тулд бид юу хийж болох вэ? Их Эзэний зүйлүүдийг тунгаах нь бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- Та нар Нифайг дүрслэхдээ ямар үгсийг ашиглах вэ? (Хариултанд, *зөв шударга, дуулгавартай* мөн *даруу* нь орж болно.) Нифай яагаад өөрийгөө “бодгаль нь түүний алдсуудын учир гашуудах” “золгүй хүн” гэж хэлсэн бэ? (2 Нифай 4:17, 27 мөн 1 Нифай 10:6-г үз.) Бурханы өмнө өөрийн унасан мөн чанараа ухаарах нь яагаад чухал вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон хэлэхдээ: “Хүн үнэндээ өлстлөө хоол идэхийг хүсдэггүй шиг, түүнд яагаад Христ хэрэгтэйг мэдтэлээ тэр Христийн авралыг хүсдэггүй. Уналтын сургаалыг болон үүний бүх хүн төрөлхтөнд үзүүлэх нөлөөг хүлээн зөвшөөрч, ойлгох хүртлээ хэн ч Христ яагаад хэрэгтэй ном бэ гэдгийг зохих ёсоор нь мөн хангалттай мэдэж авдаггүй” гэжээ (in Conference Report, Apr. 1987, 106; or *Ensign*, May 1987, 85).

- Нифай уруу таталт болон нүгэлд “хүрээлүүлсэн” ном шиг сэтгэгдэлтэй байхын оронд яагаад найдлагыг олж авсан бэ? (2 Нифай 4:18–19-ийг үз.) Их Эзэн Нифайд урьд өмнө нь хэрхэн тусалж байсан бэ? (2 Нифай 4:20–25-аас энэ асуултанд хариулт олохын тулд ангийн гишүүнээр уншуул. Тэдний хариултыг самбарт бич. Зарим хариултыг дор өгөв.)

Их Эзэн:

- а. Нифайг дэмждэг байсан (2 Нифай 4:20).
 - б. Аглаг буйд дахь зовлонгуудын дундуур Нифайг удирдсан (2 Нифай 4:20).
 - в. Түүнийг хайраараа дүүргэсэн (2 Нифай 4:21).
 - г. Түүний дайснуудыг гутаасан (2 Нифай 4:22).
 - д. Түүний гуйлтыг сонссон (2 Нифай 4:23).
 - е. Түүнд үзэгдлүүдээр мэдлэгийг өгсөн (2 Нифай 4:23).
- Та үүнтэй төстэй адислалуудыг Их Эзэнээс хэзээ авсан бэ? Урьд нь авч байсан адислалуудаа санаж байх нь хүнд хэцүү цагт танд хэрхэн тусалдаг вэ?
 - Нифай харсан мөн мэдсэн зүйлүүдийнхээ оронд яагаад гуниг зовлон, нүгэлд бууж өгсөн бэ гэж өөрөөсөө асуусан (2 Нифай 4:26–27). Бид сайн мэдээний мэдлэгийнхээ оронд заримдаа гуниг зовлон, уруу таталтаас болж яагаад зовдог вэ? Гуниг зовлон, уруу таталтыг давж гарахад бидэнд Нифайн дуулал юу заадаг вэ? (2 Нифай 4:28–30-ийг үз.)
 - Түүний дууллын эхэн хэсэгт Нифайн үгс өөр лүү нь хандсан байсан (2 Нифай 4:15–30). Дууллын төгсгөл нь залбирал байсан (2 Нифай 4:30–35).

Нифай Тэнгэрлэг Эцэгээс залбиралдаа юу асуусан бэ? (2 Нифай 4:31–33-ыг үз. Ангийн гишүүдийг Нифайн залбирлын хэсгээс ялангуяа тэдэнд илүү их утга санаа илэрхийлж байгааг нь ярилцахыг урь. Та ярилцлагыг өрнүүлэхээр дор байгаа асуултуудаас заримыг нь хэрэглэж болно.)

- а. Их Эзэн “[биднийг] дайснуудын [маань] гараас хэрхэн чөлөөлдөг” вэ? (2 Нифай 4:31, 33-ыг үз.)
 - б. “Нүглийг хараад чичрэх” гэдэг ямар утгатай вэ? (2 Нифай 4:31, Мозая 5:2; Алма 13:12-ыг үз.)
 - в. “Дорд хөндийн замаар алхах” болон “энгийн замаар шулуун байх” гэдэг нь ямар утгатай гэж та нар бодож байна вэ? (2 Нифай 4:32).
 - г. Их Эзэн “[биднийг] [Өөрийн] зөв шударгын орхимжиндоо ороох” гэдэг нь ямар утгатай гэж та нар бодож байна вэ? (2 Нифай 4:33).
- Нифай залбиралдаа юуг хийхийг амласан бэ? (2 Нифай 4:30, 34–35-ыг үз. Тэр Бурханд итгэж, Түүнийг үүрд магтахыг амласан.) Нифай “Би өөрийн найдлагыг махан бодиос бүтсэн хэн нэгний гарт тавихгүй” гэж хэлснээрээ ямар утга санааг илэрхийлсэн бэ? (2 Нифай 4:34; 28:31-ийг үз.) Хүмүүс “махан бодиос бүтсэн хэн нэгний гарт найддаг” ямар талууд байдаг вэ? Үүний аюул нь юу вэ? Их Эзэнд итгэх итгэлээ өсгөхийн тулд бид юу хийж чадах вэ?

3. Нифайн эсрэг Лэмэн, Лэмүүл хоёрын уурлах нь ихэсдэг бөгөөд Их Эзэн Нифайн дагалдагчийг Лэмэний дагалдагчдаас салахыг зарлигладаг.

2 Нифай 5-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Лэмэн, Лэмүүл хоёр Нифайд яагаад уурласан бэ? (2 Нифай 4:13; 5:3-ыг үз.) Уур нь улам ихэссэний эцэст Лэмэн Лэмүүл хоёр юу хийхийг завдсан бэ? (2 Нифай 5:2, 4-ийг үз. Тэдний уурыг 2 Нифай 4:27–29 дээр бичигдсэн Нифай өөрийн уураа хянах гэж оролдож байгаатай харьцуул.) Илүү их уурлахын аюул юу вэ? Бид гэртээ, олон нийтэд, Сүмд амар амгаланг авчрагч байхын тулд юу хийж чадах вэ?

Ерөнхийлөгч Ховард В.Хантэр заахдаа: “Бидэнд илүү их амар тайван гэр бүл, хөршүүд, олон нийтээс өсч гарах илүү амар амгалан ертөнц хэрэгтэй. Ийм амар амгаланг хамгаалж, хөгжүүлэхийн тулд ‘бид бусдыг, тэр ч бүү хэл дайснуудаа, түүнчлэн найз нөхдөө хайрлах’ ёстой. . . . Бид нөхөрлөлийн гараа сунгах хэрэгтэй. Бид илүү эелдэг, илүү зөөлөн, илүү өршөөнгүй, уурлахдаа илүү удаан байх хэрэгтэй. Бид нэг нэгнийгээ Христийн цэвэр хайраар хайрлах хэрэгтэй. Энэ нь бидний зөвлөгөө, хүсэл байг” гэжээ (in Conference Report, Apr. 1992, 87; or *Ensign*, May 1992, 63).

- Ах нар нь уурласан тул Нифай тусламж эрж залбирсан (2 Нифай 5:1). Их Эзэн түүний залбиралд хэрхэн хариулсан бэ? (2 Нифай 5:5-ыг үз.)
- Нифай болон түүний хүмүүс салж яваад, тэд “аз жаргалтай хүмүүний ёсоор амьдарсан” (2 Нифай 5:27). Тэд аз жаргалдаа хувь нэмэр оруулах юуг хийсэн бэ? (2 Нифай 5:10–17-г үз. Хариултанд, тэд зарлигуудыг дагасан, гуулин ялтсууд дээр байсан цэдгүүдийг хадгалсан нь орж болно.) Нифайчуудын жишээ бидэнд “аз жаргалтай хүмүүний ёсоор амьдрахад” хэрхэн тусалж чадах вэ?

**Заах Нэмэлт
Санаанууд**

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэ санааг хичээлдээ хэрэглэж болно.

“Сэтгэл минь сэр! . . . Баяс, өө зүрх минь” (2 Нифай 4:28)

Бид шантарсан үедээ Нифайн жишээг дагаж болно гэдгийг тайлбарла. 2 Нифай 4 ба 5-р бүлэгт шантарсан сэтгэлээ дарахад бидний хийж болох хэд хэдэн жишээг өгсөн байдаг. Дараах жишээнүүдийг ангийн гишүүдтэй ярилц:

- а. Судраас унш (2 Нифай 4:15).
- б. Их Эзэний зүйлүүдэд баясаж, тунгаа (2 Нифай 4:6).
- в. Их Эзэнд итгэж, Түүнээс дэмжлэг эрж Түүн рүү хар (2 Нифай 4:20–21, 34).
- г. Хүчирхэг залбирал үйлд (2 Нифай 4:24).
- д. Үйлдвэрлэгч байж; хөдөлмөрлө (2 Нифай 5:15, 17).
- е. Ариун сүмд үйлчил (2 Нифай 5:16).

“Бурханы Маань Сайн Сайхан Ямар Агуу Их Билээ”

Хичээл
8

2 Нифай 6–10

Зорилго Ангийн гишүүдэд Есүс Христийн Цагаатгал хэрэгтэй гэдгийг ойлгуулж, Цагаатгалын бүх адислалуудыг хэрхэн хүлээн авахыг заахад туслах болно.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. 2 Нифай 9:1–26, 39–54. Аврагчийн Цагаатгалаар дамжуулан бид зуурдын үхлээс болон сүнслэг үхлээс аврагдаж чадна гэдгийг Иаков гэрчилдэг. Тэрээр Цагаатгалын бүх л адислалуудыг хүлээн авахад бидэнд туслах зарчмуудын тухай ярьдаг.
 - б. 2 Нифай 9:27–38. Цагаатгалын бүх адислалуудыг хүлээн авахад бидэнд саад болдог зан байдал, үйлдлийн тухай тэр ярьдаг.
 - в. 2 Нифай 10. Гэтэлгэгчийг Христ гэж нэрлэх болно гэж Иаков бошиглодог. Нифайчуудын үр сад итгэлгүйгээсээ болж мөхөх бөгөөд Ерусалимын Жүүдүүд Аврагчийг цовдолж, Түүнд итгэлтэй тараагдсан байх болно гэж Иаков бошиглодог. Их Эзэний Өөрийн хүмүүстэйгээ байгуулсан гэрээнүүдийг Иаков гэрчилж, хүмүүст өөрсдийгөө Бурханы таалалд эвлэрүүл гэж уриалдаг.
 2. Нэмж унших зүйл: Исаиа 49–52. Та Исаиа 49:22–26-г 2 Нифай 6:6–7, 16–18-тай; Исаиа 50-ийг 2 Нифай 7-той; Исаиа 51-ийг 2 Нифай 8:1–23-тай; Исаиа 52:1–2-ыг 2 Нифай 8:24–25-тай харьцуулж болно.
 3. Хэрэв та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглэж байгаа бол дараах зургуудыг ангидаа авчир: Уулан Дээрх Номлол (62166; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 212); Есүс Хараагүй Хүнийг Эдгээсэн нь (62145; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 213); Шуургыг Намжаасан нь (62139; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 214); Есүс Иайрын Охиныг Адисласан нь (62231; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 215); Христ ба Хүүхдүүд (62467; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 216); Есүс Гетсеманид Залбирсан нь (62175; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 227); ба Цовдлолт (62505; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 230).

Хичээлийг

Баяжуулах

Зөвлөмж

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

“Бэлтгэл” хэсэгт жагсааж бичсэн зургуудыг үзүүл. Ангийн гишүүдийг зургуудыг хараад Есүс Христ тэдний төлөө юу хийснийг бодохыг хүс. Дараа нь тэднээс бодсон зүйлсийнхээ заримаас хуваалцахыг хүс. Тэдний хариултыг самбарт бич.

Дараах шүлгүүдийг чангаар уншихыг ангийн гишүүдээс хүс: 2 Нифай 6:17; 7:2; 8:3–16, 12. Шүлгээс Аврагчийн бидний төлөө хийсэн зүйлүүдийг харуулсан үгсийг хайхыг тэднээс хүс. Үгсийг самбарт бич. Жагсааж бичих үгст дараах нь орж болно: *чөлөөлөх* (2 Нифай 6:17; 7:2), *аврах* (2 Нифай 7:2), *тайтгарал*, *тайтгаруулах* (2 Нифай 8:3, 12), *гэрэл* (2 Нифай 8:4), *шүүлт*, *шүүх* (2 Нифай 8:4–5), ба *аврал* (2 Нифай 8:5–6).

Энэ хичээлд Есүс Христийн бидний төлөө хийсэн хамгийн агуу үйл болох Цагаатгалын тухай ярилцана гэдгийг тайлбарла.

Судрын Ярилцлага ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Есүс Христ өөрийн Цагаатгалаар дамжуулан зуурдын болон сүнслэг үхлээс гэтэлж гарахыг санал болгодог.

2 Нифай 9-д Нифайн дүү нарын нэг Иаков, Есүс Христийн авралын төлөвлөгөөний гол үйл явдал Цагаатгалын тухай ярьсан нь агуулагддаг. Энэ бүлэгт байгаа судруудыг ойлгохын тулд Иаков зуурдын болон сүнслэг үхлүүдийн тухай юу хэлснийг мэдэж авах нь тустай гэдгийг тайлбарла.

Зуурдын үхэл нь бие махбодын үхэл болоод сүнс бие махбодоос салахыг хэлдэг. Адамын Уналтын үр дүнд бүх хүн зуурдаар үхэх болно (2 Нифай 9:6), 2 Нифай 9-д Иаков зуурдын үхлийн тухай хэлэхдээ дараах үгсийг ашигладаг: “үхэл” (шүлэг 6), “биеийн үхэл” (шүлэг 10), ба булш (шүлэг 11).

Сүнслэг үхэл гэдэг нь Бурханы дэргэдээс тусгаарлагдахыг хэлдэг. Адамын Уналтын үр дүнд бид бүгд Бурханаас тусгаарлагдсан (2 Нифай 9:6). Бид нүгэл хийхдээ өөрсдийгөө Бурханаас улам тусгаарладаг (Ром 3:23; Алма 12:16; Хиламан 14:18). 2 Нифай 9-д Иаков сүнслэг үхлийн буюу Бурханаас тусгаарлагдахыг илэрхийлэхдээ дараах үгсийг хэрэглэдэг: “Бурханы дэргэдээс таслагдах” (шүлэг 9); “сүнсний үхэл” (шүлэг 10), “сүнсний үхэл” (шүлэг 12), “там” (шүлэг 12), ба “үхэл” (шүлэг 39).

2 Нифай 9:1–26, 39–54-ийг ярилц. Ангийн гишүүдийг сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь.

- Зуурдын болон сүнсний үхлийг давж гарахын тулд Аврагч юу хийсэн бэ? (2 Нифай 9:5–7, 12, 21–22; мөн Лук 22:44; Мозая 3:7; С ба Г 19:16–19-ийг үз.)
- Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан бүх хүн дахин амилж, зуурдын үхлээс аврагдана (2 Нифай 9:12–13, 22-ыг үз.) Христийн Дахин Амилалтын хүч байхгүй бол бидэнд юу тохиолдох вэ? (2 Нифай 9:6–9-т үз. Зуурдын болон сүнсний үхэл нь тогтмол байх болно. Бид Бурханы дэргэдээс үүрд таслагдаж, сүнснүүд маань Сатаны харъяалалд байна. Бид “худал хуурмагийн эцэгтэй хамт зовлонд үлдэх” болно.) Энэ нь зуурдын болон сүнсний үхлүүд нь “аймшигт мангас” юм гэдгийг хэрхэн харуулдаг вэ? (2 Нифай 9:10).
- Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан бүх хүмүүс шүүгдэхээр Бурханы дэргэд дахин сэргэгдэх болно (2 Нифай 2:10; 9:15). Хэдий тийм ч бүх хүн “Бурханы хаант улсад аврагдаж” эсвэл Бурханы дэргэд үүрд үлдэх

зөвшөөрлийг авахгүй (2 Нифай 9:23; Мормон 7:7). Иаковын хэлснээр “Бурханы хаант улсад аврагдахын” тулд бидний хийх ёстой зарим зүйл юу вэ? (Ангийн гишүүдээр 2 Нифай 9:18, 21, 23–24, 39, 41, 50–52-ыг энэ асуултанд хариу олохын тулд уншуул. Тэдний хариултыг дүгнэж самбарт бич. Хариултуудыг дор үзүүлсний адилаар ярилц.)

- а. Израилын Ариун Ганц Есүс Христэд итгэж; Түүнд ирэх (2 Нифай 9:18, 23–24, 41). Түүний Цагаатгалын бүх адислалуудыг хүлээн авахын тулд Есүс Христэд итгэх итгэл нь яагаад чухал вэ?
- б. Дэлхийн загалмайнуудыг тэвчиж мөн дэлхийн ичгүүрүүдийг умартах (2 Нифай 9:18). Дэлхийн загалмайнуудыг тэвчих гэдэг нь ямар утгатай вэ? (Матай 16:24, зүүлт 24; 3 Нифай 12:29–30-ийг үз.) Дэлхийн ичгүүрийг умартах гэдэг нь ямар утгатай вэ? (2 Нифай 9:49-ийг үз.)
- в. Их Эзэний дууг сонсох (2 Нифай 9:21). Бид Их Эзэний дууг хэрхэн сонсож чадах вэ? (С ба Г 1:38; 18:33–36; 88:66-г үз.)
- г. Наманчлал, усан баталгаа мөн эцсээ хүртэл тэвчих (2 Нифай 9:23–24).
- д. Сүнсээ бодсон байх (2 Нифай 9:39; мөн Ром 8:5–8-ыг үз.) Сүнсээ бодсон байх гэдэг нь ямар утгатай гэж та нар бодож байна вэ? Сүнсээ бодсон байх нь “мөнхийн амьдрал” руу хэрхэн хөтөлдөг вэ? Биеэ бодсон байх гэдэг нь ямар утгатай вэ? Биеэ бодсон байх нь сүнсний үхэл рүү хэрхэн хөтөлдөг вэ? Илүү их сүнсээ бодохын тулд бид юу хийж болох вэ?
- е. “Мөхөх үгүй түүний дээр хуримла” (2 Нифай 9:50–51). Хэзээ ч мөхдөггүй зарим ямар зүйлүүд байдаг вэ? Бид эдгээр зүйлүүд дээр хэрхэн “хуримлаж” болох вэ?
- ё. Бурханы үгийг сана (2 Нифай 9:52). Бурханы үгсийг санаж байх нь Цагаатгалын бүх адислалуудыг хүртэхэд бидэнд хэрхэн тусалдаг вэ? (3 Нифай 15:1-ийг үз.)
- ж. Үргэлж залбирч, таларх (2 Нифай 9:52). Залбирч Тэнгэрлэг Эцэгтээ талархлаа илэрхийлэх нь та нарыг Түүнд болон Түүний Хүүд илүү ойр болоход хэрхэн тусалсан бэ?

2. Тодорхой зан байдал болон үйлдлүүд нь биднийг Цагаатгалын бүх адислалуудыг хүлээн авахад саад болж байдаг.

2 Нифай 9:27–38-ыг уншаад ярилц. Цагаатгалын бүх адислалуудыг хүлээн авах болзлын тухай ярихын зэрэгцээ Иаков эдгээр адислалуудыг хүртэхэд бидэнд саад болдог зан байдал, үйлдлүүдийн тухай ярьсан гэдгийг тайлбарла.

- Цагаатгалын бүх адислалуудыг хүртэхэд бидэнд саад болдог зан байдал, үйлдлүүд нь юу вэ? (Ангийн гишүүдээр энэ асуултанд хариу олохын тулд 2 Нифай 9:27–38-ыг уншуул. Тэдний хариултыг дүгнэж самбарт бич. Дор үзүүлсэн хариултуудыг ярилц.)
 - а. Зарлигуудыг зөрчиж, сорилтын өдрүүдээ үрэх (2 Нифай 9:27). Мормоны Номонд бошиглогчид бидний амьдралыг “сорилтын байдал” буюу шалгуулах үе гэж үргэлж нэрлэдэг (2 Нифай 2:21; мөн 2 Нифай 2:30; Мормон 9:28-ыг үз.) Зарим хүмүүс сорилтын өдрүүдээ хэрхэн үрдэг вэ? (2 Нифай 9:38; Алма 34:31–33; Хиламан 13:38-ыг үз.)
 - б. Суралцах, мөнгө болон бусад хиймэл шүтээнийг Бурханаас дээгүүр тавих (2 Нифай 9:28–30, 37). Мэдлэг, баялгийн хойноос хөөцөлдөх нь биднийг Цагаатгалын бүх адислалуудыг хүртэхэд хэрхэн саад болдог вэ? (2 Нифай 9:28, 30, 42-ыг үз.) Суралцах явдал, эд баялаг зэрэг нь ямар

- нөхцөлд сайн зүйл байдаг вэ? (2 Нифай 9:29; Иаков 2:18–19-ийг үз.)
- в. Сүнсээрээ дүлий ба сохор байх (2 Нифай 9:31–32). Сүнсээрээ дүлий ба сохор байх гэж ямар утгатай вэ? Сайн мэдээний үнэнүүдэд бид чих болон нүдээ хэрхэн нээж чадах вэ?
- г. “Зүрх сэтгэл нь хөндөгдөөгүй” байх (2 Нифай 9:33). Эртний Израилд хөвчөө хөндүүлээгүй эр хүн Бурхантай хийсэн гэрээгээ зөрчсөн гэж үздэг байжээ (Эхлэл 17:11, 14). Үүнээс үзэхэд “зүрх сэтгэл нь хөндөгдөөгүй” гэдэг нь ямар утгатай вэ?
- д. Худал ярих, аллага, садар самууныг үйлдэгчид (2 Нифай 34–36).

3. Их Эзэн Өөрийн Хүмүүстэй байгуулсан гэрээнүүдээ санадаг.

2 Нифай 10-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Иаков Нифайн үр удам “итгэлгүйн учир бие махбодиороо мөхнө”, мөн Ерусалим дахь Жүүдүүд Аврагчийг цовдолж, нүглээсээ болж тараагдана гэж бошиглосон (2 Нифай 10:2–6). Эдгээр хүмүүс Түүнд итгэж, нүглээ наманчилбал Их Эзэн тэдний төлөө юу хийх вэ? (2 Нифай 10:2, 7–8, 21–22; мөн 1 Нифай 21:15–16; 2 Нифай 9:1–3, 53; 30:2-ыг үз.) Энэ нь бидний хүн нэг бүрт хэрхэн хамаардаг вэ? (Мозая 26:22-ыг үз.)

Ахлагч Бойд К.Пакер заахдаа: “Дэндүү оройтсон байдаг нэг алдаа (эсвэл бүр нэлээн хэдэн) болох зориг мохоосон санаа нь Их Эзэнээс ирдэггүй. Тэрээр, хэрэв бид наманчилбал, бидний гэмийг өршөөгөөд зогсохгүй харин ч Тэр нүглүүдийг маань мартаж, дахин хэзээ ч санахгүй гэж хэлсэн (Исаиа 43:25; Еврей 8:12; 10:17; Алма 36:19; С ба Г 58:42-ыг үз)” гэсэн (in Conference Report, Apr. 1989, 72; or *Ensign*, May 1989, 59).

- Их Эзэн Өөрийн гэрээт хүмүүсээ санадаг тул түүний хүмүүс “зүрх сэтгэлээ урамтай болгох” ёстой гэж Иаков хэлсэн (2 Нифай 10:22–23). Их Эзэн Өөрийн гэрээт хүмүүсээ санадаг гэдгийг мэдсэнээр бид тайтгарлыг хэрхэн олж болох вэ?
- Иаков хүмүүст хандсан яриагаа өндөрлөхдөө тэдэнд юуг санахыг уриалсан бэ? (2 Нифай 10:23–24-ийг үз.) Бид ямар замаар үүрдийн үхэл эсвэл үүрдийн амьдралыг сонгодог вэ? (2 Нифай 2:26–27-г үз.) Бурханы таалалд эвлэрүүлэх гэдэг нь ямар утгатай вэ? “Зөвхөн Бурханы ач ивээлийн дагуу [бид] аврагддаг” гэдгийг санах нь яагаад чухал вэ?

Дүгнэлт

Иаковын ярианы төгсгөлийн захиас болох 2 Нифай 10:25-ыг ангийн нэг гишүүнээр чангаар уншуул. Есүс Христийн Цагаатгалын төлөө талархлаа илэрхийлж, ангийн гишүүдийг “мөнхийн амьдралын замыг сонгохыг” уриал (2 Нифай 10:23).

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

**Заах Нэмэлт
Санаанууд**

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэ санааг хичээлдээ хэрэглэж болно.

Израилын цугларалт

- Израил хэрхэн цугларах вэ? (2 Нифай 10:8–9-ийг үз.)

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон заахдаа:

“Абрахамын үр сад болох бидний хариуцлага бол ‘энэ үйлчлэл болон пристийн зэргийг бүх үндэстэнд гэрчлэх’ номлогчид байх явдал юм (Абрахам 2:9). Мосе Көртландын Ариун Сүмд Иосеф Смитэд Израилыг цуглуулах түлхүүрүүдийг хүртээсэн (С ба Г 110:11-ийг үз.)

“Тэгвэл, энэ цугларалтанд зориулж Бурхан ямар зэмсгийг бүтээсэн бэ? Энэ нь Есүс бол Христ, Иосеф Смит бол Түүний бошиглогч, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол үнэн гэдэгт дэлхийг итгүүлэхэд зориулж бүтээсэн зэмсэгтэй адил юм. Энэ нь манай шашны тулгуур чулуу болох судар юм” гэжээ (in Conference Report, Apr. 1987, 107–8; or *Ensign*, May 1987, 85)

“Миний Бодгаль Исаягийн Үгэнд Баясдаг”

2 Нифай 11–25

Зорилго

Ангийн гишүүдэд Исаягийн бошиглолыг унших урам оруулж эдгээр бошиглолуудыг өөрсдийн амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэхийг ойлгоход нь туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. 2 Нифай 11; 25:1–7. Нифай Исаягийн бичсэн зүйлсийн чухлын талаар гэрчилж, эдгээрийг ойлгоход бидэнд туслах түлхүүрүүдийн талаар заадаг.
 - б. 2 Нифай 12:1–12. Исая хожмын үеийн ариун сүм, Израилын цугларалтыг хардаг.
 - в. 2 Нифай 15:26–29; 21:12. Исая, Их Эзэн нэгэн далбааг өргөж, Израилыг цуглуулна гэж бошиглодог.
 - г. 2 Нифай 16; 22; 25:19–30. Исая, Нифай нар Аврагчийн аврах хүчний тухай гэрчилдэг.
2. Хэрэв дараах зургууд байгаа бол хичээлдээ хэрэглэхээр бэлтгэ: Исаиа Есүс Христийн Мэндлэх Тухай Бичсэн нь (62339; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 113); Солт Лэйкийн Ариун Сүм (62433; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 502); ба Есүс бол Христ (62572; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 240).
3. Исаягийн бичсэн зүйлсийг илүү ойлгохын тулд та *Хуучин Гэрээний Сайн Мэдээний Номлолын Багшийн Гарын Авлагын* (35570) 36–40-р хичээлийг үзэж болно.

Хичээлийг

Баяжуулах

Зөвлөмж

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Мозая 8:17–18-ыг унш. Дараа нь ангийн гишүүдээс дараах асуултуудыг асуу:

- Үмэрч нар юуг үзэх чадвартай вэ? (Өнгөрсөн, одоо, ирээдүйн үйл явдлууд.) Үзмэрч нар бидэнд яагаад чухал вэ?

Исая үзмэрч байсан учраас Тэнгэр дэх Дайн, Аврагчийн үхлийн дараах Ерусалим сөнөсөн нь, Армагеддоны тулаан, Аврагчийн мянган жилийн хаанчлал зэрэг үйл явдлуудыг үзэгдэлдээ үзсэн гэдгийг тайлбарла.

Исаягийн тэмдэглэлийн ихэнх нь өнгөрсөн, ирээдүйн өргөн цар хүрээтэй үйл явдлуудыг бэлэгдлийн хэлээр илэрхийлдэг тул ойлгоход хэцүү мэт байдаг. Хэдий тийм ч үүнийг залбирч, хичээнгүйлэн уншиж, судлан хичээл зүтгэл гаргавал бид ойлгож чадна. Энэ хичээлд Исаягийн хамгийн чухал ач холбогдол бүхий тэмдэглэлүүдийн заримын тухай ярилцана.

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Нифай Исаягийн тэмдэглэлийн тухай гэрчилж, тэдгээрийг ойлгох түлхүүрүүдийг өгдөг.

2 Нифай 11; 25:1–7-г ярилц. Сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг ангийн гишүүдээс хүс. Заах нэмэлт санааны нэгдүгээрийг та хэрэглэж байгаа бол урьдчилан даалгасан ангийн гишүүнээс Исая болон түүний цаг үеийн тухай товч мэдээлэхийг урь.

- Нифай Исаягийн үгсийг өөрийн тэмдэглэлдээ оруулах нь чухал гэж яагаад бодсон бэ? (1 Нифай 19:23; 2 Нифай 11:2–6, 8; 25:3-ыг үз.) Эдгээр хэсэг тус бүрийг чангаар уншихыг ангийн өөр өөр гишүүнээс хүс. Хэсэг тус бүрийг унших үед самбар дээр гол хэсгийг нь бичиж, Исаягаас иш татсан шалтгааныг нь самбарт бичихийг ангийн нэг гишүүнээс хүс. Жишээг дор үзүүлэв.)

НИФАЙ ЯАГААД ИСАЯГААС ИШ ТАТСАН БЭ	
1 Нифай 19:23	“Их Эзэнд тэднийг илүү бүрэн дүүрэн итгүүлэх”
2 Нифай 11:2–4	Есүс Христийн өөр нэгэн гэрчийг өгөх
2 Нифай 11:5–6, 8	Биднийг (уншигч биднийг) баясахад туслах
2 Нифай 25:3	Бурханы шүүлтийг илчлэх

- Эдгээр шалтгаанууд бидэнд өнөөдөр яагаад чухал вэ? Исаягийн үгсийг ойлгох нь биднийг хэрхэн баясгаж чадах вэ?

Исаягийн бичээсийг илүү сайн ойлгоход бидэнд туслах хэд хэдэн түлхүүрүүдийг Нифай бидэнд хангаж өгсөн гэдгийг тайлбарла. Цагтаа тааруулан эдгээр түлхүүрүүдийн тухай ангийн гишүүдтэй ярилц.

Түлхүүр 1: “Бүхий л судруудыг өөрсөдтэйгөө адилтгах” (1 Нифай 19:23; мөн 2 Нифай 11:2, 8-ыг үз.) Исаягийн бошиглолын ихэнх нь хожмын үед болох үйл явдлууд байдаг. Эдгээр бошиглолуудыг биелэхийг харснаар мөн эдгээрийг биеллээ олоход оролцсоноор бид Исаягийн сургаалуудыг илүү сайн ойлгож, тэдгээрийг амьдралдаа хэрэгжүүлж чаддаг. Жишээ нь, 2 Нифай 15-д Их Эзэн “үндэстнүүдэд далбааг өргөх” болно гэж бошиглосон нь агуулагддаг (2 Нифай 15:26). Энэ бошиглол нь далбаа буюу жишиг, Их Эзэн рүү бүх үндэстнүүдийг хөтлөх дахин сэргээгдсэн сайн мэдээг хуваалцахын чухлыг илүү сайн ойлгоход бидэнд тусалдаг.

Түлхүүр 2: “Жүүдүүдийн дундах бошиглолуудын арга ухааны талаар мэдэх” (2 Нифай 25:1). Жүүдүүд уншиж, сонсохдоо дасал болсон гэсэн тэр хэв

маягаар Исаегийн бошиглолууд бичигдсэн байдаг. Түүний цаг үед байсан Жүүд хүмүүстэй төстэйгөөр зохиомол зүйл болон бэлэгдлийн зүйлүүдийг тэр хэрэглэсэн гэдгийг бид мэдвэл Исаегийн бичээсийг илүү сайн ойлгож чадна. Жишээ нь, 2 Нифай 12:1–3-т Исая “уул” гэдэг үгийг ариун сүм мэт өндөр дээд сүнслэг газар, илэрхийлэлтийн газар болон Бурхантай ойр байх газрыг бэлэгдэхдээ хэрэглэдэг.

Түлхүүр 3: “Бурханы шүүлтийг мэдэх” (2 Нифай 25:3; мөн шүлэг 6-г үз.) Исая Израил болон Иудагийн хаант улсууд ёсон бус байдлаасаа болж хэрхэн зовохыг урьдаас хардаг боловч, мөн тэд наманчилж, Есүс Христийг дагахад тэдний адислалууд нь дахин сэргээгдэнэ гэдгийг бошиглосон. Израилчууд болон Иудагийнханд тохиолдсон явдлыг бичсэн Исаегийн тэмдэглэлээс мөн Израилын угсаа ирээдүйд дахин сэргэхийг бошиглосноос нь бид Бурхан бидний амьдралд хэрхэн нөлөөлдөг, мөн Тэрээр үндэстнүүдийг өөрсдийнх нь зөв шударга байдлын дагуу хэрхэн адисладгийг илүү сайн ойлгодог.

Түлхүүр 4: “Ерусалим хавийн газар нутгийг мэдэх” (2 Нифай 25:6). Израилын газар зүйн байдал, газрын нэрсийг мэдэх нь Израил болон Иудагийн хаант улсуудын тухай болон тэднийг айлгах үндэстнүүдийн тухай Исаегийн бошиглолыг илүү сайн ойлгоход бидэнд тусалдаг. Жишээ нь, 2 Нифай 20:28–34-т Исая Ассирчуудын цэргүүд дайрч өнгөрөх хотуудыг нэрлэж, мөн энэ нь Ерусалимд хүрэнгүүтээ хэрхэн зогсох тухай хэлсэн. Эдгээр үйл явдлууд яг түүний бошиглосны дагуу болсон.

Түлхүүр 5: “Бошиглолын сүнсээр дүүрсэн байх” (2 Нифай 25:4).

- Бошиглолын сүнс гэж юу вэ? (Илчлэлт 19:10-ыг үз.) Бид үүнийг хэрхэн хүртэж чадах вэ? Аврагчийн тухай Исаегийн сургасныг ойлгоход бошиглолын сүнс бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

2. Исая хожмын үеийн ариун сүм ба Израилын цугларалтыг хардаг.

2 Нифай 12:1–12-ыг уншаад ярилц. Хэрэв та Солт Лэйкийн Ариун Сүмийн зургийг хэрэглэж байгаа бол үүнийг одоо үзүүл.

- 2 Нифай 12:2–3 дээр Исаегийн бошиглосны нэг хэсгийг Солт Лэйкийн Ариун Сүм хэрхэн биелүүлдэг вэ? Исая ариун сүмийг “Их Эзэний уул” гэж яагаад нэрлэсэн гэж та нар бодож байна вэ? (Эртний бошиглогчид Их Эзэнтэй харьцаж, Түүнээс илчлэлт хүлээн авахын тулд үе үе ууланд гардаг байсан.) Бүх ариун сүмүүд хэрхэн бидний бишрэн шүтэхэд зориулагдсан “уулс” байж болох вэ?

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм уулсын орой дээр байгуулагдаж байдаг бөгөөд ариун сүмүүдийг хүмүүс ирж, Их Эзэний тухай сурч мэдэж болох газарт барьдаг гэдгийг тайлбарла.

- Исая ариун сүмийг халуунаас мөн бороо шуурганаас “хоргодох газар” гэж тайлбарласан (2 Нифай 14:6). Энэ амьдралд бидэнтэй тулгардаг сүнслэг шуурганы ямар жишээнүүд байдаг вэ? Эдгээр шуурганаас ариун сүмүүд биднийг хэрхэн хамгаалж чадах вэ?
- 2 Нифай 12:3–5-д тайлбарласнаар Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хувьд бид Бурханы хаант улсыг дэлхий дээр байгуулахад хэрхэн тусалж чадах вэ? (С ба Г 133:7–14-ийг үз.)

- Исая Иаковын угсааг “бүгд төөрч одсон, хүн бүр өөрийн ёсон бус замуудад буюу” хэмээхийн оронд “Их Эзэний гэрэлд алхацгаая” гэж уриалсан (2 Нифай 12:5). 2 Нифай 12:7–12 дээр тодорхой ямар нүглүүдийн талаар дурдсан бэ? Эдгээр нүглүүдийн заримыг өнөөдөр ч гэсэн хэрхэн тархаж байдаг вэ? Бид энэ саадудаас хэрхэн зайлсхийж, “гэрэлд алхаж” чадах вэ?

3. Исая Их Эзэнийг нэг далбаа өргөж, Израилыг цуглуулна гэж бошиглодог.

2 Нифай 15:26–29; 21:12-ыг уншаад ярилц.

- Их Эзэн “үндэстнүүдэд далбааг өргөнө” гэж Исая бошиглосон (2 Нифай 15:26; мөн 2 Нифай 21:12-ыг үз). Далбаа гэж юу вэ? (Туг буюу далбаа; тодорхой жишигт өргөн баригч.) Энэ далбааг өргөхөд юу тохиолдоно гэж Исая хэлсэн бэ? (2 Нифай 15:26–29-ийг үз.)
- Тэнгэр элч Моронай Иосеф Смит дээр ирэхдээ түүнд Исаягийн 11-р бүлэг (2 Нифай 21-т иш татсан байгаа) нь биелсэн зүйлийн тухай (Иосеф Смитийн Түүх 1:40) байсан гэж хэлсэн. Есүс Христийн дахин сэргээгдсэн сайн мэдээ нь хэрхэн бүх үндэстнүүдэд далбаа болдог вэ? (С ба Г 64:41–43; 105:39; 115:4–6-г үз.)
- Үндэстнүүд “нэгдэн цугларах” болно гэсэн бошиглол өнөөдөр хэрхэн биелж байгаа вэ? (2 Нифай 21:12-ыг үз. Номлогч нар сайн мэдээг зааж, хүмүүсийг үнэнд цуглуулахаар дэлхий даяар явж байна.) Энэ бошиглолыг биелүүлэхийн тулд бид бүгд юу хийж чадах вэ?

4. Исая, Нифай нар Есүс Христийн гэтэлгэх хүчний тухай гэрчилдэг.

2 Нифай 16; 22; 25:19–30-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Христийн мэндэлсэн тухай Исая бичиж байгаа зураг болон Есүс Христийн зургийг та хэрэглэж байгаа бол эдгээрийг одоо үзүүл.

- 2 Нифай 16 нь Их Эзэнийг харсан Исаягийн үзэгдлийн тухайг агуулдаг. Исая үзэгдлийнхээ тухай хэрхэн тайлбарласан бэ? (2 Нифай 16:1–4-ийг үз.) Исая Их Эзэний дэргэд ямар сэтгэгдэлтэй байсан бэ? (2 Нифай 16:5-ыг үз.)
- Тэнгэр элч ноцож буй цогийг авч Исаягийн аманд хүргэсэн нь юуг бэлэгдэж байсан бэ? (2 Нифай 16:6–7-г үз. Исаягийн нүглийг өршөөсөн.) Исая Их Эзэний дуу хоолойг сонсоод юу гэж хариулсан бэ? (2 Нифай 16:8-ыг үз.) Судрын өөр ямар хэсэгт үүнтэй адил хэллэг хэрэглэхийг та нар харсан бэ? (Абрахам 3:27-г үз.) Бид хэзээ үүнтэй адил хариултыг Их Эзэнд өгч болох вэ?
- Ангийн гишүүдээр 2 Нифай 22:1–6-г уншуул. Эдгээр шүлгүүдэд бүх хүмүүс Аврагчийг Мянган Жилийн үед хэрхэн магтахыг дүрсэлдэг. Эдгээр шүлгүүдээс юу нь таны сэтгэлийг ихэд хөдөлгөж байна вэ? Аврагч бидний төлөө ямар “онц гайхамшигт зүйлүүдийг” (2 Нифай 22:5) хийсэн бэ?
- Ангийн гишүүдийг 2 Нифай 25:19–30-ийг гүйлгэн уншаад, Аврагчийн тухай Нифайн гэрчлэлийг ярилцахыг урь. Нифайн гэрчлэлийн юу нь таны сэтгэлийг хөдөлгөдөг вэ? Бид хэрхэн Нифай шиг “Христэд итгэж . . . хүүхдүүддээ . . . ятгахын тулд бичихээр хичээнгүйлэн хөдөлмөрлөж” чадах вэ? (2 Нифай 25:23; мөн шүлэг 26-г үз.)

- Нифай “бид ач ивээлээр л аврагдана, бидний хийж чадах бүхний дараа буюу” хэмээн заасан (2 Нифай 25:23). Энэ мэдэгдэл нь бидэнд Есүс Христийн ач ивээл болон бидний ажил үйл хоёрын хоорондын харьцааны талаар юуг заадаг вэ? (2 Нифай 10:24–25; С ба Г 20:29–31-ийг үз.) Өөрсдийнхөө бүх чадлаар хийхэд энэ мэдэгдэл та нарыг хэрхэн урамшуулдаг вэ?
- Ангийн гишүүнээр 2 Нифай 25:29-ийг уншуул. Их Эзэнийг “бүх хүч чадал, санаа бодол, бүх зүрх сэтгэлээрээ” бишрэн шүт хэмээн Нифайн уриалсныг та нар энэ долоо хоногт хэрхэн илүү бүрэн дүүрэн дагаж чадах вэ? (Энэ асуултанд чангаар хариулахын оронд энэ тухай бодохыг ангийн гишүүдээс урьж болно.)

Дүгнэлт

Энэ нэгэн мэдэгдэлдээ Нифай Исаегийн сургаалыг баталсан байдаг гэдгийг цохон тэмдэглэ: “Тийм ээ, миний та нарт өгөх нэг зарлиг нь эдгээрийг хичээнгүйлэн судлах юм; учир нь Исаегийн үгс нь агуу их билээ” (3 Нифай 23:1).

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Дуулал

2 Нифай 15:26-гийн тухай ярилцах хэсэгтээ ангийн нэг гишүүнээр “Уулын Оргил Дээр” (*Сүмийн Дуулал Болон Хүүхдийн Дуу*, х. 30) дууллыг дуулуул эсвэл үгийг нь уншуул. Та ангийн гишүүдтэй энэ дуулал нь сайн мэдээний Дахин Сэргэлтийн тухай Исаегийн бошиглолын биелэлтийг хэрхэн тэмдэглэдэг тухай ярилцаж болно.

2. “Сайныг муу, мууг сайн” гэж нэрлэх (2 Нифай 15:20)

- Бид ямар замаар эртний Израилчууд шиг “Сайныг муу, мууг сайн” хэмээн нэрлэж алдаа гаргадаг вэ? (2 Нифай 15:20). Бид сайныг сайн, мууг муу гэдгийг хэрхэн таньж мэдэж чадах вэ? (Моронай 7:12–17-г үз.)

3. Исаегийн тухай бидний мэдлэгийг Мормоны Ном хэрхэн нэмэгдүүлдэг вэ?

Исаегийн бичсэнийг ойлгоход бидэнд туслах хамгийн агуу удирдамжуудын нэг нь Мормоны Ном юм. Ангийн гишүүдтэй Исаег ойлгоход Мормоны Ном бидэнд тусалдаг дараах арга замуудын тухай хуваалц.

- Мормоны Номонд Исаегийн номын 66 бүлгийн 22-ынх нь бүх хэсгийг эсвэл хэсгээс иш татсан байдаг бөгөөд тэдгээр бүлгүүдийн тухай нэмэлт тайлбарыг агуулдаг. Мормоны Номын бошиглогчид Исаегийн цаг үетэй ойролцоо амьдарч байсан учир тэдний тайлбарууд түүний сургаалуудыг ойлгоход бидэнд тусалж чаддаг.
- Исаегийн бичсэнээс Мормоны Номонд иш татсан хэсэгт Исаегийн номын бусад аль ч хэсэгт гардаггүй үгс, хэлц өгүүлбэр, тайлбарууд багтдаг.

- в. Исаягийн номын дэлхийд мэдэгдээд байгаа хамгийн эртний хувь нь Мөхсөн Тэнгисийн Хуйлмал Бичиг дундаас олджээ. “Исаягийн хуйлмал бичиг” нь МЭӨ 200 онд бичигджээ (Bible Dictionary, “Dead Sea Scrolls,” 654). Хэдийгээр Мормоны Номон дахь Исаягийн бүлгүүд нь Нифайн үед, ойролцоогоор МЭӨ 600 онд бичигдсэн байсан ч Иосеф Смит Мормоны Номыг орчуулснаар Исаягийн бичээсийн Мөхсөн Тэнгисийн Хуйлмал Бичгээс 400 жилийн өмнө дэлхийд бичигдсэн хувийг хангаж өгдөг.
- г. Исаягийн эхний 33 бүлгийн өнгө аяс нь сүүлчийн 33 бүлгийнхээсээ ялгаатай байдаг учир олон хүмүүс Исаягийн ном нь хоёр өөр янзын хүмүүсээр бичигдсэн гэдэгт итгэдэг. Исаягийн эхний болон сүүлчийн хоёр хагасаас хоёулангаас нь Мормоны Номонд иш татсан байдаг бөгөөд Исаяг өөрийн бичээсийн зохиогчийн хувьд гэрч болж, мөн үүний агуу байдлыг баталж байдаг.

“Тэр Тэднийг Бүгд Өөрт нь Ирэхийг Урьдаг”

2 Нифай 26–30

Зорилго	Сайн мэдээний Дахин Сэргэлт, Мормоны Номын сургаалуудаар дамжуулан Их Эзэний үнэн нь хилэнцийг ялж гарах болгоно гэдгийг ойлгоход ангийн гишүүдэд туслах болно.
Бэлтгэл	Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир: а. 2 Нифай 26. Нифайчуудын дунд Аврагчийн үйлчилсэн тухай Нифай бошиглодог. Нифай мөн бардамнал, санваараар мэргэших явдал болон эцэст нь түүний хүмүүс устгагдана гэдгийг урьдаас хардаг. б. 2 Нифай 27. Сайн мэдээний Дахин Сэргэлтийн нэг хэсэг болж Мормоны Ном гарч ирэх тухай Нифай гэрчилдэг. в. 2 Нифай 28. Сатан хожмын өдөр худал хуурмаг сургаалыг тараана гэдгийг Нифай бошиглодог. г. 2 Нифай 29–30. Нифай Мормоны Номын чухал ач холбогдлын тухай мөн үүнийг хүлээн авдаг хүмүүст адислал ирэх тухай заадаг.

Хичээлийг Баяжуулах Зөвлөмж

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Ахлагч Жийн Р.Күүкийн өгүүлсэн дараах мэдэгдлийг унш:

“Өнгөрсөн зун цөлийн ганц замаар явж байхдаа бид өмнө байгаа зам дээр ус тогтсон мэт харагдахыг олж харлаа. Хүүхдүүд маань банкинд байгаа бүх мөнгөө үүнд тавьж барьсан ч бэлэн байлаа. Гэвч хэдхэн минутын дотор бид ус байсан газар ирсэн боловч тэнд нь усны дусал ч байсангүй. Ямар хачин төөрөгдөл байв аа!

“Энэ амьдралд олон зүйлүүд нэг байдалтай юм шиг харагддаг ч гэнэт өөр болчихдог. . . . Сатан үүнийг хийдэг юм. Тэр бол төөрөгдлийн эзэн юм. Тэрээр Хожмын Үеийн Гэгээнтнүүдийг Бурханы цэвэр үнэнээс анхаарлыг нь холдуулж, хүч чадлыг нь үгүй хийх гэж тойруу замаар явуулж, төөрөгдүүлэхийг хичээж байдаг” (in Conference Report, Apr. 1982, 35–36; or *Ensign*, May 1982, 25).

- Төөрөгдөл гэж юу вэ? (Хуурч, буруу зүйл рүү удирддаг зүйл.) Биднийг төөрөгдүүлэх гэж Сатан ямар зүйлүүдийг хэрэглэдэг вэ? Эдгээр төөрөгдөл болон үнэн хоёрыг бид хэрхэн ялгаж чадах вэ?

Энэ хичээл дээр ярилцах бүлгүүд нь хожмын өдрүүдийн тухай хүчирхэг бошиглолуудыг агуулдаг гэдгийг тайлбарла. Нифай Сатан хүмүүсийг хуурч, тэд үнэнээс салах тухай бошиглосон. Хэдий тийм ч мөн сайн мэдээний Дахин Сэргэлт болон зөв шударга хүмүүст ирдэг адислалуудыг тэрээр

урьдчилан харсан. Энэ хичээлд эдгээр бошиглолуудын тухай ярилцах бөгөөд Сатаны хууралтаас хэрхэн зайлсхийж, үнэнд итгэлтэй үлдэх тухай ойлгоход бидэнд тусалдаг.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Нифай Аврагчийг Нифайчуудын дунд үйлчлэх тухай бошиглодог.

2 Нифай 26-г ярилц. Сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг ангийн гишүүдээс урь. Аврагчийг Нифайчууд дээр ирж зочлохоос өмнө олон үеийн турш “агуу дайн болон мөргөлдөөн” байх болно гэж Нифай урьдчилан харсан гэдгийг тайлбарла (2 Нифай 26:1–2). Христийн үхэл болон Түүний Нифайчуудын дунд үйлчлэх цаг үе хоёрын хооронд ёсон бус хүмүүс нь устгагдсан байх болно гэдгийг тэр бошиглодог (2 Нифай 26:3–7).

- Аврагчийг ирэхийг хүлээх хүмүүсийн тухай Нифай хэрхэн тайлбарласан бэ? (2 Нифай 26:8-ыг үз.) Үүний адил зан чанарууд нь бидэнд өнөөдөр яагаад чухал вэ? Зөв шударга Нифайчууд болон тэдний үе удам хэрхэн адислагдсан бэ? (2 Нифай 26:9-ийг үз.)
- Амар амгалан, зөв шударга дөрвөн үеийн дараа түүний хүмүүст “хурдан устгал” ирнэ гэж Нифай бошиглосон (2 Нифай 26:10). Энэ устгал нь юунаас болж бий болдог вэ? (2 Нифай 26:10–11-ийг үз.) Бардамнал нь яагаад ноцтой гэм нүгэл байдаг вэ? Их Эзэний Сүнснийг өөрсөдтэйгөө хамт байлгахын тулд бид амьдралдаа юу хийж болох вэ?
- Сатан хүмүүсийг устгал руу удирддаг тухай Нифай хэрхэн тайлбарласан бэ? (2 Нифай 26:22-ыг үз. Та маалинган оосор нь нарийн, хөнгөхөн утсаар хийгдсэн байдаг гэдгийг тайлбарлаж болно.) Хүмүүсийг “чанга оосроор” хүлэхээсээ өмнө Сатан “маалинган оосрыг” ямар замаар хэрэглэдэг вэ?
- Аврагч хүмүүсийг аврал руу хөтөлдөг тухай Нифай хэрхэн дүрсэлсэн бэ? (2 Нифай 26:23–27, 33-ыг үз.) Бид бусдад “өөрийн авралаа хүртэхэд” нь хэрхэн тусалж чадах вэ? (2 Нифай 26:24).
- Нифай санваараар мэргэших явдлын тухай сэрэмжлүүлсэн. Санваараар мэргэших гэж юу вэ? (2 Нифай 26:29; Алма 1:16-г үз.) Өнөөдрийн дэлхий дээр санваараар мэргэших жишээ нь ил тод байгаа ямар нотолгоо байдаг вэ? Энэ байдлаас бид хэрхэн салж чадах вэ? (2 Нифай 26:30–31; 3 Нифай 18:24; Моронай 7:45–47-г үз.)

2. Нифай Мормоны Номыг гарч ирэх тухай гэрчилдэг.

2 Нифай 27-гоос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- 27-р бүлэгт хожмын өдрүүдийн тухай цаашдын бошиглолууд нь багтдаг. 2 Нифай 27 дээр энэ эрин үед биелсэн ямар үйл явдлуудын тухай тайлбарласан бэ? (2 Нифай 27:6–35-ыг дүгнэж үзэх хэдэн минутыг ангийн гишүүдэд өг. Ангийнхныг хэдэн хэсэгт хувааж, хэсэг тус бүрийг судрын хэсгийн өөр өөр шүлгүүд дээр төвлөрөн анхаарахыг хүсэж болно. Тэдний

хариултыг самбарт дүгнэж бич. Идэвхтэй оролцохыг уриалан ярилцлага өрнүүлэх зарим хариултыг дор бичив.)

- а. Эртний номыг орчуулуулахаар нэгэн хүнд хүргэж өгөх болно (2 Нифай 27:9). Энэ нь ямар ном бэ? (2 Нифай 27:6). Мормоны Номыг орчуулуулахаар юм сурч мэдээгүй, залуу хүнийг сонгосон нь ямар учиртай вэ? (2 Нифай 27:19–23-ыг үз.)
- б. Уг номын үгсийн нэгэн хэсгийг номыг харахыг хүссэн нэгэн номтой хүнд үзүүлдэг (2 Нифай 27:15). Эдгээр шүлгүүдэд ямар үйл явдлын тухай бошиглосон бэ? (Иосеф Смитийн Түүх 1:63–65-ыг үз.) Суралцсан хүн энэ номыг харахыг яагаад хүссэн бэ? (2 Нифай 27:16-г үз.) Мормоны Ном нь ямар замаар дэлхийн алдрыг эрж хайдаг хүмүүст өгөгдөхөөр “лацдуулсан” байх вэ?
- в. Гэрчүүд Мормоны Номын үнэнийг гэрчилнэ (2 Нифай 27:12–14). Ялтсуудыг гэрчүүд харах нь яагаад чухал байсан бэ? (Ифэр 5:2–4; мөн 2 Коринт 13:1-ийг үз.)
- г. Мормоны Номын хүч чадал нь хүмүүсийн амьдралд илэрхий харагдана (2 Нифай 27:26, 29–30, 35). Та нар Мормоны Номын хүчээр амьдралдаа болон бусдын амьдралд ямар өөрчлөлт гарахыг харсан бэ?

3. Сатан хожмын өдрүүдэд худал сургаалыг тараах болно гэж Нифай бошиглодог.

2 Нифай 28-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Хожмын өдрүүдэд хүмүүс Бурханы хүчийг эсэргүүцэж, худал, хоосон, мунхаг сургаалуудыг заах болно гэдгийг Нифай бошиглосон (2 Нифай 28:3–9; мөн 2 Нифай 26:20–21-ийг үз.) Энэ нөхцөл байдал нь Иосеф Смитийн цаг үед хэрхэн зонхилдог байсан бэ? (Иосеф Смитийн Түүх 1:5–6, 19, 21-ийг үз.) Энэ нь өнөөдөр хэрхэн давамгай харагддаг вэ?
- Нүгэл хийх явдлаа зөвтгөхийн тулд хүмүүс худал сургаалыг ашиглана гэдгийг Нифай хэрхэн дүрсэлсэн бэ? (2 Нифай 28:7–9-ийг үз.) Нүгэлдээ шалтаг эрж хүмүүс ямар зөвтгөх зүйлийг ашигладаг вэ? “Жижиг нүгэл үйлдэх” талаар санаа зовохгүй байхын аюул нь юу вэ? (2 Нифай 28:8).
- Хожмын өдөр хүмүүс мөн бардамналаар дүүрсэн байна гэдгийг Нифай урьдчилан харсан (2 Нифай 28:12–15). Нифайчуудын бардам байдлын цаашдын үр дүн нь юу байсан бэ? (2 Нифай 26:10–11-ийг үз.) Бардамнал нь бидний сүнслэг өсөлтөнд бүдрүүлэх чулуу хэрхэн болдог вэ? Бид бардамналыг хэрхэн давж гарч чадах вэ?
- Бардамнал нь олон хүмүүсийг “ядуусаас хулгайлах” байдал руу хөтөлнө гэж Нифай заасан (2 Нифай 28:13). “Сайхан хувцас” эсвэл бусад тансаг зүйлс нь ядуусыг үл тоомсорлох хүслийг бидэнд хэрхэн төрүүлдэг вэ? Биеийн болон сүнслэг талаараа дутагдалтай хүмүүст бид ямар замаар тусалж чадах вэ?
- Нифайн хэлснээр хожмын өдөр олон хүмүүс Их Эзэний үгийг хэрхэн хүлээж авах вэ? (2 Нифай 28:20, 28-ыг үз.) Заримдаа Бурханы үгс яагаад “[олныг] сайны эсрэг уурлуулан хутгадаг” вэ?
- Сатан хүмүүсийг тайтгаруулж, мөн “зуурдын аюулгүй байдалд тайвшруулна” гэж Нифай бошиглосон (2 Нифай 28:21). Зуурдын аюулгүй

байдал гэж юу вэ? (Зуурдын гэдэг нь махан бодийг хэлж байгаа юм. Зуурдын аюулгүй байдалд байх гэдэг нь махан бодийн таашаал сонирхлоо даган аюулгүй байж эсвэл дэлхийн зүйлс буюу санаануудад найдах явдал юм.) Зуурдын аюулгүй байдлын төлөө тэмцэх явдал нь биднийг наманчлах байдлаас хэрхэн хол байлгадаг вэ? “Тэднийг болгоомжтойгоор холдуулан удирдах” (2 Нифай 28:21) гэдэг үг Сатаны арга барилын талаар юуг өгүүлдэг вэ?

Ахлагч Жэймс И.Фауст дараах зүйрлэлийг хуваалцжээ: “Томас Р.Рауэн . . . хэлэхдээ . . . ‘Зохиолч, тайлбарлагч Малком Маггэрэж нэгэн удаа том савтай усанд байж байгаад ямар ч эсэргүүцэлгүйгээр амьдаараа буцалж үхсэн хэдэн мэлхийний түүхийг ярьсан юм. Тэд яагаад эсэргүүцэл үзүүлээгүй вэ? Яагаад гэвэл тэднийг том савтай усанд хийхэд ус тийм ч халуун байгаагүй. Дараа нь температурыг нь аажмаар нэмсэн. Дараа нь жаахан халааж, тэгсээр халаасаар. Өөрчлөлт нь маш удаан, бараг анзаарагдамгүй байсан бөгөөд мэлхийнүүд өөрсдийгөө шинэ орчинд хэтэрхий оройтлол дасгасан байв. Ноён Маггэрэжийн гол санаа нь мэлхийний тухай бус харин бидний тухай, бид бидний дээрээс гэнэт хаяж тэвдүүлэхгүй л бол хилэнцэтийг хэрхэн хүлээн зөвшөөрдөг тухай байсан юм. Бид ямар нэгэн зүйл нь бидний хүлээн зөвшөөрдөг зүйлээс жаахан л буруу байвал ёс суртахууны буруу зүйлд татагддаг” (*National Press Club Forum*).

Энэ зүйрлэлийг хуваалцсанахаа дараа Ахлагч Фауст хэлэхдээ, “Энэхүү аажим явагдах үйл явцын тухай эртний бошиглогчид урьдаас хэлсэн” гэсэн (in *Conference Report*, Apr. 1989, 40; or *Ensign*, May 1989, 32).

- Сатан зарим хүмүүсийг “зусардах” тухай Нифай хэрхэн дүрсэлсэн бэ? (2 Нифай 28:22- ыг үз.) Чөтгөр гэж үгүй, там гэж үгүй гэдэгт биднийг итгүүлэхийг Сатан хүсдэг гэж та нар яагаад бодож байна вэ? Мормоны Номоос суралцах нь биднийг сүнслэгээр сэрэмжтэй байж, мөн “Сионд сэрэмжгүй” байхаас зайлсхийхэд хэрхэн тусалдаг вэ? (2 Нифай 28:24).

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон хэлэхдээ: “Мормоны Ном Христийн дайснуудыг чичилдэг. Энэ нь худал номлолыг няцааж, маргааныг намжаадаг (2 Нифай 3:12-ыг үз.) Энэ нь Христийн даруу дагалдагчдыг чөтгөрийн арга санаа, төлөвлөгөө болон бидний үеийн чөтгөрийн номлолын эсрэг бэхжүүлдэг. Мормоны Номонд гардаг муу сөрөг явдлууд нь бидний өнөө үед байгаа байдалтай адил төстэй байдаг. Бурхан өөрийн хязгааргүй мэдлэгээрээ бидний алдааг харж, өөрсдийн цаг үеийнхээ худал боловсрол, улс төр, шашин, гүн ухааны зарчмуудыг хэрхэн давж гарахаа мэдэг хэмээн чухам Мормоны Номыг бүтээсэн” гэжээ (in *Conference Report*, Apr. 1975, 94–95; or *Ensign*, May 1975, 64).

4. Нифай Мормоны Номын чухал байдлын тухай заадаг.

2 Нифай 29–30-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Хожмын өдөр зарим хүмүүс Мормоны Номыг яагаад эсэргүүцэх вэ? (2 Нифай 29:3; мөн 2 Нифай 28:29-ийг үз.) Бид Библийн зэрэгцээгээр Мормоны Номыг мөн яагаад унших ёстой вэ? (2 Нифай 29:4–14; мөн 2 Нифай 28:30-ийг үз.)

- Мормоны Ном нь харийнхныг (2 Нифай 30:3), Лихайн үр удмыг (2 Нифай 30:3–6), Жүүдүүдийг (2 Нифай 30:7) Есүс Христ бол Аврагч гэдэгт итгүүлж амжилтыг авчирна гэж Нифай бошиглосон. Эдгээр бошиглолууд хэрхэн биелж эхэлж байна вэ?

Дүгнэлт

Мормоны Номыг суралцаж, сайн мэдээний дагуу амьдарснаар бид Сатаны мэхлэгч төөрөгдлөөс зайлсхийх хүчийг олж авч, давчуу бөгөөд нарийн зам дээр үлдэхийг хичээхэд биднийг удирддаг. Ангийн гишүүдийг Мормоны Номоос бие даан болон гэр бүлийнхэнтэйгээ хамт суралцахыг уриал. Тэгснээр тэд Их Эзэний зөв шударга хүмүүст амласан адислалуудыг хүлээн авах болно.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.


1. “Хүмүүсийн дундах агуу их ялгалт” (2 Нифай 30:10)

- Мянган Жилээс өмнө Их Эзэн “хүмүүсийн дунд агуу их ялгалтыг бий болгоно” гэж Нифай бошиглосон (2 Нифай 30:10). Энэ ялгалтыг Нифай хэрхэн дүрсэлсэн бэ? (2 Нифай 30:10-ыг үз.) Зөв шударга хүмүүс Мянган Жилд эдлэх адислалуудын зарим нь юу вэ? (2 Нифай 30:12–18-ыг үз.)


2. Өсвөр насныханд зориулсан үйл ажиллагаа

Энэ хуудсан дээр харагдаж байгаа төөрөгдүүлэх гурван зүйлийг ангийн гишүүдэд үзүүл (боломжтой бол эдгээр төөрөгдүүлэх зүйлсийг ангийн гишүүдэд хувилж тарааж болно). Дүрснүүдийн дор байгаа асуултуудыг ангийн гишүүдтэй ярилц. (Дүрс 1 дээр А ба Б шугамнууд адил хэмжээтэй. Дүрс 2 ба 3 дээр дундах хэсэг нь нөгөө хоёр хэсэгтэйгээ нийлээгүй байна.) Төөрөгдлүүдийг ярилцах хэдэн минут өгсний дараа дараах асуултуудыг тавь.

- Эдгээр зургууд яагаад худал вэ? Сатан биднийг хуурахын тулд ямар төөрөгдлийг ашигладаг вэ? Үнэнийг харж эсвэл ойлгохын тулд бид юу хийж чадах вэ?




Аль нь урт вэ?



Дүрс 2

Дунд хэсэг нь хаана нь нийлдэг вэ?



Дүрс 3

Зорилго

Ангийн гишүүдэд Христийн сургаалыг ойлгож, Түүний үгс дээр хуримлан урагшаа тэмүүлэх илүү их хүсэлтэй болоход туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. 2 Нифай 31:1–18. Нифай Христийн сургаалыг заадаг. Тэр Есүс “бүх зөв шударгыг биелүүлэх” гэж усаар батлуулсан бөгөөд бид усаар батлуулж, Түүнийг дагах ёстой гэж заадаг. Тэр мөн адислалууд болон Ариун Сүнсний хүчний тухай заадаг.
 - б. 2 Нифай 31:19–21. Бид урагшаа тэмүүлж, эцсээ хүртэл тэвчих ёстой гэж Нифай заадаг.
 - в. 2 Нифай 32. Нифай Христийн үгс дээр хуримлаж, үргэлж залбирахын чухлын тухай ярьдаг.
 - г. 2 Нифай 33. Нифай, хэрэв хүмүүс Христэд итгэвэл түүний үгст итгэн гэж тунхагладаг. Бид түүний үгийг хүлээн зөвшөөрөх эсвэл эсэргүүцсэнийхээ дагуу шүүгдэх болно гэж тэр сэрэмжлүүлдэг.
2. Нэмж унших зүйл: Моронай 7:13–17; Сургаал ба Гэрээ 20:37, 71–74.

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

**Анхаарал Татах
Үйл Ажиллагаа**

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Ангийн гишүүнээс хурим гэдгийг тайлбарлахыг хүс. Хуримын ширээн дээр ямар хоол байж болох вэ? Хурим нь ердийн зоогоос ямар ялгаатай вэ? Энэ тухай хэдэн минут ярилцсаныхаа дараа ангийн нэг гишүүнээс 2 Нифай 32:3-ын “Иймийн тул би та нарт хэлсэнчлэн” гэдгээс эхлэн уншихыг хүс. Ангийнханд Их Эзэн мөнхийн амьдралыг бидэнд өгөх хуриманд биднийг урьсан гэдгийг хэл. Энэ хичээлд Христийн сургаал номлолын дагуу хэрхэн амьдарч мөн Түүний үгэн дээр хуримлах тухай ярилцана.

**Судрын Ярилцлага
ба Хэрэглээ**

Нифай Бурханы хамгийн баатарлаг хөвгүүдийн нэг гэдгээ харуулдаг. Тэрээр гэр бүлийнхэн нь маргаан, дайн тулаан болон бусад саад тотгоруудыг туулахыг үзсэн ч гэсэн Их Эзэнийг бүх зүрх сэтгэлээрээ хайрласан. Тэр итгэл, зүтгэл, зарчимч байдлаар дүүрэн байж, дуулгавартай байдлаасаа хэзээ ч хазайгаагүй. Та нар даалгаж өгсөн бүлгүүдээс суралцахдаа Нифайн хамгийн сүүлд хэлсэн үгсийг санаарай.

1. Нифай Христийн сургаалыг заадаг.

2 Нифай 31:1–18-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Нифай сүүлчийн тэмдэглэлээ би “Христийн сургаалын талаар ярина” (2 Нифай 31:2) гэж

эхэлсэн гэдгийг цохон тэмдэглэ. Энэ өгүүлбэрийн тухай 31-р бүлгийг ярилцахдаа энэ нь ямар утга илэрхийлж байгааг тунгаан бодохыг ангийн гишүүдээс хүс. Хичээлийн төгсгөлд та “Христийн сургаал” гэж юу болох талаар тэдний бодлыг асууна гэдгийг тайлбарла.

- Нифай Есүсийн усан баталгааны тухай өмнө нь ярьсан зүйлээ хүмүүст сануулж эхэлдэг (2 Нифай 31:4). Есүс яагаад усаар батлуулсан бэ? (2 Нифай 31:5-ыг үз.) Тэрээр усаар батлуулснаараа “бүх зөв шударгыг хэрхэн гүйцэлдүүлсэн” бэ? (2 Нифай 31:6–7-г үз. Ерөнхийлөгч Иосеф Ф.Смит бүх зөв шударгыг гүйцэлдүүлэх гэдэг нь “хуулийг гүйцэлдүүлэх” гэсэн үг гэж хэлснийг та цохон тэмдэглэж болно [in Conference Report, Apr. 1912, 9].)
- 2 Нифай 31:9-д гарсны дагуу Есүс өөр ямар шалтгааны учир усаар батлуулсан бэ? Бидэнд усан баталгаа яагаад хэрэгтэй вэ? (Энэ асуултын хариуг олохын тулд ангийн гишүүдээр 2 Нифай 31:13, 17 болон С ба Г 20:37, 71–74-ийг уншуул. Тэдний хариултыг самбарт дүгнэж бич. Зарим хариултыг дор жагсаав.)
 - а. Ариун Сүнсний бэлгийг авах гэж (2 Нифай 31:13).
 - б. Нүглээ наманчлах гэж (2 Нифай 31:17).
 - в. Мөнхийн амьдралын зам дээрх хаалгаар орох гэж (2 Нифай 31:17).
 - г. Их Эзэний Сүмд гишүүн болох гэж (С ба Г 20:37, 71–74).
- Нифай хүмүүстээ “бүх зүрх сэтгэлээрээ Бурханы өмнө хоёр нүүр гаргах мөн мэхлэхийг үл үйлдэн Хүүг дагахыг” уриалсан (2 Нифай 31:13). Бурханы өмнө хоёр нүүр гаргах мөн мэхлэхийг үл үйлдэх гэдэг ямар утгатай гэж та нар бодож байна вэ? Хүүг “бүх зүрх сэтгэлээрээ” дагах нь биднийг хоёр нүүр гаргах болон мэхлэх үйлдлээс зайлсхийхэд бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- Бид усан баталгаагаар дамжуулан “ус руу орж Аврагчийг дагах” хүсэлтэйгээ үзүүлэхдээ бид ямар бэлгийг хүлээн авах вэ? (2 Нифай 31:13). Хүн усаар батлуулж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсныхаа дараа ямар байдлаар ярих тухай Нифай хэрхэн тайлбарласан бэ? (2 Нифай 31:13-ыг үз.) “Сахиулсан тэнгэрүүдийн хэлээр ярих” гэдэг нь ямар утгатай вэ? (2 Нифай 31:2–3-ыг үз. Энэ нь Христийн үгсийг Ариун Сүнсний хүчээр ярих гэсэн утгатай юм.) Бид ямар тохиолдолд “сахиулсан тэнгэрийн хэлээр” ярьж адислуулж болох вэ? (Хариултанд бид найз нөхөд, гэр бүлийнхэндээ зааж эсвэл гэрчилж байхдаа, сүмийн ярианы үеэр эсвэл залбирахдаа зэрэг нь орж болно.)
- Мөн Нифай усан баталгааны дараа бид нүглийнхээ өршөөлийг “галаар болон Ариун Сүнсээр” хүртдэг гэж заасан (2 Нифай 31:17). Нифай энэ үйл явцыг тайлбарлахдаа “гал” гэдэг үгийг яагаад хэрэглэсэн гэж та нар бодож байна вэ? (Гал цэвэршүүлж, ариутгадгийн адил Ариун Сүнс нь чин сэтгэлээсээ наманчилж, усаар батлуулдаг хүмүүсийг цэвэрлэдэг.)
- Ариун Сүнс “Эцэг, Хүүг гэрчилдэг” гэж заасан (2 Нифай 31:18). Эцэг, Хүүгийн тухай гэрчлэлийг Ариун Сүнсээр дамжуулан авах нь яагаад чухал вэ?
- Ариун Сүнсний гэрчлэл нь бидэнд ямар замаар ирж болох вэ? (С ба Г 8:2 болон дараах ишлэлийг үз.) Ариун Сүнс бидэнтэй хэрхэн ярьдгийг ойлгох нь яагаад чухал вэ? (2 Нифай 32:5-ыг үз.)

Ерөнхийлөгч Боид К.Пакер заахдаа: “Ариун Сүнс та нарын *сонсож* чадахаас илүү *мэдэрч* чадах хоолойгоор ярьдаг. Үүнийг ‘намуухан зөөлөн хоолой’ хэмээн дүрсэлсэн байдаг” гэжээ (in Conference Report, Oct. 1994, 77; or *Ensign*, Nov. 1994, 60).

Тайлбар: Сүмийн гишүүд Сүнсний нөлөөг ихэнх тохиолдолд мэдэрдэг боловч өөрсдийн мэдэрч байгааг Ариун Сүнс гэдгийг мэддэггүй. Энэ хичээлийн жилийн явцад хичээлийн үеэр заримдаа та Сүнсний нөлөөг мэдэрвэл хичээлээ зогсоож ангийн гишүүдтэй сэтгэгдлээ хуваалцаж болно. Тэд Сүнсний нөлөөг тантай яг адил байдлаар мэдрэхгүй байж болно гэхдээ Сүнс нь амар амгалан, баяр баясгаланг авчирдаг гэдгийг тайлбарла.

2. Нифай биднийг урагш тэмүүлж, эцсээ хүртэл тэмцэх ёстой гэж заадаг.

2 Нифай 31:19–21-ийг уншаад ярилц. Усан баталгаа нь мөнхийн амьдрал руу хөтлөх давчуу бөгөөд нарийн замаар орох үүд юм гэж Нифай заасан гэдгийг ангийн гишүүдэд тайлбарла. Тэр мөн энэ замаар алхах нь ямар утгатайн тухай заасан.

- 2 Нифай 31:19 дээр Нифай ямар асуултыг асуусан бэ? Энэ асуултын хариу нь юу вэ? (2 Нифай 31:19–20-ийг үз.) “Урагш тэмүүлэх” гэдэг нь ямар утгатай гэж та нар бодож байна вэ? (Саад тогторыг үл харгалзан зориглон урагшлах.) Биднийг урагш тэмүүлэхэд саад болох ямар зүйлүүд байдаг вэ? Урагш тэмүүлэх нь эцсээ хүртэл тэмцэхийн чухал хэсэг нь яагаад болдог вэ?
- “Христэд тууштайгаар итгэх” гэдэг нь ямар утгатай вэ? (2 Нифай 31:20). Христийг дагах нь “найдварын төгс гэрэлтэй” болоход бидэнд хэрхэн тусалдаг вэ? Урагш тэмүүлэхээр чармайхад нэг нэгэндээ тусалж чадах ямар арга замууд байдаг вэ? Замаар аялж эхлэхэд нь Сүмийн шинэ гишүүдэд туслахын тулд бид юу хийж чадах вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли заахдаа: “Хөрвөгдөгсдийн тоо үргэлж нэмэгдэж байгаатай холбогдуулан бид тэднийг замаа олоход нь туслах гол зүтгэл чармайлтаа нэмэгдүүлэх ёстой. Тэд нарын хүн нэг бүрт гурван зүйл хэрэгтэй: найз, үүрэг хариуцлага, ‘Бурханы сайн үгээр’ тэжээгдэх явдал юм (Моронай 6:4). Эдгээрийг бий болгож өгөх нь бидний үүрэг, хариуцлага юм” гэжээ (in Conference Report, Apr. 1997, 66; or *Ensign*, May 1997, 47).

- 2 Нифай 31 дээрх Нифайн сургаал дээр үндэслэн “Христийн сургаалыг” та нар хэрхэн тодорхойлох вэ? (2 Нифай 31:13, 15; мөн 3 Нифай 11:31–40-ийг үз. Хариултанд, Христэд итгэх, наманчлах, усаар батлуулах, Ариун Сүнсний бэлгийг хүртэх, эцсээ хүртэл тэвчих нь орж болно.)

3. Нифай Христийн үгэн дээр хуримлах тухай ярьдаг.

2 Нифай 32-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- 2 Нифай 32 дээр Нифай мөнхийн амьдрал руу хөтлөх зам дээр гарсны дараа бид юу хийх ёстой тухай нэмэлт зааварчилгааг өгсөн (2 Нифай 32:1–3). 3-р шүлэгт ямар тодорхой зааварчилгааг өгсөн бэ? Христийн үгсийг хүлээн авах ямар эх сурвалж бидэнд байдаг вэ?
- Эдгээр үгэн дээр хуримлах гэдэг нь ямар утгатай вэ? (Доорх ишлэлийг үз.) “Хуримлах” нь унших, бүр суралцахаас ямар ялгаатай вэ? Бид бусдад хуримлахад нь хэрхэн тусалж чадах вэ?

Ахлагч Нил А.Максвелл ийнхүү хэлжээ: “Бид сударт байгаа Христийн үгэн дээр мөн эдгээр үгсийг амьд бошиглогчид хэлэхэд үүн дээр хуримлах хэрэгтэй. Хааяа нэг уншсан болох нь хангалтгүй юм. (2 Нифай 31:20 ба 32:3-ыг үз.) Хуримлах гэдэг нь өлссөнөөсөө болоод юу ч бодолгүй бүхэл залгих бус ихэд хүсэн, баяртайгаар мөн бүрэн дүүрэн тааламжтайгаар хүртэх гэсэн утгатай ба хэдэн зууны туршид анхаарал болгоомжтой мөн хайраар бэлтгэсэн энэхүү гайхалтай зоогон дээр талархал, баяртайгаар хооллох явдал юм” (*Wherefore Ye Must Press Forward* [1977], 28).

- Христийн үгийн талаар Нифай юу гэж амласан бэ? (2 Нифай 32:3-ыг үз.) Үүнийг үнэн гэдгийг та нар хэрхэн мэдсэн бэ?
- Сүнс хүнд залбирахыг зааж эсвэл урамшуулдаг гэж Нифай заасан (2 Нифай 32:8). “Их Эзэнд хандан ямар нэгэн зүйлийг” үйлдэхээсээ өмнө бид залбирах нь яагаад чухал вэ? (2 Нифай 32:9). Энэ зөвлөгөөг дагаснаараа та нар хэрхэн адислагдсан бэ?

4. Хүмүүс Христэд итгэдэг бол өөрийнх нь үгэнд итгэнэ гэж Нифай тунхагладаг.

Энэ бүлэгт Нифай өөрийн үгсээ үнэн болохыг гэрчилсэн нь, мөн энэ нь бүх хүмүүс чухал гэдэг нь агуулагдсан.

- Нифайн үгс яагаад “агуу их чухал” вэ? (2 Нифай 33:3–5-ыг үз.) Эдгээр үгсийн үнэ цэнийг бид хэрхэн мэдэж чадах вэ? (2 Нифай 33:10; мөн Моронай 7:13–17-г үз.)
- Нифай бид түүнтэй шүүлтийн тавцангийн өмнө “нүүр нүүрээрээ” тулан уулзана гэж хэлсэн (2 Нифай 33:11). Нифайн үгс биднийг “эцсийн өдөр хэрхэн шийтгэх” вэ? (2 Нифай 33:14-ийг үз. Бид эдгээр үгсийг эсэргүүцэх эсвэл тэдний заасан зарчмуудад дуулгаваргүй байхыг сонговол Их Эзэний дэргэдээс зайлуулагдах болно.)
- Нифайн тэмдэглэж бичсэн сүүлчийн үгсийн дунд “Их Эзэн надад тийн зарлигласан, мөн би дагах ёстой бөлгөө” (2 Нифай 33:15) гэж тунхагласан нь бий. Нифайн тэмдэглэл яагаад ингэж төгссөн бэ? Та нар Нифайн жишээнээс илүү их дуулгавартай болоход туслах юуг сурсан бэ?

Дүгнэлт

Христэд итгэх, наманчлах, усаар батлуулах, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авах, эцсээ хүртэл тэмцэх зэрэг нь багтдаг Христийн сургаалыг дахин дүгнэ. Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэ санааг хичээлдээ хэрэглэж болно.

Ойлгоход саад болох зүйлийг давж туулах нь

- Нифайн ярихыг Сүнс яагаад болиулсан бэ? Эдгээр шүлгүүдэд дурдсан асуудлууд өнөөдөр ч гэсэн хэрхэн оршсоор байна вэ? Энэ нүхнээс хол байхад бид бие биендээ хэрхэн тусалж чадах вэ?

“Та Нар Бурханы Хаант Улсыг Эрэлхийлэгтүн”

Иаков 1–4

Зорилго

Ангийн гишүүдэд дуудлагаа эрхэмлэн биелүүлж, ариун байхыг илүү их хүсэж, бусдыг Христэд ирэхийг урих хүсэлтэй болоход туслах болно.

Бэлтгэл


1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Иаков 1. Иаков хүмүүст наманчлалыг номлон Их Эзэнээс ирсний дагуу дуудлагаа эрхэмлэн биелүүлдэг.
 - б. Иаков 2–3. Иаков эд баялгийг хайрлах, бардамнах, ариун бус явдал зэргийн эсрэг сэрэмжлүүлдэг. Тэр цэвэр ариун зүрх сэтгэлтэй хүмүүст хэрэв тэд Бурхан руу харж, Түүнийг хүлээн авч, итгэлтэйгээр залбирвал, зовсон үед нь Бурхан тэднийг тайтгаруулна гэж амладаг.
 - в. Иаков 4. Иаков Есүс Христийн Цагаатгалын тухай гэрчилдэг. Тэр хүмүүст “зорилгоос алсуур хайхын” эсрэг сэрэмжлүүлдэг.
 2. Хэрэв та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглэх гэж байгаа бол томруулдаг шил авчир (эсвэл хичээл эхлэхээс өмнө самбарт зур).
-

Хичээлийг Баяжуулах Зөвлөмж

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Томруулдаг шилийг үзүүл (эсвэл хичээл эхлэхээс өмнө самбарт дээр зур).



- Томруулдаг шилийг юунд хэрэглэдэг вэ? Томруулах гэдэг нь ямар утгатай вэ? (Томруулах, ач холбогдлыг нь нэмэгдүүлэх, илүү дээд дээдлэл буюу хүндэтгэл үзүүлэх). Сүмийн дуудлагаа “эрхэмлэн биелүүлэх” гэдэг ямар утгатай вэ?

Ангийн гишүүнээр Иаков 1:17–19-ийг чангаар уншуул. Ангийн гишүүдээс Их Эзэнээс ирсэн дуудлагаа Иаков хэрхэн эрхэмлэн биелүүлэх тухай дүрсэлсэн өгүүлбэрийг олохыг урь. Та тэдний хариултыг самбарт бичиж болно. Дараах зүйлийг жагсаан бичиж болно:

- а. Өөрийн даалгаврыг Их Эзэнээс авсан (Иаков 1:17).
- б. Аравнайлагдах буюу онцгойлон адислуулсан (Иаков 1:18).
- в. Үүрэг хариуцлага хүлээсэн (Иаков 1:19).
- г. Бүхий л чадлаараа хичээнгүйлэн Бурханы үгийг заасан (Иаков 1:19).
- д. Өөрсдийн хүчээр хөдөлмөрлөсөн (Иаков 1:19).

Нифай мөнх бус амьдралынхаа төгсгөл ирэхэд өөрийн дүү нар болох Иаков, Иосеф хоёрт Нифайчуудын сүнслэг зол жаргалын төлөө хариуцлага хүлээлгэдэг. Иаков өөрийн дуудлагаа ямар хүнд хэцүү болохыг мэдэрч, хүмүүсийг нь шунахай, ариун бус болгож байгаа бардамнал өсч байгаад гутардаг. Тэрээр тэднийг наманчилж Цагаатгалаар дамжуулан Бурхантай эвлэрэхийг хүчтэй уриалдаг. Ангийн гишүүдийг Сүм дэх өөрсдийн дуудлагаа бодож үзэн, үүнийгээ эрхэмлэн биелүүлэхээ хэрхэн илүү сайн болгох тухай бодож үзэхийг урь.

Судрын Ярилцлага ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Иаков Их Эзэнээс авсан дуудлагаа эрхэмлэн биелүүлдэг.

Иаков 1-ийг ярилц. Сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг ангийн гишүүдээс хүс. Иаков нь Лихай, Сариа нарын хүү байсан бөгөөд аглаг буйд төрсөн гэдгийг тайлбарла. Тэрээр залуу байхдаа Аврагчийг харж, мөн пристийн зэрэгт томилогдсон (2 Нифай 2:4; 6:2; 11:3). Тэр жижиг ялтсуудыг хөтөлдөг хүн болж, үйлчлэлдээ Нифайгаас илүү амжилтанд хүрсэн.

- Нифай жижиг ялтсуудыг Иаковт өгөхдөө мөн онцгой зааврыг түүнд өгсөн. Эдгээр ялтсууд дээр юуг тэмдэглэхийг Нифай Иаковт зааварласан бэ? (Иаков 1:1–4-ийг үз.) Энэ мэдээллийг бичиж, хадгалах нь яагаад чухал вэ? (Иаков 1:5–8-ыг үз.) Эдгээр шүлгүүд нь өөрсдийн амьдралын талаар бидний бичиж тэмдэглэх ёстой зарим зүйлүүдийн тухай юу заадаг вэ?
- Иаков түүний хүмүүс “Нифайг үлэмж хайрласан” гэж бичжээ (Иаков 1:10). Тэд Нифайг яагаад ийн ихэд хайрласан бэ? (Иаков 1:10-ыг үз.) Та нарын төлөө үйлчилсэн хүмүүсийн талаар та нар ямар сэтгэгдэлтэй байдаг вэ?
- Иаков хүмүүст заахаасаа өмнө “эхлээд өөрийн даалгаврыг Их Эзэнээс аваад” гэж хэлэхдээ ямар утга санааг илэрхийлсэн бэ? (Иаков 1:17–18). Бид даалгавраа Их Эзэнээс хэрхэн авдаг вэ? (Дуудагдаж, онцгойлон адислуулснаар). Дуудлагадаа юуг хийгээсэй гэж Их Эзэн биднээс хүсэж байгааг бид хэрхэн мэдэж авдаг вэ?
- Хэрэв Иосеф хүмүүст хичээнгүйлэн заагаагүй бол юу болох байсан гэж Иаков хэлсэн бэ? (Иаков 1:19-ийг үз.) Бид дуудлагаа эрхэмлэн биелүүлэх нь яагаад чухал вэ? (Хэрэв та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглээгүй

бол дуудлагаа эрхэмлэн биелүүлэх гэдэг нь ямар утгатайн тухай ярилцах цаг гарга.)

- Хүмүүс дуудлагаа эрхэмлэн биелүүлж байгаа ямар сайн жишээг та нар харсан бэ? Бид дуудлагаа хэрхэн илүү сайн эрхэмлэн биелүүлж чадах вэ? (С ба Г 58:26–28-ыг үз.) Дуудлагаа гүйцэтгэхдээ аль сайнаараа хийснээр та нар хэрхэн адислагдсан бэ?

2. Иаков эд баялгийг хайрлах, бардамнах, ариун бус явдал зэргийн эсрэг сэрэмжлүүлдэг.

Иаков 2–3-ыг ярилц. Сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг ангийн гишүүдээс урь.

- Нифайн хүмүүст номлохдоо Иаков, тэрээр урьд өмнө нь байснаасаа “үлэмж илүүгээр хүсэмжлэл мөн зовнилдоо дарагдан байна” гэж хэлсэн (Иаков 2:3). Иаковын сэтгэл яагаад “зовнисон” бэ? (Иаков 2:5–9; мөн Иаков 1:15–16-г үз.) Иаков нүглийг яагаад “хөдөлмөр” гэж дүрсэлсэн бэ? (Иаков 2:5).
- Материаллаг баялгийг эрэлхийлэх нь Иаковын үед Нифайчуудад хэрхэн бүдрэх чулуу болсон бэ? (Иаков 2:12–16-г үз.) Материаллаг баялгийг элбэг дэлбэгээр хуримтлуулах нь бардамнах явдалд хэрхэн хүргэдэг вэ? Баялгийг хэрэглэх зохистой ямар арга зам бий вэ? Баялгийг буруу хэрэглэхээс зайлсхийхэд бидэнд туслах ямар зөвлөгөөг Иаков өгсөн бэ? (Иаков 2:17–21-ийг үз.)

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл заахдаа:

“Баялгийг эзэмших нь нүгэл гэж тунхаглах шаардлагагүй. Гэхдээ нүгэл нь баялгийг буруу хэрэглэснээс болж гарч ирж болдог. . . . ‘Учир нь мөнгөний хайр бол бүх төрлийн бузар муугийн үндэс мөн. Зарим хүмүүс үүнийг хүссэнээр итгэлээсээ төөрөн одож, түмэн зовлонгоор өөрсдийгөө сүлбэжээ. Харин Бурханы эр хүн ээ, чи энэ бүгдээс зайлсхий. Зөв байдал, бурханлаг байдал, итгэл, хайр, тэвчээр ба дөлгөөн занг эрхэмлэ.’ (1 Тим. 6:10–11.)

“Мормоны Номын түүхэнд эд баялагт дурлах сэтгэлийн хөнөөлт нөлөөг уран цэцнээр илчилсэн байдаг. . . . Хүмүүс өөрсдийн баялгаа зөв зорилгоор хэрэглэсэн бол цэцэглэн хөгжсөөр баяр жаргалтай байх байсан. Гэвч тэд баялаг болон зөв шударга байдлыг нэгэн зэрэг өгөх үеийг хүртэх боломжгүй байсан” (*The Miracle of Forgiveness* [1969], 47–48).

- Иаков хүмүүсийг бардамнал, баялгийг хайрлахаас сэрэмжлүүлж хэлснийхээ дараа мөнх бус зан байдлынхаа төлөө нүглээ наманчил гэж дуудсан. Нифайчууд өөрсдийн мөнх бус зан байдлаа хэрхэн зохистой болгож байсан бэ? (Иаков 2:23–24-ийг үз.) Өнөөдөр олон хүмүүс ариун бус явдалдаа хэрхэн шалтаг тоочихыг оролддог вэ?
- Ёс суртахуунаараа цэвэр байх нь яагаад чухал вэ? (Иаков 2:27–29; мөн Египетээс гарсан нь 20:14; 1 Коринт 6:18–20-ийг үз.) Бэлгийн ёс суртахуунгүй байдал нь гэм нүгэлтэй хүний гэр бүлийнхэн, найз нөхөд болон нийгмийн олон хүмүүст хэрхэн нөлөөлдөг вэ? (Иаков 2:31–35; 3:10-ыг үз.) Бусдын ёс суртахуунгүй байдлаас болж эмзэглэж гэмтсэн хүмүүст Иаков ямар зөвлөгөө, тайтгарлыг өгсөн бэ? (Иаков 3:1–2-ыг үз.)

- Ёс суртахуунгүй байдалдаа өршөөл хүртэхийн тулд хүн юу хийх ёстой вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон ариун бус явдалдаа өршөөл хүртэх таван үе шатны тухай зөвлөсөн (“The Law of Chastity,” in *Brigham Young University 1987–88 Devotional and Fireside Speeches* [1988], 53–54). Эдгээр үе шатуудыг ангийн гишүүдтэй ярилц:

“1. Та нарыг нүгэл хийхэд хүргэж байгаа эсвэл хүргэж болох зүйлээс яаралтай холд.”

“2. Даван туулах хүчийг Их Эзэнээс гуй.”

“3. Пристийн зэргийн удирдагчдаа таны гэмийг шийдвэрлэж, Их Эзэний бүрэн нөхөрлөлд буцаж ирэхэд туслах боломжийг олго.”

“4. Тэнгэрлэг булагнаас [судрууд болон бошиглогчдын үгс] ууж, амьдралаа эерэг хүчний эх сурвалжаар дүүргэ.”

“5. Зохих ёсоор нь наманчилснаар та нар дахин цэвэр болж чадна гэдгийг сана.”

- Иаковын хэлснээр Лэмэнчүүд цэвэр ариун байснаараа хэрхэн адислагдсан бэ? (Иаков 3:5–7-г үз.) Ёс суртахуунаар цэвэр байснаар ямар адислалууд ирдэг вэ?

3. Иаков Есүс Христийн Цагаатгалыг гэрчилдэг.

Иаков 4-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Хүмүүстээ наманчил гэж хэлснийхээ дараа Иаков Цагаатгалаар дамжин ирдэг өршөөлд найддагаа гэрчилж өөрийн номлолоо дуусгасан. Судрууд болон бошиглогч нар Цагаатгалын тухай гэрчлэлийг олж авахад бидэнд хэрхэн тусалдаг вэ? (Иаков 4:4–6-г үз.) Иаковын ярьсан Христэд найдах найдварыг бид хэрхэн олж авч чадах вэ? (Иаков 4:10–12- ыг үз.)
- Жүүдүүд “зорилгоосоо алсуур” хайсан гэдэг нь ямар утгатай гэж та нар бодож байна вэ? (Иаков 4:14-ийг үз. Жүүдүүд судрын хэцүү өгүүллэгүүдийг тайлбарласандаа баясаж байсан боловч итгэл, Ариун Сүнсний тусламжгүйгээр тэд эдгээрийг ойлгож чадаагүй. Тэд судар дахь “энгийн үгсийг” үзэн ядаж, авралыг Есүс Христээс өөр бусад замаар эрж хайсан.)
- Бид өдөр тутмын амьдралдаа заримдаа хэрхэн “зорилгоосоо алсуур хайдаг” вэ? Аврагчийг өөрсдийн амьдралдаа чухал гэдгийг санаж байхдаа бид хэрхэн илүү хичээнгүй байж чадах вэ?

Энэ хэсгийг төгсгөхдөө ангийн гишүүнээр Мозая 3:17-г чангаар уншуул.

Дүгнэлт

Иаковын сургаал нь биднийг дуудлагаа эрхэмлэн биелүүлэхийн чухлыг ойлгож, бардамнал, ёс суртахуунгүй байдлаас зайлсхийхэд бидэнд тусална гэдгийг тайлбарла. Номлолынхоо төгсгөлд Цагаатгалыг онцлон тэмдэглэснээрээ Иаков, бид Аврагчид найдах ёстой гэдгийг заасан.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Иаков батлагдаагүй олон хүнтэй гэрлэх явдлыг шүүмжилсэн

- Нифайчууд садар самууныг шүүхдээ хэнийг жишээ болгодог вэ? (Иаков 2:23–24-ийг үз.) Давид, Соломон нар яагаад садар самууны жишээ болсон бэ? (С ба Г 132:38–39-ийг үз. Их Эзэн Давид, Соломон нарт эхнэр болон шивэгчин өгсөн боловч тэд гэрээнээс гадуур өөр эхнэрүүдтэй гэрлэж нүгэл хийсэн. Эрт цагт шивэгчин нь ёс суртахуунгүй нууц амраг байгаагүй харин нийгэмд бага байр суурь эзэлдэг хуулийн дагуу эхнэр байсан гэдгийг та тайлбарлаж болно (Bruce R. McConkie, *Mormon Doctrine*, 2nd ed. [1966], 154).
- Гэрлэлтийн ямар хуулийн тухай Иаков Нифайчуудад заасан бэ? (Иаков 2:27–28-ыг үз.)

Бошиглогч Иосеф Смит заахдаа, “Эр хүн ямар ч үед Их Эзэн л удирдамж өгөөгүй бол нэгээс илүү эхнэртэй байх ёсгүй” гэсэн (*Teachings of the Prophet Joseph Smith*, sel. Joseph Fielding Smith [1976], 324).

Их Эзэн ийм удирдамжийг өгсөн (С ба Г 132-ыг үз) боловч Тэрээр хожим нь нөхцөл байдал өөрчлөгдөх үед олон хүнтэй гэрлэх тухай албан ёсны зөвшөөрлөө цуцалсан (Албан Ёсны Тунхаг—1-ийг үз). Гэрлэлтийн тухай Их Эзэний хууль нь өнөөдөр Иаковын цаг үед байсантай адил ном гэдгийг онцлон тэмдэглэ.

2. Хүчирхийллийг таньж мэдэж, үүнээс зайлсхийх нь

Иаков Нифайчуудын эрчүүдийг эхнэр, хүүхдүүдээ зохисгүй хандаж байгааг нь зэмлэсэн (Иаков 2:9, 31–32, 35-ыг үз). Хожмын үеийн Сүмийн удирдагчид ямар ч төрлийн хүчирхийллийн эсрэг ноцтой сэрэмжлүүлсэн. Тэргүүн Зөвлөл болон Арван Хоёрын Чуулга “Ариун явдлын гэрээгээ зөрчин, хань ижил, үр хүүхэдтэйгээ зүй бусаар харьцсан, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй хувь хүн хожмын нэг өдөр Бурханы өмнө очиг мэдүүлэх болохыг” анхааруулсан (“The Family: A Proclamation to the World,” *Ensign*, Nov. 1995, 102).

Хүчирхийлэл гэдгийг хэн нэгнийг дорд үзэж, ноцтой гомдоосон үйлдэл, үг яриаг хэрэглэх явдал гэж тодорхойлдог. Зохих үед нь ангийн гишүүдтэй дараах тодорхойлолт болон зааварчилгааг ярилц:

Хүүхдийг хүчирхийлэх явдал нь нөлөө, хяналт бүхий байр суурийн хэн нэгэн хүн хүүхдэд биеийн болон сэтгэл санааны хор нөлөө үзүүлэх буюу айлган сүрдүүлсэн үед үүсдэг. Үүнд биеийн хүчирхийлэл буюу үл ойшоох байдал, оюун санааны хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэл орно.

Гэр бүлийн хүнээ хүчирхийлэх явдал нь мөн биеийн, оюун санааны эсвэл бэлгийн байж болно. Оюун санааны хүчирхийлэлд нэр хоч өгч доромжлох, дорд үзэх, шударга бусаар хянаж, хүчлэх, айлган, ганцаардуулах, сүрдүүлэх, хүч хэрэглэх зэрэг нь орж болно. Биеийн хүчирхийлэлд шаардлагатай зүйлийг өгөхгүй байх, түлхэх, багалзуурдах, урж маажих, чимхэх, хорих эсвэл цохих зэрэг биеийн хүчирхийллийг хэрэглэх явдал орж болно. Бэлгийн

хүчирхийлэл нь оюун санааны болон биеийн хүчирхийллийн аль аль нь байж болох бөгөөд бэлгийн хүчирхийлэл, цохиж өвтгөх, айлган сүрдүүлж хүч хэрэглэх явдал ордог.

Пристийн зэргийн удирдагчид, гэр бүлийн гишүүд болон бусад хүмүүс хүчирхийллээс сэргийлж, хүчирхийлэлд өртсөн хүмүүсийг анагаахад туслахад бүхий л хувь нэмрээ оруулах ёстой. Удирдагчид болон гэр бүлийн гишүүд хүчирхийлэл үйлдэгчийг наманчлахад нь туслах ёстой бөгөөд үүнийг шийдвэрлэхэд Сүмийн хариуцлага хүлээлгэх ажиллагааг явуулах шаардлагатай байж болно.

Ангийн гишүүд бишопоос хүчирхийллээс сэргийлж, үүний эсрэг зогсох тухай тодорхой зөвлөгөө авч болно.

- Хүчирхийллийг таньж мэдэж, үүнээс зайлсхийхийн тулд бид юу хийж чадах вэ? Хүчирхийлэлд өртсөн хүмүүст бид хэрхэн тусалж чадах вэ?

3. Иаков арьс өнгөөр ялгаварлах байдлын эсрэг сэрэмжлүүлсэн

- Нифайчуудын олонх нь Лэмэнчүүдийг яагаад дорд үзсэн бэ? (Иаков 3:5, 9-ийг үз.) Иаков үүнийг яагаад ялгаварлан гадуурхах гэж хэлсэн бэ? (Иаков 3:8–9-ийг үз.) Ялгаварлан гадуурхах явдал нь Сүмийнхнийг өөрсдийн тэнгэрлэг үүргээ биелүүлэхэд хэрхэн саад болдог вэ?

Ерөнхийлөгч Ховард В.Хантэр хэлэхдээ:

“Дахин сэргэсэн сайн мэдээ нь бүх хүн төрөлхтөн нэгэн адил Бурханы хүүхдүүд юм гэдэгт хатуу итгэх явдалд үндэслэсэн хаа сайгүй байгаа бүх хүмүүст зориулсан тэнгэрлэг хайрын тухай захиас юм. . . .

“ . . . Итгэлийн маань хүч түүх, үндэстэн буюу соёлоор хязгаарлагддаггүй гэдэг нь баттай юм. Энэ нь ямар нэгэн насны, ямар нэгэн хүний тодорхой нэг өмч биш юм” (in Conference Report, Oct. 1991, 23–24; or *Ensign*, Nov. 1991, 19).

Зорилго Ангийн гишүүдэд чидуны моддын тухай Зиносын ёгтлол, мөн энэ нь бидний амьдралд хэрхэн хэрэгждэгийг илүү сайн ойлгоход туслах болно.


- Бэлтгэл**
1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Иаков 5. Иаков Израилын угсааны түүх болон хувь заяаг дүрсэлдэг таримал болон зэрлэг чидуны модны тухай Зиносын ёгтлолоос иш татдаг.
 - б. Иаков 6. Иаков өөрийн сонсогчдод наманчилж, Христийг дагахыг уриалдаг.
 2. Нэмж унших зүйл: 1 Нифай 10:12–14; 22:3–5.

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Самбар дээр чидуны мод зурж, ангийн гишүүдээс нэг минутанд чидуны модны тухай аль болох олон зүйлийг бодож олж хэлэхийг хүс. Тэдний хариултыг самбар дээрх зургийг тойруулан бич. Ангийн гишүүдэд тусламж хэрэгтэй бол дор үзүүлсэн цөөн хэдэн хариултыг зөвлөгөө болгон өг эсвэл заах нэмэлт санаануудын хоёрдугаарт байгааг үзүүл.



Энэ хичээлд чидуны мод нь Израилын угсаанд хандах Их Эзэний үйлийг тайлбарлахад хэрхэн хэрэглэгддэг байсан тухай ярилцдаг.

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Иаков чидуны модны тухай Зиносын ёгтлолоос иш татдаг.

Иаков 5-ыг ярилц. Ангийн гишүүдийг сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь. Энэ бүлэгт Иаков Мормоны Номонд хэд хэдэн удаа дурдагддаг Зиносын ёгтлолоос иш татдаг. Ёгтлол нь нэг зүйлийг буюу үйл явдлыг тайлбарлахад эсвэл өөр зүйлийг төлөөлүүлэхэд хэрэглэдэг уран бүтээл юм. Зиносын ёгтлолд чидуны модыг Израилын түүхийг дүгнэж, хувь заяаг нь урьдчилан хэлэхэд хэрэглэдэг.

- Энэ ёгтлолд Зинос ямар бэлэгдлийг хэрэглэсэн бэ? Эдгээр бэлэгдлүүд нь ямар утгатай вэ?

Ангийн гишүүдэд аль болох олон зүйл хэлэхэд нь туслан ёгтлолоос гол бэлэгдлүүд болон утгыг нь ялгаж гарга. Эдгээрийг самбар дээрх бүдүүвчинд бич. Бүдүүвчийг бүрдүүлж дуусахад иймэрхүү харагдана:

ЗИНОСЫН ЁГТЛОЛ	
<u>Бэлэгдэл</u>	<u>Утга санаа</u>
Талбай	Дэлхий
Талбайн Эзэн	Есүс Христ
Чидуны таримал мод	Израилын угсаа, Их Эзэний гэрээт хүмүүс
Чидуны зэрлэг мод	Харийнхан (Израилын угсаанд төрөөгүй хүмүүс)
Мөчрүүд	Бүлэг хүмүүс
Үйлчлэгчид	Бошиглогчид ба үйлчлэхээр дуудагдсан бусад хүмүүс
Жимс	Хүмүүсийн амьдрал буюу бүтээл

Энэ бүдүүвчийг хичээлийн туршид самбар дээр байлга.

- Талбайн эзэн чидуны таримал модоо үхэж эхэлж байгааг нь олж мэддэгээс уг ёгтлол эхэлдэг (Иаков 5:3–4). Энэхүү үхэж байгаа явдал юуг төлөөлдөг вэ? (Урвалт.) Чидуны таримал модоо үхэж байгааг мэдээд талбайн эзэн юу хийсэн бэ? (Иаков 5:4–14-ийг үз. Та залгах гэдэг нь хоёр дахь ургамлын хэсгийг нэгдүгээр ургамалд нийлүүлж, энэ байдлаар энэ нь эхний ургамлын тогтвортой хэсэг болдог үйл явц юм гэдгийг тайлбарлах хэрэгтэй байж болно.) Эзэн хэсэг зэрлэг мөчрүүдийг залгахыг зарцдаа яагаад хэлсэн бэ? (Иаков 5:11, 18- ыг үз.)
- Энэ ёгтлолд залгах гэдэг нь юуг төлөөлдөг вэ? (Харийнхныг Израилын угсаанд усан баталгаагаар дамжуулан авчрах.) Харийнханд сайн мэдээ анх хэзээ хүрсэн бэ? (Үйлс 10-ыг үз.)

- Таримал модны мөчрийг талбайн хол байгаа хэсэгт аваачиж шилжүүлэн суулгасан нь юуг төлөөлдөг вэ? (1 Нифай 10:12–13-ыг үз.) Эдгээр таримал модны мөчрүүд нь тодорхой ямар бүлгийг төлөөлдөг вэ? (1 Нифай 2:19–20; 22:3–4-ийг үз.) Израил яагаад тарж бутарсан бэ? (Амос 9:8–9-ийг үз.)
 - Талбайн эзэн өөрийн моддыг ахин дахин танаж, эргэн тойрон сийрүүлж, мөн арчилсан. Энэ нь Өөрийн хүмүүсийн амьдралд Есүс Христ оролцдог тухай юуг харуулж байна вэ?
 - Эзэн талбайдаа хоёр дахь удаагаа ирэхдээ таримал модонд залгагдсан зэрлэг мөчрүүдийн тухай юу олж мэдсэн бэ? (Иаков 5:15–18-ыг үз.) Сайн үр жимс гаргаж байгаа нь юуг төлөөлдөг вэ? Шинэ хөрвөгдөгсөд Сүмд амьдрал, хүчийг хэрхэн нэмж чадах вэ?
 - Талбайн янз бүрийн хэсэгт тарьсан анхны (таримал) мөчрүүдээ үзэхээр ирээд эзэн нь юу олж мэдсэн бэ? (Иаков 5:19–25-ыг үз. Шим сайтай газар тарьсан мөчрүүдээс сайн болон зэрлэг жимснүүд хоёулаа ургахад, шим муутай хөрсөнд тарьсан мөчрүүд сайн үр жимс өгсөн гэдгийг цохон тэмдэглэ.) Эдгээр нөхцөл байдлууд нь бидний өнөө үетэй ямар хамааралтай вэ?
 - Эзэн талбайгаа гурав дахь удаагаа үзэхээр ирэхдээ бүх жимс нь яасан байсан бэ? (Иаков 5:29–32, 37–42-ыг үз.) Олон төрлийн өмхөрсөн жимснүүд юуг бэлэгддэг вэ? (Дэлхий даяарх урвалт.) Урвалт бий болох шалтгаан нь юу байсан бэ? (Иаков 5:37, 40, 48-ыг үз.) Талбайн “сүрлэг” байдал нь юуг бэлэгддэг вэ? Бидний өөрсдийн сүрлэг байдал буюу бардам зан сайн үр жимс гаргахад бидэнд хэрхэн саад болдог вэ?
 - Өмхөрсөн талбайнхаа тухай эзний хариу өгсөн зүйл нь бидэнд Их Эзэн Өөрийн хүмүүсийнхээ талаар ямар сэтгэгдэлтэй байдгийг хэрхэн илэрхийлдэг вэ? (Иаков 5:41, 47-г үз.) Их Эзэнийг та нарт хайртай гэдгийг мэдэх нь та нарын амьдралд хэрхэн өөрчлөлт гаргадаг вэ?
- Та Их Эзэний бидэнд зориулсан хайрыг харуулдаг өөр бусад шүлгүүдийг цохон тэмдэглэж болно. Зарим зөвлөгөөг дор өгөв:
- а. “Үхэхгүй байж болох хэмээхийн . . . би үүнийг танаж, мөн эргэн тойрон сийрүүлж, мөн үүнийг арчилна” (Иаков 5:4).
 - б. “Би энэ модыг алдах ёстой болсон нь намайг гонсойлгож байна” (Иаков 5:7).
 - в. “Би дахин түүний сайн үр жимсийг өөртөө авч болохын тул, бид уг модонд юу хийх билээ?” (Иаков 5:33).
 - г. “Би талбайнхаа үр жимсэнд дахин баясаж болохын тул” (Иаков 5:60).
- Өмхөрсөн талбайгаа хамгаалж үлдэхийн тулд эзэн нь юу хийхээр шийдсэн бэ? (Иаков 5:49–54, 58, 62–64-ийг үз. Тэр талбайгаа дахин нэг удаа танаж, арчилж, шилжүүлэн суулгасан мөчрүүдийг анх байсан модонд нь буцааж залгахаар шийдсэн.) Энэхүү сүүлчийн удаа арчилж, танаж, залгасан нь юуг төлөөлдөг вэ? (1 Нифай 10:14; 2 Нифай 29:14; С ба Г 33:3–6-г үз. Сайн мэдээний дахин сэргэлт тарж бутарсан Израилын цугларалт.)
 - Иаков 5:61, 70-д дурдсан “бусад зарц” нар нь хэн бэ? (С ба Г 133:8-ыг үз.) Эдгээр зарц нар нь цөөхөн байдаг ч гэсэн тэдний зүтгэл чармайлтын үр дүн нь юу вэ? (Иаков 5:71–75-ыг үз.) Их Эзэний талбай дахь энэхүү сүүлчийн арчилгаа, таналт болон залгалтанд бид хэрхэн тусалж чадах вэ?

2. Иаков өөрийн сонсогч нарт наманчилж, Христийг дагахыг уриалдаг.

Иаков 6-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Иаков Зиносын ёгтлолтой холбоотой зүйлийнхээ дараа юуны тухай бошиглосон бэ? (Иаков 6:1-ийг үз.) Иаков 6:2 дээр Иаков аль цаг үеийн тухай дурдсан бэ? (Хожмын өдрүүд.) Энэ нь бидэнд Зиносын ёгтлолын ач холбогдлын талаар юуг илэрхийлдэг вэ?
- Ангийн гишүүдээр Иаков 6:4–5-ыг чангаар уншуул. Аврагч хожмын өдрүүдэд Израилыг хэрхэн цуглуулах тухай эдгээр шүлгүүдэд юу дурдсан байдаг вэ?
- Зиносын ёгтлолд гарсан үйл явдлууд биелнэ гэдгийг гэрчилснийхээ дараа Иаков сайн мэдээний ямар зарчмуудыг онцлон тэмдэглэсэн бэ? (Иаков 6:3–13-ыг үз.) “Бурханы сайн үгээр тэжээгдэгсдийн” үүрэг хариуцлага нь юу вэ? (Иаков 6:11–12; Моронай 6:3–4-ийг үз.) Эдгээр үүрэг хариуцлагыг биелүүлж болох ямар тодорхой арга замууд байдаг вэ? (Сүмийн гишүүн нэг бүр эдгээр үүргийг биелүүлж чадна гэдгийг онцлон тэмдэглэ. Жишээлбэл, бид гишүүн бус найзуудаа номлогч нартай ярилцахыг урьж болно, мөн гэрийн багш, айлчлагч багшаар хичээнгүйлэн үйлчилж болно, мөн хосууд хамтдаа бүрэн цагийн номлолд үйлчилж болно.)

Дүгнэлт

Ерөнхийлөгч Иосеф Филдинг Смит хэлэхдээ, “Өнөөдөр Хожмын Үеийн Гэгээнтнүүд энэ жимсийг түүж, Эзэнийг ирэх цагт зориулан хадгалах гэж талбай дахь зарц нарын адил дэлхий даяар явж байна” гэсэн (*Answers to Gospel Questions*, comp. Joseph Fielding Smith Jr., 5 vols. [1957–66], 4:142). Бид энэхүү агуу цугларалтанд оролцох ёстой гэдгийг онцлон тэмдэглэ. Их Эзэн биднийг тэтгэдэг учраас бид бусдад энэ тэтгэлгийг хүртэхэд нь туслах ёстой.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Шеримийн хуурамч сургаалууд

Иаков 7:1–23 дээр байгаа Шеримийн тухай өгүүлдгийг ярилц.

- Шерим олон хүмүүсийг үнэнээс хэрхэн холдуулсан бэ? (Иаков 7:1–7-г үз.) Өнөөдөр зарим хүмүүс бусдыг Христээс холдуулахын тулд үүний адил аргыг ашигладаг ямар нотолгоог та нар хардаг вэ?
- Иаков Шеримийг хэрхэн үгүйсгэж чадсан бэ? (Иаков 7:8–22-ыг үз.) Христийг үгүйсгэдэг хүмүүсийн мэхлэх явдлаас бид өөрсдийгөө хэрхэн хамгаалж чадах вэ? (Иаков 7:23; Ром 16:17–18; Ефес 4:11–15-ыг үз.)

Ерөнхийлөгч Иосеф Филдинг Смит хэлэхдээ: “Энэ дэлхийд Есүс Христийн сайн мэдээнд дуулгавартай байхаас илүү агуу чухал зүйл гэж юу ч үгүй. Бүгдээрээ эдгээр судруудаас эрэлхийлцгээе. Бүгдээрээ Их Эзэний илчилсэн зүйлсийг мэдэцгээе. Амьдралаа түүний үнэнтэй зохицуулцгаая. Тэгвэл бид хууртагдахгүй” (*Doctrines of Salvation*, comp. Bruce R. McConkie, 3 vols. [1954–56], 1:301).

2. Чидуны модны тухай нэмэлт мэдээлэл

Чидуны модны тухай илүү их зүйлсийг мэдэх тусам, бид Зинос яагаад Израилыг бэлэгдэхдээ чухам энэ модыг хэрэглэхээр урам авсныг илүү сайн ойлгодог. Дараах мэдээллийг хичээлийн үеэр зохих үед нь хуваалц (хэрэгтэй бол, эдгээр мэдээллүүдийн заримыг анхаарал татах үйл ажиллагааны нэг хэсэг болгон хэрэглэ):

- а. Чидуны мод нь их жимс гаргадаг амьд зүйл юм. Үүнд амьд үлдэхэд нь тогтмол арчилгаа шаардагддаг.
- б. Чидуны мөчир нь уламжлалаараа амар амгалангийн бэлэг тэмдэг юм.
- в. Модноос үр жимс авч, үр шимийг нь хүртэхийн тулд хянуур болгоомжтойгоор тайрч засах ёстой.
- г. Зэрлэг чидуны модыг таримал үр шимтэй болгохын тулд гол ишийг нь үндсээр нь тасалж, таримал чидуны модны мөчрийг зэрлэгийнх нь ишинд залгах ёстой.
- д. Чидуны мод олон зууны туршид үр жимсээ өгч болдог. Одоо Израилд ургаж байгаа моднуудын зарим нь 400 гаруй жил үр жимсээ элбэг дэлбэгээр өгсөөр байгаа билээ.
- е. Мод хөгширч, үхэж эхлэхдээ үндэснүүд нь шинээр гөлөглөдөг, хэрэв залгаж, зассан бол бүрэн ургаж гүйцсэн чидуны мод болдог. Тиймээс модны үндэс нь мянга мянган жилийн турш шинэ моддыг ургуулж, үр жимсээ өгсөөр байж болох юм.

3. Өсвөр насныханд зориулсан үйл ажиллагаа

Чидуны модны ёгтлолыг ойлгоход залууст хүндрэлтэй байж болно. Та энэ тухай ярилцах зуураа ёгтлолыг ангийн гишүүдээр самбарт зуруулж болно. Эсвэл та ангиа талбай (дэлхий) мэт болгож, энэ тухай ярилцах үед ангийн гишүүдийг дор үзүүлсний дагуу ёгтлолын дундуур алхуулж болно.

Чидуны модыг үзүүлэн дээр зурж, үүнийг *Ерусалим (Израилын угсаа)* гэж гарчигла. Энэ үзүүлэнгээ өрөөний голд шалан дээр тавь. Өөр хэд хэдэн үзүүлэн дээр чидуны модны мөчрийг зур. Эдгээр үзүүлэнгүүдээ Израилын угсааныхны тарж явсан газар бүрээр гарчигла (*Америк, Европ, Африк, Ази гэх мэт*). Эдгээр үзүүлэнгүүдийг ангийн эргэн тойронд шалан дээр тавь. Ангийн гишүүдийг ёгтлолын тухай ярилцахдаа зохих үед нь нэг үзүүлэнгээс нөгөө рүү нүүлгэ. Жишээлбэл, ангийн хэдэн гишүүдээр Израилын угсааг (таримал буюу анхны мөчрүүд) төлөөлүүлж, зарим хэдээр нь Харийнхныг (зэрлэг мөчрүүд) төлөөлүүл. Талбайн эзэн зэрлэг мөчрийг залгаж байгаа тухай ярихдаа Харийнхныг төлөөлж байгаа ангийн гишүүдийг голд байгаа үзүүлэн рүү нүүлгэ. Талбайн эзэн анхны мөчрүүдийг авч, тэдгээрийг талбайгаараа нэг тарихад, Израилын угсааг төлөөлж байгаа ангийн гишүүдийг ангийн эргэн тойронд байгаа үзүүлэнгүүд рүү нүүлгэ.

Инос, Жэром, Омнай, Мормоны Үгс

Зорилго Биднийг удирдаж, чиглүүлэхэд зориулан судруудыг бэлтгэж хадгалсан гэдгийг онцлон тэмдэглэх болно.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Инос. Эцгийнхээ сургаалын нөлөөгөөр Инос өршөөл эрэн залбирдаг. Өршөөлийг хүртсэнийхээ дараа Инос өөрийн хүмүүс, Нифайчууд, тэдний дайснууд Лэмэнчүүдийн төлөө залбирдаг. Тэр Их Эзэнээс Нифайчуудын цэдгийг хадгалж хамгаалахыг гуйдаг.
 - б. Жэром. Жэром Лэмэнчүүд Нифайчуудын эсрэг байлдахаар ирдэг тухай бичдэг. Нифайчууд Лэмэнчүүдийн эсрэг зогсож, бошиглогчид, багш нар тэднийг үргэлж наманчилж, Бурханы зарлигуудыг дагаж, Мэсаяг ирэхийг тэсэн ядан хүлээхэд итгүүлдэг тул газар нутагтаа хөгжиж, цэцэглэдэг.
 - в. Омнай. Омнай, Амарон, Чешим, Абинадом мөн Амеликай нар цэдгүүдийг хадгалдаг. Нифайчууд амар амгалан үе, дайны үе, мөн тэдний “илүү ёсон бус хэсэг” нь устгагдахыг үздэг. Мозая болон түүний дагалдагч нар Зарахэмла (Мюлэкчүүд)-гийн хүмүүстэй тааралддаг.
 - г. Мормон үүнийг “мэргэн зорилгын учир” хийж байгаага мэдэж байсан тул Нифайн жижиг ялтсуудыг Нифайн том ялтсуудыг хураангуйлсан дээрээ нэмдэг.
 2. Хэрэв та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглэж байгаа бол ангийн гишүүнээс өдрийн тэмдэглэл дээрээ тэмдэглээгүй байсан бол мартагдах байсан явдал эсвэл сэтгэгдлээ хуваалцахаар бэлтгэхийг хүс. Эсвэл ийм явдал, сэтгэгдлээ өөрийн өдрийн тэмдэглэлээс хуваалцахаар бэлтгэ.
 3. Дараах бүдүүвчийг самбарт эсвэл том цаасан дээр бич:



4. Мормон Ялтсуудыг Хураангуйлсан нь зураг байгаа бол үүнийг хичээлийн үеэр хэрэглэхээр бэлтгэ (62520; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 306).

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Урьдчилан даалгасан ангийн гишүүнээр өдрийн тэмдэглэл дээрээ бичээгүй байсан бол мартагдах байсан явдал буюу сэтгэгдлийнхээ тухай ярихыг хүс. Ангийн гишүүнийг дараах асуултуудад хариулуул:

- Та энэ явдлыг (эсвэл сэтгэгдлээ) яагаад бичсэн бэ? Энэ мэдээллийг өдрийн тэмдэглэл дээрээ бичиж авсан нь танд ямар ашиг тустай байсан бэ?

Дараа нь ангийн бүх гишүүдээр дараах асуултын тухай ярилцуул:

- Нифай өөрийн тэмдэглэлээ бичиж хадгалахыг чухалчилсан нь ямар шалтгаантай вэ? (1 Нифай 6:4; 9:5; 19:3; 2 Нифай 25:26-г үз.)

Мормоны Номыг бичиж хадгалсан хүмүүс Их Эзэний үгийг болон Түүний зарлигуудыг сурч мэдэж авсан туршлагыг нь хадгалж үлдээхийн тулд ихэд хөдөлмөрлөсөн. Тэр эдгээр мэдээллийг ирээдүйн үе удамдаа бичиж үлдээхийн чухлыг ойлгож мэдсэн. Бичээсийг тэмдэглэж хадгалахдаа хичээнгүй байсан учир, мөн цэдгүүдийг хадгалж, хамгаалахад Бурханы гар харж хамгаалж байсан учир бид сүнслэг амжилт болон бидний өмнөх үеийнхний алдаанаас сурч авах боломжтой байдаг.

Өнөөдрийн хичээл дээр ярилцсан Инос, Жэром, Омнай болон Мормоны Үгс гэсэн дөрвөн номыг Нифайн адил ариун нандин цэдгүүдийг хөтлөхийн чухлыг ойлгосон найман хүн бичжээ гэдгийг цохон тэмдэглэ.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Инос өөрийнхөө төлөө, Нифайчууд болон Лэмэнчүүдийн төлөө залбирдаг.

Иносын номын тухай ярилц. Ангийн гишүүдийг сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь.

- Инос өөрт нь сайн мэдээг заасан хэнийг үнэлсэн бэ? (Инос 1:1-ийг үз.) Иносын аав нь хэн байсан бэ? (Иаков 7:27-г үз.) Хүүхдүүддээ “Их Эзэний халамж анхаарлын дор” заах гэдэг нь ямар утгатай вэ? (Дор байгаа ишлэлийг үз.) Сургаал болон зөв шударга эцэг эхийн жишээ нь хүүхдүүдийг нь Аврагчид итгэх итгэлээ хөгжүүлэхэд хэрхэн тусалдаг вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли эцэг эхчүүдэд Иносын аав хүүдээ үзүүлсэн жишээтэй адил хүүхдүүддээ зөв шударга жишээ бол гэж зөвлөсөн: “Хүүхдүүддээ Бурханы охид хөвгүүд мэт ханд. Эелдэг сайхан сэтгэлтэй бай. Тэднийг хайрла. Тэднийг хүндэтгэ. Тэдэнтэй зөвлөлд. Тэдэнд заа. Тэдний төлөө залбир. Тэднийг удирдан дагуул. Тэгээд Бурхан тэднийг мөн та нарыг аль алиныг чинь адислана” (in *Church News*, 1 Nov. 1997, 2).

- Иаковын сургаал Иносыг юу хийхэд нөлөөлсөн бэ? (Инос 1:3–4-ийг үз.) Инос Их Эзэнд хандсан өөрийн залбирлаа хэрхэн тайлбарласан бэ? (Инос 1:2-ыг үз.) Инос өөрт тохиолдсон явдлаа яагаад “тэмцэлдээн” гэж нэрлэсэн гэж та нар бодож байна вэ? Өршөөл эрж түүний хийсэн зүйл бидэнд наманчлалын тухай юу заадаг вэ?
- Инос өөрийнхөө нүглийг өршөөгдсөн гэдгийг яаж мэдсэн бэ? (Инос 1:5–6-г үз.) Бид нүглийнхээ өршөөлийг хүртсэн гэдгээ яаж мэдэж болох вэ? (Дор байгаа ишлэлийг үз.) нүглийнхээ өршөөлийг хүртэх боломжийг Иност юу олгосон бэ? (Инос 1:7–8-ыг үз.) Христэд итгэх итгэл нь наманчилж, өршөөл хүртэхэд бидэнд яагаад чухал вэ?

Ерөнхийлөгч Харолд Б.Ли хэлэхдээ: “Нүглээ наманчлахын тулд чадах бүхнээ хийж . . . чадлынхаа хамгийн сайнаар харамсаж, засаж залруулах цаг ирдэг юм бол . . . тэр үед та Их Эзэн таныг хүлээн авсан уу үгүй юу гэдэг баталгааг олж авахыг хүснэ. Зүрх сэтгэлдээ хайснаараа эрэлхийлбэл та нар наманчлалыг чинь Их Эзэн хүлээн авсан гэдэг тэмдгийг хүлээн авснаар оюун санаандаа амар амгаланг олж авдаг” гэжээ (*Stand Ye in Holy Places* [1974], 185).

- Инос нүглээ өршөөгдсөн гэдгийг мэдээд юуны төлөө залбирсан бэ? (Инос 1:9, 11–13-ыг үз.) Цэдгүүдийг хадгалж үлдэхэд анхаарал тавихыг Инос яагаад хүссэн бэ? (Инос 1:13–14-ийг үз.)
- Иносоос бид залбирлын тухай юу сурч болох вэ?

- Инос өөрийнхөө цаг үед байсан Нифайчуудыг “үлэмж хэрцгий авир” ба “ярихдаа үлэмж агуу тодорхой байдаг” “зөрүүд хүмүүс” гэж дүрсэлсэн (Инос 1:22–23). Иносын үеийн Нифайчууд болон өнөөдрийн зарим хүмүүсийн хооронд ямар адил төстэй зүйл байна вэ?
- Иносын итгэл, гэрчлэл нь танд ямар сэтгэгдэл төрүүлсэн бэ? (ялангуяа Инос 1:15–18, 26–27-г үз.)

2. Нифайчууд үргэлжлүүлэн наманчилснаараа цэцэглэн хөгжсөн.

Жэромын номноос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Тэмдэглэлд нэмж бичсэн нь ямар зорилготой байсан гэж Жэром хэлсэн бэ? (Жэром 1:1–2-ыг үз. Жэром хүлээн авсан бошиглол ба илчлэлүүдээ яагаад бичиж тэмдэглээгүй вэ?)
- Жэром хүмүүстээ Нифайчуудын тухай хэрхэн тайлбарласан бэ? (Жэром 1:3–4; мөн заах нэмэлт санааг үз.) Тэд хэрхэн газар нутагтаа цэцэглэн хөгжиж, Лэмэнчүүдийг ялах боломжтой байсан бэ? (Жэром 1:5, 7–12-ыг үз.)
- Нифайчуудыг амжилтанд хүрэхэд бошиглогч, прист, багш нар ямар үүрэг гүйцэтгэсэн бэ? (Жэром 1:11–12-ыг үз.) “Үгээр тэдний зүрхийг зүсэх” гэдэг нь ямар утгатай вэ? (Жэром 1:12). Та нарын зүрх бошиглогч болон Сүмийн бусад удирдагчид, багш нарын үгсээр хэзээ зүсэгдсэн бэ?
- Нифайчуудын удирдагчид хүмүүсийг “Мэсаяг харж хүлээхийг тэдэнд ятган мөн тэрээр аль хэдийн байсан мэтээр түүнийг ирнэ гэдэгт итгэхийг ятгаж” байв (Жэром 1:11; мөн Мозая 3:13-ыг үз.) Бид Аврагчийн Хоёр Дахь Ирэлтэнд бэлтгэхдээ энэ зөвлөгөөг хэрхэн дагаж чадах вэ?

3. Омнай, Амарон, Чемиш, Абинадом, Амеликай нар цэдгийг хадгалдаг.

Омнайн номноос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Омнайн ном нь ойролцоогоор 200 жилийн үйл явдлыг хамардаг бөгөөд таван хүн бичиж тэмдэглэж хөтөлсөн боловч 30 шүлгээс л бүрддэг.

- Омнайн номыг бичсэн хүмүүс бага зүйлийг бичсэн хэдий ч, бичигч нэг бүр нь ялтсуудыг бичиж, хадгалах зарлигийг дуулгавартай дагасан. Ялтсуудыг хадгалах нь яагаад чухал байсан бэ?

Амеликайн бичсэн Омнайн номны хоёрдугаар хагаст цэдгүүдийг хадгалаагүй хүмүүст юу тохиолдсоныг үзүүлснээр цэдгүүдийг хадгалахын чухлыг харуулдаг.

- Нифайн газар нутгийг орхиж явахыг Их Эзэнээр зарлиглуулсан Мозая болон түүний дагагч нарын тухай түүхийг Амеликай бичиж тэмдэглэсэн. Мозая болон түүнийг дагагч нар нь хаашаа удирдуулсан бэ? (Омнай 1:13-ыг үз.) Зарахэмлагийн газар нутгаас тэд хэнийг олсон бэ? (Омнай 1:14-ийг үз.) Эдгээр хүмүүс хаанаас гаралтай байсан бэ? (Омнай 1:15–16-г үз; мөн Лихай болон түүний гэр бүлийнхнийг аглаг буйд руу явах үед Ерусалимын хаан Зедекая байсан гэдгийг тайлбарласныг 1 Нифай 1:4-өөс үз.)
- Зарахэмлагийн хүмүүс (Мюлэкчүүд) Мозая болон түүнийг дагагчдыг хараад яагаад ихэд баярласан бэ? (Омнай 1:14-ийг үз.) Мюлэкчүүд Ерусалимаас явахдаа ямар ч цэдгүүдийг авчраагүй учраас ямар сөрөг үр

дагавар гарсан гэж Амеликай өгүүлсэн бэ? (Омнай 1:17-г үз. Тэдний хэл нь гуйвуулагдаж, Есүс Христийн болон Түүний сургаалуудын тухай мэдлэгээ алдсан.) Бидэнд судрууд байгаагүй байсан бол бидэнд ямар нөлөө үзүүлж болох байсан бэ? (Мозая 1:3–5-ыг үз.) Бидэнд судар байгаа боловч тэдгээрээс суралцахгүй байгаа үед энэ нь бидэнд хэрхэн нөлөөлдөг вэ?

Мюлекчүүдийн хадгалсан сийлбэр бүхий том чулууг хөрвүүлснээр Мозая өөр нэгэн иргэншлийн, уг газар нутагт амьдарч байсан Жаредчуудын тухай мэдэж авсан гэдгийг тайлбарла (Омнай 1:20–22). Жаредчууд дэлхийн бөмбөрцгийн баруун хэсэгт Бабелийн цамхаг байх үед ирсэн. Жаредчуудын үндэстнүүдээс хамгийн сүүлд амьд гарсан хүн Кориантумр Мюлекчүүдийн хамт хэсэг зуур амьдарсан. Жаредчуудын тухай цэдэг нь Ифэрийн номонд бичигдсэн байгаа бөгөөд тэдний тухай хожмын хичээлүүд дээр ярилцана гэдгийг цохон тэмдэглэ.

- Бид Омнай 1:25–26-гаас Амеликайн тухай юу сурч авч болох вэ? Бид Амеликайн зөвлөсөн шиг Аврагчид “[өөрсдийн] бүхэл бодгалийг хэрхэн өргөл болгон” өгч чадах вэ?

4. Мормон том ялтсуудыг хураангуйлсан хэсэгтээ Нифайн жижиг ялтсуудыг нэмж оруулдаг.

Мормоны Үгсээс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. 1 Нифайгаас эхлээд Омнай хүртэл Мормоны Номонд он тооллын шулуун бичээс багтдаг гэдгийг цохон тэмдэглэ. Хэдий тийм ч Мормоны Үгс нь Амеликай Омнайн номыг бичсэнээс 500 гаруй жилийн дараа бичигдсэн. Хэрэв та Мормон ялтсуудыг хураангуйлж байгаа зургийг хэрэглэж байгаа бол үүнийгээ одоо үзүүл.

- Мормон Мормоны Үгсийг хэзээ, яагаад бичсэн бэ? (Мормоны Үгс 1:1–5-ыг үз.)

Нифайн том ялтсуудыг хураангуйлсныхаа дараа Мормон Нифайн жижиг ялтсуудыг олж, тэдгээрийг өөрийнхөө цэдэгт хавсаргасан гэдгийг тайлбарла (Мормоны Үгс 1:3–5-ыг үз). Мормоны Номын 1 Нифайгаас Омнай хүртэлх эхний зургаан ном нь эдгээр жижиг ялтсуудын орчуулга юм. Мормоны Үгс гэсэн гарчигтай ном нь Мормон яагаад жижиг ялтсуудыг хавсаргах болсон тухай юм. Энэ нь жижиг ялтсуудын цэдгээс том ялтсуудынх руу шилжих шилжилт болж өгдөг.

- Жижиг ялтсуудын талаар Мормон ямар сэтгэгдэлтэй байсан бэ? (Мормоны Үгс 1:4, 6-г үз.) Тэр жижиг ялтсуудыг яагаад өөрийн цэдэгтээ оруулахаар шийдсэн бэ? (Мормоны Үгс 1:7-г үз.) Мормоны хэлсэн “мэргэн зорилго” нь юу байсан бэ?

Мормон, Мороднай нар цэдгүүдийг хураангуйлж, нэгтгэж байгааг харуулсан бүдүүвч зургийг үзүүл. (“Бэлтгэл,” эд зүйл 4-ийг үз). Бүдүүвчинд бичигдээгүй номнуудыг (Мормоны Үгс, Мормон, Мороднай) Мормон, Мороднай нар бичсэн гэдгийг тайлбарла.

Нифай жижиг ялтсууд нь том ялтсууд дээрх эхний цэдгүүдтэй бараг адил цаг үеийг (МЭӨ 600–200 он) хамардаг гэдгийг тайлбарла. Мормон энэ хоёрыг хоёуланг нь хураангуйлалдаа багтаах хэрэггүй байсан нь илэрхий байна. Гэхдээ олон зууны дараа том ялтсуудын эхний цэдгүүд Мартин Харрис Мормоны Номын гар бичмэлүүдийн эхний 116 хуудсыг гэр бүлийнхэн болон найзууддаа үзүүлэхээр авч явж байхад алдагдана гэдгийг

Их Эзэн мэдэж байсан. Эдгээр 116 хуудасны орчуулгыг алдагдсаны дараа Их Эзэн Иосеф Смитэд уг цэдгүүдийг дахин орчуулах хэрэггүй (С ба Г 10:8–14) хэмээн зааварчилсан. Эдгээр цэдгүүд нь Мормоны Номонд өнөөдөр байдаггүй. Оронд нь үүнтэй адил цаг үеийн тухай цэдгийг жижиг ялтсуудаас авч тайлбарласан байдаг.

- Мормон өөрийнх нь хураангуйлж байсан бүхий л нандин цэдгүүдийн зорилго нь юу байсан гэж хэлсэн бэ? (Мормоны Үгс 1:2, 8-ыг үз; мөн Мормоны Номын гарчигтай хуудсыг үз.) Энэхүү зорилгыг бодолдоо агуулан Мормоны Номыг унших нь бидэнд яагаад чухал вэ?

Дүгнэлт

Мормоны Номыг бичигч нар өөрсдийн хүмүүсийн тухай цэдгийг бичиж, хадгалсан нь Их Эзэн эдгээр хүмүүстэй хэрхэн хандаж байсныг ирээдүйн үе удам нь мэдэг гэсэндээ юм гэдгийг ангийн гишүүдэд сануул. Ангийн гишүүдэд Мормоны Номноос суралцсанаар тэд үүнд агуулагддаг Их Эзэний үгсээр удирдуулж, хөтлүүлэх болно хэмээн урамшуул.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэ санааг хичээлдээ хэрэглэж болно.

Сүнсний Өдөөлтийг Мэдрэх нь

Ангийн гишүүнээс Жэром 1:3-ыг чангаар уншихыг хүс.

- Сүнсний өдөөлтийг мэдрэхэд бидэнд саад болж байдаг ямар дөрвөн нөхцөл байдлыг Жэром дурдсан бэ? (Хатуу сэтгэл, дүлий чих, сохор ухаан, зөрүүд зан.)

Эдгээр дөрвөн бэлэгдэл бүхий нөхцөлүүд нь юуг төлөөлдгийг мөн эдгээр нь Сүнсний өдөөлтийг мэдрэхэд бидэнд хэрхэн саад болдгийг ангийн гишүүдтэй ярилц.

- Эдгээр нөхцөл байдлыг даван туулдаг хүмүүст ямар адислалууд ирдэг вэ? (Жэром 1:4-ийг үз.)

“Тэнгэрлэг Эцэгтээ Өгөх Мөнхийн Өрөнд Орсон”

Хичээл
15

Мозая 1–3

Зорилго Ангийнханд Бурханд өртэй гэдгийг нь ойлгуулж “Их Эзэн Христийн цагаатгалаар . . . эгэл хүмүүнээ орхих”-од нь урамшуулах болно (Мозая 3:19).

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Мозая 1. Бэнжамин хаан өөрийн хөвгүүддээ гуулин ялтсууд дахь үнэнүүдийн чухлыг заадаг. Тэрээр өөрийн хүү Мозаяг өөрийг нь залгамжлах хаанаар сонгон ард түмнээ цуглуулахыг хэлэв.
 - б. Мозая 2. Бэнжамин хаан ард түмэндээ тэд бусдад үйлчлэхдээ Бурханд үйлчилдэг болохыг нь заадаг. Тэрээр тэдэнд “Өөрт байгаа бүхнээ мөн өөрийгөө бүхлээр нь Тэнгэрлэг Эцэгтээ өгөх мөнхийн өрөнд орсон” гэдгийг нь сануулдаг.
 - в. Мозая 3. Бэнжамин хаан Есүс Христ болон Түүний Цагаатгалын тухай тэнгэр элчийн бошиглолуудыг давтан хэлдэг.
 2. Дараах материалууд байгаа бол тэдгээрийг хичээлдээ хэрэглэхээр бэлтгэ:
 - а. Бэнжамин Хааны зураг (62298; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 307).

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Ангийнхныг энэхүү хичээлийн гарын авлагын хавтасны зургийг харахыг урь. Ангийнхны суралцах хөтчийнх нь хавтас бас ийм зурагтай байгааг онцол. Тэгээд дараах мэдээллийг хуваалц:

- а. Мормоны Ном нь 238 бүлэгтэй.
- б. Эдгээрийн зөвхөн 50 нь (ойролцоогоор 21 хувь нь) Есүсийн төрсний дараах үйл явдлуудыг агуулдаг.
- в. Эдгээрийн зөвхөн 18 нь (ойролцоогоор 8 хувь нь) Есүсийн Нифайчууд дээр айлчилсан тухай мэдээллийг агуулдаг.

Ангийнхныг дараах асуултуудад хэрхэн хариулахаа чимээгүй бодохыг хүс:

- Яагаад энэ зургийг Мормоны Номыг судлахыг төлөөлөн сонгосон гэж та нар бодож байна вэ?

Ангийн нэг гишүүнээр Мозая 3:13-ыг чангаар уншуул. Есүс Христ бол Мормоны Номон дахь гол хүн болохыг анхааруул. Түүний Цагаатгал Түүний мөнх бусын үйлчлэлийн үед амьдарч байсан хүмүүст хамаатай байдгийн адил энэ нь мөн яг үүний адил өмнө нь ч амьдарч байсан хүмүүст хамаатай

ба одоо үед бидэнд ч бас яг адил хамаатай. Өнөөдрийн болон дараагийн долоо хоногийн хичээл нь мөнх бусын үйлчлэл болон Цагаатгалаас нь хэдэн зуун жилийн өмнө Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэхэд нь ард түмэндээ тусалсан бошиглогч, удирдагч Бэнжамин хааны хэлсэн үгэнд төвлөрөх болно гэдгийг тайлбарла.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Та хичээлээ бэлтгэж заахдаа Есүс Христийн Цагаатгалын тухай хүчтэй сургаалуудыг агуулсан Мозая 3-ыг ярилцахад хангалттай хугацаа үлдээхээ анхаар.

1. Бэнжамин хаан хөвгүүддээ зааж Мозаягаар ард түмнээ дуудуулдаг.

Мозая 1-ийг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь.

- Мозаягийн номон дахь Бэнжамин тухай эхний ишлэл нь түүний хаанчлалын тухай биш харин түүний эцэг хүний хувьд хийсэн сургаал номлолуудын тухай юм (Мозая 1:2–8). Энэ нь Бэнжамин хааны тухай юу заадаг вэ? Эцэг эхчүүд энэ жишээнээс юу сурч болох вэ?
- Бэнжамин хаан хөвгүүддээ юу заасан бэ? (Мозая 1:2–7-г үз. 3 ба 5-р шүлгийн нууцууд гэсэн үг нь зөвхөн илчлэлтээр мэдэгдэх сүнслэг үнэнүүдэд хамаатай гэдгийг анхаар.) Судруудыг судалдаг Нифайчууд болон судалдаггүй Лэмэнчүүдийн хооронд ямар ялгаа байсан бэ? (Мозая 1:5-ыг үз). Энэ ялгаа өнөөгийн нийгэмд нөлөөлж байгааг та нар хэрхэн хардаг вэ? Эцэг эхчүүд хүүхдүүддээ судрыг хайрлах хайрыг нь хөгжүүлэхэд хэрхэн тусалж чадах вэ?
- Бэнжамин хаан “гуулин ялтсууд дээрх цэдгүүдийн талаарх хариуцлагыг түүнд [Мозаяд] өгөв” (Мозая 1:16-г үз). Их Эзэн өнөөдрийн бошиглогч, үзмэрч, илчлэгч нарт судруудыг “хамгаалж хадгалж байгаа” эсэхийг харж байхыг зарлигласан (С ба Г 42:56). Судруудыг “хамгаалж хадгалж байх” нь яагаад чухал вэ? (Мозая 1:3–5-ыг үз.)
- Яагаад Бэнжамин хаан өөрийн хүү Мозаягаар ард түмнээ дуудуулахыг хүссэн бэ? (Мозая 1:10-12-ыг үз. Бэнжамин хааны дурдсан нэр бол Христийн нэр байсан гэдгийг анхаар. Бэнжамин хаан яриагаа дуусгаад Христийн нэрийг өөрсөддөө авахыг заасан. Энэ сургаалыг та 16-р хичээлд ярилцах болно.)

2. Бэнжамин хаан ард түмэндээ Бурханы өмнө мөнхийн өртэй гэдгийг нь заадаг.

Мозая 2-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Бэнжамин хааныг сонсохоор ариун сүмд ирсэн хүмүүс өөрсдийгөө хэрхэн зохион байгуулж өөрчилсөн бэ? (Мозая 2:5–6-г үз; мөн эхний заах нэмэлт санаануудыг үз.) Бэнжамин хаан хүмүүсийн зарим нь өөрийг нь сонсохгүй байгааг хараад юу хийсэн бэ? (Мозая 2:7–8-г үз. Хэрэв та Бэнжамин хааны зургийг ашиглаж байгаа бол түүнийгээ одоо үзүүл.) Энэ цугларалт нь өнөөдрийн ерөнхий чуулгантай юугаараа ижил вэ?
- Бэнжамин хаан тэднийг ирж түүний ярих тэр үгсийг тохуурхахыг тэр зарлиг болгоогүй гэж хүмүүст хэлсэн (Мозая 2:9; Хэн нэгний үгсийг

тохуурхана гэдэг нь тэдгээр үгст хөнгөмсөг хандахыг хэлж байгааг анхаар). Тэднийг сургаалуудыг сонсож байхад тэр юу хийхийг тэдэнд зөвлөсөн бэ? (Мозая 2:9-ийг үз.) Амьд бошиглогч нарын сургаалуудад сонороо дэлгэж, зүрх, оюунаа нээнэ гэдэг нь ямар утгатай вэ?

- Бэнжамины хаанаар үйлчлэх арга замын юу нь та нарын сэтгэлийг хөдөлгөсөн бэ? (Мозая 2:10–16-г үз.) Бэнжамин хааны удирдах арга нь ард түмэнд нь ямар нөлөө үзүүлсэн бэ? (Мозая 1:1; 6:7-г үз.)
- Бэнжамин хаан үйлчлэх тухай юу заасан бэ? (Мозая 2:17–19-г үз.) Бидний бусдад үйлчлэх үйлчлэл маань Бурхандаа талархсаныг маань хэрхэн харуулдаг вэ? Үйлчлэлийн ямар байдал нь бусдыг “тэнгэрлэг хаандаа талархахыг” урамшуулдаг вэ? (Зарим жишээг харахын тулд Мозая 18:8–10; С ба Г 18:10–16-г үз.)
- Ангийн гишүүнээр Мозая 2:20–21-ийг чангаар уншуул. Ашиггүй зарц гэдэг нь юу гэсэн утгатай вэ? Хэдий бид бүх сэтгэлээрээ Бурхандаа үйлчилж магтсан ч бид яагаад ашиггүй зарц хэвээр байх вэ? (Мозая 2:22–25-ыг үз; мөн хоёр дахь заах нэмэлт санааг үз.) Энэ нь Тэнгэрлэг Эцэгийн биднийг хайрлах хайрын тухай юу заадаг вэ?

Ерөнхийлөгч Иосеф Смит: “Бидний алиных нь ч хувьд хэчнээн ч хөдөлмөрлөсөн байсан хамаагүй. . . бид хүлээж авсан адислалуудынхаа төлөө хэзээ нэгэн цагт Эцэг ба Есүс Христэд төлж чадна гэж та нар бодож байна уу? Цовдлолт, шаналал, Есүс Христийн дахин амилалтаар дамжуулан адислалуудынхаа хамт дагалдан бидэнд хүрэх Түүний агуу их хайр нь бидний мөнх бус ойлголтоос гадуур юм. Бид хэзээ ч төлж чадахгүй” гэсэн (Conference Report, Apr. 1966, 102; or *Improvement Era*, June 1966, 538).

- Ашиггүй зарц нарын хувьд бид “Өөрт байгаа бүхнээ мөн өөрийгөө бүхлээр нь Тэнгэрлэг Эцэгтээ өгөх мөнхийн өрөнд орсон” (Мозая 2:34). Бид үүнийг хэрхэн хийж чадах вэ? (Мозая 2:17, 22; 4:10-ыг үз.) Тэнгэрлэг Эцэгтээ бид “бүхнээ мөн өөрийгөө” өгвөл Тэр бидэнд юу өгөх вэ? (Мозая 2:22; 41; мөн С ба Г 84:38-ыг үз.)
- Зарлигуудыг дуулгавартай дагах тухай заалгасныхаа дараа үүнээс татгалзах нь ямар үр дагавартай вэ? (Мозая 2:36–39-ийг үз.) Бэнжамин хааны хэлснээр галан нууртай олонтаа адилтгасан шийтгэл ямар шалтгаантай вэ? (Мозая 2:38; мөн 3:23–27-г үз.)

3. Бэнжамин хаан Есүс Христ болон Түүний Цагаатгалын тухай тэнгэр элчийн бошиглоуудыг давтан хэлцэг.

Мозая 3-аас сонгосон шүлгүүдийг уншиж ярилц. Бэнжамин хааныг ард түмэндээ хандахаас нь өмнө Түүн дээр тэнгэр элч “агуу их баясгалангийн уг баярт мэдээг зарлахаар” иржээ (Мозая 3:1–4). Мозая 3-г тэнгэр элчийн захиас агуулагддаг.

- Ангийн гишүүнээр Мозая 3:5–10-ыг чангаар уншуул. Яагаад Есүс уруу таталт, өвчин, цангах болон ядрахыг тэссэн бэ? (Алма 7:11–12-ыг үз.) Тэр яагаад хүмүүсийн ёсон бусын төлөө өвчин шаналлыг тэвчсэн бэ? (Энэ болон дараах гурван асуултын хариуг авахын тулд дараах ишлэлийг үз.) Тэр Бурхан ба Мариагийн Хүү гэдгийг мэдэх нь яагаад чухал вэ? Тэр

яагаад амиа өгсөн бэ? Энэ мэдээ ямар байдлаар “агуу их баясгалангийнх” болдог вэ? (Мозая 3:3).

Ахлагч Роберт Д.Хэйлз: “Аврагчийн тухай бидний санаж байх ёстой зүйл бол Тэр, зөвхөн Тэр л ганцаараа амиа өгч, мөн түүнийгээ эргүүлэн авах хүч чадалтай байсан явдал юм. Тэрээр мөнх бус ээж Мариагаас үхэх чадвартай болж, Үхэшгүй Эцэгээсээ үхлийг давах чадвартай болсон юм. Бидний Аврагч, Есүс Христ үхэл рүүгээ ийм зүйл болно гэдгийг дагалдагчиддаа хэлэн сайн дураараа, бодолтойгоор явсан. Хэн нэг нь яагаад гэж асууж болох юм. Хариулт нь: бүх хүн төрөлхтөнд үхэшгүй амийг өгч Өөрт нь итгэгчдэд мөнхийн амьдралын амлалтаа өгөхөөр (Иохан 3:15-ыг үз), бусдын төлөөх төлөөс болгон Өөрийн амийг өгөхөөр (Матай 20:28-ыг үз), Сатаны хүчийг давж, нүглийн өршөөлийг боломжтой болгохын тулд. Есүсийн Цагаатгалгүйгээр Бурхан болон мөнх бус хүмүүсийн хооронд давшгүй саад учрах байсан. Бид Цагаатгалыг ойлгосноороо Түүнийг бишрэл, хүндэтгэлтэйгээр санадаг” (in Conference Report, Oct. 1997, 34; or *Ensign*, Nov. 1997, 26)

- Тэнгэр элчийн хэлсэнчлэн хэн Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан авралыг хүлээн авах вэ? (Доорх жагсаалтыг үз.) Энэ нь “хүмүүний үрсийн дээр зөв шударга шүүлт ирж болохыг” (Мозая 3:10) хэрхэн бататгаж Цагаатгалын хүчийг харуулдаг вэ?
 - а. “Өөрсдийн талаарх Бурханы тааллыг мэдэлгүйгээр үхсэн тэд, өөрөөр хэлбэл үл мэдэн нүгэл үйлдсэн тэдний нүглүүдийг цагаатгах болой” (Мозая 3:11; Сургаал ба Гэрээ 137:7–9-өөс бид сайн мэдээг мэдэлгүй нас барсан боловч мэдсэн бол бүх сэтгэл зүрхээрээ хүлээн авах байсан хүмүүс сэлэсчел хаант улсад орно).
 - б. Сайн мэдээг мэдэж, наманчилж, Есүс Христэд итгэлтэй байдаг хүмүүс (Мозая 3:12–13).
 - в. Багадаа нас барсан хүүхдүүд (Мозая 3:16, 18, 21; мөн С ба Г 137:10-ыг үз).
- Яагаад бяцхан хүүхдүүд “Бурханы өмнө гэмгүй” байдаг вэ? (Мозая 3:16, 21; Моронай 8:12; С ба Г 29:46-г үз.) “Тэд төрөлх чанараараа унасан” хэдий ч тэд “Бурханы өмнө гэмгүй,” учир нь тэд Цагаатгалаар дамжуулан “Христээр амьд”.)
- “Эгэл хүн бол Бурханы дайсан” гэж тэнгэр элч хэлсэн (Мозая 3:19). “Эгэл хүн” гэдэг нь ямар утгатай вэ? (Алма 42:6–10 болон доорх ишлэлийг үз.)

Ахлагч Брүс МакКонки: “Адамын уналтын дараа хүн төрөлхөөсөө эгэл, тачаангуй, чөтгөр мэт болж; унасан хүмүүн болсон . . . Дэлхий дээрх бүх хариуцлага бүхий хүмүүс энэхүү уналтын байдал, сорилттой байдал, төрөлхийн тачаангуй чанартаа дэлхийн юмс хүсүүштэй мэт санагдах байдлыг өвлөдөг. Энэ байдалдаа гэтэлгэлийн агуу их төлөвлөгөөнд нийцтэл болон зөв шударга ёсонд дахин төртлөө ‘эгэл хүн бол Бурханы дайсан’ юм (Мозая 3:19). Ийнхүү бүх хүн төрөлхтөн Их Эзэний Цагаатгал байгаагүйсан бол үүрд хаягдан, унасан байх байсан. (Алма 42:4-14.)” гэж хэлжээ (*Mormon Doctrine*, 2nd ed. [1966], 267–68)

- Бид хэрхэн “эгэл хүмүүнийг орхиж” чадах вэ? (Мозая 3:19-ийг үз. Доорх хариултуудыг ярилц.)
 - а. “Ариун Сүнсийг хүлээн авах.” Энэ нь бидэнд “эгэл хүмүүнийг орхиход” хэрхэн туслах вэ? (2 Нифай 31:5; Мозая 5:2; 3 Нифай 28:11-ийг үз.)
 - б. “Христ Их Эзэний цагаатгалаар дамжуулан гэгээнтэн” болох. Жинхэнэ гэгээнтэн байна гэдэг нь юу гэсэн утгатай вэ? (Та гэгээнтэн гэдэг нь цэвэр, ариун гэсэн үг болохыг анхааруулж болно. Мормоны Номонд энэ үгийг Их Эзэний Сүмийн өөрсдийгөө зориулсан гишүүдэд хамааруулсан болно. Жишээ нь, 1 Нифай 14:12 ба 2 Нифай 9:18-д *гэгээнтэн* гэсэн үгийг хэрхэн ашигласан болохыг харж болно.) Цагаатгал нь жинхэнэ гэгээнтэн болоход бидэнд хэрхэн туслах вэ?
 - в. “Хүүхэд мэт” болох. Бид хэрхэн хүүхэд мэт болж “Христэд амьдрах” вэ? (Мозая 3:17– 19, 21; мөн 2 Нифай 25:23–26; Морунай 8:10-ыг үз.)
- Аврагчийн тухай мэдлэг хаана тархсан байна гэж тэнгэр элч хэлсэн бэ? (Мозая 3:20.) Энэхүү бошиглол хэрхэн биелсэн бэ? Энэ цаашдаа хэрхэн биелэх вэ?

Дүгнэлт

Хэрэв та хичээлийнхээ хэсэг болгон Мозая 3:19-ийг уншуулаагүй бол одоо ангийн нэг гишүүнээр үүнийг уншуул.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. “Тэд майхнуудаа. . . ариун сүмийг чиглүүлэн босгов” (Мозая 2:6)

Хүмүүс Бэнжамин хааны ярихыг сонсохоор очихдоо “майхнуудаа ариун сүмийн эргэн тойронд босгож, хүн болгон майхныхаа амыг ариун сүмийг чиглүүлэн” барьсан (Мозая 2:6). Эдгээр хүмүүсийг “майхнаа Содомын ойролцоо босгосон” Лоттой харьцуулж үз. Лот эхлээд нүгэлт Содом хотын ойролцоо амьдарч байсан боловч эцэст нь гэр бүлээрээ Содом хотод амьдарсан.

- Бид майхнаа Содом руу чиглүүлэн босгохтой ижил ямар зүйлс хийдэг вэ? Бид майхнаа ариун сүм рүү чиглүүлэн босгохтой ижил ямар зүйлс хийдэг вэ? Бид өөрсдийнхөө гэр орныг дэлхийн зүйлс рүү чиглүүлэн босгох бус харин ариун сүм рүү хэрхэн чиглүүлэн босгож болох вэ?

2. “Мөнхийн Өрөнд Орсон” (Мозая 2:34)

Самбар дээр доорх байдлаар жин зур:



- Яагаад энэ жин тэнцвэргүй байна вэ?

Ангийн гишүүдээр Мозая 2:20–25-ыг чангаар уншуул. Уншиж байхдаа тэднийг бидний Их Эзэндээ өгч чадах өргөлүүдийг болон Түүний бидэнд өгдөг адислалуудыг олохыг урь. Жингийн *Бидний Өргөлүүд* гэсэн гарчигтай талд нь өөрсдийнхөө өргөлүүдийг жагсааж *Бурханы Адислалууд* гэсэн гарчигтай талд нь Бурханы адислалуудыг жагсаа. Ангийн гишүүдэд бид Бурханы өмнө үргэлж өртэй байдгийг ойлгуул.

“Та Нар Христийн Хүүхдүүд Гэж Нэрлэгдсэн Байх Болно”

Хичээл
16

Мозая 4–6

Зорилго

Есүс Христэд итгэх итгэлээр дамжуулан ирэх “хүчтэй өөрчлөлтийг” эрж түүнийгээ хөгжүүлэхэд нь ангийнхныг урамшуулах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Мозая 4:1–12. Бэнжамин хааны ард түмэн түүний үгийн хариуд нүглүүдийнхээ өршөөлийг даруу байдалтайгаар эрэлхийлэн хүлээн авч хариулсан.
 - б. Мозая 4:13–30. Бэнжамин хаан ард олноо хүүхдүүддээ сайн мэдээг заахыг, өөрсдийн хөрөнгөөс ядууст өглөг хайрлахыг, Бурханы зарлигуудыг дуулгавартай дагахыг ухуулсан.
 - в. Мозая 5–6. Бэнжамин хааны нийт ард олон нь “хүчтэй өөрчлөлтөнд” орж Бурханы зарлигуудыг сахиж бүх зүйлд Түүний хүслээр хийж байх гэрээнд нэгдсэн. Бэнжамин хаан тэдэнд тэд хийсэн гэрээнийхээ улмаас Христийн хүүхдүүд гэж нэрлэгдэх болно гэж хэлсэн.
2. Бэнжамин хааны зураг байгаа бол хичээлдээ хэрэглэхээр бэлтгэ (62298; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 307).

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Самбарт дараах гарчгуудыг бич:

Бурханы зүүн гар

Бурханы баруун гар

- Бурханы баруун гар талд сууна гэдэг нь ямар утгатай вэ? (Өргөмжлөлийг хүлээн авч Бурхантай хамт дахин амьдрах.) Ямар хүмүүс Бурханы баруун гар талд суух эрхтэй байх вэ? Бурханы зүүн гар талд? (Матай 25:33–34; С ба Г 29:27. Ангийнхны энэ хоёр асуултад өгсөн хариуг тохирох гарчгийн доор жагсаа.)

Энэ номлолынхоо төгсгөлд Бэнжамин хаан Бурханы баруун гар талд суух эрхтэй байхын тулд хийх хэрэгтэй зүйлсийг нь ард олондоо хэлж өгсөн. Эдгээр шаардлагууд нь бидний хувьд ижил тул бид Бэнжамин хааны үгнээс суралцаж болно.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Бэнжамин хааны ард түмэн нүглүүдийнхээ өршөөлийг эрэлхийлэн хүлээн авдаг.

Мозая 4:1–12-ыг уншаад ярилц. Та Бэнжамин хааны зургийг ашиглаж байгаа бол хичээлийн турш үзүүлэнд байрлуул.

- Бэнжамин хаан ард олондоо Аврагчийн үүргийг заасныхаа дараа (хичээл 15) “тэд газарт унасан байхыг” харав (Мозая 4:1). Хүмүүс яагаад газарт унасан бэ? (Мозая 4:1–2.) Бид хэрхэн “газрын тоосноос ч өчүүхэн” байдаг вэ? (Хиламан 12:4–8; Мосе 1:9–10-ыг үз.) Та нар Бэнжамин хаан яагаад ард олондоо “юу ч бус болохыг” нь, мөн зохисгүйг нь анхааруулан хэлсэн гэж бодож байна вэ? (Мозая 4:5–8, 11–12-ыг үз.) Их Эзэнээс хамаардгаа хүлээн зөвшөөрөх нь бидний хувьд яагаад чухал вэ?
- “Тачаангуй байдлаа” ойлгосон нь Бэнжамин хааны ард олныг юу хийхэд хөтөлсөн бэ? (Мозая 4:2-ыг үз.) Тэдний “баяр баясгалангаар дүүрэх” шалтгаан юу байсан бэ? (Мозая 4:3-ыг үз.) Тэднийг нүглээ өршөөлгөх боломжийг юу бий болгосон бэ? Тэд өршөөгдсөнөө яаж мэдсэн бэ? Бид наманчилсныхаа дараа өршөөгдсөнөө яаж мэдэж болох вэ? (Энэ асуултанд хариулахын тулд х. “00” “63” дахь Ерөнхийлөгч Харолд Б.Лигийн мэдэгдлийг үз.)
- Бэнжамин хаан нүглийнхээ ангижралыг авах тухай юу заасан бэ? (Мозая 4:9–10-ыг үз.) Нүглүүдийнхээ ангижралыг хадгалах тухай тэр юу заасан бэ? (Мозая 4:11–12, 26-г үз.) Нүглүүдийнхээ ангижралыг хадгалах гэдэг нь юу гэсэн утгатай вэ?
- Бэнжамин хааны ард түмэндээ хэлсэн үг нь биднийг доройтож урам хугарсан үед хэрхэн найдлага өгч чадах вэ?

2. Бэнжамин хаан ард түмэндээ Христийн адил амьдрахыг заасан.

Мозая 4:13–30-аас сонгосон шүлгүүдийг уншиж ярилц. Та ангийнхнаа гурван бүлэгт хуваагаад ярилцлагаа эхэлж болно. Бүлэг тус бүрт доорх судрын ишлэлүүдээс хуваарилаад тэднээс ишлэлийг хамтдаа уншаад нэг үгээр хураангуйлахыг хүс. (Байж болох нэг өгүүлбэр нь ишлэл бүрийн ард өгөгдсөн; ангийнхан эдгээрийг үг бүрчлэн хэрэглэх албагүй.)

Бүлэг 1: Мозая 4:13–15 (Хүүхдүүдэд заах.)

Бүлэг 2: Мозая 4:16–26 (Ядуустай хуваалцах.)

Бүлэг 3: Мозая 4:27–30 (Санаа бодол, хэл яриа, үйлдлээ хянах.)

Гурван бүлэг уншиж хураангуйлж дууссаны дараа самбарт *Бэнжамин Хааны Зөвлөгөө* гэсэн гарчгийг бич. Энэ гарчгийн доор самбарт бүлэг тус бүрээр хураангуйлсан өгүүлбэрийг нь бичүүл.

- Бэнжамин хааны хэлснээр эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ өмнө ямар үүрэг хариуцлага хүлээдэг вэ? (Мозая 4:14–15-ыг үз.) Өнөөдөр дэлхийн ямар нөхцөлүүд Бэнжамин хааны эцэг эхчүүдэд өгсөн зөвлөгөөг онцгой чухал болгож байна вэ? Эцэг эхчүүд сайн мэдээг хүүхдүүддээ заах нь яагаад тийм их чухал вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли: “Ямар ч нийгмийн эрүүл саруул байдал, ард түмнийх нь аз жаргал, түүний хөгжил цэцэглэлт болон амар амгалан байдлын үндэс нь эцэг эхчүүдийн хүүхдүүддээ заах явдалд оршдог” (Conference Report, Oct. 1993, 79; or *Ensign*, Nov. 1993, 60).

- Бид хүүхдүүдэд бие биенээ хайрлаж, бие биендээ үйлчлэхийг хэрхэн зааж чадах вэ? (Ангийнхны үлгэр жишээ бага хүүхдүүдэд хэрхэн нөлөөлж болох талаар багш нар ярилцаж болно.)
- Мөн Бэнжамин хаан ард олондоо гачигдалтай хүмүүсийг анхаарч халамжилж байхыг заасан (Мозая 4:16). Бэнжамин хааны хэлсэнчлэн зарим хүмүүс яагаад гачигдалтай хүмүүст туслахаас татгалздаг вэ? (Мозая 4:17, 22-ыг үз.) Ийм хандлагатай байвал бид яагаад “наманчлах агуу их шалтгаантай” байдаг вэ? (Мозая 4:18–23-ыг үз.) Бид ямар утгаар “гуйлгачид” вэ? (Мозая 4:19–20-ийг үз.)
- Энэрлийн үйлчлэл нь яагаад Христийн Сүмийн гишүүдийг тодорхойлох чухал зан чанар болдог вэ?
- Бид гачигдалтай хүмүүст өгөхдөө Тэнгэрлэг Эцэгийн жишээг хэрхэн дагаж чадах вэ? (Мозая 4:16, 20–21-ийг үз.) Бид гачигдалтай хүмүүст өгөхдөө зөв аргаар зөв тусламж өгч байгаадаа хэрхэн итгэлтэй байж чадах вэ?
Та гачигдалтай хүмүүст туслахад чухам энэ л зөв зам гэх юм байдаггүй гэж тайлбарлаж болно. Бид Бэнжамин хааны заасан зарчмуудыг санаж нөхцөл бүрт Сүнсний удирдамжийг эрэлхийлэх ёстой (Моронай 7:18-ыг үз.) Их Эзэн гачигдалтай хүмүүст туслах арга замуудыг бий болгосон гэдгийг та бас анхааруулж болно. Бид мацгийн өргөл өгөх эсвэл мөнгө, эд зүйлс, цаг заваа хандивлахдаа эсвэл Сүмд өөр нэг үйлчлэл үзүүлэхдээ бидний хандивыг ухаалгаар хэрэглэсэн гэдэгт итгэлтэй байж болно.
- Өөрсдийн хөрөнгөөс өглөг хайрлаж чадахгүй ядууст Бэнжамин хаан юу гэж зөвлөсөн бэ? (Мозая 4:24–25-ыг үз.) Бид санхүүгийн байдлаасаа үл хамааран харамгүй сэтгэлийг хэрхэн хөгжүүлж чадах вэ?
- Яагаад та нар бусдад үйлчлэх нь бидэнд нүглийн өршөөлийг хүлээн авахад тусалж чадна гэж бодож байна вэ? (Мозая 4:26-г үз.)
- Ангийнхны нэгээр нь Мозая 4:27-г уншуул. Бүх зүйлийг “мэргэн ухаанд ба эмх замбараанд” хийх гэдэг нь юу гэсэн утгатай вэ? Энэ зөвлөгөө та нарт хэрхэн тусалж чадах вэ?
- Бэнжамин хаан ард олондоо нүглээс зайлсхийж, Бурханд өгсөн амлалтаа сахиж, санаа бодол, хэл яриа, үйлдлээ хянаж байхыг заасан (Мозая 4:29–30). Бидний санаа бодол, хэл яриа, үйлдэл хэрхэн илэрхийлэгддэг вэ? Бид санаа бодлоо хянавал энэ нь бидний үг болон үйлст хэрхэн нөлөөлөх вэ?

3. Бэнжамин хааны ард олон нь “хүчтэй өөрчлөлтөд” орж бүх зүйлд Бурханы хүслийг биелүүлж байх гэрээнд нэгдсэн.

Мозая 5–6-г ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь.

- Бэнжамин хааны үг үнэн болохыг хүмүүс яаж мэдсэн бэ? (Мозая 5:2-ыг үз.) Их Эзэний Сүнс хүмүүст ямар нөлөө үзүүлсэн бэ? (Мозая 5:2–5-ыг үз.) Бид “хилэнцийг үйлдэх дурыг үгүй болгох” нь амьдрал болон харьцаанд маань ямар нөлөө үзүүлэх вэ?
- Бэнжамин хааны номлолыг сонсож зүрх сэтгэлдээ хүчирхэг өөрчлөлтийг мэдэрсэн хүмүүс урьднаас Сүмийн гишүүнээр тооцогдсоныг мэдэх нь бидний хувьд яагаад чухал вэ?

- Бид нэгэнт “зүрх сэтгэлдээ хүчирхэг өөрчлөлтийг” (Мозая 5:2) мэдэрснээс хойш энэ өөрчлөлтөө хэвээр хадгалахад маань ямар бэрхшээлүүд тулгарч болох вэ? Эдгээр бэрхшээлүүдийг бид хэрхэн шийдэж чадах вэ?
- Христийн хүүхдүүд болно гэдэг нь ямар утгатай вэ? (Мозая 5:2, 5–7-г үз.) “Христийн нэрийг өөрсөд дээрээ авах” гэдэг нь ямар утгатай вэ? (Мозая 5:8–11; мөн дараах хуудасны ишлэлийг үз.) Бид зүрхэндээ бичээстэй Христийн нэрийг хадгалахын тулд өдөр бүр юу хийж болох вэ? (Мозая 5:11–15-ыг үз.)

Ахлагч Даллин Өүкс: “Есүс Христийн нэрийг өөртөө авах хүсэлтэй байдаг байдал маань Түүний баруун гар талд зогсохоор Түүгээр сонгогдох хүмүүсийн дунд тооцогдохын тулд бидний бүгдийг хийх амлалт болон эцсийн өдөр түүний нэрээр нэрлэгдэхийг маань бататгадаг. Энэ нандин утгаараа Есүс Христийн нэрийг өөртөө авах хүсэлтэй байдлын маань гэрчлэл нь сэлэсчел хаант улс дахь өргөмжлөлд нэр дэвших тунхгийг маань бүрдүүлдэг. Өргөмжлөл бол мөнхийн амьдрал хийгээд ‘Бурханаас өгөгдсөн бүх бэлгүүдийн хамгийн агуу нь’ (С ба Г 14:7) юм (Conference Report, Apr. 1985, 105; or *Ensign*, May 1985, 83).

- Бэнжамин хааны ард түмний хийсэн гэрээ нь бидний усан баталгаан дээр хийж ариун ёслолоос хүртэх болгондоо шинэчилдэг гэрээтэй юугаараа адил вэ? (Мозая 5:5, 7–8; С ба Г 20:37, 77, 79-ийг үз.) Бид энэхүү гэрээгээ байнга шинэчилж байх нь яагаад чухал вэ?
- Бэнжамин хаан бүх ард олон нь (багачуудаас бусад нь) Бурханы зарлигуудыг дуулгавартай дагах гэрээнд орохыг харсан (Мозая 6:1–2). Тэдний нэрсийг бүртгэх нь яагаад чухал байсан бэ?
- Яагаад хүмүүст зориулан багш болон пристүүдийг томилох нь чухал байсан бэ? (Мозая 6:3.) Бидэнд бидний хийсэн гэрээ ба амлалтуудыг сануулж байхын тулд багш болон Сүмийн удирдагчид бидэнд хэрхэн тусалдаг вэ?

Дүгнэлт

Мозая 5:15-аас Бэнжамин хааны хэлсэн үгийн төгсгөл хэсгийг өөрөө эсвэл ангийн нэг гишүүнээр уншуул. Эдгээр адислалуудыг хүн бүр хүртэх боломжтой хэмээн онцол. Тэднийг Христийн хүүхдүүд болгох боломжтой “зүрх сэтгэлдээ хүчирхэг өөрчлөлтийг” эрэлхийлэхийг ангийн гишүүдэд уриал.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. “Энэ нэрэн дор та нар эрх чөлөөтэй болгогдсон” (Мозая 5:8)

- Бэнжамин хаан ард түмнээ Христийн хүүхдүүд хэмээн нэрлэхдээ, “Энэ нэрэн дор та нар эрх чөлөөтэй болгогдсон” гэж хэлсэн (Мозая 5:8). Их Эзэнд дуулгавартай байх нь эрх чөлөөг хэрхэн авчирсан бэ?

Бошиглогч Иосеф Смит: “Дуулгавартай байдалд баяр баясгалан, амар амгалан нь бохирдоогүй, цэвэр байдаг; Бурхан бидний аз жаргалыг

төлөвлөснөөр . . . Тэр хэзээ ч уг чанартаа энэ аз жаргалыг урагшлуулахаар тооцоологдоогүй ёслол эсвэл зарлигийг Өөрийн хүмүүстээ тогтоож байгаагүй, тогтоох ч үгүй билээ,” гэж заасан (*Teachings of the Prophet Joseph Smith*, sel. Joseph Fielding Smith [1976], 256–57).

- Та нарын болон хүрээлэн буй хүмүүсийн чинь амьдралд Бурханы зарлигуудад дуулгавартай байх нь аз жаргал авчрахыг та нар хэрхэн харсан бэ?
2. “Өөрийн үйлчилж байгаагүй эзнээ хүн хэрхэн мэдэх билээ?”
(Мозая 5:13)
- Бэнжамин хаан, “Өөрийн үйлчилж байгаагүй эзнээ хүн хэрхэн мэдэх билээ?” гэж асуусан (Мозая 5:13). Та нар Христэд үйлчилснээрээ Түүнийг хэрхэн илүү сайн мэдэж чадах вэ?

“Үзмэрч . . . Бусаддаа Агуу Их Ашиг Тус Болох Бөлгөө”

Мозая 7–11

Зорилго

Ангийнхныг Сүмийн удирдагчид, ялангуяа Их Эзэний дуудсан бошиглогч, үзмэрч ба илчлэгчдийн зөвлөгөөг дагахад нь урамшуулна.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:


- а. Мозая 7–8. Аммон хэдэн жилийн өмнө Зарахэмлаг орхин Нифайн нутаг руу эргэж ирсэн ард түмнийг судалж мэдэхээр судалгааны хэсгийг удирддаг. Аммон ах нарынхаа хамт Лимхай болон түүний хүмүүсийг олдог. Аммон Лимхайн хүмүүст зааж, тэдний бичээсийг хүлээн авч, хүмүүсийн олсон Жаредчүүдийн 24 ялтсыг судалдаг. Үзмэрч Мозая ялтсууд дээрх сийлсэн бичээсийг орчуулж чадна хэмээн тэрээр тайлбарладаг.
- б. Мозая 9–10. Лимхайн өвөг эцэг болох Зенифийн зарим бичээсүүд нь Нифайн нутагт Зенифийн ард түмэн хэрхэн ирсэн тухай товч өгүүлдэг. Мөн түүнчлэн Их Эзэн тэднийг Лэмэнчүүдийн эсрэг дайнд хэрхэн хүчирхэгжүүлж байсан тухай өгүүлдэг.
- в. Мозая 11. Зенифийн хүү Ноа төрөө ёсон бусаар удирддаг. Хүмүүс бошиглогч Абинадайн сэрэмжлүүлгийг үл ойшоон Ноа болон түүний пристүүдийн ёсон бус явдлыг тоодоггүй.

Хичээлийг Баяжуулах Зөвлөмж

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Дараах схемийг самбарт зур:



Мозаягийн номонд Их Эзэн Өөрийн хүмүүстээ хэрхэн хандаж байсан талаар ойлгохын тулд 2 Нифай 5, Омнай ном ба Мозая 7 ба 9-д харуулсан үйл явдлуудыг ойлгох нь чухал гэдгийг тайлбарла. Эдгээр үйл явдлуудыг товчхон ярихын тулд та самбар дээрх схемийг ашиглахаа ангийнханд хэл. Доорх мэдээллийг уншиж өөрийн үгээр ярь (дугаарууд схемийн дугаартай тохирч байгаа болно):

1. Лихайн нас барсны дараа Их Эзэн Нифайн дагалдагчдыг Лэмэний дагалдагчдаас салахыг тушаасан. Нифайчууд суурьшсан газраа Нифайн нутаг гэж нэрлэсэн (2 Нифай 5:5–8). Сүүлд энэ нутгийг “Лихай-Нифайн нутаг” гэж нэрлэх болсон (Мозая 7:1).
2. 400 жил орчмын дараа Нифайчуудыг Мозая гэдэг хаан удирдаж байв. Их Эзэн Мозаяд Нифайн нутгаас “Их Эзэний дуу хоолойг сонсох тэр бүгдийг” авч явахыг тушаасан. Мозая ба түүний хүмүүс Зарахэмлагийн гэж нэрлэгдэх хэсэг хүмүүстэй тааралдав. Хоёр хэсэг хүмүүс өөрсдийгөө Нифайчууд гэж нэрлэв. Мозая тэдний хаанаар сонгогдов (Омнай 1:12–19).
3. Хэсэг Нифайчууд Нифайн нутгийг буцааж авахаар Зарахэмлагийн нутгийг орхин явав (Омнай 1:27). Тэнд тэд, тэдний хаан болсон Зениф гэдэг хүний удирдлаган дор газартай болсон (Мозая 9:1:7).
4. Ойролцоогоор 79 жилийн дараа анхны Мозая хааны ач, 2 Мозая Хаан “Лихай-Нифайн нутагт оршин суухаар явсан тэр хүмүүсийн талаар мэдэх хүсэлтэй байв.” Тэр Аммон гэдэг хүнийг энэ зорилгоор судалгааг удирдуулахаар томилон (энэ Аммон бол сүүлд Лэмэнчүүдийн дунд сайн мэдээг номлосон Мозаягийн хүү биш гэдгийг анхаар). Аммон болон түүний ах нар Лимхай Хаан ба түүний хүмүүсийг олсон. Лимхай бол Зенифийн ач байсан (Мозая 7:1–11).

Судрын Ярилцлага ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Аммон ах нарынхаа хамт Лимхай болон түүний хүмүүсийг олдог. Аммон Лимхайд үзмэрч нь чухал гэдгийг заадаг.

Мозая 7–8-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Мозая 7:1–11-ийн тайлбарыг үзэхийн тулд анхаарал татах үйл ажиллагааны 4-р хэсгийг үз.

- Лимхай Аммон болон түүний хамтрагчдыг яагаад олзолсон бэ? (Мозая 7:8–11-ийг үз.) Аммоны хэн болохыг мэдээд Лимхай яагаад баярласан бэ? (Мозая 7:12–15-ыг үз. Хичээлийн үеэр Лимхайн ард түмэн хэрхэн олзлогдсон талаар ярилцана гэдгээ хэл.) Аммонтой ярилцсанаах дараа Лимхай хүмүүстээ ямар захиас хэлсэн бэ? (Мозая 7:17–20, 29–33-ыг үз.) Энэ нь Лимхайн талаар удирдагчийнх нь хувьд юуг илчилдэг вэ?
- Лимхай нэг удаа 43 хүнийг Зарахэмла руу ахан дүүсээ олуулахаар явуулсан тухайгаа Аммонд хэлсэн (Мозая 8:7). Гэвч эдгээр хүмүүс оронд нь юу олсон бэ? (Мозая 8:8–11; мөн Ифэр 1:1–2-ыг үз. Тэд Жаредчуудын соёл иргэншлийн үлдэгдлийг олсон. Жаредчууд тэнд Нифайчуудыг ирэхээс хэдэн зуун жилийн өмнө суурьшсан байжээ.)

- Лимхай Жаредчуудын 24 алтан ялтсын талаар Аммонос юу хүссэн бэ? (Мозая 8:11-12- ыг үз.) Яагаад Лимхайн хүмүүсийн хувьд болон бидний хувьд “Жаредчуудын мөхлийн шалгааныг мэдэх нь” тустай вэ?
- Аммон Лимхайн хүсэлтэнд хэрхэн хариулсан бэ? (Мозая 8:13–14-ийг үз. Зарахэмлагийн Хаан, үзмэрч Мозая цэдгийг орчуулж чадна гэж хэлсэн.) Аммон үзмэрч гэсэн хэргэмээс өөр ямар ямар цолтой байсан бэ? (Мозая 8:16-г үз.) Өнөөдөр бид бошиглогч, үзмэрч, илчлэгчийн хувьд хэнийг дэмждэг вэ? (Тэргүүн Зөвлөл ба Арван Хоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд.)
- Үзмэрч ямар үүрэгтэй вэ? (Мозая 8:13, 17–18.) Эдгээр үүргүүдийг хожмын үеийн бошиглогч, үзмэрч, илчлэгчид хэрхэн биелүүлж байна вэ? (Доорх ишлэлийг үз. Та мөн ангийнхнаар Тэргүүн Зөвлөл ба Арван Хоёрын Чуулгын гишүүд хэрхэн үзмэрчийн үүрэг биелүүлдгийг харуулсан бусад чуулганы яриа, тунхаг эсвэл үйл явдлуудыг ярилцуулж болно.) Хожмын үеийн бошиглогч, үзмэрч, илчлэгчид та нарт хэрхэн “агуу их ашиг тус” болж байсан бэ?

Ахлагч Бонд К.Пакер ийнхүү хэлэхдээ:

“Судруудад бошиглогч нарын тухай ‘дайсныг холоос хардаг’ ‘цамхаг дээрх харуул’ бөгөөд Их Эзэн түүнийг ард олных нь дээр үзмэрчээр тавьсан тул . . . энгийн нүдээр үл харагдах бүхнийг хардаг’ хэмээн хэлдэг.

“Олон жилийн өмнө Ахан дүүс бидэнд гэр бүлийн задралын тухай анхааруулан бэлтгэлтэй байхыг хэлсэн. . . . Тэргүүн Зөвлөл долоо хоног тутмын гэр бүлийн үдшийг нэвтрүүлэв. . . . Эцэг эхчүүдийг итгэлтэй нь адислагдах болно гэсэн амлалттайгаар хүүхдүүддээ заах гоц сайн материалуудаар хангав.

“Номлол болон илчлэгдсэн байгууллага нь хэвээр үлдэхэд, Сүмийн бүх үйл ажиллагаа нь бие биендээ болон гэр орондоо хандах хандлагаараа бүрэн өөрчлөгдсөн юм. . . . Сүмийн бүхэл хөтөлбөр нь нарийн шалгагдаж судрууд дээр үндэслэгдсэн. . . . Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Их Үнэт Сувдыг шинэчлэн бэлтгэхэд он жилүүд шаардагдсан. . . .

“Бид дөнгөж одоо л гэр бүлийн аймшигт задралд хариу үйлдэл үзүүлж эхэлсэн бол бид хаана байх байснаа зөвхөн төсөөлж л болох юм. Гэвч хэрэг нь үүнд биш. Бид сандарч тэвдэн юу хийхээ мэдэхгүй байгаа юм биш. Бид юу хийхээ, юу заахаа мэднэ. . . .

“Бид явж буй замаа өөрсдөө хийгээгүй. Авралын төлөвлөгөө, аз жаргалын агуу их төлөвлөгөө бидэнд илчлэгдсэн ба Сүм болон түүний гишүүдэд нь хэрэгцээтэй бүх л илчлэлтүүдийг бошиглогчид болон Төлөөлөгчид үргэлжлүүлэн хүлээн авсаар байгаа” гэжээ (in Conference Report, Apr. 1994, 24–25; or *Ensign*, May 1994, 20).

2. Зенифийн бичээсүүд Зенифийн ард түмний түүхийг товч өгүүлдэг.

Мозая 9–10-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Мозаягийн номын 9–22-р бүлгүүдэд Зарахэмлаг орхин Нифайн нутаг руу буцсан хүмүүсийн тухай түүх агуулагддаг гэж тайлбарла. Энэ түүх нь Лимхайн өвөг Зенифийн тухай мэдээллээр эхэлдэг.

- Зениф бол Нифайн нутгийг Лэмэнчүүдээс буцаан авахыг хүссэн Нифайчуудын бүлгийн хүн юм (Мозая 9:1). Лэмэнчүүд Нифайчуудад яаж ханддаг байсан бэ? (Мозая 10:11–17-г үз. Тэдний “хилэгнэж” байсан учир нь тэдний өвөг дээдэс болох Лэмэн, Лэмүүл хоёр “тэдний ах нараар буруутгагдсан” аж. Үүнээс болж тэд хүүхдүүддээ Нифайчуудыг үзэн ядаж байхыг сургажээ.) Өнгөрсөн үеийн уламжлал нь хүмүүсийг хэрхэн хутган үймүүлж үзэн ядалтанд хүргэдэг вэ? (Та ангийнхнаа орчин тойрон, улс үндэстэн, дэлхийд болдог ижил төстэй нөхцөлүүдийн жишээнээс хуваалцуулахаар урьж болно.) Яагаад ийм уламжлалууд ахин дахин давтагддаг вэ?
- Бид Зенифээс үзэн ядалтыг давах талаар юу сурч болох вэ? (Мозая 9:1-ийг үз. Лэмэнчүүдийг хэрхэн устгах талаар мэдэхийн тулд Зенифийг тагнуулаар явуулсан байлаа. Гэвч тэр Лэмэнчүүдийн дунд “сайн зүйлийг” хараад тэднийг устгах хүсэл нь үгүй болсон юм.) Бид бусдад байгаа сайн зүйлийг шударгаар олж харахын тулд юу хийж болох вэ?
- Зениф “өвгөдийнхөө нутгийг өвлөх” чармайлтандаа ямар алдаа хийсэн бэ? (Мозая 7:21- 22, 9:3-ыг үз.) Зенифийн дэндүү их хүсэлтэй байсан нь ямар үр дагаварт хүргэсэн бэ? (Мозая 9:3-12; 10:18-ыг үз.) Сайн үйлсийн төлөө байсан ч дэндүү их хүсэлтэй байх нь ямар аюултай вэ? Бид Их Эзэний ажилд дэндүү их хүсэлтэй биш хэрнээ хэрхэн чармайлттай үйлчилж чадах вэ?
- Зениф ба түүний хүмүүс Нифайн нутгийг авах зорилгодоо “Их Эзэн өөрсдийн Бурханыг санахдаа удаан байсан” (Мозая 9:3). Эцэст нь тэднийг Их Эзэн рүүгээ эргэхэд нь юу хөтөлсөн бэ? (Мозая 9:13–17-г үз.) Тэд Бурханаа санаад чөлөөлүүлэхийн төлөө залбираад хэрхэн адислагдсан бэ? (Мозая 9:18; 10:19–21-ийг үз.) Сүмийн гишүүдийн хувьд бид Их Эзэнийг “үргэлж санаж байх” гэрээ хийсэн (С ба Г 20:77, 79). Энэ гэрээгээ сахихад бидэнд туслах ямар ямар зүйлүүдийг бид хийж болох вэ?

3. Абинадай хүмүүст анхааруулдаг боловч тэд Ноагийн ёсон бус явдлыг тоодоггүй.

Мозая 11-ээс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Зенифийн дараа хэн хаан болдог вэ? (Мозая 11:1-ийг үз.) Ноа ямаршуу захирагч байсан бэ? (Мозая 11:1–19-ийг үз. Та самбарт, Ноагийн “өөрийн зүрх сэтгэлийн дагуу алхсан” мөн “хаант улсын хэргийг өөрчилсөн” арга замуудаас заримыг жагсааж болно.)
- Ноа хүмүүсийн амьдралд ямар нөлөө үзүүлсэн бэ? (Мозая 11:2, 5–7-г үз.) Тэдгээр хүмүүс болон Ноа нүглүүдийнхээ хариуцлагыг хэрхэн хуваалцсан бэ?
- Их Эзэн бошиглогч Абинадайг Ноа болон түүний хүмүүсийг наманчлалд дуудуулахаар явуулсан (Мозая 11:20). Их Эзэн Абинадайгаар дамжуулан юу анхааруулсан бэ? (Мозая 11:20–25-ыг үз. Та энэ хичээлд дөнгөж саяхан ярилцсаны дагуу Абинадай үзмэрчийн үүргийг хэрхэн гүйцэтгэснийг ярилцаж болно.)
- Ноа болон түүний хүмүүс Абинадайн анхааруулганд хэрхэн хариулсан бэ? (Мозая 11:26–28-ыг үз. Мөн Мозая 12:13-15-ыг үз.) Хүмүүс, тэднээс татвар

хураадаг бөгөөд шударга бус явдлыг дэмжихэд тэднийг албаддаг Ноад биш харин Абинадайд яагаад зэвүүцэж байсан бэ? (Мозая 11:7, 29-ийг үз.)

- Яагаад өнөөдөр зарим хүмүүс Ноа шиг хүмүүсийг дэмжин, Абинадай шиг Их Эзэний үйлчлэгчдийг эсэргүүцдэг вэ? Бурханы бошиглогчдыг таньж дагах нь яагаад чухал вэ? (Мозая 8:16–18; С ба Г 1:38; 84:36–38-ыг үз.)

Дүгнэлт

Ангийнхныг зөв шударга удирдагчдын, ялангуяа Их Эзэний дуудсан бошиглогч, үзмэрч, илчлэгч нарын зөвлөгөөг дагахыг урамшуулан дэмж.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

“Бурхан Өөрөө . . . Өөрийн Хүмүүсийг Гэтэлгэх Болно”

Хичээл
18

Мозая 12–17

Зорилго Ангийнханд Есүс Христийн Цагаатгалыг ойлгож Цагаатгалын тухай гэрчлэлдээ үнэнч байхад нь туслах болно.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Мозая 12–13. Абинадай Ноа Хаан болон түүний пристүүдийг наманчлалд дууддаг. Тэр тэдэнд зарлигуудыг сахихыг уриалдаг. Мосегийн үйлчлэл болон ёслолууд бол Есүс Христийн Цагаатгалын хэв шинж буюу бэлэгдлүүд юм гэж тэдэнд заадаг.
 - б. Мозая 14–16. Абинадай Исаиагаас иш татдаг. Тэр Цагаатгалыг гэрчилж, гэтэлгэл нь Христээр дамжин ирдэг гэж Ноагийн пристүүдийг хүмүүст заахыг ятгадаг.
 - в. Мозая 17. Ноагийн пристүүдийн нэг Алма наманчилж, Абинадайн үгсийг бичиж авдаг. Абинадай Аврагчийн тухай гэрчлэлээ амиараа лацдан баталдаг.
 2. Абинадай Ноа Хааны Өмнө хэмээх зураг байгаа бол хичээлдээ хэрэглэхээр бэлтгэ (62042; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 308).
 3. Та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглэж байгаа бол үйл ажиллагаанд орсон зургуудын заримыг эсвэл бүгдийг нь авчир.

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Их Эзэн хүмүүст хэцүү үүрэг даалгавар биелүүлэх тушаал өгдөг тухай судрын олон ишлэл байдаг гэж тайлбарла.

- Судруудад тэмдэглэгдсэн ямар ямар хэцүү үүрэг даалгавар буюу дуудлагууд байдаг вэ? (Байж болох зарим хариултууд, үйл явдлуудыг харуулсан зургуудыг дугаарын хамт дор жагсаасан болно.)
 - а. Ноа хүмүүст номлож байна (62053; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 102)
 - б. Мосе Израилчуудыг Египетээс гаргаж байна (62100)
 - в. Лихай Иерусалим дахь хүмүүст сэрэмжлүүлж байна (62517; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 300)
 - г. Естер Ахашверош Хааны өмнө очсон нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 125)
 - д. Абинадай Ноа Хаанд номлож байна (62042; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 308)

е. Сэмүэл Зарахэмлад номлож байна (62370; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 314)
ж. Иосеф Смит Дахин Сэргээлтийн Бошиглогчийн хувьд үүргээ гүйцэтгэж байна (62470; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 403)

- Эдгээр үүрэг нь яагаад хэцүү байсан бэ? Эдгээр хүмүүс яагаад хэцүү нөхцөлүүдийг үл харгалзан өөрсдийнхөө үүргийг биелүүлэх хүсэлтэй байсан гэж та нар бодож байна вэ?

Абинадай Ноа хааны өмнө байгаа зургийг үзүүлээд энэ хичээлээр Абинадайн сургаалуудыг ярилцана гэж хэл. Ангийн гишүүдийг Абинадай олон түмэнд номлохын тулд амиа өгөхөд ч бэлэн байсан шалтгаануудыг олоход нь урамшуул.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Абинадай Ноа болон түүний пристүүдийг наманчлалд дуудаж, тэдэнд зарлигуудыг сахихад нь уриалж, Цагаатгалын тухай заадаг.

Мозая 12–13-ыг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь. Хэрэв та Абинадай Ноа Хааны өмнө байгаа зургийг ашиглаж байгаа бол түүнийгээ хичээлийн туршид үзүүлэхээр өлгөж үлдээ.

- Абинадай Ноагийн ард түмэнд номлоод хоёр жилийн дараа тэд наманчлаагүй учраас боолчлогдож зовох болно гэж хэлэхээр эргэж ирсэн (Мозая 12:1–7). Тэд наманчлаагүй бол устгагдах болно гэж хэлэв (Мозая 12:8). Хүмүүс энэ захиасыг хэрхэн хүлээж авсан бэ? (Мозая 12:9–16-г үз.) Тэд яагаад Ноаг хамгаалсан гэж та нар бодож байна вэ?
- Абинадай, түүний үгсийг “авцалдахгүй болгох” гэсэн пристүүдийн оролдлогын эсрэг зогссоны дараа пристүүдийн нэг нь Абинадайгаас нэгэн судрын хэсгийн тухай асуулт асуусан (Мозая 12:19–24; эдгээр шүлгийг ангийн нэг гишүүнээр чангаар уншуул). Пристүүд яагаад энэ судрын хэсгийг ойлгох чадваргүй байсан бэ? (Мозая 12:25–27-г үз. Хичээлийн дундуур энэ судрын хэсгийн утгыг ярилцахаа анхааруул.) Зүрх сэтгэлээ ойлгоход зориулна гэдэг нь юу гэсэн утгатай вэ? Бид сайн мэдээг судалж заахдаа зүрх сэтгэлээ зориулах нь яагаад чухал вэ? (С ба Г 8:2–3-ыг үз.)
- Пристүүд Мосегийн хуулийг заадаг гэж мэдэгдэхэд Абинадай тэдний ямар асуудлуудыг илчилсэн бэ? (Мозая 12:28–37-г үз.) Бид зааж буй үнэнүүдийнхээ дагуу амьдрахаар чармайх нь яагаад чухал вэ?
- Захиасаа үлдээх боломжийг Абинадайд юу олгосон бэ? (Мозая 13:1–9-ийг үз. Их Эзэн Абинадайд Есүс Христийн Цагаатгалыг гэрчлэх боломж олгохын тулд үүнийг хийсэн гэж онцол. Энэ нь Цагаатгалын захиас чухал болохыг харуулж байгаа хэрэг юм.)
- Яагаад Абинадай Ноа болон түүний пристүүдэд Арван Зарлигийг уншсан бэ? (Мозая 13:11-ийг үз.) “Зүрхэндээ бичигдсэн” зарлигуудтай байна гэдэг нь ямар утгатай вэ? Зүрхэндээ бичигдсэн зарлигуудтай байх нь тэдгээрийг дуулгавартай дагахыг чармайхад маань хэрхэн нөлөөлдөг вэ?

- Мосегийн хуулийг сахихгүй байгаагийнх нь төлөө Ноа ба түүний пристүүдийг наманчлалд дуудаад Абинадай: “Аврал зөвхөн хуулиар ирэх нь үгүй,” гэжээ (Мозая 13:28). Аврал хэрхэн ирдэг вэ? (Мозая 13:14, 28, 32–35; Итгэлийн Тунхаг 1:3.)
- Мосегийн хууль ямар зорилготой вэ? (Мозая 13:29–33-ыг үз. Мосегийн хуулийн үйлчлэл болон ёслолуудын хэв шинж буюу бэлэгдлүүд нь ирээдүйд болох зүйлүүдийг төлөөлдөг гэж тайлбарла. Христ рүү харахад олон түмэнд туслахын тулд эдгээр нь өгөгдсөн.)

2. Абинадай Исаиагаас иш татаж, Цагаатгалыг гэрчилж, гэтэлгэл нь Христээр дамжин ирдэг гэж Ноагийн пристүүдийг хүмүүст заахыг ятгадаг.

Мозая 14–16-гаас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Абинадай Есүс Христийн тухай гэрчлэлийнхээ хэсэг болгон бошиглогч Исаиагаас иш татсан. Мозая 14-т иш татсан бошиглолоос Аврагчийн тухай бид юу сурдаг вэ? (Энэ асуултын хариуг олохын тулд ангийнхнаар шүлгүүдийг ээлжлүүлэн уншуул. Тэдний хариултыг самбарт хураангуйлан бич. Байж болох зарим хариултыг дор жагсаасан болно.)
 - Аврагч номхон бөгөөд даруухнаар амьдарч байсан (Мозая 14:2).
 - Олон хүмүүс түүнийг гадуурхсан (Мозая 14:3).
 - Тэр бидний гашуудал, харамслыг үүрсэн (Мозая 14:4).
 - Тэр өөртөө бүх хүмүүсийн нүглүүдийг авсан (Мозая 14:5–6, 8, 10–12).
 - Тэр сайн дураараа хавчигдан Өөрийгөө үхэлд өгсөн (Мозая 14:7–9).
 - Тэр нүгэлгүй байсан (Мозая 14:9).
- Аврагч “шударга ёсны шаардлагыг хангасан” гэж Абинадай хэлсэн (Мозая 15:9). Шударга ёсны шаардлага нь юу вэ? (Алма 42:11, 14-ийг үз.) Аврагч шударга ёсны шаардлагыг хангахын тулд юу хийсэн бэ? (Мозая 15:9; Алма 42:12–13, 15-ыг үз.)
- Абинадай үр буюу Есүс Христийн хөвгүүд, охидын тухай ярьсан (Мозая 15:10; Мозая 14:10). Аврагчийн хөвгүүд, охид байна гэдэг нь ямар утгатай вэ? (Мозая 15:11–14; Мозая 5:5–7-г үз. Есүс Христ бол авралын эх үндэс юм гэдгийг тайлбарла. Тэр болон Түүний сайн мэдээг хүлээн авдаг хүмүүсийн хооронд Эцэг хүүхдийн холбоо байдаг. Бид Түүнд итгэж, нүглээ наманчилж, Түүний хүслийг биелүүлэх гэрээ хийж, Түүний зарлигуудыг дуулгавартай дагахдаа Түүний үр буюу хөвгүүд, охид нь болдог.)
- Ангийнханд Ноагийн пристүүдийн нэг нь Абинадайд Исаиагийн “Сургаалыг авчрах түүний хөл нь уулсын дээр ямар үзэсгэлэнтэй билээ” гэсэн мэдэгдлийг тайлбарлаж өгөхийг хүссэн гэдгийг сануул (Мозая 12:20–24). Эдгээр сургаал нь юу вэ? (Мозая 15:19–25; С ба Г 76:40–42-ыг үз.) Эдгээр сургаалыг хуваалцсан элчүүд хэн байсан бэ? (Мозая 15:13–18-ыг үз. Аврагч Өөрөө, бошиглогчид болон сайн мэдээг хуваалцдаг бусад хүмүүс.) Эдгээр сургаалыг бусдад авчрахын тулд бид хэрхэн тусалж чадах вэ?
- Бид Христэд итгэж, Түүнийг дагаж, Түүний Цагаатгалыг хүлээн авбал нас барсныхаа дараа хэрхэн адислагдах вэ? (Мозая 15:21–23; 16:8–11-ийг үз.) Бид Христ болон Түүний Цагаатгалаас татгалзвал бидэнд юу тохиолдох вэ? (Мозая 15:26–27; 16:2–3, 5, 10–12-ыг үз.)

- Абинадай яриа өгснийхөө дараа Ноа ба пристүүдийг юу хийхийг ятгасан бэ? (Мозая 16:13–15-ыг үз.) Бид энэ зөвлөгөөг өөрсдийнхөө амьдралд хэрхэн хэрэглэж болох вэ?

3. Абинадай Аврагчийн тухай гэрчлэлээ амиараа лацдан баталдаг.

Мозая 17-гоос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Абинадай Ноа Хаан ба түүний хүмүүсийн төлөө хүлээсэн үүргээ амжилттай сайн гүйцэтгэж чадсан уу? Яагаад тэгж гүйцэтгэсэн эсвэл яагаад үгүй вэ? Абинадайн номлолоос шалтгаалан хэн хөрвүүлэгдсэн бэ? (Мозая 17:2–4; Алма 5:11–12; мөн 4 дэх заах нэмэлт санааг үз.)
- Абинадайд захиасаа өгснийх нь дараа Ноа Хаан ба шүүгчид түүнийг яахаар шийдсэн бэ? (Мозая 17:1, 7-г үз.) Алуулахгүйн тулд Абинадай юу хийж болох байсан бэ? (Мозая 17:9–10, 20-ыг үз.) Итгэлийнхээ төлөө бид бүр үхэх хэрэггүй ч гэсэн ямар замаар Абинадайн жишээг дагаж болох вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон: “Христ хүнийг өөрчилдөг бөгөөд өөрчлөгдсөн хүн дэлхийг өөрчилж чадна. Христийн төлөө өөрчлөгдсөн хүн Христээр удирдуулах болно. . . . Христээр удирдуулсан хүн Христэд шингэх болно. . . . Тэдний хүсэл Түүний хүсэлд шингэсэн байх болно. (Иохан 5:30-ийг үз.) Тэд үргэлж Их Эзэний таалалд нийцэх зүйлүүдийг хийдэг. (Иохан 8:29-ийг үз.) Тэд Их Эзэний төлөө зөвхөн үхэхийг бус харин тэд Түүний төлөө амьдрахыг хүснэ” гэсэн (in Conference Report, Oct. 1985, 5–6; or *Ensign*, Nov. 1985, 6).

Дүгнэлт

Абинадай ба Алма нарын хийсэн зүйлүүд бидэнд Цагаатгалын чухал ач холбогдлын тухай ойлгоход тусалж чадна. Их Эзэн Абинадайн амийг хамгаалсан тул тэр цагаатгалыг гэрчилж чадсан (Мозая 13:1–9). Абинадай энэ захиасыг хуваалцсаныхаа дараа “Аврагчийн тухай гэрчлэлээ амиараа лацдан баталсан” (Мозая 16:15). Ангийн гишүүдийг гэрчлэлдээ үнэнч байж Цагаатгалын захиасыг хуваалцахад урамшуул.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Дуулал

Ангийн гишүүдийн хамт Есүс Христийн Цагаатгалын тухай “Би Гайхширна” эсвэл “How Great the Wisdom and the Love” (*Hymns*, no. 195) дууллыг дуулах буюу үгийг нь унш. Эсвэл Цагаатгалын тухай дууллын бичлэгийг сонго.

2. “Эцэг мөн Хүү” (Мозая 15:2)

Мозая 15:1–9 дэх Абинадайн сургаал номлолыг тайлбарлахын тулд дараах мэдээллийг ашигла:

Абинадай Есүсийн тухай “Эцэг мөн Хүү” хэмээн ярихдаа Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр бол нэг хүн гэж заагаагүй. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ, Ариун Сүнс бол тусдаа гурван өөр хүн юм (С ба Г 130:22).

Эртний бошиглогчид Бурханы тухай эсвэл Их Эзэний тухай ярихдаа, мөнх бусын өмнөх Месая болох Жэховагийн тухай ярьдаг байсан (Мозая 13:33–34; 14:6). Тиймээс Абинадай Есүсийн тухай заахдаа: “Бурхан өөрөө хүмүүний үрсийн дунд доош ирэх болно, мөн өөрийн хүмүүсийг гэтэлгэх болно” гэжээ (Мозая 15:1; Мозая 7:27–28-ыг үз). Мозая 15:1–9 дэх Абинадайн сургаал номлолууд нь Есүсийн Эцэг байх үүрэг болон Түүний Бурханы Хүү болох үүргийн тухай юм.

Есүсийн Эцэг байх үүрэгт (а) Түүний ажлыг “тэнгэр мөн хорвоогийн Эцэг, эхлэлээс бүх зүйлүүдийг Бүтээгч” (Мозая 3:8); (б) Түүний үүргийг Түүний сайн мэдээг хүлээн авч Түүнийг дагагчдын Эцэг болох (Мозая 5:7; 15:10–13; Ифэр 3:14); мөн Түүний эрх мэдлийг “тэнгэрээс батлагдсан эрх мэдэл” хэмээн нэрлэж Тэнгэрлэг Эцэгийн өмнөөс ярьж үйлдэх эрх мэдэл зэрэг багтдаг. Есүсийн Бурханы Хүү болох үүрэгт (а) дэлхийн нүглүүдийн төлөөх Түүний Цагаатгал (Мозая 15:6–9) болон (б) Тэнгэрлэг Эцэгтэй бидний Зуучлагч болон Өмгөөлөгч болох Түүний үйлчлэл багтана (Иаков 4:10–11; С ба Г 45:3–5).

Есүс “махан бодид оршихын учир” Хүү гэж нэрлэгддэг ба “Бурханы хүчээр бий болгогдсон” учир Эцэг гэж нэрлэгддэг гэж Абинадай хэлжээ (Мозая 15:2–3; С ба Г 93:3–4-ийг үз). Абинадай “Хүүгийн таалал Эцэгийн талаалд багтсан байх болно” (Мозая 15:7) гэж хэлэхдээ Есүс өөрийн махан бодийг Өөрийн сүнсэнд захируулсан болохыг хэлсэн юм (Мозая 15:2–5; мөн 3 Нифай 1:14-ийг үз). Есүс өөрийн махан бодийг Өөрийн сүнсэнд захируулахдаа мөн Өөрийн хүслийг Тэнгэрлэг Эцэгийн хүсэлд захируулсан юм (Матай 26:39; С ба Г 19:16–19).

3. Номлолын ажлын урьдчилан хараагүй үр дүн

Абинадай өөрийнх нь сургаал номлолд хэн нэг нь итгэсэн гэж мэдэлгүй нас барсан байж болно. Гэвч Абинадайн чармайлтын хүчээр Алма хөрвүүлэгдэж тэр өөрөө мөн түүний үр сад нь олон үеийн туршид Нифайчуудад агуу их нөлөө үзүүлж байсан. Ерөнхийлөгч Гордон Б.Хинклигийн ярьсан дараах түүхийг хуваалц:

“Хэр их сайн юм хийж чадахаа та нар мэдэхгүй; та нар чармайлтынхаа үр дүнг урьдчилан харж чадахгүй. Хэдэн жилийн өмнө урьд нь Өмнөд Улсуудын Номлолын Ерөнхийлөгч байж байгаад дараа нь Арван Хоёр Чуулгын гишүүн болсон Ерөнхийлөгч Чарлз А.Каллис энэ түүхийг надад ярьсан юм. Өмнөд Нэгдсэн Улсуудын нэг номлогч номлолоо дуусгаад чөлөөлөгдөхөөр ирсэн юм гэж тэр ярьлаа. Номлолынх нь Ерөнхийлөгч түүнээс, ‘Чи номлолоо сайн хийв үү?’ гэж асуулаа.

“Тэр, ‘Үгүй,’ гэлээ.

“‘Яагаад?’

“‘За, миний ажил ямар ч үр дүнгүй болсон. Би цагаа болон аавынхаа мөнгийг дэмий үрлээ. Энэ бол цаг барсан зүйл боллоо.’

“Каллис ах, ‘Чи хэнийг ч усаар батлаагүй юу?’ гэлээ.

“Тэр, ‘Би энд байх хоёр жилийн хугацаанд ганцхан хүн л усаар баталлаа. Энэ бол Теннессийн алс бөглүү газрын арван хоёртой хүү юм,’ гэлээ.

“Тэр гэр лүүгээ гэм хийсэн мэт сэтгэгдэлтэйгээр буцсан юм. Каллис ах, ‘Би тэр усаар батлуулсан хүүд юу болсныг олж мэдэхийг шийдлээ. Тэр чухам ямар хүн болсныг нь би мэдэхийг хүссэн юм. . . .

“. . . ‘Би түүнийг хэдэн жилийн турш дагалаа. Тэр Ням Гарагийн Сургуулийн Удирдагч, тэгээд эцэст нь салбарын ерөнхийлөгч болсон. Тэр гэрлэсэн. Урьд эцэг эх нь амьдарч байсан жижигхэн түрээсийн фермээсээ нүүж өөрийн гэсэн жижигхэн газартай болж түүнийгээ үр өгөөжтэй болгосон юм. Тэр дүүргийн ерөнхийлөгч болсон. Тэр Теннесси дэх жижигхэн газраа зараад Айдахо руу нүүж тэнд Снейк Риверийн дагуу орших ферм худалдаж аваад тэндээ цэцэглэн амьдарсан. Хүүхдүүд нь өсөж том болсон. Тэд нар нь номлолд явсан. Тэд буцаж ирсэн. Тэд нар өөрсдийн хүүхдүүдтэй болсон ба тэд нь номлолд явсан.’

“Каллис ах, ‘Би Айдаход тэр гэр бүлийн хүн нэг бүрийг олж уулзаж тэдний номлолын үйлчлэлийнх нь тухай ярилцаж нэг долоо хоногийг өнгөрүүлсэн юм. Өөрийгөө бүтэлгүйтлээ гэж бодож байсан нэгэн номлогчийн Теннессийн алслагдсан бөглүү газрын нэгэн бяцхан хүүг усаар батлуулсны үр дүнд Сүмд 1,100 гаруй хүн иржээ.’

“Та нар номлогчоор үйлчилж байхдаа хэзээ ч ажлынхаа үр дүнг урьдчилан хэлж чадахгүй, хайрт ах эгч дүүс минь” (*Teachings of Gordon B. Hinckley* [1997], 360–61).

“Их Эзэнээс Өөр Хэн ч Тэднийг Чөлөөлж Чадахгүй”

Хичээл
19

Мозая 18–24

Зорилго Ангийн гишүүдийг усан баталгааныхаа гэрээг дээдлэн, Их Эзэнд итгэх шийдвэрээ шинэчлэхэд урамшуулна.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Мозая 18. Алма усан баталгааны гэрээг зааж, хүмүүсийг усаар баталж, хүмүүсийн дунд Сүмийг байгуулдаг.
 - б. Мозая 19. Ноа Хаан ард түмнээсээ урваж, галт шатаж үхдэг. Ноагийн хүү Лимхай хаан болдог.
 - в. Мозая 20–22. Лэмэнчүүд Лимхайн ард түмнийг боолчилдог. Өөрсдөө боолчлолоос гарах гэж оролдсныхоо дараа тэд наманчилж Их Эзэндээ эргэн ханддаг. Эцэст нь Их Эзэн тэднийг боолчлолоос чөлөөлдөг.
 - г. Мозая 23–24. Алмагийн хүмүүс Лэмэнчүүдэд олзлогдов. Ноагийн пристүүдийн нэг байсан Амолон гэгч тэднийг захирдаг. Тэд Их Эзэнд эргэн хандаж, Тэрээр тэдний дарлалыг багасгаж, улмаар боолчлолоос чөлөөлдөг.
 2. Та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглэж байгаа бол ангидаа Алма Мормоны Усанд Усаар Баталсан нь (62332; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 309) зургийг авчир. Мөн түүнчлэн энэ зургийг хичээлийн үеэр ашиглаж болно.

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Ангийн гишүүдээс асуу:

- Та нарын хэзээ нэгэн цагт үзсэн ямар үзэсгэлэнт газрууд байдаг вэ? Та нарын хувьд эдгээр газруудыг ямар зүйл тийм сайхан болгодог вэ?

Алма Мормоны усанд усаар баталж байгаа зургийг үзүүл.

- Алмагийн хүмүүсийн хувьд энэ газрыг юу сайхан болгосон бэ? (Ангийн нэг гишүүнээр Мозая 18:30-ийг чангаар уншуул. Ангийн гишүүдийг нэг, хоёроор нь тэдний хувьд сүнслэг ач холбогдол бүхий газрынхаа тухай сэтгэгдлээ хуваалцахыг урь.)

Энэ хичээлд Алмагийн хүмүүсийн “Мормоны газарт” хийсэн гэрээний тухай ярилцана гэдгээ хэл.

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Алма усан баталгааны гэрээг зааж, олон хүмүүсийг усаар баталдаг.

Мозая 18-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Ноа Хааны пристүүдийн нэг болох Алма Абинадайн сургаалуудад итгэсэн гэдгийг ангийн гишүүдэд сануул. Тэр Ноагийн үйлчлэгчдээс зугтаж цөлд нуугдаж тэндээ “Абинадайн хэлсэн бүх үгсийг” бичжээ (Мозая 17:2–4). Дараа нь тэр “нүглээ наманчилж . . . Абинадайн үгсийг зааж эхлэв” (Мозая 18:1–3). Алмад итгэж байсан хүмүүс түүний заахыг сонсохоор Мормон гэдэг газар луу явжээ (Мозая 18:4–6).

- Алма Мормон гэдэг газар юу заасан бэ? (Мозая 18:7.) Алмаг заасны дараа хүмүүс юу хүссэн бэ? (Мозая 18:8-ыг үз.) “Бурханы сүрэгт ирж . . . түүний хүмүүс гэж нэрлэгдэх” гэдэг нь ямар утгатай вэ? (Мозая 18:16–17; мөн Еврей 8:10; Алма 5:60-ыг үз.)
- “Бурханы сүргийн” гишүүдийн хувьд хүмүүс юу хийхийг хүсэж байсан бэ? (Энэ асуултын хариуг олуулахаар ангийнхнаар Мозая 18:8–9-ийг уншуул. Самбарт хариултуудыг хураангуйл. Тэгээд хариултуудыг доорх байдлаар ярилц.)
 - а. “Бие биенийхээ ачааг үүрэлц” (Мозая 18:8). Бид “бие биенийхээ ачааг хэрхэн үүрэлцэж” болох вэ? Бие биенийхээ ачааг үүрэлцэх нь ачааг хэрхэн хөнгөлж чадах вэ? Бусад нь ачаанаас чинь үүрэлцэхэд та нар хэрхэн адислагдсан бэ?
 - б. “Гашуудах тэдний хамт гашуудах” (Мозая 18:9). “Гашуудах тэдний хамт гашуудах” нь яагаад тус болдог вэ?
 - в. “Тайтгарал хэрэгтэй тэдгээрийг тайтгаруулах” (Мозая 18:9). Бид бусдыг хэрхэн зөв байдлаар тайтгаруулж чадах вэ?
 - г. “Бурханы гэрчлэгч болох” (Мозая 18:9). “Ямар ч цагт мөн бүх зүйлүүдэд мөн өөрийн байж болох хаана ч гэсэн Бурханы гэрчлэгч болох” гэдэг нь ямар утгатай вэ? (Мозая 18:9).
- Алма хүмүүст номлосныхоо дараа хүмүүсийг юу хийхэд урьсан бэ? (Мозая 18:10. Тэр тэднийг усаар батлуулж Их Эзэнтэй гэрээ байгуулахыг урьсан.) Гэрээ гэж юу вэ?

Ерөнхийлөгч Иосеф Филдинг Смит: “Гэрээ бол доод тал нь хоёр талын хооронд хийгдэх хэлэлцээр ба тохиролцоо юм. Сайн мэдээний гэрээний хувьд бол талууд нь тэнгэр дэх Их Эзэн болон газар дээрх хүн юм. Хүн зарлигуудыг дагахаа зөвшөөрч, Их Эзэн үүнийх нь дагуу шагналыг амладаг” гэжээ (in Conference Report, Oct. 1970, 91; or *Improvement Era*, Dec. 1970, 26).
- Мозая 18:8–13-ын тухай Ерөнхийлөгч Марион Г.Ромни хэлэхдээ: “Усан баталгааны гэрээний үүнээс илүү сайн талбарыг би мэдэхгүй” гэжээ (in Conference Report, Oct. 1975, 109; or *Ensign*, Nov. 1975, 73). Мозая 18:8–13-ын дагуу бид усаар батлуулахдаа юу хийхээр гэрээ хийдэг вэ? (Мөн Моронай 6:2–3; С ба Г 20:37-г үз.) Биднийг усаар батлуулж усан баталгааныхаа гэрээг сахивал Их Эзэн юу хийхээр амласан бэ? (Мозая 18:10, 12–13; мөн 2 Нифай 31:17-г үз.)

- Хүмүүс Алмагийн усаар батлуулах урилгад хэрхэн хариу хандсан бэ? (Мозая 18:11-ийг үз. Та Алма усаар баталж байгаа зургийг ашиглаж байгаа бол түүнийгээ одоо үзүүл.) Энэ агуу баяр баясгаланг хүмүүсийг хүлээн авахад нь туслахын тулд бид юу хийж болох вэ? (Та ангийнхныг сайн мэдээг хуваалцаж болох хүмүүсийнхээ тухай бодоход урамшуул.)
- Хүмүүс усаар батлуулсны дараа Алма тэдэнд “зүрх сэтгэлээ эв нэгдэл мөн . . . хайранд нэгтгэхийг” зарлигласан (Мозая 18:21). Энэ зарлигийг дагахын тулд бид гэртээ болон хэсэг эсвэл салбартаа юу хийж болох вэ? (Мозая 18:19–21.)

2. Ноа Хаан ард түмнээсээ урваж, галт шатаж үхдэг.

Мозая 19-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Ноа Хааны зарим хүмүүс түүний эсрэг эргэж эхэлсэн гэж тайлбарла (Мозая 19:2–3). Тэдний нэг болох Гидеон гэдэг хүн Лэмэнчүүдийн том арми тэдэн рүү давшлан ирэхийг хараад Ноаг бараг алах шахсан (Мозая 19:4–6).

- Ноа Хаан Лэмэнчүүдийн том арми тэдэн рүү давшлан ирэхийг хараад юу хийсэн бэ? (Мозая 19:7-г үз.) Ноа хэний талаар хамгийн их санаа зовж байсан бэ? (Мозая 19:8-г үз.) Биднийг Их Эзэн болон Түүний бошиглогчдоос холдуулахыг оролддог Ноа шиг хүмүүсийг өнөөдрийн хүмүүстэй хэрхэн харьцуулж болох вэ?
- Абинадай Ноа Хааны үхлийн тухай юу бошиглосон бэ? (Мозая 12:3-ыг үз.) Энэ бошиглол хэрхэн биелсэн бэ? (Мозая 19:18–20-ыг үз. Эцэст Ноагийн амьдралыг “халуун тогоон дахь гармент” гэж дүгнэсэн хүмүүс Мозая 11:29-д харуулсанчлан нэг үе түүний ёсон бус явдлыг тоож үздэггүй хүмүүс байсан гэж онцол.)

3. Лимхайн ард түмэн цээрлэгдэж эцэст нь Их Эзэн тэднийг авчирдаг.

Мозая 20–22-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц (17-р хичээлд ярилцсанчлан эдгээр бүлгүүдэд Лимхайн хүмүүс Аммон болон түний ахан дүүсийг олсон тухай агуулагддаг гэдгийг анхаар). Ноа алагдсаны дараа түүний хүү Лимхай хаан болсон гэдгийг хэл. Лимхай өөрөө болон түүний ард түмэн өөрсдийнхөө бүх эд хөрөнгөний хагасыг тэднийг алахгүй байхыг амлавал Лэмэнчүүдэд төлөхөөр тангараг тавьсан (Мозая 19:25–26).

- Хоёр жил тайван амгалан байсны дараа Лэмэнчүүд Лимхайн хүмүүсийн эсрэг дайн өдөөв (Мозая 20:7–10). Яагаад Лэмэнчүүд Лимхайн ард түмнийг устгахыг эрэлхийлж байсан бэ? (Мозая 20:1–6-г үз.)
- Лэмэнчүүд Лимхайн ард түмний талаар буруу бодож байснаа ойлгоод өөрсдийнхөө нутаг руу амар амгалан буцав (Мозая 20:17–26). Гэвч “олон хоногийн дараа Нифайчуудын эсрэг уурандаа өдөөгдөж эхлэв” (Мозая 21:2). Өөрсдийг нь алахгүй гэсэн хааны тангарагаасаа няцахын оронд Лэмэнчүүд Нифайчуудын эсрэг юу хийсэн бэ? (Мозая 21:3-ыг үз.)
- Лимхайн ард түмний боолчлогдол нь Абинадайн бошиглолыг хэрхэн биелүүлсэн бэ? (Ангийн гишүүдээр Мозая 21:3–5, 14–15-ыг Мозая 11:20–25 ба 12:2, 4–5-тай харьцуулуул.) Яагаад Лимхайн ард түмэн боочлогдсон бэ? (Мозая 7:25–32; 20:21-ийг үз. Тэд Абинадайн сургаал ба гэм нүглийн үр дагаварын анхааруулгыг эсэргүүцсэн). Гэм нүгэл үр дагавартай байдгийг санаж байх нь яагаад чухал вэ?

- Лимхайн ард түмэн тулалдаанд, Лэмэнчүүдэд гурван удаа ялагдаад эцэст нь юу хийсэн бэ? (Мозая 21:13–14-ийг үз.) Их Эзэн яагаад тэдний гуйлтгыг сонсохдоо удаан байсан бэ? (Мозая 21:15-ыг үз; мөн С ба Г 101:1–9-ийг үз.) Хэдийгээр Их Эзэн тэднийг шууд хаяагүй ч Тэр тэдний төлөө юу хийсэн бэ? (Мозая 21:15–16-г үз.) Их Эзэн биднийг заримдаа хэрхэн “бага багаар дэгжүүлдэг” вэ?
- Лимхайн ард түмэн Лэмэнчүүдээс хэрхэн зугтаж байсан бэ? (Мозая 22:3–12-ыг үз.) Зарахэмла дахь хүмүүс тэднийг хэрхэн хүлээн авсан бэ? (Мозая 22:13–14-ийг үз.)

4. Их Эзэн Алмагийн хүмүүсийг боолчлолоос чөлөөлдөг.

Мозая 23–24-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Ангийн гишүүдээр Их Эзэн рүү эргэн хандахаасаа өмнө өөрсдөө гурван удаа чөлөөлөгдөхийг оролдож байсан Лимхайн ард түмний адисласан байдал болон Түүн рүү бүрэн хандсан Алмагийн хүмүүсийг адисласан байдал хоёрын хоорондох ялгааг олуул.

- Алма ба түүний хүмүүсийг Мормоны газарт байхад нь Ноа Хаан “тэднийг устгуулахаар их цэргээ илгээв” (Мозая 18:33). Их Эзэн Алмагийн хүмүүст анхааруулсан тул тэд зугтаж чадсан (Мозая 18:34–35; 23:1–5). Энэ явдал нь Лимхайн ард түмнийхээс юугаараа өөр вэ? (Мозая 19:6. Анх Лэмэнчүүд энэ хүмүүс рүү дайралт хийхэд Ноа тэдний хаан хэвээр байсан ба хүмүүс ямар ч анхааруулга хүлээж аваагүй гэдгийг анхаар.)
- Хүмүүс Алмаг хаан болохыг гуйхад тэр хэрхэн хариулсан бэ? (Мозая 23:6–7-г үз.) Алма “хүний бусдаас илүү өөрийгөө бодохын” аюулыг хэрхэн мэдсэн бэ? (Мозая 23:8–14-ийг үз.) Ийм алдаанаас бидэнд зайлсхийхэд туслах ямар зүйлийг бид Алма ба түүний хүмүүсээс сурч чадах вэ? (Мозая 23:15-ыг үз.)
- Алмагийн удирдлаган дор түүний хүмүүс зөв зохистой амьдарч дэгжсэн (Мозая 23:15–20). Тэгсэн ч Их Эзэн тэднийг Ноа Хааны пристүүдийн нэг байсан Амюлонд боолчлуулсан (Мозая 23:23–39). Алмагийн хүмүүсийн боолчлогдол нь Абинадайн бошиглолыг хэрхэн биелүүлсэн бэ? (Мозая 12:2; 4–5-ыг үз.) Бид нүглээсээ өршөөгдсөн ч бидний муу сонголтууд бидэнд хожимдсон үр дагаварыг хэрхэн авчирч болох вэ?

Ахлагч Марвин Ж.Аштон: “Өөрсдийн явах замаа сонгох эрх чөлөө нь биднийг хийсэн зүйлийн маань үр дагавраас чөлөөлдөггүй. Биднийг хайрлах Бурханы хайр өөрчлөгдөшгүй бөгөөд багасахгүй ч, буруу сонголт хийснээс шалтгаалсан харамсмаар үр дүнгээс Тэр биднийг аварч чадахгүй” гэжээ (in Conference Report, Oct. 1990, 24; or *Ensign*, Nov. 1990, 20).

Хэдийгээр Их Эзэн Алмагийн хүмүүст өнгөрсөн нүглээс нь шалтгаалсан зовлонгоос сэрэмжлүүлж чадаагүй ч, Тэр тэднийг зовлон зүдгүүртэй үед нь тайтгаруулж хүчийг өгсөн. Энэ хичээлийн үлдсэн хугацаа нь Тэр хэрхэн тэднийг боолчлолоос чөлөөлсөн тухай ярилцахад зориулагдана.

- Алмагийн хүмүүсийн боолчлолын тухай ярихдаа Мормон: “Их Эзэн өөрийн хүмүүсийг зэмлэх нь зүйд нийцэх хэмээнэм” гэсэн (Мозая 23:21). Их Эзэн яагаад өөрийн хүмүүсийг зэмлэдэг вэ? (Мозая 23:21; С ба Г 95:1–2-ыг үз.) Их Эзэн биднийг зэмлэхэд бид хэрхэн хандах ёстой вэ? (Мозая 23:22-ыг үз.)

- Амглон тэднийг залбирвал ална гэж сүрдүүлэхэд Алмагийн хүмүүс юу хийсэн бэ? (Мозая 24:10–12-ыг үз.) Их Эзэн тэдний чимээгүй залбиралд хэрхэн хариулсан бэ? (Мозая 24:13–16-г үз.) Энэ нь тэдэнд Мормоны усанд гэрээлснийх нь дагуу Их Эзэний “гэрчээр зогсоход” хэрхэн тусалсан бэ? (Мозая 24:14-ийг үз.)
- Биднийг “баяртайгаар мөн тэвчээртэйгээр Их Эзэний бүх тааллуудад захирагдахад” ачаа маань яагаад хөнгөрдөг вэ? (Мозая 24:15.) “Ачааг чинь үүрэхэд хөнгөн болгохын” тулд Их Эзэн та нарт ямар замаар тусалсан бэ? Энэ нь та нарт Их Эзэний гэрчээр зогсоход хэрхэн тусалсан бэ?
- Их Эзэн яагаад боолчлолд байхад нь Алмагийн хүмүүсийг Лимхайн хүмүүсээс илүү хурдан ба өгөөмрөөр адисласан бэ? (Мозая 21:5–15-ыг Мозая 23:26–27; 24:10–16-тай харьцуул.) Энэ нь бидний амьдралд хэрхэн хэрэглэгдэх вэ?
- Их Эзэн чөлөөлөхөөс өмнө Алмагийн хүмүүс болон Лимхайн хүмүүсийн аль аль нь нүгэлт захирагчдын боолчлолд байсан. Ноа Хааны үед хүмүүс мөн “алдсын хүлгээр хүлэгдсэн байсныг” харсан (Мозая 23:12). Алдас буюу нүгэл нь хэрхэн боолчлолын хэлбэр болдог вэ? Бид Лимхайн болон Алмагийн хүмүүсээс нүглийн боолчлолоос чөлөөлөгдөх талаар юу сурч чадах вэ? (Мозая 7:33; 21:14; 23:23; 29:18–20-ийг үз; мөн С ба Г 84:49–51-ийг үз. Ганцхан Их Эзэн л биднийг нүглийн боолчлолоос чөлөөлж чадна. Наманчлал, итгэл, төлөв түвшин байдал болон эцсээ хүртэл дуулгавартай байснаар бид Түүнд эргэн хандах ёстой.)

Дүгнэлт

Усан баталгааны гэрээн дэх Их Эзэний амлалтуудыг давт (Мозая 18:10, 13). Их Эзэний бидэнд амласан адислалуудын гэрэлд бид “түүнд үйлчилж түүний зарлигуудыг сахих” гэрээгээ биелүүлэхэд бидэнд хэцүү байх ёсгүй гэдгийг цохон тэмдэглэ (Мозая 18:10). Бид усан баталгааны ёслолыг хүлээн аваад наманчлал, Есүс Христэд итгэх итгэл, төлөв түвшин байдал, дуулгавартай байдлаа үргэлжлүүлбэл нүглийн боолчлолоос чөлөөлөгдөн мөнхийн амьдралын зам дээр байх болно гэдгийг онцлон тэмдэглэ (2 Нифай 31:17–20).

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт

Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. “Алма мөн Хелам хоёул усанд бүрхэгдэв” (Мозая 18:14)

Алмаг хэрхэн усаар батлах эрх мэдэлтэй байсныг тайлбарлаж, мөн Алма Хеламыг усаар батлахдаа өөрийгөө усаар батлаагүй гэдгийг харуулахын тулд доорх мэдэгдлийг ашигла:

Ерөнхийлөгч Иосеф Филдинг Смит заахдаа, “Абинадайг ирэхээс өмнө Алма усаар батлуулж, пристийн зэрэгтэй болсон байсан ч, тэр бусад пристүүдийн хамт нүгэл хилэнцэт Ноа Хааны удирдлаган дор байсан бөгөөд Хеламыг усаар батлахдаа өөрийгөө цэвэрлэгдсэн байх ёстой хэмээн мэдэрч бүрэн наманчлалынхаа тэмдэг болгон өөрийгөө усанд умбуулсан” гэсэн (*Doctrines of Salvation*, comp. Bruce R. McConkie, 3 vols. [1954–56], 2:336–37).

2. Их Эзэнд Даруухнаар Үйлчлэх нь

- Алма хүмүүсийг усаар батлахынхаа өмнө, “Ай Их Эзэн, тэрээр энэ ажлыг зүрхний ариунаар хийж болохын тул өөрийн Сүнсийг та зарцынхаа дээр юүлээч” хэмээн залбирав (Мозая 18:12). Бид Их Эзэнд өөрсдийнхөө үйлчлэлийг ийм сүнсэнд хүргэвэл хэрхэн адислагдаж болох вэ?

3. “Хишиг өдрийг сахиж, мөн үүнийг ариунаар байлга” (Мозая 18:23)

- Хишиг өдрийг сахиж нь яагаад чухал вэ? (Мозая 18:23, 25-ыг үз.) Хишиг өдрийг ариунаар хадгалахдаа та нар хэрхэн адислагдсан мэдрэмжийг мэдэрсэн вэ? Үүнийг ариун өдөр болгоход нь туслах ямар зүйлүүдийг та нар хийдэг вэ?

4. Гачигдалтай хүмүүст туслах нь

- Гачигдалтай хүмүүст тусламж үзүүлэх тухай Алма ямар зарчмуудыг заасан бэ? (Мозая 18:27–29-ийг үз.) Бид эд зүйлсийн зэрэгцээгээр сүнслэг тусламж өгөх нь яагаад чухал вэ? Өгөөмрөөр өгч талархангуй хүлээн авснаар ямар адислалууд ирдэг вэ?

“Миний Бодгаль Цаашид Дахин Өвдөх нь Үгүй”

Хичээл
20

Мозая 25–28; Алма 36

Зорилго Наманчлалын зарчмыг тасралтгүй хэрэгжүүлж, хөрвүүлэгдэн, сайн мэдээг хуваалцахад ангийн гишүүдэд урам өгөх болно.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Мозая 25. Лимхайн болон Алмагийн хүмүүс Зарахэмлагийн нутагт Мозаягийн хүмүүстэй хамтдаа цугладаг. Лимхай болон түүний хүмүүс усаар батлуулдаг. Хаан Мозая Зарахэмла даяар Бурханы Сүмийг байгуулах эрхийг Алмад олгодог.
 - б. Мозая 26; 27:1–7. Үл итгэгчид Сүмийн олон гишүүнийг нүгэл рүү хөтөлдөг. Их Эзэн Алмад наманчилсан нь өршөөгдөх бөгөөд наманчлаагүй нь Сүмийн хүмүүсийн дунд тоологдохгүй гэж хэлдэг. Мозая итгэгч болон үл итгэгчдийг бие биенээ хавчин гадуурхахыг нь хориглосон зарлиг гаргадаг.
 - в. Мозая 27:8–31; Алма 36:6–23. Бага Алма болон Мозаягийн дөрвөн хүү нийлж Бурханы Сүмийг нураахыг эрэлхийлдэг. Тэдний эцгүүд болон бусад Сүмийн гишүүдийн залбирлын хариуд тэдэнд тэнгэр элч үзэгддэг. Бага Алма болон Мозаягийн хөвгүүд хөрвүүлэгддэг. Бага Алма хөрвүүлэгдсэнээ гэрчилдэг.
 - г. Мозая 27:32–28:20; Алма 36:24. Бага Алма болон Мозаягийн хөвгүүд өөрсдийгөө сайн мэдээг номлоход зориулдаг.
 2. Ангийн нэг гишүүнээр Бага Алма болон Мозаягийн хөвгүүдийг хөрвүүлэгдэхэд хүргэсэн үйл явдлын товч тоймыг ярихад бэлтгүүл (Мозая 27:8–24).
 3. Бага Алмагийн хөрвүүлэлтийн зураг байгаа бол хичээлд хэрэглэхээр бэлтгэ (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 321).

Хичээлийг Баяжуулах Зөвлөмж

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Ангийн гишүүдээс асуу:

- Та нарын хэд нь хөрвүүлэгдсэн бэ?

Бид *хөрвүүлэгдэх* гэсэн үгийг ихэвчлэн найман нас өнгөрснөөсөө хойш усаар батлуулж Сүмд орсон хүний тухай ярихдаа хэрэглэдэг гэдгийг цохон тэмдэглэ. Нөгөө талаар бол бидний хүн нэг бүр хөрвүүлэгдсэн байх ёстой. Бидний хүн нэг бүр хэзээ усаар батлуулснаасаа үл хамааран Есүс Христийн сайн мэдээний тухай гэрчлэлтэй байх ёстой. Зарим хүмүүсийн хувьд энэхүү хөрвүүлэлт нь гэнэт л, гайхамшигтайгаар болдог байхад ихэнх хүмүүсийн

хувьд энэ нь нарийн ба удаан үйл явц байдаг. Зарим хүмүүс амархан хөрвүүлэгддэг байхад зарим нь гэрчлэл болон амлалтаа хөгжүүлэхийн төлөө тэмцэх ёстой байдаг. (22-р хичээлд хөрвүүлэгдэх үйл явцын талаар үргэлжлүүлэн ярилцдаг гэдгийг анхаар.)

Энэ хичээлээр таван залуу эрэгтэй Сүмийн хүчтэй мөн итгэлтэй удирдагчдын хөвгүүд байсан ч гэсэн Есүс Христийн сайн мэдээнд хөрвүүлэгддэг тухай тэдэнд тохиолдсон явдлыг ярилцах болно.

Судрын Ярилцлага ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой түршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Лимхайн болон Алмагийн хүмүүс Мозаягийн хүмүүстэй Зарахэмлагийн нутагт нэгддэг.

Мозая 25-ыг ярилц. Ангийн гишүүдийг сонгосон шүлгүүдийг уншихыг урь. Лимхайн болон Алмагийн хүмүүс Мозаягийн хүмүүстэй Зарахэмлагийн нутагт нэгддэг гэдгийг тайлбарла (Мозая 22:11–14; 24:20, 23–25). Энэ үед дөрвөн бүлэг хүмүүс Зарахэмлад Мозая Хааны удирдлаган дор нэгдсэн гэдгийг ангийн гишүүдэд ойлгоход нь тусал:

- а. Зенифийн үр удам болох Лимхайн хүмүүс болон Зарахэмлагаас Нифайн нутаг руу буцаж ирсэн хүмүүс.
- б. Ноагийн хаанчлалын үеэр Зенифийн үр удмаас тасарч салсан Алмагийн хүмүүс.
- в. Зарахэмлад үлдсэн Нифайчууд.
- г. Зарахэмлагийн ууган нутгийнх болох Мюлекчүүд.

Энэ бүх хүмүүс өөрсдийгөө энэ үед Нифайчууд гэж нэрлэх болсон гэдгийг тайлбарла (Мозая 25:12–13).

- Мозая Зарахэмла дахь хүмүүсийг зохион байгуулаад Лимхайн хүмүүсийн болон Алмагийн хүмүүсийн цэдгийг тэдэнд уншиж өгсөн (Мозая 25:5–6). Зарахэмлагийн хүмүүс эдгээр бичээсийг хэрхэн хүлээн авсан бэ? (Мозая 25:7–11.) Тэдний хандлага тэдний энэрлийг хэрхэн харуулсан бэ?
- Лимхайн болон Алмагийн хүмүүсийн цэдгийг судалснаар та нарт энэ нь хэрхэн ашиг тусаа өгсөн бэ?
- Мозая цэдгүүдийг уншиж дуусаад Алмаг ярихыг урьсан (Мозая 25:14). Алма юуны тухай ярьсан бэ? (Мозая 25:15–16-г үз.) Хэн тэднийг боолчлолоос чөлөөлснийг хүмүүс санаж байх нь яагаад чухал байсан бэ? Алмагийн сургаал номлолууд Лимхай ба түүний хүмүүст яаж нөлөөлсөн бэ? (Мозая 25:17–18-ыг үз.)
- Мозая Алмад “Зарахэмлагийн нутаг даяар сүмүүдийг байгуулах эрх мэдэл” олгосон (Мозая 25:19–20). Хүмүүс өөр өөр цуглаануудад хуваагдан зохион байгуулагдсаныхаа дараа тэд хэрхэн “нэг сүм” хэвээр байх боломжтой байсан бэ? (Мозая 25:21–24-ийг үз.) Дэлхий даяарх сүмд “нэгдмэл нэг” байхад нь бэрхшээлүүд тулгарах үед өнөөдөр тэдний жишээ бидэнд хэрхэн тусалж болох вэ?

2. Үл итгэгчид Сүмийн олон гишүүдийг нүгэл рүү хөтөлдөг.

Мозая 26; 27:1–7-гоос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Яагаад “өсвөр үеийнхний” олон нь Сүмд нэгдэхээс татгалзсан бэ? (Мозая 26:1–4-ийг үз.) Ахмад үеийнхэн нь залуучуудад Есүс Христ ба Түүний сайн мэдээний гэрчлэлтэй болоход нь хэрхэн тусалж чадах вэ? Ахмад үеийнхэн нь залуучуудад Бурханы хайрыг мэдрэхэд нь болон Түүнтэй харьцах харьцаагаа ойлгоход нь хэрхэн тусалж чадах вэ?
- Үл итгэгчид Сүмийн олон гишүүдийг нүгэл рүү хөтөлсөн. Нүгэл үйлдсэн Сүмийн гишүүдийн төлөө Алма ямар хариуцлага хүлээсэн байсан бэ? (Мозая 26:6–8-ыг үз.) Ноцтой нүгэл үйлдсэн гишүүдэд туслахын тулд Их Эзэн өнөөдөр Сүмийн удирдагчдад ямар үүрэг хариуцлага хүлээлгэсэн бэ?
- Мозая нүгэл үйлдсэн хүмүүсийг шүүхээс татгалзахад Алма хэнтэй зөвлөлдсөн бэ? (Мозая 26:10–14-ийг үз.) Та нар Бурханд хандан залбирахдаа үүрэг хариуцлагынхаа талаар ямар удирдамж хүлээж авч байсан бэ?
- Их Эзэн Алмад нүгэл үйлдсэн хүмүүсийг яахыг хэлсэн бэ? (Мозая 26:29–30, 32-ыг үз.) Нүглээ хүлээх нь яагаад наманчлах үйл явцын чухал алхам болдог вэ? “Бие биенээ” уучлах нь яагаад чухал вэ? (Мозая 26:31.) Та нар хэн нэгнийг уучлахдаа эсвэл хэн нэгэн чамайг уучлахад хэрхэн адислагдаж байсан бэ?
- Хэдийгээр Сүм “дахин амар амгалан болж дэвжсэн” ч үл итгэгчид Сүмийн гишүүдийг олонтаа хавчин мөрддөг байлаа (Мозая 26:37–38; 27:1). Сүмийн гишүүд энэ хавчлагын талаар гомдоллоход Мозая Хаан юу хийсэн бэ? (Мозая 27:1–5.) Өнөөдөр Сүмийн гишүүд ямар арга замаар хавчигдаж болох вэ? Хавчлагыг зохицуулах ямар үр дүнтэй аргууд байдаг вэ?

3. Бага Алма болон Мозаягийн хөвгүүдэд тэнгэр элч үзэгдсэн.

Мозая 27:8–31; Алма 36:6–23-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Мозая хавчлагыг хориглосон зарлиг гаргасан ч зарим үл итгэгчид Сүмийг нураах оролдлогоо үргэлжлүүлсээр байсан. Эдгээр үл итгэгчдэд Мозаягийн өөрийнх нь хөвгүүд болон Алмагийн хүү орж байсан (Мозая 27:8–9).

Урьдчилан даалгасан ангийн гишүүнээр Бага Алма болон Мозаягийн хөвгүүдийг хөрвүүлэгдэхэд хүргэсэн үйл явдлыг тоймлон яриул (Мозая 27:8–24). Та Бага Алмагийн зургийг ашиглаж байгаа бол түүнийгээ одоо үзүүл.

- Их Эзэн Бага Алма болон түүний нөхдөд хандан тэнгэр элчээр яриулахаар яагаад илгээсэн бэ? (Мозая 27:14-ийг үз.) Бидний хайрладаг хүмүүс сайн мэдээгээрээ амьдрахаа боливол бидэнд залбирал хэрхэн тусалж чадах вэ?

Жеффри Р.Холланд Сүмийн Боловсролын Онцгой Төлөөлөгч байхдаа: “Хүүхдийнхээ сүнсний төлөө айж буй эцэг, эхийн шаналалтай дүйцэх хүний сүнсний шаналал үгүй бизээ. . . . Гэвч эцэг эхчүүд найдвар, анхаарал халамж, итгэлээ хэзээ ч орхиж чаддаггүй. Мэдээж тэд залбирахаа хэзээ ч орхихгүй. Заримдаа залбирал нь хийх зүйлээс үйлдсэн цорын ганц зүйл байж болох боловч энэ нь бүх зүйлүүдээс хамгийн хүчтэй нь юм” гэжээ (“Alma, Son of Alma,” *Ensign*, Mar. 1977, 80–81).

- Төөрөлдөн холдсон хайртай хүмүүсийнхээ төлөө залбирсан зөв шударга хүмүүсийн залбирлын хариуд Их Эзэн ямар арга замаар тусламж илгээдэг вэ? (Ангийн гишүүдэд Их Эзэн тэр болгон тэнгэр элчийг Алма руу илгээсний адил илгээдэггүй боловч Тэр тоолж баршгүй өөр олон аргаар тусламж илгээдэг гэдгийг ойлгоход нь тусал. Тэрээр мэдрэмтгий удирдагч эсвэл найз, хичээнгүй гэрийн багш эсвэл айлчлагч багш нар эсвэл урамшуулагдсан сургаал номлолыг бидний залбирч буй хүмүүсийн амьдралд нөлөө үзүүлэхээр илгээж болно.) Засч эмчилж болохгүй мэт нөхцөлд залбирлын хүч туслахыг та нар хэрхэн харсан бэ?
- Тэнгэр элч Бага Алмад юу гэж хэлсэн бэ? (Мозая 27:13–17-г үз.) Тэнгэр элчийг явсны дараа Бага Алмад юу тохиолдсон бэ? (Мозая 27:18–19-ийг үз.) Хүүгийнхээ тэнгэр элчтэй тохиолдсон явдлыг сонсоод Алма яасан бэ? (Мозая 27:20-ийг үз.) Тэр яагаад баярласан бэ?

Хөрвүүлэгдсэнээсээ хойш олон жилийн дараа Алма хүү Хеламандаа энэ явдлынхаа тухай ярьсан гэдгийг тайлбарла (Мозая 36:6–24.) Мозая 27 ба Алма 36 дээрх түүхийг ашиглан ангийнхнаар Алмагийн өршөөгдөхийн өмнөх болон дараах сэтгэгдлүүдийг харьцуулуул (ангийн зарим гишүүдээр Мозая 27, нөгөө хэсгээр нь Алма 36 дээрх түүхийг харуулахаа анхаар). Та ярилцлагыг доорх хүснэгтэнд харуулсны адилаар хураангуйлж болно.

ӨМНӨ НЬ	ДАРАА НЬ
Эгэл ба унасан байдал, зайлуулагдах (Мозая 27:25–27; Алма 36:11)	Бурханаар гэтэлгэгдэж, Сүнсээр төрсөн (Мозая 27:24–25; Алма 36:23)
Их бэрхшээлийг туулж (Мозая 27:28)	Үүрдийн шаталтаас шүүрэгдэх (Мозая 27:28)
Шаналлын гүн, алдсын хүлээс (Мозая 27:29)	Шаналлын гүн, алдсын хүлээснээс гэтэлгэгдэх (Мозая 27:29)
Харанхуйн ангал (Мозая 27:29)	Бурханы гайхамшигт гэрлийг үзэх (Мозая 27:29)
Мөнхийн зовлонд тарчилж (Мозая 27:29)	Бодгаль цаашид дахин өвдөх нь үгүй (Мозая 27:29)
Олон нүглийн дурсамжиндаа тарчлагдаж (Алма 36:17)	Нүглүүдийнхээ санамжинд цаашид тарчлагдахгүй (Алма 36:19)
Хурц ба үлэмжийн шаналал (Алма 36:20–21)	Хурц ба үлэмжийн баяслыг мэдэрсэн (Алма 36:20–21)
Бурханы дэргэд байгаагаа бодоход бодгаль минь аймшигтайгаар тарчилж (Алма 36:14–15)	Бодгаль минь Бурханы дэргэд байхаар тэмүүлсэн (Алма 36:22)

- Алмаг зовлон шаналлаасаа ангижрахад юу хөтөлсөн бэ? (Алма 36:17–18.)
- Хөрвүүлэгдэх явдлын талаар Алмагийн туршлагыг бидний туршлагатай хэрхэн харьцуулж болох вэ? (Байж болох хариултын нэг болгон доорх ишлэлийг үз.)

Ахлагч Брүс Р.МакКонки: “Алма бол загвар болж үйлчилсэн. Түүнийг бүхэлд нь нөмөрсөн нүглийн айдсыг хаант улсын замаасаа гажсан гишүүн бүр мэдрэх ёстой; улмаар бидний Нифай найзтай тохиолдсон шиг наманчлал ирэх ёстой” гэжээ (*A New Witness for the Articles of Faith* [1985], 229).

4. Бага Алма болон Мозаягийн хөвгүүд өөрсдийгөө сайн мэдээг номлоход зориулдаг.

Мозая 27:32–28:20; Алма 36:24–өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Бага Алма болон Мозаягийн хөвгүүд хөрвүүлэгдсэнийхээ дараа юу хийсэн бэ? (Мозая 27:32–37-г үз.) Тэд үнэхээр хөрвүүлэгдсэн болохыг энэ нь хэрхэн харуулж байна вэ? Бидний сэтгэлээсээ болон гүн гүнзгий хөрвүүлэгдсэнийг үйлдлүүд маань хэрхэн харуулдаг вэ?
- Мозаягийн хөвгүүд болон тэдний нөхөд яагаад Лэмэнчүүдийн дунд сайн мэдээг номлохыг хүссэн бэ? (Мозая 28:1–3 ба доорх ишлэлийг үз.) Их Эзэн Мозая Хаанд хөвгүүдийнх нь номлол хийх чармайлтын талаар ямар амлалтуудыг өгсөн бэ? (Мозая 28:6–7-г үз.)

Ахлагч Л.Том Перри: “Хөрвүүлэлтийн дараа энэ нь үүрэг юм гэж бодсоны улмаас бус, хэдийгээр энэ нь пристийн зэрэгтний үүрэг хариуцлага байдаг ч, харин хүлээн авсан зүйлийнхээ төлөө чин сэтгэлийн хайр, талархлаас бусадтай хуваалцах хүсэл ирдэг юм. Ийм ‘агуу их үнэт сувд’ бидний амьдралд ирэхэд бид зөвхөн өөрсдөө үүнийгээ бишрэх нь хангалттай бус юм. Үүнийг хуваалцах ёстой!” гэсэн (in Conference Report, Apr. 1984, 106; or *Ensign*, May 1984, 79).

- Бид нэгэнт хөрвүүлэгдсэнийхээ дараа сайн мэдээг хуваалцах амлалтаа хэрхэн өсгөх вэ?

Дүгнэлт

Бид бүгд, хүн нэг бүр өөрсдийнхөө хөрвүүлэлтийг биеэрээ үзсэн байх ёстой. Энэ нь Алма ба Мозаягийн хөвгүүдийн үзсэн хөрвүүлэлтийг бодвол илүү нарийн ялгаатай ба аажим алгуур байж болох ч энэ нь ижил үр дүнд хүргэдэг.

Мозая 27:29-ийг унш. Бидний зүрх сэтгэл дахин “өвдөж шаналахгүйн” тулд бид наманчлал болон Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан өршөөлийг хүлээн авч чадна гэдгийг онцлон тэмдэглэ. Тэгээд бид бусдын амьдралыг адислахаар Их Эзэний гар дахь багаж хэрэгсэл болж чадна.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэ санааг хичээлдээ хэрэглэж болно.

“Тэд бялдууч үгсээрээ . . . олныг мэхэлж” (Мозая 26:6)

- Бага Алма болон Мозаягийн хөвгүүд бусад үл итгэгч нартай нийлж Сүмийн олон гишүүнийг хэрхэн нүгэл рүү хөтлөх боломжтой байсан бэ? (Мозая 26:6; 27:8–9-ийг үз.) Бялдууч үг нь биднийг хэрхэн хуурч буруу

тийш хөтөлж болох вэ? Бид яагаад бидэнд нөлөөлж болох хүмүүстэй болгоомжтой хандах ёстой вэ? (Доорх ишлэлийг үз.) Есүс Христэд итгэх итгэлийн суурь нь үл итгэгчдийн бялдууч үгсээс болгоомжлоход бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

Ахлагч Эзра Тафт Бэнсон: “Бид дэлхийд алдартай болохыг эрэлхийлэхдээ дэлхийд нэр хүндээ олсон хүмүүст хүндлэгдэхийг хүсдэг. Харин үүнд л аюул оршиж байдаг. Яагаад гэвэл ихэнхдээ тэдгээр алдрыг хүртэхийн тулд бид зарим нэг хүмүүсийн тэргүүлэн удирдах байр сууринд авчирсан тэрхүү хилэнцэт нөлөө болон бодлогын хүчнүүдэд нэгдэж дагах ёстой болдог. . . . Өнөөдөр бид дотроосоо дэлхий дэх нэртэй хүмүүсийн бялдууч үгэнд идэгдээд байна” гэсэн байдаг (in Conference Report, Oct. 1964, 57; or *Improvement Era*, Dec. 1964, 1067).

“Алма . . . Зөв Шударга Шүүлтүүдээр Шүүсэн Болой”

Хичээл
21

Мозая 29; Алма 1–4

Зорилго Ангийн гишүүдэд төр, засгийн газрын зөв шударга зарчмыг ойлгож, санваараар мэргэших явдал болон бардамналаас зайлсхийхэд нь туслах болно.

Бэлтгэл Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:

- Мозая 29. Мозая сайн засаглалын зарчмуудыг зааж, хүмүүстээ хаантай байхын аюулыг анхааруулдаг. Хүмүүс түүний зөвлөгөөг анхаарч Бага Алмагаар тэргүүлүүлсэн шүүгчдийг улс төрийнхөө удирдагчдаар сонгодог.
- Алма 1. Бага Алма тэргүүн шүүгч болон дээд пристээр үйлчилдэг. Тэрээр хүмүүсийн дундах санваараар мэргэших явдалтай тэмцдэг.
- Алма 2–3. Амлисай хаан болохыг эрэлхийлсэн боловч хүмүүс түүнийг эсэргүүцдэг. Тэр ба түүний дагалдагчид Лэмэнчүүдтэй нэгдэн духан дээрээ улаан тэмдэг тавин итгэгч Нифайчуудын эсрэг дайтдаг.
- Алма 4. Сүм дэвждэг боловч бардам болдог. Алма үйлчлэлдээ өөрийгөө зориулахаар шүүгчийнхээ суудлаас буув.

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Самбарт дараах үгсийг жагсааж бич: Эзэн хаант улс, Бүгд найрамдах улс, Ардчилал, Шашинт төр.

- Эдгээр үгс ямар утгатай вэ? (Ангийн гишүүдэд туслах шаардлагатай бол дараах тодорхойлолтуудыг ашигла.)

Эзэн хаант улс: Хаан гэх зөвхөн нэг хүн удирддаг.

Бүгд найрамдах улс: сонгуулийн төлөөлөгч болох бүлэг хүмүүс удирддаг.

Ардчилал: ард түмний олонх нь удирддаг засаг төр.

Шашинт төр: Бошиглогчид өгөгдөх илчлэлтээр дамжуулан Бурханаар удирдуулсан засаг төр.

- Нифайчууд Мозаягаар удирдуулахдаа ямар төрлийн засаглалтай байсан бэ?

Олон жилийн турш Мозая ард олноо удирдахаар Бурханаас илчлэлт хүлээн аван хаан ба бошиглогчоор үйлчилсэн. Мозая Хааны хаанчлалын дараа Бага Алма Нифайчуудын тэргүүн шүүгчээр томилогдсоноор засаглалын шинэ хэлбэр бий болж “шүүгчдийн ноёрхол” гэж нэрлэгдэх үе эхэлсэн юм.

Сударт хэлсэнчлэн, “Алма Их Эзэний замаар алхаж, мөн түүний зарлигуудыг дагасан, мөн зөв шударга шүүлтүүдээр тэр шүүсэн болой” (Мозая 29:43).

Энэ хичээл нь зөв шударга удирдлагатай байхын тулд шүүхийн систем нь хэрхэн зохион байгуулагдсан болохыг тайлбарлаж ард олны тэргүүн шүүгч болон ерөнхийлөн удирдах дээд пристийн хувьд нь Алмад тулгарсан зарим нэг бэрхшээлүүдийг дүрслэн харуулдаг.

Судрын Ярилцлага ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Мозая сайн засаглалын зарчмуудыг заадаг.

Мозая 29-ийг ярилц. Ангийн гишүүдийг сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь. Мозая Хааны бүх хөвгүүд түүний хаан ширээг залгамжлахаас татгалзсан тул Мозая ард түмнийхээ дунд түүнийг нас барсны дараа хаанчлалыг төр засгийн системээр солихыг зөвлөсөн тунхаглал илгээсэн гэдгийг тайлбарла.

- Мозая хаантай байх талаар ард түмэндээ ямар зөвлөгөө өгсөн бэ? (Мозая 29:13, 16-г үз.) Мозая ямар хоёр хүнийг өөр өөр хааны жишээ болгон дүрсэлж үзүүлсэн бэ? (Мозая 29:13, 18-ыг үз. Энэ хоёр хааны ард олонд үзүүлсэн нөлөөг та товч тоймлож болно.) Мозая гэм нүгэлтэй удирдагчтай байхын үр дагаврыг хэрхэн дүрсэлсэн бэ? (Мозая 29:16, 18, 21–23-ыг үз.)
- Мозая ард түмэндээ хаанчлалыг төр, засгийн газрын системээр солихыг зөвлөсөн. Эдгээр шүүхүүдийг Мозая ямар шинж чанар агуулах ёстой гэж хэлсэн бэ? (Мозая 29:11 ба С ба Г 98:10-ыг үз.) Эдгээр чанар нь өнөөгийн удирдагчдад яагаад чухал вэ?
- Хүмүүсийн шүүгдэх хуулийн үндэс нь юу байсан бэ? (Мозая 29:11, мөн Мозая 29:12–14-ийг үз.) Зөв шударга зарчмууд дээр үндэслэсэн хулиудаар амьдарвал хүмүүс ямар адислалуудыг хүртэх вэ?
- Гэм нүгэлтэй хувь хүмүүс болон бүлэг этгээдүүдийн нөлөөнд орохгүйн тулд Мозая эрх мэдлийг хязгаарлах ямар санал гаргасан бэ? (Мозая 29:24–26, 28–29-ийг үз. Тэрээр хүмүүсийн саналаар бүх зүйлийг хийх, ард олноор шүүгчдийг томилуулан ард олных нь өмнө хариуцлага хүлээлгэх, хуулийн дагуу шүүгээгүй шүүгчдийн эсрэг давж заалдах системтэй байхыг санал болгосон.)
- Хүмүүсийн олонх нь ёсон бусыг сонговол юу болно гэж Мозая хэлсэн бэ? (Мозая 29:27-г үз.) Бидэнд бусдад ойлгуулж зөв шударгыг сонгоход нь туслах ямар арга зам байдаг вэ?

2. Бага Алма тэргүүн шүүгчээр үйлчилж, санваараар мэргэших явдалтай тэмцдэг.

Алма 1-ээс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Ард олон Мозаягийн зөвлөгөөг даган улс даяар Бага Алмагаар тэргүүлүүлсэн шүүгчдийг томилсон хэмээн тайлбарла.

- Шүүгчдийн засаглалын эхний жилд Алмагийн өмнө нэгэн Нихор гэдэг хүнийг шүүлгэхээр авчирчээ (Алма 1:1–2, 15). Нихор хүмүүст юу зааж байсан бэ? (Алма 1:3–4.) Түүний сургаал ямар нөлөө үзүүлсэн бэ? (Алма

1:5–6-г үз.) Нихорын сургаалууд яагаад тийм олон хүмүүсийн анхаарлыг татсан гэж та нар бодож байна вэ? Өнөө үед та нар үүнтэй адил сургаалуудын алийг нь сонссон бэ?

- Нихор хүмүүст номлож байхдаа багшаар үйлчилж байсан Гидеон хэмээх нэгэн Сүмийн гишүүнтэй тааралджээ (Алма 1:7–8; та ангийн гишүүдэд Гидеоныг Лимхай Хааны үнэнч хурандаа байсан хэмээн сануулж болно.) Гидеон Нихорын хуурамч номлолд хэрхэн хандсан бэ? (Алма 1:7-г үз.) Бурханы үгийг мэдэж гэрчлэх нь бидэнд хуурамч номлолын эсрэг зогсоход хэрхэн тусалдаг вэ?
- Нихор Гидеонд уурлаж түүнийг жадлав (Алма 1:9). Хүмүүс Нихорыг Алмагийн өмнө авчрахад Алма түүнийг ямар хоёр гэмт хэрэгт буруутай гэж үзсэн бэ? (Алма 1:10–13-ыг үз. Санваараар мэргэших ба аллага хийсэн.) Санваараар мэргэших гэж юу вэ? (Алма 1:16 ба 2 Нифай 26:29-ийг үз.) Санваараар мэргэших явдлын талаар Алма ямар анхааруулга өгсөн бэ? (Алма 1:12-ыг үз.) Та нар өнөө үед санваараар мэргэших явдлын ямар нотолгоог харсан бэ?
- Хэдийгээр Нихорыг гэмт хэргийнх нь төлөө ялласан ч гэсэн санваараар мэргэших явдал болон бусад ёсон бус явдал дэлхий даяар түгсээр л байсан (Алма 1:15–16). Сүмд харьяалагддаг болон харьяалагддаггүй хүмүүсийн хооронд юу болж эхэлсэн бэ? (Алма 1:19–22-ыг үз.) Бидний итгэл шүтлэгийг хүлээн зөвшөөрдөггүй хүмүүстэй бид хэрхэн харьцах ёстой вэ? (С ба Г 38:41-ийг үз.)
- Энэ зөрчил нь зарим Сүмийн гишүүдэд хэрхэн нөлөөлсөн бэ? (Алма 1:23–24-ийг үз.) Бурханы Сүмд үлдсэн хүмүүсээс бид юу сурч болох вэ? (Алма 1:25-ыг үз.) Бид Бурханы зарлигуудыг сахихдаа хэрхэн “гуйвшгүй мөн хөдөлшгүй” байж чадах вэ?

Алма 1:26–30-д Сүмийн хүмүүсийн дундах энх амгалан болон хөгжил дэвшлийг харуулдаг. Та эдгээр шүлгүүдийг чангаар уншаад дараах асуултуудын заримыг ярилцаж болно.

- Пристүүд зааж буй хүмүүстээ хэрхэн хандаж байсан бэ? (Алма 1:26-г үз.) Бусдад заахдаа ингэж хандах нь яагаад чухал вэ? Та нар төлөв даруу байдалтайгаар зааж байсан багш нараар хэрхэн адислагдаж байсан бэ?
- Алма гачигдалтай хүмүүст хандах Сүмийн гишүүдийн хандлагыг хэрхэн дүрсэлсэн бэ? (Алма 1:27-г үз.) Тэдгээрээс үлгэр дууриал авах нь бидэнд амар амгаланг хэрхэн авчрах вэ?

3. Амлисай хаан болохыг эрэлхийлсэн боловч хүмүүс түүнийг эсэргүүцдэг.

Алма 2–3-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Шүүгчдийн засаглалын тав дахь жилд зальжин эр Амлисай гэгч түүнийг газар нутагтаа хаанаа болгох гэсэн олон дагалдагчдынхаа хамтаар гарч ирэв (Алма 2:1–2). Амлисай хаан болохыг яагаад хүссэн бэ? (Алма 2:4-ийг үз.) Хүмүүсийн дийлэнх нь түүний эсрэг саналаа өгөхөд тэр яасан бэ? (Алма 2:7–10-ыг үз.)
- Нифайчууд болон Амлисайчуудын хооронд болсон анхны тулалдааны үр дүн нь юу байсан бэ? (Алма 2:16–19-ийг үз.) Алма үлдсэн Амлисайчуудын

араас тагнуулууд явуулахад тагнуулууд нь юу харсан бэ? (Алма 2:23–25-ыг үз.) Хэдий Нифайчууд цөөхөн байсан ч Амписайчууд болон Лэмэнчүүдийн хамтарсан армийг яаж бут цохиж чадсан бэ? (Алма 2:27–28-ыг үз.)

- Амписайчууд Нифайчуудаас ялгагдахын тулд юу хийсэн бэ? (Алма 3:4, 13-ыг үз.) Эдгээр тэмдгүүд нь бошиглолын биелэл хэрхэн болж байна вэ? (Алма 3:14–19-ийг үз.) Бидний хувьд “тэд өөрсдийнхөө дээр зүхлийг авчирсныг ойлгох” нь яагаад чухал вэ? (Алма 3:19).

4. Сүм дэвждэг боловч бардам болдог. Алма үйлчлэлдээ өөрийгөө зориулахаар шүүгчийнхээ суудлаас буув.

Алма 4-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Хэдийгээр Нифайчууд Амписайчууд болон Лэмэнчүүдийг тулалдаанд ялсан ч гэсэн амьд үлдэгсдийн мал хорогдон, тариа будааны гарз учирч зовлон үзжээ (Алма 4:1–2). Эдгээр зовлон зүдгүүрийн зарим үр дагавар нь юу байсан бэ? (Алма 4:3–5-ыг үз.) Бидний зовлон зүдгүүр бидэнд үүргийг маань хэрхэн сануулах вэ?
- Сүмийн гишүүдэд агуу их зөв шударга байдлаас бардамнал, ертөнцийн зүйлс рүү эргэн ороход хэр их хугацаа гарсан бэ? (Алма 4:5–6-г үз. Нэг жил.) Та нар яагаад дэвжиж буй хүмүүст бардамнал болон эд зүйлсээс зайлсхийхэд илүү хэцүү байдаг гэж бодож байна вэ? Эдгээр нүглээс бид хэрхэн зайлсхийх вэ?
- Бардамнал нь Сүмийн хүмүүсийн бусдад болон өөр хоорондоо, мөн Сүмээс гаднах хүмүүст хандах хандлагад хэрхэн нөлөөлдөг вэ? (Алма 4:8–12-ыг үз.) Энэ нь гишүүн бус хүмүүсийн Сүмийг үзэх үзэлд хэрхэн нөлөөлсөн бэ? (Алма 4:10-ыг үз.) Сүмийн гишүүдийн жишээ Сүмийн номлолын ажилд яагаад чухал вэ? Сүмийн гишүүдийн жишээ хүмүүст сайнаар нөлөөлөхийг та нар хэзээ харсан бэ?
- Хүмүүсийн бардамнал, алдас өсөн нэмэгдэхэд Алма юу хийсэн бэ? (Алма 4:15–18-ыг үз.) Тэр яагаад үүнийг хийсэн бэ? (Алма 4:19-ийг үз.) Бурханы үгийг номлох нь хэрхэн “тэдэнд үүргийг нь сануулахаар өдөөдөг” вэ? Бурханы үгийг номлох нь бардамнал, башир арга, тэмцлүүдийг хэрхэн “намжааж” чадах вэ?
- “Шударга гэрчлэлийг үзүүлэх” гэсэн хэллэг нь Алмагийн заах хүчийг хэрхэн харуулсан бэ? (Алма 4:19). Бусдын сайн мэдээний шударга гэрчлэлийг сонссоноор та нарын амьдрал хэрхэн өөрчлөгдсөн бэ? Сайн мэдээг номлож түүгээр амьдарснаар өнөөгийн дэлхий дээрх ямар асуудлууд шийдэгдэж болох вэ?

Дүгнэлт

Алмад тулгарсан бэрхшээлүүд өнөөдөр бидэнд тулгарч буй бэрхшээлүүдтэй төстэй байгаа ба эдгээр асуудлуудын шийдэл нь мөн хэрхэн төстэй байгаа талаар ангийн гишүүдийг эргэцүүлэн бодохыг урь.

Ирэх долоо хоногт ангийн гишүүд Алма ард олны дээд пристийн хувьд тулгарсан бусад бэрхшээлүүдэд хэрхэн хариулсныг сурах болно хэмээн хэл. Тулгарсан нөхцөл тус бүрийг шийдэхийн тулд Алма Бурханы үгийг хэрхэн номлосныг судлахад ангийн гишүүдийг уриалан дэмж.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

“Та Нар Түүний Дүрслэлийг Өөрсдийн Царай Төрхөндөө Хүлээж Авсан уу?”

Алма 5–7

Зорилго Ангийн гишүүдэд зүрх сэтгэлийн өөрчлөлтийг мэдрэх, мөн хөрвүүлэлтийн үйл явцын үргэлжлэл гэж юу болохыг ойлгоход туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Алма 5. Зүрх сэтгэлийн “хүчит өөрчлөлтийг” мэдрэхээр бэлтгэгдсэн байх замаар амьдрахыг Алма Зарахэмла дахь Сүмийн гишүүдэд ухуулан ятгадаг.
 - б. Алма 6. Зарахэмла дахь олон хүмүүс өөрсдийгөө даруусган нүглээ наманчилдаг. Алма болон хүмүүс Зарахэмлад Сүмийн жаягийг байгуулж эхэлдэг.
 - в. Алма 7. Гидеоны аманд Алма Есүс Христийг гэрчилдэг. Тэрээр хүмүүсийг Аврагчийг үргэлжлүүлэн дагахыг уриалан дэмждэг.

Хичээлийг Баяжуулах Зөвлөмж

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Самбар дээр хоёр том зүрх зур. Зүрх нь ихэнхдээ бидний хүсэл, хайрын бэлэгдэл болон хэрэглэгддэг гэж тайлбарла. Нэг зүрхнийх нь дээд талд *Бардам* гэж бич.

- Бардам хүмүүс зүрх сэтгэлээ юун дээр суурилуулдаг вэ? (Ангийн хоёр гишүүнээр Алма 4:8, Алма 5:53-ыг чангаар уншуул.) “Дэлхийн хий хоосон зүйлүүдийн” ямар жишээнүүд бий вэ? (*Бардам* гэж бичсэн зүрхний дотор талд ангийн гишүүдийн хариултыг бич.)

Хоёр дахь зүрхний дээд талд нь *Даруу* гэж бич.

- Даруу хүмүүс юу хүсдэг вэ? (*Даруу* гэж бичсэн зүрхний дотор талд нь ангийн гишүүдийн хариултуудыг бич.)

Бид өөрсдийгөө Бурханы өмнө даруусгахад “Бурханаас төрж” зүрх сэтгэлийн “хүчит өөрчлөлтийг” мэдрэхэд бэлтгэгддэг (Алма 5:14). Энэ хичээлд Их Эзэн бидний зүрх сэтгэлийг өөрчилж болох нөхцөлүүдийг заадаг.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь

өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Алма хүмүүст зүрх сэтгэлийн “хүчит өөрчлөлтийг” хэрхэн мэдэрч болохыг заасан.

Алма 5-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Ангийн гишүүдэд Алмаг ард түмний төр засгийн тэргүүн шүүгч байсан гэдгийг сануул. Тэргүүн шүүгчийн хувьд тэр газар нутгийн хуулийг мөрдүүлэх эрх мэдэлтэй байсан. Тэр мөн Сүмийг ерөнхийлөн удирдах дээд прист байсан. Дээд пристийн хувьд тэр Бурханы үгийг номлох үүрэгтэй байсан. Тэр Сүмийн гишүүдийн ёсон бус байдлыг хараад тэргүүн шүүгчээсээ татгалзан “өөрийгөө тэр чигээр нь . . . дээд пристийн зэрэгт . . . үгийн гэрчлэлд зориулав” (Алма 4:11–20). Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон, тэргүүн шүүгчээр үйлчилснээс Есүс Христийн сайн мэдээг номлох нь Алмад яагаад чухал болсныг заасан:

“Их Эзэн дотор талаас нь гадагш ажилладаг. Дэлхий гаднаас нь дотогш ажилладаг. . . . Дэлхий орчныг өөрчлөн хүнийг хэлбэршүүлдэг. Христ бол хүнийг өөрчилж тэр нь дараа нь орчноо өөрчилдөг. Дэлхий хүний зан чанарыг хэлбэршүүлдэг, харин Христ хүний мөн чанарыг өөрчилж чадна” (in Conference Report, Oct. 1985, 5; or *Ensign*, Nov. 1985, 6).

- Үг хэлэхийнхээ өмнө Алма бие болон сүнсний боолчлолоос ангижирсан өмнөх үеийнхний тухай ярив (Алма 5:3–9). Хүмүүс эцгүүдийнхээ олзлогдол болон чөлөөлөлтийг мэдэж байх нь яагаад чухал гэж та нар бодож байна вэ? (Та ангийн гишүүдээр энэ асуултыг ярилцуулан Алма 5:5–7-г уншуулж болно.) Алма, Их Эзэн эцгүүдийнх нь “зүрх сэтгэлийг өөрчилсний” дараа тэднийг хэрхэн дүрсэлсэн бэ? (Алма 5:7–9-ийг үз.)
- Ангийн гишүүдээр Алма 5:10 дээрх гурван асуултыг уншуул. Эдгээр асуултын хариу нь юу вэ? (Алма 5:11–13-ыг үз.) Ямар захиас Алмагийн эцгийн зүрх сэтгэлийг “хүчтэй өөрчлөгдөхөд” хөтөлсөн бэ? (Мозая 16:13–15-ыг үз.) Хөгшин Алмаг сайн мэдээг заахад түүнд итгэгчдэд юу тохилдсон бэ? (Алма 5:13-ыг үз; мөн Мозая 18:1–11-ийг үз.) Бусдын Аврагчийн тухай гэрчлэлүүд бидэнд зүрх сэтгэлийн өөрчлөлтийг мэдрэхэд хэрхэн тусалж чадах вэ?
- Зарахэмлагийн хүмүүст ярьсан ярианыхаа туршид Алма зүрх сэтгэлийн “хүчтэй өөрчлөлтийг” мэдрэх тухай болон “Бурханаас төрөх” тухай ярьсан (Алма 5:14). Бид энэхүү мэдрэмжийн тухай ярихдаа ихэнхдээ *хөрвүүлэлт* гэсэн үгийг хэрэглэдэг. Хөрвүүлэгдэнэ гэдэг нь юу гэсэн үг вэ? (Мозая 5:2; 27:24–26-г үз.) Хөрвүүлэлт нь нэг л удаа болчихдог зүйл эсвэл үйл явц уу?

Ахлагч Брүс Р.МакКонки ингэж заасан: “Алмагийнх шиг ер бусын нөхцөлүүдийг эс тооцвол сүнслэг дахин төрөлт нь үйл явц юм. Энэ нь агшин зуур болдоггүй. Энэ нь бага багаар болдог. Наманчлагч хүн Христээр бүхэлдээ амьд болгогдож түүний дэргэд үүрд амьдрахаар тэнцтэлээ сүнслэг нэг бодит байдлаас нөгөөд нь мэдрэмтгий болдог” (*Doctrinal New Testament Commentary*, 3 vols. [1966–73], 3:401).

Та энэхүү ярилцлагынхаа нэгэн хэсэг болгон Алма 5:45–46-г ангийнхантайгаа уншиж болно. Гайхамшигт хөрвүүлэлтийг мэдрэсэн Алма хүртэл “эдгээр зүйлүүдийг мэдэж болохын тул олон хоног мацаг барьж мөн залбирсан” гэдгийг анхааруул.

Алма Зарахэмла дахь хүмүүст номлож байхдаа тэдэнд маш олон асуулт тавьсан гэж тайлбарла. Бид хөрвүүлэлтийнхээ үйл явцыг үргэлжлүүлж байхдаа өөрсдийгөө шалгахгаар эдгээр асуултыг хэрэглэж болно. Ангийн гишүүдээр ээлжлүүлэн Алма 5:14–21, 26–31-р шүлгүүдийг уншуул. Эдгээр шүлгүүдээс ялангуяа тэдний хувьд утга учиртай гэсэн асуултуудыг ярилцахыг урь. Оролцохыг нь урамшуулахын тулд та дараах ярилцлагын асуултуудыг ашиглаж болох ба ангийнхныг хөрвүүлэлтийнхээ үйл явцыг хэрхэн үргэлжлүүлэх талаар эргэцүүлэн бодоход нь тусал.

- Алма “Бурханы төрхийг өөрсдийн зүс царайндаа шингээх” тухай ярьсан (Алма 5:19). Зүс царай гэсэн үг нь хүний зан байдалд хамаатай буюу хүн өөрийнхөө зан чанарыг нүүрээрээ илэрхийлэх байдлыг хэлж байгаа юм. Ангийн гишүүдийг Алмагийн “Бурханы төрхийг өөрсдийн зүс царайндаа шингээгээд өөд харж чадах уу?” гэсэн асуултанд тэд хэрхэн хариулахаа чимээгүй эргэцүүлэн бодохыг урь.
- Өөрсдийгөө Их Эзэнд шүүгдэх гэж байгаагаар төсөөлөх нь бидэнд яагаад тустай вэ? (Алма 5:15–19-ийг үз.)
- Алма, “Хэрэв та нар зүрх сэтгэлийн өөрчлөлтийг мэдэрсэн бол, мөн хэрэв та нар гэтэлгэх хайрын дууг дуулмаар санагдаж байсан бол . . . та нар одоо тийн мэдэрч чадна уу?” гэж асуужээ (Алма 5:26). Ангийнхныг энэ асуултанд тэд хэрхэн хариулахаа чимээгүй бодохыг урь. Хүнд гэтэлгэх хайрын дууг дуулмаар санагдах үед үүнийг нь болиулах шалтгаан юу болох вэ? Бид хөрвүүлэлтийнхээ үйл явцыг үргэлжлүүлэхийн тулд юу хийж болох вэ?
- Бид өөрсдийгөө хэрхэн “Бурханы өмнө буруугүй” байлгаж чадах вэ? (Алма 5:27, 50–51-ийг үз.)
- Бардамнал болон атаархал нь биднийг Бурханыг угтахад хэрхэн бэлтгэлгүй болгох вэ? (Алма 5:28–29-ийг үз.) 30, 31-р шүлгүүдэд тэмдэглэсэнчлэн бусдаар доог хийж, хавчвал бид яагаад Бурханыг угтахад бэлтгэлгүй байх вэ?
- Алма эдгээр асуултыг тавьсныхаа дараа хүмүүсийг нүглээ наманчлахыг уриалсан (Алма 5:31–32). Тэгээд тэр Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан тэднийг өршөөгдөх болно гэж батлан хэлсэн (Алма 5:33–35). Аврагч биднийг юу гэж урьдаг вэ? (Алма 5:33–35-ыг үз.) Энэхүү урилга бидэнд хэрхэн найдвар өгч байна вэ?
- Зарахэмла дахь зөв шударга бус хүмүүст Алма, “Уг хоньчин та нарын араас дуудаж байсан мөн та нарын араас дуудсаар л буй, гэвч та нар түүний дуу хоолойг сонсохгүй болой!” (Алма 5:37). Алмагийн хэлж буй хоньчин нь хэн бэ? (Алма 5:38-ыг үз.) Аврагч биднийг хэрхэн дууддаг вэ? Түүний дуу хоолойг сонсохын тулд бид юу хийж болох вэ?
- Бошиглогчийн дуудах тухай бид Алма 5:43–49-өөс юу сурч болох вэ?
- Алма хүмүүст ёсон бус байдалдаа үлдэх эсвэл үүнийгээ үргэлжлүүлэх ёсгүй хэмээн анхааруулсан (Алма 5:53–56; Алма “зөрж үлдсээр байх уу?” гэсэн асуултыг дөрвөн удаа тавьсныг анхааруул.) Яагаад нүглээ орхих нь наманчлалын шаардлагатай хэсэг болдог вэ? (Алма 5:56; Мозая 16:5; С ба Г 58:42–43-ыг үз.)

- Алма хүмүүстээ, “Ёсон бусыг үйлдэгчдийн дундаас гарч ирцгээ, мөн та нар тусдаа байгтун” гэж зарлигласан (Алма 5:57). Бид дэлхийд байхдаа ёсон бус байдлаас өөрсдийгөө хэрхэн тусгаарлаж чадах вэ?

2. Алма болон хүмүүс Зарахэмлад Сүмийн жаягийг байгуулж эхэлдэг.

Алма 6-гаас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Алмагийн сургаалын дараа олон хүмүүс нүглээ наманчилж Бурханы өмнө өөрсдийгөө даруусгав (Алма 6:1–2). Бусад нь яагаад нүглээ наманчлахыг хүсээгүй вэ? (Алма 6:3-ыг үз. Тэд “зүрх сэтгэл дэх бардамналдаа хөөрсөн” байлаа.) Бардамнал нь хүмүүсийг яагаад наманчлуулдаггүй вэ? Бид зүрх сэтгэл дэх бардамналыг яаж давах вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон, “Бардамналыг дарагч зүйл нь төлөв түвшин байдал болох хүлцэнгүй, дуулгавартай байдал юм (Алма 7:23-ыг үз). . . . Бүгдээрээ даруу байхыг сонгоё. Бид ах, эгс, дүүстээ эрүүл бус ханддагаа больж, тэднийг өөрсдийнхөө адил үзэж, тэднийг өөрсдийнхөө хэмжээнд, аль эсвэл түүнээс ч дээгүүрт тавьж даруу байхыг сонгож чадна. . . . Бид зөвлөмж, зэмлэл хүлээн авснаараа өөрсдийгөө даруусгахыг сонгож чадна. . . . Бид гомдоогчдоо уучилснаараа өөрсдийгөө даруусгахыг сонгож чадна. . . . Бид сэтгэл харамгүй үйлчлэл үзүүлснээрээ өөрсдийгөө даруусгахыг сонгож чадна. . . . Бид номлолд явж бусдыг даруусгах үгийг номлосноороо өөрсдийгөө даруусгахыг сонгож чадна. . . . Бид ариун сүмд ойр ойрхон очсоноороо өөрсдийгөө даруусгахыг сонгож чадна. . . . Бид нүглээ хүлээн зөвшөөрч, нүглээ орхин, Бурханаас төрөн өөрсдийгөө даруусгахыг сонгож чадна. . . . Бид Бурханыг хайрлан, Түүний хүслийг өөрсдийнхөөс дээгүүр тавьж, Түүнийг амьдралдаа эхэнд нь тавьснаар өөрсдийгөө даруусгахыг сонгож чадна” гэж хэлсэн (in Conference Report, Apr. 1989, 6; or *Ensign*, May 1989, 6–7).

- Алма болон Зарахэмла дахь хүмүүс прист, ахлагч нарыг томилж, шинэ хөрвүүлэгдэгчдийг усаар батлан, мацаг болон залбиралдаа тогтмол цугларан “сүмийн жаягийг байгуулж эхэлсэн” (Алма 6:1–6). Ийм Сүмийн жаяг нь бидэнд хөрвүүлэлтийнхээ үйл явцыг үргэлжлүүлэхэд хэрхэн тусалж чадах вэ?

3. Алма Есүс Христийг гэрчилдэг. Тэрээр Гидеон дахь хүмүүсийг Аврагчийг дагахыг уриалан дэмждэг.

Алма 7-гоос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Алма Зарахэмлад сургаал айлтгасныхаа дараа Гидеоны аман дахь хүмүүст номлохоор явсан (Алма 6:8).

- Гидеон дахь хүмүүст “маш олон зүйл” тохиолдох боловч хамгийн агуу их ач холбогдолтой нь Есүс Христийн ирэлт гэжээ (Алма 7:7). Алма дэлхий дээрх Аврагчийн үүргийн тухай юу заасан бэ? (Алма 7:10–13-ыг үз.) Аврагч яагаад өөртөө бидний өвдөлт, шаналал, өвчин болон нүглүүдийг авсан бэ? (Алма 7:11–14-ийг үз. Та тохиромжтой гэж бодож байгаа бол ангийн гишүүдээр тэдний хэрэгцээ, бэрхшээл, уйтгар гунигийг ойлгож нүглүүдийг авч хаях Аврагчийн хүч чадлын талаарх сэтгэгдлийг нь хуваалцуул.)
- Алмагийн Гидеон дахь хүмүүст хийсэн захиас нь Зарахэмлад хийсэн захиасаас нь юугаараа ялгаатай вэ? Захиасууд юугаараа ижил вэ? Алма

Гидеон дахь хүмүүст номлохдоо тэднийг зөв шударга амьдрахыг чармайж байсан ч яагаад наманчлалыг номлож байсан бэ? (Алма 7:9, 14–16, 22, 26-г үз.)

Дүгнэлт

Ангийн нэг гишүүнээр Алма 7:23–25-ыг уншуул. Эдгээр шүлгүүдэд Алмагийн ярьсан зүрх сэтгэлийн өөрчлөлтийг үзэж “гэтэлгэх хайрын дууг дуулсаар” байгаа нэгэн хүний тухай үзүүлдэг (Алма 5:26). Бид хөрвүүлэлтийнхээ үйл явцыг үргэлжлүүлэх явцдаа “тэнгэрийн хаант улсад ахин гарахгүйгээр хамт суух” тэрхүү өдөрт найдах боломжтой болно (Алма 5:25).

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Зорилго

Ангийн гишүүдийн гэтэлгэлийн төлөвлөгөө болон сайн мэдээний үнэнийг гэрчлэхэд нэгээс илүү гэрчлэлтэй байхын хүчийг ойлгох ойлголтыг нь нэмэгдүүлнэ.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Алма 8–9. Алма Мелект номлож, Аммонайхагийн хүмүүсийг наманчлахаар дуудсан боловч тэд түүнийг эсэргүүцдэг. Тэрээр явдаг боловч тэнгэрийн элч түүнд буцахыг тушаадаг. Алмаг Амюлек хүлээн авч тэд хоёулаа Аммонайхад номлох зарлиг хүлээн авдаг.
 - б. Алма 10. Амюлек Аммонайха дахь хүмүүст номлож өөрийнхөө хөрвүүлэлтийг ярьдаг. Алмагийн номлолд өөр нэгэн гэрчлэл байхыг мэдээд гайхан биширдэг. Амюлек зөв шударга бус хуульчид болон шүүгчидтэй маргалддаг.
 - в. Алма 11. Амюлек Зиезромтой маргалдаж Христийн ирэлт, нүгэлтнүүдийн шүүлт, гэтэлгэлийн төлөвлөгөөг гэрчилдэг.
 - г. Алма 12. Алма цааш нь Амюлекийн үгийг тайлбарлаж хатуу зүрх сэтгэл, ёсон бусыг анхааруулж, Уналт болон гэтэлгэлийн төлөвлөгөөг гэрчилдэг.
2. Ангийн нэг гишүүнээс Алма, Амюлек хоёрын хэрхэн уулзсан тухай түүхийг дүгнэн ярихад бэлтгэхийг хүс (Алма 8:19–32).
3. Ангийн хоёр гишүүнээс Алма 11:21–40 дэх харилцан ярианы Амюлекийн үгийг нэг нь , нөгөө нь Зиезромын үгийг уншихаар бэлтгэхийг хүс.
4. Та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглэж байгаа бол ангидаа хайрцаг эсвэл цүнхтэй юм авчир. Ангийн гишүүдийг танд байна гэж бодохооргүй буюу итгэхээргүй ямар нэгэн ер бусын зүйл авчир. Хайрцаг буюу цүнхтэй зүйл ангийн гишүүдэд харагдахааргүй байх ёстойг анхаар.

Хичээлийг

Баяжуулах

Зөвлөмж

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Хайрцаг буюу цүнхтэй зүйлийг гаргаж тавь (“Бэлтгэл”-ийн 4-ийг үз). Ангийн гишүүдэд хайрцган доторх зүйлийг хэл, гэхдээ түүнийгээ битгий үзүүл. Тэднээс энэ нь үнэхээр хайрцганд байгаад тэд итгэж байгаа эсэхийг асуу.

Ангийн гишүүдээр хариулуулаад дараа нь нэгийг нь урьж хайрцган доторхийг харуул. Тэгээд түүнээс ангийн бусад гишүүддээ хайрцган дотор юу байгааг хэлэхийг хүс. Дараа нь ангийн гишүүдээс хайрцганд үүнийг байгаад итгэж байгаа эсэхийг нь дахин асуу.

- Яагаад хэн нэгэн нь хайрцган доторхийг харсны дараа тухайн зүйл тэнд байсанд итгэхэд илүү хялбар байсан бэ?

Алмаг Аммонайхагийн хүмүүст наманчлалын тухай номлосны дараа Амюлек түүнтэй нэгдсэн. Энэ хичээл Алмагийн сургаал Амюлекийн гэрчлэлээр хэрхэн хүчирхэгжсэн тухай заадаг.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Алма Аммонайхагийн хүмүүсийг наманчил гэж уриалсан боловч тэд түүнийг эсэргүүцдэг.

Алма 8–9-ийг ярилц. Ангийн гишүүдээр сонгосон шүлгүүдийг чангаар уншуул. Алма шүүгчийнхээ суудлыг Нифайхад дамжуулан өгөөд номлолынхоо аяныг эхэлсэн гэдгийг ангийн гишүүдэд сануул. Үүнд хилэнцэт хот Аммонайха руу аялсан нь орсон.

- Алма Гидеон болон Мелек дэх хүмүүсийн дунд Сүмийн жаягийг байгуулсныхаа дараа Аммонайхагийн нутагт номлохоор явсан. Тэр тэнд ямар бэрхшээлтэй тулгарсан бэ? (Алма 8:8–9-ийг үз.) Алма 8:10-т Алмагийн ямар үгс нь Аммонайха дахь түүний чармайлтын идэвхийг дүрсэлж байна вэ? Аммонайха дахь хүмүүс Алмагийн номлолыг хэрхэн хүлээн авсан бэ? (Алма 8:11–13-ыг үз.)
- Алма Аммонайхаг орхин Аароны хот руу явахад юу тохиолдсон бэ? (Алма 8:14–17-г үз.) Тэнгэр элчийн хэлсэнчлэн Алмад баясах ямар шалтгаан байсан бэ? (Алма 8:15-ыг үз.) Алма тэнгэр элчийн зааварчилгааг хэрхэн хүлээн авсан бэ? (Алма 8:18-ыг үз.) Түүний хариултаас бид юу сурч чадах вэ?

Урьдчилан даалгасан ангийн нэг гишүүнээр Алма, Амюлек хоёрын уулзсан тухай товч яриул (Алма 8:19–32). Хэрэв та ангийн нэг гишүүнд ярихыг даалгаагүй бол өөрөө ярь.

- Их Эзэн Амюлекийг Алматай хамт номлоход хэрхэн бэлтгэсэн бэ? (Алма 8:20, 27; 10:7–11-ийг үз.) Их Эзэний ажлыг хийхэд хувь хүмүүс бэлтгэгддэг ямар арга замууд байдаг вэ?
- Аммонайхагийн хүмүүс Алмагийн анхааруулгыг яагаад эсэргүүцсээр байсан бэ? (Алма 9:5-ыг үз.) Түүний захиасыг эсэргүүцэх ямар шалтгаануудыг тэд хэрэглэсэн бэ? (Алма 9:2, 6-г үз.)
- Аммонайхагийн бусармаг хүмүүс эцэг өвгөдийнхөө зөв шударга ёс заншил, Бурханы зарлигууд, Их Эзэн эцэг өвгөдийг нь чөлөөлснийг мартсан гэж Алма хэлсэн (Алма 9:8–11-ийг үз.) Тэдний ийн мартсан явдал тэднийг ёсон бус явдал руу хэрхэн хөтөлсөн бэ? Хүмүүс, тэдний болон бусдын төлөө Их Эзэний хийснийг мартаж ямар шалтгаанууд байсан бэ? Та нар Их Эзэний та нарт өгсөн адислалуудыг санаж байх ямар үр дүнтэй арга замуудыг олсон бэ?
- Аммонайхагийн бусармаг Нифайчууд наманчлахгүй байх юм бол тэднийг бодвол Лэмэнчүүдийн хувьд шүүлтийн өдөр нь “илүү тэвчиж болмоор

байх болно” гэж Алма анхааруулсан (Алма 9:15). Яагаад ийм болох вэ? (Алма 9:14–24-ийг үз; мөн Лук 12:47–48; С ба Г 82:3-ыг үз.) Их Эзэн илүү их гэрэл хүлээн авсан хүмүүсээс юу шаарддаг вэ?

- Алма “Лэмэнчүүдэд зориулагдсан олон амлалтуудын” талаар юу заасан бэ? (Алма 9:16–17). Өнөөдөр эдгээр амлалтууд хэрхэн биелэгдсэн бэ?

2. Амюлек Аммонайха дахь хүмүүст номлодог.

Алма 10-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Алмаг хүмүүст яриа өгсний дараа Амюлек босож тэдэнд номлож эхэлсэн. Амюлек Лихайн үр удам байсан бөгөөд ард олныхоо дунд баян “нэр хүндээр багагүй хүн” байжээ (Алма 10:2–4).

- Амюлек “олон удаа дуудагдсан” боловч “сонсохоос татгалзсан,” тэд “эдгээр зүйлүүдийн талаар мэдэж байсан боловч мэдэхийг хүссэнгүй” гэж хэлсэн (Алма 10:6). Их Эзэн биднийг дууддаг ямар арга замууд байдаг вэ? Яагаад бид заримдаа Түүнд хариу хандахдаа удаан байдаг вэ? Бид яаж Түүнийг илүү нааштай хүлээн авах чадвартай байх вэ?
- Амюлек хэзээ бүрэн гүйцэт хөрвүүлэгдсэн бэ? (Алма 10:7–11-ийг үз; та ангийн нэг гишүүнээр эдгээр таван шүлгийг бүгдийг нь уншуулж болно.)
- Ямар зорилгоор шүүгчид Амюлекийг шалгаасан бэ? (Алма 10:13–16, 31–32-ыг үз.) Тэд яагаад түүний эсрэг башир арга хэрэглэж чадахгүй байсан бэ? (Алма 10:17-г үз.)
- Амюлек шүүгчдийг буруушааж тэд ард олноо сүйрүүлэх үндсийг тавьж байна хэмээн анхааруулан хэлсэн (Алма 10:17–21, 27). Тэд энэ үндсийг хэрхэн тавьж байсан бэ? Тэднийг сүйрэхээс юу хамгаалж байсан бэ? (Алма 10:22–23-ыг үз.) Зөв шударга хүмүүсийн залбирлууд өнөөдөр ёсон бус байдлын нөлөөг хэрхэн үгүйсгэдэг гэж та нар бодож байна вэ?
- Хүмүүс Амюлекийн үгст яагаад гайхширсан бэ? (Алма 10:12-ыг үз.) Сайн мэдээг хуваалцахдаа нэгээс илүү гэрчлэлтэй байхын ашиг тус юу вэ? Эдгээр чармайлтууддаа бид бие биенээ хэрхэн дэмжиж чадах вэ? (Та бүрэн цагийн номлогчид, гэрийн багш нар, айлчлагч багш нар болон эцэг эхчүүд зэрэг Сүмийн хос хосоороо заадаг хүмүүсийг дурдаж болно.)

Хичээлийн үлдсэн хугацаанд ангийн гишүүдийг, Алма, Амюлек хоёр нэгэн ижил сургаалыг номлохдоо бие биенийхээ чармайлтанд хэрхэн дэмжлэг үзүүлж байсныг нь ажиглахыг урь. Сургаал номлолуудыг ярилцсаны дараа та тэдгээрийг самбарт дүгнэн бичиж болно. Үүнийг хэрхэн хийхийг дараах хүснэгтээс үз.

СУРГААЛ НОМЛОЛ	АМЮЛЕКИЙН ГЭРЧЛЭЛ	АЛМАГИЙН ГЭРЧЛЭЛ
Цагаатгал	Алма 11:40	Алма 12:33–34
Наманчлал	Алма 11:40	Алма 12:24
Шүүлт	Алма 11:41	Алма 12:14
Дахин амилалт	Алма 11:41–42	Алма 12:24–25

3. Амюлек Зиезромтой маргалдаж, Христийг гэрчилдэг.

Алма 11-ээс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. 11-р бүлэг нь Нифайчуудын мөнгөний тогтолцоог дүрслэн эхэлдэг гэж тайлбарла. Алма 11:20-ийг эхэнд Амюлекийг Аммонайха нутгийн хамгийн зальжин эр болох Зиезромд шалгагдсан хэсэг гардаг.

- Аммонайхагийн шүүгчид яаж мөнгө олдог байсан бэ? (Алма 11:1, 20 -ийг үз.) Тэд яагаад Алма, Амюлек хоёртой маргалдахыг хүсэж байсан бэ? (Алма 11:20 -ийг үз.)

Урьдчилан даалгасан ангийн хоёр гишүүнээр Амюлек, Зиезром хоёрын хооронд болсон яриаг уншуул (Алма 11:21–40-ийг үз). Эсвэл эдгээр шүлгүүдийг танилцуулахын тулд хичээлийн төгсгөлд байгаа заах нэмэлт санааг ашигла. Тэгээд энэ хэсэг дэх бусад асуултыг ярилц.

- Амюлек Зиезромын эхний асуултанд хэрхэн хариулсан бэ? (Алма 11:21–22-ыг үз). Бид хэрхэн өөрсдийнхөө үг болон сургаалуудаа Их Эзэний Сүнсний зохицолд байлгаж чадах вэ?
- Зиезром Амюлекээс Есүс нүгэлтэй хүмүүсийг аврах уу гэж асуусан (Алма 11:34). Бид нүгэлтэй байвал аврагдаж чадахгүй гэдгийг хэлэхдээ Амюлек ямар шалтгаануудыг хэлсэн бэ? (Алма 11:34, 37-г үз.) Нүгэлтэйгээрээ аврагдах буруу санаа, мөн нүглээсээ аврагдаж болох үнэн нь хоорондоо ямар ялгаатай вэ? (Бид наманчлахгүй, нүгэлт байдалдаа үлдэх юм бол аврагдаж чадахгүй. Бид наманчилвал Есүс Христ биднийг нүглүүдээс маань аварч чадна.)
- Христийн Цагаатгалын ямар адислалууд бүх хүмүүст ирдэг вэ? (Алма 11:42–43-ыг үз.) Ямар нь зөвхөн Түүнд итгэж, Түүний зарлигуудыг сахисанд нь ирдэг вэ? (Алма 11:40–41-ийг үз.)
- Амюлек дахин амилалтын талаар юу заасан бэ? (Алма 11:43–45-ыг үз.) Эдгээр үнэнүүдийг мэдэх нь бидэнд яагаад чухал вэ?

4. Алма цааш нь Амюлекийн үгийг тайлбарлаж, хатуу зүрх сэтгэлтэй болохоос сэрэмжлүүлдэг.

Алма 12-оос сонгосон шүлгүүдийг уншаас ярилц. Амюлекийг Зиезромын маргаанд хариулсны дараа Зиезром “салгалж эхлэв” гэдгийг цохон тэмдэглэ (Алма 11:46). Үүнийг хараад Алма “Амюлекийн үгсийг батлан. . . Амюлекийн хийснээс илүүгээр судруудыг дэлгэн” ярьж эхэлсэн (Алма 12:1).

- Алма 12:3–6 дахь Алмагийн Зиезромд хэлсэн үгнээс бид Сатаныг юу хүсдэг, мөн тэр хэрхэн ажилладаг тухай юу сурч чадах вэ? (Ихэнхдээ Сатан олон хүмүүсийг сүйрүүлэхийн тулд нэг хүнээр хууруулахыг оролддог гэдгийг цохон тэмдэглэ.) Бид өөрсдийгөө Сатаны нарийн аргаас хэрхэн хамгаалж чадах вэ?
- Алма бидний зүрх сэтгэлийн байдал Бурханы үгийг ойлгох ойлголтонд маань нөлөөлдөг тухай юу заасан бэ? (Алма 12:9–11-ийг үз.) Зүрх сэтгэлээ хатууруулаагүй хүмүүст ямар адислалууд ирдэг вэ? (Алма 12:10-ыг үз.) Бурханы үгийг таньж, ойлгож, хүлээн авдаг зүрх сэтгэлийг бид хэрхэн хөгжүүлэх вэ? (1 Нифай 2:16; 15:11-ийг үз.)
- Бурханы үгийн эсрэг зүрх сэтгэлээ хатууруулсан хүмүүс өөрсдийн үг, үйлс, бодлоороо шийтгэгдэх болно гэж Алма хүмүүст заасан (Алма

12:13–14). Их Эзэн яагаад үг, үйлсийнх нь дагуу шүүхийн хажуугаар бас бодлынх нь дагуу шүүдэг гэж та нар бодож байна вэ?

- Наманчлалгүй нүгэл хилэнцэндээ үхэгсдийн байдлыг Алма хэрхэн дүрсэлсэн бэ? (Алма 12:14–18-ыг үз.) Эдгээр хүмүүс яагаад “тэдэнд гэтэлгэл үгүй мэт” байх вэ? (С ба Г 19:16– 18-ыг үз.)
- Алма 12:22–34 нь Алмагийн Адамын Уналт болон гэтэлгэлийн төлөвлөгөөний тухай тайлбарласныг агуулдаг. Мөнх бус байдлын зорилгын тухай Алма юу заасан бэ? (Алма 12:24-ийг үз.) Энэхүү зарчмыг ойлгох нь бидэнд илүү их зөв шударгаар амьдрахад хэрхэн тусалж чадах вэ?
- Яагаад “Бурхан (Адам, Ева хоёрт) гэтэлгэлийн төлөвлөгөөг мэдүүлсний дараа тэдэнд зарлигуудыг өгсөн” нь чухал ач холбогдолтой вэ? (Алма 12:32; бичмэлийг оруулав). Гэтэлгэлийн төлөвлөгөөг ойлгох байдал нь зарлигуудыг сахихад бидэнд хэрхэн тусалж чадах вэ? Эцэг эхчүүд болон багш нар зарлигуудын ач холбогдлыг зааж байхдаа уг зарчмыг хэрхэн ашиглаж болох вэ?
- Бурхан бидний гэтэлгэлд зориулан төлөвлөгөө бэлтгэснийг нь бид яагаад мэдэх шаардлагатай вэ? Гэтэлгэлийн төлөвлөгөө бидэнд Бурханы шүүлт болон өршөөлийн тухай юу заадаг вэ?

Дүгнэлт

Алма Амюлек хоёр Есүс Христийн сайн мэдээний гэрчээр хамтран ажиллахдаа бие биеэ хүчирхэгжүүлэн гэтэлгэлийн төлөвлөгөөний тухай хүчтэй сургаалуудыг заасан. Ангийн гишүүдийг бие биеэ сайн мэдээний гэрч болоход нь хүчирхэгжүүлэх боломжуудыг эрж хайхад урамшуулан дэмж. Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэ санааг хичээлдээ хэрэглэж болно.

Зиезромын асуултуудад хариулах нь

Ангийн гишүүдийг судраа хааж, урьдчилсан ярилцлага хийлгүйгээр Алма 11:26–39 дэх Зиезромын Амюлект тавьсан асуултуудад зөв хариулахыг хичээхийг хүс. Тэдний хариултуудыг Амюлекийнхтэй харьцуул. Тэгээд дараа нь Зиезром хэрхэн Амюлекийг зальт аргаар будлиантай хариулт өгүүлэхийг оролдож байсныг нь ярилц. Ийм асуултуудад бэлтгэгдсэн байхын тулд сайн мэдээний зарчмуудыг ойлгож, Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийлэх нь амин чухал болохыг онцлон тэмдэглэ.

“Христэд Итгэх . . . Бидний Итгэлийн Дагуу Бидэнд Хүчийг Өгөөч”

Алма 13–16

Зорилго

Ангийн гишүүдэд урьдчилан томилогдсон үүрэг, дуудлага, пристийн зэргийн үүрэг хариуцлагаа дээдлэхийн чухлыг мэдэхэд нь, мөн бошиглогчдын зөвлөгөөг дагах нь бидэнд Их Эзэний энхжинд ороход тусалдгийг ойлгоход туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Алма 13. Алма пристийн зэрэг болон урьдчилсан томилолтын сургаалын тухай хүчтэй яриа өгдөг.
 - б. Алма 14. Алма, Амюлек болон бусад итгэгчид зөв шударга байсныхаа төлөө хавчигддаг. Их Эзэн Алма, Амюлек хоёрыг Христэд итгэсэн итгэлийнх нь төлөө шоронгоос чөлөөлдөг.
 - в. Алма 15. Зиезром эдгээгдэн усаар батлуулдаг. Сидом дахь олон хүмүүс усаар батлуулдаг.
 - г. Алма 16. Лэмэнчүүд Аммонайхаг устгахад Алмагийн үгс биелэгддэг. Их Эзэн Алма, Амюлек болон бусдын номлосон үгийг хүлээн авахад нь хүмүүсийн зүрх сэтгэлийг бэлтгэдэг.
2. Нэмж унших зүйл: Joseph Smith Translation, Genesis 14:25–40; Ифэр 12:12–13.
3. Та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглэж байгаа бол Христ Төлөөлөгчдөө Томилсон нь (62557; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 211) эсвэл Мелкизэдэк Пристийн Зэргийг Дахин Сэргээсэн нь (62371; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 408) зэрэг пристийн зэргийг хүлээн авч байгаа хүнийг дүрсэлсэн зургуудыг авчир.

Хичээлийг Баяжуулах Зөвлөмж

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Ангийн гишүүдэд самбар дээр бидний асууж болох хамгийн чухал асуултуудын нэгийг бичих гэж байгаагаа хэл. Тэгээд самбар дээр *Хэрхэн?* гэж бич.

Бидний хувийн зан байдалд хамаатай үед энэ асуулт маш чухал байдаг гэдгийг тайлбарла. Үүнийг харуулахын тулд ангийн гишүүдээр дараахыг төсөөлүүл:

- а. Залуу эрэгтэй тодорхой нэг газарт тодорхой цагт байх ёстой гэдгээ мэдэж байгаа боловч тэнд яаж очихоо мэдэхгүй байлаа.
- б. Эмэгтэй усаар батлуулах хэрэгтэй гэдгээ мэдэж байгаа боловч энэ талаар юу хийхээ мэдэхгүй байлаа.
- в. Нэг эрэгтэй Есүс бол Христ гэдгийг мэдэх боловч Түүнд яаж хүрэхээ мэдэхгүй байлаа. (Та энэ жишээг хуваалцахдаа ангийн гишүүдээр 1 Нифай 15:14-ийг уншуулж болно.)

Алма Аммонайхагийн хүмүүст заахдаа Христэд ирэхийг мэдэж болох нэгэн арга замын тухай ярьсан хэмээн тайлбарла. *Хэрхэн* гэсэн үгийг хэрэглэхээсээ илүүтэй тэрээр “ямар маягаар” гэсэн үгийг хэрэглэжээ. Ангийн нэг гишүүнээр Алма 13:1–2-ыг уншуул.

Пристийн зэргийн томилолтыг дүрсэлсэн зургийг үзүүл (“Бэлгэл”-ийн 3-ыг үз). Тус хичээлийн нэг хэсэгт нь бидэнд пристийн зэргийн жаяг нь хэрхэн “Хүүгийн гэтэлгэлийг ямар маягаар хүсэн хүлээхийг мэдэхэд” тусалдаг гэдгийг тайлбарла (Алма 13:2).

Судрын Ярилцлага ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Алма пристийн зэрэг болон урьдчилсан томилолтын тухай хүчтэй яриа өгдөг.

Алма 13-ыг ярилц. Ангийн гишүүдээр сонгосон шүлгүүдийг уншуул. Алма Аммонайхад Зиезром болон бусад хүмүүст гэтэлгэлийн төлөвлөгөөг заасныхаа дараа пристийн зэрэг болон урьдчилсан томилолтын тухай номлолын талаар гэрчилсэн гэдгийг тайлбарла. Энэхүү яриан дахь пристүүд нь Мелкизедек Пристийн Зэргийн дээд пристүүд байсан гэдгийг цохон тэмдэглэ (Алма 13:10).

- Хүмүүс анх хэзээ пристийн зэрэгт томилогдохоор “дуудагдаж, бэлтгэгдсэн” бэ? (Алма 13:3-ыг үз.)
Бошиглогч Иосеф Смит, “Дэлхийн суугчдад үйлчлэх дуудлагатай хүн бүр чухамхүү энэхүү зорилгод энэ дэлхийг үүсэхээс өмнө тэнгэрийн Тэргүүн Чуулганаар томилогдсон билээ” гэж хэлсэн (*Teachings of the Prophet Joseph Smith*, sel. Joseph Fielding Smith [1976], 365).
- Хүн мөнх бус байдлын өмнөх амьдралдаа Мелкизедек Пристийн Зэргийг хүртэхээр урьдчилан томилогдохуйц зохистой байсан гэдгээ хэрхэн харуулсан бэ? (Алма 13:3–5-ыг үз.) Урьдчилан томилогдохуйц зохистой байхын тулд хүн энэ амьдралдаа юу хийх ёстой вэ? (Алма 13:3–10-ыг үз.)
- Бидний дээр тэргүүлэхээр дуудагдсан хүмүүсийг дэмжих байдалд маань Алмагийн урьдчилан томилолтын тухай номлол хэрхэн нөлөөлөх ёстой вэ? Эдгээр номлолууд пристийн зэргийн удирдагч бидэнд дуудлага эсвэл үүрэг даалгавар өгөхөд бидний хариу хандах байдалд хэрхэн нөлөөлөх ёстой вэ?

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл заахдаа: “Биднийг энд ирэхээс өмнө итгэлтэй эмэгтэйчүүдэд нь тодорхой үүрэг даалгавар өгөгдөж, итгэлтэй эрэгтэйчүүд нь пристийн зэргийн тодорхой үүрэгт томилогдсон байсан. Бид одоо үүнийг нэг бүрчлэн санадаггүй ч, энэ нь бидний нэгэн цагт зөвшөөрсөн сүр жавхлант бодит байдлыг өөрчилдөггүй. Бид бошиглогч, төлөөлөгчдийг дэмждэг шиг урт хугацааны өмнө хүлээн зөвшөөрсөн тэдгээр зүйлүүдийнхээ төлөө та хариуцлага хүлээдэг!” (“The Role of Righteous Women,” *Ensign*, Nov. 1979, 102).

- Хүн “түүний энхжинд орж болохын тул хүмүүний үрсэд түүний зарлигуудыг заахаар” Мелкизедек Пристийн Зэргийг хүлээн авдаг гэж Алма хэлсэн (Алма 13:6; мөн 1-р шүлгийг үз). Мелкизедек Пристийн Зэрэгтнүүд зааж сургах ямар боломжтой байдаг вэ? “Их Эзэний энхжинд орно” гэдэг нь юу гэсэн үг вэ? (Доорх ишлэлийг үз.) Та нар Их Эзэний энхжинд орохын тулд бид сайн мэдээг яагаад суралцаж заах ёстой гэж бодож байна вэ?

Ахлагч Брус Р.МакКонки ийнхүү заасан: “Мөнх бусынхны санаа зовж буй тэрхүү Их Эзэний энхжин нь хожмын үеийн агуу их ажлын тэнгэрлэг байдлын талаарх төгс мэдлэгийг олж авахад зориулагдсан билээ. [Ерөнхийлөгч Иосеф Смит]: ‘Энэ нь бид зөв хэмээн мэдэх тэрхүү хэмжээнд Бурханы мэдлэг болон хайранд орох, түүний зорилго болон төлөвлөгөөнд итгэх болон бид өөр ямар нэгэн зүйлийг эрж хайгаагүй гэсэн үг юм. Бид аливаа номлолын салхи хүмүүсийн ов мэх болон зальхай хуйвалдааны башир арганд туугдахгүй.’ Энэ бол ‘дэлхийн шашны үймээн самуунаас, энд тэнд Хараач, Христ энд байна, Хараач, Христ тэнд байна гэж хашхирах дуунаас амрах газар’ юм. (*Gospel Doctrine*, 5th ed. pp. 58, 125–126.) Мөнх байдалд орших Их Эзэний энхжин нь мөнхийн амьдралд ороход, Их Эзэний алдар суугийн бүрэн дүүрэнг хүлээн авахад зориулагдсан (С ба Г 84:24.)” (*Mormon Doctrine*, 2nd ed. pp. 58, 125–126).

- Их Эзэний энхжинд орох зөвшөөрлийг авахын тулд бид хэрхэн цэвэр болж чадах вэ? (Алма 13:11–12-ыг үз.) Хурганы цусаар болон Ариун Сүнсээр дамжуулан ариусгагдахын тулд бид яаж амьдрах ёстой вэ? (Алма 13:12–13, 16, 27–29-ийг мөн 3 Нифай 27:19–20-ийг үз.)

Ангийн нэг гишүүнээр Алма 13:2, 16-г чанга уншуул. Тэгээд дор жагсаасан шүлгүүдийг тоймло. Ангийн гишүүдэд пристийн зэргийн жаяг бидэнд Аврагчийн гэтэлгэлийг хэрхэн харахад тусалж буй аргуудыг мэдэхэд нь тусал. Бичмэлээр бичсэн үг, хэллэгийг онцгойлон анхаар.

- Алма 13:3–4. (Мелкизедек Пристийн Зэргийг хүлээн авахаар урьдчилан томилогдсон тэдгээр хүмүүс нь “тэдний үлэмжийн *итгэл* мөн *сайн үйлүүдээс* үндэслэн дуудагдаж бэлтгэгдсэн.”)
 - Алма 13:6. (Тэд “түүний энхжинд орж болохын тул хүмүүний үрсэд түүний [Бурханы] *зарлигуудыг* заахаар томилогдсон [урьдчилан томилогдсон]”)
 - Алма 13:8. (Энэ амьдралд тэд “*ариун ёслолоор* томилогдсон.”)
 - Алма 13:10. (Үргэлжийн *итгэл*, *сайн үйлс* болон *наманчлалаараа* дамжуулан тэд урьдчилан томилогдохуйц зохистойгоо харуулдаг.)
- Итгэл болон наманчлал нь Есүс Христийн гэтэлгэл өөд харахад бидэнд хэрхэн тусалдаг вэ? Сайн үйлс болон зарлигуудыг дуулгавартай дагах нь

бидэнд түүн рүү харахад хэрхэн тусалдаг вэ? Пристийн зэргийн ёслолууд Түүн рүү харахад бидэнд хэрхэн тусалдаг вэ?

- Алма Мелкизедекийн тухай агуу их дээд пристийн жишээ болгон ярьсан (Алма 13:14–15). Мелкизедекийн жишээнээс бид юу сурч болох вэ? (Алма 13:17–18-ыг үз; мөн Joseph Smith Translation, Genesis 14:25–40-ийг үз.)
- Бид Алма 13:27-гоос Алмагийн Амонайхайн хүмүүст зориулсан хайрын тухай юу сурч болох вэ?
- Ангийн нэг гишүүнээр Алма 13:27–29 дэх хүмүүст хандсан Алмагийн гуйлтыг уншуул. Яагаад наманчлалыг хойш тавихгүй байх нь чухал вэ? (Алма 34:32–36-г үз.) Бид “үргэлж сэрэмжилж залбирвал” ямар адислалуудыг хүлээн авах вэ? (Алма 13:28-ыг үз.) Бид хэрхэн “мөнхийн амьдралыг хүлээн авах найдвартай” байж болох вэ? (Алма 13:29; Моронай 7:41-ийг үз.)

2. Алма, Амюлек болон бусад итгэгчид зөв шударга байсныхаа төлөө хавчигддаг.

Алма 14-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Олон хүмүүс Аммонайхад Алма, Амюлек нарын сургаалд итгэж наманчилж, судруудыг эрэлхийлэх болсон (Алма 14:1). Гэхдээ хүмүүсийн ихэнх нь дургүйцэж Алма, Амюлек нарыг хавчиж эхэлсэн (Алма 14:2–5). Зарим хүмүүсийг наманчлалд дуудахад тэд яагаад уурлаж дургүйцсэн бэ? (1 Нифай 16:1–3-ыг үз.)
- “Хүмүүсийн дунд өөрийн бий болгосон” зүйлээ хараад Зиезром юу хийсэн бэ? (Алма 14:6–7-г үз.) Зиезром өөрийнхөө гэм бурууг хүлээж Алма, Амюлек хоёрыг хамгаалахад хүмүүс үүнийг хэрхэн хүлээн авсан бэ? (Алма 14:7-г үз.)
- Аммонайхагийн нүгэлтнүүд Бурханы үгст итгэгчдэд юу хийсэн бэ? (Алма 14:7–9-ийг үз.) Их Эзэн яагаад ийм зүйлийг тохиолдуулсан бэ? (Алма 14:10–11; 60:13-ыг үз.) Алма, Амюлек хоёрын амийг аврах нь яагаад Бурхан хүсэл зориг байсан бэ? (Алма 14:12–13-ыг үз.)
- Алма, Амюлек хоёр шоронд олон хоногийн турш хавчигдан мөрдөгдсөнийхөө дараа эцэст нь хэрхэн чөлөөлөгдсөн бэ? (Алма 14:26–29; Ифэр 12:12–13-ыг үз. Тэдэнд “Христэд итгэх итгэлийнх нь дагуу” хүч чадал, эрх мэдэл өгөгдсөн.) Бидэнд чөлөөлөгдөх шаардлагатай ямар зүйлүүд байдаг вэ? Чөлөөлөлт рүү хөтлөгдөхийн тулд бид яагаад итгэлээ Христэд төвлөрүүлэх ёстой вэ? (Мозая 3:17; Моронай 7:33-ыг үз.)

3. Зиезром эдгэрч, усаар батлуулдаг.

Алма 15-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Их Эзэн тэднийг шоронгоос сулласны дараа Алма, Амюлек хоёр Сайдомын нутаг руу явсан. Тэнд тэд Аммонайхагаас Бурханы үгэнд итгэснийхээ төлөө хөөгдөж, чулуугаар нүүлгүүлсэн хүмүүстэй тааралджээ (Алма 15:1; мөн Алма 14:7-г үз). Зиезром эдгээр хүмүүсийн нэг байжээ (Алма 15:3).

- Зиезром ёсон бусаас нь үүдсэн оюун санаа болон биеийн зүдрэлд орсон байсан боловч Алма, Амюлек хоёр Сайдомд байгааг нь сонсоод “түүний зүрх зоригжиж эхлэв” (Алма 15:3–4). Тэр Алма, Амюлек хоёроос юу

гуйсан бэ? (Алма 15:5.) Энэ нь түүний тэдэнд итгэсэн тухай юуг илчилсэн бэ? Эдгэрэхийн тулд тэр хэнд итгэх ёстой байсан бэ? (Алма 15:6–10-ыг үз.)

- Зиезромын эдгэрснийх нь дараах үйлдлээс бид юу сурч болох вэ? (Алма 15:11–12-ыг үз.)
- Аммонайха дахь хүмүүсийг бодвол Сайдомын хүмүүс Алма, Амюлек хоёрын заасан захиаст итгэж усаар батлуулсан (Алма 15:12–15). Алма “хүмүүс өөрсдийн зүрхний бардамналын тухайд өөрчлөгдөхийг” харсан (Алма 15:17; *Өөрчлөгдөх* гэдэг нь багасгах буюу болих гэсэн үг гэдгийг анхааруул). Хүмүүс илүү даруу болохын тулд юу хийсэн бэ? (Алма 15:17-г үз.) Бурханаа үнэн сэтгэлээсээ шүтэхийн тулд бид яагаад өөрсдийгөө даруусгах ёстой вэ?
- Амюлек сайн мэдээгээр амьдарч, номлогчоор үйлчлэхээр сонгохдоо юуг орхисон бэ? (Алма 15:16-г үз.) Тэр юу олж авсан бэ? (Алма 8:30; 34:1, 8; Ифэр 12:12–13-ыг үз.) Та нар сайн мэдээний дагуу амьдарч заахыг сонгохдоо ямар золиослол хийсэн бэ? Үүний төлөө та нар хэрхэн адислагдсан бэ?
- Сайдомд Сүм байгуулагдсаны дараа Алма Амюлекийн төлөө юу хийсэн бэ? (Алма 15:18-ыг үз.) Энэхүү үйлдэл нь Алмагийн талаар юуг илчилж байна вэ? Бид ямар арга замаар бусдад үйлчлэл үзүүлж тэднийг Их Эзэнд хүчирхэгжүүлж болох вэ?

4. Лэмэнчүүд Аммонайхаг устгахад Алмагийн үгс биелдэг.

Алма 16-гаас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Алма, Амюлек хоёрыг Аммонайхад номлосноос бараг жилийн дараа Лэмэнчүүд Нифайчуудын нуггийг эзэлжээ (Алма 16:1–2). Аммонайха дахь Нифайчуудад юу тохиолдсон бэ? (Алма 16:2–3; 9–11-ийг үз.) Энэ нь Алмагийн бошиглолын биелэл хэрхэн болсон бэ? (Алма 9:4–5, 12,18-ыг үз.)
- Яагаад Зорам ба түүний дагалдагчид Лэмэнчүүдийг хөөж олзлогдсон ахан дүүсээ аварч чадсан бэ? (Алма 16:4–8-ыг үз.) Бид Аммонайхагийн сүйрлийг Зорамын армийн амжилттай харьцуулснаар юу сурч чадах вэ? (Алма 9:1–8 ба 15:15-ыг Алма 16:4–6-тай харьцуул; мөн 2 Нифай 4:34-ийг үз. Бид ертөнцийн мэдлэг, хүч чадал, эд зүйлст бус харин Бурхан ба Түүний бошиглогчдод итгэх ёстой гэдгийг онцлон тэмдэглэ.)
- Аммонайхагийн сүйрлийн дараа Их Эзэн хүмүүсийн зүрх сэтгэлийг Алма, Амюлек хоёр болон энэхүү ажлыг хийхээр сонгогдсон бусад хүмүүсийн номлосон үгийг хүлээн авахад бэлтгэсэн (Алма 16:13–21). Их Эзэн хүмүүсийн зүрх сэтгэлийг, үгийг нь хүлээн авахад хэрхэн бэлтгэсэн бэ? (Алма 16:16-г үз.) Бид Бурханы үгийг “цэвэр ариунаар” нь номлож байгаа гэдгээ хэрхэн баталж чадах вэ? (Алма 16:21; Мозая 18:18–20; С ба Г 52:9-ийг үз.)

Дүгнэлт

Ангийн гишүүдийг Алма 13–16-д ярилцсан зүйлүүдээс олж авсан ойлголт болон сэтгэгдлийг нь хуваалцуулахаар урь.

Матай 11:28–30 болон Алма 13:27–29-ийг унш. Эргэлзээ, будлианаар дүүрэн дэлхийд бид пристийн зэргээр дамжуулан “Хүүгийн гэтэлгэлийг ямар маягаар хүсэн хүлээхийг мэдэж болох тийм маягаар” мэдэж болно гэдгийг

мэдэх нь бидэнд тайвшрал болдог гэдгийг онцлон тэмдэглэ (Алма 13:2). Бид Их Эзэн рүү харж, Түүнд итгэж, Түүний бошиглогчдын зөвлөгөөг дагахдаа Түүний энхжинд ордог.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт
Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэ санааг хичээлдээ хэрэглэж болно.

“Бурханы зөгнөх мэдлэгийн дагуу” (Алма 13:3)

Урьдчилсан томилолтын тухай ангийн гишүүдийн ойлголтыг бэхжүүлэхийн тулд Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны дараах мэдэгдлийг унш:

“Бурхан та нарыг Их Эзэний хоёр дахь ирэлтийн өмнөх эцсийн өдрүүдэд гаргаж ирэхээр хүлээлгэсэн билээ. . . . Бурхан хамгийн хүчтэй хүүхдүүдийнхээ заримыг [эцсийн өдрүүддээ] зориулан хаант улсын ялгуусан их ялалтыг авчрахад нь туслуулахаар нөөцлөн хадгалсан билээ. Тиймээс та нар Бурханаа угтахаар бэлтгэгдэх ёстой үе удам тул энд байгаа билээ. . . .

“Бүх үед бошиглогчид өнөөгийн өдрүүд рүү цаг хугацааны гудмаар доош харж байлаа. Бум түмэн үхэгсэд болон төрөгсөд биднийг харж байлаа. Алдаа бүү гарга, та нар бол онцгойлон тэмдэглэгдсэн үе удам юм шүү. Биднээс хүсэн хүлээдгийн адил ийм богинохон хугацаанд итгэгчдээс үүнээс илүүг хэзээ ч хүсэн хүлээж байгаагүй” (*The Teachings of Ezra Taft Benson* [1988], 104–5).

“Бурханаас Хүлээн Авсан Хүч Мөн Эрх Мэдэлтэйгээр Тэд Зааж Байв”

Хичээл
25

Алма 17–22

Зорилго

Ангийн гишүүдэд сайн мэдээг хуваалцан, бусдад үйлчлэл үзүүлэн Мозаягийн хөвгүүдийн жишээг дагахад урамшуулна.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Алма 17:1–18. Мозаягийн хөвгүүд Лэмэнчүүдэд сайн мэдээ номлодог.
 - б. Алма 17:19–39; 18; 19. Аммон Лэмонай Хаанд үйлчилж, мөн заадаг. Хаан, хатан болон өөр олон Лэмэнчүүд хөрвүүлэгддэг.
 - в. Алма 20–22. Аммон ахан дүүсээ шоронгоос суллахаар Сүнсээр хөтлөгддөг. Лэмонайн эцэг хөрвүүлэгддэг.
2. Ангийн нэг гишүүнээс Алма 17:19–39-ийг дүгнэн ярихад бэлтгэхийг хүс. Түүнээс уг түүхийн үйл явдлыг илтгэхийг хүс. Үүний дараа ишлэл дэх сургаал болон үүний хувийн амьдралд хэрэглэгдэх байдлыг ярилцах болно.
3. Аммон Лэмонай Хааны Хонин Сүргийг Хамгаалсан нь (62535; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 310) зураг байгаа бол хичээлдээ хэрэглэхээр бэлтгэ.

Хичээлийг

Баяжуулах

Зөвлөмж

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Самбарт дараах үгсийг бич: *Мэдэх, Мэдрэх, Хийх*

- Эдгээр үгс номлогчийн ажилд хэрхэн хамаатай байдаг вэ?

Ахлагч Карлос И.Эсэй дараах тохиолдлыг ярьсан юм:

“Саявтар би шинээр хөрвөгдөгчийн гэрчлэлийг сонссон юм. Залуу эрэгтэй Сүнсээр эзэмдүүлсэн нь тодорхой байлаа. Өөр зүйлүүд ярьсны дотор тэр гэр бүл болон найз нөхөдтэйгөө дахин сэргээгдсэн сайн мэдээг хуваалцах агуу их хүсэлтэй байгаагаа хэлсэн юм. Нүдэнд нь нулимс хурж, хоолой нь чичрэн тэр ингэж хэлсэн юм:

“Миний мэдэж байгаа зүйлүүдийг тэд мэдээсэй гэж би хүсэж байна.

“Миний мэдрч байгаа зүйлүүдийг тэд мэдрээсэй гэж би хүсэж байна.

“Миний хийж байгаа зүйлүүдийг тэд хийгээсэй гэж би хүсэж байна.”

“Номлогчийн сүнс гэж байдаг. Энэ сүнс нь биднийг өөрсдөөсөө гадуур амьдарч бусдын сайн сайхны төлөө санаа тавихад уриалан дууддаг юм. Нэр төртэйгөөр номлолдоо үйлчилсэн, найздаа хөрвүүлэгдэхэд нь тусалсан, номлолын талбарт хүү, охиноо дэмжсэн, номлогчидтой сайхан хамтран нэгдэж байсан хэн нь ч үүний үнэн бодитойг гэрчилнэ” (in Conference Report, Oct. 1976, 58; or *Ensign*, Nov. 1976, 42).

Мозаягийн хөвгүүд хөрвүүлэгдсэнийхээ дараа сайн мэдээг бусадтай хуваалцах агуу их хүсэлтэй байсан. Тэдэнд тохиолдсон явдал нь судрууд дээрх номлолын үйлчлэлийн агуу их үлгэр жишээ болж өгдөг. Энэ хичээлээр Лэмэнчүүдийг үнэний мэдлэгт авчрах явдалд тэд хэрхэн Бурханы мутар дахь зэмсэг болсныг ярилцах болно.

Судрын Ярилцлага ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Мозаягийн хөвгүүд Лэмэнчүүдэд сайн мэдээг номлодог.

Алма Мантайн нутаг руу аялж байхдаа Лэмэнчүүдэд хийсэн 14 жилийнхээ номлолоос буцаж байсан Мозая Хааны хөвгүүдтэй тааралдсан. Алма 17–26-д Мозаягийн хөвгүүдийн номлол болон тэдэнд тохиолдсон явдлууд бичигджээ. Алма 17:1–18-ыг уншаад ярилц.

- Яагаад Мозаягийн хөвгүүд тийм хүчтэй, нөлөөтэй багш нар болсон бэ? (Алма 17:2–4-ийг үз. Самбарт *Номлолын Ажлыг Амжилттай Сайн Хийх Түлхүүрүүд* гэсэн гарчиг бич. Гарчгийн дор *Суралцах, мацаг барих, залбирах* гэж бич.) Бидний зохистой байдал болон бэлтгэл нь хэрхэн Их Эзэний мутар дахь зэмсэг болж чадах вэ? Хувийн бэлтгэлийн улмаас адислагдсан номлогч эсвэл өөр нэг хүнийг та нар мэдэх үү?
- Мозаягийн хөвгүүд номлолын ажлаа хийхийн тулд ямар золиослолууд хийсэн бэ? (Алма 17:5–6-г үз.) Тэд яагаад үүнийг хийх хүсэлтэй байсан бэ? (Алма 17:9, 16; мөн Мозая 28:1-3-ыг үз. Самбар дээр *Бурхан болон бусдыг хайрлах* гэж бич.) Бид Мозаягийн хөвгүүдийн үзүүлсэн бусдын төлөөх хайр, халамжийг хэрхэн хөгжүүлж чадах вэ?
- Мозаягийн хөвгүүд “хатуу сэтгэлт, харгис хүмүүст” номлохоор явсан (Алма 17:14). Тэдэнд номлолдоо бэлтгэхэд нь туслахын тулд Их Эзэн ямар зөвлөгөө өгч тайвшруулсан бэ? (Алма 17:10–11-ийг үз.) Их Эзэнээс зөвлөгөө болон тайвшруулалтыг хүлээн аваад Мозаягийн хөвгүүд ямар сэтгэгдэлтэй болсон бэ? (Алма 17:12-ыг үз.) Эдгээр шүлгүүд нь биднийг дуудлагатаа бэрхшээлүүдтэй тулгарахад хэрхэн тусалж чадах вэ?

2. Аммон Лэмонай Хаанд үйлчилдэг бөгөөд олон хүмүүс хөрвүүлэгддэг.

Урьдчилан даалгасан ангийн нэг гишүүнээр Алма 17:19–39-д дүрслэгдсэн үйл явдлуудыг хураангуйлуул. Тэгээд Алма 17:19–39; 18; 19-өөс сонгосон шүлгүүдийг уншиж ярилц. Та Аммон хааны хонин сүргийг хамгаалж байгаа зургийг хэрэглэж байгаа бол үүнийгээ одоо үзүүл.

- Хааны хонин сүргийг тарахад Аммоны “зүрх сэтгэл яагаад баяраар бялхсан” бэ? (Алма 17:29-ийг үз.) Аммон энэ явдлыг зөв тал руу хэрхэн эргүүлсэн бэ? (Алма 17:30–39-ийг үз.)
- Зарц нар хаанд Аммон түүний сүргийг хэрхэн хамгаалсан тухай хэлэхэд хаан үүнд юу гэж хариулсан бэ? (Алма 18:2–5-ыг үз.) Хаан Аммоноос түүнийг хаана байсныг нь асуухад тэр юу гэж хариулсан бэ? (Алма 18:8–9-ийг үз. Самбарт *Үйлчилж итгэлээ хөгжүүлэх* гэж бич.) Энэ нь Лэмонай Хаанд сурахаар бэлтгэхэд нь хэрхэн тусалсан бэ? (Алма 18:10–11-ийг үз.)
- Аммоныг хаантай уулзахаар ирэхэд хааны зарц нар түүнд яаж хандсан бэ? (Алма 18:13-ыг үз.) Аммоны Лэмонай Хаанд хандсан үг нь түүнийг даруу үйлчлэгч хэвээр үлдсэнийг нь хэрхэн харуулсан бэ? (Алма 18:14–17-г үз.)
- Яагаад Аммоны хувьд хаанд заахаасаа өмнө үйлчлэх нь чухал байсан гэж та нар бодож байна вэ? Бид бусдад үйлчилж итгэлийн харьцаатай болох нь тэдэнд сайн мэдээний захиасыг заахад хэрхэн тусалж чадах вэ? Бид зааж буй хүмүүстээ ямар замаар үйлчилж болох вэ?
- Аммон Лэмонай Хаанд зааж эхлэхдээ Бурхан болон тэнгэрийн тухай ойлголттой болоход нь түүнд хэрхэн тусалсан бэ? (Алма 18:24–33-ыг үз. Тэр хааны ойлгож чадах аргаар заасан.) Бид сайн мэдээг заахдаа энэ жишээг хэрхэн дагаж чадах вэ?
- Лэмонай Хааныг ойлголттой болсны дараа Аммон түүнд ямар гол номлолуудыг заасан бэ? (Алма 18:34–39-ийг үз. Самбарт *Сүдрүүдаас гэтэлгэлийн төлөвлөгөөг заа* гэж бич.) Мормоны Ном нь өнөө үед эдгээр үнэнийг заахад яагаад чухал хэрэгсэл болдог вэ?
- Аммоны үгсийг дуулаад, итгэснийхээ дараа Лэмонай Хаан яасан бэ? (Алма 18:40–41-ийг үз.) Хүмүүс сайн мэдээний зарчмуудыг заалгахдаа яагаад өршөөл эрэлхийлэх нь чухал вэ? Яагаад хөрвүүлэлтийн үйл явцад залбирал чухал вэ?
- Залбирсныхаа дараа Лэмонай Хаан газарт унасан. Лэмонайг үхэх гэж байхад нь хатан өөрийнхөө итгэлийг хэрхэн харуулсан бэ? (Алма 19:1–5, 8–9-ийг үз.)
- Лэмонай хөрвүүлэгдсэнийхээ дараа хатантай ярьж байхдаа юуг онцолж байсан бэ? (Алма 19:12–13-ыг үз.)
- Хатан хаантай ярьсны дараа Лэмонай, хатан хаан болон Эбишээс бусад бүх зарц нар газарт унав (Алма 19:13, 15–16). Эбиш гэж хэн бэ? (Алма 19:16–17-г үз. Та ангийн гишүүдээр Эбишийн тухай ярилцуулан эргэн тойрных нь эсрэг байсан ч тэр эмэгтэй Их Эзэнд хэрхэн хөрвүүлэгдсэн хэвээр байсны жишээ болж болохыг цохон тэмдэглэж болно.) Эбиш юу болсныг ойлгоод яасан бэ? (Алма 19:17-г үз.) Бид хэрхэн сайн мэдээг хуваалцах боломжуудыг таньж ашиглаж болох вэ?
- Хааны гэрт цуглараад хүмүүс хэрхэн өөр өөрөөр хандсан бэ? (Алма 19:18–28-ыг үз.) Эбиш хүмүүсийн дундах маргааныг зохицуулах гэж хэрхэн оролдсон бэ? (Алма 19:28–29-ийг үз.) Хаан, хатан хоёр босч өөрсдийнхөө хөрвүүлэлтийг хэрхэн харуулсан бэ? (Алма 19:29–31, 33-ыг үз.)
- Аммон, Лэмонай Хаан болон түүний хүмүүст тохиолдсон явдлаас Мормон биднийг юу сурахыг хүссэн гэж та нар бодож байна вэ? (Алма 19:36-г үз.)

Хариултанд Их Эзэний гар “наманчлах мөн түүний нэрэнд итгэх бүх хүмүүст . . . сунгаастай байдаг” гэж орж болно.)

3. Аммон ахан дүүсээ суллахаар Сүнсээр удирдуулдаг. Лэмонайн эцэг хөрвүүлэгддэг.

Алма 20–22-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Хаант улсад нь Сүм байгуулагдсаны дараа Лэмонай юу хийхийг хүссэн бэ? (Алма 20:1- ийг үз.) Яагаад шинээр хөрвөгдөгчдийн хувьд бусадтай гэрчлэлээ хуваалцах нь чухал вэ? Бид хэрхэн ийм урам зоригтой хэвээр байж чадах вэ?
- Лэмонай ба түүний эцгийн хоорондын яриа нь Лэмонайн хөрвүүлэлтийн гүнийг хэрхэн харуулж байна вэ? (Алма 20:13–15-ыг үз.)
- Лэмонай Хааны эцэг Аммоны юунд нь гайхсан бэ? (Алма 20:26–27-г үз.) Хайр болон гэрчлэл нь хүний зүрх сэтгэлийг зөөлрүүлэхэд яагаад тийм их хүчтэй байдаг вэ? (Ангийн гишүүдийг хайр болон гэрчлэл нь тэдний буюу гэр бүлийнхнийх нь эсвэл найз нөхдийнх нь зүрх сэтгэлийг зөөлрүүлсэн тохиолдлуудаас хуваалцахыг урь.)

Алма 21 нь Аммоны ах Аарон болон түүний ахан дүүсийн тухай ишлэлээр эхэлдэг гэж хэл. Тэд Ерусалимд Амалекайчууд болон Амюлончуудад сайн мэдээг номлосон боловч эдгээр урвагч Нифайчуудын зүрх сэтгэл маш их хатуурч тэд сонсохоос татгалсан юм. Аарон ахан дүүстэйгээ тэндээс явж Миддонид номлож эхэлсэн боловч тэднийг хилсдүүлэн шоронд хорьжээ.

- Аароныг ахан дүүсийнх нь хамт суллаж, хооллож ундалж, хувцасласных нь дараа тэд юу хийсэн бэ? (Алма 21:14–15-ыг үз. Самбарт *Зовлон зүдгүүрийг үл харгалзан цааш үргэлжлүүлсэн* гэж бич.) Бидэнд зовлон зүдгүүр, бэрхшээл тулгарсан ч Бурханы хаант улсын ажлыг үргэлжлүүлэх нь яагаад чухал вэ?
- Аарон болон ахан дүүс нь сайн мэдээг заахаар хаашаа явах ёстойгоо хэрхэн мэдсэн бэ? (Алма 21:16-г үз.) Тэд Сүнсээр хөтлөгдөхдөө хэрхэн адислагдсан бэ? (Алма 21:17-г үз.) Та нар Сүнсний өдүүлбэрт анхааралтай хандахдаа хэрхэн адислагдаж байсан бэ?
- Аарон Лэмонай Хааны эцгийн гэр лүү Сүнсээр хөтлүүлэн явсан (Алма 22:1). Аммоны жишээ нь Лэмонайн эцгийг сурахад бэлтгэхэд хэрхэн тусалсан бэ? (Алма 22:2–3-ыг үз. Самбарт *Сайн жишээ бол* гэж бич.) Та нар сайныг хийхэд Сүмийн гишүүдийн нөлөөлсөн жишээг хэрхэн харсан бэ?
- Лэмонайн эцэгт Аароны заасан нь Аммоны Лэмонайд заасантай хэрхэн төстэй вэ? (Алма 18:24–39 ба Алма 22:7-г харьцуул.) Лэмонайн эцэг гэтэлгэлд найддаг болохын тулд юу хийх ёстойгоо асуухад Аарон юу гэж хэлсэн бэ? (Алма 22:16-г үз. Самбарт ангийн гишүүдийн хариултыг жагсааж бич. Үүнд доор жагсаасан зүйлүүд орж болно.)
 - а. “Бурханы өмнө бөхийх.”
 - б. “Бүх нүглээ наманчлах.”
 - в. “Итгэлдээ Бурханы нэрийг дуудах.”
- Бурханыг мэдэхийг тулд хаан ямар золиослолуудыг хийхэд бэлэн байсан бэ? (Алма 22:15, 17–18-ыг үз.) Хааны жишээнээс бид юу сурч чадах вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон Алма 22:15, 18-ын тухай ярихдаа: “Бид бүгд, хүн нэг бүр үнэхээр Христийг мэддэг л юм бол нүглээ орхих хэрэгтэй. Яагаад гэвэл бид түүнтэй адил болохоос нааш Түүнийг мэдэж чадахгүй. Зарим нь өөрсдөөс нь “үндэслэсэн ёсон бус сүнсийг” орхиж, баяр баясгаланг олж автлаа мөн хааны адил залбирах хэрэгтэй” гэсэн (in Conference Report, Oct. 1983, 63; or *Ensign*, Nov. 1983, 43).

- Хаан өөрийн хүү Лэмонайн адил үнэхээр Сүнсээр даван гарсан юм. Хаан босч гэрчлэлээ тунхаглахад олон хүмүүс энэ тохиолдлоор дамжуулан хөрвүүлэгджээ (Алма 22:18–26). Хааны хөрвүүлэлт нь мянга мянган хүнийг Их Эзэний тухай мэдлэгтэй болгоход номлогчдод тусалсан ба тэрээр энэ хөрвүүлэлтийнхээ дараа юу хийсэн бэ? (Алма 22:26; 23:1–6-г үз.) Нэг хүний хөрвүүлэлт бусад олон хүмүүст сайнаар нөлөөлсөн ямар тохиолдлыг та нар мэдэх вэ?

Дүгнэлт

Бидний одоогийн номлолын ажлаа хийх арга маань Аммон болон Аароныхтай ижил төстэй гэдгийг цохон тэмдэглэ. Номлогчдод итгэл дээр тогтсон харилцаа, Сүнсийг дагах, судруудаас гэтэлгэлийн төлөвлөгөөг заахыг уриалдаг.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Зорилго Ангийн гишүүдийг өөрсдийнхөө хөрвүүлэлтийг хүчирхэгжүүлж, хөрвүүлэгдэхэд нь бусдад туслах хүслээ нэмэгдүүлэхэд урамшуулна.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Алма 23–24. Мозаягийн хөвгүүдээр заалгасныхаа дараа мянга мянган Лэмэнчүүд хөрвүүлэгддэг. Хөрвүүлэгдсэн Лэмэнчүүд өөрсдийгөө Антай-Нифай-Лихайчууд гэж нэрлэх болсон. Бурханд гэрчлэл болгон, үхсэн ч дахин хэзээ ч нүгэл үйлдэхгүй гээд Антай- Нифай-Лихайчууд зэвсгээ булж Лэмэнчүүдийн цэргийг дайрахад зэвсгээ авахаас татгалздаг.
 - б. Алма 27–28. Аммон Антай-Нифай-Лихайчуудыг удирдан аюулгүй газар эрж Нифайчуудын дунд аваачдаг. Нихайчууд Антай-Нифай-Лихайчуудад Жэршоны нутгийг өгч дайснаас хамгаалахаа амладаг. Лэмэнчүүд дахиад л Нихайчуудтай байлдахаар ирдэг боловч ялагддаг.
 - в. Алма 26, 29. Аммон ахан дүүсийнхээ хамт Лэмэнчүүдэд номлосноо тоймлоод Их Эзэнийг бахархан магтав. Алма наманчлалаар мөн гэтэлгэлийг төлөвлөгөөгөөр дамжин ирэх баяр баясгаланг хүсдэг.
2. Антай-Нифай-Лихайчууд Зэр Зэвсгээ Булсан нь (62565; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 311) зураг байгаа бол хичээлдээ хэрэглэхээр бэлтгэ.

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Ангийн гишүүдээс асуу:

- Ямар зан чанар буюу биеэ авч явах байдал нь жинхэнээсээ хөрвөгдөгсдийг ялгаатай харагдуулдаг вэ?

Энэ хичээлээр Их Эзэнд маш их гүн хөрвүүлэгдэж бүр судруудад “хэзээ ч итгэл алдраагүй” (Алма 23:6) хэмээн бичигдсэн хэсэг хүмүүсийн тухай ярилцана гэдгийг тайлбарла.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Антай-Нифай-Лихайчууд Их Эзэнд хөрвүүлэгддэг.

Алма 23–24-ийг ярилц. Ангийн гишүүдийг сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь. Бүх Лэмэнчүүдийн хаан байсан Лэмонайн эцэг Аароны сургаалуудаар дамжуулан хөрвүүлэгдсэнийг ангийн гишүүдэд сануул (Алма 22).

- Лэмэнчүүдийн хаан хөрвүүлэгдсэнийхээ дараа яасан бэ? (Алма 23:1–2.) Тэр яагаад үүнийг хийсэн бэ? (Алма 23:3-ыг үз.) Энэ тунхаглалын үр дүнд юу болж мөн Аарон болон түүний ахан дүүс юу хийсэн бэ? (Алма 23:4–7-г үз.)
- Хөрвүүлэгдсэн Лэмэнчүүдийн ямар үйлдэл тэднийг жинхэнээсээ болон үнэн сэтгэлээсээ хөрвүүлэгдсэнийг харуулсан бэ? (Ангийн гишүүдийн хариултуудыг самбарт дүгнэн бич. Зарим хариултыг ярилцлагыг өрнүүлэх асуултуудын хамт дор жагсаав.)
 - а. Тэд “Их Эзэнд хөрвүүлэгдсэн” (Алма 23:6). Есүс Христ бидний хөрвүүлэлтийн төвд байх нь яагаад зайлшгүй хэрэгтэй вэ? Өөр ямар шалтгааны улмаас хүмүүс Сүмд татагдаж болох вэ? (Хариултанд номлогчдын зан чанар, нөхдийн нөлөө эсвэл сонирхолтой олон нийтийн хөтөлбөр орсон байж болно.) Яагаад эдгээр зүйлүүд нь дангаараа жинхэнэ хөрвүүлэлтийг авчирч чадахгүй вэ?
 - б. Тэд “ах дүүсээсээ ялгагдах . . . хүсэлтэй байлаа” (Алма 23:16). Хөрвүүлэгдсэн Лэмэнчүүд ёсон бус байдалдаа үлдсэн ахан дүүсээс өөрсдийгөө ялгагдахыг ямар аргаар сонгосон бэ? (Алма 23:16–18; 27:27–30.) Бид хөрвүүлэгдэхээрээ дэлхийгээс юугаараа ялгагддаг вэ? Бид өөрсдийгөө ийм байдлаар ялгаруулах нь яагаад чухал вэ?
 - в. Тэд сорилт болон зовлон тохиолдох үедээ ч гэсэн Бурханд талархлаа илэрхийлдэг (Алма 24:6–10, 23). Антай-Нифай-Лихайчууд хөрвүүлэгдсэнийхээ улмаас ямар ямар зовлон зүдгүүртэй тулгарсан бэ? (Алма 24:1–2, 20–22; 27:1–3-ыг үз.) Эдгээр зовлон зүдгүүрийг эс тооцвол тэд юуны төлөө талархаж байсан бэ? (Алма 24:7–10-ыг үз.) Бурханд талархах нь сорилт, зовлон зүдгүүрийг давахад бидэнд хэрхэн тусалдаг вэ?
 - г. “Тэд сэлэмнүүдээ. . . авч, . . . газрын гүнд булшилсан болой” (Алма 24:15–17). Та Антай-Нифай-Лихайчуудын зургийг ашиглаж байгаа бол түүнийгээ одоо үзүүл. Антай-Нифай-Лихайчууд сэлэмнүүд болон бусад зэвсгээ яагаад булшилсан бэ? (Алма 23:7; 24:11–13, 18–19-ийг үз.) Тэд зүгээр л зэвсгээ хэрэглэхгүй гэж амлах бус харин булшилсан нь яагаад чухал ач холбогдолтой вэ? Заримдаа бид хэрхэн “Бурханы эсрэг босдог” вэ? Бид “бослогынхоо зэвсгийг” булшлахын тулд юу хийж болох вэ?
 - д. Тэд ахан дүүстээ “агуу их хайраа” үзүүлсэн (Алма 26:31). Антай-Нифай-Лихайчуудын зэвсгээ булшлах шийдвэр нь тэдний Бурханыг мөн андаа хайрлах хайрыг хэрхэн харуулсан бэ? (Алма 24:18; 26:32–34-ийг үз.) Хөрвүүлэлт нь бусдыг хайрлах хайрыг ямар арга замаар өсгөдөг вэ?
- Антай-Нифай-Лихайчуудыг тэдний эсрэг зэвсгээ авахгүй байхыг нь хараад хөрвүүлэгдээгүй Лэмэнчүүд яасан бэ? (Алма 24:20–27-г үз.) Мормоны хэлснээр бид энэ ишлэлээс юу сурч чадах вэ? (Алма 24:27-г үз; Мормоны ажиглалтыг “тийн бид” гэсэн үгээр эхлүүлэн унш.)

2. Антай-Нифай-Лихайчууд аюулгүй газрыг Нифайчуудын дунд эрдэг.

Алма 27–28-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Аммон болон түүний ахан дүүс Антай-Нифай-Лихайчуудыг Нифайчуудын амьдардаг Зарахэмлагийн нутаг руу явахыг яагаад ятгасан бэ? (Алма 27:1–5-ыг үз.) Хаан хүмүүсээ Зарахэмла руу аваачихаас яагаад эмээж байсан бэ? (Алма 27:7–14-ийг үз.) Их Эзэнд итгэх итгэл маань биднийг айдас төрүүлсэн нөхцөлтэй тулгарахад хэрхэн туслах вэ?
- Аммон Нифайчуудаас Антай-Нифай-Лихайчуудыг нутаг руугаа оруулахыг гуйхад тэд яасан бэ? (Алма 27:20–26-г үз.) Нифайчууд Антай-Нифай-Лихайчуудад Их Эзэнтэй хийсэн гэрээгээ сахихад нь хэрхэн тусалсан бэ? Бид бусдад Их Эзэний хөрвүүлэлтэндээ үлдэхэд хэрхэн тусалж чадах вэ?

Антай-Нифай-Лихайчуудыг Жэршонд суурьшсан цагаас хойш Тэднийг Аммоны хүмүүс хэмээн мэддэг байжээ (Алма 27:26). Мормоны Номын үлдсэн бусад хэсэгт буюу энэхүү Сайн Мэдээний Номлолын сургалтын бусад хэсэгт тэднийг Аммоны хүмүүс буюу Аммончууд гэж нэрлэх болно.

- Антай-Нифай-Лихайчуудыг Жэршонон нутагт суурьшсаны дараа маш эмгэнэлтэй ямар явдал болсон бэ? (Алма 28:1–3-ыг үз.) Энэ агуу их тулалдааны дараа тулалдаанд үрэгдэгсдийнхээ төлөө олон хүн гашуудаж байлаа (Алма 28:4–6). Гашуудагчдын зарим нь айж байхад зарим нь яагаад баярлаж байсан бэ? (Алма 28:11–12-ыг үз.) Эдгээр хариунуудаас бид юу сурч болох вэ? (Алма 28:13–14-ийг үз.)

3. Аммон, Алма хоёр Их Эзэний ажлыг дуусгасандаа баярладаг.

Алма 26, 29-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Алма 26 нь Аммоны ахан дүүсийнхээ хамт Лэмэнчүүдэд сайн мэдээг авчирсан тухай Аммоны мэдрэмжийг тэмдэглэсэн байдаг гэдгийг онцлон тэмдэглэ. Алма 29 нь Аммоны ахан дүүсийнхээ хамт олсон амжилтын талаарх Алмагийн мэдрэмж болон бүх хүмүүс сайн мэдээг сонсож хүлээн аваасай гэсэн Алмагийн хүслийг илэрхийлдэг.

- Их Эзэн Аммон болон түүний ахан дүүст ямар “агуу их адислалыг” өгсөн бэ? (Алма 26:1–9-ийг үз.) Бид хэрхэн “Бурханы мутар дахь түүний агуу үйлсийг бүтээх үр нөлөөтэй зэмсэг” болж чадах вэ? (Алма 26:22-ыг үз.)
- Аарон Аммоныг бардамнасных нь төлөө зэмлэхэд тэр хэрхэн хүлээн авсан бэ? (Алма 26:10–16, 35–37-г үз.) Бид хэрхэн “Бурханаараа бардамнаж” “Их Эзэнийхээ нэрийг алдаршуулж” болох вэ? Их Эзэн Түүний ажлыг дуусгахад нь туслахын тулд ямар ямар арга замаар та нарт илүү хүч нэмж адислаж байсан бэ?
- Аарон ба ахан дүүсийг анх Лэмэнчүүдэд номлох тухайгаа мэдэгдэхэд Зарахэмла дахь хүмүүс үүнд хэрхэн хандсан бэ? (Алма 26:23–25-ыг үз.) Бид хүмүүсээр өөрсдөөр нь сайн мэдээг хүлээж авах, авахгүйг нь шийдүүлэхийн оронд өмнөөс нь урьдчилан шийддэг хүмүүсийн тухай энэхүү нөхцөлөөс юу сурч болох вэ? Бид хэрхэн иймэрхүү хандлагыг даван гарч чадах вэ?
- Бид зовлон зүдгүүрт яаж хандах ёстойгоо Аммон болон түүний ахан дүүсээс хэрхэн сурч чадах вэ? (Алма 26:27–30-ийг үз.) Тэвчээр болон Их

Эзэнд итгэх итгэл нь хэцүү нөхцөл байдлаас сайныг олоход та нарт хэрхэн тусалж байсан бэ?

- Алма яагаад сахиулсан тэнгэр байхыг хүссэн бэ? (Алма 29:1-ийг үз.) “Хүн бүр” наманчилж Бурханд ирвэл үр дүнд нь юу болно гэж Алма хэлсэн бэ? (Алма 29:2, Алма 28:14-ийг үз.) Сайн мэдээгээр амьдрах нь бидний амьдралд баяр хөөр авчирдаг гэдгийг ямар тохиолдлоос та нар сурсан бэ?
- Алма сахиулсан тэнгэр байхыг хүссэн хүсэлдээ өөрийгөө нүгэл үйлдсэн гэж яагаад бодсон бэ? (Алма 29:3, 6–7-г үз.) Бид өсч, өөрсдийгөө сайжруулахаар чармайхдаа Их Эзэний бидэнд өгсөн зүйлүүдэд хэрхэн сэтгэл ханамжтай байж болох вэ?
- Бурхан “хүслийн дагуу, тэр нь үхэлд эсвэл амьдралд хүргэх байлаа ч түүнийг хүмүүнд” өгдөг гэж Алма хэлсэн (Алма 29:4). Энэ нь ямар утгатай вэ? (2 Нифай 2:27-г үз.)
- Алма Их Эзэний, түүний төлөө болон эцэг өвгөдийнх нь төлөө хийсэн зүйлүүдэд баясдаг (Алма 29:10–13). Их Эзэн та нарт болон та нарын гэр бүлийнхэнд баярлах ямар ямар зүйлүүдийг хийсэн бэ? (Ангийнхныг анги дотроо хуваалцахыг хүсээгүй зүйлүүдэд дотроо тунгаан бодохыг урь.)

Дүгнэлт

Антай-Нифай-Лихайчууд жинхэнээсээ хөрвүүлэгдсэнийг харуулсан арга замуудыг дүгнэж үз. Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэ санааг хичээлдээ хэрэглэж болно.

Номлогчийн ажил хайр, баяр баясгаланг тэтгэдэг

Аммон номлогчид болон тэдний заадаг хүүмүүсийн хоорондын хайр, баяр баясгаланг онцолсон (Алма 26:1–4, 9, 11, 13, 30–31, 35). Ангийн гишүүдийг тэдэнд сайн мэдээг заасан хүмүүст мэдэрч байгаа хайраа илэрхийлэхийг, мөн бусадтай сайн мэдээг хуваалцахад мэдэрсэн баяр баясгалангаа илэрхийлэхийг урь.

Зорилго Ангийн гишүүдэд хуурамч сургаалыг хэрхэн таньж, илчилж, Есүс Христийн гэрчлэлдээ үнэнч үлдэхийг сурахад туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Алма 30:1–18. Христийг эсэргүүцэгч Корихор Зарахэмла дахь олон хүний зүрх сэтгэлийг “Христ үгүй” “хүний хийсэн зүйлд нүгэл үгүй” хэмээн замаас нь холдуулдаг.
 - б. Алма 30:19–60. Корихор Жэршон болон Гидеоны нутагт номлохыг оролддог. Хүмүүс түүнийг сонсохыг хүсэхгүй удирдагчдынхаа өмнө аваачдаг. Тэгээд дараа нь түүнийг Алмагийн өмнө аваачихад тэр Христийн ирэлт болон Бурхан байдгийг түүнд гэрчилдэг. Корихор тэмдгүүдийг шаардсан ба “цочирдон хэлгүй болдог.”
 - в. Алма 31. Алма хуурамч сүсэг, бардамнах хэлбэртэй бишрэлийг өөртөө авсан урвагч Зорамчуудыг буцаан залруулах номлолыг толгойлдог.
2. Ангийн нэг гишүүнд Алма 31:15–18-ыг, нөгөөд нь Алма 31:26–35-ыг уншиж бэлтгэхийг хүс.

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Байдаг боловч тэдний хэзээ ч очиж байгаагүй газрыг ангийн гишүүдээр бодуул.

- Та нар яагаад энэ газрыг байдаг гэдэгт итгэж байна вэ?

Энэ хичээлээр биднийг үзээгүй зүйлүүдээ мэдэж чадахгүй гэсэн хүний тухай ярилцахаа хэл. Корихор Бурханыг үзээгүй хүн Түүнийг байгаа гэдгийг мэдэж чадахгүй хэмээн маргаж байлаа. Гэвч бидэнд, үзээгүй газруудыг байдаг гэж мэдэхэд маань тусалдаг бусдын мэдээлэл байдагтай адил бидэнд Бурхан байдаг ба Түүний сайн мэдээ үнэн гэдгийг мэдэхэд тусалдаг бошиглогчдын гэрчлэл, судрууд болон Ариун Сүнсний бэлэг байдаг.

Өнөөдөр дэлхийд Корихорын сургаал нийтлэг байдаг хэмээн цохон тэмдэглэ. Хүмүүс түүний худал хуурмаг зүйлүүдэд хэрхэн хандсаныг ойлгох нь бидэнд хуурамч гүн ухаан болон санаануудтай тулгарахад тусалж чадна.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын

зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Корихор Зарахэмла дахь олон хүний зүрх сэтгэлийг замаас нь холдуулдаг.

Алма 30:1–18-ыг ярилц. Ангийнхныг сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь. Жэршоны нутагт Аммоны улсыг байгуулж Лэмэнчүүдийг хөөсний дараа Нифайчууд шүүгчдийн засаглалын 16, 17 дахь жилийн ихэнхэд нь амар тайван амьдарч байв.

- 17 дахь жилийн төгсгөл хавьд хүмүүсийн амар тайван байдлыг эвдэх юу тохиолдсон бэ? (Алма 30:6, 12.) Христийг эсэргүүцэгч гэж юу вэ? (Христийг эсэргүүцэгч гэдэг нь “үнэн сайн мэдээг буюу авралын төлөвлөгөөг хуурамч болгодог мөн Христийн эсрэг ил тод эсвэл нууцаар эсэргүүцэл илэрхийлдэг хүн эсвэл ямар нэгэн зүйл” гэж хэлсэн Bible Dictionary, “Antichrist,” 609-ийг үз.)
- Зарахэмлагийн хүмүүсийн дунд Корихор ямар ямар хуурамч номлол тарааж байсан бэ? (Энэ асуултын хариуг олохын тулд ангийн гишүүдээр Алма 30:12–18-ыг уншуул. Зарим хариултыг доор үзүүлсэн болно.)
 - а. “Христ байх нь үгүй. . . . Та нар харахгүй байгаа тэр зүйлүүдийг мэдэж чадахгүй; тиймийн тул та нар Христ байх болно гэдгийг мэдэж чадахгүй” (Алма 30:12–15). Та Анхаарал татах үйл ажиллагааг ашиглаж байгаа бол түүн рүү хандаж бидний хараагүй боловч байгаа гэж мэдэж байгаа зарим зүйлүүдийг товч ярилц.
 - б. “Нэг ч хүн ирэх зүйлийн тухай юу ч мэдэхгүй” (Алма 30:13). Нэг ч хүн ирэх зүйлийн тухай юу ч мэдэхгүй боловч Христ байх нь үгүй хэмээн тунхаглах нь Корихорын хувьд зөрчилдөөнтэй гэдгийг цохон тэмдэглэ.
 - в. Цагаатгалд итгэх нь “галзуурсан сэтгэлийн нөлөө” (Алма 30:16).
 - г. “Хүн бүр өөрийн суу билгийн дагуу дэгжиж, хүн бүр өөрийн хүчний дагуу ялан дийлдэг” (Алма 30:17).
 - д. “Хүмүүний хийсэн юу боловч гэмт хэрэг бус” (Алма 30:17).
 - е. “Хүн үхэхэд түүний төгсгөл нь тэр” (Алма 30:18).
- Корихорын номлол түүнийг сонсож байсан хүмүүст ямар нөлөө үзүүлсэн бэ? (Алма 30:18-ыг үз.) Эдгээр номлол хүмүүсийг яагаад нүгэл рүү хөтлөх вэ? Есүс Христ, Цагаатгал болон үхлийн дараах амьдралын тухай мэддэг байх нь бидний өдөр тутмын сонголтонд ямар байдлаар нөлөөлдөг вэ?

2. Корихорыг Алмагийн өмнө авачихад тэр Христийн ирэлтийг түүнд гэрчилдэг.

Алма 30:19–60-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Корихор хуурамч номлолоо Зарахэмлад тараасныхаа дараа үүнийгээ Жэршон болон Гидеоны хүмүүсийн дунд номлохыг оролдсон гэж тайлбарла. Зарахэмла дахь хүмүүсийг бодвол эдгээр хүмүүс Корихор шиг хүмүүстэй тулахдаа хэрхэн хариулах ёстойн сайн жишээ болсон. Самбарт *Өнөөгийн Корихоруудтай Харьцах нь* гэж бич. Үүнийгээ дор нь энэ хэсэгт ярилцах үед гарсан санаануудыг жагсаа.

- Корихор хуурамч номлолоо Аммоны хүмүүсийн дунд тараахыг оролдоход тэд яасан бэ? (Алма 30:19–21-ийг үз.) Тэдний үйлдэл Зарахэмла дахь

Нифайчуудыг бодвол “илүү ухаалаг” байсныг хэрхэн харуулж байна вэ? (Зарахэмла дахь хүмүүс Корихорын хуурамч номлолыг сонсож байсан; Аммоны хүмүүс болон Гидеоны хүмүүс сонсоогүй.) Бид иймэрхүү төстэй нөхцөлүүдэд яаж илүү ухаалаг, ялгах чадвартай байж чадах вэ? (Самбар дээрх гарчгийн дор *Ухаалаг байх* гэж бич.)

- Корихор Сүмийн удирдагчдын эсрэг ямар хуурамч ял тулгасан бэ? (Алма 30:23–24, 27–28, 31-ийг үз.) Тэр яагаад үүнийг хийсэн гэж та нар бодож байна вэ? Сүмийн удирдагчдаа дуулгавартай дагах нь үнэн хэрэгтээ биднийг хэрхэн Корихорын хэлж байгаагаар боолчлох бус харин чөлөөлдөг вэ?
- Корихорын Сүмийн удирдагчдын эсрэг хуурамч ял тулгахад Алма хэрхэн хариулсан бэ? (Алма 30:32–35-ыг үз. Самбарт *Үнэнийг мэдэх* гэж бич.) Үнэнийг мэдэх нь биднийг хуурамч сургаалтай тулгарахад хэрхэн тусалж чадах вэ?
- Алма Корихорын Бурхан гэж үгүй гэсэн үгэнд хэрхэн хариулсан бэ? (Алма 30:39. Самбарт *Хувийн гэрчлэлээ хуваалц* гэж бич.) Есүс Христийн тухай гэрчлэлээ хэлэхдээ бид хэрхэн адислагддаг вэ?
- Алма Корихорын тухай юуг ялгаж мэдэх чадвартай байсан бэ? (Алма 30:42-ыг үз.) Бид үнэний болон хуурамч номлолуудыг хэрхэн ялгаж чадах вэ? (Моронай 10:5-ыг үз. Самбарт *Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийл* гэж бич.)
- Корихор Бурхан байдаг гэсэн тэмдэг шаардахад Алма Бурхан байдгийг гэрчилсэн ямар тэмдгүүдийг хэлсэн бэ? (Алма 30:44-ийг үз. Алма “бүх ахан дүүстээ” бошиглогчид, судрууд болон “бүх зүйлүүдийн” гэрчлэлийг хэлсэн. Самбарт *Үнэнийг бошиглогчдоос мөн судруудаас заа* гэж бич.) Эдгээр гэрчлэлүүд та нарт итгэлээ хүчирхэгжүүлэхэд хэрхэн тусалсан бэ?
- Алма гэрчилсний дараа ч Корихор тэмдгүүд үзүүлэхийг шаардсаар байв (Алма 30:45). Корихор ямар тэмдэг хүлээн авсан бэ? (Алма 30:49–50-ийг үз.) Яагаад энэхүү тэмдэг өгөгдсөн бэ? (Алма 30:47-г үз.) Хууртагдсан байсныг нь Корихорт мэдэгдэхэд тэр чөтгөрийг дагах болсон шалтгаанаа юу гэж тайлбарласан бэ? (Алма 30:53.)
- Эцэст нь Корихорт юу болсон бэ? (Алма 30:54–56, 58–59-ийг үз.) Мормон яагаад Корихорын явдлыг ялтсуудынхаа хураангуйлалд багтаасан гэж та нар бодож байна вэ? Энэхүү явдал нь бидэнд Их Эзэний замаас төөрөгдүүлэхийг оролдогсдын хувь тавилангийн тухай юу заадаг вэ? (Алма 30:60-ыг үз.)

3. Алма урвагч Зорамчуудыг буцаан залруулах номлолыг удирддаг.

Алма 31-ийн сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Алма яагаад Зорамчуудыг буцаан залруулахаар номлолд явахаар шийдсэн бэ? (Алма 31:1–6-г үз. Тэд хуурамч бурхад шүтсэнд үүний санаа зовсон. Түүнээс гадна, Нифайчууд Зорамчуудыг Лэмэнчүүдтэй нийлэх эсэх талаар санаа зовж байсан.) Алма болон түүний ахан дүүс Бурханы үгийг номлох ёстой гэдэгт яагаад итгэж байсан бэ? (Алма 31:5-ыг үз.) Бурханы үг хүмүүсийн амьдралд өөрчлөлт авчрахыг та нар хэрхэн харсан бэ?

- Зорамчууд Сүмийн гишүүд байсан боловч тэд “их төөрөгдлүүдэд унасан” байлаа (Алма 31:8–9). Тэд яагаад урвалтанд унасан бэ? (Алма 31:9–11-ийг үз.) Хувь хүний урвалтын эсрэг манаанд бид хэрхэн зогсох вэ?
- Алма болон түний ахан дүүс Зорамчуудын сүсэглэх маягийн талаар юу мэдсэн бэ? (Алма 31:12–23-ыг үз. Та тэдний буруу сүсэглэхээс гадна “тэд гэртээ эргэж очоод. . . дахин цугларах хүртлээ Бурханыхаа тухай дахин огт ярьдаггүй” байсан гэдгийг нь онцолж болно.) Энэхүү буруу шүтлэгийн гэрч болоод Алма болон түүний ахан дүүс яасан бэ? (Алма 31:19, 24-ийг үз.)

31-р бүлэг нэг нь Зорамчуудын, нөгөө нь Алмагийн гэсэн хоёр залбирлыг агуулдаг гэдгийг тайлбарла. Урьдчилан даалгасан ангийн гишүүдээр залбирлуудыг уншуул (“Бэлтгэл”-ийн 2-ыг үз.) Тэднийг унших хооронд ангийн хоёр гишүүнийг залбирлуудын ялгааг бодож байхыг хүс. Залбирал тус бүрийн зарим гол санааг дор жагсаасан болно.

Зорамчуудын Залбирал

Бурхан бол сүнс байсан, одоо ч байгаа, мөн үүрд ч тийм байх болно” (Алма 31:15).

“Ах дүүсийнхээ тэр уламжлалуудад бид итгэдэггүй” (Алма 31:16).

“Христ гэж үгүй байх болно” (Алма 31:16).

“Биднийг аврагдсан байхаар сонгосон” боловч бусад бүх хүмүүс “доош тамд хаягдана” (Алма 31:17).

Бусад нь “мунхаг уламжлалуудад” хүлэгдсэн (Алма 31:17).

“Бид сонгогдсон мөн ариун хүмүүс” (Алма 31:18).

Алмагийн Залбирал

“Өөрийн сул дорой байдалд тэвчээртэй хандах хүчийг та надад өгөөч” (Алма 31:30).

“Та бодгалийг минь Христээр тайтгаруулна уу” (Алма 31:31).

“Надад амжилтыг өгнө үү, түүнчлэн надтай хамт буй миний хамтран ажиллагчдад ч буюу” (Алма 31:32).

“Тэдний бодгалиудыг [хамтран ажиллагчдыг] Христээр тайтгаруулаач” (Алма 31:32).

Зорамчуудыг “танд авчрахад” туслаач (Алма 31:34–35).

Зорамчуудын “бодгаль нь эрхэм үнэт” (Алма 31:35).

“Хүч чадал мөн мэргэн ухааныг бидэнд өгөөч” (Алма 31:35).

- Алмагийн залбирал Зорамчуудын залбирлаас юугаараа ялгаатай вэ? (Та бардамнал, хувиа хичээсэн байдал, Зорамчуудын итгэлгүй байдлыг Алмагийн төлөв түвшин байдал, бусдыг хайрлах хайр болон итгэлд нь сөргүүлэн тавьж болно.)
- Зорамчуудын ямар хандлага нь тэдэнд Христэд итгэх итгэлтэй байхад нь хамгийн том саад болж байна вэ? (Алма 31:24–29-ийг үз.) Бардамнал нь бидний бишрэлд хэрхэн нөлөөлдөг вэ? (Алма 15:17, 34:38; С ба Г 59:21-ийг үз.) Бардамнал нь авралд хүрэхэд яагаад саад болдог вэ?
- Зорамчуудын бусармаг байлаас болж Алмагийн “зүрх сэтгэл гашуудсан”. Тэрээр ахан дүүсийнхээ хамтаар тэднийг “дахин Христэд . . . авчрахын” төлөө залбирав (Алма 31:24, 34). Өнөөдөр бид Есүс Христийн сургаалаас холдсон нөхөддөө туслахын тулд ямар үүрэг хариуцлага хүлээдэг вэ?

(3 Нифай 18:32-ыг үз.) Биднийг номлолд үйлчлэх эсвэл төрөл бүрийн дуудлагаа гүйцэтгэхэд маань залбирал бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

- Алма болон түүний ахан дүүс хэрхэн адислагдсан бэ? (Алма 31:38-ыг үз.) Их Эзэн биднийг зөв зүйлийн төлөө итгэлтэйгээр залбирвал хэрхэн туслах вэ? (Ангийн гишүүдийг Их Эзэн тэднийг итгэлтэйгээр залбирахад нь адислаж байсан тохиолдлуудаасаа хуваалцахыг урь.)

Дүнэлт

Корихор болон Зорамчуудын философи нь өнөө үед өргөн дэлгэрсэн хэмээн онцол. Бидний “баяр баясгаланг сарниулахын” (Алма 30:22) тулд анги танхимаас авахуулаад ажлын байр, хэвлэл мэдээлэл, ном, заримдаа гэр маань Корихорын хуурамч номлолыг номлогчид байдаг. Мөн Зорамчуудын адилаар олон хүмүүс өнөөдөр зүрх сэтгэлээ “дэлхийн дэмий хоосон зүйлүүдэд” (Алма 31:27) зориулдаг. Ангийн гишүүдийг өдөр бүр Мормоны Номыг хичээнгүйлэн судалж, залбирч, Бурханы зарлигуудыг тасралтгүй дуулгавартай дагаж, өөрсдийгөө хүчирхэгжүүлэхэд урамшуулан уриал. Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

“Авралд Хүргэдэг Үг нь Христэд Буй”

Хичээл
28

Алма 32–35

Зорилго Ангийн гишүүдэд Бурханы үг тэднийг Есүс Христ рүү хөтөлдөг гэдгийг ойлгоход тусалж, тэднийг зүрх сэтгэлдээ “үгийг тэжээхэд” нь урамшуулна (Алма 32:40).

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Алма 32:1–27. Алма даруу Зорамчуудыг итгэлээ хөгжүүлж, зүрх сэтгэлдээ Бурханы үгэнд зай гаргахыг урамшуулдаг.
 - б. Алма 32:28–43. Алма Бурханы үгийг хүмүүсийн зүрх сэтгэлд суулгасан үртэй харьцуулдаг. Тэрээр хүмүүст уг үгийг маш их анхаарал халамж тавин тэжээснээрээ тэд нэгэн өдөр мөнхийн амьдралыг хүлээн авах болно гэдгийг заадаг.
 - в. Алма 33. Алма бошиглогчдын Есүс Христийн тухай гэрчлэлүүдийг иш татан хүмүүст Бурханы үгийг зүрх сэтгэлдээ суулгахыг уриалдаг.
 - г. Алма 34. Амюлек Есүс Христийн Цагаатгалыг гэрчилдэг. Тэрээр хүмүүст залбирч, наманчлалд итгэх итгэлээ хөгжүүлэхийг зарлигладаг.
2. Та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглэх гэж байгаа бол ангидаа үр авчир.

Хичээлийг Баяжуулах Зөвлөмж

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Авчирсан үрээ ангийнханд үзүүл. Ангийн гишүүдээр хэн нэгэн хүн тэдэнд энэ үрийг өгөөд үүнийг таривал маш их амттай үр жимс өгнө гэж хэллээ хэмээн төсөөлүүл.

- Энэ үр үнэхээр маш их амттай үр жимс өгөх эсэхийг мэдэхийн тулд та нар юу хийх вэ?

Энэ хичээлийг Алма 32-ыг ярилцаж эхэлнэ гэдгээ хэл. Энэхүү бүлэгт Бурханы үгийг үртэй харьцуулсан Алмагийн хэлсэн үг агуулагддаг. Тэрээр даруу Зорамчуудыг “зүрх сэтгэлдээ үр суулгах зай гаргахыг” ятгадаг (Алма 32:28). Тэд энэ үрийг тэжээх юм бол “хамгийн үнэтэй” болон “амттайгаас хамгийн амттай” амьдралын мод болон ургана гэж амладаг (Алма 32:40–42).

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Алма даруу Зорамчуудыг итгэлээ хөгжүүлж, зүрх сэтгэлдээ Бурханы үгэнд зай гаргахыг заадаг.

Алма 32:1–27-гоос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Алма, Амюлек болон тэдний ахан дүүс Зорамчуудын нэгэн сүм рүү орсон гэдгийг сануул. Зорамчууд тэндээ “Христ гэж үгүй байх болно” хэмээн тунхаглаж байхыг нь тэд сонссон (Алма 31:16–17). Энэ хуурамч сургаалыг сонсоод Алма, Амюлек болон тэдний ахан дүүс Бурханы үгийг номлож Христийг гэрчлэхээр хуваагдаж явсан (Алма 31:36–37; 32:1).

- Алмаг номлож байхад нь маш олон тооны Зорамчууд хүрч ирэв. Эдгээр Зорамчуудыг түүн дээр ирэхэд Алма яагаад ихэд баярласан бэ? (Алма 32:6–8-ыг үз.) Эдгээр хүмүүсийг Бурханы үгийг сонсоход бэлтгэхийн тулд юу болсон бэ? (Алма 32:2–5-ыг үз.)
- Зорамчууд албадлагаар даруу байх нь тэдэнд яагаад адислал байсан бэ? (Алма 32:12–13-ыг үз.) Албадлагаар даруу байснаас өөрөө өөрсдийгөө даруусгах нь яагаад дээр вэ? (Алма 32:14–16-г үз.) Бурханы үг биднийг өөрсдийгөө даруусгах байдал руу хэрхэн хөтөлж чадах вэ?
- Алма Зорамчуудад итгэлтэй байх талаар юу заасан бэ? (Алма 32:17–18, 21-ийг үз.) Бурханд итгэх итгэлээ хөгжүүлэхэд шаардлагатай эхний зүйлийг Алма юу гэж хэлсэн бэ? (Алма 32:22-ыг үз.) Бид Бурханы үгийг ямар арга замаар хүлээн авдаг вэ? (Алма 17:2; 32:23; С ба Г 1:38; 18:33–36-г үз.)
- Эдгээр үгсийг үнэн гэдгийг мэдэхийн тул Алма сонсогчдоо юу хийхийг урамшуулсан бэ? (Алма 32:26–17-г үз.) “Сэрж чадвараа сэргээх” гэдэг нь ямар утгатай вэ? Бид Бурханы үгэн дээр хэрхэн “туршиж” чадах вэ? (Иохан 7:17-г үз.) Та нарыг үгэн дээр туршихад юу тохиолдож байсан бэ?

2. Алма хүмүүст Бурханы үгийг зүрх сэтгэлдээ тэжээхийг заадаг.

Алма 32:28–43-ыг уншаад ярилц.

- Алма Бурханы үгийг хүмүүсийн үртэй харьцуулахдаа Зорамчуудад “зүрх сэтгэлдээ үрийг суулгаж болох зай гаргахыг” зөвлөсөн (Алма 32:28). Бид зүрх сэтгэлдээ Бурханы үгэнд “зай гаргахын” тулд юу хийх ёстой вэ?
- Алмагийн хэлсэнчлэн Бурханы үг зүрх сэтгэлд нь суулгагдахад хүмүүс юу мэдэрч эхэлсэн бэ? (Алма 32:28–31, 33–35-ыг үз. Та самбарт ангийн гишүүдийн хариуг жагсааж бичиж болно.) Та нар үг “цээж дүүргэхийг” мэдрэх гэдэг нь юу гэсэн утгатай гэж бодож байна вэ? Судрууд хэрхэн зүрх сэтгэлийг томруулж, ойлголтыг маань гэгээрүүлж, оюун санааг маань тэлдэг вэ? (Алма 37:8–9-ийг үз.) Бурханы үг та нарт ямар байдлаар амттай байдаг вэ?
- Бурханы үг бидний зүрх сэтгэлд ургаж эхлэхэд бид юуг үргэлжлүүлэн хийх ёстой вэ? (Алма 32:37-г үз.) Бид үгийг хэрхэн “маш их анхаарал халамж тавин тэжээж” чадах вэ? (Алма 32:41-ийг үз.) Бидний зүрх сэтгэлд “үндэслэн” ургах гэдэг нь ямар утгатай вэ? (Алма 32:37).
- Үг бидний зүрх сэтгэлд ургаж эхэлснийх нь дараа бид үгийг ойшоохгүй, тэжээхгүй байвал юу болох вэ? (Алма 32:38–40-ийг үз.) Бидний хөрс буюу зүрх сэтгэл маань үржил шимтэй байхын тулд бид юу хийж болох вэ?
- Энэ ярианыхаа дараа Алма үгийг үрнээс ургасан модтой харьцуулсан (Алма 32:37). Тэр ямар модны тухай хэлсэн бэ? (Алма 32:40–42-ыг үз.)

Лихай ба Нифайн харсан амьдралын модны үзэгдлийг товч хэл. Ангийн гишүүдэд амьдралын мод бол Есүс Христийг бэлэгддэг гэдгийг сануул (тус гарын авлагын х. 13-ыг үз). Энэ үзэгдэлд Бурханы үгийг төмөр бариулаар төлөөлүүлдэг бол Алмагийн ярианд үрээр төлөөлүүлж амьдралын модоор төлөөлүүлсэн Аврагч руу хөтөлдөг.

Алма 32-ын тухай ярихдаа Ахлагч Жеффри Р.Холланд ингэж заасан, “Энэхүү гайхамшигт яриандаа Алма үрээр дүрсэлсэн Бурханы үгэнд итгэх итгэлийн тухай ерөнхий санаанаас Бурханы Үг болох Христэд итгэх итгэлийн тухай яриан дээр уншигчийг төвлөрүүлэн хөтөлдөг” (*Christ and the New Covenant* [1997], 169).

- Амьдралын модны жимс юу вэ? (Мөнхийн амьдрал. Алма 32:41; 33:23; мөн 1 Нифай 15:36; С ба Г 14:7-г үз.)

3. Алма бошиглогчдын Есүс Христийн тухай гэрчлэлүүдийг иш татан хүмүүст Бурханы үгийг зүрх сэтгэлдээ суулгахыг уриалдаг.

Алма 33-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Хүмүүс Алмагийн яриаг сонссоныхоо дараа “ямар маягаар тэд итгэлээ хөгжүүлж эхэлбэл зохихыг” мэдэхийг хүссэн гэж тайлбарла (Алма 33:1). Алма Зинос, Зинок, Мосе зэрэг бошиглогчдын Есүс Христийн тухай сургаалуудыг иш татан хариулсан.

- Алма Зиносын ямар сургаалыг Зорамчуудад заасан бэ? (Та ангийнхнаар Алма 33:3–11-ийн шүлгүүдийг ээлжлүүлэн уншуулж болно.) Алма ямар зорилготойгоор залбирлын тухай Зеносын сургаалыг иш татсан бэ? (Алма 33:11–14-ийг үз. Тэр Зорамчуудад Бурханы Хүүд итгэлээ хөгжүүлэхийг заахыг хүссэн. “[Түүний] Хүүгийн улмаас” л Тэнгэрлэг Эцэг бидний залбирлуудыг сонсож Өөрийнхөө шүүлтийг биднээс буцаадаг.)
- Бошиглогч Зинок бас Христийн тухай гэрчилсэн гэж Алма хэлсэн (Алма 33:15). Зинок юу заасан бэ? (Алма 33:16-г үз.) Энэ нь яагаад Зорамчуудад хамаарах ёстой чухал сургаал вэ? (Алма 31:12, 16–17-г үз.)
- Алма Мосегийн хийж аглаг буйд өргөж өлгөсөн хүрэл могойн тухай ярьсан (Алма 33:19; Тоолууд 21:9-ийг үз). Энэхүү могой хэрхэн Есүс Христийн нэгэн хэлбэр буюу бэлэгдэл болсон бэ? (Алма 33:19; Иохан 3:14–16; Хиламан 8:13–15-ыг үз.) Алмагийн хүрэл могойн тухай ишлэл бидэнд Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэх талаар юу заадаг вэ? (Алма 33:20–23; Алма 37:46-г үз.)

4. Амюлек Есүс Христийн Цагаатгалыг гэрчилдэг. Тэрээр хүмүүст залбирч, наманчлалд итгэх итгэлээ хөгжүүлэхийг зарлигладаг.

Алма 34-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Алма ярьсны дараа Амюлек босч хүмүүст зааж эхэлсэн.

- Алма, Амюлек хоёр хүмүүс Христэд итгэх эсэх талаар асуулттай хэвээр байгааг мэдэрсэн (Алма 34:2–5). Амюлек энэ асуултанд хэрхэн хариулсан бэ? (Алма 34:6–8-ыг үз.) Христийн тухай ийм хүчтэй гэрчлэлийг хэрхэн хүлээж авах вэ? Судрууд, бошиглогчид болон Христийн тухай бусад гэрчүүд Түүний тухай та нарын гэрчлэлийг хэрхэн хүчирхэгжүүлсэн бэ?
- Есүс Христийн Цагаатгалгүйгээр “бүх хүн төрөлхтөн яагаад гарцаагүй мөхөх ёстой” вэ? (Алма 34:8–9; мөн Алма 22:14-ийг үз.) Есүс яагаад дэлхийн нүглүүдийн төлөө цагаатгагдаж биднийг Уналтын нөлөөнөөс

аварч болох цорын ганц хүн байсан бэ? (Алма 34:10–12-ыг үз.) Цагаатгал бол “хэмжээлшгүй мөн үүрдийн золиослол” гэсэн Амюлекийн сургаал ямар утгатай вэ? (34:14–16-г үз.)

Ахлагч Брүс Р.МакКонки ингэж заасан: “Хүн өөрөө дахин амилж чадахгүй; хүн өөрөө өөрийгөө аварч чадахгүй; хүний хүч чадал бусдыг аварч чадахгүй; хүний хүч чадал бусдын нүглийн төлөө цагаатгаж чадахгүй. Гэтэлгэлийн ажил нь хэмжээлшгүй мөн үүрдийн байх ёстой; энэ нь хэмжээлшгүй нэгнээр хийгдэх ёстой; Бурхан өөрөө дэлхийн нүглүүдийн төлөө цагаатгах ёстой”(A New Witness for the Articles of Faith [1985], 111–12).

- Та нар Алма 34:17–29 дахь зөвхөн синагогад, мөн зөвхөн долоо хоногийн нэг өдөр сүсэглэх ёстой гэдэгтээ итгэж байсан Зорамчуудад өгсөн Амюлекийн зөвлөгөө хэрхэн тусалсан гэж бодож байна вэ? Энэхүү зөвлөгөөнөөс бид юу сурч чадах вэ?
- Амюлек хүмүүст Аврагчийн тухай ийм их гэрчлэл хүлээн авсны дараа юу хийхийг зарлигласан бэ? (Алма 34:30–31; мөн “наманчлалд итгэх итгэл” гэж дөрвөн удаа гардаг 15- 17-р шүлгүүдийг үз.) Христэд итгэх итгэл нь яагаад наманчлалын чухал ач холбогдолтой хэсэг болдог вэ?
- Амюлек бидэнд наманчлалынхаа өдрийг хойшлуулахгүй байхыг сэрэмжлүүлсэн (Алма 34:31–36). Заримдаа хүмүүс яагаад наманчлалаа хойшлуулдаг вэ? Алма 34:32 дахь зөвлөгөө бидний өдөр тутам амьдрах байдалд маань хэрхэн нөлөөлж болох вэ?

Дүгнэлт

Жимсний мод тарих зорилго нь түүний жимснээс хүртэх боломжтой байх явдал юм хэмээн цохон тэмдэглэ. Бид зүрх сэтгэлдээ “суулгах газрыг” гаргахдаа “үүний үр жимсийг авна” хэмээн найдаж болно (Алма 32:28, 41). Алма 32:41–42-оос Алмагийн уг жимсний тодорхойлолтыг унш. Энэхүү жимс бол мөнхийн амьдрал бөгөөд зөвхөн Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан бид энэ жимснээс хүртэх боломжтой (Алма 34:14–16).

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. “Би та нарыг эдгээр зүйлийг санаасай гэж хүсэж байна” (Алма 34:37)

Хичээлийн дүгнэлт болгон ангийн нэг гишүүнээс Алма 34:37–41 дэх Зорамчуудад хандсан Амюлекийн төгсгөлийг үгийг уншихыг урь.

2. Сүмийн шинэ гишүүдийг хүчирхэгжүүлэх нь

- “Зорамчуудын илүү нэр хүндтэй хэсэг” нь Алма болон түүний ахан дүүсийн үгэнд итгэсэн хүмүүсийг хөөн зайлуулав (Алма 35:1–6). Аммоны хүмүүс эдгээр хүмүүсийг хэрхэн хүлээн авсан бэ? (Алма 35:7–9-ийг үз.) Шинэ хөрвөгдөгсдийг хүчирхэгжүүлэх талаар энэ жишээ юу заадаг вэ?

Алма 36–39

Зорилго Ангийн гишүүдэд сайн мэдээнд итгэлтэй үлдэгсдэд өгсөн Алмагийн зөвлөгөөг зааж, эцэг эхчүүдэд зөв шударга болон зөв шударга бус хүүхдүүдийн аль алинд нь хэрхэн зааж зөвлөхийг ойлгуулах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Алма 36–37. Алма өөрийн хүү Хиламанд өөрийнхөө хөрвүүлэлт болон гэрчлэлийг ярьдаг. Тэрээр Хиламанд нандин цэдэгүүдийг хадгалах талаар зааварладаг.
 - б. Алма 38. Алма хүү Шиблоноо итгэлтэй байдлынх нь төлөө магтаж, түүнийг цаашид ч зөв шударга байж эцсээ хүртлээ тэвчихийг урамшуулдаг.
 - в. Алма 39. Алма хүү Кориантоноо ёс суртахуунгүй үйлдлүүдийнх нь төлөө зэмлэж ийм нүглүүдийн үр дагаврын талаар зөвлөж хэлдэг.
2. Алтан Ялтсуудын зураг байгаа бол хичээлд хэрэглэхээр бэлтгэ (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 325).

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

**Анхаарал Татах
Үйл Ажиллагаа** Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Ангийн гишүүдээс асуу:

- Эцэг эхчүүдийн чинь та нарт өгч байсан зөвлөгөөнүүдээс хамгийн сайн нь аль нь байсан бэ? Яагаад энэ зөвлөгөө тийм үнэтэй байсан бэ?

Ангийн гишүүдэд бодох хугацаа өгч дараа нь хариултаа хуваалцахад урь.

Энэ хичээлд ярилцах бүлгүүдэд Алмагийн өөрийн хөвгүүд Хиламан, Шиблон Кориатон нарт зөвлөж хэлсэн үгс агуулагддаг хэмээн тайлбарла. Эдгээр зөвлөж хэлсэн үгс нь бидэнд ч бас тохирно.

**Судрын Ярилцлага
ба Хэрэглээ**

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Алма гэрчлэлээ хуваалцаж цэдгүүдийг өөрийн хүү Хиламанд өгдөг.

Алма 36–37-г ярилц. Ангийн гишүүдийг сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь.

- Алма 36 нь Алмагийн өөрийн хүү Хиламанд илэрхийлсэн гэрчлэлийг агуулдаг (онцгойлон 3–5, 26–28-р шүлгүүдийг үз). Хүүхдүүдэд эцэг эхийнхээ гэрчлэлийг сонсох яагаад чухал байдаг вэ? Эцэг эхчүүдийн чинь гэрчлэл та нарын амьдралд ямар байдлаар нөлөөлсөн бэ?
- Алма гэрчлэлийнхээ нэгэн хэсэг болгон Хиламанд өөрийнхөө хөрвүүлэлтийн тухай ярьсан (Алма 36:6–24-ийг үз; мөн Алмагийн өөрийнхөө хөрвүүлэлтийн тухай ярьж буй хэсэг болох Алма 38:7–9-ийг болон Алмагийн хөрвүүлэлтийн тухай нарийвчлан ярилцдаг 20-р хичээлийг үз). Та нар яагаад Алмаг хөрвүүлэлтийнхээ түүхийг хөвгүүдтэйгээ хуваалцсан гэж бодож байна вэ? Бусдын хөрвүүлэлтийн тухай сонсох нь та нарт ямар ашиг тустай байсан бэ?
- Алма Хиламаныг өөрийнх нь үлгэр жишээг дагахад олон удаа урамшуулж байсан. (Та ангийнханд Хиламанд өгсөн Алмагийн зөвлөгөөг харуулсан дор жагсаасан хэллэгүүдийг тоймлож болно.) Эцэг эхчүүдэд хүүхдүүддээ зөв шударга үлгэр дууриал болох нь яагаад чухал вэ?
 - а. “Би чамайг миний хийснийг хийгээсэй хэмээнэ” (Алма 36:2).
 - б. “Би чамайг үгсийг минь сонсож мөн надаас сураасай хэмээн чамаас хүсэж байна” (Алма 36:3).
 - в. “Та нар миний адилаар . . . санаандаа хадгалж байвал зохино” (Алма 36:29).
 - г. “Та нар миний мэдэж байгааг мэдвэл зохино” (Алма 36:30).
- Та алтан ялтсуудын зураг хэрэглэж байгаа бол түүнийгээ одоо үзүүл. Алма Хиламанд цэдгүүдтэй байхын чухлыг хэрхэн онцолсон бэ? (Алма 37:1–2, 6–12-ыг үз.) Цэдгүүдтэй байх нь “агуу их зүйлүүдийг” авчрах “жижиг бөгөөд энгийн зүйл” ямар байдлаар болдог байсан бэ? (Алма 37:6–7). Бид судруудаас чармайлт гарган суралцвал судрууд бидний төлөө ямар “агуу их зүйлүүдийг” хийх вэ? (Алма 37:8–10-ыг үз.)
- Алма Хиламанд хүмүүст заах талаар юу хэлсэн бэ? (Алма 37:32–34-ийг үз.) Өнөөдөр эцэг эх, багш болон бусад насанд хүрэгсэд “өөрийн залууд мэргэн ухааныг суралцахад” залуучуудад хэрхэн тусалж чадах вэ? (Алма 37:35).
- Ангийн нэг гишүүнээр Алма 37:36–37-г чанга уншуул. Энэ зөвлөгөөг дагахыг чармайхад та нарын амьдрал хэрхэн өөрчлөгдсөн бэ? Бид энэхүү зөвлөгөөнд хэрхэн илүү анхаарал тавьж чадах вэ?
- Алма Бурханы үг болон Лиахонаг хооронд нь хэрхэн харьцуулсан бэ? (Алма 37:38–45-ыг үз.) Бурханы үгийг хүн бүрийн хувьд Лиахона болгохын тулд бид юу хийх ёстой вэ?
- Алма Хиламанд, “Уг замын амархны учир хойргошихгүй байцгаая” гэж зөвлөсөн (Алма 37:46; мөн Тоолол 21:5–9; 1 Нифай 17:41-ийг үз). Мөнхийн амьдралд хүрэх зам нь ямар утгаараа амархан бэ? Амархан зам нь зарим хүмүүсийн хувьд яагаад бүдрэх чулуу болдог вэ? Бид хэрхэн Христэд итгэх энгийн бөгөөд аврах итгэл дээр төвлөрч чадах вэ? Бид хэрхэн “Бурханд найдан амьдрах” вэ? (Алма 37:47).

2. Алма хүү Шиблоноо магтаж урамшуулдаг.

Алма 38-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Алма бас хүү Шиблондоо гэрчлэлээ хуваалцаж хөрвүүлэлтийнхээ тухай хэлсэн (Алма 38:6–9).

- Шиблоны ямар зан чанарууд эцэгт нь агуу их баяр баясгалан авчирсан бэ? (Алма 38:2–4-ийг үз.) Эцэг эхчүүдийн хувьд хүүхдүүдийнхээ сайн зан чанар, зөв шударга амьдралыг танин мэдэж, магтан сайшааж байх нь чагаад чухал вэ?
- Ангийн нэг гишүүнээр Алма 38:5-ыг чанга уншуул. Бурханд найдвараа тавих нь та нарын сорилт болон зовлон зүдгүүрт хэрхэн тусалж байсан бэ?
- Хэдийгээр Шиблон итгэлтэй байсан ч Алма үгийнхээ төгсгөлд хүүдээ зөвлөмж өгсөн (Алма 38:10–15). Зөв шударга хүний хувьд ч гэсэн зөвлөгөө, санамж авах нь яагаад чухал вэ? Бид хэрхэн төлөв түвшин байдалтайгаар ийм зөвлөгөө, санамжийг хүлээн авахыг сурч чадах вэ?
- Алма Шиблонд цаашид ч Бурханы үгийг номлохдоо “хичээнгүй мөн өөрийгөө захирах чадвартай” байж, “зоригийг хэрэглэ, гэвч бүү дээрэлх” хэмээн зөвлөсөн (Алма 38:10, 12.) Бид итгэл бишрэлээ бусадтай хуваалцахдаа энэ зөвлөгөөг хэрхэн дагаж чадах вэ?
- Алма Шиблонд өөрийн мэргэн ухаан буюу хүч чадлаараа бусад бардамнахгүй байхыг анхааруулсан (Алма 38:11). Өөрийн мэргэн ухаан буюу хүч чадалдаа бардах нь биднийг илүү их нүгэл рүү хэрхэн хөтөлж болох вэ? (Алма 38:13–14-ийг үз. Бид “Бурханы өмнө өөрийн зохисгүй байдлаа цаг үргэлж хүлээнэ.”)
- Алма Шиблонд “бүх хүслээ хазаарлахыг” (Алма 38:12) зөвлөсөн. Хүслээ хазаарлана гэдэг нь ямар утгатай вэ? (Та морины хазаар нь мориог чиглүүлж удирдах зорилготой зүйл гэдгийг онцлон тэмдэглэ.) Бид “хайраар дүүрэн” байхын тулд өөрсдийн хүслийг яагаад хазаарлах ёстой вэ?

3. Алма хүү Кориантоноо наманчлуулахаар зэмлэдэг.

Алма 39-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Алмагийн хүү Кориантондоо өгсөн зөвлөгөө нь бусад хүүхдүүддээ өгсөн зөвлөгөөнөөс нь өөр байсан гэдгийг онцлон тэмдэглэ. Хиламан, Шиблон хоёр зөв шударга амьдарч байсан боловч Кориантон ноцтой нүглүүд үйлдсэн байлаа.

- Кориантон ямар ноцтой нүглүүд үйлдсэн бэ? (Алма 39:2–3-ыг үз.) Сексийн нүгэл нь яагаад тийм их харамсалтай нүгэл вэ?

Ахлагч Бойд К.Пакер ийнхүү заасан:

“Бидний биед өгөгдсөн хүч нь нандин бүтээлтийн хүч юм, өөрөөр хэлбэл, бусад гэрлүүдийг асаах хүч болох гэрэл юм. Энэ бол зөвхөн нандин гэрлэлтийн хүрээнд л хэрэглэгдэх бэлэг юм. Энэхүү бүтээлтийн хүчийг хэрэглэснээр мөнх бус бие жирэмсэлж дотор нь сүнс орон шинэ хүн энэ амьдралд төрдөг.

“Энэ хүч бол сайн. Энэ нь гэр бүлийн амьдралыг үүсгэн дэмждэг ба бидний оргилсон аз жаргал нь гэр бүлийн амьдрал дотор болдог билээ. . . .

“Бүтээлтийн хүч буюу хүүхэд төрүүлэх хүч нь төлөвлөгөөн дэх ердөө л нэг санамсаргүй хэсэг биш, энэ бол үүнд зайлшгүй шаардлагатай хэсэг

билээ. Үүнгүйгээр төлөвлөгөө биелэхгүй билээ. Үүнийг буруу ашиглах нь төлөвлөгөөг замбараагүй байдалд хүргэнэ.

“Та нарын амьдралд ирэх аз жаргалын дийлэнх нь та нарын бүтээлтийн нандин хүчийг хэрэглэх байдлаас шалтгаалах болно. . . . Та нар [Сатаны] энэхүү хүчийг зуурдын байдлаар, хэт ойр ойрхон буюу ямарваа байдлаар буруугаар ашиглах уруу таталтанд орох юм бол та нар мөнхийн дэвшилтэнд орох боломжоо лавтайяа алдах болно. . . .

“Та нар бэлгээ хамгаалж мана. Та нарын жинхэнэ аз жаргал гадаст оршино. Мөнхийн гэр бүлийн амьдралд . . . хүрч болно, яагаад гэвэл Тэнгэрлэг Эцэг маань энэхүү сонгогдсон бэлэг болох энэхүү бүтээлтийн хүчийг та бүгдэд бэлэглэсэн юм. Энэ бол аз жаргалд хүрэх тэрхүү түлхүүр бөлгөө” (in Conference Report, Apr. 1972, 136–39; or *Ensign*, July 1972, 111–13).

- Алма яагаад Кориантоны нүглийг түүнтэй ярилцах хэрэгтэй гэж бодсон бэ? (Алма 39:7- 8, 12–13-ыг үз.) Алдаа гаргасан буюу нүгэл хийсэн хүүхдүүддээ хэрхэн зөвлөх тухай эцэг эхчүүд Алмагаас юу сурч болох вэ? (Хариутанд дор жагсаасан зүйлүүд орж болно.)
 - а. Алма Кориантонд түүнийг юунаас болж нүгэл рүү хөтлөгдсөнийг нь сануулсан (Алма 39:2–4).
 - б. Тэрээр Кориантоны нүглийн үр дагаврыг нь тайлбарласан (Алма 39:7–9, 11).
 - в. Тэр Кориантонд хэрхэн наманчилж, ирээдүйд нүглээс зайлсхийхийг зааж өгсөн (Алма 39:9–14).
 - г. Тэр Кориантонд Бурханы хайр болон өршөөлийн тухай заасан (Алма 39:15–19).
- Кориантоны ямар үйлдлүүд буюу ямар зан чанар түүнийг нүгэл рүү хөтөлсөн бэ? (Алма 39:2–3-ыг үз.) Бид Сатаны ёс суртахуунгүй байх уруу таталтын эсрэг өөрсдийгөө хэрхэн хүчирхэгжүүлж чадах бэ? (Алма 39:4, С ба Г 121:45-ыг үз.)
- Кориантоны нүгэлт байдал бусдад хэрхэн нөлөөлсөн бэ? (Алма 39:11, 13-ыг үз.) Яагаад Алмагийн үгийг бодвол Кориантоны үйлдлүүд Зорамчуудад илүү нөлөөлсөн гэж та нар бодож байна вэ? Сүмийн гишүүдийн хувьд сайн дууриал болох нь яагаад чухал вэ? Та нар сайн дууриал болдог хүмүүсээр хэрхэн адислагдаж байсан бэ? (Ангийн гишүүдийг тэдний үйлдэл бусад Сүмийнхний санаа бодолд хэрхэн нөлөөлж болох талаар чимээгүй бодохыг урь.)
- Алма Кориантонд хэрхэн наманчилж ирээдүйд нүглээс зайлсхийх талаар юу гэж зөвлөсөн бэ? (Алма 39:9–14-ийг үз. Ангийн гишүүдийн хариултыг самбарт жагсаа. Ярилцлагыг өрнүүлэх зорилгоор зарим хариултыг ярилцлагын асуултуудын хамт дор жагсаасан болно.)
 - а. “Нүдээрээ шунасныхаа араас дахин бүү яв” (Алма 39:9). Бидний харахаар эсвэл анхаарахаар сонгосон зүйлүүд нь ёс суртахуунаар цэвэр байх шийдвэрт маань хэрхэн нөлөөлөх вэ?
 - б. “Ах нартайгаа зөвлөхийг өөртөө хүлээ” (Алма 39:10). Зөв шударга гэрийнхэн эсвэл нөхөдтэйгөө зөвлөлдөх нь бидэнд уруу таталтыг эсэргүүцэх байдлаа батжуулахад хэрхэн тусалж чадах вэ?

- в. “Өөрийгөө ямар нэг хоосон эсвэл мунхаг зүйлд удирдуулахыг бүү тэвч” (Алма 39:11). Сатан биднийг ямар хоосон эсвэл мунхаг зүйлүүдээр удирдаж холдуулахыг оролддог вэ?
- г. “Өөрийн бүх оюун, хүч мөн чадлаараа Их Эзэнд ханд” (Алма 39:13). Бид уруу таталттай тулгарахдаа Их Эзэнд хэрхэн хандаж чадах вэ?
- д. “Өөрийн алдаанууд мөн өөрийн хийсэн тэр бурууг хүлээ” (Алма 39:13). Буруугаа хүлээх нь яагаад наманчлалын чухал хэсэг болдог вэ?
- е. “Баялгийг болон энэ дэлхийн хоосон зүйлсийг бүү эрэлхийл” (Алма 39:14). Баялгийг буюу энэ дэлхийн хоосон зүйлсийг эрэлхийлэх нь биднийг нүгэлд хэрхэн уруу татдаг вэ?
- Алма Кориантонд Христийн тухай юу заасан бэ? (Алма 39:15–19-ийг үз. Ангийн гишүүдийн хариултыг самбарт жагсааж бич.) Эдгээр зүйлүүдийг ойлгох нь биднийг нүгэлд уруу татагдах үед бидэнд хэрхэн тусалдаг вэ?

Дүгнэлт

Алма Кориантонд хэрхэн наманчилж эргэж итгэлтэй болохыг зааж, Хиламан, Шиблон нарт хэрхэн итгэлтэй хэвээр үлдэх талаар зөвлөсөн хэмээн онцол. Ангийн гишүүдийг Алмагийн зөвлөгөөг амьдралдаа хэрэглэхийг урамшуул. Ангийнхны эцэг эхчүүдийг хүүхдүүддээ зааж зөвлөхдөө Алмагийн жишээг дагахыг урамшуул.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Хүүхдүүдэд ганцаарчлан зөвлөх нь

Ангийн нэг гишүүнээр Алма 35:16-г чангаар уншуул.

- Өөр өөр зан чанартай, бэрхшээлүүдтэй болон хэрэгцээ бүхий хүүхдүүдэд заах талаар энэ шүлгээс бид юу сурч болох вэ? (Алма хөвгүүдийнхээ тус бүртэй нь “ганцаарчлан” ярьсан гэдгийг онцол. Тэр хөвгүүддээ захиас өгөхдөө хамтад нь буюу ижил захиас өгөөгүй; тэр хүү тус бүртэйгээ тусад нь ярилцаж түүнд тусгайлан сонсох хэрэгтэй зүйлсийг хэлсэн.) Энэ нь хүүхдүүдэд байн байн ганцаарчлан заахад хэрхэн тустай байж чадах вэ?

2. Эцэг эхчүүдийн хүүхдүүдийнхээ төлөө хүлээсэн үүрэг

- Эцэг эхчүүд хүүхдүүдээ өсгөхөд ямар үүрэг хариуцлага хүлээдэг вэ? (Мозая 4:14–15; С ба Г 68:25–28-ыг үз.)

Ангийн гишүүдийг судруудаас зөв шударга, бас зөв шударга бус хүүхдүүдтэй зөв шударга эцэг эхчүүдийг олуул. Хариултанд дараах зүйлүүд орж болно:

Адам, Ева хоёр (Абел, Каин хоёр)
Исаак, Ребекка хоёр (Иаков, Есау хоёр)
Лихай, Сариа хоёр (Нифай, Сам, Иаков, Иосеф, Лэмэн, Лэмүүл)
Бага Алма (Хиламан, Шиблон ба Кориантон)

Зөв шударга эцэг эхчүүдэд хүртэл зохисгүй хүүхдүүдтэйгээ харьцах бэрхшээлүүд байдаг гэдгийг онцлон тэмдэглэ. Эцэг эхчүүд хүүхдүүддээ сайн мэдээг заах үүрэгтэй ба тэднийг сайн мэдээний зарчмуудаар амьдрахад нь урамшуулах үүрэгтэй боловч хүүхдүүдийнхээ чөлөөт сонголтыг тэд бас хүндлэх ёстой гэдгийг онцлон тэмдэглэ. Эцэг эхчүүд хүүхдүүдээ хүчээр зөв шударга амьдруулж чадахгүй.

3. “Ийм агуу их гэмт үйл” (Алма 39:7)

Та Алмагийн ариун явдлын хуулийн тухай сургаалыг онцолж болно. Ангийн гишүүдэд ариун явдлын хуулийг ойлгуулахаа, энэ нь яагаад чухал болох, мөн үүнийг хэрхэн тууштай сахихыг ойлгуулахаа анхаар. Залуучуудад ариун явдлын хуулийг сахих тухай заахдаа та *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* (34285) товхимлыг ашиглаж болно. Товхимолгүй байгаа ангийнхандаа үүнийг авч өгөх талаар бишоптойгоо зөвлөлд.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинклигийн дараах мэдэгдэл бас тустай байж болно:

“Та нар аймшигт уруу таталттай дэлхийд амьдарч байгаа билээ. Бохир заваан порнографи нь аймшигтайгаар нөмрөн ирж буй урсгал мэт дэлхийг хамарч байна. Энэ бол хор. Үүнийг бүү үз, бүү унш. Та нар ингэх л юм бол өөрийгөө хөнөөнө. . . . Үүнээс хол бай. Бузар өвчин мэт үүнээс зугт яагаад гэвэл энэ бол үхэл. Оюун санаа болон үйлсдээ ухаалаг бай. Бурхан та нарын дотор, хилэнцэт хийгээд хөнөөлт төгсгөлд амархан уруу татагдаж болох тэнгэрлэг хэрэгцээ шаардлагыг зорилготойгоор суулгаж өгсөн билээ. Та нар залуу багадаа байнгын болзоонд бүү ор. Та нар гэрлэлтийн талаар бодох насанд хүрэхэд л үүнд оролцох цаг нь болдог. Гэвч арван жилийн сургуулийн хөвгүүд та нар, мөн охид ч үүнийг хийх хэрэггүй” (in Conference Report, Oct. 1997, 71–72; or *Ensign*, Nov. 1997, 51).

“Аз Жаргалын Агуу Их Төлөвлөгөө”

Хичээл
30

Алма 40–42

Зорилго Ангийн гишүүдэд үхлийн дараах амьдрал, мөн Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан тэд өршөөл авах боломжтойг илүү сайн ойлгуулна.

Бэлтгэл


1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Алма 40:1–23. Алма Кориантонд үхэл болон дахин амилалтын талаар заадаг.
 - б. Алма 40:24–26; 41. Алма Кориантонд дахин амилсныхаа дараа зөв шударга хүмүүс аз жаргалд дахин сэргээгдэж, нүгэлтнүүд зовлонд сэргээгдэх болно гэж заадаг.
 - в. Алма 42. Алма Кориантонд агуу их аз жаргалын төлөвлөгөөн дэх шударга ёс болон өршөөлийн тухай заадаг.
2. Нэмж унших зүйл: Сургаал ба Гэрээ 138.

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Самбарт дараах бүдүүвчийг зур:



Бид авралын төлөвлөгөөг заахдаа голдуу энэ бүдүүвчийг зурдаг гэж тайлбарла. Гэхдээ зөвхөн үүгээр төлөвлөгөөг тайлбарлах юм бол энэхүү

төлөвлөгөөнд гол үүргийг гүйцэтгэгч Есүс Христийг бид орхигдуулдаг. Мөн түүнчлэн Уналт, Цагаатгал, чөлөөт сонголт гэсэн энэхүү төлөвлөгөөний цөм нь болсон номлолуудыг орхигдуулах болно.

Ахлагч Нил А.Максвеллын дараах мэдэгдлийг унш:

“Их Эзэн Аз Жаргалын Төлөвлөгөө болох гэтэлгэлийн төлөвлөгөөгөө дүрсэлсэн. . . . Заримдаа бид яриандаа энэхүү агуу төлөвлөгөөний талаар дэндүү хайнга ярьдаг; тэр бүү хэл бид үндсэн бүдүүвчийг нь самбар эсвэл цаасан дээр байшингийн нэмэлт давхрын төсөл гаргаж байгаа мэт зурдаг. Харин бид үнэхээр цаг гарган энэхүү төлөвлөгөөний талаар эргэцүүлэн бодох юм бол энэ нь сэтгэл хөдлөм, дийлдэшгүй их хүчтэй болохыг мэддэг” (“Thanks Be to God,” *Ensign*, July 1982, 51).

Өнөөдөр Алмагийн хүү Кориантондоо өгсөн зарим зөвлөгөөг ярилцах болно гэдгээ тайлбарла. Кориантонд заахдаа Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөөний талаар ярихдаа “дахин сэргээлтийн төлөвлөгөө” (Алма 41:2), “авралын агуу төлөвлөгөө” (Алма 41:5), “аз жаргалын агуу их төлөвлөгөө” (Алма 41:8), “гэтэлгэлийн төлөвлөгөө” (Алма 41:11), “нигүүлслийн агуу их төлөвлөгөө” (Алма 42:31) хэмээн ярьсан. Алма уг төлөвлөгөөний тухай заахдаа Уналт, Есүс Христийн Цагаатгал болон хувь хүний чөлөөт сонголтыг төв болгон онцолсон.

Судрын Ярилцлага ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Алма Кориантонд үхэл болон дахин амилалтын талаар заадаг.

Алмагийн номын 40–42-р бүлгүүдэд дуулгаваргүй хүү Кориантондоо Алмагийн өгсөн зөвлөгөө үргэлжилдэг. Кориантоны буруу үйлдлүүд зарим талаараа гэрчлэлгүйгээс мөн сайн мэдээний үндсэн номлолуудыг ойлгоогүйгээс үүдсэнийг Алма ойлгосон. Алма Кориантонд биднийг үхсэний дараа юу болохыг ойлгуулсан.

Алма 40:1–23-ыг ярилц. Ангийн гишүүдийг сонгосон шүлгүүдийг чанга уншихыг урь.

- Алма Кориантонд юуны тухай ярихаа хэрхэн шийдсэн бэ? (Алма 40:1; мөн Алма 41:1; Алма 42:1-ийг үз.) Алма хэрхэн Кориантоны асуудлыг “ухаарах” чадвартай байсан гэж та нар бодож байна вэ? Бид зааж буй хүмүүсийнхээ хэрэгцээг хэрхэн илүү ухаарч чадах вэ?
- Үхэл болон дахин амилалтын хооронд бидний сүнсэнд юу тохиолдох вэ? (Алма 40:11–13-ыг үз. Тэд диваажин ба сүнсний шоронгийн аль нэгэнд нь очно. 13-р шүлэг дэх “гадаад харанхуй” гэдэг нь бидний сүнсний шорон гэж нэрлэдэг зүйл болохыг тайлбарла.) Алма диваажин ба сүнсний шоронг хэрхэн дүрсэлсэн бэ? (Ангийн гишүүдээр хариултыг олуулахаар Алма 40:11–15, 21-ийг уншуул. Та ангийн гишүүдийн хариултыг доорх бүдүүвчийн адилаар самбарт дүгнэн бичиж болно.)

ДИВААЖИН	СҮНСНИЙ ШОРОН
Аз жаргалтай байдал	Зовлонт байдал
Амар тайван, энх амгалангийн байдал	Уйлаан, гаслан, шүдээ хавирах харанхуйн байдал
Харамсал, зовнил үгүй	Бурханы уурыг айн харуулдах аймшигт байдал

Үхэл болон дахин амилалтын хоорондох (С ба Г 138) бидний сүнсний байдлын талаар бидэнд илүү сайн ойлгоход туслах илэрхийлэлтийг 1918 онд Ерөнхийлөгч Иосеф Ф.Смит хүлээн авсан гэж тайлбарла. Энэхүү илэрхийлэлтдээ Ерөнхийлөгч Смит Аврагчийг диваажин дахь үйлчилж мөн сүнсний шоронд сайн мэдээг зааж байхыг нь харсан юм. Ерөнхийлөгч Смит сүнсний шорон дахь сүнснүүдэд сайн мэдээг заах юм байна, мөн тэд эцсийн шүүлтийнхээ өмнө наманчлах боломжтой байх юм байна гэдгийг мэдсэн (С ба Г 138:29–34, 57–59).

- Алма биднийг товлосон цагт дахин амилна гэж хэлсэн (Алма 40:21). Дахин амилна гэдэг ямар утгатай вэ? (Алма 40:21, 23-ыг үз. Сүнс ба бие нэгдэж бие “төгс хэлбэрт” сэргээгдэнэ.) Ямар хүмүүс дахин амилах вэ? (Алма 40:5; мөн 11:42–44-ийг үз.)
- Алма хэд хэдэн удаа үхэл болон дахин амилалтын тухай *мэддэггүй* байснаа дурдсан (Алма 40:2–5, 8, 19–21). Хэдийгээр Алма дахин амилалтын тухай нарийвчлан мэдээгүй байсан ч дахин амилалтын номлолыг гэрчилсэн баримтаас нь бид юу сурч болох вэ? (Энэхүү номлолыг үнэн болох гэрчлэл хүлээн авахаасаа өмнө заавал үүний бүх нарийвчилсан зүйлүүдийг буюу үйл явдлуудыг мэдэх шаардлагагүй гэдгийг ойлгоход ангийн гишүүдэд тусал.)

2. Алма, дахин амилсныхаа дараа зөв шударга хүмүүс аз жаргалд дахин сэргээгдэж, нүгэлтнүүд зовлонд сэргээгдэх болно гэж заадаг.

Алма 40:24–26; 41-ээс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Сүнс ба бие нэгдэж бие “төгс хэлбэрт” сэргээгдэх тул Алма дахин амилалтыг дахин сэргээлт хэмээн ярьсан (Алма 40:23; 41:2). Биднийг дахин амилж “үйлсийнхээ дагуу шүүгдэхэд” цаашид ямар дахин сэргээлт явагдах вэ? (Алма 41:3–6-г үз. Зөв шударга хүмүүс аз жаргалд дахин сэргээгдэж, нүгэлтнүүд зовлонд сэргээгдэх болно.) Сайн сайханд эсвэл хилэнцэд сэргээгдэнэ гэдэг нь ямар утгатай вэ?

Ахлагч Брус Р.МакКонки ийн мэдэгдсэн, “Дахин амилалт бол дахин сэргээлт. Энэ бол бие ба сүнсний аль алиных нь дахин сэргээлт бөгөөд энэ амьдралд нь түүнд байсан оюун санаа, сүнс, зан чанаруудын тэрхүү хувийн шинжүүдийнх нь дахин сэргээлт юм” (Mormon Doctrine, 2nd ed. [1966], 64).

- Бид ямар утгаар “өөрсдийнхөө шүүгч” вэ? (Алма 41:7–8-ыг үз. Бид сайн эсвэл хилэнцэтийг хийхийг сонгосноор үхсэнийхээ дараа юунд дахин сэргээгдэхээ сонгодог.)
- Алма Кориантонд, нүглээс аз жаргалд сэргээгдэхгүй яагаад гэвэл “бусармаг явдал хэзээ ч аз жаргал байгаагүй” гэж тайлбарласан (Алма 41:10). Бусармаг явдал яагаад аз жаргалыг авчрахгүй вэ? (Алма 41:10–13-ыг мөн Хиламан 13:38-ыг үз.) Зарим хүмүүс зарлигуудын эсрэг буй үйл ажиллагаануудад баяр жаргалаа олдог гэсэн зөрчилд та нар хэрхэн хариулах вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон ийн хэлсэн: “Хүмүүс нүгэлд зуурдынхаа баяслыг олохдоо аз жаргалгүй төгсгөлөөр үр дүн нь гардаг. . . . Нүгэл Бурхантай үл зохицлыг үүсгэж, сүнсийг дарамтанд оруулдаг” (in Conference Report, Oct. 1974, 91; or *Ensign*, Nov. 1974, 65– 66).

- Сайн сайханд дахин сэргээгдэхийн тулд Кориантоныг юу хийх хэрэгтэй гэж Алма хэлсэн бэ? (Алма 41:14–15-ыг үз.) “Өөд нь хаясан чулуу өөрийн толгой дээр унана” гэсэн үгийн үнэнийг та нар ямар тохиолдлуудад харсан бэ?

3. Алма Кориантонд шударга ёс болон өршөөлийн тухай заадаг.

Алма 42-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Кориантон эцгийнхээ сургаалуудын талаар зовниж байсан хэмээн тайлбарла. “Нүгэлтэн зовлонгийн байдалд яагаад хуваарилагдах ёстойг” тэр ойлгохгүй байлаа (Алма 42:1). Ийн санаа зовохынх нь хариуд Алма Бурханы шударга ёсны тухай заасан. Мөн түүнчлэн тэр Есүс Христийг “нигүүлслийн төлөвлөгөөг гүйцэлдүүлэхээр, шударга ёсны шаардлагыг хангахаар” дэлхийн нүглүүдийн төлөө цагаатсан гэдгийг заасан (Алма 42:15).

Ангийн гишүүдэд Алмагийн заасан шударга ёсны тухай сургаалыг ойлгуулахын тулд Алма 42:6–7, 10, 18-ыг чанга уншуул. Тэдэнд уншуулан доорх жагсаасан үнэнүүдийг ойлгуул:

- Адам, Ева хоёрын Уналтын улмаас бид уналтын байдалд байдаг. Бид мөнх бус, үхэх тавилантай ба төгс бус. Энэхүү уналтын байдалдаа бид үхэшгүй ба төгс Бурханы оршилд очиж чадахгүй. Биднийг Бурханы дэргэдээс бие болон сүнслэг байдлын аль алинаар нь тусгаарлагдсан байхыг шударга ёс шаарддаг.
 - Бид нүгэл үйлдэхдээ өөрсдийгөө Бурханы дэргэдээс улам тусгаарладаг яагаад гэвэл “цэвэр бус нэгээхэн ч зүйл Бурхантай оршиж эс чадна” (1 Нифай 10:21). Нүглүүдийнхээ төлөө биднийг шийтгэгдсэн байхыг шударга ёс шаарддаг.
- Биднээс зөвхөн шударга ёсыг л шаарддаг байсан бол бидэнд юу тохиолдох байсан бэ? (Алма 42:14-ийг үз.) Бид Тэнгэрлэг Эцэгийн дэргэд буцаж очихын тулд шударга ёсны шаардлагыг биелүүлэхийн тулд юу хийх хэрэгтэй вэ? (Алма 42:15-ыг үз.)

Та “Зуучлагч” гэсэн дүрс бичлэгийн танилцуулга хэрэглэж байгаа бол одоо үзүүл. Хэрэв та сургаалт үлгэрийг өөрөө ярих бол одоо ярь. Өртэй хүн нь бид бүгдийг төлөөлж, зээлдүүлэгч нь шударга ёсыг төлөөлж, Өртэй хүний найз нь Аврагчийг төлөөлж байгаа гэдгийг онцлон тэмдэглэ.

- Есүс Христийн Цагаатгал нь “шударга ёсны шаардлагыг хэрхэн хангасан” бэ? (Мозая 15:7–9-ийг үз. Тэрээр Өөрийгөө үхэлд өгч, Өөртөө бүх хүн төрөлхтний нүглийг авсан.)
- Алма “нигүүлсэл нь цагаатгалын учир ирдэг” гэдгийг гэрчилсэн (Алма 42:23). Бид Бурханы нигүүлслийг бүрэн дүүрэн хүлээж авахын тулд юу хийх ёстой вэ? (Алма 42:13, 23, 27, 29–30-ийг үз; мөн Алма 41:14; С ба Г 19:15–18-ыг үз.)

Дүгнэлт

Эцгийнхээ зөвлөгөөг хүлээж авсныхаа дараа Кориантон наманчилж, номлолынхоо үйлчлэлийг эргэн хийсэн гэдгийг онцлон тэмдэглэ (Алма 43:1; 49:30). Бид Бурханы зарлигуудыг дагаж, нүглээ наманчилбал Аврагчийн Цагаатгалаар дамжуулан нигүүлслийг хүртэх боломжтой гэдгийг онцлон тэмдэглэ.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Зорилго

Ангийн гишүүдэд Нифайчуудын дайны үе дэх тэдний зан байдал, үйлдлүүд нь биднийг дэлхийн бэрхшээлүүд болон Сатаны эсрэг тулалдаанд оролцоход хэрхэн загвар болж үйлчилж байгааг харахад туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Алма 43–44. Зерахэмнагаар удирдуулсан Лэмэнчүүд Нифайчуудын эсрэг дайтаж олзлохоор ирэв. Моронайгаар удирдуулсан Нифайчууд гэр орон, эрх чөлөөгөө хамгаалан байлддаг. Нифайчууд “зөв шалтгааны улмаас зоригжуулагдаж,” мөн Есүс Христэд итгэлтэй байсан тул ялдаг.
 - б. Алма 45:20–24; 46. Амаликая хаан болохыг санаархан Нифайчуудын дунд зөрөлдөөн үүсгэдэг. Ахмад Моронай хүмүүсийг зоригжуулахын тулд “эрх чөлөөний туг” мандуулсан бөгөөд тэд Бурханыг дагахаар гэрээ хийдэг. Амаликая болон түүний хэдэн тооны дагагчид Лэмэнчүүдтэй нэгддэг.
 - в. Алма 47–48. Башир аргаар Амаликая Лэмэнчүүдийн хаан болдог. Тэр Лэмэнчүүдийг Нифайчуудын эсрэг дайнд өдөөн хатгадаг. Ахмад Моронай Нифайчуудыг өөрсдийгөө зөв зохистойгоор хамгаалахад бэлтгэдэг.
 - г. Алма 49–52. Нифайчууд болон Лэмэнчүүдийн хооронд дайн үргэлжилсээр байдаг. Хааныг хүсэгч хүмүүс Нифайчуудын дээр хаантай байхыг эрэлхийлсэн боловч тэд ялагддаг. Тианкам Лэмэнчүүдийн хаан Аммороныг залгамжилсан Амаликаяг алдаг.
2. Ахмад Моронай Эрх Чөлөөний Далбайг Өргөн Мандуулсан нь (62051; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 312) зураг байгаа бол хичээлдээ хэрэглэхээр бэлтгэ.

Хичээлийг

Баяжуулах

Зөвлөмж

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Ангийн гишүүдээс асуу:

- Та нар Мормоныг яагаад Мормоны Номонд дайны тухай тийм их мэдээлэл оруулсан гэж бодож байна вэ?

Та ангийн гишүүдийн хариултанд нэмж дараахыг зөвлөж болно:

1. Дэлхий даяар дайн дажин их болсон цагт Мормоны Номыг уншиж судлах болно гэдгийг Мормон мэдэж байсан. Эдгээр бичээсүүд бидэнд зөрчилдөөнтэй цагт хэрхэн Христ адил үлдэхийг заадаг.

2. Мормон Аврагчийг ирэхээс өмнөх Нифайчуудын түүхийг маш дэлгэрэнгүй бичсэн. Бид Нифайчуудын түүхийг уншин Христийн Хоёр Дахь Ирэлтийн өмнөх өнөөгийн өдрүүдэд болж буй ижил төстэй үйл явдлуудад бэлтгэгдсэн байж чадна.

Энэ хичээлд Нифайчууд болон тэдний дайснуудын хоорондын дайн нь дэлхийн зөрчилдөөнүүдийг шийдвэрлэж, Сатаны эсрэг дайнд өөрсдийгөө болон гэр бүлүүдээ хэрхэн хамгаалах талаар бидэнд юу зааж болох талаар ярилцах болно.

Судрын Ярилцлага ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Нифайчууд гэр орон, эрх чөлөөгөө хамгаалан байлддаг.

Алма 43–44-ийг ярилц. Ангийн гишүүдийг сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь.

- Нифайчууд Лэмэнчүүдийн эсрэг яагаад байлдсан бэ? (Алма 43:3–4, 9–11, 45–47; 48:14-ийг үз.) Их Эзэн ямар болзолтойгоор хүмүүсийг дайнд явахыг зөвшөөрсөн бэ?

Тэргүүн Зөвлөлийн гишүүн асан Ерөнхийлөгч Чарлз В. Пенрөүз ийн хэлсэн: “Өшөө авах эсвэл хариу болгон хүмүүний цусыг урсгах нь бидний хувьд зүй бус юм. Харин Их Эзэн өөрийн үйлчлэгчдийг Израилын хөвгүүд болон охидыг зөв шударга дайнд хүчээ дайчлахыг зарлиглаж буюу зоригжуулж байвал энэ нь өөр хэрэг. . . . Бид хүч чадалдаа босон ялалт өөд явах ёстой; цус асгаруулах хүсэлд бус, бүтээлтийн нөхдөө устгах хүсэлд бус, харин өөрсдийгөө хамгаалахын тулд бөгөөд яагаад гэвэл бид үр удамдаа эрх чөлөөний тэдгээр дээд тэнгэрээс илчлэгдсэн нандин зарчмуудыг үргэлжлүүлэн дамжуулахыг хүсдэг” (in Conference Report, Oct. 1917, 21).

Ахлагч Дэвид О.МакКэй ийн хэлсэн: “Жинхэнэ Христэд итгэгч дайнд орох болсон— би *эхлэх бус*, харин *орох* гэж байгааг минь анхаарна уу— шалтгааныг хоёр нөхцөл зөвтгөж чадна: (1) Чөлөөт сонголтынхоо нэгээс нь татгалзаж, нөгөөхийг нь давамгайлуулах оролдлого (2) Эх орондоо үнэнч байх. Магадгүй, гурав дахь нь байж болно, үгчлэн хэлбэл, шударга бусаар хүчтэй, харгис нэгэнд ялагдсан сул дорой үндэстнийг хамгаалах” (in Conference Report, Apr. 1942, 72).

- Моронай Зерахэмнатай тулгарахад тэр тулалдааны Нифайчуудын амжилтыг юутай холбосон бэ? (Алма 44:3–4-ийг үз.) Нифайчууд Есүс Христэд итгэх итгэлээ хэрхэн харуулсан бэ? (Алма 43:23, 49–50-ийг үз.)
- Нифайчуудын хайрлаж байсан эрх чөлөөг хадгалахад нь туслахын тулд бид өөрсдийн гэр бүл болон нийгэмдээ юу хийж болох вэ?
- Дайн дажинтай үед зөв шударга Нифайчуудын зан чанар, үйлдлийг удирддаг байсан дараах зарчмуудыг ярилц. Өнөөдөр эдгээр зарчмуудыг ойлгож хэрэглэх нь дэлхийд илүү их энх амгалан байдлыг авчрахад хэрхэн тусалж чадах вэ? Бид эдгээр зарчмуудыг хувийн амьдрал дахь зөрчлөө шийдвэрлэхэд хэрхэн хэрэглэж болох вэ?

- а. Өөрийгөө хамгаалах зэрэг зөвхөн зөв шударга шалтгааны улмаас байлд (Алма 43:8–10, 29–30, 45–47; 48:14; Нифайчуудын дайн эхлүүлж байсан анхны бичээс Мормон 4:1–4-т байдгийг та онцолж болно).
- б. Дайснуудаа бүү үзэн яд; өөрийнхөө төлөө сайныг эрэлхийлдгийн адил тэдний сайн сайхныг эр (Алма 43:53–54; 44:1–2, 6).
- в. Зөв шударга амьдарч Бурханд итгэ (Алма 44:3–4; 48:15, 19–20).
- г. Зөв шударга, ухаалаг удирдагчдыг дага (Алма 43:16–19; 48:11–13, 17–19; мөн С ба Г 98:10-ыг үз).

2. Ахмад Моронай хүмүүсийг зоригжуулахын тулд “эрх чөлөөний туг” мандуулсан.

Алма 45:20–24; 46-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Лэмэнчүүдтэй байлдсаныхаа дараа Хиламан болон түүний ахан дүүс бүх нутгаар явж номлон Сүмийн зохион байгуулалтыг шинэчилсэн (Алма 45:20–22). Гэвч зарим Нифайчуудын бардамнал нь өсч Сүмийн эсрэг босжээ. Энэхүү тэрслэгчдийн бүлгийн удирдагч нь Нифайчуудын хаан болохыг эрэхийлэгч Амаликая байв (Алма 45:23–24; 46:1–4).

- Амаликая өөрийгөө дагахыг бусдад хэрхэн итгүүлж чадсан бэ? (Алма 46:1–7, 10-ыг үз.) Ямар шалтгааны улмаас хүмүүс түүнийг дэмжсэн бэ? (Алма 46:4–5-ыг үз.) Амаликая болон түүнийг дагагчдын түүхээс бид юу сурч болох вэ? (Алма 46:8–9-ийг үз.)
- Ахмад Моронайн эрх чөлөөний тугийг өргөн мандуулж буй зургийг хэрэглэж байгаа бол үүнийгээ одоо үзүүл. Моронай яагаад эрх чөлөөний туг хийх болсон бэ? (Алма 46:11–13, 18–20-ийг үз.) Хүмүүс энэхүү эрх чөлөөний тугийг хэрхэн хүлээн авсан бэ? (Алма 46:21–22-ыг үз.) Гэрээнүүдийг хийж сахих нь бидний амьдралд хэрхэн нөлөөлдөг вэ?

3. Амаликая Лэмэнчүүдийн хаан болж тэднийг дайнд өдөөн хатгадаг.

Алма 47–48-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Амаликая Нифайчуудын хаан болж чадалгүй яасан бэ? (Алма 46:33; 47:1, 4. Амаликая хэрхэн Лэмэнчүүдийн хаан болсон тухай ишлэлийг ангийн гишүүдээр тоймлуул [Алма 47:1–35] эсвэл та өөрөө үүнийг тоймло.)
- Нифайчуудын хамгийн хүчтэй эсэргүүцэгчид болох Амалекайчууд (Алма 24:29–30; 43:6–7), Зорамчууд (Алма 30:59; 31:8–11; 43:4), Амаликаячууд (Алма 46:1–7), Мориантон (Алма 50:26, 35), Амаликаягийн ах Амморон (Алма 52:3) зэрэг нь өөрсдөө урд нь Нифайчууд байсан. Яагаад Сүмийг орхисон хүмүүс түүний эсрэг тийм их хүчтэй тэмцдэг вэ? (Мозая 2:36–37; Алма 47:35–36-г үз.)

Бошиглогч Иосеф Смит Сүмийг орхисон хүмүүс түүний эсрэг яагаад тийм их хүчтэй тэмцдэгийг мэдэхийг хүссэн нэгэн эрэгтэйд дараахыг мэдэгджээ: “Та нар Сүмд орохоосоо өмнө дундын газар дээр зогсож байсан. Та нар сайн мэдээг номлосны дараа та нарын өмнө сайн зүйл, хилэнц нь ялгардаг. Та нар үүнийг аль нэгийг нь сонгох, сонгохгүйгээ шийддэг. Эсрэг тэсрэг хоёр эзэн та нарыг түүнд үйлчлэхээр урьдаг. Та нар энэ Сүмд нэгдэхдээ Бурханд үйлчлэхээр татагддаг. Та нар үүнийг хийхдээ дундын газрыг орхин түүн рүү дахин хэзээ ч буцаж очдоггүй. Та нар хилэнцэтийн өдөөн хатгалгаар, үйлчлэхээр татагдсан Эзэнээ орхин түүний

тушаалуудыг дагаж түүний үйлчлэгч болох ёстой юу” (in “Recollections of the Prophet Joseph Smith,” *Juvenile Instructor*, 15 Aug. 1892, 492).

- Амаликаяг Моронайд сөргүүлэн тавь (Алма 48:1–17). Нэг нүгэлтэн олны дунд бусармаг явдлын шалтгаан болж чаддагтай адил (Алма 46:9) Моронайтай адил нэг зөв шударга хүн маш ихээр зөв шударга байдлыг зоригжуулж чадна. Бид хэрхэн зөв шударга удирдагчдыг урамшуулан дэмжиж чадах вэ? Бид бүгдийн хүн нэг бүр бусдын дунд зөв шударга байдлыг хэрхэн урамшуулж чадах вэ?

4. Нифайчууд болон Лэмэнчүүдийн хооронд дайн үргэлжилсээр байдаг.

Алма 49–52-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Эдгээр бүлгүүд Нифайчууд болон Лэмэнчүүдийн хооронд үргэлжилсээр байгаа дайны тухай агуулдаг. Энэхүү мэдээлэл нь бидэнд үнэн ба зөв шударгын эсрэг дайнд бидний мөнхийн амьдралын боломжуудыг устгахаар байлдаж буй Сатан болон түүний эздийн эсрэг үргэлжилж буй тулалдаанд бидэнд тусалж чадна.

- Мормоны Номон дахь дайны тухай мэдээллүүд бидний Сатаны нөлөөллийн эсрэг тулалдаанд хэрхэн хэрэглэгдэж болох вэ? (Зарим жишээг ярилцлагыг өрнүүлэхэд хэрэглэх асуултын хамт дор өгөв. Мөн ангийн гишүүд өөр жишээ гаргаж болно.)
 - а. Нифайчууд Лэмэнчүүдийн дайралтаас хотуудаа хамгаалан хананууд барьж босгосон (Алма 48:7–9; 49:2–4, 13, 18). Биднийг Сатаны нөлөөнөөс ямар зүйлүүд хамгаалах вэ?
 - б. Нифайчууд тасралтгүйгээр хамгаалалтаа бэхжүүлж байсан (Алма 50:1–6). Бид яагаад Сатаны эсрэг хамгаалалтаа тасралтгүйгээр бэхжүүлж байх ёстой вэ?
 - в. Нифайчууд Бурханы зарлигуудаа сахин Сүмийн удирдагчдаа дагасан (Алма 44:3–4; 49:30; 50:20–22). Бурханы зарлигууд болон Сүмийн удирдагчдын зөвлөгөөнүүд бидэнд хэрхэн ёсон бусын эсрэг байлдахад тусалж чадах вэ?
 - г. Нифайчууд өөрсдийг нь тулалдаанд хамгаалсных нь төлөө Бурханд талархсан (Алма 45:1; 49:28). Их Эзэнд талархах нь биднийг Сатанаас хэрхэн хамгаалж чадах вэ?
 - д. Нифайчуудын хоорондоо дайтах шалтгаан нь маргаан байсан бөгөөд Лэмэнчүүдэд тэдний дээр гарах хүч өгсөн (Алма 51:2–7, 12–23; 53:8–9). Маргаан нь Сатанд бидний дээр гарах хүчийг хэрхэн өгдөг вэ? Бусармаг явдлын эсрэг бидний тэмцэлд бусад хүмүүсийн эв нэгдэл, дэмжлэг хэрхэн тусалж чадах вэ?
 - е. Зөв шударга Нифайчууд дайны үед ч дэвжин аз жаргалтай байсан (Алма 49:30; 50:23). Бид аймшигт бусармаг явдлын үед ч амар амгалан, аз жаргалыг хэрхэн олж авч чадах вэ?

Дүгнэлт

Мормоны Номын эдгээр бүлгүүдэд заасан зарчмууд биднийг болон гэр бүлүүдийг маань хилэнцэтийн харгис дайралтаас хамгаалахад тусалж чадна гэдгийг онцлон тэмдэглэ. Мөн түүнчлэн эдгээр нь дайн дажин болон зовлон зүдгүүрт маань биднийг сэтгэл зүрхэндээ амар амгалан байхад тусалж чадна.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

“Тэд Зарлигийн Үг Бүрийг Яг Таг Гүйцэтгэхдээ Дуулгавартай Байсан”

Алма 53–63

Зорилго

Ангийн гишүүдэд хэрэв тэд Хиламаны эрэлхэг залуу дайчдын жишээг дагавал Их Эзэн тэднийг хүчирхэгжүүлэх болно гэдгийг ойлгоход туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Алма 53:10–19; 56:1–8. Аммончуудын хоёр мянган эрэлхэг залуу дайчин Нифайчуудын эрх чөлөөний төлөө байлдахаар гэрээ хийдэг. Тэд Хиламаныг өөрсдийнхөө удирдагч байхыг хүсдэг.
 - б. Алма 56:9–58:41. Залуу цэргүүд эхчүүдийнхээ сургаалд үнэнч, Бурханд итгэлтэй байж зоригтой байлддаг. Тэдэнтэй бас өөр 60 залуу Аммончууд нэгддэг. 2060 цэрэг бүгд шархадсан боловч нэг нь ч амь эрсддэггүй.
2. Хоёр Мянган Залуу Дайчдын (62050; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 313) зураг байгаа бол хичээлдээ хэрэглэхээр бэлтгэ.

Хичээлийг Баяжуулах Зөвлөмж

Анхаарал Татах Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Залуу Дайчдын зургийг үзүүл. Алма 57:25–26-г чангаар уншихдаа 26-р шүлгийн *алагдсан байхад* гэсэн үгийн дараа зогс.

Нифайчууд болон Лэмэнчүүдийн хоорондох тулалдаанд амь нь гайхалтайгаар хэлтрүүлэгдсэн Нифайчууд байсан нь тодорхой. Гэсэн ч бас олон зөв шударга Нифайчууд амь үрэгдсэн (Алма 56:10–11; 57:36).

Хиламаны залуу дайчдын арми Мормоны Номонд дурдагдсан армиудаас нэг ч цэрэг алагдаагүй цорын ганц арми юм.

Ангийн гишүүдэд бид ч гэсэн Хиламаны залуу дайчид шиг агуу их армийн хэсэг мөн гэж хэл. Тэгээд Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны дараах мэдэгдлийг унш. Хэдийгээр энэхүү мэдэгдэл нь Аароны Пристийн Зэрэгтнүүдэд хандсан байсан ч Сүмийн бүх гишүүдэд хамаатай хэмээн тайлбарла.

“Та нар энэ цаг үед нандин бөгөөд сүр жавхлант зорилгын төлөө төрсөн билээ. Та нар энэхүү сүүлчийн цаг хугацааны бүрдлийн эрин үед дэлхийд ирэхийн тулд нөөцөнд байсан нь санамсаргүй хэрэг биш юм. Энэхүү чухал үед төрөх нь мөнх оршилд урьдчилан томилогдсон билээ.

“Та нар хожмын өдрүүд дэх Их Эзэний хаант улсын арми болох учиртай. . . .

“Та нарын орж буй сүнсний тулалдаанд би та нарыг өнөөдрийн Хиламаны хөвгүүд мэтээр харж байна. Мормоны Номон дахь Хиламаны хоёр мянган эрэлхэг залуу дайчдын түүхийг сайн санаж яваарай” (in Conference Report, Apr. 1986, 55; or *Ensign*, May 1986, 43; залуу гэдэг нь залуу эрэгтэйчүүдийг хэлж байгаа гэдгийг тайлбарла).

- “Их Эзэний хаант улсын арми байна” гэдэг ямар утгатай вэ? (Ефес 6:11–18; 1 Петр 2:9; С ба Г 138:55–56-г үз.) Бид Их Эзэний хаант улсын армийн нэгэн хэсгийнх нь хувьд “сүнсний ямар тулалдаанд” ордог вэ?

Энэ хичээл нь Аммончуудын 2060 дайчдад Их Эзэнээс тийм их хүч хүлээн авахад нь тусалсан зарчмууд болон зан чанаруудыг ярилцдаг хэмээн тайлбарла. Бид эдгээр зарчмуудаар амьдарч, зан чанаруудыг хөгжүүлэхэд сүнслэг хүч маань өсөн нэмэгддэг. Бид “Их Эзэний хаант улсын арми”-д үйлчлэгч байхдаа илүү их үр нөлөөтэй байж чадна.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Аммончуудын хоёр мянган эрэлхэг залуу дайчин Нифайчуудын эрх чөлөөний төлөө байлдахаар гэрээ хийдэг.

Алма 53:10–19; 56:1–8-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Энэ ишлэлийг ярилцахаасаа өмнө ангийн гишүүдээр Аммончуудын (Антай-Нифай-Лихайчууд) хөрвүүлэлтийнхээ үед (Алма 24:15–18; 53:10–11) хийсэн энх амгалангийн гэрээг нь товч тоймлуул.

- Нифайчууд Аммончуудыг Лэмэнчүүдээс хамгаалахаар амласан (Алма 27:22–24; 53:12). Аммончууд Нифайчуудын зовлон зүдгүүрийг хараад юу хийхийг хүссэн бэ? (Алма 53:13- ыг үз.) Хиламан яагаад хүмүүсийг гэрээгээ зөрчихгүй байхыг ятгаж байсан бэ? (Алма 53:14–15; 56:8-ыг үз.) Энэ нь гэрээнүүдийг сахих талаар юу заадаг вэ?
- Аммончуудын хөвгүүд Нифайчуудад туслахын тулд юу хийсэн бэ? (Алма 53:16-г үз.) Залуу Аммончууд Нифайчуудад тусална гэсэн өөрсдийнхөө амлалтын хүчийг хэрхэн харуулсан бэ? (Алма 53:17-г үз. Тэд гэрээн байгуулж, гэрээгээ “ямар ч нөхцөлд” сахихаар шийдсэн. Самбарт *Нандин гэрээнүүдийг хийж сахих* гэж бич.)
- Бид Түүнтэй гэрээ хийж “ямар ч нөхцөлд” гэрээгээ сахвал Их Эзэн биднийг хэрхэн хүчирхэгжүүлэх вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон ийн хэлсэн: “Бурхан руу өөрсдийнхөө амьдралыг эргүүлсэн эрэгтэй, эмэгтэйчүүд Түүнийг тэдний амьдралдаа чадахаас нь хамаагүй илүүг хийж чаддаг гэдгийг олж мэдэх болно. Тэрээр тэдний баяр баясгаланг гүн гүнзгий болгож, тэдний ойлголтыг тэлж, оюун ухааныг нь хурдасгаж, булчинг нь чангаруулж, сүнсийг нь өргөж, адислалуудыг нь үржүүлж, боломжуудыг нь нэмэгдүүлж, зүрх сэтгэлийг нь тайтгаруулж, найз нөхөдтэй болгож, амар амгаланг асгаруулах болно. Бурханы үйлчлэлд амиа алдсан хэн бүхэн мөнхийн амьдралыг олох болно” (*The Teachings of Ezra Taft Benson* [1988], 361).

- Залуу Аммончууд Хиламаныг тэдний удирдагч болохыг хүсэж асуусан (Алма 53:19; 56:1, 5). Хиламан бол бошиглогч болон Сүмийн дээд прист байсан (Алма 37:1–2, 14; 46:6). Бошиглогчийг дагах шийдвэр нь Аммончуудыг яагаад тулаанд илүү амжилттай байхад хүргэсэн бэ? Ямар маягийн удирдагчид хүмүүсийг сүнслэг тулалдаанд нь сулруулдаг вэ?
- Залуу Аммончууд хүлээн авсан тушаалууддаа хэрхэн хандсан бэ? (Алма 57:21-ийг үз. Самбарт бошиглогчийг “яг таг” дага гэж бич.) Их Эзэний бошиглогчийн сургаалуудыг яг таг дуулгавартай дагах нь яагаад чухал вэ? (Доорх ишлэлийг үз.) Өнөөдөр бид бошиглогчийг “яг таг” дагахын тулд ямар онцгой зүйлүүдийг хийж болох вэ?

Ерөнхийлөгч Харолд Б.Ли ийнхүү заасан:

“Сатаны хүч өснө; бид алхам тутамдаа үүний гэрчлэлийг хардаг. . . .

Одоо энэ сүмийн гишүүдийн хувьд бидний цорын ганц аюулгүй байдал нь Сүмийг зохион байгуулагдах тэр өдөр Сүмд хандан Их Эзэний хэлсэн зүйлүүдийг нарийн чанд биелүүлэх явдалд оршдог. ‘Миний өмнө бүхэл ариун байдлаараа явж, үгсийг маань хүлээн авахынх нь хэрээр; . . . бүхэл тэвчээр болон итгэлээрээ миний өөрийн амнаас гарахтай адилаар’ (С ба Г 21:4–5) Их Эзэний бошиглогчдоороо дамжуулан өгөх үгс болон зарлигуудад нь анхаарал тавихыг бид сурах ёстой. Тэвчээр болон итгэл шаардах зарим зүйлүүд байх болно. Сүмийн эрх мэдэлтнүүдээс ирэх зүйлүүдийг та нар таалахгүй байж болно. Энэ нь та нарын улс төрийн бодолтой зөрчилдөж болно. Энэ нь та нарын нийгмийн бодолтой зөрчилдөж болно. Энэ нь та нарын нийгмийн амьдралд хөндлөнгөөс оролцож болно. Харин та нар эдгээр зүйлсийг Их Эзэний өөрийнх нь амнаас гарахтай адилаар тэвчээр болон итгэлээрээ сонсох юм бол ‘тамын үүд та нарыг дийлэхгүй, тийм ээ, Их Эзэн Бурхан та нарын өмнөх харанхуйн хүчийг замхруулж тэнгэрийг та нарын сайн сайхны төлөө болон түүний нэрийг алдаршуулахын төлөө чичрүүлнэ’ гэсэн амлалт өгөгдөнө (С ба Г 21:6)” (in Conference Report, Oct. 1970, 152; or *Improvement Era*, Dec. 1970, 126).

2. Залуу цэргүүд Бурханд итгэлтэй байж зоригтой байлдаг.

Алма 56:9–58:41-ийг ярилц. Ангийн гишүүдийг сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь. Та залуу дайчдын зургийг ашиглаж байгаа бол түүнийгээ одоо үзүүл.

- Аммончуудын тулгарсан анхных нь арми бол хамгийн хүчтэй бөгөөд хамгийн том Лэмэнчүүдийн арми байсан (Алма 56:34–43). Хиламаныг тэд энэ армийн эсрэг явах уу гэж асуухад залуу цэргүүд юу гэж хариулсан бэ? (Алма 56:44–47-г үз.) Ийм агуу их итгэл, эр зоригтой байхыг эдгээр дайчид хэнээс сурсан бэ? (Алма 56:47–48; мөн Алма 53:21; 57:21-ийг үз. Та насанд хүрэгсдэд зааж байгаа бол самбарт Хүүхдүүдээ Бурханд итгэх итгэлтэй байхыг заа гэж бич. Та залуучуудад зааж байгаа бол Эцэг эхчүүдийнхээ зөв шударга сургаалыг дага гэж бич.)

Эхчүүдийн хүүхдүүдээ үзүүлж чаддаг нөлөөг онцлохын тулд та Ерөнхийлөгч Спэнсер В.Кимболлын дараах мэдэгдлийг уншиж болно:

“Аврагчийг маань ирэхийн өмнөх энэ дэлхийн шийдвэрлэх энэ үед зөв шударга эмэгтэй байх нь нэн сүр жавхлантай дуудлага юм. Өнөөдөр зөв

шударга эмэгтэйн хүч болон нөлөө нь илүү амар тайван үед байхаас арав дахин илүү байж болох юм. Тэрээр нийгмийн үндсэн ба хамгийн сүр жавхлантай байгууллага болох айл өрхийг баяжуулж, хамгаалж, манахад нь туслахаар энд байгаа билээ. Нийгмийн бусад байгууллагууд тогтворгүй болж, бүр алдагдаж ч мэднэ. Харин зөв шударга эмэгтэй салхи шуурга, зөрчилдөөн дунд мөнх бус зарим нэг бидний мэдэх сүүлчийн бөгөөд цорын ганц орогнол болох айл өрхийг аврахад нь тусалж чадна” (*The Teachings of Spencer W. Kimball*, ed. Edward L. Kimball [1982], 326–27).

- Залуу цэргүүд эхчүүдийнхээ гэрчлэлд эргэлзээгүй (Алма 56:48). Хүүхдүүд эцэг эхчүүдийнхээ гэрчлэлийн хүч болон баттай байдлыг мэдэх нь яагаад чухал вэ? Эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ гэрчлэлээ ямар арга замаар хуваалцдаг вэ?
- Нэгэн хүнд тулалдааны үеэр олон Нифайчууд “ухрахад бэлэн” байлаа (Алма 57:20; мөн 12–19-р шүлгүүдийг үз). Энэхүү тулалдааны үеэр залуу Аммончууд ямар чиг хандлагатай байсан бэ? (Алма 57:19–20-ийг үз. Самбарт *Бусад нь “ухарсан” ч “гуйвшгүй мөн ухаршгүй” бай* гэж бич.)
- Аммончуудын итгэл, эр зориг ямар үр дүнд хүргэсэн бэ? (Алма 57:22–25; 58:31–33, 39-ийг үз.) Найз нөхөд, хамтрагчид болон бусад нь бараг “ухрахад бэлэн” байхад бид хэрхэн “гуйвшгүй мөн ухаршгүй” үлдэж чадах вэ? Бид “ухрахад бэлэн” байгаа нэгнийгээ хэрхэн хүчирхэгжүүлж чадах вэ?
- Аммончууд ямар байдлаар “гуйвшгүй мөн ухаршгүй” байсан бэ? (Зарим жишээг Алма 53:20–21; 57:26–27; 58:40-өөс үз.)
 - а. “Тэд . . . үлэмж баатарлаг байв” (Алма 53:20).
 - б. “Тэд итгэж даалгасан ямар ч зүйлд цаг үргэлж үнэнч эрс билээ” (Алма 53:20).
 - в. “Тэд үнэн мөн чанд байдлын эрс байв” (Алма 53:21).
 - г. Тэд “итгэхээр сургагдсан байсан түүндээ итгэх үлэмжийн итгэлтэй байсан” (Алма 57:26).
 - д. “Тэд үргэлж Бурханд найдлагаа тавьдаг бөлгөө” (Алма 57:27).
 - е. “Тэд Бурханаар чөлөөлөгдсөн эрх чөлөөндөө бат зогсож байна” (Алма 58:40).
 - ж. “Тэд Их Эзэн өөрсдийн Бурханаа өдрөөс өдөрт дурсан санахдаа хичээнгүй байдаг” (Алма 58:40).
 - з. Тэд Бурханы “дүрмүүдийг, мөн түүний тогтоолуудыг, мөн түүний зарлигуудыг үргэлж дагахыг чармайдаг болой” (Алма 58:40).
 - к. “Ирэх тэр зүйлийн талаарх бошиглолуудад тэдний итгэл нь хүчтэй юм” (Алма 58:40).

Залуу Аммончууд эдгээр зан чанарыг цэрэг болохоосоо өмнө багаасаа хөгжүүлсэн гэдгийг онцлон тэмдэглэ. Та залуучуудад зааж байгаа бол самбарт *Багаасаа зөв шударга зан чанаруудыг хөгжүүлэх* гэж бич.

- Хиламан, Гид, Тиамнэр нарын ахалсан Нифайчуудын арми нэгэн тулалдаанд “олон тоотой армитай” нүүрлэхэд Зарахэмлагийн нутгаас тэдэнд маш бага тусламж иржээ (Алма 58:1–9). Хүч авахын тулд Нифайчууд ямар эх сурвалжид хандсан бэ? (Алма 58:10-ыг үз. Самбарт *Хүч чадал, авралын төлөө залбир* гэж бич.)

- Их Эзэн Нифайчуудын залбиралд хэрхэн хариулсан бэ? (Алма 58:11–12-ыг үз.) Залбирлуудын ийм хариулт бидэнд “хүч зориг авахад” ямар арга замаар тусалж чадах вэ?

Дүгнэлт

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны мэдэгдлийг х. “00” “142”-оос унш. Тус мэдэгдэлтэй холбогдуулан самбарт бичсэн зарчмуудыг тоймло.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт

Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэ санааг хичээлдээ хэрэглэж болно.

Алма 60–61 дэх санаанууд

Моронайн нутгийн захирагч Пахоранд бичсэн захидлыг болон Пахораны хариултыг агуулсан Алма 60 болон 61-ийг ярилц. Эдгээр бүлгүүдэд багтсан хичээлүүд нь:

- а. Их Эзэний өгсөн бүх л аргуудыг хэрэглэх (Алма 60:21).
- б. “Дотоод хэсгийг” цэвэрлэх (Алма 60:23).
- в. “Зарлигуудыг дагана хэмээн хийсэн тэр гэрээний дагуу албадуулагдсан” (Алма 60:34).
- г. “Дэлхийн нэр төрийг бус, харин Бурханы алдар сууг эрэлхийлсэн” (Алма 60:36).
- д. Гомдолгүйгээр (Алма 61:9).

Хиламан 1–5

Зорилго	Есүс Христийн суурин дээр гэрчлэлээ хөгжүүлэхийг ангийн гишүүдэд урамшуулна.
Бэлтгэл	<ol style="list-style-type: none">Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:<ol style="list-style-type: none">Хиламан 1–2. Нифайчуудын дотор сатаны нууц ажиллагаа явагдан дотоод зөрчилдөөн үүсэн бий болж бусармаг явдал өсөн нэмэгддэг. Гадиантон Кишкүмэний дээрэмчдийн нууц бүлэглэлийнхний удирдагч болдог.Хиламан 3. Хүмүүс мянга мянгаараа Сүмд нэгдэн дэвжиж эхэлдэг. Сүмийн зарим гишүүд бардамналд автдаг.Хиламан 4. Лэмэнчүүд болон Нифайчуудын тэрслэгчид Нифайчууд руу тэдний ёсон бус болон бардамналынх нь улмаас дайрдаг.Хиламан 5. Нифай болон Лихай нар Христийн хадан дээр сууриа барих эцгийнхээ зөвлөгөөг санаж явдаг. Наманчлалыг номлох тэдний үйлчлэлийн үеэр гайхамшиг тохиолддог.Та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглэж байгаа бол дараах ажиллагаануудаас нэгийг сонго:<ol style="list-style-type: none">Ангийн гишүүдээр ангидаа “Бат Бөх Суурь” (Сүмийн Дуулал Ба Хүүхдийн дуу, х.6) дууллын 1, 2, 3 ба 7-р шүлгүүдийг нь хэсэг бүлгээрээ дуулахаар бэлтгэхийг хүс.Ангийн гишүүдтэй хамт “Бат Бөх Суурь” дууллын 1, 2, 3 ба 7-р шүлгүүдийг нь дуулах эсвэл уншихаар бэлтгэ.
Хичээлийг Баяжуулах Зөвлөмж	
Анхаарал Татах Үйл Ажиллагаа	<p>Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.</p> <p>Бэлтгэсэн оршлынхоо танилцуулгыг хий (“Бэлтгэл” дэх 2-ыг үз).</p> <p>Дуулал эсвэл дууны дараа өнөөдрийн хичээл дээр өөрсдийнхөө суурийг сул суурин дээр барьсан буюу өөрсдийнхөө итгэлийг эд баялаг эсвэл хүч тэнхээнд тавьсан хүмүүс болон “бат бэт суурь болох. . . Гэтэлгэгчийн маань хадан дээр” барьсан хүмүүсийн ялгааг үзүүлэх болно гэдгийг онцлон хэл. (Хиламан 5:12).</p>
Судрын Ярилцлага ба Хэрэглээ	Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Нифайчуудын дунд дотоод зөрчилдөөн үүсэн бий болдог.

Хиламан 1–2-ыг ярилц. Ангийн гишүүдийг сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь. Ерөнхий шүүгч Пахораныг нас барахад түүний гурван хүү Пахоран, Пэйнкай, Пэкүмэнай нар шүүгчийн суудлын төлөө тэмцэлдсэн (Хиламан 1:1–4).

- Пахораныг Ерөнхий шүүгч болохыг шийдэхэд Пэйнкай, Пэкүмэнай нарын аль алин нь үүнд хэрхэн хандсан бэ? (Хиламан 1:5–7-г үз.) Пэйнкайн эсэргүүцлийн улмаас юу болсон бэ? (Хиламан 1:8–13-ыг үз.)
- Пэкүмэнайг Ерөнхий шүүгч болсны дараа Лэмэнчүүд Нифайчуудын эсрэг байлдахаар ирсэн (Хиламан 1:13–17). Нифайчууд гаднаас ирэх Лэмэнчүүдийн дайралтанд яагаад бэлтгэлгүй байсан бэ? (Хиламан 1:18-ыг үз.) Зөрчил нь улс үндэстэн, нийгэм, хэсэг, гадас, гэр бүл, хувь хүмүүсийг яагаад доройтуулдаг вэ? Бид зөрчлөөс хэрхэн зайлсхийж эсвэл даван гарч чадах вэ?
- “Олон үг ярихдаа болон . . . башир аргад үлэмж мэргэжсэн” Гадиантон Кишкүмэний дээрэмчдийн бүлэглэлийнхний удирдагч болдог (Хиламан 2:4). Гадиантон Кишкүмэний дагалдагчдыг өөрийг нь дагахыг ятгахдаа тэдэнд юу амласан бэ? (Хиламан 2:5; мөн Хиламан 5:8-ыг үз.) Хүмүүс заримдаа зусар үг болон амлалтын хүчний нөлөөнд ямар байдлаар ордог вэ? Бид энэхүү нөлөөллөөс хэрхэн зайлсхийж болох вэ?

2. Хүмүүс мянга мянгаараа Сүмд нэгддэг; Сүмийн зарим гишүүд бардамналд автдаг.

Хиламан 3-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Хиламан 3 нь Нифайчуудын түүхийн бараг 11 жилийг багтаадаг. Эдгээр 11 жилийн үеэр Нифайчуудад энх амгалан байх үе ч байсан, мөн зөрчилдөөнтэй үе ч байсан. Эдгээр жилүүдэд Нифайчуудын энх амгаланг юу эвдсэн бэ? (Хиламан 3:1, 33–34-ийг үз.) Нифайчуудын бардам болох шалтгаан юу байсан бэ? (Хиламан 3:36-г үз.) Бардамнал бидний амьдралын энх амгаланг хэрхэн эвддэг вэ? Бид өөрсдийгөө бардамналын эсрэг манаанд байлгахын тулд юу хийж болох вэ? (Хиламан 3:27–30-ийг үз; мөн Дэд Хууль 8:11, 17–18; Алма 62:48–51-ийг үз.)
- Ангийн нэг гишүүнээр Хиламан 3:29-ийг чангаар уншуул. “Бурханы үгэн дээр тулгуурлах” гэдэг ямар утгатай вэ? “Бурханы үгэн дээр тулгуурлавал” бид хэрхэн адислагдах вэ? (Хиламан 3:27–30-ийг үз; мөн 1 Нифай 11:25; 15:24-ийг үз.)
- 51 дэх жилд зарим Сүмийн гишүүд бусдыг хавчиж эхэлсэн (Хиламан 3:33–34). Сүмийн бардамналд автсан гишүүдийн хавчлагад Христийн даруу дагалдагчид хэрхэн хандсан бэ? (Хиламан 3:35-ыг үз.) Биднийг хавчлага, шүүмжлэл буюу зовлон зүдгүүртэй тулгарахад тэдний үлгэр жишээ хэрхэн тусалж чадах вэ?
- Сүмийн даруу гишүүд “Бурханд зүрх сэтгэлээ зориулсны учир” ариусгагдсан (Хиламан 3:35). Ариусгал гэж юу вэ? (Энэ бол Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан цэвэр, ариун болж нүглээс чөлөөлөгдөх үйл явц юм. С ба Г 76:41; 88:74–75-ыг үз.) Бурханд зүрх сэтгэлээ зориулна гэдэг ямар утгатай вэ?

3. Лэмэнчүүд болон Нифайчуудын тэрслэгчид Нифайчууд руу дайрдаг.

Хиламан 4-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Лэмэнчүүд болон Нифайчуудын тэрслэгчид Нифайчууд руу дайрдаг. Лэмэнчүүд Нифайчууд руу дайрч тэдний газар нутгийн ихэнхийг эзэлсэн (Хиламан 4:5). Хиламаны номыг эмхтгэсэн Мормон Нифайчуудын сул дорой болсон шалтгаан нь юу байсан гэж ажигласан бэ? (Хиламан 4:11–13-ыг үз.) Нифайчуудын үйлдэл болон өнөөгийн зарим хүмүүсийн үйлдэлд ямар ижил талууд бий вэ? Их Эзэнээс хамааралтайгаа мэдэж байх нь биднийг хэрхэн хүчирхэгжүүлэх вэ?
- Моронайха, Лихай ба Нифай нар “хүмүүст тэдний алдсуудын талаар мөн хэрэв тэд нүглүүдээ наманчлахгүй аваас тэдний дээр юу ирэх ёстой талаар олон зүйлийг бошиглосон болой” (Хиламан 4:14). Хүмүүсийг наманчилж эхлэхэд юу тохиолдсон бэ? (Хиламан 4:15–16; мөн 21–26-р шүлгүүдийг үз.)

4. Нифай болон Лихай нар эцгийнхээ зөвлөгөөг санаж явдаг. Тэдний үйлчлэлийн үеэр гайхамшиг тохиолддог.

Хиламан 5-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Нифай яагаад Бурханы үгийг номлохоор шүүгчийн суудлыг орхисон бэ? (Хиламан 5:1–4.) Нифай, Лихай хоёр өөрсдийн нэрийн тухай эцгийнхээ хэлсэн зүйлийн талаар юу санаж байсан бэ? (Хиламан 5:5–7-г үз.) Бошиглогчид, бусад Сүмийн удирдагчид болон бусад зөв шударга хүмүүсийн үлгэр жишээ та нарт хэрхэн тусалсан бэ?
- Хиламан Есүс Христийн Цагаатгалын тухай хөвгүүддээ юу заасан бэ? (Хиламан 5:9–11-ийг үз.)
- Ангийн нэг гишүүнээр Хиламан 5:12-ыг чангаар уншуул. Христийн хадан дээр сууриа барих гэдэг ямар утгатай вэ? (Мөн 3 Нифай 14:24–27-г үз.) Сатан бидэн рүү өөр ямар салхи шуурга илгээдэг вэ? Христ бидэнд эдгээр салхи шуургыг тэсвэрлэхэд хэрхэн тусалдаг вэ?
- Бид яагаад Христийг бидний хад хэмээн ярьдаг вэ? Христийнхээс өөр ямар суурин дээр хүмүүс амьдралаа барьдаг вэ? Та нар Христийн хадан дээр амьдралаа барьснаар хэрхэн адислагдаж байсан бэ?
- Нифай, Лихай хоёр сайн мэдээг Зарахэмлад номлож байх үед ямар гайхамшиг тохиолдсон бэ? (Хиламан 5:17–19-ийг үз.) Лэмэнчүүдийн “эцэг өвгөдийнхөө уламжлалын ёсон бус” явдлыг эсэргүүцэх нь яагаад чухал байсан бэ? (Хиламан 5:19, 51; мөн Мозая 1:5-ыг үз.)

Ахлагч Ричард Г. Скотт ийн хэлсэн: “Та нар Есүс Христийн Сүм дэх гишүүнчлэл болон Түүний сургаалуудыг амьдралынхаа анхны суурь болгон үнэнч байснаараа аз жаргалд хүрэх саад тотгоруудыг зайлуулан илүү их амар амгаланг олно гэдгийг би гэрчилж байна. Гэр бүл эсвэл үндэсний ёс заншил эсвэл уламжлал нь Бурханы сургаалуудтай зөрчилдвөл тэдгээрийг хойш тавь. Ёс заншил, уламжлал нь Бурханы сургаалуудтай зохицсон үедээ тэдгээр нь хайраар тэтгэгдэн танай соёл, өвийг хамгаалсан байх учиртай. Та нар нэг өвийг хэзээ ч өөрчилж чадахгүй. Энэ бол Тэнгэр дэх Эцэгийн охин буюу хүү байхын өв юм” (in Conference Report, Apr. 1998, 114; or *Ensign*, May 1998, 87).

- Ангийн нэг гишүүнээр Хиламан 5:21–32-ыг чангаар уншуул. Хүмүүс наманчилж эхлэхэд юу тохилдсон бэ? (Хиламан 5:43–45-ыг үз.) Ариун Сүнс хүмүүст хэрхэн гэрчилсэн бэ? (Хиламан 5:45–47-г үз.) Ариун Сүнс та нарын амьдралд үнэнийг хэрхэн гэрчилсэн бэ?
- Аврагчийн тухай гэрчлэл хүлээн авсан хүмүүс юу хийсэн бэ? (Хиламан 5:49–52-ыг үз.) Есүс Христийн тэнгэрлэг байдлын тухай болон аврагч хүчийг нь тухай гэрчлэлийг хүлээн авсныхаа дараа бид ямар үүрэг хариуцлагатай болдог вэ? (С ба Г 33:9; 88:81-ийг үз.)

Дүгнэлт

Ангийн нэг гишүүнээр Хиламан 5:12-ыг дахин уншуул. Бид Есүс Христийн хадан дээр сууриа барьснаар өөрсдийгөө бардамнал, маргаан зөрчил болон Сатаны “хүчит шуурганаас хамгаалж чадна” гэдгийг онцлон тэмдэглэ.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. “Санагтун, санагтун, хөвгүүд минь” (Хиламан 5:5–14)

- Санах гэсэн үгийг буюу үүнтэй холбоотой хэлбэрийг (санасан, санах, бүү март гэх зэрэг) Мормоны Номонд 240 удаа хэрэглэсэн байдаг. Эдгээрийн 15 нь Хиламан 5-д байдаг. Бид юуг санаж байх ёстой вэ? (Хиламан 5:9; мөн Мозая 3:17-г үз.) Санах нь яагаад чухал вэ?

Ахлагч Спэнсер В.Кимболл ийн хэлсэн:

“Та нар толь бичигт хамгийн чухал үгсийг хайхдаа энэ нь ямар үг болохыг мэдэх үү? Энэ нь ‘санагтун’ байж болох юм. Бид бүгд гэрээ хийсэн тул . . . бидэнд хамгаас хэрэгтэй зүйл бол санах явдал юм. Тийм учраас хүн бүр Хүндэтгэлийн өдөр бүр ариун ёслолын цуглаандаа ариун ёслолоос хүртэж пристүүдийн ‘үргэлж түүнийг санаж, мөн түүний тэдэнд өгсөн зарлигуудыг нь дагах’ гэж залбирахыг сонсохын тулд очдог. . . . ‘Санагтун’ гэдэг нь тэрхүү үг билээ” (“Circles of Exaltation” [address to religious educators, Brigham Young University, 28 June 1968], 8).

2. “Зүрх сэтгэлээ Бурханд зориулсан” (Хиламан 3:35)

Та Хиламан 3:35-ыг ярилцаж байхдаа Ахлагч Нийл А.Максвеллын дараах мэдэгдлийг хуваалц:

“Зүрх сэтгэлээ Бурханд зориулснаар л бид Түүний бидний төлөө гэсэн хүсэл зоригийг ухаарч эхэлдэг. Бид үнэхээр Бурханд итгэдэг бол түүний хайрлах ойлголтонд өөрсдийгөө зориулахгүй гэж үү? Эцсийн эцэст Тэрээр биднийг болон боломжуудыг маань биднээс хамаагүй дээр мэдэх билээ” (in Conference Report, Apr. 1985, 91; or *Ensign*, May 1985, 72).

“Та Нар Бурханаа Хэрхэн Мартаж Чадсан бэ?”

Хичээл
34

Хиламан 6–12

Зорилго

Ангийн гишүүдэд зөв шударга байдлаас бусармаг явдал руу мөн түүнээсээ буцаж зөв шударга байдалд хүрэх тойргийг мэдэхэд туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:

- а. Хиламан 6:1–14. Лэмэнчүүд Нифайчуудаас илүү зөв шударга болдог. Хүмүүс адислагдан амар амгалан аж төрж, хөгжин дэвждэг.
- б. Хиламан 6:15–10:1. Нифайчууд бардам, нүгэлтэй болдог. Нифай хүмүүст наманчлахыг уриалан дууддаг. Тэргүүн шүүгчийн аллагыг тойрсон үйл явдлуудыг гэрчилснийх нь дараа зарим хүмүүс Нифайг бошиглогч хэмээн хүлээн авсан боловч ихэнх нь наманчлалгүй үлддэг.
- в. Хиламан 10:2–11:6. Их Эзэн Нифайд холбох хүчийг өгдөг. Нифай Их Эзэнээс Нифайчууд руу өлсгөлөн илгээж цээрлүүлэхийг гуйдаг.
- г. Хиламан 11:7–38; 12. Нифайчууд өөрсдийгөө даруусган наманчилдаг. Их Эзэн Нифайн хүсэлтээр бороо илгээж, Нифайчууд дахин адислагдаж амар амгалан аж төрж, хөгжин дэвждэг. Мормон зөв шударга байдал, бусармаг явдлын тойргийг тодорхойлон тус тойргийг хэрхэн таслахыг хэлдэг.

2. Дараах үгийн хайчилбаруудыг бэлтгэ:

Зөв Шударга Байдал ба Хөгжил Дэвшил

Бардамнал ба Бусармаг Явдал

Сүйрэл ба Зовлон Зүдгүүр

Төлөв Даруу Байдал ба Наманчлал

Та үгийн хайчилбаруудыг хэрэглэхийг хүсэхгүй бол хичээлд хайчилбарууд хэрэгтэй болсон үед самбар дээр үгсийг бич.

3. Ангийн нэг гишүүнээр Хиламан 7:13–29; 8; 9 дээр гардаг үйл явдлуудыг товч яриулахаар даалга.

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Самбарт дараах тоонуудыг бич: 2, 3, 5, 8, 12


Эдгээр тоонууд ямар нэгэн онцгой дараалалтай гэдгийг цохон тэмдэглэ. Ангийн гишүүдээс энэхүү дарааллын дараах гурван тоо нь ямар тоо байхыг асуу. (Дараах гурван тоо нь 17, 23, 30 юм. Энэ загвар нь эхний тоонд 1, хоёр дахь тоонд 2, гурав тоонд 3-ыг нэмэх гэх мэтчилэнгээр хийгдсэн болохыг та тайлбарлаж өгөх нь зүйтэй.)

Мормоны Номонд энэ дараалалтай адил бараг урьдчилан хэлж болмоор загвар байдаг гэдгийг тайлбарла. Энэ загвар олон удаа давтагддаг. Энэ загварыг таньж мэдсэнээр бид Нифайчуудыг мөхөл рүү хөтөлсөн зүйлүүдийг хийхээс зайлсхийж чадна.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

Тус хичээл нь дөрвөн хэсэгт хуваагдана. Хэсэг тус бүр нь бардамналын тойргийн нэг үе шатыг хамардаг. Заасан хугацааны дагуу самбарт хэсэг тус бүрт хамааралтай үгийн хайчилбаруудыг байрлуул. Дор харуулсан үгийн хайчилбаруудыг холбох сумнуудыг зур:



1. Хүмүүс зөв шударга байснаараа адислагдан амар амгалан аж төрж, хөгжин дэвждэг.

Хиламан 6:1–14-өөс сонгосон шүлгүүдийг уншиж ярилц. Ангийн гишүүдэд Нифай, Лихай хоёр Лэмэнчүүдэд номлохоор явсан номлогч нар байсан бөгөөд олон хүнд наманчилж, усаар батлуулахад нь тусалсан гэдгийг сануул. Лэмэнчүүд удалгүй Нифайчуудаас илүү зөв шударга болдог.

- Лэмэнчүүдэд Нифайчуудын ихэнхийг бодвол илүү зөв шударга болоход нь тусалсан ямар зан чанарууд байсан бэ? (Хиламан 6:1-ийг үз.) Хөрвүүлэгдсэн Лэмэнчүүд Нифайчуудад туслахыг хэрхэн оролдож байсан бэ? (Хиламан 6:4–6-г үз.) Үр дүнд нь юу болсон бэ? (Хиламан 6:7–14-ийг үз.)

Самбарт *Зөв Шударга Байдал ба Хөгжил Дэвшил* гэсэн үгийн хайчилбараа байрлуул.

2. Нифайчууд бардам, нүгэлтэй болдог. Нифай хүмүүст наманчлахыг уриалан дууддаг.

Хиламан 6:15–10:1-ийг ярилц. Ангийн гишүүдийг сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь. Нифайчууд хөгжиж дэвжээд ирснийхээ дараа тэдний ихэнх нь Бурханаа мартаж эхлэн эд баялаг, дэлхийн зүйлсийг эрэлхийлж эхэлсэн гэдгийг онцлон тэмдэглэ.

Самбарт *Бардамнал ба Бусармаг Явдал* гэсэн үгийн хайчилбараа байрлуул.

- Хөгжиж дэвжих нь бусармаг явдал руу яагаад олонтаа хөтөлдөг вэ? (Хиламан 6:17; 7:20–21-ийг үз.)
- Ангийн гишүүдээр Хиламан 6:21–24 болон 7:4–5-ыг уншуулж, Гадиантоны дээрэмчдийн зан чанарыг тодорхойлуул. Эдгээр байдлуудын аль нь өнөө үед байдаг вэ? Бид нийгэмдээ хилэнцэт нөлөөллийн эсрэг хэрхэн оновчтой тэмцэж чадах вэ?
- Хэн нууц явуулгуудын эх үүсвэр байсан бэ? (Хиламан 6:25–30-ийг үз.) Сатан “Нифайчуудын зүрх сэтгэлд агуу их нөлөөллийг олоход” тэд юу хийсэн бэ? (Хиламан 6:31-ийг үз.)

Ангийн гишүүдээр Хиламан 6:34–38-ыг уншуулан Нифайчууд болон Лэмэнчүүдийн хоорондын ялгааг олуул. Та ангийн гишүүдийн хариултуудыг доорх бүдүүвчийн адил самбарт хураангуйлж болно:

НИФАЙЧУУД	ЛЭМЭНЧҮҮД
Итгэлгүйдээ бууран доройтсон (шүлэг 34).	Бурханыхаа мэдлэгт өссөн (шүлэг 34).
Ёсон бусад мөн нүгэлдээ улам бүр автсан (шүлэг 34).	Бурханы өмнө зөв шударгаар мөн үнэнээр алхсан (шүлэг 34).
Их Эзэний Сүнсний удирдамжийг алдсан (шүлэг 35).	Сүнсийг хүлээн авсан (шүлэг 36).
Гадиантоны дээрэмчдийн бүлгийг өсгөж дэмжсэн (шүлэг 38).	Гадиантоны дээрэмчдэд Бурханы үгийг номлосон (шүлэг 37).

- Сүнс яагаад “Нифайчуудаас холдсон” бэ? (Хиламан 6:35-ыг үз.) Их Эзэн яагаад “Лэмэнчүүдийн дээр Сүнсээ юүлсэн” бэ? (Хиламан 6:36-г үз.) Ариун Сүнсний нөлөөллийг хэрхэн хүлээн авч болох талаар энэ нь бидэнд юу зааж болох вэ?

Нифайчуудыг бусармаг явдлаа үргэлжлүүлэхэд нь Их Эзэн Хиламаны хүү Нифайг тэдэн рүү наманчлуулахаар илгээдэг. Нифай хүмүүсийн бусармаг

явдлыг хараад “зүрх нь цээжин дотроо харамслаар тэлэв” (Хиламан 7:6). Тэрээр цэцэрлэгийн цамхаг дээр гарч залбирахаар сөгдөв. Түүнийг Бурханд сэтгэлээ юулж байхад хүмүүсийн бусармаг байдлын төлөө гашуудлынх нь шалтгааныг мэдэхийн тулд хүмүүс цуглан ирцгээв (Хиламан 7:11).

Урьдчилан даалгасан ангийн нэг гишүүнээр Хиламан 7:13–29; 8; 9-ийн үйл явдлуудыг товч яриул.

- Нифай хүмүүсийг бусармаг байдлынх нь төлөө буруушаахад хүмүүс үүнд хэрхэн хандсан бэ? (Хиламан 8:1–10-ыг үз.) Тийм олон хүмүүс яагаад наманчлаагүй байсаар байсан бэ?
- Сийнтум өөрийн ах тэргүүн шүүгчийг алснаа хүлээхэд хүмүүс үүнд хэрхэн хандсан бэ? (Хиламан 9:39–10:1-ийг үз.) Хүмүүс Нифайг бошиглогч уу аль эсвэл бурхан уу хэмээн маргалдсаныхаа дараа түүнийг ганцааранг нь орхив. Юу биднийг хожмын үеийн бошиглогчдыг сонсуулдаггүй вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон ийнхүү хэлсэн: “Хоёр төрлийн бардам хүмүүст бошиглогчийг дагахад ихээхэн хүндрэл учирдаг. Нэг нь мэдлэгтэй хүмүүс, нөгөөх нь чинээлэг хүмүүс. Мэдлэгтэй нь бошиглогчийг тэдэнтэй санал нэгтэй байвал л сүнсэлэг урамтай байна гэж боддог ба тэгэхгүй бол бошиглогч ердөө л нэг өөрийнхөө санааг гаргаж байна буюу жирийн хүн шиг ярьж байна гэж боддог. Чинээлэг нь дорд бошиглогчийн зөвлөгөө тэдэнд хэрэггүй гэж боддог” (*The Teachings of Ezra Taft Benson* [1988], 138).

3. Их Эзэн Нифайд холбох хүчийг өгдөг. Наманчлаагүй Нифайчуудад дайн дажин, өлсгөлөн нүүрлэдэг.

Хиламан 10:2–11:6-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Нифайчууд Их Эзэнийг мартаж бусармаг явдлаа үргэлжлүүлсэн. Тэдний бусармаг явдлаас болж хүмүүст тэвчишгүй их сүйрэл, зовлон зүдгүүр нүүрлэдэг.

- Их Эзэн Нифайд холбох хүчийг өгөхдөө, “Бүх зүйл [Нифайн] үгийн дагуу хийгдсэн байх [болно]” гэсэн (Хиламан 10:5–10). Их Эзэн Нифайд ийм агуу их хүчийг яагаад хариуцуулсан бэ? (Хиламан 10:4–5-ыг үз.)
- Хүмүүс Нифайгаас татгалзаж Бурханд дуулгаваргүй болоход тэдэнд юу тохиолдсон бэ? (Хиламан 10:18–11:2-ыг үз.) Хүмүүст Бурханаа санаж наманчлахад нь туслахын тулд Нифай юуны төлөө залбирсан бэ? (Хиламан 11:4-ийг үз.) Нифайн залбирлын хариу хэрхэн ирсэн бэ? (Хиламан 11:5–8-ыг үз.)

Самбарт *Сүйрэл ба Зовлон Зүдгүүр* гэсэн үгийн хайчилбараа байрлуул.

4. Нифайчууд өөрсдийгөө даруусган наманчилдаг.

Хиламан 11:7–38; 12-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Өлсгөлөнгийн сүйрэл ба зовлон зүдгүүр нь Нифайчуудыг Их Эзэн рүү тусламж авахаар хандахад нөлөөлсөн гэдгийг тайлбарла. Тэд өөрсдийгөө даруусган наманчилдаг.

Самбарт *Төлөв Даруу Байдал ба Наманчлал* гэсэн үгийн хайчилбараа байрлуул.

- Өлсгөлөнг дуусгахыг хүссэн Нифайн залбиралд өгсөн Их Эзэний хариугаас бид юу сурч болох вэ? (Хиламан 11:10–17-г үз.) Их Эзэн

өлсгөлөнг дуусгахаасаа өмнө хүмүүсээс юу шаардсан бэ? (Хиламан 11:14–15-ыг үз.)

- Хүмүүс итгэлтэй байсныхаа төлөө дахин хэрхэн адислагдсан бэ? (Хиламан 11:20–21-ийг үз.)
- Хоромхон зуурын төлөв даруу байдал болон зөв шударга амьдрал төгссөний анхны шинж тэмдэг нь юу байсан бэ? (Хиламан 11:22-ыг үз.) Нифай, Лихай болон тэдний ахан дүүс энэхүү маргааныг хэрхэн эцэслэсэн бэ? (Хиламан 11:23-ыг үз.) “Сургаалын үнэний утга санааг” заах нь маргааныг эцэслэхэд бидэнд ямар аргаар тусалж болох вэ?
- Бусармаг явдал болон дайны сүйрлийн бас нэг өөр үеийн дараа наманчилж Их Эзэнд эргэхэд хүмүүст юу тусалсан бэ? (Хиламан 11:28–34-ийг үз.) Бид үүнтэй ижил төстэй бусармаг явдлаар хүрээлүүлсэн байх үедээ үргэлж Их Эзэнийг санаж байхын тулд юу хийж болох вэ?
- Хоёр жилийн дараа Нифайчууд “Их Эзэн Бурханаа дахин мартаж эхлэв” (Хиламан 11:36). Хүмүүс яагаад Их Эзэнийг амархан мартдаг гэж та нар бодож байна вэ? Өнөөдөр бид Их Эзэнийг ямар байдлаар мартдаг байж болох вэ?
- Мормон, “Хүмүүний үрс. . . газрын тоосноос ч өчүүхэн” гэсэн (Хиламан 12:7). Тэрээр энэхүү мэдэгдлийг ямар зарчимд тулгуурлан хийсэн бэ? (Ангийн гишүүдээр Хиламан 12:1–6, 8-аас шүлгүүдийг ээлжлүүлэн уншуул.)
- Бид Бурханы зарлигуудыг дуулгавартай дагах, дагахгүй байх эрхтэй ч, бид үйлдлийнхээ үр дагаврыг сонгодоггүй. Дуулгаваргүй хүмүүсийг ямар хувь тавилан хүлээнэ гэж Мормон хэлсэн бэ? (Хиламан 12:25–26-г үз.) Наманчилж Их Эзэнд дуулгавартай байдаг хүмүүсийг ямар хувь тавилан хүлээх вэ? (Хиламан 12:23–24, 26-г үз.)
- Ангийн гишүүдийн анхаарлыг самбар дээрх тойрог руу хандуул. Хүмүүс энэхүү тойргийг хэрхэн тасдан гарч чадах вэ? (Алма 62:48–51; мөн Хиламан 12:23–24-ийг үз.)

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли: “Хуурамч бус, жинхэнэ юмсыг эрэлхийл. Замхарч алга болох шохоорхлыг бус, мөнхөд үргэлжлэх үнэнийг эрэлхийл. Өнөөдөр байж байгаад маргааш нь үгүй болох юмсыг бус, Бурханы мөнхийн юмсыг эрэлхийл. Бурхан руу харж амьдар” гэж хэлсэн (*Teachings of Gordon B. Hinckley* [1997], 494).

Дүгнэлт

Мормоны Номын тухай өгүүлж буй Ахлагч Гордон Б.Хинклигийн дараах мэдэгдлийг унш:

“Хүмүүс болон хүн ард Бурханы айдас дотор мөн түүний зарлигуудад дуулгавартай явбал тэд хөгжин дэвшиж өсдөг боловч тэд түүнээс болон түүний үгнээс зөрвөл өмхрөл явагдаж түүнийг зөв шударга ёс зогсоохоос нааш тэр нь доройтол болон үхэл рүү хөтөлдөг бодит байдлыг ийм тод харуулсан өөр ямар ч гэрээ бичигдээгүй билээ” (in *Conference Report*, Oct. 1979, 10; or *Ensign*, Nov. 1979, 8).

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. Бардамналын тойргоос зайлсхийх нь

Ангийн гишүүдээс тэдний ичмээр эсвэл тэнэг алдаа буюу хийсэн сонголтоо тухай бодохыг хүс. Тэгээд дараа нь тэднээс ийм алдаагаа давтахгүйн тулд тэд юу хийснийг асуу. Ангийн гишүүдэд эдгээр тохиолдлоосоо хуваалцах боломж олго.

Нифайчууд зөв шударга байдлаас бусармаг явдал руу хөтлөх, сүйрэл болон зовлон зүдгүүрээр төгсөх шийдвэрүүдийг яагаад гаргасаар байсныг ярилц.

- Нифайчуудын хийсэн алдаанаас зайлсхийхэд бидэнд туслах ямар зүйлийг бид Нифайчуудаас сурч болох вэ?

2. “Тэд Христийн ирэлтийн талаар гэрчилсэн” (Хиламан 8:22)

Тэнгэр болон газар дээрх бүх зүйлсийг хийдгийн адил бошиглогчид Есүс Христийг гэрчилдэг гэдгийг тайлбарла. Дараа нь ангийн гишүүдээр Хиламан 8:11–24-ийн шүлгүүдийг ээлж ээлжээр нь уншуулж эдгээр шүлгүүд дэх Аврагчийн тухай олон гэрчлэлүүдийг олуул. Энэхүү ярилцлагынхаа нэгэн хэсэг болгон та Мосегийн зэсэн могойн тухай хэсэгт анхаарал хандуулж болно:

- Зэсэн могой юуны бэлэгдэл байсан бэ? (Хиламан 8:13–15; мөн Тооллого 21:6–9; Иохан 3:14–16-г үз.) Бид Христэд итгэх итгэлээ хэрхэн өсгөж чадах вэ? Та нарын Христэд итгэх итгэл болон Түүний Цагаатгал амьдралд чинь хэрхэн нөлөөлсөн бэ?

Та ярилцлагаа төгсгөхдөө чуулгын материалаас одоогийн Сүмийн Ерөнхийлөгчийн гэрчлэлийг уншиж өгч болно.

Хиламан 13–16

Зорилго	Наманчилж Их Эзэндээ хандан бошиглогчдыг дагахын чухлыг ангийн гишүүдэд сануулах болно.
Бэлтгэл	<ol style="list-style-type: none">1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:<ol style="list-style-type: none">а. Хиламан 13. Лэмэнчүүдийн Сэмүэл хэмээх бошиглогч Нифайчуудыг наманчлахгүй бол устгагдах болно гэж бошиглодог.б. Хиламан 14. Сэмүэл Аврагчийн мэндлэх болон нас барахынх нь өмнөх тэмдгүүдийг бошиглодог. Тэрээр хүмүүсийг наманчлахыг дуудсаар байдаг.в. Хиламан 15–16. Сэмүэл Нифайчуудад Лэмэнчүүдийн хөрвүүлэлтийн тухай хэлдэг. Нифайчуудын зарим нь Сэмүэлд итгэж усаар батлуулдаг. Бусад нь зүрх сэтгэлээ хатууруулан Сэмүэлийг алах гэж оролддог боловч тэрээр Бурханы хүчээр хамгаалуулдаг.2. Лэмэнчүүдийн Сэмүэл Хэрмэн Дээр (62370; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 314) зураг байгаа бол хичээлдээ хэрэглэхээр бэлтгэ.

Хичээлийг Баяжуулах Зөвлөмж

Анхаарал Татах Үйл Ажиллагаа	<p>Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.</p> <p>Ангийн гишүүдээс ердөө нэг л зарах юмтай худалдаачныг төсөөлөхийг хүс. Энэ нь: өвчин зовлон.</p> <ul style="list-style-type: none">• Энэ худалдаачин бараагаа зарахын тулд юу хийж болох вэ? (Хариултанд тэрээр бараагаа сэтгэл татам болгох эсвэл бараа нь өвчин зовлон бус аз жаргал болно гэж хүмүүсийг хуурч итгүүлэх орж болно.)• Сатанд өвчин зовлонгоос өөр санал болгох юм юу ч байхгүй (2 Нифай 2:17–18, 27). Сатан өвчин зовлон болон нүглийг хэрхэн сэтгэл татам болгодог вэ? Тэрээр хүмүүст аз жаргал, зөв шударга байдлыг хэрхэн хүсмээргүй зүйл болгон итгүүлэхийг оролддог вэ? <p>Энэ хичээлд та Лэмэнчүүдийн бошиглогч Сэмүэлийн бошиглолуудын талаар ярилцахаа хэл. Сэмүэл Сатаны руу таталтуудад автсан хэсэг Нифайчуудад номлодог. Тэд “алдсыг үйлдэж аз жаргалыг эрэлхийлсэн нь” Бурханы мөн чанарын эсрэг зүйл байсан (Хиламан 13:38).</p>
---------------------------------	---

Судрын Ярилцлага ба Хэрэглээ	Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын
---------------------------------	---

зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Сэмүэл Нифайчуудыг наманчлахгүй бол устгагдах болно гэж анхааруулдаг.

Хиламан 13-ыг ярилц. Ангийн гишүүээс сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь. Лэмэнчүүдийн Сэмүэл хэмээх бошиглогч Зарахэмлад номлохоор очсон боловч Нифайчууд түүнийг нутгаасаа хөөн гаргасан гэдгийг тайлбарла. Их Эзэн Сэмүэлд Зарахэмла руу буцаж бошиглохыг зарлигласан. Нифайчууд Сэмүэлийг хот руу оруулахгүй байсан тул тэрээр хотын хэрмэн дээр гарч тэдэнд бошиглосон (Хиламан 13:1–4). Сэмүэлийн зураг байгаа бол түүнийгээ хичээлийн туршид үзүүлэхээр байрлуул.

- Сэмүэл хүмүүст тэднийг зүрх сэтгэлээ хатууруулснаас нь болж Их Эзэн Өөрийнхөө үгийг тэднээс буцаан авч, тэднээс Сүнсээ авах болно гэж анхааруулсан (Хиламан 13:1–8). Зүрх сэтгэлээ хатууруулсан хүмүүст эдгээр үр дагаврууд яагаад ирэх вэ? (Мозая 2:36–37-г үз.) Бид зүрх сэтгэлээ зөөлрүүлэхийн тулд юу хийж болох вэ?
- Их Эзэн бошиглогч Сэмүэлээр дамжуулан “Наманчлах мөн надад хандах тэд ивээгдсэн болой” гэсэн (Хиламан 13:11). Зарим хүмүүс Их Эзэнд хандахгүйгээр наманчлах гэж хэрхэн оролдож болох вэ? Их Эзэнд хандах нь яагаад наманчлалын салшгүй хэсэг байдаг вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон ийнхүү заасан:

“Наманчлал нь зүгээр нэг биеэ авч яваа байдлаа өөрчлөхөөс ч илүү зүйл юм. Дэлхий дээрх олон эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд махан биеийн муу зуршил болон дорой байдлыг давж гарахад агуу их хүсэл эрмэлзэл болон өөрийгөө хянах чадвараа харуулдаг. Энэ үед тэд Эзэнийг боддоггүй, заримдаа бүр Түүнийг нээлттэйгээр эсэргүүцдэг. Ийнхүү өөрийгөө өөрчлөх явдал нь жинхэнэ наманчлалыг илтгэдэггүй. . . .

“. . . Жинхэнэ наманчлал нь Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл дээр үндэслэн гарч ирдэг. Өөр ямар ч зам үгүй билээ. Жинхэнэ наманчлал нь зөвхөн өөрийгөө өөрчлөх байдлыг бус, бас зүрх сэтгэлийн өөрчлөлтийг багтаадаг (Алма 5:13-ыг үз)” (*The Teachings of Ezra Taft Benson* [1988], 71).

- Нифайчууд “зүрх сэтгэлээ баялгууд дээр тавьсан” (Хиламан 13:20–21). Нэмж хэлэхэд, тэд тэдэнд эд баялгуудыг өгсөн Их Эзэний үгийг сонсоогүй (Хиламан 13:21). Үүний улмаас Нифайчууд болон тэдний эд баялаг хараагдсан (Хиламан 13:17–22). Хүмүүс сүнслэг зүйлүүдээс илүү дэлхийн зүйлст цаг зав, анхаарлаа ямар байдлаар тавьдаг вэ? Бид сүнслэг сайн сайхандаа хангалттай анхаарал тавьж байгаа эсэхээ хэрхэн мэдэж болох вэ?
- Нифайчууд эд баялгаа үргэлж санаж байсан боловч тэдгээрийнхээ төлөө Их Эзэнд талархахаа санадаггүй байсан гэж Сэмүэл хэлсэн (Хиламан 13:22). Зарим хүмүүсийн хувьд элбэг дэлбэг байдлаар адислуулчихаад талархахад яагаад хэцүү байдаг вэ? Талархал хэрхэн бардамналыг үгүйсгэдэг вэ? Бид Их Эзэнд талархлаа ямар байдлаар харуулж болох вэ?
- Нифайчууд тэр үеийнхээ бошиглогчдыг мөрдөн алсан хэрнээ ингэж хэлжээ, “Хэрэв бидний өдрүүд хуучны эцэг өвгөдийн минь өдрүүдэд байсан бол, бид бошиглогчдыг алахгүй байсан” (Хиламан 13:24–25; Матай

23:29–39-тэй харьцуул). Хүмүүс заримдаа яагаад өнгөрсөн үеийн бошиглогчдыг магтан амьдарч буй бошиглогчдыг эсэргүүцдэг вэ? (Хиламан 13:26-г үз.) Зарим хүмүүс хэрхэн “мунхаг мөн сохор удирдагчдаар дагуулагддаг” вэ? (Хиламан 13:27–29-ийг үз.)

- Сэмүэлийн хэлсэнчлэн Нифайчууд “алдсыг үйлдэж аз жаргалыг эрэлхийлсэн” (Хиламан 13:38). Нүглээс жинхэнэ аз жаргалыг яагаад олж болдоггүй вэ? (Хиламан 13:38; мөн Алма 41:10–11-ийг үз.) Бид хэрхэн аз жаргалыг олж болох вэ? (Та ангийн гишүүдийн хариултыг авахаас гадна бас дараах мэдэгдлийг уншиж өгч болно.) Бид бусдад жинхэнэ аз жаргалыг олоход нь хэрхэн тусалж болох вэ?

Бошиглогч Иосеф Смит ийнхүү хэлсэн: “Аз жаргал бол бидний оршлын зорилго болон хэв загвар юм; бид түүнд хүрэх зам дээр гарч чадвал зорилгодоо хүрнэ; тэгээд энэ зам нь ариун журам, үнэнч шударга байдал, итгэлтэй байдал, цэвэр ариун байдал болон Бурханы бүх зарлигуудыг дагахыг хэлнэ” (*Teachings of the Prophet Joseph Smith*, sel. Joseph Fielding Smith [1976], 255–56).

2. Сэмүэл Аврагчийн мэндлэх болон нас барахын өмнөх тэмдгүүдийг бошиглодог. Тэрээр хүмүүсийг наманчлахыг дуудсаар байдаг.

Хиламан 14-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Сэмүэл Аврагчийн мэндлэх болон нас барах тухай бошиглодог (Хиламан 14:2, 15). Аврагчийг мэндлэх болон нас барахад ямар тэмдгүүд үзэгдэнэ гэж Сэмүэл хэлсэн бэ? (Хиламан 14:3–7, 20–28-ыг үз. Эдгээр бошиглолуудыг нэмэлт заах санаанд дурдсан байгаа. Эдгээр бошиглолуудын биелэлтийг 36-р хичээлд ярилцах болно.)
- Хүмүүс наманчилбал тэд Христийн гавьяа зүтгэлээр дамжуулан нүглийнхээ өршөөлийг хүлээн авах болно гэж Сэмүэл хэлсэн (Хиламан 14:13). Гавьяа зүтгэл гэдэг нь ямар нэгэн хүнд шагнал хүртэх эрхийг олгох чанар буюу үйлдэл юм. Бид яагаад зөвхөн Аврагчийн гавьяа зүтгэлээр л дамжуулан нүглээсээ өршөөгдөж чадах вэ? (2 Нифай 2:7–9; мөн Алма 22:14-ийг үз.)

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон ийнхүү заасан: “Тэр ч бүү хэл хамгийн шударга болон үнэнч хүн өөрөө өөрийгөө цор ганцаараа өөрийнхөө гавьяа зүтгэлээр аварч чадахгүй” (*The Teachings of Ezra Taft Benson*, 71).


- Сэмүэлийн хэлснээр Есүс яагаад үхэх ёстой вэ? (Хиламан 14:15–18-ыг үз.) Аврагчийн золиослолыг мэдэх нь та нарт хэрхэн нөлөөлсөн бэ?
- Сэмүэл, “Хэрэв хүмүүс буруушаагдвал тэд өөрсдийн дээр буруушаалтыг авчрах бөлгөө” гэж хэлсэн (Хиламан 14:29). Яагаад вэ? (Хиламан 14:30–31-ийг үз.) Бид яагаад “[өөрсдийнхөө] төлөө үйлдэхээр зөвшөөрөгдсөн” байх нь чухал вэ?

3. Нифайчуудын зарим нь Сэмүэлд итгэж усаар батлуулдаг. Бусад нь зүрх сэтгэлээ хатууруулан Сэмүэлийг алах гэж оролддог.

Хиламан 15–16-гаас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Их Эзэн Нифайчуудыг яагаад хашраасан бэ? (Хиламан 15:3; мөн Хиламан 12:6-г үз.) Их Эзэний хашраах явдал нь бидэнд түүний хайрыг хэрхэн үзүүлдэг вэ? Их Эзэний хашраах явдлаас бид юу сурч болох вэ?

Ангийн нэг гишүүнээр Хиламан 15:7–8-ыг чангаар уншуул. Унших хооронд нь самбарт дараах бүдүүвчийг зур:



- Үнэний мэдлэг болон судруудад итгэх итгэл нь итгэл болон наманчлал руу ямар арга замаар хөтөлдөг вэ? Итгэл болон наманчлал зүрх сэтгэлийн өөрчлөлт рүү ямар арга замаар хөтөлдөг вэ?
- Зүрх сэтгэлийн өөрчлөлтийг үзсэн Лэмэнчүүд “итгэлдээ гуйвшгүй ба тууштай” үлдсэн (Хиламан 15:8). Бид зүрх сэтгэлийн өөрчлөлтийг мэдрэхэд энэ өөрчлөлтийг үргэлж явагдаж байхыг бататгахын тулд юу хийх ёстой вэ? (2 Нифай 31:19–20-ийг үз.)
- Нифайчууд Сэмүэлийн бошиглол болон анхааруулгад хэрхэн хандсан бэ? (Хиламан 16:1–7-г үз.) Хүмүүсийн ихэнх нь Сэмүэлийг гайхамшигтайгаар хамгаалагдахыг нь харсан ч түүнд яагаад итгээгүй гэж та нар бодож байна вэ?
- Хэдийгээр тэд бошиглогчдын үгс биелэхийг харсан ч Нифайчуудын ихэнх нь зүрх сэтгэлээ хатууруулж эхлэн өөрсдийн хүч, мэргэн ухаандаа найдах болсон (Хиламан 16:13–15). Эдгээр итгэлгүй Нифайчууд өөрсдийн үзсэн тэмдгүүдийг хэрхэн үгүйсгэн тайлбарлаж байсан бэ? (Хиламан 16:16–23-ыг үз.) Зөвхөн өөрийн оюун ухаанаар сайн мэдээг ойлгохыг оролдох нь юугаараа аюултай вэ?

Дүгнэлт

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Сэмүэлийн бошиглолуудыг тоймлож, мөн эдгээр бошиглолуудыг судлах нь бидэнд Аврагчийн Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэхэд хэрхэн туслахыг харуулахын тулд та заах нэмэлт санааг ашиглаж болно.

Заах Нэмэлт
Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэ санааг хичээлдээ хэрэглэж болно.

Хоёр дахь Ирэлтэнд Бэлтгэх нь

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны дараах мэдэгдлийг унш:

“Аврагчийг айлчилж ирэхийн өмнөх Нифайчуудын түүхийн цэдэг Аврагчийн хоёр дахь ирэлтэнд бид өнөө үед оролцохтой адил төстэй олон

зүйлүүдийг илчилдэг” (in Conference Report, Apr. 1987, 3; or *Ensign*, May 1987, 4).

Тус мэдэгдэл дэх Ерөнхийлөгч Бэнсоны дурдаж буй “Нифайчуудын түүхийн бичээс” нь дахин амилсан Их Эзэнийг айлчлахын нь өмнөх Нифайчуудын түүхийг агуулсан 3 Нифайн Ном юм. Дараах бүдүүвч нь Нифайчуудыг Аврагчийн мэндэлсний тэмдгүүдийг харахаас өмнөх түүх болох Хиламаны Номын тухай Ерөнхийлөгч Бэнсоны мэдэгдэлтэй холбоотой юм.

Есүс Христийн хоёр дахь ирэлтийн өмнө үзэгдэх шинж тэмдгүүд, үйл явдлуудтай ижил төстэй Хиламан 13–16-д агуулагдсан бошиглолууд болон үйл явдлуудыг харуулахын тулд уг бүдүүвчийг ашигла.

Хиламан 13–16-д Тэмдэглэгдсэн Бошиглолууд Болон Үйл Явдлууд	Бошиглол Буюу Үйл Явдал	Хоёр Дахь Ирэлтийн Өмнө Үзэгдэх Тэмдгүүд Болон Үйл Явдлууд
Хиламан 16:1, 3, 6, 10	Хүчтэй зөв шударга цөөнх	1 Нифай 14:12; Иаков 5:70
Хиламан 16:13–14	Сүнслэг асаралт ба гайхамшгууд	Иоел 2:28–30; С ба Г 45:39–42
Хиламан 13:22; 16:12; 22–23	Маш их бусармаг явдал	2 Тимот 3:1–5; С ба Г 45:27
Хиламан 13:2, 6, 8, 10–11; 14:9, 11; 15:1–3, 17; 16:2	Их Эзэний бошиглогчдыг эсэргүүцэх явдал ба тэдгээрийг наманчлалд дуудсан нь	С ба Г 1:14–16
Хиламан 15:4–11	Лэмэнчүүдийн олонхын хөрвүүлэлт	С ба Г 49:24
Хиламан 14:3–4	Харанхуйгүй шөнийн талаарх бошиглол	Зехариа 14:7
Хиламан 14:5–6, 20	Тэнгэр дэх тэмдгүүд болон гайхамшгуудын талаарх бошиглол	Иоел 2:30–31; С ба Г 45:40
Хиламан 16:13–18	Тэмдгүүд, гайхамшгууд болон Христийн ирэлтийг үгүйсгэсэн нь	2 Петр 3:3–4; С ба Г 45:26
Хиламан 14:21, 23, 26	Агуу их салхи шуурга болон бусад байгалийн сүйрлийн талаарх бошиглол	Илчлэлт 16:18, 21; С ба Г 88:88–90
Хиламан 14:24; 15:1	Бусармаг явалтнуудын устгалын талаарх бошиглол	Исаиа 26:21; Малахи 4:1; С ба Г 1:9; 133:41

- Өнөөгийн хүмүүс болон Христийг мэндлэхийн яг өмнө нь амьдарч байсан хүмүүсийн хооронд ямар ижил төстэй зүйлүүд байна вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны дараах мэдэгдлийг унш:

“Мормоны Номонд бид Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэх загварыг хардаг. Номын ихэнх хэсэг нь Христийн Америкт ирэхийн яг өмнөх хэдэн арван жил дээр төвлөрдөг. Энэхүү хугацааг бид анхааралтай судалснаар зарим нь яагаад

Түүний ирэлтийн өмнө болсон аймшигт шүүлтэнд устгагдаж, бусад нь Элбэг Дэлбэгийн газарт ариун сүмд авчрагдан түүний мутар дахь мөн түүний хөлөн дэх хадаасны оруудыг тэмтрэн зогсож байсныг мэдэх болно. . . . Энэ ном бидэнд л зориулагдсан байсан бөгөөд үүнээс л бид агуу их хүч чадал, агуу их тайтгарал, мөн агуу их хамгаалалтыг олж авдаг гэдэгт хэн нэгэн эргэлзэж чадна гэж үү?" (in Conference Report, Oct. 1986, 5–6; or *Ensign*, Nov. 1986, 6–7).

Ангийн гишүүдийг Хиламан 13–16-г ярилцахад төрсөн санал бодол, сэтгэгдлээ ярилцахыг урь. Аврагчийн Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэхэд эдгээр зүйлс тэдэнд хэрхэн тусалж болохыг асуу.

“Маргааш Би Дэлхийд Ирэх Бөлгөө”

Хичээл
36

3 Нифай 1–7

Зорилго Ангийн гишүүдэд сорилт болон уруу таталттай үед итгэлтэйгээр эцсээ хүртлээ тэвчих хэрэгтэй гэдгийг ойлгоход нь туслах болно.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. 3 Нифай 1:1–22. Газар нутаг дахь тэмдэг болон гайхамшгуудыг үл харгалзан үл итгэгчид Аврагчийн ирэх хугацааг өнгөрсөн гэж байдаг. Бусармаг явдалдтнууд итгэгчдийг алахаар төлөвлөдөг. Аврагчийн төрөлтийг илтгэх тэмдгүүд үзэгдэж, эцсээ хүртэл итгэлтэй байгсдыг хамгаалдаг.
 - б. 3 Нифай 2–4. Газар нутаг даяар бусармаг явдал өсөн нэмэгддэг. Гадиантоны дээрэмчид хүчирхэгжин Нифайчуудтай тулалдахаар ирдэг. Нифайчууд нүглээ наманчилдаг бөгөөд Их Эзэн тэдэнд Гадиантоны дээрэмчдийг ялахад тусалдаг.
 - в. 3 Нифай 5–7. Нифайчууд нүглээ бүрмөсөн орхин зөв шударга амьдардаг. Тэд хөгжин дэвжихийн зэрэгцээгээр Сүмд бардамнал болон сөргөлдөөн өсөн нэмэгддэг. Удалгүй хүмүүс “аймшигт ёсон бус байдалд” амьдарч байлаа. Нифай наманчлал болон Христэд итгэх итгэлийг номлон хэдэн хүмүүс хөрвүүлэгддэг.

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Ангийн гишүүдтэй Арван Хоёрын Чуулгын гишүүн асан Ахлагч Жорж А.Смитийн ярьсан дараах ёгт үлгэрийг хуваалц:

“Нэгэн аялагч маш баян, тансаг, том хотод ирээд хотыг үзээд хөтөчдөө ингэж хэлжээ, ‘Энэ хотын нэг жижигхэн чөтгөрийг эс тооцвол энд зөв шударга хүмүүс маш их байдаг байж таарна.’

“Хөтөч, ‘Эрхэм ээ, та ойлгоогүй бололтой. Энэ хот бүх төрлийн бусармаг явдал, хээл хахууль, доройтол болон жигшүүрт хэрэгт их гүн гүнзгий автсан тул тэд бүгдийг захирахын тулд ердөө л ганцхан чөтгөр хэрэгтэй,’ гэж хэлжээ.

“Цааш жаахан яваад тэрээр хивсээр хучсан зам дээр хүрч ирлээ. Тэгээд тэр аварга том догшин ширүүн чөтгөрүүдээр хүрээлүүлсэн нэг хүн уул өөд гарах гэж оролдож байхыг харлаа.

“‘Пөөх, энэ хүн маш их нүгэлтэй байж таараа, түүнийг тойроод хэчнээн чөтгөр байгааг хар л даа!’ хэмээн аялагч хэлэв.

“Хөтөч түүнд, ‘Энэ бол энэ улс дахь цорын ганц зөв шударга хүн билээ. Хамгийн том долоон чөтгөр түүнийг замаас нь гаргах гэж оролдоод дийлэхгүй байгаа нь энэ дээ,’ хэмээн хариулсан юм” (in *Deseret News*, 11 Nov. 1857, 7:287).

Бид зарлигуудыг итгэлтэйгээр дагахыг чармайхдаа эсрэг тэсрэг байдалтай тулгарна. Өнөөдрийн хичээлээр Нифайчуудын дундах итгэгчдэд тулгарсан эсрэг тэсрэг байдлуудыг ярилцах болно. Бүх эсрэг тэсрэг байдлуудыг үл харгалзан зарим нь эцсээ хүртэл тэвчиж байхад, нөгөө хэсэг нь агуу их адислалуудыг хүлээж авсан дороо “өөрсдийн зөв шударга байдлаас буцсан” (3 Нифай 7:8). Бид эдгээр бүлгүүдээс сорилт, уруу таталтуудыг үл харгалзан итгэлтэй үлдэхийн чухлыг суралцах болно.

Судрын Ярилцлага ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Аврагчийн төрөлтийг илтгэх тэмдгүүд эцсээ хүртэл итгэлтэй байгсдыг хамгаалдаг.

3 Нифай 1:1–22-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Тус бүлэг дэх үйл явдлууд Есүсийг мэндлэх тухай Сэмүэлийн бошиггосноос таван жилийн дараа болсон хэмээн тайлбарла. Сэмүэл, “Дахин таван жил өнгөрөхөд, мөн болгоогтун, тэгэхэд Бурханы Хүү . . . ирэх бөлгөө” гэж хэлсэн (Хиламан 14:2). Та Есүсийг мэндлэхэд дагалдах тэмдгүүдийн тухай Сэмүэлийн бошиглолыг товч тоймлож болно (Хиламан 14:2–7).

- Сэмүэлийн бошиглолын биелэлтийг хүлээхдээ “итгэсэн хүмүүс ихэд уйтгарлан гуньж эхлэв” (3 Нифай 1:7). Уйтгарлан гуних ямар шалтгаан байсан бэ? (3 Нифай 1:5–9-ийг үз.)
 - а. Зарим үл итгэгчид бошиглол биелэх хугацаа өнгөрсөн бөгөөд итгэгчид дэмий итгэж байжээ гэж ярьсан (3 Нифай 1:5–6).
 - б. Үл итгэгчид “уг нутаг даяар агуу их самууныг дэгдээсэн болой” (3 Нифай 1:7).
 - в. Бүх итгэгчдийг алах өдрийг тогтоосон (3 Нифай 1:9).
- Итгэлийнхээ сорилтуудыг үл харгалзан итгэгчид юу хийсэн бэ? (3 Нифай 1:8-ыг үз.) Итгэлээ сориулахад бид үнэнч үлдэхийн тулд юу хийж болох вэ?
- Нифай үл итгэгчдийн бусармаг явдлыг хараад ард олныхоо төлөө Их Эзэнд хандан залбирсан (3 Нифай 1:10–11). Түүнийг ард олныхоо төлөө залбирсны дараа ямар захиас түүнд илчлэгдсэн бэ? (3 Нифай 1:12–14-ийг үз. Та ангийн нэг гишүүнээр эдгээр шүлгүүдийг чангаар уншуулж болно.) Сэмүэлийн бошиглолууд хэрхэн биелсэн бэ? (3 Нифай 1:15–21-ийг үз.) Энэхүү ишлэл нь та нарт Есүс Христэд итгэх итгэлээ хүчирхэгжүүлэхэд хэрхэн тусалдаг вэ?

2. Гадиантоны дээрэмчид Нифайчуудтай тулалдахаар ирдэг.

3 Нифай 2–4-ийг ярилц. Ангийн гишүүдээс сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь.

- Сатан хүмүүсийг Аврагч болон түүний мэндлэх явдалд итгэхээс холдуулахыг хэрхэн оролдсон бэ? (3 Нифай 1:22; 2:1–3-ыг үз. Сатан бага багаар хүмүүсийн зүрх сэтгэлийг эзэмдсэнээр хүмүүс удалгүй “тэдгээр тэмдгүүд болон гайхамшгуудыг мартаж эхэлсэн.”) Өнөөдөр дайсны хэрэглэж буй эдгээр аргуудын ямрыг нь та нар харсан бэ? Бид сүнслэг мэдрэмжээ санаж, хамгаалахын тулд юу хийж болох вэ?
- Хүмүүсийн бусармаг байдал ихсэж эхлэхэд тэдэнд ямар аюул нүүрлэсэн бэ? (3 Нифай 2:11–13, 17–19-ийг үз.) Бидний өнөөдрийн аюулгүй байдалд ямар төрлийн зан чанар болон хандлагууд заналхийлж байна вэ?
- Христийг төрснөөс 16 жилийн дараа Нифайчуудын захирагч болон тэргүүн шүүгч Лаконеус Гадиантоны дээрэмчдийн удирдагч Гидианхайгаас захидал хүлээн авдаг (3 Нифай 3:1). Гидианхай Лаконеусаас юу хүссэн бэ? (3 Нифай 3:6–8-ыг үз.)
- Гадиантоны дээрэмчид Нифайчуудыг устгах гэж байгаагаа мэдэгдэхэд хүмүүс даруй Лаконеус болон Гидигидонай нарын удирдлаган дор өөрсдийгөө хамгаалахад бэлтгэж эхэлсэн. Уруу таталт болон айдастай байх үед биднийг хамгаалахад туслах ямар зүйлүүдийг бид тэдний үйлдлээс сурч болох вэ? (Ангийн гишүүдээр 3 Нифай 3:12–26-г уншуулж асуултын хариут олуул. Ангийн гишүүдийн хариултуудыг самбарт хураангуйл. Зарим хариултыг ярилцлага өрнүүлэх асуултуудын хамт дор жагсаасан болно.)
 - а. “Лаконеус, захирагч нь, шударга хүн байж . . . сүрдүүлэхийн аргагүй байсан” (3 Нифай 3:12). Айдас хэн нэгнийг уруу таталтанд хэрхэн оруулж болох вэ? Хувийн зөв шударга байдал нь биднийг уруу таталт эсвэл зовлон зүдгүүртэй нүүрлэхэд зоригтой байхад маань хэрхэн тусалж чадах вэ?
 - б. Лаконеус хүмүүсээ “Их Эзэнд хандан . . . хүч чадлын төлөө гуйхаар болгов” (3 Нифай 3:12). Уруу таталт болон сорилтуудтай тулгарахдаа хүч чадлыг гуйж залбирах нь яагаад чухал вэ?
 - в. Лаконеус хүмүүстээ “нэг газарт нэгдэн цуглахыг” хэлсэн (3 Нифай 3:13, 22). Нифайчуудын хувьд өөрсдийгөө хамгаалахаар нэг газарт цуглах нь яагаад чухал байсан бэ? (3 Нифай 4:3–4-ийг үз.) Сүмийн бусад гишүүдтэй нэгдмэл байх нь хилэнцэтийн хүчийг сөрөн зогсоход бидэнд хэрхэн тусалж чадах вэ? (Моронай 6:4–6-г үз.)
 - г. “Тэр эргэн тойронд бэхлэлтүүдийг бариулж” “эргэн тойронд харуулууд байрлуулав” (3 Нифай 3:14). Бид өөрсдийгөө хэрхэн бэхэлж уруу таталтын эсрэг харуулдаж чадах вэ?
 - д. Нифайчууд “Лаконеусын үгсийн дагуу үйлдэхээр өөрсдийн бүх хүчээр чармайцгаав” (3 Нифай 3:16). Бид сүнслэг урам зоригтой удирдагчдыг дагахдаа хэрхэн адислагддаг вэ?
 - е. “Тэд бүх нүглээ наманчилсан” (3 Нифай 3:25). Наманчлал бидэнд Их Эзэнээс илүү их хүч чадал хүлээн авахад хэрхэн тусалдаг вэ?

ж.Тэд “хуяг дуулгатайгаар хүчирхэг” байв (3 Нифай 3:26). Бидэнд ямар хуяг дуулга өмсөхийг зөвлөсөн бэ? (С ба Г 27:15–18-ыг үз.) Бурханы бүрэн хуяг дуулгыг өмсөхийг бидэнд яагаад заасан бэ? Бид өдөр бүр энэхүү хуяг дуулгыг хэрхэн өмсөж болох вэ?

- Эдгээр бэлтгэл нь Гадиантоны дээрэмчид Нифайчуудтай байлдахаар ирэхэд ямар үр нөлөөтэй байсан бэ? (3 Нифай 4:11–13, 16–29-ийг үз.) Нифайчууд ялсныхаа дараа хэрхэн баяр хөөртэй байсан бэ? (3 Нифай 4:30–33.) Биднийг хамгаалж адисласных нь төлөө бид Их Эзэнд ямар аргаар талархлаа илэрхийлж болох вэ?

3. Нифайчууд ариун журамтай амьдарч хөгжин дэвжсэн боловч бардамнал болон сэргэлдөөн нь өсөн нэмэгддэг.

3 Нифай 5–7-гоос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Нифайчууд Гадиантоны дээрэмчдийг Христийг мэндэлнээс хойш 21 дэх жилд ялжээ. 13 жилийн дараа Аврагч Нифайчууд дээр айлчлан тэдэнд үйлчлэх болно.

- Нифайчууд Гадиантоны дээрэмчдийг ялснаас хойш хэдэн жилийн туршид амар амгалан амьдарч хөгжин дэвжиж байв (3 Нифай 5:1–26; 6:1–9). Тэдний амар амгалан байдлыг юу алдагдуулсан бэ? (3 Нифай 6:10–15-ыг үз. Мөн та 34-р хичээлээр ярилцсан бардамналын тойргийг товч тоймлож болно.)
- Хүмүүс бусармаг явдалтай байсаар байсан учир бошиглогчид тэднийг наманчлалд дуудахаар ирсэн боловч хүмүүс тэднийг эсэргүүцэж алжээ (3 Нифай 6:17–23). Нууц бүлэглэлүүд нэмэгдэж удалгүй хүмүүс овгуудад хуваагджээ (3 Нифай 6:27–30; 7:1–5). Энэхүү бусармаг явдлын эсрэг Нифай юу хийсэн бэ? (3 Нифай 7:15–19-ийг үз.) Түүний хийсэн ажлын үр дүнд хүрсэн бэ? (3 Нифай 7:21–26-г үз.)

Дор жагсаасан хугацаануудыг самбарт бич. Холбогдох хэсгүүдийг ангийн өөр өөр гишүүдээр чангаар уншуул. Хэсэг тус бүрийг уншсаны дараа ангийн гишүүдээр хүмүүсийн сүнслэг байдлыг дүрслүүл.

МЭӨ 21–26 3 Нифай 5:1–3	(Хүмүүс Бурханд “байдгаараа хичээнгүйлэн” үйлчилж байлаа.)
МЭӨ 26–27 3 Нифай 6:4–5	(Маш их дэг журамтай байж, дэвжиж байв.)
МЭӨ 28 3 Нифай 6:9	(Үргэлжилсэн энх амгалан байдалтай байсан.)
МЭӨ 29 3 Нифай 6:10–16	(Маргаанууд, бардамнал, сагсуурал байлаа.)
МЭӨ 30 3 Нифай 6:17–18	(“Тэд аймшигт ёсон бус байдалд байв.”)
МЭӨ 31 3 Нифай 7:21	(Хэдэн хүн Их Эзэнд хөрвүүлэгдэв.)
МЭӨ 32–33 3 Нифай 7:23	(Нифай наманчлалд дуудсаар байлаа.)

- Хүмүүс бүгдээрээ итгэлтэй үлдсэн бол ямар адислалуудыг хүртэх байсан бэ? (3 Нифай 10:18–19-ийг үз. Аврагчийн Цовдлолтыг дагалдсан устгалын үеэр хүмүүсийн зөв шударга хэсэг нь хэлтрүүлэгдсэн. Аврагчийг Дахин Амилалтынхаа дараа айлчлан ирэхэд тэд агуу их адислалуудыг хүлээн авсан. Ихэнх нүгэлтнүүд устгагдсан. Эдгээр үйл явдлуудыг дараачийн хичээлээр ярилцах болно.)

Дүгнэлт

Бид ч бас Аврагчийн ирэлтийг хүлээж байгаа хэмээн тайлбарла. Бидний хүлээх ЭНЭ үед Сатан Нифайчуудыг бусармаг явдал руу эргүүлснийхээ адил биднийг бас эргүүлэх гэж оролдох болно. Лаконеусын үеийн хүмүүсийн адил бид өөрсдийгөө бэлтгэж, мөн эцсээ хүртэл зөв шударга байх юм бол бид Их Эзэний бидэнд бэлэглэхийг хүссэн бүх л зүйлийг хүлээн авахуйц зохистой байх болно.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт**Санаанууд**

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэ санааг хичээлдээ хэрэглэж болно.

“Есүс Христийн шавь билээ би” (3 Нифай 5:13)

Ангийн нэг гишүүнээр 3 Нифай 5:13-ыг чангаар уншуул. Энэхүү шүлэг нь бошиглогч Мормоны үгийг агуулсан гэдгийг тайлбарла.

- Өнөөдөр Есүс Христийн шавь байна гэдэг ямар утгатай вэ?

“Ирэх Хэнийг Боловч, Түүнийг Би Хүлээн Авах Болно”

3 Нифай 8–11

Зорилго

Ангийн гишүүдэд Сэмүэлийн бошиглолын биелэлт болон Аврагчид ирсэн хүн болгонд ирэх боломжтой адислалуудыг ойлгоход туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. 3 Нифай 8. Христийг нас барах үед Америкт агуу устгал болдог. Олон хотууд устгагддаг.
 - б. 3 Нифай 9–10. Амьд үлдэгсэд Их Эзэний Түүнд ирж, наманчилж, хөрвүүлэгдэхийг урьсан дуу хоолойг сонсдог.
 - в. 3 Нифай 11. Дахин амилсан Аврагч тэнгэрээс бууж ирж хүмүүст заадаг.
2. Дараах зургууд байгаа бол хичээлдээ хэрэглэхээр бэлтгэ: Христ Нифайчуудад Үзэгдсэн нь (62047; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 315) ба Есүс Америк Тивд Сургаалын Заасан нь (62380; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 316).
3. Хичээл эхлэхээс өмнө самбарт “00” “165”-р хуудсан дахь бүдүүвчийг зур.

Хичээлийг Баяжуулах Зөвлөмж

Анхаарал Татах Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Хүмүүс номлогчдоос Мормоны Номыг хүлээх авах үед номлогчид ихэнхдээ 3 Нифайн 11-ийг уншихыг урьдаг. Энэ бүлэгт дахин амилсан Аврагч Нифайчууд дээр айлчилсан хэсэг агуулдаг.

- 3 Нифайн 11 нь яагаад Мормоны Номыг хэн нэгэнд танилцуулах үр нөлөөтэй арга гэж та нар бодож байна вэ? Та нарыг энэхүү бүлгийг уншиж байхад ямар бодол, сэтгэгдэл төрж байсан бэ?

Аврагчийн Нифайчууд дээр хийсэн айлчлалыг дүрсэлсэн хэсэг нь Мормоны Номын хамгийн хүчтэй хэсгүүд болно гэдгийг цохон тэмдэглэ. Энэ хичээлээр Есүсийн цовдлогдох үед Америкт тохиолдсон гай гамшгуудыг ярилцах болно. Үүнд Түүний Нифайчуудын дунд хийсэн үйлчлэл багтдаг.

Судрын Ярилцлага ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Есүсийг нас барах үед Америкт агуу устгал болдог.

3 Нифай 8-ыг ярилц. Ангийн гишүүдийг сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь. Ангийн гишүүдэд Есүсийг цовдлогдох үед аймшигт устгал болохыг Лэмэнчүүдийн Сэмүэл бошигლოსныг сануул (Хиламан 14:20–27). Есүсийн мэндэлсний тэмдгүүдээс хойш 33 жилийн дараа хүмүүс Сэмүэлийн үгсийг биелэгдэхийг хүлээн “агуу ихээр идэвхийлэн харж эхлэв” (3 Нифай 8:3).

Ангийн гишүүдийн анхаарлыг самбар дээрх бүдүүвч рүү хандуул:

СЭМҮЭЛИЙН БОШИГЛОЛ	БИЕЛЭЛТ
Хиламан 14:21, 23	3 Нифай 8:5–7, 17–18; 9:8
Хиламан 14:24	3 Нифай 8:8–10, 14
Хиламан 14:20, 27	3 Нифай 8:20–21

Ангийн гишүүдээр “Сэмүэлийн Бошиглол” гэдгийн дор жагсаасан хэсэг тус бүрийг уншуулаад, дараа нь “Биелэлт” гэдгийн дор бичигдсэн хэсгүүдийг уншуул.

- Сүйрлийн дараа дэлхийг өтгөн харанхуй нөмөрсөн байлаа (3 Нифай 8:19–23). Хав харанхуй нь яагаад Аврагчийн нас баралтын зохих тэмдэг вэ? (3 Нифай 9:18; Иохан 8:12; С ба Г 11:28-ыг үз.) Та нарын амьдралд Аврагч ямар арга замаар гэрэл авчирсан бэ?
- Сүйрлээс амьд гарсан хүмүүс ямар сэтгэгдэлтэй байсан бэ? (3 Нифай 8:23–25-ыг үз.) Тэдгээрийн сэтгэгдлийн тухай унших нь Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэхэд бидэнд хэрхэн туслах вэ?

2. Амьд үлдэгсэд Их Эзэний Түүнд ирэхийг урьсан дуу хоолойг сонсдог.

3 Нифай 9–10-аас сонгосон шүлгүүдийг уншиж ярилц.

- Сүйрлийн дараа Нифайчууд Христийн өөр өөр хотууд хэрхэн сүйрснийг дүрсэлж буй дууг сонссон (3 Нифай 9:1–12). Сүйрлийн шалтгааныг Их Эзэн юу гэж тайлбарласан бэ? (3 Нифай 9:12-ыг үз. Тэрээр энэхүү шалтгааныг 2–12-р шүлгүүдэд хэр олон давтсаныг онцолж болно.) Амьд гарсан хүмүүст Тэрээр ямар захиас хүргэсэн бэ? (3 Нифай 9:13–14-ийг үз. Та 14-р шүлэгт ирэх гэсэн үг нь гурван удаа гарч байгааг онцолж болно. Мөн доорх ишлэлийг үз.) Энэхүү урилгыг хүлээн авахын тулд өнөөдөр бид юу хийх шаардлагатай вэ?

Ахлагч Жэффри Р.Холланд ийнхүү хэлсэн: “‘Ирэгтүн,’ гэж [Христ] хайраар хэлдэг. ‘Ирж, Намайг дагагтун.’ Та нар хаа ч байсан эхлээд ирж миний юу хийж байгааг хар. Би цагаа хаана мөн хэрхэн өнгөрөөдгийг хар. Надаас суралц, надтай хамт яв, надтай ярь, итгэ. Залбирахыг минь

сонс. Хариуд нь та нар өөрсдийнхөө залбирлын хариуг олох болно. Бурхан та нарын сэтгэл зүрхийг амраана. Ирж, Намайг дагагтун” (Conference Report, Oct. 1997, 88; or *Ensign*, Nov. 1997, 65).

Та ангийн гишүүдээр одоо эсвэл хичээлийн төгсгөлд “Христэд Ирэгтүн” буюу “Come unto Jesus” (*Hymns*, no. 117) дууг дуулуулах буюу үгийг нь уншуулж болно.

- Мосегийн хууль Түүнд хэрэгжсэн бөгөөд үүнээс хойш Тэрээр шатаалтын өргөл болон золиослол дахин хийх хэрэггүй хэмээн Есүс мэдэгдсэн (3 Нифай 9:17, 19). Тэрээр биднийг ямар золиослол хийх ёстой гэсэн бэ? (3 Нифай 9:20-ийг үз.) “Харууссан зүрх, гэмшсэн сэтгэлээ” өргөх гэдэг ямар утгатай вэ? (Доорх ишлэлийг үз.) Энэхүү өргөлийг хийсэн хүмүүст Аврагч юу амласан бэ? (3 Нифай 9:20-ийг үз.)

Тэргүүн Зөвлөлийн гишүүн асан Ерөнхийлөгч Ж.Рүбэн Кларк ийнхүү хэлсэн: “Христтэй хамт ирсэн шинэ гэрээний дагуу нүгэлтэн нь бусад бүтээлтүүдийн цусыг өргөх бус харин өөрийн амьдралаас золиослол хийх ёстой; тэрээр нүглүүдээ орхих ёстой, тэрээр наманчлах ёстой, тэрээр өөрөө золиослол хийх ёстой” (*Behold the Lamb of God* [1962], 107).

- Есүс амиа хэний төлөө өгсөн гэж хэлсэн бэ? (3 Нифай 9:22-ыг үз.) Аврагч дээр очихын тулд бид хүүхдийн ямар зан чанартай байх ёстой вэ? (Мозая 3:19-ийг үз.)
- Есүс сүйрлийн хэр хэмжээг хэлж, түүнд итгэсэн хүмүүст гэтэлгэлийг амласны дараа хэдэн цаг нам гүм байв. Есүс дахиж ярьж эхлэхдээ Тэр хүмүүсээ цуглуулах хүслээ илэрхийлэхдээ ямар зүйрлэлийг ашигласан бэ? (3 Нифай 10:4–6-г үз. Есүс энэхүү зүйрлэлийг гурван удаа ашигласан нь шүлэг бүрт бага зэрэг өөрчлөгдсөн байдаг.) Тэрээр биднийг цуглуулахыг яагаад хүсдэг вэ? (Доорх ишлэлийг үз.) Энэхүү цугларалтанд бид хэрхэн тусалж чадах вэ? (С ба Г 4:1–7-г үз.)

Бошиглогч Иосеф Смит ийн заасан: “Дэлхийн ямар ч цаг үед Бурханы хүмүүсийг . . . цуглуулах нь ямар зорилтыг агуулж байсан бэ? . . . Гол зорилт нь Түүний гэр дэх ёслолуудыг болон Түүний хаант улсын алдрыг хүмүүстээ илчилж, мөн хүмүүстээ авралын замыг зааж болохын тул Их Эзэний гэрийг барих явдал юм. . . . Эдгээр сүүлчийн өдрүүдэд тэр л зорилттойгоор Бурхан хүмүүсээ цуглуулж байна” (*Teachings of the Prophet Joseph Smith*, sel. Joseph Fielding Smith [1976], 307–8).

- Хүмүүсийг наманчлахад нь болон Түүнд ирэхэд нь дуудсаныхаа дараа Христ хүмүүст ярихаа зогсоов. Гашуудлын гурван өдөр өнгөрөв. Харанхуй замхарч, шуугиан болон сүйрэл зогсож хүмүүсийн гуниг баяр хөөр болов (3 Нифай 10:9–10). Хүмүүс яагаад хэлтрүүлэгдсэн бэ? (3 Нифай 10:12–13-ыг үз.) Тэд ямар адислалууд хүлээн авсан бэ? (3 Нифай 10:18–19-ийг үз.)
- Энэхүү хэсэгт уншигч бидэнд Мормон юу зөвлөж байна вэ? (3 Нифай 10:14-ийг үз.)

3. Есүс Христ тэнгэрээс бууж ирж хүмүүст заадаг.

3 Нифай 11-ээс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Өгөөмрийн нутаг дахь хүмүүс ариун сүмийг тойрон цугларч, болсон өөрчлөлтүүдийг бишрэн

гайхаж “мөн түүний үхлийн талаар өгөгдсөн тэмдэгтэй холбоотой энэ Есүс Христийн тухай тэд ярилцаж байлаа” (3 Нифай 11:1–2).

- Хүмүүс болсон явдлыг ярилцаж байх үед Бурхан Эцэгийн дуу гарахыг тэд сонсов. Тэр дуу юутай адил байсан бэ? (3 Нифай 11:3-ыг үз.) Хүмүүс ойлгох хүртлээ тэр дууг хэдэн удаа сонссон бэ? (3 Нифай 11:4–6-г үз.)
- Эцэст нь хүмүүс тэр дууг хэрхэн ойлгосон бэ? (3 Нифай 11:5-ыг үз.) “Үүнийг сонсохоор сонороо дэлгэв” гэдэг нь ямар утгатай вэ? (3 Нифай 11:5.) Бурханы бидэнд хэлсэн үгсийг илүү сайн сонсож ойлгохын тулд бид юу хийж болох вэ?
- Бурхан Эцэг Аврагчийг хэрхэн танилцуулсан бэ? (Ангийн нэг гишүүнээр 3 Нифай 11:7-г чангаар уншуул. Аврагч Өөрийгөө хэрхэн танилцуулсан бэ? (Ангийн нэг гишүүнээр 3 Нифай 11:8–11-ийг чангаар уншуул. Та Есүсийн Нифайчуудад хийсэн айлчлалын зургийг ашиглаж байгаа бол түүнийгээ одоо үзүүл.)
- Бүх цугласан олонд хандан Есүс ямар уриалга хийсэн бэ? (3 Нифай 11:13–15-ыг үз; мөн цугласан олон нь 2,500 хүн байсан хэмээн өгүүлсэн 3 Нифай 17:25-ыг үз. Та Есүсийн зааж байгаа зургийг ашиглаж байгаа бол түүнийгээ одоо үзүүл.) Аврагчийн энэхүү хайрын жишээнээс бид юу сурч болох вэ?
- Аврагч Нифай болон бусдад усаар батлах эрхийг өгсөнийхөө дараа тэдэнд усан баталгааны талаар юу заасан бэ? (3 Нифай 11:22–27-г үз.) Зөв журмын дагуу усаар баталж, мөн усаар батлах эрх бүхий хүнээр усаар батлуулах нь яагаад чухал вэ?
- Хүмүүсийн дунд усан баталгааны талаар буюу Түүний сургаалын өөр аливаа асуудлын талаар “сөргөлдөөнүүд” байх учиргүй гэж Есүс заасан (3 Нифай 11:22, 28). Сайн мэдээний сургаалуудын талаар маргах нь яагаад аюултай вэ? (3 Нифай 11:29; С ба Г 10:62–63-ыг үз.) Бид үнэний сургаалуудаар хэрхэн нэгдэж чадах вэ?
- Аврагч сургаалуудынхаа талаар юу заасан бэ? (3 Нифай 11:30–38-ыг үз. Хариултанд Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэд итгэх, наманчлах, хүүхэд адил болох, усаар батлуулах болон Ариун Сүнс хүртэх зэрэг багтах ёстой.) Түүний сургаалууд дээр амьдралаа барьдаг хүмүүст Тэрээр юу амласан бэ? (3 Нифай 11:39-ийг үз.)
- Эдгээр үгсийг “дэлхийн хязгааруудад тунхаглахын” тулд бид Аврагчийн удирдамжинд хэрхэн илүү бүрэн дүүрэн дуулгавартай байж чадах вэ? (3 Нифай 11:41).

Дүгнэлт

3 Нифай 10:14-ийг уншаад ангийн гишүүдэд судруудыг ойлгож эрэхийн чухлыг сануул. Зөв шударга байдал болон нүгэл хилэнцийн хоорондох зай өсөн нэмэгдэхийн хэрээр хавчлага өсөн нэмэгдэхэд бид судруудаа судалж бошиглогчдоо дагаснаар хүчирхэгжих болно.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт
Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэ санааг хичээлдээ хэрэглэж болно.

Тоймлон үзэх үйл ажиллагаа

Тоймлон үзэх үйл ажиллагаа болгон Есүс Америк Тивд Заасан нь (62380; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 316) зургийг үзүүл. Дараах мэдээллүүдийг уншиж ангийн гишүүдээр мэдээлэл тус бүрийн зөв, бурууг тогтоолго. Ангийн гишүүдээс мэдээлэл тус бүрт хамаатай судрын хэсгийг уншихыг хүс.

1. Энэ зургийн үйл явдал Зарахэмла хотод болсон. (Буруу; 3 Нифай 11:1-ийг үз.)
2. Хүмүүс Их Эзэний дуу хоолойг сонсчихсон байсан. (Зөв; 3 Нифай 9:1–2-ыг үз.)
3. Их Эзэн Түүнд хүрэхгүй байхыг гуйсан. (Буруу; 3 Нифай 11:14-ийг үз.)
4. Есүс Христ Нифайчууд дээр айлчлахдаа дахин амилсан биетэй байсан. (Зөв; 3 Нифай 11:15-ыг үз.)
5. Сүйрлээс аврагдагсад нүглээс чөлөөлөгдсөн байсан. (Буруу; 3 Нифай 9:13-ыг үз.)
6. Есүс хүмүүст усан баталгааны зөв журмын тухай заасан. (Зөв; 3 Нифай 11:21–26-г үз.)

“Хуучин Зүйлүүд Төгсөж Бүх Зүйл Шинэ Боллоо”

Хичээл
38

3 Нифай 12–15

Зорилго Жишээг даган Түүний Нифайчуудад заасан дээд хуулиудаар амьдран Есүс Христийн жинхэнэ шавь байхад ангийн гишүүдийг урамшуулах болно.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. 3 Нифай 12:1–12. Есүс Нифайчуудад Адис Ерөөлүүдийг заадаг.
 - б. 3 Нифай 12:13–16. Есүс Түүний дагалдагчид дэлхийн давс, хүмүүст гэрэл байх ёстойг тунхаглан мэдэгддэг.
 - в. 3 Нифай 12:17–48; 15:1–10. Есүс Мосегийн хуулийг биелүүлснээ тунхаглан мэдэгддэг. Тэрээр хүмүүст дээд хуулиудыг заадаг.
 - г. 3 Нифай 13–14. Есүс Нифайчуудад Түүний жинхэнэ шавь байхын тулд тэд хэрхэн амьдрах ёстойг заадаг. Тэрээр тэдэнд Түүний хэлснийг сонсож, хийвэл тэд хадан дээр байшингаа барьдаг мэргэн хүнтэй адил байх болно хэмээн хэлдэг.
 2. Нэмж унших зүйл: Матай 5–7; С ба Г 101:39–40; 103:9–10.
 3. Та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглэж байгаа бол ангидаа Есүс Христийн зургуудыг (цуглааны байрны номын сангаас эсвэл Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга) авчир.
 4. Та 195-р хуудсан дахь үйл ажиллагааг ашиглаж байгаа бол нэгэнд нь цэвэр давс, нөгөөд нь шороотой хольсон давс хийсэн хоёр ширхэг тунгалаг буюу шилэн сав авчир.

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

**Анхаарал Татах
Үйл Ажиллагаа**

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Есүс Христийн хэдэн зургийг үзүүл. Есүсийн зан чанарыг харуулахын тулд өөр өөр зураачид Есүсийг өөр өөр аргаар дүрсэлсэн гэдгийг цохон тэмдэглэ. Дараа нь ангийн гишүүдээр чанга хариулахгүйгээр дараах асуултуудын талаар бодуул:

- Хэрэв хэн нэгэн хүн та нараас Есүсийн зан чанарыг дүрсэлж өгөхийг хүсвэл та нар юу гэх вэ?

Ерөнхийлөгч Харолд Б.Ли Есүсийн зан чанарын нэгэн тодорхой дүрслэлийн тухай ярьсан хэмээн хэл. Тэгээд Ерөнхийлөгч Лигийн дараах мэдээллийг унш:

“Эзэн маань Уулан дээрх Номлолдоо бидэнд төгс төгөлдөр буюу өөрөөр хэлбэл үе бүрийг нь үйлсээрээ бичсэн намтар болсон зарим нэг байдлаар Өөрийнхөө зан чанарын талаар илэрхийлэлтийг өгсөн бөгөөд ингэснээрээ

бидний хувийн амьдралд зориулсан төлөвлөгөөг өгсөн билээ” (*Stand Ye in Holy Places* [1974], 342).

Есүс Нифайчууд дээр айлчлахдаа тэдэнд Уулан дээрх Номлолтой төстэй номлол хийсэн гэдгийг тайлбарла. Бид энэхүү номлолын сургаалуудыг судалж хэрэглэхдээ Аврагчийн зан чанарын талаар илүү ихийг сурч мэдэх болно. Мөн бид Эзэний амьдралаар өөрсдийнхөө амьдралыг загварчлах буюу төлөвлөгөөгөө боловсронгуй болгох боломжтой байх болно.

Судрын Ярилцлага ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Есүс Нифайчуудад Адис Ерөөлүүдийг заадаг.

Дор гаргасны дагуу 3 Нифай 12:1–12-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Та ангийн гишүүдээр 3 Нифай 12:3–12 дахь номлолыг Матай 5:3–12 дахь Уулан дээрх Номлолтой харьцуулуулж болно.

- 3 *Нифай* 12:3. Христэд ирнэ гэдэг ямар утгатай вэ? (Ангийн гишүүд энэ асуултыг ярилцахад та 3 Нифай 9:13–14, 20–22 ба Ифэр 12:27-г хэлж болно.) “Гэмшсэн сэтгэл” буюу даруу байдал нь бидэнд Христэд ирэхэд хэрхэн тусалдаг вэ?
- 3 *Нифай* 12:4. Их Эзэн бидэнд тайтгарал олох өөр ямар замуудыг бэлтгэдэг вэ? (Зарим жишээнүүдийг Иохан 14:26–17; Мозая 18:8–9-ийг үз.)
- 3 *Нифай* 12:5. Хүлцэнгүй, номхон байна гэдэг нь ямар утгатай вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли ийнхүү хэлсэн: “Хүлцэнгүй, номхон байдал нь өөрийн чадалдаа итгэх хандлагын эсрэг хүний дээр буй илүү их агуу хүчийг мэдэх, Бурханыг хүлээн зөвшөөрөх, мөн Түүний зарлигуудыг хүлээн зөвшөөрөхийн талархлын сүнсийг илтгэдэг” (“With All Thy Getting Get Understanding,” *Ensign*, Aug. 1988, 3–4).

- 3 *Нифай* 12:6. “Зөв шударгын төлөө өлсөж мөн цангах” гэдэг нь ямар утгатай вэ? Бид “зөв шударгын төлөө өлсөж мөн цангахдаа” юугаар дүүргэгдэх вэ?
- 3 *Нифай* 12:7. Нигүүлсэнгүй байх нь яагаад чухал вэ? Бидэнд Их Эзэний өршөөл нигүүлсэл яагаад хэрэгтэй вэ? (2 Нифай 2:8–9-ийг үз.)
- 3 *Нифай* 12:8. Бид яагаад Бурханыг харахын тулд зүрх сэтгэлдээ цэвэр ариун байх ёстой вэ? (1 Нифай 10:21-ийг үз.) Бид ямар аргаар зүрх сэтгэлээ цэвэр ариун байлгаж чадах вэ? (Энэ асуултын зарим хариуг С ба Г 93:1-ээс үз.)
- 3 *Нифай* 12:9. Бид өөрсдийн гэр орон болон нийгэмдээ хэрхэн энхийг сахигч байж чадах вэ?
- 3 *Нифай* 12:10–12. Заримдаа зөв шударгыг сахигчдыг яагаад хавчдаг вэ? Бид хавчлаганд хэрхэн хандах ёстой вэ? (3 Нифай 12:44; мөн Лук 6:35-ыг үз.)

2. Есүс Түүний дагалдагчид дэлхийн давс, хүмүүст гэрэл байх ёстойг тунхаглан мэдэгддэг.

3 Нифай 12:13–16-г уншиж ярилц.

Есүс, “Би та нарт газар дэлхийн давс байх үүргийг өгдөг,” гэж хэлсэн (3 Нифай 12:13). Ангийн гишүүдэд “газар дэлхийн давс байхын” учрыг ойлгуулахын тулд Ахлагч Брүс Р.МакКонкийн дараах мэдэгдлийг унших, ангийн нэг гишүүнээр нь уншуул:

“Эртний Еврейчүүд давсыг. . . улирлын чанартай хоол хүнсийг хадгалахын тулд болон бүх төрлийн амьтдын золиослолд ашиглаж байсан. (Левит 2:13; Езекиел 43:24; Марк 9:49–50.) Энэхүү нандин ёслолтой холбогдон Бурхан болон Түүний хүмүүсийн хооронд хийсэн гэрээний бэлэгдэл болсон золиослолын ёслолд энэ нь зайлшгүй хэрэгтэй байсан. (Левит 2:13; Тооллого 18:19; 2 Шастирын дэд 13:5.)

“Тиймээс Их Эзэний маань мэдэгдэл эхлээд Иүдейчүүдэд хийгдэж, дараа нь Еврейчүүдийн гол хэсэг болох Нифайчуудад хийгдэж ‘газар дэлхийн давс байх’ хүчтэй болсон нь агуу их ач холбогдолтой болсон юм. . . . Тэд хүч болсон буюу өөрөөр хэлбэл, дэлхийд амлах, хадгалах нөлөө үзүүлж, бусад бүх хүмүүст энх амгалан болон адислалуудыг авчрах нөлөө болсон” (*Mormon Doctrine*, 2nd ed. [1966], 667–68).

• Бусад бүх хүмүүст энх амгалан болон адислалуудыг хүлээн авахад нь бидний нөлөө хэрхэн тусалж чадах вэ?

Давстай савнуудаа гаргаж тавь (“Бэлтгэл”-ийн 4-ийг үз). Ангийн гишүүдээс тэд аль давсыг нь хэрэглэхийг асуу. Тэгээд дараа нь Ахлагч Карлос И.Эсэйн дараах мэдэгдлийг унш: “Дэлхийн нэгэн нэртэй химич надад он жил өнгөрснөөр давс амт чанараа алддаггүй, амт нь холилдож, бохирдсоноос л алга болдог гэж хэлсэн” (in Conference Report, Apr. 1980, 60; or *Ensign*, May 1980, 42).

- Дэлхийн зүйлүүдэд “бохирдохоос” бид хэрхэн зайлсхийж чадах вэ?
- Ангийн гишүүдээр Сургаал ба Гэрээ 101:39–40 ба 103:9–10-ыг чангаар уншуул. Эдгээр хэсгүүд “дэлхийн давс” болон “хүмүүст гэрэл байх” тухай юу заадаг вэ? Хожмын Үеийн Гэгээнтнүүд хэрхэн “хүмүүсийн аврагч” байж чадах вэ? (Хариултанд сайн мэдээг хуваалцах, ариун сүмийн ажил хийх зэрэг нь орж болно.)
- Бид “хүмүүсийн өмнө гэрлээ” хэрхэн “туяаруулан гийгүүлэх” вэ? (Нифай 12:16; 18:24-ийг үз.) Бидний хүмүүсийн өмнө гэрлээ туяаруулан гийгүүлэх нь ямар үр дүнтэй байх ёстой вэ? (Нифай 12:16-г үз.)

3. Есүс Мосегийн хуулийг биелүүлснээ тунхаглан мэдэгддэг. Тэрээр хүмүүст дээд хуулиудыг заадаг.

3 Нифай 12:17–48; 15:1–10-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Эдгээр шүлгүүдэд дурдагдсан хууль нь Мосегийн хууль болохыг тайлбарла. Мосегийн хууль бол амьтнаар хийх золиослол хийгээд гүйцэтгэл болон ёслолуудын шууд тогтолцоо юм (Мозая 13:29–30). Энэ нь Израилчуудад Есүс Христийн Цагаатгалыг хүлээхэд нь туслахаар өгөгдсөн юм (2 Нифай 25:24; Мозая 13:31–33; Алма 34:13–14).

- Израилчуудад Мосегийн хуулийг хэн өгсөн бэ? (3 Нифай 15:4–5-ыг үз.)
- Есүс Мосегийн хуулийг биелүүлснээ тунхаглан мэдэгддэг (3 Нифай 12:17–19; 15:2–5). Есүс энэ хуулийг хэрхэн биелүүлсэн бэ?

Аврагч бидний нүглийн төлөө цагаатгагдахдаа Мосегийн хуулийг биелүүлсэн (Алма 34:13–16). Түүний Цагаатгалаас хойш Есүс Христийн золиослолын цагаатгалыг онцолж заасан Мосегийн хуулийн хэсэг болсон амьтны золиослолыг хийх шаардлагагүй болсон. Харин үүний оронд хүмүүст “харууссан зүрх гэмшсэн сэтгэлээ тахил болгон өргөхийг” зарлигласан (3 Нифай 9:20; мөн 19-р шүлгийг үз).

Есүс Мосегийн хуулийг биелүүлснээ тунхаглан мэдэгдсэнийхээ дараа Тэрээр Нифайчуудад дээд хуулийг өгсөн гэдгийг тайлбарла. Ангийн гишүүдэд хамгийн их тустай гэж бодож байгаа судрын хэсгүүдийг жагсаан самбар дээр дараах бүдүүвчийг хий. Ангийн гишүүдээр “Мосегийн Хууль”-ийн дор жагсаасан хэсэг тус бүрийг уншуулсны дараа “Дээд хууль”-ийн дор жагсаасан холбогдох хэсгүүдийг уншуул. Тэд нараар эдгээр хуулиудын ялгааг ярилцуул. Тэднийг дээд хууль биднийг Их Эзэнд ойртоход хэрхэн тусалж болох арга замуудаас хуваалцахыг урь.

МОСЕГИЙН ХУУЛЬ	ДЭЭД ХУУЛЬ
3 Нифай 12:21	3 Нифай 12:22–24
3 Нифай 12:27	3 Нифай 12:28–30
3 Нифай 12:31	3 Нифай 12:32; мөн заах нэмэлт санааны нэгдүгээрийг үз
3 Нифай 12:33	3 Нифай 12:34–37
3 Нифай 12:38	3 Нифай 12:39–42
3 Нифай 12:43	3 Нифай 12:44–45

- Нифайчуудад дайснаа хайрлах ёстой тухай заасныхаа дараа Есүс “Тиймийн тул би эсвээс тэнгэрт буй тэр Эцэг тань төгсийн адил та нарыг төгс төгөлдөр байгаасай хэмээнэ, би” гэсэн (3 Нифай 12:48). Бидэнд яагаад төгс төгөлдөр болохын тулд Есүс Христийн Цагаатгал хэрэгтэй вэ? (2 Нифай 2:7–9; 3 Нифай 19:28–29; Моронай 10:32–33-ыг үз.)

4. Есүс Нифайчуудад Түүний жинхэнэ шавь байхын тулд тэд хэрхэн амьдрах ёстойг заадаг.

3 Нифай 13–14-өөс сонгосон шүлгүүдийг уншиж ярилц. Эдгээр бүлгүүд нь бид Есүс Христийн жинхэнэ шавь хэрхэн болж болох тухай сургаалуудыг агуулдаг гэдгийг тайлбарла. Дор гаргасны дагуу эдгээр сургаалуудын заримыг нь эсвэл бүгдийг нь ярилц.

- *3 Нифай 13:1–8, 16–18.* Өглөг өгөх үйлдэх (ядууст өглөг өгөх), залбирах, мацаг барих зэрэг зүйлүүдийг хийдэг зарим хүмүүсийг Есүс яагаад буруушаасан бэ? Бид үйлчлэл үзүүлэх болон бусад сайн үйлсийг хийхдээ юугаар хөтлөгдсөн байх ёстой вэ?

- 3 Нифай 13:9–13; 14:7–11. Биднийг хэрхэн залбирах ёстой талаар эдгээр шүлгүүд дэх Есүсийн үгс юу заадаг вэ?
- 3 Нифай 13:14–15. Бид бусдыг уучилж байх нь яагаад чухал вэ? Бид хэрхэн илүү их өршөөнгүй болж чадах вэ?
- 3 Нифай 13:19–24. “Нэг л зүгт чиглэсэн” нүдтэй байна гэдэг нь юу гэсэн үг вэ? (С ба Г 88:67–69-ийг үз.) Бид яагаад нэгэн зэрэг Бурхан болон эд хөрөнгөнд (дэлхийн зүйлст) үйлчлэх боломжгүй вэ?
- 3 Нифай 13:25–34. Эдгээр шүлгүүдэд тэмдэглэгдсэн үгсийг Аврагч хэнд хандуулсан бэ? (3 Нифай 13:25-ыг үз.) Хэдийгээр бидэнд хоол, унд, хувцас хунарын талаар “бодохгүй байхыг” зарлиг болгоогүй ч бид эдгээр үгсийг амьдралдаа хэрхэн хэрэглэж болох вэ? (3 Нифай 13:33-ыг үз.) Өөрийнхөө амьдралд Бурханы зүйлүүдийг түрүүнд тавьдаг хүмүүст ямар адислалууд ирдэг вэ?
- 3 Нифай 14:1–5. Бид бусдыг буруу шүүх буюу шүүмжлэхээс хэрхэн зайлсхийж чадах вэ?
- 3 Нифай 14:6. Үүний адил сургаал Матай 7:6-д байдаг. Энэхүү шүлгийн Иосеф Смитийн Орчуулганд Есүс шавь нартаа хаант улсын гайхамшгуудыг заахаасаа илүү наманчлалыг номлохыг зарлигласан (Joseph Smith Translation, Matthew 7:9–11). Бид сайн мэдээний сургаалыг үндсэн номлолд төвлөрүүлэх нь яагаад чухал вэ?
- 3 Нифай 14:12. Энэхүү зарчмыг дагах нь бидэнд Христийн илүү сайн шавь болоход хэрхэн тусалдаг вэ?
- 3 Нифай 14:13–14. Сүйрэлд хүрэх зам нь өргөн байхад мөнхийн амьдралд хүрэх зам нарийн байгаа нь яагаад чухал ач холбогдолтой вэ?
- 3 Нифай 14:15–20. Энэхүү сургаал нь өнөөдөр яагаад нэн чухал вэ? (Сүүлчийн өдрүүдийг дүрсэлсэн Joseph Smith Translation, Matthew 1:22-ыг үз.)
- 3 Нифай 14:21–23. Тэнгэрийн хаант улсад орох боломжтой байхын тулд бид яагаад Тэнгэрлэг Эцэгийн хүслийг биелүүлж байх ёстой вэ? (С ба Г 130:20–21-ийг үз.)
- 3 Нифай 14:24–27. Гэрээ хад эсвэл элсэн дээр барих тухай Есүсийн сургаалт үлгэр нь бидний амьдралд ямар арга замаар хэрэглэгддэг вэ? (Хиламан 5:12-ыг үз.)

Дүгнэлт

Ангийн нэг гишүүнээр 3 Нифай 15-аас чангаар уншуул. Бид Аврагчийн сургаалуудын дагуу амьдрахдаа илүү их бат суурьтай болж ямар ч сорилт эсвэл уруу таталт тулгарахад тэдгээрийг сөрөн зогсоход хүчирхэгжих болно. Бид “дэлхийн давс” болон “хүмүүст гэрэл нь болж” бусдад Аврагчид илүү их ойртоход нь туслах боломжтой байх болно (3 Нифай 12:13–16).

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. Гэр бүлийн салалтын тухай Есүсийн сургаал

Та 3 Нифай 12:32-г тэмдэглэгдсэн Аврагчийн сургаалыг ярилцахдаа дараах мэдээллийг хуваалцаж болно:

Эртний Израилд эрэгтэй хүн ялихгүй шалтгааны улмаас эхнэрээ хөөх буюу салж болдог байлаа. Харин төгс дэлхийд буюу сэлэсчел хаант улсад салалт гэж үгүй билээ. Дэлхий хараахан төгс төгөлдөр биш салалт байдаг бөгөөд салалт нь хамгийн ноцтой шалтгаанаас бусад тохиолдолд гарах ёсгүй юм. Матай 19:9-д ялихгүй шалтгаанаар эхнэрээсээ салсан эрэгтэй хүн Бурханы мэлмийд гэрлэсэн хэвээр байх бөгөөд өөр эмэгтэйтэй гэрлэвэл энэ нь садар явдлыг үйлдсэн хэмээн тооцогддог хэмээн Есүс онцолж хэлсэн. (See James E. Talmage, *Jesus the Christ*, 3rd ed. [1916], 473–75, 484; see also Bruce R. McConkie, *The Mortal Messiah*, 4 vols. [1979–81], 2:138–39.)

2. “Та нар бол миний . . . хэлсэн тэд билээ: Өөр хонинууд надад бий” (3 Нифай 15:21)

- Ангийн нэг гишүүнээр Иохан 10:16-г чангаар уншуул. Эдгээр “өөр хонинууд” нь хэн бэ? (3 Нифай 15:21; 16:1–3-ыг үз.) Иерусалим дахь шавь нар нь Есүсийн ярьсан “өөр хонинуудын” тухай сургаалыг яагаад ойлгохгүй байсан бэ? (3 Нифай 15:14–19-ийг үз.) Итгэхгүй байх нь хүмүүст Бурханы үгийг бүрэн дүүрнээр нь яагаад ойлгуулдаггүй вэ?

“Болгоогтун, Миний Баясал Дүүрэн Байна”

Хичээл
39

3 Нифай 17–19

Зорилго

Ангийн гишүүдэд Их Эзэн Есүс Христийн хайрыг мэдэрч, Түүнд итгэх итгэлээ хөгжүүлэх болон Түүний тухай гэрчлэлтэй болох илүү их хүсэлтэй болоход нь тусална.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. 3 Нифай 17. Нифайчуудад заасныхаа дараа Есүс тэдэнд эргэцүүлэн бодож, залбирахын тулд гэртээ харьж дараачийн өдөр нь Түүнийг эргэж ирэхэд бэлэн байхыг тушаав. Түүнийг байлгахыг хүсэж байгаа хүмүүсийн хүслийг ойлгон Тэрээр хэсэг хугацаанд үлдэж өвчтөнүүдийг эдгээж, хүүхдүүдийг адислаж, хүмүүсийн төлөө залбирдаг.
 - б. 3 Нифай 18. Есүс Нифайчуудын дунд ариун ёслолыг тогтоож тэнгэр өөд явахаасаа өмнө тэдэнд нэмэлт зөвлөмжүүдийг өгдөг.
 - в. 3 Нифай 19. Нифайчууд Есүсийн айлчлалын тухай мэдээг түгээж олон хүмүүс Түүнийг эргэж ирэх явдалд оролцохоор цуглардаг. Шавь нар нь олон түмэнд зааж сурган үйлчлэл үзүүлдэг. Шавь нар усаар батлуулан, Ариун Сүнс болон тэнгэр элчүүдийн үйлчлэлийг хүлээн авдаг. Аврагч эргэн ирж хүмүүст зааж сурган, тэдний төлөө залбирдаг.
2. Та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглэж байгаа бол Есүс Нифайчуудыг Эдгээсэн нь (62541; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 317) болон Есүс Нифайчуудын Хүүхдүүдийг Адисласан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 322) зургуудыг үзүүлж, ангийн нэг гишүүнээр 3 Нифай 17:5–13, 17–24-ийг чангаар уншуулахаар бэлтгэ.
3. Бишрэл хүндэтгэлтэй байдлыг бий болгохын тулд та ангийн гишүүдийг ангидаа орж ирэх үед нь Аврагчийн тухай дууллуудаас тавьж болно.

Хичээлийг Баяжуулах Зөвлөмж

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Есүсийн Нифайчуудыг эдгээж байгаа болон хүүхдүүдийг адислаж байгаа зургуудыг үзүүлж урьдчилан даалгасан ангийн нэг гишүүнээр 3 Нифай 17:5–13, 17–24-ийг чангаар уншуул.

Ангийн гишүүдээр эдгээр үйл явдлуудыг үзсэн олны дунд байсан бол ямар байх байсан тухай бодлоосоо хуваалцахыг урь. Энэ хичээлээр эдгээр үйл явдлууд болон үхээд Дахин Амилсныхаа дараа Тэрээр Нифайчууд дээр айлчлахдаа дахин амилсан Аврагч юу хийж, юу заасан тухай илүү ихийг ярилцах болно.

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Есүс Нифайчуудад Түүний заасан зүйлийн талаар эргэцүүлэн бодож, залбирахыг тушаадаг. Тэрээр өвчтөнүүдийг эдгээж, хүүхдүүдийг адислаж, хүмүүсийн төлөө залбирдаг.

3 Нифай 17-г ярилц. Ангийн гишүүдийг сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь.

- Есүс Нифайчуудыг орхин явахаар бэлэн болох үед хүмүүс Түүний заасан зүйлүүд нэг бүрийг ойлгоогүй болохыг мэдсэн (3 Нифай 17:1–2). Тэрээр хүмүүст юу хийхийг заасан бэ? (3 Нифай 17:3-ыг үз.) Эргэцүүлэн бодох гэдэг нь ямар утгатай вэ? Эргэцүүлэн бодох нь Аврагчаас цаашид зааварчилгаа хүлээн авахад нь Нифайчуудад хэрхэн туслах вэ? Эргэцүүлэн бодох нь бидэнд сайн мэдээний зарчмуудыг илүү сайн ойлгоход хэрхэн тусалж чадах вэ?

Ахлагч Иосеф Б.Вөөртлин ийнхүү заасан: “Оюун санаандаа жинлэх, тунгаах, бясалгах гэсэн утгатай эргэцүүлэн бодох нь ойлгох сүнслэг нүдийг нээдэг. Мөн түүнчлэн, Их Эзэний Сүнс эргэцүүлэн бодож буй хүнд дээр ирдэг” (in Conference Report, Apr. 1982, 33; or *Ensign*, May 1982, 23).

- Мөн Есүс хүмүүст Түүний заасан зүйлүүдийн талаар залбирахыг хэлсэн. Залбирал бидэнд сайн мэдээний зарчмуудыг илүү сайн ойлгоход хэрхэн тусалдаг вэ? Их Эзэний үнэнүүдийг хүлээн авахад “оюун санаагаа бэлтгэх” өөр ямар арга замууд байдаг вэ?
- Есүс яагаад хүмүүстэй “дахин хэсэгхэн зуур үлдсэн” бэ? (3 Нифай 17:5–6-г үз.) Энэ нь Түүний хүмүүсийн төлөө гэсэн сэтгэлийг хэрхэн харуулсан бэ? Та нарын төлөө гэсэн Есүсийн хайр болон сэтгэлийг та нар хэрхэн мэдэрч байсан бэ?

Та анхаарал татах үйл ажиллагааг ашиглаж байгаа бол ангийн гишүүдээр Аврагчийн Нифайчуудтай дахин хэсэгхэн зуур үлдсэн явдлыг дүгнэн яриул (3 Нифай 17:7–25).

- Аврагч Нифайчуудын дундах өвчтэй болон хазгар доголон хүмүүсийг эдгээхэд боломжийг юу олгосон бэ? (3 Нифай 17:7–9, 20-ийг үз.) Өвчтэй болон хазгар доголон хүмүүсийг эдгэрсний дараа хүмүүс юу хийсэн бэ? (3 Нифай 17:10-ыг үз.) Бид Аврагчийн бидэнд өгсөн адислалуудын төлөө талархлаа хэрхэн илэрхийлж болох вэ?
- Нифайчуудын хүүхдүүд хэрхэн адислагдсан бэ? (3 Нифай 17:21-ийг үз. Аврагч жаахан хүүхдүүдэд Өөрийнхөө хайрын гүнийг харуулан тэднийг нэг нэгээр нь адисласан гэдгийг цохон тэмдэглэ. Мөн түүнчлэн та Матай 19:13–15-ыг уншиж өгч болно.)
- Аврагч Нифайчуудад жаахан хүүхдүүдтэй адил болохыг тушаасан (3 Нифай 11:37–38). Есүс биднийг хүүхдийн ямар зан чанартай байхыг хүсдэг вэ? (Мозая 3:19-ийг үз.) Эдгээр зан чанарыг хөгжүүлэхийн тулд бид юу хийж болох вэ?

2. Есүс Нифайчуудын дунд ариун ёслолыг тогтоодог.

3 Нифай 18-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Есүс хүүхдүүдийг адисласныхаа дараа Нифайчуудын дунд ариун ёслолыг тогтоосон (3 Нифай 18:1–4). Бид 3 Нифай 18:1–11-ээс ариун ёслолын ёслолын тухай юу сурч авдаг вэ? (Хариултанд дор жагсаасан зүйлүүд орж болно.)
 - a. Ариун ёслолыг үүнийг хийхээр томилогдсон хүмүүсээр адислан түгээх ёстой (3 Нифай 18:5).
 - б. Ариун ёслолыг Сүмийн зохистой бүх гишүүдэд түгээдэг (3 Нифай 18:5, 11).
 - в. Талх болон дарс нь Аврагчийн бие болон цусыг төлөөлдөг (3 Нифай 18:7, 11; мөн өнөөдөр бид дарсны оронд ус хэрэглэдэг гэдгийг онцлон С ба Г 27:2-ыг үз).
- Бид ариун ёслолоос хүртэхдээ юуг гэрчилдэг вэ? (3 Нифай 18:7, 10–11-ийг үз.) Христийг санаж, мөн дагадаг хүмүүст ямар адислалыг амласан байдаг вэ? (3 Нифай 18:7, 11-ийг үз.) Бид долоо хоног бүр ариун ёслолоос хүртэхээр өөрсдийгөө бэлтгэхийн тулд юу хийж болох вэ? Та нарт ариун ёслолоос хүртэх нь хэрхэн адислал болж байсан бэ?
- Ариун ёслолоос зохистойгоор хүртэхийн чухлын талаар Аврагч шавь нартаа юу заасан бэ? (3 Нифай 18:26–29; мөн 1 Коринт 11:28–29-ийг үз.) Ариун ёслолоос зохисгүй хүртэх явдал нь бидэнд яагаад зэмлэлийг авчрах вэ?
- Аврагч шавь нартаа ариун ёслолоос хүртэхээр зохисгүй хүмүүст юу хийхийг хэлсэн бэ? (3 Нифай 18:29–32-ыг үз.) Тэр ариун ёслолоос хүртэх зохисгүй хүмүүсийг хөөхгүй байхыг яагаад зааварласан бэ? (3 Нифай 18:32-ыг үз.) Сайн мэдээнээс нүүрээ бууруулсан хүмүүст үргэлжлүүлэн үйлчлэл үзүүлэх нь яагаад чухал вэ? Бид үүнийг ямар аргаар хийж болох вэ?
- Их Эзэн ямар шалтгааны улмаас Түүнд ирэхийг хүмүүст тушаасан бэ? (3 Нифай 18:25-ыг үз.) Есүс Христийн тухай гэрчлэлтэй байх нь бидэнд яагаад чухал вэ?

3. Шавь нар олон түмэнд зааж сурган үйлчлэл үзүүлдэг. Аврагч эргэж ирж хүмүүст зааж сурган, тэдний төлөө залбирдаг.

3 Нифай 19-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Тэнгэр өөд гарсныхаа дараа Аврагчийн юу хийснийг харсан Нифайчууд яасан бэ? (3 Нифай 19:1–3-ыг үз.) Аврагчийн тухай Нифайчуудын гэрчлэлийг сонссон хүмүүс эдгээр гэрчлэлүүдэд хэрхэн хариулсан бэ? (3 Нифай 19:3-ыг үз.) Аврагчийн тухай гэрчлэлтэй байх ямар боломжууд бидэнд байгаа вэ?
- Дараачийн өдөр нь олон түмэн Аврагчийн ирэхийг хүлээж байх хооронд арван хоёр шавь нар хүмүүст зааж сурган, тэдэнтэй хамт залбирч, тэдэнд үйлчилж байлаа (3 Нифай 19:4–8; энэ бол 3 Нифай 18:16-д бичсэнчлэн Аврагч тэдэнд зааварчилсны биелэлт гэдгийг онцлон тэмдэглэ.) Шавь нар юуны төлөө залбирсан бэ? (3 Нифай 19:9; мөн 10–15-р шүлгүүдийг болон 2-р заах нэмэлт санааг үз.) Шавь нар “Ариун Сүнс тэдэнд өгөгдөхийг”

яагаад хамгийн их хүссэн гэж та нар бодож байна вэ? (3 Нифай 19:9).
Ариун Сүнсийг хүлээн авах нь бидэнд яагаад амин чухал вэ?

- Есүс шавь нартаа залбирч байхыг хэлээд ганцаараа залбирахаар “тэднээс бага зэрэг холдов” (3 Нифай 19:17, 19). Есүс юуны төлөө залбирсан бэ? (3 Нифай 19:21–23-ыг үз. Та энэхүү залбирлыг Иохан 17:20–23-т тэмдэглэсэн Түүний Цовдлолтын өмнөх Есүсийн агуу их залбиралтай харьцуулж болно.) Есүс Христийн дагалдагчид Түүнтэй болон Эцэгтэй “нэг байх” нь яагаад чухал вэ? Бид Тэдэнтэй хэрхэн нэг байж чадах вэ?
- Нифайчуудын шавь нарын залбирал яагаад Их Эзэний таалалд нийцсэн бэ? (3 Нифай 19:24–25-ыг үз. Та ангийн гишүүдийн хариултыг самбарт бичиж болно.) Бид залбирахдаа шавь нарын жишээг хэрхэн дагаж чадах вэ?
- Олон түмэн яагаад гурав дахь удаа залбирахад нь Есүсийн үгсийг сонсож, мөн ойлгосон бэ? (3 Нифай 19:31–33-ыг үз.) Зүрх сэтгэл нь нээлттэй байна гэдэг ямар утгатай вэ? Бид зүрх сэтгэлээ нээж, улмаар Сүнс бидэнд заах боломжийг авчрахын тулд юу хийх ёстой вэ?

Дүгнэлт

Нифайчууд агуу их итгэл (3 Нифай 17:20; 19:35) болон чин сэтгэлийн залбирлынхаа (3 Нифай 19:6–9) улмаас гайхамшигт зүйлүүдийг үзэж, мөн сонсож адислуулсан гэдгийг ангийн гишүүдэд сануул. Есүс Христэд итгэлтэй байж хувийн болон гэр бүлийнхээ залбиралд чин сэтгэлээсээ залбирвал Их Эзэний Сүнс бидний хийж буй бүх зүйлд биднийг адислаж, туслахаар бидэнтэй хамт байх болно.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно.
Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. “Үргэлж сэрэмжилж, мөн залбир” (3 Нифай 18:15)

Ангийн гишүүдээр 3 Нифай 18:15, 18–19, 21-ийг уншуул.

- Залбирал биднийг Сатаны уруу таталтаас хамгаалахад хэрхэн тусалж чадах вэ? Гэр бүлийн залбирал та нарын гэр бүлд хэрхэн нөлөөлсөн бэ? Өдөр тутмын гэр бүлийн залбирлынхаа амлалтыг бид хэрхэн баталж чадах вэ?

2. “Тэд хамгийн их хүссэн түүнийхээ төлөө залбирсан” (3 Нифай 19:9)

3 Нифай 19:9-ийг ярилцахаасаа өмнө ангийн гишүүдэд цаас, харандаа өгч тэднээс хамгийн их хүсэж байгаа зургаан зүйлээ бичихийг хүс. (Хэрэв цаас, харандаа байхгүй бол ангийн гишүүдийг зүгээр л хамгийн их хүсэж байгаа зургаан зүйлээ бодохыг хүс.) Тэгээд дараа нь жагсаалтаас залбирахад эвгүй гэж бодсон зүйлүүдээ хасахыг хүс. Ангийн гишүүдийг 3 Нифай 19:9-ийг уншихыг урь.

- Нифайчуудын шавь нар юуг хамгийн их хүсэж байсан бэ? Бид зөв шударга болон сүнслэг байдлыг хүсэх хүслээ хэрхэн нэмэгдүүлж чадах вэ?

3. “Тэд Есүст залбирсан болой” (3 Нифай 19:18)

Нифайчуудын шавь нар Есүст яагаад залбирсныг тодруулахын тулд (3 Нифай 19:18, 24–25, 30) ангийн гишүүдээр 3 Нифай 19:22-ыг уншуул. Мөн та Ахлагч Брүс Р.МакКонкийн дараах мэдэгдлийг уншиж болно:

“Залбирлаа Хүүд хандуулсан судрын цорын ганц тохиолдол болон шалтгаан нь! дахин амилсан дүр болох Ариун Хүн нь залбирал өргөгчийн өмнө зогсож байсан үед болсон юм” (*Doctrinal New Testament Commentary*, 3 vols. [1966–73], 2:79).

Есүс Өөрөө энэ үед Эцэгт хандан залбирч байсан гэдгийг цохон тэмдэглэ (3 Нифай 19:19–24, 27–29, 31). Бид бүх залбирлуудаа Тэнгэр дэх Эцэгт хандуулан Есүс Христийн нэрээр төгсгөх ёстой.

“Тэгээд Би Тэднийг. . . Цуглуулах Болно”

3 Нифай 16; 20–21

Зорилго

Ангийн гишүүдэд Израилыг цуглуулж Сионыг байгуулах хожмын үеийн ажлыг ойлгоход нь туслах болно.

Бэлтгэл

1. 3 Нифай 16; 20 ба 21-ийг уншиж, эргэцүүлэн бодож, залбир. Эдгээр бүлгүүд нь дахин амилсан Аврагчийн Нифайчуудад айлтгасан сургаалын хэсгийг агуулдаг. Эдгээр бүлгүүдэд Их Эзэн сайн мэдээний Дахин Сэргээлт болон сүүлчийн өдрүүд дэх Израилын угсааны цугларалтын тухай зааж бошиглодог.
2. Нэмж унших зүйл: 3 Нифай 29–30; Мормон 5:9–24; Итгэлийн Тунхаг 1:10.
3. Хичээлийн өмнө самбарт дараах асуултыг бич:

Израилын угсаа гэж юу вэ?

Яагаад Израил тарж бутарсан бэ?

Харийнхан гэж хэн бэ?

Харийнхан нь Израилын бутрал болон цугларалттай ямар холбоотой вэ?

Израилын цугларалт гэж юу вэ?

Израилын хожмын үеийн цугларалт эхэлснийг ямар тэмдэг харуулдаг вэ?

Сүмийн гишүүдийн хувьд Израилын цугларалтанд бид ямар үүрэгтэй вэ?

4. Та анхаарал татах үйл ажиллагааг ашиглаж байгаа бол дараах зүйлүүдээс авчирна уу:
 - а. Иаков Хөвгүүдээ Адисласан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 122); Иосеф Смит (62449; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 400); Усаар Батлуулж Буй Хүү (62018) эсвэл Усан Баталгаа (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 601) зургууд.
 - б. Мормоны Ном.
 - в. Номлолын ажлыг төлөөлөх номлогчийн тэмдэг эсвэл өөр нэгэн зүйл.
 - г. Өөрийн болон гэр бүлийнхээ зургийг.

Хичээлийг Баяжуулах Зөвлөмж

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Ангид авчирсан зүйлүүдээ гаргаж тавь (“Бэлтгэл”-ийн 4-ийг үз). Эдгээр зүйлүүдийн тус бүр нь өнөөдрийн хичээлийн чухал хэсгийг төлөөлж байгаа хэмээн тайлбарла. Ангийнхныг хичээлийн үеэр эдгээр зүйлүүдийг тогтоож эдгээрийн 3 Нифай 16; 20 болон 21-тэй холбоотой арга замуудыг олохыг хүс.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Аврагч Изралын угсааны бутралыг бошиглодог.

Ангийн гишүүдийн анхаарлыг самбар дээрх эхний асуулт руу хандуул (“Бэлтгэл”-ийн 3-ыг үз):

- Израилын угсаа гэж юу вэ?

Израилын угсаа буюу *Израил* гэсэн нэр томъёо нь, нэр нь Израил болон өөрчлөгдсөн Иаковын үр удмыг хэлж байгааг тайлбарла (та анхаарал татах үйл ажиллагааг ашиглаж байгаа бол энэхүү тайлбарынхаа хэсэг болгон Иаковын хөвгүүдээ адислаж байгаа зургийг үзүүлж болно). Израилын угсааны гишүүдийг сударт “Их Эзэнтэй гэрээт хүмүүс” (1 Нифай 15:14) болон “гэрээний хүүхдүүд” (3 Нифай 20:25–26) гэдэг. Нифайчууд Иаковын хүү Иосефын үр удмын хувьд Израилын гэрээс гаралтай (1 Нифай 5:14).

Аврагч Израилын бутралын тухай заасан хэмээн тайлбарла. Тэгээд ангийн гишүүдийн анхаарлыг самбар дээрх хоёр дахь асуулт руу хандуул:

- Израил яагаад тарж бутарсан бэ?

Ангийн нэг гишүүнийг 3 Нифай 16:4-ийг чангаар уншихыг урь. Бусад гишүүдийг асуултын хариуг эрж хамтдаа дотроо уншихад урамшуул. Ангийн гишүүд асуултыг ярилцах үед тэд Израилын угсааны гишүүд нь “өөрсдийн итгэлгүйн улмаас газрын дээр тараагдсан” гэдгийг ойлгож байгаа эсэхийг нь анхаар.

2. Аврагч Израилын гэрийн сүнслэг цугларалтын тухай бошиглодог.

Ангийн гишүүдийн анхаарлыг самбар дээрх гурав дахь асуулт руу хандуул:

- Харийнхан гэж хэн бэ?

Судруудад *Харийнхан* гэсэн нэр томъёог Израилын гэрт төрөөгүй, мөн сайн мэдээгүй өөр улс түмнийг тодорхойлохын тулд хэрэглэсэн хэмээн тайлбарла. Тус хичээлд ярилцах бүлгүүдэд Харийнхан гэсэн нэр томъёог сайн мэдээгүй, тэр ч бүү хэл тэдний дотор Иаковын удмынхан ч байж болох улс түмнийг тодорхойлоход хэрэглэдэг.

Ангийн гишүүдийн анхаарлыг самбар дээрх дөрөв дэх асуулт руу хандуул:

- Харийнхан нь Израилын бутрал болон цугларалттай ямар холбоотой вэ?

Ангийн нэг гишүүнийг 3 Нифай 16:7–9 болон 21:1–5-ыг уншихыг урь. Бусад гишүүдийг асуултын хариуг эрж хамтдаа дотроо уншихад урамшуул.

Харийнхан Израилын бутралд үүрэг гүйцэтгэх талаар Аврагч бошиглосон хэмээн онцол. Мөн түүнчлэн Израил эцэст нь Харийнхнаар дамжуулан дахин сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авч цугларах болно хэмээн бошиглосныг онцлон тэмдэглэ.

Ангийн гишүүдийн анхаарлыг самбар дээрх тав дахь асуулт руу хандуул:

- Израилын цугларалт гэж юу вэ?

Ангийн нэг гишүүнийг 3 Нифай 16:4, 12; 20:10–13-ыг уншихыг урь. Бусад гишүүдийг асуултын хариуг эрж хамтдаа дотроо уншихад урамшуул. Ангийн гишүүд асуултыг ярилцах үед тэд дараахыг ойлгож байгаа эсэхийг анхаар:

Хүмүүс Гэтэлгэгч болон Түүний дахин сэргэсэн сайн мэдээний гэрчлэлтэй болж Түүний Сүмд нэгдэхэд Израил цугларсан (та анхаарал татах үйл ажиллагааг ашиглаж байгаа бол ярилцлагынхаа нэгэн хэсэг болгон усан баталгааны зургийг үзүүлж болно).

Дахин сэргээгдсэн Сүмийн анхны өдрүүдэд Өөрийн Сүмийн гишүүдэд Миссури, Иллинойс, аль эсвэл Солт Лэйк Валигийн алинд нь ч байсан Хойт Америкийн Гэгээнтнүүдийн гол хэсэгтэй нэгдэх Их Эзэний зарлиг нь Израилын цугларалтын нэг хэсэг байлаа. Ирээдүйд Израилын угсааны гишүүд өв болсон нутагтаа цугларахад бас нэгэн бодит цугларалт болно (тус хичээлийн 3-р хэсгийг үз). Харин одоо болж буй цугларалт бол сүнслэг цугларалт юм.

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл ийнхүү тайлбарласан: “Алс холын орнуудын хүмүүс сайн мэдээг хүлээн авч өөрсдийнхөө улс оронд үлдэхэд ‘Израилын цугларалт’ хэрэгжих болно. Мексикчүүдийн Израилын цугларалт Мексикт; хойт зүгийн орнуудад амьдардаг бол Скандинавт; Герман хүмүүсийн цугларалт Германд; Полинезчууд арлуудад; Бразилчууд Бразилд; Аргентинчууд Аргентинд байх болно” (in Conference Report, Apr. 1975, 4; or *Ensign*, May 1975, 4).

Ангийн гишүүдийн анхаарлыг самбар дээрх зургаа дахь асуулт руу хандуул:

- Израилын хожмын үеийн цугларалт эхэлснийг ямар тэмдэг харуулдаг вэ?

Ангийн нэг гишүүнийг 3 Нифай 21:2–7 ба 29:1–2-ыг уншихыг урь. Бусад гишүүдийг асуултын хариуг эрж хамтдаа дотроо уншихад урамшуул.

- Нифайчуудын “хэлж ярих” болон “үйл хэрэг” нь Харийнханд хэрхэн хүрч ирсэн бэ? (Мормоны Номын орчуулгаар дамжуулан. Та анхаарал татах үйл ажиллагааг ашиглаж байгаа бол уг ярилцлагын хэсэг болгон Мормоны Номыг ашиглаж болно.) Мормоны Ном Израилын цугларалтанд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? (Жишээ болгон 3 Нифай 16:4, 12 ба 20:10–13-ыг 1 Нифай 6:3–4-тэй болон Мормоны Номын оршлын хэсгийг харьцуул. Мормоны Ном нь Их Эзэний гэрээнүүдийг зааж бүх хүмүүст Есүс бол Христ гэдгийг итгүүлэхийн тулд бичигдсэн хэмээн онцол.)
- Их Эзэн Мормоны Номыг урагшлуулах “агуу их хийгээд гайхамшигт байх тэр ажлыг” хийхэд нь туслах нэгэн үйлчлэгчийн тухай ярьсан (3 Нифай 21:9–10). Энэ үйлчлэгч хэн байсан бэ? (Иосеф Смит. Та анхаарал татах үйл ажиллагааг ашиглаж байгаа бол уг ярилцлагын хэсэг болгон Иосеф Смитийн зургийг үзүүлж болно.)

Та Иосеф Смитийг Иаковын шууд үр удам байсан боловч тэрээр (2 Нифай 3:3–8, 11–12) Харийнхны дунд амьдарч байсан хэмээн онцолж болно. Түүний сайн мэдээг дахин сэргээх болон Мормоны Номыг урагшлуулах ажил нь Их Эзэний “үнэн нь Харийнханд ирэх болно” гэсэн амлалтын биелэлтийн нэг хэсэг юм (3 Нифай 16:7).

- Ангийн нэг гишүүнээр 3 Нифай 16:11–12-ыг чангаар уншуул. Харийнхнаар дамжуулан сайн мэдээ бүрэн дүүрнээрээ дахин сэргээгдсэний дараа Их Эзэн юу хийхээр амласан бэ? (Тэрээр Израилын гэртэй хийсэн Өөрийн гэрээг санаж байхаа амласан.)
- Их Эзэний санаж байхыг амласан тэр гэрээ бол Абрахамын үеийн гэрээ юм (3 Нифай 20:25, 27, 29; 21:4; Мормон 5:20). Абрахамын үеийн гэрээний ямар адислал болон үүргүүд байдаг вэ? (Эхлэл 17:1–8; Абрахам 2:6, 9–11-ийг үз.)
- Наманчилж Бурханд хандсан Харийнханд юу тохиолдох вэ? (2 Нифай 30:2; 3 Нифай 16:13; 21:6, 22-ыг үз. Наманчилж Их Эзэнд усан баталгаагаар дамжуулан ирсэн бүх хүмүүс Түүний гэрээт хүмүүсийн тоонд тооцогдох болно.)

Ерөнхийлөгч Иосеф Филдинг Смит ийнхүү хэлсэн: *“Сайн мэдээг хүлээн авсан хүн бүр Израилын угсааны нэг хэсэг нь болдог. Өөрөөр хэлбэл, тэд сонгогдсон угсааны гишүүд буюу Исаак болон Иаковоор дамжуулан амлалт өгөгдсөн Абрахамын хүүхдүүд болдог. Сүмийн гишүүн болсон ихэнх хэсэг нь Иосефын хүү Ефраимаар дамжуулан үгчлэн Абрахамын удам угсаа мөн юм. Үгчлэн Абрахам болон Израилын угсааны бус хүмүүс нь тийм болох ёстой ба тэд усаар батлуулж батлагдахдаа удмын модонд орон өв залгамжлагчийн хувьд бүх эрх, мэдлийг эдлэх болно”* (Doctrines of Salvation, comp. Bruce R. McConkie, 3 vols. [1954–56], 3:246).

Ангийн нэг гишүүнийг самбар дээрх долоо дахь асуултыг уншуулахаар урь:

- Сүмийн гишүүдийн хувьд Израилын цугларалтанд бид ямар үүрэгтэй вэ?
Ангийн гишүүдэд асуултанд хариулах хугацаа олго. Мөн та ярилцлагыг илүү их өрнүүлэхийн тулд доорх асуултыг тавьж болно. Та анхаарал татах үйл ажиллагааг ашиглаж байгаа бол уг ярилцлагын үеэр фото зураг болон номлогчийн тэмдгийг (аль эсвэл өөр зүйлийг) үзүүлж болно.
- Сүмийн үүрэг бол бүх хүмүүсийг Христэд ирэхэд нь урих явдал юм. Бид энэхүү үүргийг сайн мэдээг тунхаглан, үхэгсдийг гэтэлгэн, Гэгээнтнүүдийг төгөлдөржүүлэн биелүүлж чадна. Сүмийн үүрэг Израилын цугларалтанд хэрхэн хувь нэмэр оруулдаг вэ?

3. Аврагч Израилын угсааны бодит цугларалтыг бошиглодог.

- Ангийн нэг гишүүнээр 3 Нифай 16:16 болон 20:14-ийг чангаар уншуул. Эдгээр шүлгүүдийн дагуу Их Эзэн Нифайчуудад ямар онцгой амлалт өгсөн бэ? (Тэдэнд Америк нутгийг өв болгон өгнө. 2 Нифай 1:5–7-г үз.) Энэхүү амлалтыг ямар үүрэг хариуцлага дагалддаг вэ? (Инос 1:10; Ифэр 2:8–9-ийг үз.)
- Ангийн гишүүдээр 3 Нифай 21:22–29 дэх шүлгүүдийг ээлжлүүлэн уншуул. Эдгээр шүлгүүдийн дагуу хожмын өдрүүдэд энэ өвлөгдсөн нутагт юу тохиолдох вэ? (Шинэ Иерусалим хэмээх хот байгуулагдах болно.)

Эх Иерусалим хот бас дахин сэргээгдэх болно хэмээн онцол (3 Нифай 20:29–34). Иүдейчүүдэд энэ газар нутгийг өв болгон өгөх болно.

- Аврагч хүмүүсээ цуглуулан тэдний дунд Сионыг байгуулахаа хэлсэн (3 Нифай 21:1). Хэдийгээр *Сион* нь онцгой гаруудыг тодорхойлдог ч энэ нь бас зүрх сэтгэл, оюун санааны байдлыг илэрхийлдэг. Судруудад Сионыг хэрхэн дүрсэлсэн байдаг вэ? (С ба Г 97:21 ба Мосе 7:18–19-өөс зарим жишээг үзэж болно.) Бид өөрсдийн гэр орон, хэсэг, гадастаа өнөөдөр Сионыг хэрхэн байгуулж эхэлж болох вэ?

Дүгнэлт

Ангийн гишүүдэд сүүлчийн өдрүүдэд Израилын угсаа гэсэн нэрийн дор наманчилж, Есүс Христийг дагаж, Түүний Сүмд усаар батлуулсан бүх хүмүүс багтдаг хэмээн сануул. Ангийн гишүүдийг Их Эзэний гэрээт хүмүүсийн хэсэг байхаар зохистой амьдрахад урамшуул. Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

“Тэр Тэдэнд Бүх Зүйлсийг Тайлбарласан”

Хичээл
41

3 Нифай 22–26

Зорилго Ангийн гишүүдэд бошиглогчдын үгсийг эрэлхийлэхийг хичээнгүйлэн хүсэхэд туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. 3 Нифай 22; 23:1–5. Аврагч Израилын угсааны хожмын өдрийн тухай Исаиагийн бошиглолын заримаас иш татдаг. Тэрээр хүмүүст Исаиа болон бусад бошиглогчдын үгсийг эрэлхийлэхийг зарлигладаг.
 - б. 3 Нифай 23:6–14; 24; 25. Аврагч хүмүүст өөрсдийнхөө тэмдэглэлд Лэмэнчүүдийн Сэмүэл болон Малахи нарын зарим үгсээс нэмж бичихийг зарлигладаг.
 - в. 3 Нифай 26. Аврагч бүх зүйлийг эхнээс нь Тэрээр Өөрийн алдар суугаараа ирэх үе хүртэл тайлбарладаг.
2. Нэмж унших зүйл: Исаиа 54; Малахи 3–4.
3. Хэрэв Христ Бичээсүүдийг Авчрахыг Хүссэн нь зураг байгаа бол үүнийг хичээлдээ хэрэглэхээр бэлтгэ (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 323).

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

**Анхаарал Татах
Үйл Ажиллагаа** Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Дараах үгсийг самбарт бич: *Судал, Эргэцүүлэн Бод, Залбир*

Ангийн гишүүдээс эдгээр үгс нь биднийг судраас суралцахад ямар холбоотой байдаг тухай асуу.

Энэ хичээлд Аврагч үнэт үнэнийг заахад судрыг хэрхэн хэрэглэхийг харуулдаг. Бид судраас судалж, эргэцүүлэн бодож, залбирахад эдгээр үнэнүүдийг илүү их ойлгоно.

**Судрын Ярилцлага
ба Хэрэглээ** Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Израилын угсааны тухай Исаиагийн зарим бошиглолоос Аврагч иш татдаг.

3 Нифай 22; 23:1–5-ыг ярилц. Сонгосон шүлгүүдийг ангийн гишүүдээс чангаар уншихыг урь. 22-р бүлэгт Аврагч Сионы хожмын өдрүүд дэх алдар суугийн талаарх Исаиагийн сургаалтай (Исаиа 54) бүлгийг бүхлээр нь иш татсаныг бичсэн байдаг.

- Исаиа Израилын угсаанд “Майхныхаа зайг томсгож, . . . аргамжаагаа уртасгаж мөн гадсаа бөхлөгтүн” (3 Нифай 22:2) гэж уриалсан. Майхан, гадаснууд нь юуг бэлэгддэг вэ? (Доорх ишлэлийг үз.) “Майхныхаа зайг томсгож,” “гадсаа бөхлөх” гэдэг нь ямар утгатай гэж та нар бодож байна вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон хэлэхдээ:

“Бошиглогчид хожмын үеийн Сионыг дэлхийг багтаасан агуу майхангаар адилтгасан. Майхныг гадаснуудад бөхлөж уясан аргамжаагаар бэхэлж байв. Мэдээж тэдгээр гадаснууд нь дэлхийгээр хаа сайгүй тархсан газар зүйн янз бүрийн газарт байгаа байгууллагууд юм. Саяхнаас Израилыг Сионы янз бүрийн гадаснуудад цуглуулж байгаа билээ. . . .

“ . . . Гадаснууд нь Гэгээнтнүүдийг үзэгдэх болон үл үзэгдэх дайснуудаас хоёулангаас нь хамгаалдаг. Хамгаалалт нь гэрчлэлийг батжуулж, гэр бүлийн эв нэгдэл, хувь хүний зөв шударга байдлыг тэтгэн дэмждэг пристийн зэргийн үе холбоогоор дамжин ирдэг зүг чиг юм” гэжээ (“Strengthen Thy Stakes,” *Ensign*, Jan. 1991, 2, 4).

- Бид хувиараа болон гэр бүлээрээ гадаснууд нь биднийг хилэнцэтээс хоргодож, хамгаалах газар болж байгааг анхаарахад юу хийж чадах вэ?
- Исаиа Их Эзэн, Израилын угсаа хоёрын хоорондын холбоог хэрхэн дүрсэлсэн бэ? (3 Нифай 22:4–10-ыг үз. Тэр Их Эзэнийг нөхөр, Израилыг эхнэр нь гэж дүрсэлсэн.) Энэ дүрслэлт нь Их Эзэний Өөрийн хүмүүсийн төлөө бүхнээ зориулдаг тухай юуг заадаг вэ?

Ахлагч Жэффри Р.Холланд заахдаа: “Жэховаг сүйт залуу, Израилыг сүйт бүсгүй болгон төсөөлсөн нь сударт Тэнгэрлэг Дээд болон гэрээний хүүхдүүд хоёрын хоорондын холбоог Их Эзэн, түүний бошиглогч нар дүрслэхдээ хэрэглэдэг хамгийн өргөн хэрэглэгддэг хэрэглүүрийн тоонд ордог. . . . Христ зарим тохиолдолд доройтож байсан Израилд үнэндээ уурлаж байсан боловч энэ нь товчхон бөгөөд ‘богино хугацаанд’ түр зуур болдог байв. Энэрэл, нигүүлсэл үргэлж эргэн ирж, хамгийн баттай замаар ялж гардаг. Уул, толгод алга болж болно. Их далайн ус хатаж ширгэж болно. . . . Их Эзэний сайхан сэтгэл, амар амгалан түүний гэрээт хүмүүсээс хэзээ ч холдохгүй. Тэр тэдэнд үүрд уурлахгүй гэж тэнгэрлэг тангараг өгсөн билээ” гэжээ (*Christ and the New Covenant* [1997], 290).

- Израилын угсаа хожмын өдөр цуглах газрыг Их Эзэн хэрхэн дүрсэлсэн бэ? (3 Нифай 22:11–12-ыг үз; мөн Илчлэлт 21:18–21-ийг үз.) Энэ газарт амьдрах хүмүүст ямар амлалтууд өгөгдсөн байдаг вэ? (3 Нифай 22:13–17-г үз.) Эдгээр амлалтууд зовж шаналсан хүмүүст хүчийг хэрхэн өгдөг вэ?

- Есүс эдгээр бошиглолуудаас иш татсаныхаа дараа хүмүүст, “Та нар эдгээр зүйлүүдийг судалбал зохино” (3 Нифай 23:1) гэж хэлсэн.
Судруудыг өнгөц уншихын оронд судална гэдэг нь ямар утгатай вэ?
Ахлагч Хэнри Б.Айринг хэлэхдээ: “Бид Бурханы үгийг зөвхөн уншиж биш тэдгээрийг суралцсанаар нандигнадаг. Бид судрын бүхэл бүлгүүдийг ерөнхийд нь яаран уншихын оронд өөрсдөө Ариун Сүнсний тусламжаар тэдгээрийг нандигнах боломжтой байж цөөн үгсийг эргэцүүлэн бодож илүү их тэжээгдэх болно” гэжээ (in Conference Report, Oct. 1997, 115; or *Ensign*, Nov. 1997, 84).
- Та нар судраас суралцсанаар хэрхэн адислагдсан бэ? (Та ангийн гишүүдийг судрын тодорхой нэг хэсэг нь урам, ойлголт өгч эсвэл хувийн асуудалд нь хариу өгөх утга санаа илэрхийлсэн явдлаасаа хуваалцахыг урьж болно.)
- Аврагчийн үгсийг бичиж тэмдэглэх нь хүмүүст яагаад чухал байсан бэ? (3 Нифай 23:3–5-ыг үз.)
- Аврагч хүмүүст, “Бошиглогчдыг эрэлхийлж, учир нь эдгээр зүйлийн талаар гэрчлэх нь олон байдаг” (3 Нифай 23:5) гэж зарлигласан.
Бошиглогчид юуны тухай гэрчилдэг вэ? Та эртний болон өнөөгийн бошиглогчдын гэрчлэлээс хэрхэн батажсан бэ?

2. Аврагч хүмүүст өөрсдийн бичээстээ нэмж бичихийг зарлигладаг.

3 Нифай 23:6–14; 24; 25-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.
Есүс хүмүүст заасан зүйлийнх нь тухай бичиж тэмдэглэ гэж зарлигласныхаа дараа өөр бусад судруудын тухай заасаар байдаг. Есүс бичиж тэмдэглэхийг хүсэж байгаа зургийг та хэрэглэж байгаа бол үүнийгээ одоо үзүүл.

- Лэмэнчүүдийн Сэмүэлийн хэлсэн бошиглолыг бичээстээ нэмж бичихийг Есүс Нифайчуудад зарлигласан. Энэ бошиглолд Сэмүэл “олон гэгээнтнүүд үхэгсдийн дундаас босож, олонд үзэгдэж, мөн тэдэнд тохинуулах болно” (3 Нифай 23:6–13) гэж хэлсэн. Чухам энэ бичээс чухал байсан гэж та нар яагаад бодож байна вэ? (Хариултанд Сэмүэлийн бошиглолын биелэл Дахин Амилалтын бодит үнэн байдлыг гэрчилсэн гэдэг нь орж болно.)
- Есүс хүмүүст Сэмүэлийн бошиглолын тухай бичихийг хэлсний дараа тэднийг юу хий гэж зарлигласан бэ? (3 Нифай 23:14-ийг үз.) Аврагчийн үгсийг бид тодорхой ямар замаар илүү үр ашигтайгаар зааж болох вэ?
- Мөн Есүс бошиглогч Малахигийн зарим үгсээс бичихийг хүмүүст зарлигласан (3 Нифай 24:1). Малахигийн үгс Нифайчуудын бичээст яагаад байгаагүй вэ? (Малахи Лихайг Ерусалимаас яваад бараг 200 жил болтол амьдарч байгаагүй учир түүний үгс нь гуулин ялтсуудад ороогүй байсан.)
- Малахигийн ямар сургаал нь бидэнд онцгойлон чухал байдаг вэ? (Энэ асуултанд хариулт олуулахаар ангийн гишүүдээр 3 Нифай 24:1, 8–18 ба 25:1–6-г уншуул. Та ангиа дөрвөн хэсэгт хувааж болно. Хэсэг тус бүрийг дараах хэсгүүдээс нэгийг уншиж, Малахи юу заасныг тайлбарлахыг урь. Дараа нь хэсгүүдийг дор үзүүлсний дагуу ярилц.)
а. 3 Нифай 24:1; Малахи 3:1-гэй харьцуул. Их Эзэний Хоёр Дахь Ирэлтэд замыг бэлтгэхээр илгээгдсэн элч хэн байсан бэ? (С ба Г 45:9-ийг үз.)

Дахин сэргэсэн сайн мэдээ тэнгэрлэг элчийн дахин сэргээсэн түлхүүрүүд, хүч чадлын хамт.) Иосеф Смит ямар талаараа хожмын үеийн элч болдог вэ?

- б. 3 Нифай 24:8–12; Малахи 3:8–12-той харьцуул. Аравны нэг, өргөлүүдээ төлдөг хүмүүст эдгээр шүлэгт ямар адислалууд амлагдсан байдаг вэ? Та нар аравны нэг, өргөлүүдээ төлснөөр хэрхэн адислагдаж байсан бэ?
- в. 3 Нифай 24:13–18; Малахи 3:13–18-тай харьцуул. Зарим хүмүүс “Бурханд үйлчлэх нь хий хоосон зүйл юм гэж яагаад итгэдэг вэ? (3 Нифай 24:14–15-ыг үз.) Хилэнцэт өсч нэмэгдээд байхад хүртэл бид итгэлдээ хэрхэн баттай үлдэж чадах вэ?
- г. 3 Нифай 25:1–6; Малахи 4:1–6-тай харьцуул. Үндэс эсвэл мөчиргүй үлдсэн гэдэг ямар утгатай вэ? (Үндэс гэдгийг эцэг эх, өвөг дээдсээ, *мөчир* гэдгийг та нарын үр хүүхэд, үр сад гэж үз. Өөрсдийн үндэс, мөчиртэйгөө нэгдмэл байхын тулд бид ариун сүмийн ёслолуудыг хүртэх ёстой.) Их Эзэн Хоёр Дахь Ирэлтийн өмнө хэнийг илгээнэ гэж хэлсэн бэ? Элайжа хэзээ, хаана ирсэн бэ? (С ба Г 110:13–16-г үз.) Тэр ямар түлхүүрүүдийг дахин сэргээсэн бэ? (Өөрсдийн өвөг дээдэс, үр садтайгаа нэгдмэл болох замыг хангаж өгөх холбох хүчний түлхүүрүүд.)

3. Аврагч бүх зүйлүүдийг эхнээс нь тайлбарладаг.

3 Нифай 26-гаас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Малахигийн бошиглолыг Нифайчуудад заах тухай ямар шалтгааныг Аврагч өгсөн бэ? (3 Нифай 26:2-ыг үз.) Малахигийн сургаалуудын аль нь та нарт онцгой чухал ач холбогдолтой байсан бэ?
- Малахигийн бошиглолын тухай ярилцсаны дараа Аврагч хүмүүст юуны тухай заасан бэ? (3 Нифай 26:1, 3–5-ыг үз. Шаардлагатай бол *тайлбарлах* гэдэг нь няхуур сайн, нэг бүрчлэн тайлбарлах гэсэн утгатай гэдгийг тайлбарла.) Бид Есүсийн адил сайн мэдээг яагаад “эхнээс нь” заах ёстой вэ?
- Мормон Есүсийн хүмүүст заасан зүйлээс зөвхөн “багахан хэсгийг” бичээстээ оруулсан (3 Нифай 26:8). Зөвхөн энэ багахан хэсэг нь бидний итгэлийг хэрхэн сорьдог вэ? Бид “агуу их зүйлүүдийг” хэрхэн хүртэж чадах вэ? (3 Нифай 26:9-ийг үз.)

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл хэлэхдээ: “Олон жилийн туршид олон хүн надаас, ‘Бид Мормоны Номын үлдсэн хэсгийг хэзээ хүлээн авна гэж та бодож байна вэ?’ гэж асуухад нь би, ‘Цугларагсдын дотроос хэд нь ялтсуудын лацадсан хэсгийг уншихыг хүсэж байна вэ?’ гэж асуусан. Тэгэхэд бараг үргэлж 100 хувь хариулт өгдөг байв. Дараа нь би мөн адил цугларагсдаас, ‘Та нарын хэд нь бидэнд өгөгдсөн нээлтэй байгаа хэсгийг нь уншсан бэ?’ гэж асуудаг. Лацдаагүй хэсэг болох Мормоны Номыг уншаагүй хүн олон байдаг. Бид үе үе онцгой, хүртэж боломгүй юмыг эрж хайж байдаг. Олон хүн доод хуулийн дагуу амьдардаггүй байж илүү дээд хуулийн дагуу амьдрахыг хүсдэг гэдгийг би олж мэдсэн” гэсэн (*The Teachings of Spencer W. Kimball*, ed. Edward L. Kimball [1982], 531–32).

- Ангийн гишүүнийг 3 Нифай 26:14, 16-г уншихыг урь. Аврагч хүүхдүүдийг хэрхэн авч үздэг тухай эдгээр шүлэгт юу харуулдаг вэ?

- Эдгээр үйл явдлын гэрч болсон Нифайчууд бие биендээ хэрхэн хандаж байсан бэ? (3 Нифай 26:19–21-ийг үз.) Бид гэрлэлт, гэр бүл, хэсэг болон гадсандаа тэдний жишээг хэрхэн дагаж чадах вэ?

Дүгнэлт

Аврагч бидэнд судраас иш татаж, эдгээрийг судлахыг хүмүүст зарлиглаж, сударт нэмснээр судрууд чухал гэдгийг бидэнд харуулсан гэдгийг тайлбарла. Бид судраас судалж, эргэцүүлэн бодож, залбирснаар эдгээрийг илүү гүн гүнзгий ойлгож, бусдад илүү үр ашигтайгаар зааж чадна.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Зорилго

Ангийн гишүүдэд Есүс Христийн сайн мэдээний үндсэн номлолыг ойлгоход тусалж, мөн сайн мэдээний дагуу амьдрах нь үнэн болоод мөнхийн аз жаргалд хүрэх цорын ганц зам мөн гэдгийг заах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. 3 Нифай 27. Аврагч арван хоёр Нифайчууд болох шавь нартаа Сүмийг Түүний нэрээр нэрлэ гэж зарлигладаг. Тэр Өөрийн сайн мэдээгээ тайлбарладаг.
 - б. 3 Нифай 28. Аврагч нэг нэгээр нь арван хоёр Нифайчууд болох шавь нартаа тэдний зүрх сэтгэлийн хүслийг биелүүлдэг. Шавь нарынх нь гурав нь Аврагчийг өөрийнх нь алдар суугаар эргэж ирэх хүртэл дэлхий дээр үлдэж сайн мэдээг номлох хүчийг хүссэн бөгөөд үүнийгээ авдаг.
 - в. 4 Нифай 1. Бүх хүмүүс хөрвүүлэгддэг бөгөөд тэд төгс амар амгалангийн нийгмийг тогтоодог. Олон жилийн дараа хүмүүсийн ихэнх нь үл итгэх байдалтай болж, сайн мэдээг эсэргүүцдэг.
2. Нэмж унших зүйл: Сургаал ба Гэрээ 39:1–6.
3. Христ Гурван Нифайн Хамт зураг байгаа бол үүнийг хичээлдээ хэрэглэхээр бэлтгэ (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 324).

Хичээлийг Баяжуулах Зөвлөмж

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Мормоны Сүм гэж самбарт бич. Ангийн гишүүдээс энэ хочны тухай дотроо бодохыг хүс. Дараа нь Ерөнхийлөгч Боид К.Пакерын дараах мэдэгдлийг унш:

“Бусад хүмүүст биднийг Мормончууд гэдэг. Тэд энэ нэрийг хэрэглэхэд нь би татгалздаггүй. Гэхдээ бид заримдаа өөрсдийгөө ‘Мормоны Сүм’ гэж нэрлэх дуртай байдаг. Ингэх нь бидэнд хамгийн сайн зүйл гэж би бодохгүй байна” (“The Peaceable Followers of Christ,” *Ensign*, Apr. 1998, 64).

- Бид өөрсдийгөө “Мормоны Сүм” гэж нэрлүүлэхгүй байх нь яагаад сайн бэ?

Тэргүүн Зөвлөлөөс мэдэгдэхдээ: “Энэ бол Есүс Христийн Сүм юм гэдгийг бодол санаандаа хадгалагтун; үүнийг бусадтай харьцаж байхдаа онцлон тэмдэглэгтүн. . . . Бид зарим хүмүүс ‘Мормоны Сүм’ гэж байнга хэрэглэдэг нэрнээс болж төөрөлдөж байна гэж бодож байна” гэжээ (“Policies and Announcements,” *Ensign*, Mar. 1983, 79).

Мормоны Сүм гэж самбарт бичсэнээ арч. Ангийн гишүүдэд 3 Нифай 27-д Есүс Өөрийн Нифай шавь нартаа Түүний Сүмийн нэрийн талаар зааварчилсан зүйл нь багтсан байдгийг тайлбарла.

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Аврагч Өөрийн Нифай шавь нартаа Сүмийг Түүний нэрээр нэрлэхийг зарлигладаг. Тэрээр Өөрийн сайн мэдээгээ тайлбарладаг.

3 Нифай 27-гоос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Есүсийн Нифай шавь нар нь “хүчирхэг залбирал, мөн мацаг барилтанд нэгдэхэд” Есүс тэдэн дээр ирээд тэднээс ийн асуусан, “Намайг та нарт юу өгөөсэй хэмээн та нар хүснэв?” (3 Нифай 27:1–2). Шавь нар нь Түүнээс юуг хүссэн бэ? (3 Нифай 27:3-ыг үз.) Тэрээр тэдний асуултанд юу гэж хариулсан бэ? (3 Нифай 27:4–9-ийг үз.)
- Нифайчуудын дундах Сүмтэй нь адил Түүний дахин сэргээгдсэн Сүмийг Түүний нэрээр нэрлэнэ гэж Их Эзэн зарлигласан. (С ба Г 115:4). Сүмийг Есүс Христийн нэрээр нэрлэхийг санах нь бидэнд яагаад чухал вэ?
- Есүс хэлсэн нь, “Та нар юуг ч үйлдсэн, үүнийгээ миний нэрээр үйлдэх болно” (3 Нифай 27:7). Бид Христийн нэр дээр ямар зүйлүүдийг хийдэг вэ? (Та ангийн гишүүдийн хариултыг хүсэхийн зэрэгцээгээр дор байгаа ишлэлийг уншиж өгч болно.)

Ерөнхийлөгч Боид К.Пакер хэлсэн нь:

“Бид залбирал болгоноо Түүний нэр дээр хэлдэг. Гүйцэтгэдэг ёслол бүрээ Түүний нэр дээр хийдэг. Усан баталгаа, баталгаа, адислал, ёслолууд нэг бүр, номлол бүрийг Түүний нандин нэр дээр залбиран төгсгөдөг. Бид Түүний нэрээр өвчтэй хүмүүсийг анагааж, бидний ярьж болдоггүй гайхамшгуудыг гүйцэтгэдэг.

“Ариун ёслол дээр бид Христийн нэрийг өөрсөд дээрээ хүлээн авдаг. Бид Түүнийг дурсан санаж, Түүний зарлигуудыг дагана гэдэг гэрээг байгуулдаг. Тэрээр бидний итгэдэг зүйл бүрт бидний дэргэд байдаг” (“The Peaceable Followers of Christ,” *Ensign*, Apr. 1998, 64).

- Есүс Өөрийнх нь нэрээр нэрлүүлэхийн зэрэгцээгээр, Түүний Сүм “[Түүний] сайн мэдээн дээр баригдсан” байх ёстой гэж хэлсэн. Тэрээр хэлэхдээ, “Хэрэв уг сүм нь сайн мэдээн дээр минь тулгуурласан аваас тэгвэл Эцэг үүний дотор өөрийнхөө ажлуудыг үзүүлэх болно” гэжээ (3 Нифай 27:10). Эцэгийн ажлууд гэж юу вэ? (Жишээлбэл, 3 Нифай 21:1–9, 24–29; Мосе 1:39-ийг үз.) Та эдгээр ажлуудыг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд хэрхэн харсан бэ?

Хожмын үеийн Гэгээнтнүүд гэрчлэлээ хуваалцахдаа, үргэлж сайн мэдээг үнэн гэдгийг мэддэг гэж хэлдэг гэдгийг цохон тэмдэглэ. Ангийн гишүүдээс хэрэв тэд “Би сайн мэдээг үнэн гэдгийг мэднэ” гэж хэлснийхээ дараа “Сайн мэдээ гэж юу вэ?” гэсэн асуултыг тэднээс асуувал тэд юу гэж хариулахаа дотроо чимээгүйхэн эргэцүүлж бодохыг хүс.

Самбар дээр “Энэ бол миний сайн мэдээ” гэж бич. Есүс Түүний Сүм нь Түүний сайн мэдээн дээр байгуулагдсан байх ёстой бөгөөд Тэрээр Өөрийн

сайн мэдээний тухай товч бөгөөд бүрэн дүүрэн тодорхойлолтыг шавь нартаа өгсөн гэдгийг тайлбарла. Ангийн гишүүдээр ээлжлүүлэн 3 Нифай 27:13–22 шүлгүүдийг уншуулж, Есүс Христийн сайн мэдээний янз бүрийн хэлбэрүүдийг хайлга. Та ангийн нэг гишүүнээр хариултуудыг самбар дээр бичүүлж болно. Байж болох зарим хариулт:

а. Есүс Эцэгийнхээ хүсэлд захирагдсан (3 Нифай 27:13)

б. Цагаатгал (3 Нифай 27:14)

в. Дахин Амилалт (3 Нифай 27:14–15)

г. Шүүлт (3 Нифай 27:14–15)

д. Наманчлал (3 Нифай 27:16, 19–20)

е. Усан баталгаа (3 Нифай 27:16, 20)

ё. Есүс Христэд итгэх итгэл (3 Нифай 27:19)

ж. Ариун Сүнсний Бэлэг (3 Нифай 27:20)

з. Эцсээ хүртэл тэвчих (3 Нифай 27:16–17, 19)

- Есүс Өөрийнх нь сайн мэдээний дагуу амьдардаг хүмүүст юуг амласан бэ? (3 Нифай 27:21–22-ыг үз.)
- Есүс Өөрийн шавь нарт хэлэхдээ, “Та нар ямархуу маягийн хүмүүс байвал зохих вэ?” гэсэн. Энэ асуултын хариу нь юу байсан бэ? (3 Нифай 27:27-г үз. Ангийн гишүүдээс Аврагчтай илүү адил байхын тулд тэд юу хийж болох тухайгаа чимээгүйхэн тунгаан бодохыг урь.)

2. Аврагч арван хоёр шавь нарынхаа хүслийг биелүүлдэг. Шавь нарынх нь гурав нь Түүний Хоёр Дахь Ирэлт хүртэл дэлхий дээр үлдэхийг сонгодог.

3 Нифай 28-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Аврагч Эцэг рүүгээ эргэж очихын өмнө шавь нартайгаа нэг нэгэнтэй нь ярьж, хүн нэг бүрийн хүслийг нь асуудаг гэдгийг тайлбарла. Тэдний ес нь тэд тодорхой нэг насыг хүртлээ өөрсдийн үйлчлэлээ үргэлжлүүлэх бөгөөд дараа нь тэд шууд Түүний хаант улс руу Түүн рүү явахыг хүсдэг. Бусад гурав нь өөрсдийн хүслээ хэлэхээс цааргалж байсан боловч Аврагч тэдний бодлыг мэдэж байсан (3 Нифай 28:1–5). Хэрэв та Есүс гурван Нифайтай хамт байгаа зургийг хэрэглэж байгаа бол үүнийгээ одоо үзүүл.

- Сүүлчийн гурван Нифай шавь нарынх нь хүсэл юу байсан бэ? (3 Нифай 28:7–9-ийг үз. Тэд дэлхий дээр үлдэж, дэлхийн төгсгөл хүртэл хүмүүсийг Христэд авчрахыг хүссэн.) Есүс энэ шавь нар нь өөрсдийнхөө хүслээс болоод “илүү адислагдсан” гэж хэлдэг (3 Нифай 28:7). Бид энэ мэдэгдлээс юу сурч авч болох вэ? (С ба Г 15:6; 16:6; 18:10–16-г үз.)
- Гурван шавийн хүсэлтийн хариуд тэдний бие махбодь өөрчлөгдөж, улмаар тэд “Бурханы юмсыг харж чадан” хувирсан (3 Нифай 28:13–15). Дараа нь тэд хөрвүүлэгдсэн. 3 Нифай 28 дахь түүх бидэнд хөрвүүлэгдсэн хүмүүсийн тухай юу заадаг вэ? (3 Нифай 28:7–40-ийг, мөн дор байгаа жагсаалтыг үз. Та ангийнхнаа гурван хэсэгт хувааж, нэг хэсэгт нь 7–17-р шүлгийг, хоёрдугаар хэсэгт нь 18–28-р шүлгийг, гуравдугаарт нь 29–40-р шүлгүүдийг уншуулж болно. Хэсэг тус бүрээр дааж авсан шүлгүүдээс хөрвүүлэгдсэн хүмүүсийн тухай өгүүлснийг яриул.)
- а. Хөрвүүлэгдсэн хүмүүс нь үхлийг хэзээ ч үздэггүй буюу үхлийн зовлон шаналлыг мэдэрдэггүй (3 Нифай 28:7–8, 38).

- б. Аврагч Өөрийн алдар суугаараа ирэхэд тэд “нүд ирмэхийн зуур зуурдын байдлаас үхэшгүй байдалд өөрчлөгдөх” болно (3 Нифай 28:8).
- в. Дэлхийн нүглүүдийн төлөө харамсахаас биш тэд зовлон болон гунигийг мэдрэхгүй (3 Нифай 28:9, 38).
- г. Тэд хүмүүсийг Их Эзэнд хөрвүүлэгдэхэд тусалдаг (3 Нифай 28:9, 18, 23, 29–30).
- д. Тэднийг ямар ч замаар алж эсвэл тэдэнд хор учруулж болохгүй (3 Нифай 28:19–22).
- е. Сатан тэднийг уруу татаж чадахгүй буюу тэдний дээр гарах хүчгүй (3 Нифай 28:39).
- ё. Тэд хөрвүүлэгдсэн байдалдаа дахин амилж, Бурханы хаант улсад ортлоо Шүүлтийн Өдрийг хүртэл байна (3 Нифай 28:40).

Тайлбар: Хөрвүүлэгдсэн гурван Нифайн тухай түүхүүд үргэлж яригдаж байдаг. Сүмийн гишүүд эдгээр түүхүүдийг хүлээн зөвшөөрч, дахин ярихдаа болгоомжтой байх ёстой. Та эдгээрийн тухай ангид ярих ёсгүй.

3. Олон жил амар амгалан байсны дараа хүмүүсийн ихэнх нь үл итгэгч болж, сайн мэдээг эсэргүүцэх болсон.

4 Нифайгаас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. 4 Нифайн богинохон ном нь Мормоны хураангуйлж бичсэн 300 жилийн түүхийг агуулдаг гэдгийг тайлбарла. Энэ түүхийг анх дөрвөн эрэгтэй бичжээ: Аврагчийн арван хоёр Нифай шавь нарын нэг Нифай; Нифайн хүү Амос; Амосын хөвгүүд Амос, Аммарон нар байв. Энэ номын эхний хэсэгт агуу их зөв шударга байдал, аз жаргалтай үеийн тухай дүрсэлдэг бөгөөд хоёр дахь хэсэгт хүмүүсийг бусармаг явдал руу орсон тухай өгүүлдэг.

4 Нифайн тухай ярилцаж эхлэхийн тулд та ангийн гишүүдээр 4 Нифай 1:1–18-аас сонгосон шүлгүүдийг ээлжлүүлэн уншуулж болно. Тэд нарыг эдгээр шүлгүүд дээр гарсан хүмүүсийн зан чанарыг эрж хайхыг хүс. Ангийн гишүүдийг зан чанаруудыг хэлэхэд нь самбар дээр бич.

- Есүсийг айлчилснаас хойш олон жилийн турш хүмүүсийн дунд маргаангүй байсан (4 Нифай 1:2, 4, 13, 15–18). Яагаад маргаангүй байсан бэ? (4 Нифай 1:15-ыг үз.) 4 Нифай дээр дүрсэлсэн шиг бид хэрхэн зөв шударга хүмүүс болж болох вэ? Бурханы хайрыг өөрсдийн зүрхэндээ байлгахын тулд би юу хийж чадах вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлсэн нь: “Хэрэв дэлхийг сайжруулах гэж байгаа бол хайрын үйл явц нь бидний зүрх сэтгэлд өөрчлөлт гаргах ёстой. . . . Бид өөрсдөөсөө цаадхыг харж, Бурханд болон бусдад өгөх үед энэ өөрчлөлт бидэнд гардаг бөгөөд үүнийг бүх зүрх, сэтгэл, бодлоороо хийдэг” (“And the Greatest of These Is Love,” *Ensign*, Mar. 1984, 5).

- Энэ амар амгалангийн үеэр “ямар нэгэн -чууд гэж” байгаагүй (4 Нифай 1:17). Энэ нь ямар утгатай вэ? (4 Нифай 1:2–3, 15–17-г үз.) Бүлэг хүмүүсийн хоорондох ялгаанаас болоод ямар асуудлууд гарч ирдэг вэ? Сайн мэдээ нь биднийг ялгаагаа үл харгалзан нэгдмэл болоход ямар замаар тусалдаг вэ?
- Энэ амар амгалангийн урт эринг төгсгөл болоход юу нөлөөлсөн бэ? (Ангийн гишүүдээр 4 Нифай 1:20–46-г энэ асуултанд хариулт олуулахаар уншуул. Тэдний хариултыг самбарт дүгнэж бич. Зарим боломжийн хариултыг дор үзүүлэв.)

- а. Хуваагдалт ба ангилалууд бүтээгдсэн нь (4 Нифай 1:20, 26, 35)
 - б. Бардамнал ба баялагт шунах нь (4 Нифай 1:23–25, 41, 43; мөн 3 Нифай 27:32-ыг үз.)
 - в. Христийг мэднэ гэж ярьдаг Сүмүүд Түүний ихэнх сайн мэдээг үгүйсгэдэг (4 Нифай 1:26–29, 34)
 - г. Сүм нь хүмүүсийн эрх ашгийн төлөө байгуулагдсан (4 Нифай 1:26–29, 41)
 - д. Хатуу зүрх сэтгэл (4 Нифай 1:31)
 - е. Христийн дагалдагч нарыг хавчсан нь (4 Нифай 1:29–34)
 - ё. Эцэг эхчүүд хүүхдүүддээ Христэд итгэхгүй байхыг заасан (4 Нифай 1:38)
 - ж. Эцэг эхчүүд хүүхдүүддээ үзэн ядахыг заасан (4 Нифай 1:39)
 - з. Нууц явуулга (4 Нифай 1:42, 46)
- 4 Нифай 1:40–46 дээр дүрсэлсэн зан байдал, үйлдлүүд Нифайчуудыг устах явдал руу хөтөлсөн. Энэ үйл явдлыг хянаж үзэх нь бидэнд яагаад чухал вэ?

Дүгнэлт

Ангийн нэг гишүүнээр 3 Нифай 27:10, 22, 28–29 дээр Их Эзэний амласан амлалтыг чангаар уншуул. Хүмүүс сайн мэдээнд итгэлтэй байхад “тэдний дунд илүү аз жаргалтай хүмүүс [байгаагүй]” (4 Нифай 1:16).

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь хичээлдээ хэрэглэж болно.

1. Мөрдлөг хавчлагад хандах нь

- “Есүсийн хүмүүсийг” мөрдөж хавчиж байхад тэд үүнд хэрхэн хандсан бэ? (4 Нифай 1:34-ийг үз.) Ийнхүү хандсан байдал нь тэд үнэхээр Есүсийн хүмүүс гэдгийг хэрхэн харуулсан бэ? (3 Нифай 12:10–12, 38–39-ийг үз.) Хэрэв биднийг мөрдөж хавчвал бид хэрхэн хандах ётсой вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлсэн нь: “Бидний эсрэг харааж зүхэж байгаа хүмүүст хайр, эелдэг байдлаар хандацгаая. . . . Нөгөө хацраа тавьж өг гэж зөвлөсөн Христийн сүнсээр хилэнцэтийг сайн сайхнаар давж гаръя” (in Conference Report, Oct. 1982, 112; or *Ensign*, Nov. 1982, 77).

2. 3 Нифай 29–30 дахь бодол санаа

3 Нифай 29–30-ийг ярилц. 29-р бүлэгт Мормоны Номыг гарч ирсэн явдал, Их Эзэний Израилчуудтай хийсэн гэрээний биелэлт хоёрын хоорондын холбооны тухай заадаг (3 Нифай 29:1–4, 8–9). 30-р бүлэг нь Их Эзэн Мормонд хожмын үеийн Харийнханд зориулж бичихийг зарлигласан үгсийг агуулдаг.

“Та Нар Их Эзэний Замаас Яахин Салж Чаднав?”

Хичээл
43

Мормон 1–6; Мороднай 9

Зорилго Ангийн гишүүдэд дэлхий дээр өсч байгаа ёсон бус явдлыг үл харгалзан сайн мэдээний зарчмуудын дагуу амьдрахын чухлыг олж харахад нь туслах болно.

- Бэлтгэл**
1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Мормон 1. Мормон залуу хүү байхдаа нандин бичээсүүдийг хариуцах үүргийг хүлээдэг. Ёсон бус явдал газар нутгаар нь дүүрсэн боловч Мормон зөв шударга байдаг. Аврагч түүн дээр зочилж ирдэг боловч түүнийг хүмүүст номлохыг нь хориглодог.
 - б. Мормон 2; 3:1–16. Мормон Нифайчуудын цэргийн удирдагч болдог бөгөөд Нифайчуудыг Лэмэнчүүдийн эсрэг олон олон дайнд удирддаг. Нифайчууд ёсон бус байдлаасаа болж дайнд зовдог. Мормон Нифайн ялтсуудыг авч, үргэлжлүүлэн хөтөлдөг. Яваандаа Нифайчуудын ёсон бус байдлаас болж Мормон тэднийг удирдахаас татгалздаг.
 - в. Мормон 3:17–22; 5:8–24. Мормон өөрийн хураангуйлж бичсэн бичээсүүдийнхээ зорилгыг тайлбарлан хожмын үеийн хүмүүст хандан ярьдаг.
 - г. Мормон 4; 5:1–7; 6; Мороднай 9. Нифайчууд Лэмэнчүүдтэй дайтсаар байв. Мормон цэргүүдээ дахин нэг удаа удирдахаар зөвшөөрдөг. Тэр бичээсүүдийг Шим толгойгоос авч, Кумора толгойд нуудаг. Сүүлчийн их тулаанд Нифачуудын 24-өөс бусад нь бүгд алуулдаг.
 2. Мормон Нэгэнтээ Агуу Байсан Үндэстэнд Сүүлчийн Үгээ Хэлсэн нь (62043; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 319)-ийг үзүүлж, ангийн нэг гишүүнээр Мормон 6:16–22-ыг чангаар уншуул.

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Ангийн гишүүдээс асуу:

- Хэрэв та нар завиар явж байсан бол үүндээ ямар хэрэгслүүд авч явах байсан бэ?

Бүх хариултыг хүлээн зөвшөөрөөд, дараа нь Мормон өөрийн хүмүүс Нифайчуудыг, зарим нэг чухал хэрэгсэл нь дутсан завьтай харьцуулсан гэдгийг тайлбарла. Ангийн нэг гишүүнээр Мормон 5:17–18-ыг чангаар уншуул.

- Аврагчийг дагадаггүй хүмүүс ямар талаараа “далбаа эс бөгөөс зангуу үгүй сав” мэт байдаг вэ?

Мормон Нифайчуудын адилаар бус, харин сайн мэдээг амьдралдаа далбаа, зангуу адил хоёулангаар нь хэрэглэсэн гэдгийг цохон тэмдэглэ. Өөрийнх нь эргэн тойронд байгаа бүх хүн ёсон бус юм шиг санагдсан ч гэсэн тэр зөв шударга амьдарсан. Энэ хичээлд Мормон болон түүний хүмүүст юу тохиолдсон болон бид сайн мэдээг амьдралдаа хэрхэн далбаа, зангуу адил хэрэглэж болох тухай ярилцана.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Нандин цэдгүүдийг хөтлөх үүрэг хариуцлагыг Мормон хүлээн авсан.

Мормон 1-ийг ярилц. Сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг ангийн гишүүдээс урь. Мормон бүх ялтсуудыг бидний Мормоны Ном гэж мэдэх цэдэг болгон эмхэтгэх үүрэгтэй байсан. Мормон 1–6 нь Мормоны өөрийнх нь цаг үе, хүмүүсийн цэдгийг багтаадаг.

- Мормон нандин бичээсүүдийг хөтлөх үүргийг авахдаа хэдэн настай байсан бэ? (Мормон 1:2–3; мөн заах нэмэлт санааг үз.) Аммарон Мормонд ялтсуудыг хэрхэх тухай юу зааварласан бэ? (Мормон 1:3–4-ийг үз.) Нандин бичээсүүдийг хадгалж, эмхэтгэх үүрэгт нь бэлтгэсэн ямар зан чанарыг залуу Мормон өвлөсөн байсан бэ?
- Мормон 15 настай байхдаа тэрээр “Их Эзэнээр зочлогдон, мөн Есүсийн сайн сайхныг амталж мэдсэн” аж (Мормон 1:15). Бид Есүсийн сайн сайхныг хэрхэн мэдэж авч чадах вэ?
- Их Эзэн Мормоныг Нифайчуудад номлохыг яагаад хориглосон бэ? (Мормон 1:16–17-г үз.) Хатуу сэтгэлээсээ болоод Нифайчууд өөр ямар алдагдал үзсэн бэ? (Мормон 1:13–18- ыг үз. Холдуулан аваачигдсан “хайрт шавь нар” нь Аврагчийн Хоёр Дахь Ирэлт хүртэл дэлхий дээр үлдэхийг хүссэн гурван Нифай шавь нар нь байсан гэдгийг тайлбарла; 3 Нифай 28:1–9-ийг үз.) Их Эзэн болон Түүний үйлчлэгчдийн эсрэг зүрх сэтгэлээ хатууруулбал бид ямар алдагдал үзэж болох вэ?

2. Мормон Нифайчуудын цэргийн удирдагч болдог. Нифайчууд өөрсдийн ёсон бус байдлаас болж тулаанд зовдог.

Мормон 2; 3:1–16-гаас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Мормоны амьдарч байсан цаг үед Нифайчуудын нийгэм ямар нөхцөлд байсан бэ? (Мормон 1:19; 2:1, 8, 10, 18-ыг үз.) Эдгээр нөхцөлүүд эртний бошиглогчдын үгсийг хэрхэн биелүүлсэн бэ? (Мормон 1:19; Мозая 12:4–8; Хиламан 13:5–10-ыг үз.) Бид Мормонтой адил ёсон бус байдал ихэссэн цаг үед амьдарч байгаа ч гэсэн өөрсдийн итгэл, хувийн зөв шударга байдлаа хадгалж үлдэхийн тулд юу хийж чадах вэ? (Зарим боломжийн хариултанд Алма 17:2–3; Хиламан 3:35; С ба Г 121:45–46-г үз.)
- Хүмүүсийг уйлж байхыг Мормон хараад яагаад баяр хөөр болсон бэ? (Мормон 2:10–12- ыг үз.) Түүний баяр хөөр болсон нь яагаад хий хоосон

байсан бэ? (Мормон 2:13–14-ийг үз.) “Наманчлалд . . . харуусах,” “яллагдагсдын харуусал” хоёрын ялгаа нь юу вэ? (Мөн 2 Коринт 7:9–10-ыг үз.)

- “Есүс рүү харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэйгээр” хүрч ирэх гэдэг нь ямар утгатай вэ? (Мормон 2:14; мөн 3 Нифай 9:20; С ба Г 59:8-ыг үз.)
- Мормон хүмүүсийнхээ ёсон бус байдлыг харсан ч гэсэн түүнд найдлага, амар амгаланг юу өгсөн бэ? (Мормон 2:19-ийг үз.) Өнөөдөр дэлхийн ёсон бусын дунд бид найдвар, амар амгалангаа хэрхэн хадгалж чадах вэ?
- Мормон өөрийн хүмүүсээ Лэмэнчүүдийн тулаанд ялахад “тэднийг хэлтрүүлсэн нь Их Эзэн байсан гэдгийг тэд ухаараагүй” гэж хэлсэн (Мормон 3:3). Бидний хүлээн авч байгаа адислалууд Их Эзэнээс ирж байгаа гэдгийг ойлгох нь яагаад чухал вэ? (Мормон 3:9-ийг үз.)
- 30 гаруй жил Нифайчуудын цэргийг удирдсаныхаа дараа Мормон ёсон бус байдал, цусан өшөөг эрэлхийлэх хүслээс нь болж тэднийг удирдахаас татгалзсан (Мормон 3:9–13). Их Эзэн тэдэнд цусан өшөөг бүү хай гэж зарлиглаад, Тэрээр “өшөө авалт бол минийх” юм гэж тунхаглажээ (Мормон 3:14–15). Хүмүүс өшөө авалтыг эрэлхийлснээр ямар сөрөг үр дагаварт хүрдэг вэ? Өшөө авах хүсэл зүрх сэтгэлд маань төрвөл бид үүнийг хэрхэн давж гарч чадах вэ?
- Хатуу сэтгэлтэй хүмүүст хариулт өгөх тухай бид Мормоноос юу сурч авч чадах вэ? (Мормон 3:12-ыг үз.) Бид ийм хүмүүсийг хайрлах хайраа хэрхэн илүү их хөгжүүлж чадах вэ? Хатуу сэтгэлтэй хүмүүсийн төлөө үргэлжид залбирсаар байх нь яагаад чухал вэ?

3. Мормон цэдгүүдийг эмхэтгэж, бичсэн зорилгоо тайлбарладаг.

Мормон 3:17–22; 5:8–24-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Мормон Нифайчуудын цэргийг удирдахаас татгалзсаныхаа дараа Нифайчуудын дунд болж байсан явдлыг бичсэнээр “гэрч болон зогсоно” (Мормон 3:16) гэж хэлжээ. Эдгээр шүлгүүдэд Мормон хэнд зориулж цэдгүүдээ бичсэн, тэдэнд шууд хандаж хэлсэн.

- Мормон цэдгээ хэнд зориулсан бичсэн бэ? (Мормон 3:17–19; 5:9–10, 14-ийг үз. Ангийн гишүүдийн хариуг самбарт бич.)
- Цэдгийг ямар зорилгоор хөтөлж, хадгалсан бэ? (Мормон 3:20–22; 5:14–15-ыг үз. Хариултанд дор бичигдсэн зүйлүүд орж болно.) Мормоны бичсэн зүйлс эдгээр зорилгуудыг амьдралдаа биелүүлэхэд танд хэрхэн тусалсан бэ?
 - а. “Та нар бүгд Христийн шүүлтийн суудлын өмнө зогсох ёстой . . . өөрсдийн үйлдлүүдээр шүүгдэх ёстой” (Мормон 3:20).
 - б. “Есүс Христийн сайн мэдээнд та нар итгэж болохын тул” (Мормон 3:21; мөн Мормон 5:15-ыг үз).
 - в. “Есүс бол чухамхүү Христ, мөн чухамхүү Бурхан” гэдгийг гэрчлэхийн тул (Мормон 3:21; мөн Мормон 5:14-ийг үз).
 - г. “Дэлхийн бүх хязгаарууд та нарыг наманчлахыг ятгахын” тул (Мормон 3:22).

4. Сүүлчийн агуу тулаанд Нифайчуудын 24-өөс бусад нь бүгд алуулдаг.

Мормон 4; 5:1–7; 6; Мороднай 9-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Лэмэнчүүдийн эсрэг тэмцэхэд Нифайчуудын үзсэн алдагдлын талаар тайлбар хэлэхдээ Мормон “ёсон бусыг үйлдэгчдээр ёсон бусыг үйлдэгчид нь шийтгэгддэг” (Мормон 4:5) гэжээ. Энэ нь ямар утгатай гэж та нар бодож байна вэ? Энэ нь хэрхэн тохиолддогийг та нар өнөөдрийн дэлхий дээр яаж хардаг вэ?
- Цэргийг дахин удирдахаар зөвшөөрөхдөө Мормон ямар сэтгэгдэлтэй байсан бэ? (Мормон 5:2-ыг үз.) Нифайчуудыг тулаанд хэн ялуулж болох тухай Мормон юу ойлгосон бэ? Энэ нь Нифайчууд өөрсдийгөө ялна гэж бодож байснаас хэрхэн ялгагдаж байсан бэ? (Мормон 5:1-ийг үз.)
- Шим толгойгоос Мормон ялтсуудыг яагаад авсан бэ? (Мормон 4:23; мөн Мормон 1:3–4-ийг үз.) Тэр тэдгээрийг яагаад Кумора толгойд нуусан бэ? (Мормон 6:6-г үз.) Ялтсуудыг хамгаалах нь яагаад чухал байсан бэ?
- Куморагийн дэргэд болсон сүүлчийн тулааны үр дүн нь юу байсан бэ? (Мормон 6:7–15-ыг үз.)

Мормон Нифайчуудын үндэстнүүдэд сүүлчийн үгээ хэлсэн нь зэргийг үзүүлж, ангийн гишүүнээр Мормон 6:16–22-ыг чангаар уншуул.

- Куморагийн тулааны дараа Лэмэнчүүд үлдсэн 24 Нифайчуудыг барьж, Мороднайгаас бусдыг бүгдийг нь алсан (Мормон 8:2–3). Нифайчуудын үндэстнүүд ийнхүү бүгд устгагдсан. Яагаад ийм “агуу гай гамшиг” Нифайчуудад нүүрлэсэн бэ? (Мормон 1:13, 16; 2:26–27; 3:2–3; 4:12; 5:2, 16–19; Мороднай 9:3–5, 18–20-ийг үз.)
- Бид мөн их ёсон бус байдлын дунд амьдардаг. Хувь хүний зөв шударга байдал шударга бус нийгэмд ялгааг хэрхэн бий болгож чадах вэ?

Ахлагч Нил А.Максвелл сэрэмжлүүлэхдээ: “Зөвхөн шинэчлэлт, өөрийгөө барих явдал, засаг захиргааны байгууллага, хувь хүмүүс л сая нэг нийгмийг авардаг! Нүглийн эсрэг зогсогч хангалттай тооны хүмүүс л дэлхийг өөрчилж чадна. Сүмийн гишүүдийн хувьд бид тэр нүглийг эсэргүүцэгч соёлын нэг хэсэг нь байх ёстой” гэжээ (in Conference Report, Apr. 1993, 96; or *Ensign*, May 1993, 77).

Дүгнэлт

Нифайчуудын нийгэм агуу их ёсон бус байдлаас болж устгагдсан гэдгийг онцлон тэмдэглэ. Мөн бид агуу их ёсон бус байдалтай цаг үед амьдарч байгаа ч гэсэн үүний нэг хэсэг болох ёсгүй юм. Мормоны гуйвшгүй байдал, итгэлийн жишээг дагаснаар, мөн түүний хянуур нямбай хадгалсан бичээсүүдийг суралцсанаар бид өнөөгийн өдрүүдийн хилэнцэтийн нөлөөний эсрэг зогсож эр зоригийн жишээ, бусдад найдлагыг төрүүлж чадна.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудыг хичээлдээ хэрэглэж болно.

1. Зөв шударга залуучууд

- Аммарон бичээсүүдийг Мормонд найдан орхиход Мормон хэдэн настай байсан бэ? (Мормон 1:2–4-ийг үз.) Мормон Есүс Христийг харах үедээ хэдэн настай байсан бэ? (Мормон 1:15-ыг үз.) Иосеф Смит Эцэг, Хүү хоёрын Анхны Үзэгдлийг хүлээн авахдаа 14 настай байсан бөгөөд алтан ялтсуудыг тэнгэр элч Моронайгаас хүлээн авахдаа 21-тэй байсан гэдгийг цохон тэмдэглэ.

Зөв шударга байдал ба мэргэн ухаан нь нас эсвэл бусад нөхцөл байдлуудаар хязгаарлагддаггүй гэдгийг онцлон тэмдэглэ. Их Эзэн Өөрт нь үйлчилдэг хүмүүсийг хэдэн ч насанд нь адислана.

2. Өсвөр насныханд зориулсан ярилцлага

Ангийн гишүүдэд Мормон эргэн тойронд нь байсан хүмүүс ёсон бус байсан ч гэсэн зөв шударга, итгэлтэй хэвээр үлдсэн гэдгийг сануул.

- Бид зөв шударга бус нийгмийн дарамтыг үл харгалзан хэрхэн итгэлтэй үлдэж чадах вэ?
- Эргэн тойронд маань байгаа сайн мэдээний дагуу амьдрахгүй байгаа хүмүүст бид хэрхэн тусалж чадах вэ? Мормон өөрийн эргэн тойронд байгаа зөв шударга бус хүмүүст хэрхэн хандсан бэ? (Жишээ нь, Мормон 3:12-ыг үз.) Бид бидний жишигт нийцэхгүй нөхцөлд татагдан оролгүйгээр хэрхэн хайр, нөхөрлөлөөр бусдад хүрч тусалж чадах вэ?

Зорилго

Ангийн гишүүдэд Мормон, Моронай нарын хожмын үед амьдарч байгаа хүмүүст өгсөн сэрэмжлүүлгийг ойлгоход нь туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Мормон 7. Мормон Лихайн хожмын үеийн үр удамд наманчилж, Христэд итгэн, усаар батлуулахыг уриалдаг.
 - б. Мормон 8. Моронай Мормоны Ном агуу их бусармаг явдалтай үед гарч ирнэ хэмээн бошиглодог.
 - в. Мормон 9. Моронай хожмын үеийн хүмүүсийг Христэд итгэхийг уриалдаг. Тэрээр Их Эзэн бол гайхамшгийн Бурхан хэмээн тунхагладаг.
2. Нэмж унших зүйл: Мормоны Номын эхний хуудас.
3. Та ангийн дөрвөн гишүүнтэй урьдчилан ярилцаж, дараах судрын хэсгүүдээс нэг нэгийг чангаар уншихаар бэлтгэхийг хүсэж болно: 2 Нифай 28:2–6; Мормон 9:7 Иосеф Смитийн Түүх 1:17–19, 21–22; ба Итгэлийн Тунхаг 1:7.
4. Хэрэв та анхаарал татах үйл ажиллагааг хэрэглэж байгаа бол дараах мэдээллүүдийг хичээлээ эхлэхээс өмнө самбарт бич:

“Та нар өмнө минь байгаа мэтээр би та нартай ярьж байна, гэхдээ та нар хараахан өмнө минь ирээгүй байна.”

“Есүс Христ чамайг надад үзүүлсэн бөгөөд би чиний хийж байгаа зүйлийг мэднэ.”

Хичээлийг
Баяжуулах
ЗөвлөмжАнхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Багш нар хичээлийнхээ эхэнд түүх, бодит юмс эсвэл сонирхолтой асуултуудыг хүмүүсийн анхаарлыг татах гэж хэрэглэдэг гэдгийг тайлбарла. Дараа нь та самбар дээр бичсэн мэдээллээ хэрэглэ (“Бэлтгэл,” заалт 4-ийг үз).

- Эдгээр мэдээллүүд нь яагаад бидний анхаарлыг татах ёстой вэ? (МЭ 400 оны үед, Моронай энэ мэдэгдлийг хийхдээ тэрээр шууд бидэнд хандан ярьсан. Мормон 8:35-ыг үз.)

Мормон 7–9 дээрх бүх сургаалууд нь хожмын үед амьдарч байгаа хүмүүст хандсан байдаг гэдгийг цохон тэмдэглэ. Мормон 7 нь ялангуяа Лихайн хожмын үеийн үр удамд зориулсан зөвлөгөөг агуулдаг бөгөөд Мормон 8–9 нь хожмын үеийн бүх хүмүүст зориулсан зөвлөгөөг агуулдаг.

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Мормон хожмын үеийн Лихайн үр удамыг наманчилж, Христэд итгэн, усаар батлуулахыг уриалдаг.

Лихайн хожмын үеийн үр удамд хандан хэлсэн Мормоны үгсийг агуулдаг Мормон 7-г уншаад ярилц. Та Лихайн хожмын үеийн үр удам нь Хойд, Төв, Өмнөд Америк, Номхон далайн Арлуудаас олддог гэдгийг тайлбарлаж болно.

- Ангийн гишүүнээр Мормон 7:2-ыг чангаар уншуул. Энэ сүүлчийн захиас нь Мормоны Лихайн хожмын үеийн үр удамд хэлсэн анхны захиас байсан гэдгийг цохон тэмдэглэ. Лихайн үр удам өөрсдийгөө “Израилын угсааных” гэдгээ мэдэх нь яагаад чухал вэ? Израилын угсааны зөв шударга гишүүдэд Их Эзэн ямар адислалуудыг амласан бэ? (Абрахам 2:8–11-ийг үз.)
- Лихайн хожмын үеийн үр удамд Мормон ямар зааварчилгаа өгсөн бэ? (Мормон 7:3–10-ыг мөн дор байгаа жагсаалтыг үз. Эдгээр жагсаалтын зарим заалтуудад ярилцлаганд нэмэр болох асуултууд орсон.)
 - а. Наманчилж, усаар батлуулан, Ариун Сүнсний бэлгийг хүлээн ав (Мормон 7:3, 5, 8, 10).
 - б. Бурхан өөр зүйлийг зарлиглаагүй л бол дайны зэвсгээ газарт тавьцгаа (Мормон 7:4).
 - в. Өвөг дээдсийнхээ тухай мэддэг болсон (Мормон 7:5). Лихайн хожмын үеийн үр удамд өвөг дээдсийнхээ тухай мэдэж авах нь яагаад чухал вэ? (Мормон 7:9 мөн Мормоны Номын эхний хуудсыг үз.) Өвөг дээдсийн маань дунд Бурханы хийсэн үйлсийн тухай мэдэх нь бидэнд ямар ашиг тустай вэ?
 - г. Есүс Христ болон Түүний Цагаатгалд итгэх (Мормон 7:5–7, 10).
 - д. Библи болон Мормоны Номноос сайн мэдээг судлах (Мормон 7:8–9). Библид итгэдэг хүмүүст Мормоны Ном нь хэрхэн тусалдаг вэ? (Мормон 7:9-ийг үз; мөн 1 Нифай 13:38–40; 2 Нифай 3:11–12-ыг үз.)
- Энэ үр удамд Их Эзэн хэлэхдээ “Лэмэнчүүд сарнай мэт цэцэглэнэ” гэсэн (С ба Г 49:24). Энэ бошиглол өнөөдөр хэрхэн биелж байна вэ?

2. Моронай Мормоны Ном нь агуу их бусармаг явдалтай үед гарч ирнэ гэж бошиглодог.

Мормон 8-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Энэ бүлэгт Моронай эцэг Мормоноо нас барсны дараа хамгийн анх бичсэн зүйлс нь багтдаг гэдгийг тайлбарла.

- Ангийн нэг гишүүнээр Мормон 8:1–5-ыг чангаар уншуул. Та нар эдгээр үгсийг уншихдаа сэтгэлийн ямар хөдөлгөөнийг мэдэрч байна вэ? Ганцаараа байгаагаа үл тоон хичээнгүйлэн байгаа Моронайгаас бид юу сурч болох вэ?

- Моронай Иосеф Смитийн тухай бошиглохдоо, “Энэ зүйлийг [Мормоны Ном] гэрэлд авчрах тэр нь ивээгдсэн байх болой” (Мормон 8:16; мөн шүлэг 14–15-ыг үз). Иосеф Смит Мормоны Номыг “харанхуйгаас гэрэлд” авчрахад Моронай ямар үүрэг гүйцэтгэсэн бэ? (Мормон 8:14-ийг үз; Иосеф Смитийн Түүх 1:30–35, 46, 59.) Мормоны Номыг “харанхуйгаас гэрэлд гаргаж ирэхэд” нь бид юу хийж чадах вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон хэлэхдээ: “Би дэлхийг болон амьдралаа Мормоны Номоор үерлүүлэхийг хичээж байгаа итгэлтэй Гэгээнтнүүдэд талархаж байна. Бид зөвхөн тэмдэглүүштэйгээр Мормоны Номын илүү олон хувийг түгээгээд зогсохгүй өөрсдийн амьдралдаа зоригтойгоор урагшилж, үүний гайхамшигт захиасыг дэлхий даяар түгээх ёстой” гэжээ (in Conference Report, Apr. 1989, 3; or *Ensign*, May 1989, 4).

- Ангийн гишүүнээр Мормон 8:21–22-ыг чангаар уншуул. Мормон 8:22 дээрх Моронайн үгс Их Эзэний үйл хэргийн төлөө хөдөлмөрлөхөд биднийг хэрхэн зоригжуулах вэ?
- Мормоны Номыг гарч ирэх үед дэлхий ямар нөхцөл байдалтай байх тухай Моронай юу гэж бошиглосон бэ? (Ангийн гишүүдээр Мормон 8:26–33-ын шүлгүүдийг ээлжлүүлэн уншуул. Тэднийг уншихад эдгээр шүлгүүдэд дүрслэгдсэн нөхцөлүүд өнөө үед хэрхэн нотлогдож байгаа замуудын тухай тэднээс асуу.) Моронай хожмын өдрүүдийн тухай яагаад тийм тодорхой бошиглож чадсан бэ? (Мормон 8:34–35-ыг үз.)
- Моронай хожмын өдрүүдэд байх хүмүүст “[биднийг] өмнө нь байгаа мэт” ярина гэж хэлсэн (Мормон 8:35). Дараа нь тэрээр, “Та нар өөрсдийн зүрх сэтгэлийн бардамналд алхдаг гэдгийг би мэднэ” гэжээ (Мормон 8:36). Моронай хожмын өдрүүдэд байх бардамналын тухай юу гэж хэлсэн бэ? (Мормон 8:36–41-ийг үз.)
- Хүмүүсийн гачигдалтай хүмүүст хандах байдалд бардамнал нь хэрхэн нөлөөлдөг вэ? (Мормон 8:37, 39-ийг үз.)
- Ангийн нэг гишүүнээр Мормон 8:38-ыг чангаар уншуул. Зарим хүмүүс яагаад “[өөрсдийн] дээр Христийн нэрийг авахаас ичдэг” вэ? “Төгсгөлгүй аз жаргал” нь “дэлхийн магтаалаас” илүү үнэ цэнэтэй гэдгийг санах нь бидэнд яагаад тустай вэ?
- Бардамналын тухай Моронайн бошиглолд бид хэрхэн хариу хандах ёстой вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон хэлсэн нь:

“Бардамналыг номхотгож чадах зүйл бол төлөв түвшин байдал номхон дөлгөөн байдал, хүлцэнгүй байдал юм (Алма 7:23-ыг үз). Энэ бол харууссан зүрх, гэмшсэн сэтгэл юм (3 Нифай 9:20; 12:19; С ба Г 20:37; 59:8; Дуулал 34:18; Исаиа 57:15; 66:2-ыг үз). . . .

“Бурхан даруу хүмүүсийг хүлээн авах болно. Бид даруу байхыг сонгож болно эсвэл даруу байхыг биднээс албадан шахаж болно. . . .

“Бүгдээрээ даруу байхыг сонгоцгооё” (in Conference Report, Apr. 1989, 6; or *Ensign*, May 1989, 6).

3. Моронай сүүлчийн өдрүүдийн хүмүүсийг Христэд итгэхэд уриалдаг.

Мормон 9-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Мормон 9 нь Христэд итгэдэг хожмын үеийн хүмүүст хандан хэлсэн Моронайн үгсээр эхэлдэг (Мормон 9:1). Ийм хүмүүс яагаад “Бурхантай хамт оршихдоо . . . тамд яллагдсан бодгалиудтай оршноос илүү зовлонтой байх” вэ? (Мормон 9:3–5-ыг үз.) Мормон 9:6 дээр Бурханы дэргэд оршихын тулд бид юу хийх ёстой гэж заадаг вэ? (Мөн С ба Г 121:45-ыг үз.)
- Ангийн дөрвөн гишүүнийг дараах судрын хэсгүүдийг уншихыг урь: 2 Нифай 28:2–6; Мормон 9:7; Иосеф Смитийн Түүх 1:17–19, 21–22; ба Итгэлийн Тунхаг 1:7 (“Бэлтгэл,” заалт 3-ыг үз). Эдгээр дөрвөн шүлгүүд хоорондоо ямар холбоотой вэ? Сүнсний бэлгэнд итгэдэггүй хүмүүст Моронай юу гэж хэлсэн бэ? (Мормон 9:8–10-ыг үз.)
- Бурхан гайхамшгаа үзүүлэхээ больсон гэж итгэдэг хүмүүст Моронай “би та нарт гайхамшгийн Бурханыг үзүүлнэ” гэж хэлсэн (Мормон 9:11). Тэрээр Их Эзэн бол гайхамшгийн Бурхан юм гэдгийг үзүүлэхийн тулд юу заасан бэ? (Дараагийн хуудсанд дүгнэн үзүүлсэн Мормон 9:11–17-г үз. Эдгээр сургаалууд нь авралын төлөвлөгөөг дүгнэн нэгтгэж өгдөг гэдгийг цохон тэмдэглэ.)
 - а. Тэнгэрийн бүтээлт, дэлхий, хүн төрөлхтөн (Мормон 9:11–12, 17).
 - б. Уналт (Мормон 9:12).
 - в. Есүс Христээр дамжин ирэх аврал (Мормон 9:12–13).
 - г. Бүх хүмүүсийн дахин амилалт (Мормон 9:13).
 - д. Бүх хүмүүс Их Эзэнд шүүгдэхээр эргэж очно (Мормон 9:13–14).
- Моронай Есүсийн болон Түүний Төлөөлөгчдийн үйлдсэн “олон хүчит гайхамшгийн” тухай өгүүлсэн (Мормон 9:18). Есүсийн болон Түүний Төлөөлөгчдийн гүйцэтгэсэн ямар гайхамшгууд нь та нарт урам оруулсан бэ?
- Зарим хүмүүст гайхамшиг нь ирэхээ болих шалтгаан нь юу болдог вэ? (Мормон 9:20-ийг үз.) Христэд итгэдэг хүмүүсийг ямар шинж тэмдэг дагасаар байх вэ? (Мормон 9:21–25-ыг үз.)
- Хэрэв хэн нэгэн хүн та нарт Бурхан гайхамшгийн Бурхан биш гэж хэлсэн бол та нар үүнийг яаж хүлээн авах вэ? Их Эзэн бол гайхамшгийн Бурхан мөн гэдгийг гэрчлэхийн тулд та нар ямар туршлагаасаа ярих нь зохистой вэ?
- Моронай бидэнд “бүү эргэлз, харин итгэлтэй бай” гэж уриалсан (Мормон 9:27). Энэ эрин үед Бошиглогч Иосеф Смит тунхаглахдаа, “Эргэлзээ байгаа цагт итгэл хүчгүй байдаг” гэсэн (*Lectures on Faith* [1985], 46). Эргэлзээгээ давж гарахын тулд бид юу хийж болох вэ?

Иосеф Смит заахдаа: “Нүглийн эсрэг өөрсдийн дорой байдал, сул талаа мэддэг хүмүүс хэрэв тэдний Бурхан бол онц сайн Бурхан бөгөөд тэрээр уурлах, тэвчихдээ удаан, мөн өршөөнгүй сэтгэлтэй, шударга бус явдал, гэм, нүглийг өршөөдөггүй байсан бол тэд авралынхаа талаар үргэлж эргэлзэж байх байсан. Эдгээр баримтууд нь эргэлзээг үгүй хийж, итгэлийг үлэмж хүчтэй болгодог” гэсэн (*Lectures on Faith*, 42).

Дүгнэлт

Та Мормон 9:27-г уншаагүй бол ангийн нэг гишүүнээр уншуул. Мороднай Бурханы шүүлтийн талаар сэрэмжлүүлсэн ч гэсэн тэр мөн Их Эзэнийг Цагаатгал нь “хүмүүнийг авардаг” “гайхамшгийн Бурхан” гэж гэрчилсэн гэдгийг цохон тэмдэглэ. (Мормон 9:11–12).

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

“Таны Нэгэн Адилаар Надад Хүмүүн Итгэж Байсангүй”

Хичээл
45

Ифэр 1–6

Зорилго Ангийн гишүүдэд итгэл биднийг хэрхэн Их Эзэний дэргэд мөнхөд оршуулж чадах тухай Жарэдийн ахын үзүүлсэн жишээг ойлгоход туслах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Ифэр 1. Их Эзэн Жарэдийн ахын хүсэлтийг биелүүлж, Жарэдчуудыг амлагдсан газар луу удирдана гэж амладаг.
 - б. Ифэр 2. Жарэдчууд амлагдсан газар луу аялж эхэлдэг.
 - в. Ифэр 3. Жарэдийн ах Есүс Христийг хардаг.
 - г. Ифэр 4. Моронай Харийнхныг наманчилж, итгэлээ хөгжүүлтэл нь Жарэдийн ахын бичсэн бичээсүүдийг лацаддаг.
 - д. Ифэр 6:1–12. Жарэдчууд амлагдсан газар луу аялж, тэнд хүрч очоод тэднийг энэрснийх нь төлөө Их Эзэнийг магтан дуулдаг.
2. Нэмж унших зүйл: Эхлэл 11:1–9; Мозая 8:7–11.
3. Жарэдийн Ах Их Эзэний Хурууг Харсан нь зураг байгаа бол үүнийг хичээлдээ хэрэглэхээр бэлтгэ (62478; Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 318).

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Дараах түүхийг ангийн гишүүдтэй хуваалц:

“Кортландад амьдарч байхдаа Ахлагч Рэйнолдс Кахүүн хүүтэй болжээ. Нэг өдөр Бошиглогч Иосеф Смит тэдний үүдээр өнгөрч явтал, тэрээр Бошиглогчийг дуудаж оруулаад, хүүхдийг нь адислаж, нэр өгөхийг хүсжээ. Иосеф хүсэлтийг нь ёсоор болгож, хүүд Махонри Морианкумер гэж нэр өгөв. Хүүхдийг адислаж дуусаад оронд дээр нь тавьж, Ахлагч Кахүүн руу эргэн, ‘Танай хүүд өгсөн нэр бол Жарэдийн ахын нэр юм; Их Эзэн дөнгөж сая надад үүнийг [илчиллээ]’ гэж хэлжээ. Ахлагч Уиллиам Ф.Кахүүн . . . Бошиглогч энэхүү мэдэгдлийг аавд нь хэлж байхыг сонсжээ. Энэ бол Жарэдийн ахын нэр энэхүү эрин үед Сүмд мэдэгдсэн анхны удаа байлаа” (George Reynolds, “The Jaredites,” *Juvenile Instructor*, 1 May 1892, 282).

Их Эзэн “Таны нэгэн адил хүмүүн надад итгэж байсангүй” (Ифэр 3:15) гэж хэлсэн Жарэдийн ах Махонри Морианкумерын тухай энэ хичээлд ярилцана гэдгийг тайлбарла. Бабелийн цамхгаас хойш Жарэдчууд өөрсдийн итгэлийн ачаар хэлээ хамгаалан үлдэж адислагдсан бөгөөд тэд амлагдсан газар луу аюулгүйгээр удирдуулсан. Түүний жишээ итгэлийн хүч чадлын чухал ач холбогдлын тухай бидний ойлголтыг нэмэгдүүлдэг.

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Их Эзэн Жарэдийн ахын хүсэлтийг биелүүлдэг.

Ифэр 1-ийг ярилц. Ангийн гишүүдийг сонгосон шүлгүүдийг чангаар уншихыг урь. Бошиглогч Ифэр Бабелийн цамхгийг барихаар оролдож байсан хүмүүсийн хэлийг Их Эзэн бусниулснаас болж Бабелоныг орхин явсан Жарэдчуудын бичээсийг бичсэн гэдгийг тайлбарла (Ифэр 1:33–43; мөн Эхлэл 11:1–9-ийг үз). Ифэр энэ бичээсийг Лимхайн хүмүүс хожим нь олсон 24 алтан ялтас дээр бичсэн (Мозая 8:7–11). Ифэрийн ном нь Моронайн хураангуйлсан Ифэрийн бичээсийг агуулдаг.

- Хүмүүсийг тарааж, хэлийг нь бусниулахад Жарэд ахыгаа Их Эзэн рүү очихыг хүссэн. Жарэдийн ах ямаршуухан хүн байсан бэ? (Ифэр 1:34-ийг үз.)
- Жарэдийн хүсэлтийн хариуд Жарэдийн ах “Их Эзэнээс залбиран гуйсан” (Ифэр 1:34–39). “Их Эзэнээс залбиран гуйх” ба зүгээр залбирал хэлэх хоёрын ялгаа нь юу вэ? Залбирлаа илүү үр дүнтэй болгохын тулд бид юу хийж болох вэ? (Алма 34:17–28-ыг үз.)
- Жарэдийн ахыг залбирах бүрт Их Эзэн түүнийг болон түүний хүмүүсийг “өрөвдөн хайрласан” (Ифэр 1:35, 37, 40). Та нарын залбирлын хариуд Их Эзэний өрөвдөн хайрлахыг хэрхэн мэдэрч байсан бэ?
- Их Эзэн хүмүүсийг ямар бэлтгэл хий гэж зааварчилсан бэ? (Ифэр 1:41–42-ыг үз.) Жарэдчуудыг амлагдсан газар луу удирдахаар амласан шалтгаан нь юу вэ? (Ифэр 1:43-ыг үз. Их Эзэний үгсийг анхаар: “Та ийм удаан хугацаагаар надаас залбиран гуйсан.”) Энэ жишээнээс бид залбирлын хүчний тухай юу сурч авч болох вэ?

2. Жарэдчууд амлагдсан газар луу аялж эхэлдэг.

Ифэр 2-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Их Эзэн Жарэдчуудыг “бусад нутгуудаас сонгомол болох тэр, амлалтын нутаг” (Ифэр 2:7) руу удирдахаар амласан. Их Эзэн тэр сонгомол газрыг хэнд зориулж хадгалсан бэ? (Ифэр 2:7-г үз.) Их Эзэн Жарэдийн ахад амлагдсан газрын тухай ямар сэрэмжлүүлэг өгсөн бэ? (Ифэр 2:8-ыг үз.)
- Амлагдсан газрын тухай Бурханы тогтоолын тухай Моронай юу гэж хэлсэн бэ? (Ифэр 2:9–12-ыг үз. Сэрэмжлүүлэг, амлалт нь зөвхөн Жарэдчуудад бус Америкт орших бүх хүмүүст зориулагдсан гэдгийг цохон тэмдэглэ.)
- Далайн эрэг дээр ирээд Жарэдчууд майхнаа босгож, тэндээ дөрвөн жилийн турш үлдсэн (Ифэр 2:13). Дөрвөн жилийн төгсгөлд Их Эзэн Жарэдийн ахтай ярьсан. Их Эзэн түүнийг яагаад зэмлэсэн бэ? (Ифэр 2:14-ийг үз.) Бид заримдаа яагаад Их Эзэнийг дуудахаасаа хойш суудаг вэ?
- Жарэдийн ах наманчилж, далайг гатлах хөлгүүд хийж эхэлсэн (Ифэр 2:15–17). Хөлгүүдийг барьж дууссаны дараа Жарэдийн ахад ямар асуудлууд тулгарсан бэ? (Ифэр 2:19-ийг үз.) Хөлгүүд дотор амьсгалах агаар оруулахын тулд Жарэдийн ахыг юу хий гэж Их эзэн зааварласан бэ? (Ифэр 2:20-ийг үз.)

- Хөлгүүдийг хэрхэн гэрэлтэй болгох тухай Жарэдийн ахыг асуухад Их Эзэн түүнд юу гэж хариулсан бэ? (Ифэр 2:23–25-ыг үз.) Бид Их Эзэний хариултаас юу сурч болох вэ? (Дор байгаа ишлэлийг үз.) Их Эзэний тусламжийг хүсэхийн зэрэгцээгээр өөрийн чадах бүхнээ хийх нь яагаад чухал вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли үргэлж “Би ямар нэгэн зүйлийг өвдөг дээрээ сөгдөн, тусламж гуйж, дараа нь хөл дээрээ зогсон ажилдаа явахаас өөрөөр яаж хийхийг мэдэхгүй юм” гэж хэлдгийг үе үе сонсдог байснаа Ахлагч Рассел М.Нэлсон хэлж байна (in Conference Report, Oct. 1997, 18; or *Ensign*, Nov. 1997, 16).

- Хөлгүүдийг гэрэлтэй болгох сорилт Жарэдийн ахыг өсч хөгжихөд хэрхэн тусалсан гэж та нар бодож байна вэ? Сорилтууд нь бидний амьдралд хэрхэн тусалдаг вэ?

3. Жарэдийн ах Есүс Христийг хардаг.

Ифэр 3-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Жарэдийн ах хөлгүүдийг гэрэлтэй болгох асуудлыг шийдвэрлэхдээ хэрхэн хандсан бэ? (Ифэр 3:1–5-ыг үз.) Энэ нь түүний төлөв түвшин байдал, итгэлийг хэрхэн харуулсан бэ? (Та ангийн гишүүдээр Жарэдийн ахын төлөв түвшин байдал, итгэлийг харуулсан үгс, хэллэгийг тодорхойлуулж болно.)
- Жарэдийн ахыг ярьж дуусахад Их эзэн чулуунуудад нэг нэгээр нь хуруугаараа хүрсэн (Ифэр 3:6). Их Эзэний хурууг хараад Жарэдийн ах яагаад ихэд айсан бэ? (Ифэр 3:6–8-ыг үз. Жарэдийн ах Их Эзэний хурууг харж байгаа зургийг та хэрэглэж байгаа бол үүнийг одоо үзүүл.) Жарэдийн ахын итгэлийн тухай Их Эзэн юу гэж хэлсэн бэ? (Ифэр 3:9-ийг үз.)
- Их Эзэн Жарэдийн ахад Өөрийгөө үзүүлэхээс өмнө түүнд ямар асуулт тавьсан бэ? (Ифэр 3:11-ийг үз.) Жарэдийн ахын хариулт түүний итгэл хэр гүн гэдгийг хэрхэн харуулсан бэ? (Ифэр 3:12-ыг үз. Тэр Их Эзэний үгсийг бүр сонсохоосоо өмнө хүлээн зөвшөөрсөн.) Бид түүний жишээг дагахын тулд юу хийж чадах вэ?
- Их Эзэн Өөрийгөө Жарэдийн ахад хэрхэн дүрсэлсэн бэ? (Ифэр 3:13–14-ийг үз. Та ангийн нэг гишүүнээр эдгээр шүлгүүдийг чангаар уншуулж болно.) Их Эзэний дэргэд байхад Жарэдийн ахад юу шаадлагатай байсан бэ? Их Эзэний дэргэд мөнхөд байхын тулд бидэнд юу шаардлагатай вэ?
- Их Эзэн Жарэдийн ахад юу үзүүлсэн бэ? (Ифэр 3:15–18, 25–26-г үз.) Их Эзэн Жарэдийн ахад эдгээр зүйлүүдийг харсныхаа дараа юу хий гэж зааварласан бэ? (Ифэр 3:21–24, 27–28; 4:1-ийг үз.)

4. Моронай Жарэдийн ахын бичээсүүдийг лацаддаг.

Ифэр 4-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Жарэдийн ахын үзсэн үзэгдлийг Моронай хэрхэн дүрсэлсэн бэ? (Ифэр 4:4-ийг үз.) Их Эзэн Моронайд Жарэдийн ахын бичээс болон хөрвүүлэн бичигчдийг яахыг зарлигласан бэ? (Ифэр 4:3, 5-ыг үз.) Бид эдгээр бичээсүүдийг хэзээ авах боломжтой болох вэ? (Ифэр 4:6–7-г үз. Бид Жарэдийн ахтай адил итгэлтэй болж, ариусгагдсан үедээ тэдгээрийг хүлээн авна.)

- Их Эзэн өөрийнх нь үгсийг сүүлчийн өдөр үгүйсгэдэг хүмүүсийн тухай юу заасан бэ? (Ифэр 4:8, 10, 12-ыг үз.) Их Эзэний үгст итгэдэг хүмүүст ямар адислалууд ирэх вэ? (Ифэр 4:11-ийг үз.) Их эзэний үгс үнэн гэдгийг Ариун Сүнс та нарт ямар замуудаар мэдүүлдэг вэ?
- Их Эзэн Харийнхан болон Израилын угсааг Түүнд ирж, агуу адислалууд болон мэдлэгийг хүлээн ав гэж уриалсан (Ифэр 4:13–14). Тэрээр бид Түүнд очихын тулд юу хийх ёстой гэж хэлсэн бэ? (Ифэр 4:15, 18-ыг үз.) Эдгээр зүйлсийг хийдэг хүмүүст тэр ямар адислалуудыг амласан бэ? (Ифэр 4:15–19-ийг үз.)

5. Жарэдчууд амлагдсан газар луу аялдаг.

Ифэр 6:1–12-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Эдгээр шүлгүүд нь Жарэдчууд амлагдсан газар луу аялсан бичээсийг үргэлжлүүлдэг гэдгийг тайлбарла. Жарэдчуудын амлагдсан газар луу аялсан аяллыг бид амьдрал дундуур аялдагтай хэрхэн адилтгаж болох тухай ярилц.

- Их Эзэн хөлгүүдийн доторх чулуунуудыг “харанхүйд гэрэлтэн, эрчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүдэд . . . гэрэл өгөх” болгосон (Ифэр 6:3). Амьдрал дундуур биднийг аялахад Их Эзэн бидэнд ямар “гэрлийг” өгдөг вэ?
- Жарэдчууд аялалд бэлтгэж чадах бүхнээ бэлтгэсний дараа юу хийсэн бэ? (Ифэр 6:4-ийг үз. Тэд өөрсдийгөө Их Эзэнд итгэн тушаасан.) Бид үүнтэй адил итгэлийг Их Эзэнд хэрхэн үзүүлж чадах вэ?
- Салхи үлээн, Жарэдчуудыг урагш удирдахад Жарэдчууд өдөр, шөнийн туршид юу хийж байсан бэ? (Ифэр 6:8–9-ийг үз.) Бид Их Эзэнийг магтан дуулах ямар арга замууд байдаг вэ?
- Жарэдчууд амлагдсан газарт ирээд юу хийсэн бэ? (Ифэр 6:12-ыг үз.) Энэ нь бид Тэнгэр дэх Эцэгтээ эргэж очихтой ямар байдлаараа төстэй вэ?

Дүгнэлт

Ахлагч Жэффри Р.Холландын дараах мэдэгдлийг унш:

“Жарэдийн ах өөртөө нэг их итгэдэггүй байсан байж болох хэдий ч түүний Бурханд итгэх итгэл урьд өмнө нь тохиолдож байгаагүй зүйл байсан. Үүнээс үзэхэд бидэнд бүгдэд маань найдлага байгаа. Түүний итгэл нь эргэлзээгүй ба хязгааргүй байсан. . . . Ердийн сорилтуудтай ердийн хүмүүс үл итгэх байдлын хөшгийг урж хаян, мөнхийн улсад орж болно гэдгийг нэгэнтээ тунхагласан билээ” (*Christ and the New Covenant* [1997], 29).

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэ санааг хичээлдээ хэрэглэж болно.

Ифэр 5 дээрх сургаалууд

- Ифэр 5 нь хэнд зориулагдсан бэ? (Иосеф Смитэд.) Ифэр 5:3 дээр Моронайн дурьдсан гурван гэрч нь хэн байсан бэ? (Оливэр Коудри, Давид Уитмер, Мартин Харрис. Мормоны Номын удиртгал материалуудаас Гурван Гэрчийн Гэрчлэлийг үз.) Гурван Гэрчийн Гэрчлэл нь Мормоны Номын тухай та нарын гэрчлэлийг бэхжүүлэхэд хэрхэн тусалсан бэ?

“Итгэлээр Бүх л Зүйлс Гүйцэлддэг”

Хичээл
46

Ифэр 7–15

Зорилго Ангийн гишүүдэд итгэлээ хөгжүүлж, даруу байж, бошиглогчдын зөвлөгөөг сонсохын чухлыг ойлгоход туслах болно.

Бэлтгэл Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:

- Ифэр 12:1–22. Моронай итгэлийн чухал ач холбогдлын тухай тайлбарлаж, итгэлийн хүчний жишээ татдаг.
- Ифэр 12:23–41. Их Эзэн Моронайд тэрээр биднийг даруу байлгахын тулд бидэнд сул дорой байдлыг өгдөг гэж заадаг. Моронай “бошиглогчид мөн төлөөлөгчдийн тухайлан бичсэн тэрхүү Есүсийг эрэлхийлэхийг” бидэнд санал болгодог.
- Ифэр 13:1–12. Моронай амлагдсан газрын тухай Ифэрийн бошиглолыг бичдэг.
- Ифэр 13:13–15:34. Жарэдчуудын соёл иргэншил сөнөх тухай Ифэрийн бичсэн зүйлийг Моронай бичдэг.

**Хичээлийг
Баяжуулах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Ангийн гишүүдээр Мозая 8:8–9, 12, 19; 28:17–19-ийг уншуул.

- Энд ямар бичээсийн тухай өгүүлсэн бэ? (Ифэрийн номонд Моронайн хураангуйлан оруулсан Жарэдчуудын бичээс.) Энэ бичээсийн тухай сонссон нь Мозаягийн хүмүүст ямар нөлөө үзүүлсэн бэ? Энэ түүхийг унших нь бидэнд яагаад чухал гэж та нар бодож байна вэ?

Энэ хичээлд амлагдсан газарт хүрч ирснээс нь эхлээд олон үеийн дараа бүрэн устах хүртэлх Жарэдчуудын түүхийн тухай ярилцдаг гэдгийг тайлбарла. Тэдний утсан явдал нь эмгэнэлтэй хэдий ч Мозаягийн хүмүүсийн адилаар бид энэхүү бичээсийн бидэнд мэдүүлдэг зүйлст баясаж болно.

Судрын Ярилцлага
ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Моронай итгэлийн чухал ач холбогдлын тухай тайлбарладаг.

Амлагдсан газарт хүрч ирснийхээ дараа Жарэдчууд “үржиж . . . мөн нутагтаа . . . хүчирхэгжиж” (Ифэр 6:18) эхэлсэн гэдгийг тайлбарла. Жарэд болон

түүний ахыг нас барахад хүмүүсийг нь удирдах хааныг сонгосон (Ифэр 6:21–30). Ифэр 7–11 дээр зөв шударга ба бусармаг хаадын үе залгамжилсан байдал, нууц явуулга хүмүүсийн дунд бий болж, Жарэдчуудад наманчлахыг номлохоор дуудагдсан бошиглогчдын сургаалуудын тухай бичсэн байдаг (Ифэр 7–11-ийн тухай илүү ярилцахад зориулсан нэг ба хоёрдугаар заах нэмэлт санаануудыг үз). Ифэр 12 нь эдгээр бошиглогчдын нэг байсан Ифэрийн сургаалуудын тухай өгүүлж эхэлдэг.

Ифэр 12:1–22-оос сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Ифэр “итгэлээр бүх зүйлс гүйцэлддэг” (Ифэр 12:3) хүмүүсийг Бурханд итгэхийг уриалсан. Ифэр Бурханд итгэдэг хүмүүсийг хэрхэн дүрсэлсэн бэ? (Ифэр 12:4-ийг үз.) Итгэл, найдвар хоёр нь бидэнд хэрхэн зангуу болдог вэ? Итгэл нь Бурханыг алдаршуулах сайн үйлс рүү удирддаг ямар жишээ байдаг вэ?
- Ифэр хүмүүст “агуу хийгээд гайхамшигт зүйлүүдийн” тухай бошиглосон боловч тэд түүнд итгээгүй. Яагаад тэр вэ? (Ифэр 12:5-ыг үз.)

Ангийн гишүүдээс тэд эсвэл бусад хүмүүс зөвлөгөөний учир шалтгааныг нь “харж” эсвэл ойлгож чадаагүй ч гэсэн бошиглогчдын зөвлөгөөг дагаснаар адислагдаж байсан үеүдийн тухай бодохыг хүс. Зохимжтой жишээнүүдээ хуваалцахыг тэднээс урь.

- Хүмүүс Ифэрийн бошиглоуудыг харж чадахгүй байгаа учир итгээгүйг Моронай бичжээ. Дараа нь Моронай итгэлийн тухай тодорхойлж, үүнийг жишээгээр харуулсан. Тэр итгэлийг яаж тодорхойлсон бэ? (Ифэр 12:6-г үз; мөн Еврей 11:1; Алма 32:21-ийг үз.) Бид “[өөрсдийн] итгэлийн сорилтын дарааг хүртэл гэрчийг үл хүлээн авах болой” гэдэг нь ямар утгатай гэж та нар бодож байна вэ? (Ифэр 12:6; мөн Ифэр 12:29–31; С ба Г 58:2–4-ийг үз). Сорилт нь ямар замаар та нарын итгэлийг батжуулж, бататгасан бэ?
- Итгэлийн үр дүнд тохиолдсон хэд хэдэн үйл явдлыг Моронай бичжээ. Тэр ямар үйл явдлуудын тухай бичсэн бэ? (Ифэр 12:7–22-ыг үз. Ангийн гишүүдийн хариултуудыг самбарт бич. Мөн эдгээр шүлгүүдэд *итгэл* гэдэг үг гарах бүрт тэмдэглэгээ хийхийг ангийн гишүүдэд зөвлө.) Судраас өөр ямар жишээнүүд та нарт итгэлийн хүчийг харуулсан бэ?
- Бошиглогч Иосеф Смит заахдаа, “Бид хүлээн авч байдаг эд материалын адислалуудаа итгэлээрээ хүлээн авдагтай адилаар бүх сүнслэг адислалуудаа итгэлээрээ хүлээн авч байдаг” гэжээ (*Lectures on Faith* [1985], 3). Итгэлээсээ болж та нар ямар адислалуудыг хүлээн авч байсан бэ? (Та ангийн гишүүдээс энэ асуултанд чангаар хариулахын оронд дотроо бодохыг хүсэж болно.)

2. Их Эзэн Моронайд тэрээр биднийг даруу байлгахын тулд бидэнд сул дорой байдлыг өгдөг гэж заадаг.

Ифэр 12:23–41-ээс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Харийнхан түүний бичээсийг хэрхэн хүлээж авах талаар Моронай юунд эргэлзэж байсан бэ? (Ифэр 12:23–25-ыг үз.) Их Эзэний хариулт юу байсан бэ? (Ифэр 12:26-г үз.) Моронайн үгсийг мөн бүх судруудыг даруухнаар унших нь яагаад чухал вэ?

Ангийн нэг гишүүнээр Ифэр 12:27-г чангаар уншуул. Ангийн гишүүдийн анхаарлыг өөрсдийгөө даруу болгож, Түүнд итгэдэг хүмүүст өгсөн Их Эзэний амлалтанд хандуул. (“Тэгвэл би тэдэнд сул дорой зүйлүүдийг нь хүчирхэг болгож өгнө.”) Судар дахь энэ амлалт амьдралд нь эсвэл бусдын амьдралд биелж байсан жишээг бодохыг ангийн гишүүдээс хүс. Тэднийг эдгээр жишээнүүдийн заримыг нь хуваалцахад урь.

- Моронай итгэл, найдвар, энэрлийн чухал ач холбогдлын тухай бичсэн (Ифэр 12:28–34). Эдгээр чанарууд нь биднийг Христэд хэрхэн хүргэдэг вэ?
- Моронай бидэнд “бошиглогчид мөн төлөөлөгчдийн тухайлан бичиглэсэн тэрхүү Есүсийг эрэлхийл” (Ифэр 12:41) гэж уриалсан. Бид өнөөдөр “Есүсийг эрэлхийлэхдээ” ямар замаар хайж болох вэ? Үүнийг хийдэг хүмүүст Их Эзэн юу амладаг вэ? (Ифэр 12:41-ийг үз.) Бидэнд Бурхан болон Түүний Хүүгийн ач ивээл яагаад хэрэгтэй вэ?

3. Моронай амлагдсан газрын тухай Ифэрийн бошиглолыг бичдэг.

Ифэр 13:1–12-ыг уншаад ярилц.

- Ифэр Шинэ ба Хуучин Ерусалимын тухай юу гэж бошиглосон бэ? (Ангийн гишүүдээр Ифэр 13:2–12-ыг уншуулж энэ асуултанд хариу олуул; мөн дор байгааг үз.)
 - а. (“Лихайн тэндээс [ирсэн]”) хуучин Ерусалим “Их Эзэний тул ариун хот болон дахин баригдах” билээ (Ифэр 13:5). Үүнийг Хоёр дахь ирэлтийн өмнө Жүүдүүдийн үр сад хийх болно.
 - б. Хоёр дахь Ирэлтээс өмнө “шинэ Ерусалим энэ нутагт [Америкт] . . . баригдах” болно (Ифэр 13:6). Шинэ Ерусалимыг Иосефын угсааны үлдэгдэл ариун хот болгон барина (Ифэр 13:8).
 - в. Инохын Хот тэнгэрээс буун ирж, Шинэ Ерусалимын нэг хэсэг болно (Ифэр 13:3, 10; мөн Илчлэлт 21:2, 10-ыг үз). Энэ нь хоёр дахь ирэлтийн дараа болно.
- Ариун хотуудад амьдрах зохистой хүмүүсийг Моронай хэрхэн дүрсэлсэн бэ? (Ифэр 13:10–11-ийг үз.) “Хурганы цусанд угаагдсан” гэдэг нь ямар утгатай вэ? (Есүс христийн Цагаатгалаар дамжуулан нүглээсээ цэвэрлэгдэх.)

4. Газар нутаг даяар дайн болдог. Жарэдчуудын соёл иргэншил мөхдөг.

Ифэр 13:13–15:34-өөс сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Хүмүүс Ифэрийг гаргаж хаясан бөгөөд тэр бичээсийнхээ үлдсэн хэсгийг хадан агуйд нуугдаж байхдаа бичсэн гэдгийг тайлбарла (Ифэр 13:13–14). Хүмүүс удалгүй дайн дажин, нууц явуулгад автсан.

- Ифэрийн хадан агуйд амьдарч байсан хоёр дахь жилд Их Эзэний үг түүн дээр ирсэн. Их Эзэн түүнд юу хийхийг зааварласан бэ? (Ифэр 13:20–21-ийг үз.) Ифэрийн бошиглолын хариуд Кориантумр юу гэж хариулсан бэ? (Ифэр 13:22-ыг үз.)

Ифэр 13:23–15:28-д өөр өөр бүлгүүд хүч чадлыг олохоор эрэлхийлэн үргэлжлүүлэн цус урсгасан тухай дүрсэлдэг гэдгийг тайлбарла. Тулаанд мянга мянган Жарэдчууд алуулсан. Кориантумр олон тулаанд ялагдаж, хэд хэдэн удаа шархадсан ч гэсэн үхээгүй. Бичээсийн төгсгөл хавьд Кориантумр,

Шиз хоёр сүүлчийн тулаанд орохоор бүх хүмүүсээ цуглуулсан. Хэдэн өдөр тулалдсаны дараа зөвхөн Кориантумр, Шиз хоёр л амьд үлдсэн.

- Тулаан эцэст нь яаж төгссөн бэ? (Ифэр 15:29–32-ыг үз.) Энэ нь Ифэрийн бошиглолын биелэлт хэрхэн болсон бэ? (Ифэр 13:20–21-ийг үз.)
- Нүгэлд гүн орохоосоо өмнө наманчлахын чухлын тухай Жарэдчуудын бичээсээс бид юу сурч болох вэ? (Ифэр 15:1–5, 18–19; мөн Хиламан 13:32–33, 38-ыг үз.) Нүгэл үйлдэх нь бидний чөлөөт сонголтыг хэрхэн хязгаарладаг вэ?
- Нифайчуудын түүх, Жарэдчуудын түүх хоёрын адил төстэй талууд нь юу вэ? Эдгээр соёл иргэншлүүдийн түүхээс бид юу сурч болох вэ?

Дүгнэлт

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

**Заах Нэмэлт
Санаанууд**

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та эдгээр санаануудаас нэг буюу түүнээс дээшийг хичээлдээ хэрэглэж болно.

1. Бошиглогчдыг дагахын чухал ач холбогдол

Жарэдчуудын түүх нь дараах загварын тухай олон олон жишээг харуулдаг гэдгийг цохон тэмдэглэ:

- а. Хүмүүс ёсон бус болдог.
- б. Бошиглогчид хүмүүсийг наманчлалд дууддаг.
- в. Бошиглогчдыг хүлээн зөвшөөрдөг хүмүүс адислагдаж, харин бошиглогчдыг эсэргүүцсэн нь өөрсдийн бусармаг явдлын үр дагавраар зовж эхэлдэг.
- г. Үр дагаврын хариуд хүмүүс наманчилж, бошиглогчдыг дагадаг буюу зарим нь бусармаг явдлаа үргэлжлүүлж, сүйрэл рүүгээ явдаг.

Та энэ загварын жишээнүүдийг Ифэр 7:23–27; 9:23–35; 11:1–8, 11–14, 19–23-аас уншаад ярилцаж болно.

2. Моронай нууц явуулгаас сэрэмжлүүлдэг

Жарэд болон түүний ахыг нас барсны дараа хаад үе залгамжлан хүмүүсийг удирдах болсон. Үе удам өнгөрөх тусам хаан ширээний төлөөх маргаан улам ихэссэн. Маргаан ихсэхийн зэрэгцээгээр Жарэдийн охин өөрийн эцгээ хаан болгох төлөвлөгөө зохиосон. (Ифэр 8:8; ангийн гишүүдэд энэ түүхэнд гарсан Жарэд гэдэг нэртэй хүн Ифэр 1–6 дээр гарсан Жарэдийн үр сад байсан гэдгийг сануул).

- Эцгийгээ хаан болгохын тулд Жарэдийн охин ямар төлөвлөгөө зохиосон бэ? (Ифэр 8:9–12-ыг үз.) Энэ төлөвлөгөө нь нууц явуулгыг тэдний нутагт хэрхэн анхлан тавьсан бэ? (Ифэр 8:13–18-ыг үз.)
- Моронай нууц явуулгын аюулын талаар юу гэж заасан бэ? (Ифэр 8:21–22-ыг үз.) Тэр эдгээр зүйлүүдийг өөрийн бичээстээ яагаад оруулсан бэ? (Ифэр 8:23, 26-г үз.) Бид нууц явуулгыг хэрхэн таньж мэдэж, үүнээс өөрсдийгөө хамгаалж чадах вэ? (Ифэр 8:23–25-ыг үз.)

**3. “Та өөрийн сул доройг харсны учир . . . хүчирхэг болгогдох болно”
(Ифэр 12:37)**

- Хайрум Смит Бошиглогч Иосеф Смитийн алуулсан Заргажийн Шорон руу явахаар бэлтгэж байхдаа Ифэр 12:36–38-ыг уншиж, хуудсыг нь нугалж орхижээ (С ба Г 135:4–5). Эдгээр шүлгүүд ямар тайтгарлыг өгдөг вэ? Судрын ямар хэсгүүд та нарыг бэхжүүлж эсвэл тайтгаруулдаг вэ?

Зорилго

Ангийн гишүүдийн сайн мэдээний ёслолуудын тухай ойлголтыг мөн нэг нэгнийгээ батжуулах хэрэгцээг нэмэгдүүлэх болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Моронай 1. Нифайчуудын устгалыг туулж гарсныхаа дараа Моронай бичээсээ үргэлжлүүлэн бичдэг. Тэр “Христийг эсэргүүцэхгүй тул” нуугдсан хэвээр үлдэх ёстой.
 - б. Моронай 2–5. Моронай сайн мэдээний чухал ёслолуудын тухай заадаг.
 - в. Моронай 6. Моронай Сүмийн гишүүн байхад шаардагддаг зүйлүүд мөн бичээсийг бичиж хадгалах болон нөхөрлөхийн хэрэгцээний тухай тайлбарладаг.

Хичээлийг Баяжуулах Зөвлөмж

Анхаарал Татах Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Ангийн гишүүдээс өөрсдийнхөөсөө өөр хэсэг эсвэл салбарын ариун ёслолын цуглаанд хамгийн сүүлд оролцсон тухайгаа бодохыг хүс.

- Сүмд хаана ч явлаа гэсэн ариун ёслолын цуглааны ямар зүйлүүд нь адилхан байдаг вэ? (Хариултанд залбирах, дуулуудыг дуулах, ариун ёслолыг адислаж, хүртэх, шинэ хөрвөгдөгсдөд Ариун Сүнсний бэлгийг хүртээх болон Есүс Христийн нэр дээр гэрчлэлээ болон яриагаа төгсгөх зэрэг нь орж болно.) Бид эдгээр зүйлүүдээрээ нэгдмэл байх нь яагаад чухал гэж та нар бодож байна вэ?

Энэ хичээлд Ариун Сүнсний бэлгийг хүртээх, пристүүд болон багш нарыг томилох, ариун ёслолыг гүйцэтгэх, усаар батлах зэрэг өнөө үед дахин сэргээгдсэн Сүмийн нэг хэсэг болсон сайн мэдээний зарим ёслолуудын тухай Моронайн заасан зүйлүүдийн талаар ярилцдаг гэдгийг тайлбарла. Түүний сургаалууд нь Аврагч эрт үед байгуулсан Сүмд хийдэг байсантай адил ёслолуудыг өнөөдөр ч хийсээр байгааг харахад бидэнд тусалдаг. Эдгээр нь мөн Сүмийн гишүүдийн хувьд “[биднийг] зөв замд байлгахын тулд” (Моронай 6:4; мөн 2 Нифай 25:28–29-ийг үз) нэг нэгнийгээ батжуулах үүрэг хариуцлагаа биелүүлэхэд тусалдаг.

Судрын Ярилцлага ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Нифайчуудын устгалыг туулж гарсныхаа дараа Моронай бичээсээ үргэлжлүүлэн бичдэг.

Моронай 1-ийг уншаад ярилц. Моронай Ифэрийн бичээсийг хураангуйлж бичсэн нь түүний сүүлчийн бичээс байна гэдэгт итгэж байсан гэдгийг тайлбарла. Хэдий тийм ч тэрээр хараахан амь үрэгдээгүй байсан болохоор бичсээр л байсан.

- Ангийн нэг гишүүнээс Моронай 1:1–4-ийг чангаар уншихыг хүс. Моронай өөрийн номын бүлгүүдийг ямар нөхцөл байдалд бичсэн бэ? (Моронай 1:1-ийг үз. Тэр ганцаараа Лэмэнчүүдээс нуугдаж байсан.) Лэмэнчүүд түүнийг яагаад алчих байсан бэ? (Моронай 1:2–3-ыг үз.) Энэ нь бидэнд Моронайн итгэлийн тухай юуг харуулдаг вэ? Бид Есүс Христэд итгэх итгэлээ хэрхэн ийм бат бэх хөгжүүлж чадах вэ?
- Моронай яагаад үргэлжлүүлэн бичсээр байсан бэ? (Моронай 1:4-ийг үз. Тэр үеийн Лэмэнчүүд Моронайн амийг хөнөөчихөж болох байсан ч гэсэн тэрээр үе удмынхаа төлөө сэтгэл зовж байсан.)

2. Моронай сайн мэдээний чухал ёслолуудын тухай заадаг.

Моронай 2–5-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Мормоны Ном нь бидэнд сайн мэдээний ёслолуудын чухал ач холбогдлын тухай заадаг гэдгийг тайлбарла. Хэдий тийм ч Моронайн номыг хүртэл ёслолуудыг хэрхэн гүйцэтгэх талаар харьцангуй бага зүйлийг бичсэн байдаг. Эртний Сүмд ёслолуудыг хэрхэн гүйцэтгэдэг байсныг ойлгох явдлыг маань Моронай хэрхэн нэмэгдүүлдэг тухай ярилц.

Ангийн нэг гишүүнийг Аврагч Өөрийн шавь нар Нифайчуудын дээр гараа тавьж байгаад хэлсэн үгсийг тайлбарласан Моронай 2-ыг чангаар уншихыг урь. Самбарт *Ариун Сүнсний Бэлгийг Хүртээх* гэж гарчиг тавь.

- Аврагч Ариун Сүнсний бэлгийг хэрхэн хүртээх тухай шавь нартаа юу гэж зааварласан бэ? (Моронай 2:2-ыг үз. Самбарт байгаа гарчгийн дор *Есүс Христийн нэр дээр гар тавьснаар* гэж бич.)

Ангийн нэг гишүүнийг шавь нар нь пристүүд, багш нарыг хэрхэн томилсон тухай дүрсэлдэг Моронай 3-ыг чангаар уншихыг урь. Самбарт *Пристүүд, Багш нарыг Томилох* гэж гарчиг тавь.

- Пристүүд болон багш нар юу хийхээр томилогддог байсан бэ? (Моронай 3:3-ыг үз. Хоёр дахь гарчгийн дор *Наманчлалыг болон нүглийн өршөөлийг номлох* гэж бич.) Эдгээр үүргүүд нь өнөөдрийн пристийн зэрэгтнүүдийн үүрэгтэй хэрхэн төстэй байдаг вэ? (С ба Г 20:46–59-ийг үз.) Бид Аароны Пристийн Зэрэгтнүүдэд өөрсдийн томилогдсон үүргээ ойлгож, биелүүлэхэд хэрхэн тусалж чадах вэ?

Ангийн хоёр гишүүнээс ариун ёслолыг гүйцэтгэх байдлын тухай дүрсэлдэг Моронай 4 ба 5-ыг чангаар уншихыг урь. Самбарт *Ариун Ёслолыг Гүйцэтгэх* гэж гарчиг тавь.

- Бид ариун ёслолоор дамжуулан ямар гэрээг хийдэг вэ? (Моронай 4:3; 5:2-ыг үз. Гурав дахь гарчгийн дор *Аврагчийг дурсан санаж, дагаж, дуулгавартай дагах* гэж бич.) Бид хариуд нь юу гэж амладаг вэ? Та нар ариун ёслолоос бишрэнгүй мөн зохистойгоор хүртээд ямар сэтгэгдэлтэй байдаг вэ?

- 2–5-р бүлгүүд бидний үед яагаад чухал вэ? (Хариултанд, эдгээр нь сайн мэдээний ёслолуудын өөр өөр цаг үед тогтвортой нэгэн хэвийн байгааг харахад тусалдаг нь орж болно.) Их Эзэний Сүмийн өөр өөр эрин үед адил ёслолууд байсаар байгааг харах нь таныг хэрхэн батжуулдаг вэ?

3. Моронай Сүмийн гишүүн байхад шаардагддаг зүйлүүд мөн бичээсийг бичиж хадгалах болон нөхөрлөхийн хэрэгцээний тухай тайлбарладаг.

Моронай 6-г уншаад ярилц.

- Усан баталгаа хийлгэхэд шаардагддаг зүйлүүдийн тухай Моронай юу заасан бэ? (Моронай 6:1–3-ыг үз.)

Ангийн гишүүдээс усаар батлуулсныхаа дараа эдгээр шаардлагуудыг үргэлжлүүлэн биелүүлсээр байсан хүмүүсийн жишээг бодохыг хүс. Эдгээр жишээнүүдээ зохистойгоор хуваалцахыг тэд нараас урь.

- Хүмүүс усаар батлуулж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсныхаа дараа “Христийн сүмийн хүмүүсийн дунд тоологдсон; мөн . . . тэдний нэрс нь тэмдэглэгдсэн байв” (Моронай 6:4) гэж Моронай заасан. Тэдний нэрс яагаад тэмдэглэгдсэн байсан бэ? (Моронай 6:4-ийг үз.) Урт хугацааны туршид гишүүн байсан мөн шинэхэн гишүүн хүмүүсийг “Бурханы сайн үгээр дурсагдан мөн тэжээгдэхийг” харж байх үүргийг хэн хүлээсэн байдаг вэ? (Бидний хүн нэг бүрт энэ боломж бий гэдгийг онцлон тэмдэглэ. Дараа нь дор байгаа ишлэлийг хуваалц.)

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли заахдаа: “Итгэл нь хөрч байгаа ямар ч хөрвөгдөгч нь эмгэнэлтэй юм. Аливаа гишүүн идэвхгүй болж байгаа нь ноцтой асуудал юм. Их Эзэн алдагдсан нэг хонио хайхаар ерөн есөн хонио орхиж явсан байдаг. Алдагдсаных нь төлөө Тэрээр ихэд санаа зовж байсан бөгөөд Тэрээр үүнийг Өөрийн агуу хичээлүүдийн нэгийнх нь уриа болгосон байдаг. Бид Сүмд нэгдэж байгаа хөрвөгдөгстэй чин сэтгэлээсээ, халуун дотно, гайхамшигтай байдлаар нөхөрлөх мөн идэвхгүй байдлын сүүдэр лүү ямар нэгэн шалтгаанаар ганц хоёр алхмаар явж орсон хүмүүст хайраар хандах агуу үүрэг хариуцлагатай гэдгийг нь Сүмийн ажилтнууд болон гишүүдэд үргэлж сануулж байх ёстой” гэсэн (in *Church News*, 8 Apr. 1989, 6).

Мөн Ерөнхийлөгч Хинкли хэлэхдээ: “Хөрвөгдөгсдийн тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан бид тэднийг замаа олоход нь туслах чухал зүтгэл чармайлтаа нэмэгдүүлэх ёстой. Тэдний хүн нэг бүрт гурван зүйл хэрэгтэй: найз, үүрэг хариуцлага, мөн ‘Бурханы сайн үгээр’ тэжээгдэх явдал юм (Моронай 6:4)” гэсэн (in *Conference Report*, Apr. 1997, 66; or *Ensign*, May 1997, 47).

- Ерөнхийлөгч Хинклигийн зөвлөгөөг дагахын тулд бид юу хийж чадах вэ? Та нарыг дурсаж, тэжээсэн хүмүүс та нарыг хэрхэн адислаж байсан бэ?
- Сүмийнхэн “ойр ойрхон цугладаг байсан” (Моронай 6:5) гэж Моронай тэмдэглэсэн байдаг. Яагаад тэр вэ? (Моронай 6:5–6-г үз.) Бид хамтдаа мацаг барьж, залбирснаар хэрхэн батаждаг вэ? Сүмийн цуглаанууд нь нэг нэгэндээ “[өөрсдийн] бодгалиудын зол жаргалын тухай” ярих боломжийг бидэнд хэрхэн өгдөг вэ? Бид ариун ёслолоос хүртэхээр хамтдаа цуглах нь яагаад чухал вэ?

- Сүмийн цуглаануудыг хэрхэн явуулдаг байсан тухай Моронай юу заасан бэ? (Моронай 6:9-ийг үз.) Бидний хүн нэг бүр цуглаануудад Сүнсийг урьж авчрахын тулд юу хийж болох вэ?

Дүгнэлт

Моронай Сүмийн гишүүдийн хувьд нэг нэгнийгээ батжуулахын чухал ач холбогдлын талаар заасан гэдгийг тайлбарла. Ангийн гишүүдийг хэсгийнхээ буюу салбарынхаа бусад гишүүдийг “дурсан мөн тэжээх” арга замуудыг эрж хайхыг уриал.

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Дараах материал нь санал болгосон хичээлийн гол санаанд нэмэлт болно. Та энэ санааг хичээлдээ хэрэглэж болно.

Бусдыг хэсэгтээ болон салбартаа тавтай морилоход нь туслах

Ахлагч Карл Б.Пратт, гэрийнхэн нь Сүмийн янз бүрийн хэсгүүдэд айлчлах үед ямар сэтгэгдэл төрснөө ярьжээ. Дараах ишлэлийг ангийн гишүүдтэй хуваалц:

“Манай хүүхдүүд залуусын дундаас найз нараа амархан олсон учраас зарим хэсгүүдэд нь зочлохдоо дуртай байдаг байлаа мөн бид бүгд халуун дотно, чин зүрхний урилгыг хүлээн авдаг байлаа. Гэвч зарим хэсгүүдэд явчихаад хүүхдүүд маань нэг их урам зориггүй хүрч ирдэг нь мөн халуун дотно, чин зүрхний урилга байхгүй байгаагаас илэрхий байдаг байв.

“Тэгээд хэрэв бид сонирхогч эсвэл шинэхэн гишүүн байсан бол тийм их дотно урилгыг мэдрэхгүй байх байсан . . . гэдгийг зарим хэсгүүдэд ажиглаж эхэлсэн. . . .

“Энэ явдал маань . . . бидэнд бид бүгд нөхөрлөх гэсэн ур чадвараа дээшлүүлэх хэрэгтэй юм байна гэдгийг ойлгуулсан. . . .

“Ах, эгч, дүү нар аа, бид Бурхан хүүхдүүддээ өгдөг хамгийн баялаг адислалуудыг хүртсэн билээ. Бидэнд Есүс Христийн бүрэн дүүрэн сайн мэдээ байгаа. Бид бүх дэлхий дээрх хамгийн дотно, нөхөрсөг, аз жаргалтай, эелдэг, халамжтай, бодлоготой, бусдыг хайрладаг хүмүүс байх учиртай билээ. . . .

“Манай сүмийн байранд ирсэн гишүүн бус хүмүүс, шинэхэн хөрвөгдөгсөд, зочид биднийг халуун дулаан мэндчилгээгээр, зөөлөн инээмсэглэлээр, бидний нүдэнд гэрэлтэж байдаг эелдэг байдал, чин сэтгэлийн халамжаар маань Түүний шавь нарын хувьд таних болов уу?” (in Conference Report, Oct. 1997, 12; or *Ensign*, Nov. 1997, 11–12).

- Манай хэсэг болон салбарт ирсэн зочид ямар сэтгэгдэлтэй байна гэж та нар бодож байна вэ? (Ангийн гишүүдээс энэ асуултанд чангаар хариулахын оронд дотроо эргэцүүлж бодохыг хүс.) Бид зочдыг болон шинэхэн хөрвөгдөгсдийг хүлээн авдаг байдлаа хэрхэн сайжруулж болох вэ?

Зорилго

Ангийн гишүүдэд сайн сайхан хилэнцэт хоёрын хооронд хэрхэн шүүхийг мөн сайн мэдээний болон Мормоны Номын тухай гэрчлэлийг хэрхэн олж авах тухай заах болно.

Бэлтгэл

1. Дараах судруудыг уншаад эргэцүүлэн бодож, залбир:
 - а. Моронай 7:1–19. Мормон сайн сайхан хилэнцэт хоёрын хооронд хэрхэн шүүх тухай тайлбарладаг (эдгээр үгсийг Мормоны хүү Моронай бичсэн гэдгийг тайлбарла).
 - б. Моронай 7:20–48. Мормон Христэд итгэх итгэл нь гайхамшгууд ирдэг хүч чадал юм гэж тайлбарладаг. Тэрээр итгэл, найдвар, энэрлийн чухал ач холбогдлын тухай тайлбарладаг.
 - в. Моронай 8. Моронайд бичсэн захиандаа Мормон аврагдах нөхцөлүүдийг зааж, бяцхан хүүхдүүд нь Христийн Цагаатгалаар дамжин аврагддаг гэдгийг тайлбарладаг.
 - г. Моронай 10. Моронай Ариун Сүнс нь итгэлтэйгээр асуудаг хэн хүнд бүх үнэнийг гэрчилдэг гэдгийг тайлбарладаг. Тэрээр сүнслэг бэлгийн тухай тайлбарлаж, бүх хүмүүсийг Христэд ирэхийг ухуулдаг.

Хичээлийг Баяжуулах Зөвлөмж

Анхаарал Татах
Үйл Ажиллагаа

Боломжтой бол дараах үйл ажиллагааг эсвэл өөрийн бэлтгэсэн үйл ажиллагаанаас нэгийг хичээлийг эхлүүлэхээр хэрэглэ.

Дараах түүхийг ярь:

1910 оны 2-р сарын нэгэн хүйтэн өдөр Винчензо ди Франческо гэгч Протистант шашны үйлчлэгч, нар салхинд элэгдэн хуучирсан гарчиг нь байхгүй нэгэн шашны холбогдолтой номыг олжээ. Сонирхсондоо тэрээр номыг сонинд боон авч явлаа. Гэртээ очоод номыг цэвэрлэж, уншжээ. Тэрээр “Би үүнийг уншиж, мөн дахин уншиж, хоёр дахин, мөн хоёр дахин уншаад, үүнийг Гэтэлгэгчийн тав дахь сайн мэдээний номтой тохирч байна гэж хэлмээр байлаа,” гэж хэлжээ.

Түүний олсон ном нь Мормоны Ном байжээ. Тэр үүнийг уншаад Моронай 10:4 дээрх сануулгыг дагажээ. “Нэгэн өдрийн төгсгөлд би өрөөнийхөө хаалгыг түгжээд, гартаа номыг барин өвдөн сөгдөж, Моронайн номын аравдугаар бүлгийг уншсан. Би Бурхан, Мөнхийн Эцэгт түүний хүү, Есүс Христийн нэрээр энэ ном нь Бурханых мөн эсэхийг мөн энэ нь зөв сайн, үнэн ном эсэхийг хэлж өгөөч, би сургаал номлож байхдаа үүний үгсийг дөрвөн сайн мэдээтэй холих ёстой юу хэмээн залбирсан.

“Бие минь далайн салхи мэт хүйтэн болохыг би мэдэрсэн. Дараа нь зүрх минь хүчтэй цохилж эхлэн, ямар нэгэн үнэ цэнэтэй, ер бусын зүйл олсон мэт баяр жаргалтай болж, зүрх сэтгэлийг минь тайтгаруулж, хүний хэлээр тайлбарлах аргагүй баяр баясгаланг надад үлдээсэн. Бурхан залбирлыг минь хариуллаа, мөн энэ ном надад болон үүний үгсийг сонсох бүх хүмүүст агуу их ашигтай гэдэгт баттай итгэлийг олсон.”

Винчензо ди Франческогийн энэ үед авсан гэрчлэл нь түүнд олон хүнд хэцүү явдлыг туулахад тусалсан. Тэр Мормоны Номоос заасан учраас үйлчлэх эрх мэдлээ хасуулсан. Тэр 1930 онд л энэ номын нэрийг мөн үүнийг хэвлэн гаргасан Сүмийн нэрийг олсон. Дайн болон өөр бусад улс төрийн асуудлуудаас болж, тэр усаар батлуулах боломжтой болтол дахин 21 жил өнгөрсөн. Эдгээр хүнд хэцүү үеийн туршид тэрээр Мормоны Номын үнэний тухай хүчирхэг гэрчлэлээ хадгалж чадсан. (See Vincenzo di Francesca, “I Will Not Burn the Book!” *Ensign*, Jan. 1988, 18–21.)

Энэ хичээлд Мормоны Номын сүүлчийн бүлгүүдийн тухай ярилцдаг гэдгийг цохон тэмдэглэ. Эдгээр бичээст бидний хүн нэг бүр хэрхэн Мормоны Номын үнэний тухай хувийн гэрчлэлтэй болох тухай Моронайн зааварчилгаа багтдаг.

Судрын Ярилцлага ба Хэрэглээ

Ангийн гишүүдийн хэрэгцээнд хамгийн сайн нийцэх судрын хэсэг, асуултууд болон хичээлийн бусад материалуудыг залбирч сонго. Сонгосон судрууд нь өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг тухай ярилц. Судрын зарчмуудтай холбоотой зохимжтой туршлагаасаа хуваалцахыг ангийн гишүүдэд уриал.

1. Мормон сайн сайхан, хилэнцэт хоёрын хооронд хэрхэн шүүх тухай тайлбарладаг.

Моронай 7:1–19-ийг ярилц. Ангийн гишүүдээр сонгосон шүлгүүдийг чангаар уншуул. Моронай 7 нь Мормоны үгийг агуулдаг ба үүнийг түүний хүү бичиж тэмдэглэсэнийг онцол.

- Мормон Сүмийн гишүүдийг “Христийн дөлгөөн амгалан дагалдагчид” гэсэн (Моронай 7:3). Мормон юун дээр үндэслэн Сүмийн гишүүдийн талаар ийнхүү шүүн хэлсэн бэ? (Моронай 7:4–5-ыг үз.) Бид хэрхэн “Христийн дөлгөөн амгалан дагалдагчид” болдог вэ?
- Сайн үйлсийг хийх хүслийн маань чухал ач холбогдлын талаар Мормон юу заасан бэ? (Моронай 7:6–9-ийг үз.) Бэлэг өгөх буюу “зүрх сэтгэлийн үнэн хүслээр” залбирах гэдэг нь ямар утгатай вэ? Бид сайн үйлс хийхийн тулд хүслээ хэрхэн цэвэршүүлж чадах вэ?
- Бид сайныг хилэнцээс хэрхэн ялгах тухай Мормон бидэнд юу заасан бэ? (Моронай 7:12–19-ийг үз.)

Самбар дээр _____ нь намайг Бурханыг хайрлаж, түүнд үйлчлэхэд урьдаг уу? _____ нь Бурханаар урамшуулагдсан уу? гэж бич. Ангийн гишүүдийг аливаа зүйлийг эсвэл үйлдлийг сайн эсвэл хилэнцэт зүйл үү гэдгийг дүгнэж байхдаа эдгээр асуултуудыг хэрэглэж байхыг уриал. (Ямар нэгэн зүйл нь биднийг Бурхан руу удирддаг уу үгүй юу гэдгийг шүүх нь ямар нэгэн зүйл нь биднийг чөтгөр лүү удирддаг уу үгүй юу гэдгийг шүүхээс илүү амархан байдаг гэдгийг та цохон тэмдэглэж болно. Сатаны

хууран мэхлэх ажиллагаа нь ямар нэгэн зүйл “тийм ч их муу биш”, энэ нь сайн зүйл биш байлаа ч гэсэн үнэндээ хилэнцэт зүйл биш гэж бодохыг бидэнд үргэлж уриалж байдаг. Биднийг Бурхан руу хөтөлдөггүй ямар ч зүйл нь биднийг Түүнээс холдуулдаг гэдгийг онцлон тэмдэглэ.)

- Мормон хүмүүст “та нар хилэнцэт болох тэр нь Бурханаас хэмээн эсвээс сайн мөн . . . тэр нь чөтгөрөөс байх хэмээн бодохгүй байхыг анхаарагтун” гэж анхааруулсан (Моронай 7:14; мөн 2 Нифай 15:20-ийг үз). Энэ нь өнөөдөр тохиолдож байгааг харах ямар замууд байдаг вэ? (Та *Хилэнцэт нь сайн зүйл мэтээр тооцогдсон* болон *Сайн зүйл нь хилэнцэт мэтээр тооцогдсон* гэсэн гарчгийн дор ангийн гишүүдийн хариултыг самбарт бичиж болно.)
- Сайныг хилэнцэтээс ялган шүүхэд туслах ямар нөлөөг бидэнд өгсөн байдаг вэ? (Моронай 7:16, 18–19-ийг үз.)

“Христийн Сүнс” буюу “Христийн гэрэл” нь “Есүс Христийн ачаар хүн төрөлхтөнд ирдэг өөдрөг, эрхэм дээд, цөхрөшгүй нөлөө юм” (Bible Dictionary, “Light of Christ,” 725). Бүх хүмүүс үүнийг хүртэх боломжтой бөгөөд үнэнийг олж, Ариун Сүнсийг хүлээн авахад хүнийг бэлтгэдэг. Зөв, буруу хоёрыг ялгахад бидэнд тусалдаг үүрэгтэй энэхүү Христийн гэрлийг заримдаа бидний ухамсар гэж нэрлэдэг.

- Христийн гэрэл сайныг хилэнцэтээс ялгахад та нарт ямар замаар тусалдаг вэ? Христийн гэрэлд та нар хэрхэн илүү нааштай ханддаг болж чадах вэ?

2. Моронай итгэл, найдвар, энэрлийн чухал ач холбогдлын тухай тайлбарладаг.

Моронай 7:20–48-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Мормон, “Та нар сайн зүйл болгоноос барих нь явал боломжтой байх билээ?” гэж асуусан (Моронай 7:20). Тэр энэ асуултанд юу гэж хариулсан бэ? (Моронай 7:21–26-г үз. “Христээр сайн зүйл болгон ирдэг” бөгөөд Түүнд итгэлээ хөгжүүлснээр үүнээс “барьж” чадна.)

Ангийн гишүүдээс итгэлээс нь болж өөрсдөд нь эсвэл бусдад ирдэг адислалуудын тухай бодохыг хүс. Эдгээр жишээнүүдээс зохистойгоор хуваалцахыг тэднээс урь.

- Итгэл, гайхамшиг хоёрын хоорондын холбоо нь юу вэ? (Моронай 7:28–30, 35–38-ыг үз.) Итгэл яагаад гайхамшигийн өмнө байх ёстой вэ? (Моронай 7:37-г үз; мөн Ифэр 12:12, 18-ыг болон дор байгаа ишлэлийг үз.) Гайхамшиг нь яагаад ганцаараа итгэлийн баттай суурь болдоггүй вэ?

Ерөнхийлөгч Бригам Ян хэлэхдээ, “Бурханы хүч чадлын гайхамшгууд буюу эдгээр ер бусын илрэлүүд нь үл итгэгч нарт зориулагдсан зүйл биш юм; эдгээр нь Гэгээнтнүүдийг тайтгаруулж, Бурханыг хайрлаж, түүнээс эмээж, түүнд үйлчилдэг хүмүүсийн итгэлийг бэхжүүлж, бататгахын тулд өгөгдсөн юм” гэсэн (*Discourses of Brigham Young*, sel. John A. Widtsoe [1941], 341).

- Найдвар гэж юу вэ? Итгэл, найдвар хоёрын хооронд ямар холбоо байдаг вэ? (Моронай 7:40–42-ыг үз.)

Ахлагч Брүс Р.МакКонки заахдаа: “Илчлэлтэнд хэрэглэгддэгээр бол *найдар* нь одоо болон хожим нь Бурханы хаант улсад орж мөнхийн авралыг олж

авах гэсэн итгэлтэй хүмүүсийн хүсэл юм. . . . Итгэл, найдвар хоёр нь салшгүй холбоотой юм. Найдвар нь [бидэнд] нэн түрүүнд итгэлтэй байх боломжийг өгдөг бөгөөд улмаар итгэлээр найдвар нь авралыг олж авах хүртэл өсдөг” гэжээ (*Mormon Doctrine*, 2nd ed. [1966], 365–66).

- Итгэл, найдвар хоёрын өмнө ямар шинж чанар байх ёстой вэ? (Моронай 7:43-ыг үз.) Хүн жинхэнэ итгэл, найдвартай байхын тулд яагаад “хүлцэнгүй даруу мөн зүрх сэтгэлдээ номхон” байх ёстой вэ?
- Мормон итгэл, найдвар хоёрын зэрэгцээгээр бидэнд энэрэл байх ёстой гэж заасан. Энэрэл гэж юу вэ? (Моронай 7:46–47-г үз.) Энэрлийн шинж чанар нь юу вэ? (Моронай 7:45-ыг үз. Та ангийн гишүүдийн хариултуудыг самбарт бичиж болно.) “Энэрэл хэзээ ч дуусдаггүй” гэдгийг та нарын амьдралд тохиолдсон явдлууд хэрхэн баталсан бэ?
- Бид өөрсдийн итгэл, найдвараа хэрхэн нэмэгдүүлж болох вэ? Бид Христийн цэвэр хайраар хэрхэн дүүрэн болж чадах вэ? Бид яагаад итгэл, найдвар, энэрлийг эзэмшиж авахаар чармайх ёстой вэ? (Моронай 10:20–21-ийг үз.)

3. Мормон бяцхан хүүхдүүд нь Христийн Цагаатгалаар дамжин аврагддаг гэж заадаг.

Моронай 8-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц. Энэ бүлэг нь Мормон хүү Моронайдаа бичсэн захидлыг агуулдаг гэдгийг цохон тэмдэглэ.

- Бяцхан хүүхдүүдэд яагаад усан баталгаа хэрэггүй вэ? (Моронай 8:8–9, 11, 19–20-ийг үз. Бяцхан хүүхдүүдийн тухай Моронайн сургаалууд нь мөн зарлигууд болон сайн мэдээний ёслолуудыг оюун санаагаараа ойлгох чадваргүй тэдгээр “хууль үгүй орших бүгдэд” [Моронай 8:22] нь хамаардаг гэдгийг анхаар.) Бяцхан хүүхдийг усаар батлах нь яагаад “Бурханы өмнөх элэглэл” байдаг вэ? (Моронай 8:20, 22–23-ыг үз.)
- Бяцхан хүүхдүүд нь гэмгүй бөгөөд нүгэл үйлдэх чадваргүй учир аврагдсан байдаг. Бидний нүгэл хийсэн нь Христийн Цагаатгалаар дамжуулан хэрхэн аврагдаж чадах вэ? (Моронай 8:10, 24–26-г үз.)

4. Ариун Сүнс бүх үнэнийг гэрчилдэг. Сүнслэг бэлгүүд нь Христэд ирдэг хүмүүсийг дагадаг.

Моронай 10-аас сонгосон шүлгүүдийг уншаад ярилц.

- Мормоны Номын төгсгөлийн бүлгийн хувьд Моронай 10 нь Моронайн төгсгөлийн үгсийг агуулдаг. Энэ бүлэг нь хэнд зориулагдсан бэ? (Моронай 10:1-ийг үз.) Моронай “ухуулах замаар хэдэн үг хэлэн” төгсгөсөн (Моронай 10:2). *Ухуулах* гэдэг нь ямар утгатай үг вэ? (Зөвлөх буюу хүчтэйгээр уриалах.) Ангийн гишүүдээс энэ бүлгийг хурдхан уншаад Моронай уншигчиддаа хийхийг ухуулсан зүйлүүдийг тодорхойлохыг хүс. (Хариултуудыг дор бичсэн болно. Та ухуулах зүйлсийг агуулсан шүлэг нэг бүрийг ангийн гишүүдээр чангаар уншуулж болно.)
 - а. “Их Эзэн хүмүүний үрсэд ямар нигүүлсэнгүй байсаар буйг сана” (шүлэг 3).
 - б. “Бурхан, Мөнхийн Эцэгээс, Христийн нэрээр эдгээр зүйлүүд нь үнэн бус эсэхийг асуу” (шүлэг 4).
 - в. “Бурханы хүчийг үгүйсгэхгүй бай” (шүлэг 7).

- г. “Бурханы бэлгүүдийг үгүйсгэхгүй бай” (шүлэг 8).
- д. “Сайн бэлэг бүр Христээс ирдгийг сана” (шүлэг 18).
- е. “[Христ] өчигдөр, өнөөдөр, мөн үүрд хэвээр гэдгийг сана” (шүлэг 19).
- ё. “[Моронайн бичсэн] эдгээр зүйлүүдийг сана” (шүлэг 27).
- ж. “Христэд ирэгтүн” (шүлэг 30).

- Мормоны Ном бол Бурханы үг юм гэсэн гэрчлэлтэй эсэхээ бодож үзэхийг ангийн гишүүдээс урь. Сүнслэг зүйлүүдийн тухай гэрчлэлтэй болоход Ариун Сүнс ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? (Моронай 10:4–5-ыг үз.) Яагаад бид гэрчлэлээ ганц ухамсраараа олж авч болохгүй вэ? (1 Коринт 2:11; Алма 26:21–22; Моронай 10:6–7-г үз.)
- Моронай бидэнд “Бурханы хүч чадлыг бүү эсэргүүц” гэж уриалсан (Моронай 10:7). Бид ямар байдлаар заримдаа Бурханы хүч чадлыг эсэргүүцдэг вэ? (Ангийн гишүүдийн хариултыг асуухаас гадна та дор байгаа мэдэгдлийг уншиж өгч болно.)

Ахлагч Жэффри Р.Холланд заахдаа:

“Аврагч хэлэхдээ, `Амар амгаланг би та нарт үлдээнэ. . . . Та нар зүрхээ бүү зовоо, бүү ай’ гэсэн (Иохан 14:27).

“Би та нарт Аврагчийн зарлигуудын нэг нь байж болох, бараг дэлхий ертөнцөөрөө, тэр ч бүү хэл итгэлтэй Хожмын үеийн Гэгээнтнүүдийн зүрх сэтгэлд хүртэл дуулгавартай дагахгүй байсан нэгэн зүйлийг үзүүлж байна; тэр ч бүү хэл энэ урилгыг эсэргүүцэх байдал нь Их Эзэний энэрэнгүй зүрх сэтгэлийг илүү их шаналгах байх даа. Би эцэг хүний хувьд үүнийг та нарт хэлж чадна; хэрэв хүүхдүүдийн минь нэг нь амьдралынхаа аль нэгэн үедээ маш ноцтойгоор зовж эсвэл аз жаргалгүй буюу дуулгаваргүй байсан бол би маш их санаа зовох байсан. Тэр ч бүү хэл ийм үедээ хүүхэд маань намайг тусална гэдэгт итгээгүй эсвэл түүний юу сонирхож байгаа нь надад чухал биш эсвэл миний халамжлах баталгаатай биш гэж тэр бодож байгаа гэдэг сэтгэгдэл надад төрсөн бол би хязгааргүй ихээр уй гашууд автах байсан. Үүнтэй адилаар дэлхийн Аврагч өөрийнх нь хүмүүс түүний халамжинд тааламжтай байхгүйг буюу түүний гарт аюулгүй байгааг мэдрэхгүй эсвэл түүний зарлигуудад итгэдэггүй гэдгийг мэдэх үед түүний хайрлах сэтгэл ямар их гүн гүнзгийгээр шархалж байгааг бидний хэн нь ч ойлгож чадахгүй” (“Come unto Me,” *Ensign*, Apr. 1998, 19).

- Моронай сүнслэг бэлгүүдийн тухай юу гэж заасан бэ? (Моронай 10:8–19-ийг үз.) Бидний хүн нэг бүр Бурханаас яагаад өөр өөр бэлгүүдийг хүлээн авдаг вэ? (С ба Г 46:11–12-ыг үз.)
- Та нар Мормоны Номын захиасын тухай эргэцүүлж бодохдоо юу сурч, мэдэрсэн бэ? (Ангийн гишүүдийг хэрэв тэд өөрсдийн бодлоо ангийнхандаа хуваалцахыг хүсэхгүй байвал энэ асуултыг чимээгүйхэн тунгаан бодохыг урь.)
- “Христэд ирэгтүн” гэсэн Моронайн уриалга нь Мормоны Номын захиасыг бүхэлд нь хэрхэн тусган харуулдаг вэ? (Моронай 10:30, 32). Энэ жил Мормоны Номноос суралцсан нь та нарыг Христэд ирэхэд чухам ямар тодорхой замаар тусалсан бэ?

Дүгнэлт

Сүнсээр удирдуулан хичээлийн дундуур ярилцсан үнэнүүдийг гэрчил.

Заах Нэмэлт Санаанууд

Мормоны Номоос үргэлжлүүлэн суралцахыг ангийн гишүүдэд уриалахдаа дараах мэдэгдлүүдийг тэдэнтэй хуваалцаж болно:

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ: “Би эрэгтэй, эмэгтэй хүн нэг бүрийг . . . мөн уншиж чадахуйц том болсон охид, хөвгүүд нэг бүрийг энэ ирж буй жилийн турш Мормоны Номыг дахин уншихыг уриалмаар байна. . . . Хүн нэг бүрийн амьдралдаа Есүс бол Христ, Амьд Бурханы Амьд Хүү мөн гэсэн гуйвшгүй итгэл үнэмшилтэй болж зоригжихоос илүү агуу чухал зүйлийг бид хийж чадахгүй. . . . Энэ бол энэхүү гайхамшигт, тэмдэглүүштэй номын гарч ирэх болсон зорилго юм” гэжээ (in *Church News*, 4 May 1996, 2).

Ерөнхийлөгч Иосеф Филдинг Смит хэлэхдээ: “Мормоны Номыг нухацтайгаар мөн анхааралтайгаар уншаагүй энэ Сүмийн ямар ч гишүүн Бурханы дэргэд батлагдан зогсож чадахгүй” гэжээ (in *Conference Report*, Oct. 1961, 18).

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон хэлэхдээ: “Мормоны Номыг бид Ням Гарагийн Сургууль, семинар дээрээ дөрвөн жил тутамд суралцдаг билээ. Сүмийн гишүүд хувиараа болон гэр бүлээрээ суралцахдаа энэхүү дөрвөн жил тутмын загварыг дагах хэрэггүй юм. ‘Бусад номныхыг дагаснаас үүнийг зааврыг дагаснаар хүнийг Бурханд илүү ойр болгох’ энэ номын хуудаснаас бид өдөр бүр унших хэрэгтэй” гэжээ (*History of the Church*, 4:461)” (in *Conference Report*, Oct. 1988, 3; or *Ensign*, Nov. 1988, 4).

Мөн Ерөнхийлөгч Бэнсон хэлэхдээ: “Хожмын Үеийн Гэгээнтэн нэг бүр энэ номыг суралцахаа энэ насныхаа явдал болгох ёстой” гэжээ (in *Conference Report*, Apr. 1975, 97; or *Ensign*, May 1975, 65)

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

MONGOLIAN



4 02356 83363 7

35683 363